Sendly

Сэндли

# БОНД 2.0

Үнэт цаасны танилцуулга

2024

ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР

UIZII & Co CAPITAL

ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР

RHINOS Investment

Golomt Capital

СЗХ
2024-06-20
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

АГУУЛГА

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР ..... 8
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР ..... 8
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД ..... 9
ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД ..... 10
ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ..... 12
ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ТОГТООЛ ..... 13
**НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ** ..... 17
1.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ ..... 18
1.1.1. Үүсгэн байгуулагдсан тухай ..... 18
1.1.2. Үнэт цаас гаргагчийн эрхэм зорилго, үнэт зүйлс ..... 18
1.1.1. Үнэт цаас гаргагч хуулийн этгээдийн бүртгэл, хаяг ..... 19
1.1.2. Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөл ..... 20
1.1.3. Үнэт цаас гаргагчийн бизнесийн онцлох үйл явдлууд ..... 20
1.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ..... 24
1.2.1. Үнэт цаас гаргагчийн толгой компаниудын тухай ..... 25
1.2.2. Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компаниуд ..... 25
1.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ..... 28
1.3.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод ..... 28
1.3.2. Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөл ..... 30
1.3.3. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын баг ..... 32
1.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА 35
1.4.1. "Sendly" аппликэйшний давуу тал, онцлог ..... 35
1.4.2. Зээлийн үйл ажиллагаа ..... 39
1.4.3. Олон Улсын мөнгөн гуйвуулга ..... 41
1.4.4. Үнэт цаас гаргагчийн нийгмийн хариуцлага ..... 43
1.4.5. Үнэт цаас гаргагчийн шагнал, урамшуулал ..... 44
1.5. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО ..... 45
1.6. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ИХ ХЭМЖЭЭНИЙ БА СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ..... 49
1.7. НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО ..... 49
ХОЁР. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ШИНЖИЛГЭЭ ..... 52
2.1. 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ДҮГНЭЛТ ..... 53
2.2. СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ ..... 53
2.3. НИЙТ АКТИВЫН БҮТЭЦ ..... 56
2.4. АШИГТ АЖИЛЛАГАА, ӨГӨӨЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ ..... 58
2.5. САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ ..... 59
2.6. МӨНГӨН УРСГАЛ БА ХӨРВӨХ ЧАДВАР ..... 60
2.7. САНХҮҮГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД ..... 61

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
9021031195 6183855 СТС2420

ГУРАВ. ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА ........ 65
3.1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ ........ 66
3.1.1. Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал ........ 66
3.1.2. Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал ........ 73
3.2. БАНК БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ ........ 75
3.3. МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ЗАХ ЗЭЭЛ ........ 78
3.4. ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА ........ 86
3.4. SWOT ШИНЖИЛГЭЭ ........ 92
ДӨРӨВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮ, БИЗНЕСИЙН ТӨСӨӨЛӨЛ ........ 94
4.1. ДУНД ХУГАЦААНЫ БИЗНЕСИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 95
4.1.1. Зээлийн үйл ажиллагааны төлөвлөгөө ........ 95
4.1.1. Мөнгөн гүйвуулгын үйл ажиллагааны төлөвлөгөө ........ 96
4.2. САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ ........ 98
ТАВ. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ........ 104
5.1. НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ........ 105
5.1.1. Бондын нэрлэсэн үнэ, хугацаа, нөхцөл ........ 105
5.2. ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ ........ 106
5.3. БОНДЫН БАРЬЦАА ........ 107
5.4. ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ ........ 112
5.5. ӨРИЙН ХЭРЭГСЛЭЭР ГЭРЧЛЭГДЭХ ЭРХ, ҮҮРЭГ ........ 112
5.6. ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТУХАЙ ........ 115
5.6.1. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө ........ 116
5.6.2. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа ........ 116
5.6.2. Өрийн хэрэгсэл худалдан авах заавар ........ 117
ЗУРГАА. ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИД ........ 119
6.1. ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА ........ 120
6.2. ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА ........ 122
6.3. АУДИТЫН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА ........ 126
6.4. ХУУЛИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА ........ 127
6.5. ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИ ........ 129
6.6. АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ ........ 130
ХАВСРАЛТ ........ 139
ХАВСРАЛТ-1. АУДИТЫН ТАЙЛАН, ДҮГНЭЛТ ........ 140
ХАВСРАЛТ-2. ХУУЛИЙН ДҮГНЭЛТ ........ 140
ХАВСРАЛТ-3. БАРЬЦАА ГАРГАГЧИЙН ТОГТООЛ, САНХҮҮГИЙН ТАЙЛАН ........ 247
ХАВСРАЛТ-4. БАРЬЦАА ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ........ 289
ХАВСРАЛТ-5. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ........ 327
ХАВСРАЛТ-6. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ........ 329
БАТЛАХ ХУУДАС ........ 335

СЗХ
он 2024 сар 06 өдөр 10
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

## График

График 1. Нийт зээлийн багц ба идэвхтэй харилцагчдын тоо ....39
График 2. Зээлийн багцын ангилал, (тэрбум төгрөг) ....39
График 3. Зээл олголт (тэрбум төгрөг) ба зээлийн тоо ....40
График 4. Зээлдэгчдийн хүн ам зүйн шинж чанар ....40
График 5. Зээл олгосон хэлбэр ....41
График 6. Нийт актив ба зээлийн багц, (сая төгрөг) ....56
График 7. Нийт активын бүтэц, (сая төгрөг) ....57
График 8. Зээлийн багцын чанар ....57
График 9. Нийт цэвэр орлого ба цэвэр ашиг (сая төгрөг) ....58
График 10. Хүүгийн бус орлогын бүтэц, (сая төгрөг) ....58
График 11. Ашигт ажиллагаа, өгөөжийн үзүүлэлт ....59
График 12. Өр төлбөрийн бүтэц, (сая төгрөг) ....59
График 13. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, (сая төгрөг) ....60
График 14. Үндсэн үйл ажиллагааны орох мөнгөн урсгалын бүтэц, (сая төгрөг) ....61
График 15. Монгол Улсын бодит ДНБ-ийн өсөлт ....66
График 16. 2024 оны эдийн засгийн өсөлтийн төсөөлөл ....66
График 17. Инфляц ба бодлогын хүү ....67
График 18. 2024 оны инфляцын төсөөлөл ....67
График 19. Экспорт ба импорт, (сая ам.доллар) ....69
График 20. Урсгал дансны тэнцэл, (сая ам.доллар) ....69
График 21. Гадаад валютын улсын нөөц (сая ам.доллар) ба ам.долларын сарын дундаж ханш ....70
График 22. Мөнгөний нийлүүлэлт ба зээлийн үлдэгдэл (их наяд төгрөг) ....70
График 23. ААН, иргэдийн зээлийн үлдэгдэл, (их наяд төгрөг) ....71
График 24. Төсвийн тэнцэржүүлсэн тэнцэл, (тэрбум төгрөг) ....71
График 25. Засгийн газрын нийт өр, (тэрбум төгрөг) ....72
График 26. Засгийн газрын нийт өрийн эргэн төлөлт, (тэрбум төгрөг) ....72
График 27. Үнэт цаасны гүйлгээ (сая төгрөг) ба ТОП-20 индекс ....73
График 28. Зах зээлийн үнэлгээ (их наяд төгрөг) ба ЗЗҮ/ДНБ харьцаа ....73
График 29. Бонд ба хувьцааны арилжаа (тэрбум төгрөг) ....74
График 30. ББСБ-ын салбарын нийт хөрөнгө ба зээл (тэрбум төгрөг) ....75
График 31. Өөрийн хөрөнгө ба Хувь нийлүүлсэн хөрөнгө ХНХ (тэрбум төгрөг) ....75
График 32. Нийт харилцагчид ба зээлдэгчдийн тоо, (мянган хүн) ....76
График 33. Зээлийн жигнэсэн дундаж хүү (ЗЖДХ) ба салбарын ашигт ажиллагаа ....76
График 34. Зээлийн багц (тэрбум төгрөг) ба зээлийн чанар ....77
График 35. Салбарын санхүүжилтийн бүтэц (тэрбум төгрөг) ....77
График 36. Дэлхийн мөнгөн гүйвуулгын хэмжээ, (тэрбум ам.доллар) ....78

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
5183855
9021031195 СТС2420

СЗХ 2024.06.10 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

График 37. ТОП-10 мөнгөн гуйвуулга хүлээн авагч орнууд, (тэрбум ам.доллар) ............79
График 38. Хувийн гуйвуулга, (мянган ам.доллар) ............81
График 39. Гадаад улсад оршин сууж буй Монгол иргэдийн тоо, 2020 оны байдлаар .83
График 40. Гадаад улсад оршин суугаа Монгол иргэдийн мөнгөн гуйвуулгын мэдээлэл ............84
График 41. Жилийн дундаж мөнгөн гуйвуулга, бусад илгээмжийн орлогод эзлэх хувь ............85
График 42. Зах зээлд эзлэх хувь (зөвхөн нээлттэй ХК хувьд) ............91
График 43. Ногдол ашгийн өгөөж ба Үнэ-ашгийн харьцаа ............91
График 44. Нийт хөрөнгө ба нийт зээлийн төсөөлөл, (сая төгрөг) ............98
График 45. Нийт активын бүтцийн төсөөлөл, (сая төгрөг) ............99
График 46. Өр төлбөрийн бүтцийн төсөөлөл, (сая төгрөг) ............99
График 47. Нийт цэвэр орлогын төсөөлөл, (сая төгрөг) ............100
График 48. Цэвэр ашгийн төсөөлөл, (сая төгрөг) ............101
График 49. Мөнгөн гүйлгээ, төрлөөр (сая төгрөг) ............102
График 50. Тогтмол өгөөжтэй хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн дундаж хүү ............107
График 51. Сэндли ББСБ ХК-ийн хувьцааны ханш ............108

## Хүснэгт

Хүснэгт 1. Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэл ............19
Хүснэгт 2. Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлүүд ............20
Хүснэгт 3. Сэндли ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн жагсаалт ............24
Хүснэгт 4. Үнэт цаас гаргагчийн толгой компаниудын мэдээлэл ............25
Хүснэгт 5. Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компаниудын мэдээлэл ............26
Хүснэгт 6. Мөнгөн гуйвуулга, мөнгөн дүнгээр ............42
Хүснэгт 7. Мөнгөн гуйвуулгын тоо ............42
Хүснэгт 8. Компанийн сүүлийн 3 жилд байгуулсан их хэмжээний ба сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээлэл ............49
Хүснэгт 9. Ногдол ашгийн мэдээлэл ............49
Хүснэгт 10. Санхүү байдлын тайлан, (мянган төгрөг) ............53
Хүснэгт 11. Орлогын дэлгэрэнгүй тайлан, (мянган төгрөг) ............54
Хүснэгт 12. Мөнгөн гүйлгээний тайлан, (мянган төгрөг) ............55
Хүснэгт 13. Өр төлбөрийн харьцаа үзүүлэлт ............60
Хүснэгт 14. Санхүүгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, (2024.I улирал) ............61
Хүснэгт 15. Сэндли бондын эргэн төлөлтийн мэдээлэл ............64
Хүснэгт 16. Уул уурхайн голлох бүтээгдэхүүний экспорт, оны эхний хоёр сард ............68
Хүснэгт 17. Экспортын орлого (сая ам.доллар), оны эхний хоёр сард ............68
Хүснэгт 18. Мөнгөн гуйвуулга, бага, дунд орлоготой улс орнууд (тэрбум ам.доллар) ............78

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

Хүснэгт 19. Зүүн Ази ба Номхон далайн орнуудаас 200 ам.доллар шилжүүлэх дундаж өртөг ... 80
Хүснэгт 20. Хүлээн авсан хувийн гуйвуулга, (мянган ам.доллар) ... 81
Хүснэгт 21. Шилжүүлсэн хувийн гуйвуулга, (мянган ам.доллар) ... 82
Хүснэгт 22. Гадаадад зорчсон Монгол Улсын иргэд ... 82
Хүснэгт 23. Монгол Улсын хилээр орсон гадаад зорчигчид ... 83
Хүснэгт 24. Мөнгөн гуйвуулгын жилийн дундаж хэмжээ, (мянган төгрөг) ... 84
Хүснэгт 25. Зөвхөн аппликэйшнээр зээл олгодог ББСБ ... 86
Хүснэгт 26. ББСБ-ын тусгай зөвшөөрөл эзэмшигчид, өрсөлдөгчдөөр ... 87
Хүснэгт 27. Цахим үйлчилгээ үзүүлэгч ББСБ-уудын үйлчилгээний харьцуулсан үзүүлэлт ... 88
Хүснэгт 28. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч компаниудын мэдээлэл ... 88
Хүснэгт 29. Гадаад мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгчийн судалгаа ... 89
Хүснэгт 30. ББСБ-уудын орон нутаг дахь тархац ... 90
Хүснэгт 31. ББСБ-уудын хувьцааны ханшийн мэдээлэл ... 90
Хүснэгт 32. Үнэт цаас гаргагчийн SWOT шинжилгээ ... 92
Хүснэгт 33. Идэвхтэй харилцагчдын төсөөлөл ... 95
Хүснэгт 34. Мөнгөн гуйвуулгын үйл ажиллагааны төлөвлөгөө ... 96
Хүснэгт 35. Үйл ажиллагааны төлөвлөгөө, чиглэлээр ... 96
Хүснэгт 36. Санхүү байдлын тайлангийн төсөөлөл, (сая төгрөг) ... 98
Хүснэгт 37. Орлого, үр дүнгийн тайлангийн төсөөлөл, (сая төгрөг) ... 100
Хүснэгт 38. Мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл, (сая төгрөг) ... 101
Хүснэгт 39. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн төсөөлөл ... 103
Хүснэгт 40. Бондын нэрлэсэн үнэ, хугацаа, бусад нөхцөл ... 105
Хүснэгт 41. Нээлттэй бонд, ХБҮЦ-ны хүү ... 107
Хүснэгт 42. Барьцаа хөрөнгийн мэдээлэл ... 108
Хүснэгт 43. Эх үүсвэрийн зарцуулалт ... 112
Хүснэгт 43. Эх үүсвэрийн зарцуулалт ... 136

## Схем

Схем 1. Үнэт цаас гаргагчийн үнэт зүйлс, зорилго ... 18
Схем 2. Үнэт цаас гаргагчийн голлох үзүүлэлтүүд, 2023 он ... 19
Схем 3. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц ... 24
Схем 4. Толгой компанийн охин компаниуд дахь хувь эзэмшил ... 25
Схем 5. Компанийн бүтэц зохион байгуулалт ... 28
Схем 6. Мерчант зээлийн онцлогууд ... 38
Схем 7. Мөнгөн гуйвуулгын мэдээлэл, 2023 он ... 41
Схем 8. Финтекийн үйлчилгээ үзүүлэгчдийн нэгдсэн матриц ... 86

СЭХ 2024.06.10 БҮРТГЭВ № 1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

Схем 9. Бондыг анхдагч зах зээлд байршуулах дараалал ........ 116

## Зураг

Зураг 1. Үнэт цаас гаргагчийн 2022 оны IPO үйл ажиллагааны нээлт ........ 18
Зураг 2. Компанийн IPO үйл ажиллагаа ........ 20
Зураг 3. Open invest 2022 Korea арга хэмжээ ........ 20
Зураг 4. БНСУ-ын Шинхан Секьюритис компанитай хамтарсан санамж бичиг ........ 21
Зураг 5. Хувьцаа эзэмшигчдийн хурал ........ 21
Зураг 6. Ногдол ашгийн бодлогын хэрэгжилт ........ 21
Зураг 7. Сэндли нээлттэй бонд ........ 22
Зураг 8. ISO Олон Улсын стандарт ........ 22
Зураг 9. Paysend PLC компанитай хамтран ажиллах гэрээ ........ 22
Зураг 10. Шинэ салбарын нээлт ........ 23
Зураг 11. БНХАУ-ын Alipay компанитай хамтын ажиллагаа эхлүүлэв ........ 23
Зураг 12. Сэндли ББСБ ХК ТОП-20 индексэд багтав ........ 23
Зураг 13. “Sendly ба Hipay” аппликэйшн ........ 35
Зураг 14. “Sendly” АНУ-аас Монгол Улс руу шилжүүлэх мөнгөн гуйвуулга ........ 35
Зураг 17. “Sendly” Япон улсад ........ 36
Зураг 18. “Sendly” Европын холбооны улс орнуудад ........ 36
Зураг 19. “Paysend” хамтын ажиллагаа ........ 36
Зураг 20. “WeChat Pay” хамтын ажиллагаа ........ 36
Зураг 21. “Sendly” аппликэйшн дээрх цахим зээлийн үйлчилгээ ........ 37
Зураг 22. “Sendly” аппликэйшн дээрх мерчант зээлийн үйлчилгээ ........ 37
Зураг 23. “Sendly” аппликэйшн дээрх төлбөр тооцоо ........ 38
Зураг 24. “Аутист артистууд” хөгжмийн наадам ........ 43
Зураг 25. Улаанбаатар марафон 2023 ........ 43
Зураг 26. Ид шидийн орон төсөл ........ 43
Зураг 27. Тэрбум мод үндэсний хөдөлгөөн ........ 43
Зураг 28. Хорт хавдрын эсрэг аян ........ 44
Зураг 29. Компанийн шагнал, урамшуулал ........ 44

СЗХ
он 2024 сар 06 өдөр 10
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ 2024.06.10

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

| | |
|---|---|
| Андеррайтер | Үнэт цаасыг олон нийтэд санал болгох үйл ажиллагааг зохион байгуулагч компани |
| Анхдагч зах зээл | Анх удаа олон нийтэд үнэт цаасаа худалдаж байгаа арилжаа |
| Аппликэйшн | Гар утсанд суулгаж ашигладаг программ |
| Арилжаа | Үнэт цаас худалдах, худалдан авах ажиллагаа |
| Бичил зээл | Бага хэмжээтэй хэрэглээний зээл |
| Бонд | Өрийн хэрэгсэл эсхүл өрийн бичиг |
| Их хэмжээний хэлцэл | Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш үнэтэй гэрээ, хэлцэл |
| Лиценз | Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх |
| Мерчант | Жижиглэнгийн худалдаа эрхлэгч |
| Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасан хэлцэл |
| Үнэт цаас гаргагч | Үнэт цаасаа олон нийтэд худалдахаар санал болгож буй компани |
| Финтек | Санхүүгийн үйлчилгээг технологитой хамтатгасан бизнесийн загвар |
| Хоёрдогч зах зээл | Анхдагч зах зээлд гарсан үнэт цаасыг дахин худалдах, худалдан авах, арилжихтай холбогдсон харилцаа |

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| ААНОАТ | Аж ахуй нэгжийн орлогын албан татвар |
| ААНБ | Аж ахуй нэгж байгууллага |
| АНУ | Америкийн Нэгдсэн Улс |
| АХБ | Азийн хөгжлийн банк |
| ББСБ | Банк бус санхүүгийн байгууллага |
| БНСУ | Бүгд Найрамдах Солонгос Улс |
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| ГВУН | Гадаад валютын улсын нөөц |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| МХБ | Монголын хөрөнгийн бирж эсхүл Бирж |
| СЗХ | Санхүүгийн зохицуулах хороо эсхүл Хороо |
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |
| УБ | Улаанбаатар |
| ҮЦК | Үнэт цаасны компани |
| ҮЦТХТ | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |
| ХК | Хувьцаат компани |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| IPO | Initial Public Offering буюу компани олон нийтэд хувьцаагаа анх удаа санал болгох үйл ажиллагаа |

УЛААНБААТАР ХОТ ... ХХК 5183855 СТС2420

СЗХ 2024 оны 05 сарын 16 өдөр БҮРТГЭВ №1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Сэндли ББСБ ХК (цаашид "Үнэт цаас гаргагч", "Компани", "Сэндли ББСБ" гэх) нь Монгол Улсын "Компанийн тухай хууль", "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль", "Санхүүгийн зохицуулах хороо" болон "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн холбогдох журмын дагуу олон нийтэд өрийн хэрэгсэл (цаашид "Бонд", "Өрийн бичиг" эсхүл "Өрийн хэрэгсэл" гэх) нээлттэй санал болгон гаргаж байгаа болно.

**"ЭНЭХҮҮ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАСАН БОНДЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БОЛОН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСАНД ГАРГАСАН АЛИВАА БАТАЛГАА БИШ БӨГӨӨД ТҮҮНИЙ АГУУЛСАН АЛИВАА МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВ, БҮРЭН БҮТЭН БАЙДЛЫГ ХОРОО БОЛОН БИРЖ ХАРИУЦАХГҮЙ! ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, БОНДЫН ТАНИЛЦУУЛГА, БОНД ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА."**

Үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч таны Бонд худалдан авах шийдвэр гаргалтад туслах, шаардлагатай гэсэн бүхий л мэдээллийг оруулахыг зорилоо. Таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан илүү дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай болох буюу лавлах тодруулах нэмэлт зүйл гарвал Үнэт цаас гаргагч "Сэндли ББСБ" ХК болон андеррайтер компаниуд "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК, "Голомт капитал ҮЦК" ХХК, "Райнос инвестмент ҮЦК ХХК"-д хандана уу.

Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцож буй аудитын компани "Хүлэгтхүнну аудит" ХХК, Хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН, андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК, "Голомт Капитал ҮЦК" ХХК, "Райнос инвестмент ҮЦК" ХХК нар нь холбогдох хууль, дүрэм журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд үнэт цаас гаргагч Сэндли ББСБ ХК-д холбогдох мэргэжлийн үйлчилгээ үзүүлж буй бөгөөд **ҮНЭТ ЦААС ГАРГАГЧТАЙ АЛИВАА БАЙДЛААР НЭГДМЭЛ СОНИРХОЛГҮЙ, ЭНД ДУРДСАНААС ӨӨРӨӨР БИЗНЕСИЙН ХАМААРАЛГҮЙ БОЛНО.**

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

# ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ

### “СЭНДЛИ ББСБ” ХК

Монгол улс, Улаанбаатар хот 14200, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 40, 50 мянгат, Бакула ренбүчи гудамж, 8/4

contact@sendly.mn

+976 7017 7700, 7799-7700

www.sendly.mn

## ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР

### “ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК” ХХК

Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити тауэр, 25 давхар, 2506 тоот

info@ucc.mn

+976 7777 6377

www.ucc.mn

## ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР

### “РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК” ХХК

Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Д.Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1308Б тоот

info@rhinosinvest.mn

+976 7510 0575

www.rhinosinvest.mn

## ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР

### “ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ” ХХК

Монгол улс, Улаанбаатар хот 14200, СБД, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Парк Плэйс оффис, 403 тоот

info@golomtcapital.com

+976 7012 1530

www.golomtcapital.com

## ХУУЛИЙН ФИРМ

### “ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС” ХХН

Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Д.Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот

info@mdsa.mn

+976 11 330048, +976 11 330049

www.mdsa.mn

СЗХ 2024.06.10 БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## АУДИТЫН КОМПАНИ

**“ХҮЛЭГТХҮННҮ АУДИТ” ХХК**

Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Сити капитал, 4 давхар, 402 тоот

info@hulegthunnu.mn

+976 7014 0505

## ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИ

**“ФАЙН ЭСТИМЭЙТ” ХХК**

Монгол Улс, Улаанбаатар хот 14200, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Ялалт плаза 1002 тоот

halo_tsoomoo@yahoo.com

+976 8800 0267, +976 8886 1839

САХ
2024.06.10
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

## ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | Сэндли ББСБ ХК |
| Үнэт цаасны төрөл | Бонд буюу өрийн хэрэгсэл |
| Бондын арилжаа | Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй хүрээнд |
| Бондын төрөл | Тогтмол хүүтэй энгийн бонд |
| Нэгж бондын нэрлэсэн үнэ | 100,000.0 (нэг зуун мянга) төгрөг |
| Бондын нийт тоо, ширхэг | 100,000.0 (нэг зуун мянга) ширхэг |
| Бондын нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн | 10,000,000,000.0 (арван тэрбум) төгрөг |
| Бондын хугацаа | 24 (хорин дөрөв) сар |
| Бондын жилийн хүүгийн түвшин | 18.5 (арван найм аравны тав) хувь |
| Хүү төлөгдөх давтамж | Улирал тутамд (Бондын хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш улирал тутмын буюу 3 сар тутмын мөн өдрүүдэд хүүг төлөх бөгөөд хүүгийн төлбөр төлөх өдөр амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр төлнө.) |
| Үндсэн төлбөр төлөх | Хугацааны эцэст (Хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 24 дэх сарын мөн өдөр төлнө. Хэрэв амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр төлнө.) |
| Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт | Үндсэн үйл ажиллагаа буюу зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх |
| Бондын барьцаа | • Толгой компани нь өөрийн эзэмшиж буй үнэт цаас гаргагчийн 111,785,000 ширхэг хувьцааг холбогдох журмын дагуу барьцаалуулсан болно.<br>• Толгой компани нь эзэмшиж буй газар эзэмших хоёр эрхээ хөндлөнгийн үнэлгээний компанийн тогтоосон 2,811,280,000 төгрөг бүхий үнэлгээнд үндэслэн барьцаалуулсан. |
| Бондын хадгалалт, төлбөр тооцоо | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |

## ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ГАРГАСАН ШИЙДВЭР

“Сэндли ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 14 тоот тогтоолоор Компани нь нээлттэй өрийн хэрэгсэл гарган Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгох замаар хөрөнгө оруулалт татан төвлөрүүлж, зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

СЗХ
2024 .06. 10
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -05- 17
БҮРТГЭВ-02

Сэндли

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 24 оны 4 сарын 25-ны өдөр № 14 Улаанбаатар хот

***Нээлттэй өрийн хэрэгсэл гаргах тухай***

Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 41 дүгээр зүйл, 42 дугаар зүйлийн 42.1, 43 дугаар зүйлийн 43.1, 55 дугаар зүйлийн 55.2, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.6, 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 16 дугаар зүйл, "Сэндли ББСБ" ХК (*цаашид "Компани" гэх*)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.2, 8.6.12, 8.6.23, 8.10 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2024 оны 4 сарын 25-ны өдрийн тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

3. Компани нь нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 100,000 (нэг зуун мянга) ширхэг, нийт 10,000,000,000 (арван тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий нээлттэй өрийн хэрэгслийг ("Сэндли Бонд 2.0") Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгон арилжаалахаар гаргасугай.

4. Нээлттэй хүрээнд олон нийтэд санал болгох Бондын хэмжээ, төрөл, хугацаа, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт болон бусад нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.

5. Бондын эргэн төлөлтөд дор дурдсан хувьцаа болон газар эзэмших эрхийг толгой компани "Монголын финтек групп" ХК холбогдох хууль, журам, тогтоолын дагуу барьцаалуулж, баталгаа гаргаж буйг дурдсугай.

Хувьцаа:

| № | Барьцаа хөрөнгийн нэр | Барьцаалуулагчийн нэр | Тоо, ширхэг | Барьцааны зүйлийн үнэлгээ |
|---|---|---|---|---|
| 1 | "Сэндли ББСБ" ХК-ийн энгийн хувьцаа | "Монголын финтек групп" ХК | 111,785,000 | СЗХ-ны журамд зааснаар Монголын хөрөнгийн бирж дээрх хувьцааны сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшаар тооцсон үнэлгээний 70%-иар тооцох. |

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ 2024.08.10 өдөр БҮРТГЭВ № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

Газар эзэмших эрх.

| № | Барьцаа хөрөнгийн нэр | Хаяг талбайн хэмжээ | Улсын бүртгэлийн дугаар, гэрчилгээний дугаар | Хөрөнгийн үнэлгээний байгууллагын үнэлгээ |
|---|---|---|---|---|
| 1 | Зочид буудлын цогцолбор, олон нийтийн газар | Дорноговь аймгийн Замын-Үүд сум, 1-р баг Соёмбо 406 хаягт байрлах нэгж талбарын 4401010485 дугаар бүхий 10000 м.кв газар эзэмших эрх | Г-0000237626 Э-0714002972 | Хөндлөнгийн хөрөнгийн үнэлгээний "Файн Эстимэйт ХХК-ийн 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хөрөнгийн үнэлгээний тайлант үндэслэх |
| 2 | Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор зориулалттай | Дорноговь аймгийн Замын-Үүд сум, 1-р баг Соёмбо 320 хаягт байрлах нэгж талбарын 4401002556 дугаар бүхий 1200 м.кв газар эзэмших эрх | Г-0000237326 Э-0714002967 | |

6. **Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн тогтоолд дурдсан үүргийн дагуу Компанийн Гүйцэтгэх захирал нээлттэй хүрээнд Бонд гаргахтай холбоотойгоор Үндсэн андеррайтераар "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК, туслах андеррайтераар "Райнос инвестмент ҮЦК" ХХК, "Голомт капитал ҮЦК" ХХК, Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх байгууллагаар "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН, Аудитын дүгнэлт гаргах байгууллагаар "Хүлэгтхүнү аудит" ХХК-ийг тус тус сонгож, холбогдох гэрээ байгуулан ажиллаж байгаа болохыг дурдсугай.**
7. **Энэхүү тогтоолын дагуу Бондыг нийтэд санал болгохтой холбоотой үйл ажиллагааг зохион байгуулж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д үүрэг болгосугай.**
8. **Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих үүргийг Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Э.Цэлмэг)-д үүрэг болгосугай.**

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

2024.06.10
БҮРТГЭВ

Сэндли ББСБ" ХК-ийн 2024 оны 4-р сарын 25-ны өдрийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 14 дугаар тогтоолын Хавсралт №01

КОМПАНИЙН БОНДЫГ НЭЭЛТТЭЙ ХҮРЭЭНД
ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОХ НӨХЦӨЛ

| № | Үзүүлэлт | Нөхцөл |
|---|---|---|
| 1. | Үнэт цаас | Нээлттэй арилжаалах өрийн хэрэгсэл "Сэндли Бонд 2.0" |
| 2. | Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага | Монголын хөрөнгийн бирж |
| 3. | Үнэт цаасны төрөл | Энгийн хүүтэй бонд |
| 4. | Нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн | 10,000,000,000 *(арван тэрбум)* төгрөг |
| 5. | Бондын тоо ширхэг | 100,000 *(нэг зуун мянга)* ширхэг |
| 6. | Нэгж бондын нэрлэсэн үнэ | 100,000 *(нэг зуун мянга)* төгрөг |
| 7. | Бондын хугацаа | 24 *(хорин дөрөв)* сар |
| 8. | Бондын хүү (жилийн буюу 365 хоног) | 18.5% *(татварын өмнөх)* |
| 9. | Хүү төлөгдөх давтамж | Улирал тутамд |
| 10. | Үндсэн төлбөр төлөх хугацаа | Бондын хугацааны эцэст (24 сарын дараа) |
| 11. | Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт | Үндсэн үйл ажиллагаа буюу зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх |
| 12. | Нийтэд санал болгон гаргах хугацаа | 2024 оны III улирал (Зохицуулагч байгууллагын зөвшөөрлөөс шалтгаалан өөрчлөгдөж болно) |
| 13. | Бондын хадгалалт, төлбөр тооцоо | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |
| 14. | Бондын барьцаа/баталгаа | Компанийн толгой компани болох "Монголын финтек групп" ХК нь "Сэндли ББСБ" ХК-д өөрийн эзэмшиж буй 111,785,000 ширхэг энгийн хувьцаа, "Монголын финтек групп" ХК-ийн Дорноговь аймгийн Замын-үүд сум, 1-р баг Соёмбо, ТЗӨЧ-4 гудамжны 406 тоот хаягт байрлах Улсын бүртгэлийн дугаар Э-0714002972, газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар 0000237626, нэгж талбарын дугаар 4401010485 бүхий зочид буудлын цогцолбор, олон нийтийн газар зориулалттай, 10000 м.кв газар эзэмших эрх болон Дорноговь аймгийн Замын-үүд |

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ 2024-06-10 өдөр БҮРТГЭВ № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

| | | |
|---|---|---|
| | | сум, 1-р баг Соёмбо, ТЭӨЧ-3 гудамжны 320 хаягт байрлах, Улсын бүртгэлийн дугаар Э-0714002967, газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар 0000237326, нэгж талбарын дугаар 4401002556 бүхий Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор зориулалттай 1200 м.кв газар эзэмших эрх |
| 15. | Үндсэн андеррайтер | "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК |
| 16. | Туслах андеррайтер | "Райнос Инвестмент ҮЦК" ХХК болон "Голомт Капитал ҮЦК" ХХК |

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

Сэндли
БОНД 2.0

# 1. Үнэт цаас гаргагчийн тухай

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2024 -05- 17
БҮРТГЭВ-02

2024

ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР

ULZII & Co

ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР

RHINOS Investment

Golomt Capital

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

## 1.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

### 1.1.1. Үүсгэн байгуулагдсан тухай

Сэндли ББСБ ХК нь 2015 оны 05 дугаар сард "Гялс кредит" нэртэйгээр үүсгэн байгуулагдсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зээл, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, гадаад валютын арилжаа, итгэлцэл, факторинг, төлбөрийн баталгаа гаргах тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж буй **банк бус санхүүгийн байгууллага** юм.

*Зураг 1.* Үнэт цаас гаргагчийн 2022 оны IPO үйл ажиллагааны нээлт




Сэндли ББСБ ХК нь Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох зөвшөөрлийн дагуу хувьцаагаа олон нийтэд санал болгож анхдагч зах зээлийн арилжаагаа 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр Монголын хөрөнгийн бирж дээр эхлүүлсэн ба компанийн нийт хувьцааны 29.97 хувьтай тэнцэх 67.0 сая ширхэг энгийн хувьцааг нэг бүрийг нь 150 төгрөгөөр нийтэд санал болгон нийт 10,050,000,000.0 төгрөгийг амжилттай татан төвлөрүүлж, 3,000 гаруй хувьцаа эзэмшигчтэй, **нээлттэй хувьцаат компани** болсон билээ.

### 1.1.2. Үнэт цаас гаргагчийн эрхэм зорилго, үнэт зүйлс

*Схем 1.* Үнэт цаас гаргагчийн үнэт зүйлс, зорилго

**Алсын хараа**

Холыг ойртуулж, дэлхийн стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх

**Эрхэм зорилго**

Монголдоо байгаа мэт үйлчилгээг хүлээж авах боломжийг бүрдүүлж, технологиор дамжуулан санхүүгийн цогц үйлчилгээг саадгүй хүргэнэ.

СЭХ 2024.06.10 өдөр БҮРТГЭВ № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## Үнэт зүйлс

Цаг хугацаа хэмнэсэн найдвартай үйлчилгээг олон улсын стандартад нийцсэн технологиор хүргэх.

*Схем 2.* Үнэт цаас гаргагчийн голлох үзүүлэлтүүд, 2023 он

| Салбарын тоо | Нийт актив | Зээлийн багц |
|---|---|---|
| **57** УБ, Орон нутаг | **63.5** тэрбум.₮ | **42.3** тэрбум.₮ |

| Нийт ажилтан | Чанаргүй зээл | Зээлдэгчид |
|---|---|---|
| **112** | **5.4%** | **20.6к** идэвхтэй |

*Эх сурвалж:* Компанийн үйл ажиллагааны тайлан

### 1.1.1. Үнэт цаас гаргагч хуулийн этгээдийн бүртгэл, хаяг

*Хүснэгт 1.* Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэл

| | |
|---|---|
| **Хуулийн этгээдийн нэр:** | Сэндли ББСБ |
| **Хариуцлагын хэлбэр:** | Хувьцаат компани (Нээлттэй ХК) |
| **Биржид бүртгэлтэй эсэх:** | Монголын хөрөнгийн биржийн II ангилалд бүртгэлтэй (MSE: SEND) |
| **Үүсгэн байгуулагдсан огноо:** | 2015.05.04 |
| **Улсын бүртгэлийн дугаар:** | 9007001010 |
| **Регистрийн дугаар:** | 5961548 |
| **Гүйцэтгэх захирал:** | Балжинням овогтой Одгэрэл |
| **Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр** | 11,178,500.0 |
| **Хаяг:** | Монгол Улс, Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 40, 50 мянгат, Бакула ренбүчи гудамж, 8/4 тоот |
| **Утас:** | 7017-7700, 7799-7700 |
| **Цахим шуудан:** | contact@sendly.mn |
| **Факс:** | - |
| **Цахим хаяг:** | www.sendly.mn |

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

### 1.1.2. Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөл

“Сэндли ББСБ” ХК нь Монгол Улсын “Зөвшөөрлийн тухай хууль”, “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн №318 тогтоолоор “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл” авсан.

*Хүснэгт 2.* Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлүүд

| № | Тусгай зөвшөөрөл | Олгосон огноо |
|---|---|---|
| 1 | Зээл | 2015.07.03 |
| 2 | Гадаад валютын арилжаа | 2018.02.07 |
| 3 | Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ | 2018.02.07 |
| 4 | Факторинг | 2021.10.13 |
| 5 | Итгэлцэл | 2021.10.13 |
| 6 | Төлбөрийн баталгаа гаргах | 2021.10.13 |

### 1.1.3. Үнэт цаас гаргагчийн бизнесийн онцлох үйл явдлууд

*Зураг 2.* Компанийн IPO үйл ажиллагаа




Сэндли ББСБ нь 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр Монголын хөрөнгийн бирж дээр анх удаа олон нийтэд хувьцаагаа санал болгосон. Тус анхдагч зах зээлийн арилжаанд нийт 3,325 хөрөнгө оруулагчийн 11.5 тэрбум төгрөгийн захиалга хүлээн авч, IPO үйл ажиллагаа 115.2 хувийн давсан үзүүлэлттэйгээр амжилттай хаагдсан.

*Зураг 3.* Open invest 2022 Korea арга хэмжээ




Сэндли ББСБ нь 2022 оны 11 дүгээр сард БНСУ-д ажиллаж амьдарч буй Монгол Улсын иргэдэд Монголын хөрөнгийн зах зээлд гадаад улсаас оролцох боломж, хэрхэн хамгийн оновчтой хөрөнгө оруулалтыг хийх талаар мэдлэг, мэдээллийг хуваалцах зорилготой тус арга хэмжээнд хамтран зохион байгуулагчаар оролцсон.

СЭХ он сар өдөр БҮРТГЭВ №1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

*Зураг 4.* БНСУ-ын Шинхан Секьюритис компанитай хамтарсан санамж бичиг




БНСУ-ын хөрөнгийн зах зээлд олон жил үйл ажиллагаа явуулж буй "Шинхан Секьюритис" компанитай 2025 онд тус улсын KOSDAQ хөрөнгийн бирж дээр давхар бүртгэлтэй хувьцаа буюу DR (deposit receipt) гаргах үйл ажиллагаанд үндсэн зөвлөхөөр ажиллах гэрээ байгуулсан. Энэхүү компани нь БНСУ-ын хөрөнгийн биржид олон гадаад компанийг гаргасан туршлагатай юм.

*Зураг 5.* Хувьцаа эзэмшигчдийн хурал




Сэндли ББСБ ХК нь нээлттэй хувьцаат компани болсноор анхны хувьцаа эзэмшигчдийн хурлаа 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулж ТУЗ-ийн ердийн болон хараат бус нийт 9 гишүүдийг сонгож, нээлттэй хувьцаат компанийн дүрмээ баталсан. Мөн ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлаа 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр амжилттай зохион байгуулсан.

*Зураг 6.* Ногдол ашгийн бодлогын хэрэгжилт




Сэндли ББСБ нь 2022 оны цэвэр ашгаасаа татварын өмнөх дүнгээр нэгж хувьцаанд 2.7 төгрөг, нийт дүнгээр 614.8 сая төгрөгийн ногдол ашиг тараасан бол өнгөрсөн онд буюу 2023 оны цэвэр ашгаасаа нэгж хувьцаад 5.6 төгрөг, нийт 1.2 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараах шийдвэр гаргасан.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195
СТС2420

СЗХ
2024 06 10 өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

*Зураг 7.* Сэндли нээлттэй бонд




Сэндли ББСБ нь Монголын хөрөнгийн бирж дээр 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр анхны нээлттэй өрийн хэрэгслээ олон нийтэд санал болгож 8.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг амжилттай татан төвлөрүүлсэн. Тус өрийн хэрэгсэл гаргах үйл ажиллагаанд 3 андеррайтер компани оролцсон нь чухал онцлох үйл явдал байлаа.

*Зураг 8.* ISO Олон Улсын стандарт



Сэндли ББСБ нь үйл ажиллагаандаа Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO/IEC27001:2013 стандартыг бүрэн нэвтрүүлснийг баталгаажуулсан гэрчилгээг БНЭУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд М.П.Сингх гардуулан өгөв. Тус баталгаажуулалтыг Монсертф ХХК гүйцэтгэсэн байна.

*Зураг 9.* Paysend PLC компанитай хамтран ажиллах гэрээ




Сэндли ББСБ нь “Paysend” PLC-тэй хамтран ажиллах гэрээ байгуулснаар Монгол Улсаас 170 гаруй гадаад улс орон руу ердөө 10 минутын дотор мөнгөн гуйвуулга хийх боломжтой болсон. Мөн АНУ-ын Нью-Йорк, Мичиган мужаас Монгол Улс руу гүйлгээ хийх боломжтой гарцыг нээв.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

*Зураг 10.* Шинэ салбарын нээлт




Сэндли ББСБ нь Багануур дүүрэг, Ховд, Хөвсгөл аймагт шинээр салбараа нээснээр Улаанбаатар хотод 6, орон нутагт 51, нийт 57 салбартайгаар үйл ажиллагаагаа өргөжүүлэн, иргэдэд санхүүгийн үйлчилгээгээ түргэн шуурхай хүргэж байна. 2023 оны эцсийн тайлан мэдээллээр нийт зээлийн багцын 61.0% орон нутагт ногдож байна.

*Зураг 11.* БНХАУ-ын Alipay компанитай хамтын ажиллагаа эхлүүлэв




Сэндли ББСБ нь БНХАУ-ын “Ant Group”-ийн охин компанитай 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс албан ёсоор хамтын ажиллагаагаа эхлүүлснээр Олон Улсын мөнгөн гуйвуулгын Sendly аппликэйшнээр дамжуулан Монголчууд БНХАУ-ын иргэдийн Alipay данс руу түргэн шуурхай, найдвартайгаар мөнгөн гуйвуулга илгээх боломжтой болсон.

*Зураг 12.* Сэндли ББСБ ХК ТОП-20 индексэд багтав




2023 оны 01 дүгээр сард Монголын хөрөнгийн биржээс ТОП-20 индексийн багцыг шинэчлэн танилцуулсан ба тус багцад 2022 оны 10 дугаар сард IPO амжилттай гаргасан Сэндли ББСБ ХК багтсан. Мөн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс гаргасан 2023 оны эхний гурван улирлын байдлаарх үнэт цаасны төвлөрлийн судалгаагаар хамгийн их хувьцаа эзэмшигч нэмэгдсэн 5 компанийн нэгээр шалгарсан ба 2024 оны 3 дугаар сарын 22-ны мэдээллээр 6,916 хувьцаа эзэмшигч бүртгэгдсэн байна.

## 1.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Сэндли ББСБ ХК-ийн хамгийн том хувьцаа эзэмшигч нь толгой компани болох “Монголын финтек групп” хаалттай ХК нийт 56.42 хувийг эзэмшдэг бөгөөд олон нийт 29.97 хувь, “Сэндли Эмплойе” ХХК 8.95 хувь, Б.Наранбат 3.58 хувь, 0.77 хувийг Sendly аппликэйшнийг хөгжүүлэгч “Радикс технологи” ХХК, үлдсэн 0.31 хувийг компанийн 7 ажилтан тус тус эзэмшиж байна.

*Схем 3.* Хувьцаа эзэмшигчдийн бүтэц




*Тайлбар:* (*)-Давхардсан захиалгын тоогоор

*Хүснэгт 3.* Сэндли ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн жагсаалт

| № | Хувьцаа эзэмшигчийн нэр | Хувьцааны тоо ширхэг | Хувь эзэмшил, % |
|---|---|---|---|
| 1 | Монголын финтек групп хаалттай ХК | 126,141,700 | 56.4% |
| 2 | Олон нийт | 67,000,000 | 29.9% |
| 3 | Сэндли Эмплойе ХХК | 20,000,000 | 8.9% |
| 4 | Б.Наранбат | 8,000,000 | 3.6% |
| 5 | Радикс технологи ХХК | 1,714,200 | 0.8% |
| 6 | Б.Нямжаргал | 285,700 | 0.1% |
| 7 | З.Цолмон | 107,100 | 0.05% |
| 8 | Ч.Дашсүрэн | 71,400 | 0.03% |
| 9 | Л.Нарантуяа | 71,400 | 0.03% |
| 10 | О.Нямдэлэг | 71,400 | 0.03% |
| 11 | Г.Саруул-Од | 71,400 | 0.03% |
| 12 | Г.Гантуяа | 35,700 | 0.02% |
| | **Нийт** | **223,570,000** | **100.0%** |

### 1.2.1. Үнэт цаас гаргагчийн толгой компаниудын тухай

*Хүснэгт 4.* Үнэт цаас гаргагчийн толгой компаниудын мэдээлэл

| № | Компанийн нэр | Үйл ажиллагааны тухай |
|---|---|---|
| 1 | **Монгол мючуал Пте.Лтд**<br><br>(Регистр: 201912742с) | Тус компани нь 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр гадаадын өндөр хөгжилтэй улс орнуудтай төлбөр тооцоо саадгүй гүйцэтгэх боломжтой төлбөрийн системийн платформыг хөгжүүлэх, дэлхийн зах зээлд өөрийн охин компаниудыг сурталчлах, гадаадын хөрөнгө оруулалт татах зорилготой үүсгэн байгуулагдсан.<br>"Монгол мючуал Пте.Лтд" нь Сингапур улсад бүртгэлтэй ба тус компанийн 70%-ийг Монгол Улсын иргэн Б.Наранбат, 30%-ийг М.Цолмон нар эзэмшдэг. |
| 2 | **Монголиан мючуал финанс групп ХХК**<br><br>(Регистр: 6234151) | Тус компани нь 2017 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Монгол Улсын санхүүгийн болон технологийн салбарт шинэлэг, шуурхай үйлчилгээ нэвтрүүлэхэд хувь нэмрээ оруулах үндсэн зорилготойгоор үүсгэн байгуулагдсан.<br>"Монголиан мючуал финанс групп ХХК"-ийг "Монгол мючуал" Пте.Лтд 100% эзэмшдэг. |
| 3 | **Монголын финтек групп ХК**<br><br>(Регистр: 6692257) | Тус компани нь хаалттай хувьцаат компани бөгөөд финтек технологид суурилсан бизнес эрхлэгч өөрийн охин компаниудыг гадаад, дотоод хөрөнгө оруулагчидтай холбох, Олон Улсад тэдгээрийн бизнесийг таниулах, өргөжүүлэн тэлэх гүүр нь буюу Санхүүгийн холдинг компани болох зорилгоор байгуулагдсан.<br>"Монголын финтек групп" ХК-ийн нийт хувьцааны 85.3 хувийг "Монголын мючуал финанс групп" ХХК, үлдсэн 14.7 хувийг бусад жижиглэн хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна. |

### 1.2.2. Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компаниуд

*Схем 4.* Толгой компанийн охин компаниуд дахь хувь эзэмшил



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

2024.06.10

Хүснэгт 5. Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компаниудын мэдээлэл

| № | Компанийн нэр | Регистр | Үйл ажиллагааны тухай |
|---|---|---|---|
| 1 | Хайпэй ХХК | 6303277 | 2018 оноос эхлэн Монгол Улсад цахим төлбөр тооцооны иж бүрэн, найдвартай экосистемийг нэвтрүүлэх зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд финтек технологид суурилсан “Hi-pay” гар утасны аппликэйшнийг хөгжүүлж, төлбөр тооцооны цогц шийдлийг бий болгохоор ажиллаж байна. |
| 2 | Гялс төгрөг ХЗХ | 6125875 | 2016 онд үүсгэн байгуулагдсан ба 2021 оны эцсийн байдлаар нийт 15,395 гишүүнтэй болоод байна. Гялс төгрөг нь Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт нийт 52 салбар нэгжээр дамжуулан 12 төрлийн хадгаламж, зээлийн үйлчилгээг уламжлалт болон онлайн хэлбэрээр хослуулан хүргэж, салбартаа өөрийн байр суурийг эзлэн, дэвшилтэт технологийг амжилттай нэвтрүүлж чадсан хоршоо юм. |
| 3 | Хөүм Моргейж Корпорэйшн ХХК | 5463785 | 2011 онд үүсгэн байгуулагдсан, хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл бүхий компани юм. Тус компани нь гадаад улсад ажиллаж, амьдарч буй Монгол улсын иргэдэд санхүүгийн хүртээмжийг бий болгож, эх орондоо орон сууц худалдан авах боломжийг www.1home.mn вэб сайтаар дамжуулан олгох зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна. |
| 4 | Мастер шийдэл ХХК | 5908345 | Мастер шийдэл ХХК нь 2014 онд байгуулагдаж, 2015 оны 01 дүгээр сард “Даатгалын зуучлагч”-ын тусгай зөвшөөрлийг авснаар үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Тус компани нь “Hipay” аппликейшнээр дамжуулан даатгалын гэрээг онлайнаар зуучлан борлуулах “Hi-daatgal” платформыг хөгжүүлж буй даатгалын зуучлагч компани юм. |
| 5 | Инвестлаб Ви СИ ХХК | 6695388 | “Инвестлаб ви си” ХХК нь 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр байгуулагдсан, гарааны бизнест шаардлагатай санхүүжилтийг олгож, хууль эрх зүй, технологийн чиглэлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх зорилготой, олон улсын “Venture capital fund”-н үйл ажиллагааны зарчмаар ажиллаж буй компани юм. Одоогийн байдлаар “Инвестлаб ви си” ХХК - ийн хөрөнгө оруулалтын багцад 10 гаруй гарааны бизнес нэгдээд байна. |

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

| | | | |
|---|---|---|---|
| 6 | Стоклаб секьюритиз ҮЦК ХХК | 6695159 | “Стоклаб секьюритиз ҮЦК” ХХК нь 2021 онд Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрлөө авч, Гадаад улсад ажиллаж амьдарч буй болон Улаанбаатар хот, орон нутгийн харилцагчдадаа дэвшилтэт технологид суурилсан, төлбөрийн уян хатан нөхцөлтэй, хамгийн бага шимтгэлтэйгээр хөрөнгийн зах зээлийн зуучлалын үйлчилгээг үзүүлж байна. Тус компани нь дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтер, номинал данс эзэмших тусгай зөвшөөрөлтэй. |
| 7 | Ард Кредит ХХК | 6235085 | Арт Кредит ХХК нь 2017 оны 10 сарын 02-ны өдөр байгуулагдсан бөгөөд 2020 оны 11 сарын 25-ны өдөр Сангийн яамнаас “Эд мөнгөний хонжворт сугалаа гаргах” тусгай зөвшөөрлөө авсан. тус компанийн анхны тохирол нь 2022 оны 12 сарын 18-нд явагдсан бөгөөд лотерейн тохирлоо 7 хоногт тогтмол 2 удаа олон нийтийн телевизийн сувгуудаар шууд дамжуулж байна. |
| 8 | Мони маркет фанд ХХК | 6723721 | Мони маркет фанд нь 2021 оны 6 дугаар сард дөрвөн хувьцаа эзэмшигчтэйгээр үүсгэн байгуулагдсан. Тус компани нь сул чөлөөтэй, богино хугацаат эх үүсвэрийг нэгдсэн платформын тусламжтай, харилцан ашигтайгаар банк бус санхүүгийн байгууллагуудын хооронд зуучлах, тэдгээрийг холбох, цаашлаад мөнгөний зах зээлийн хамтын санг олон улсын жишигт нийцүүлэн байгуулах эрхэм зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Мони маркет фанд ХХК нь шинээр хадгаламжийн сертификатын үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна. |
| 9 | Корea ремитанс ХХК | 6695302 | Тус компани нь Монгол болон Солонгос улсын хооронд “Sendly” аппликэйшнээр дамжуулан мөнгөн гуйвуулгын үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор “Gmoney Transfer” компанитай хамтран ажиллаж байна. Одоогийн байдлаар “Корea ремитанс” ХХК нь БНСУ-д “Сэндли Монголиа” хэмээх охин компаниа байгуулж, тус улсын Санхүүгийн зохицуулах хорооноос мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авахаар ажиллаж байгаа |

## Бусад үүсгэн байгуулсан компаниуд

Үнэт цаас гаргагчийн толгой компани нь өөрийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “Сэндли эмплоуй” ХХК (*Регистр:* 5999782, *Үйл ажиллагааны чиглэл:* Бизнесийн зөвлөгөө өгөх, менежментийн зөвлөгөө өгөх), “Бим бокс лайт” ХХК, “Датапуул Монголиа” ХХК, “Хай лоялти” ХХК нарыг үүсгэн байгуулсан байгаа болович идэвхитэй үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

## 1.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

*Схем 5.* Компанийн бүтэц зохион байгуулалт




Сэндли ББСБ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн №22/08 тогтоолын дагуу Компанийн зохион байгуулалтын бүтцийг баталсан ба 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр ТУЗ-ийн №11 тогтоолоор ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн баталсан байна.

### 1.3.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

ТУЗ нь Аудит, эрсдэлийн удирдлагын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороо гэсэн байнгын 3 хороодтой байна. ТУЗ нь шаардлагатай тохиолдолд тодорхой асуудал хариуцсан, тусгай чиг үүрэг бүхий түр болон байнгын хороог байгуулах боломжтой байна.

ТУЗ-ийн хороод нь өөрсдийн чиг үүрэгт хамаарах асуудлаар дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, хууль, компанийн дүрэмд заасан зарим асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй. ТУЗ-ийн дэргэдэх хороог ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 10 тоот тогтоолоор шинэчлэн байгуулсан байна

#### Аудит, эрсдэлийн удирдлагын хороо

Аудит, эрсдэлийн удирдлагынхороо нь 3 гишүүнтэй байх бөгөөд хорооны дарга болон гишүүдийн 2/3 нь хараат бус гишүүн байна. Аудит, эрсдэлийн удирдлагын хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлж, тухайн асуудлаар дүгнэлт гарган ТУЗ-д танилцуулна.

- Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, бүртгэл нь олон улсын болон үндэсний стандартад нийцэж байгаа эсэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих;
- Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих;

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -05- 17
БҮРТГЭВ-02

СЗХ
2024 .06. 10
БҮРТГЭВ

- Хөндлөнгийн аудитын байгууллагатай харилцах бодлогыг боловсруулж, ТУЗ-өөр батлуулах, түүнийг хэрэгжүүлэх, хөндлөнгийн аудитыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох, уг байгууллагаас хийх шалгалтын болон гаргах дүгнэлтийн чиглэлийг тогтоох талаар санал боловсруулах;
- Аудит, эрсдэлийн удирдлагын хороо нь жилд нэгээс доошгүй удаа ТУЗ-д ажлаа тайлагнах бөгөөд ТУЗ-ийн хурал аудит, эрсдэлийн удирдлагын хорооны тайланг хэлэлцэн дүгнэлт гаргана.
- Аудит, эрсдэлийн удирдлагын хороо нь санхүүгийн мэдээллийн болон нягтлан бодох бүртгэлийн асуудлаар хөндлөнгийн аудитор болон дотоод хяналтын албатай байнга санал солилцдог байна.
- Дотоод хяналтын тогтолцоо нь үр дүнтэй байгаа эсэхэд хяналт тавьж дүгнэлт өгнө.

## Цалин урамшууллын хороо

Цалин урамшуулаллын хороо нь 3-аас доошгүй гишүүнтэй байх бөгөөд гишүүдийн 2/3 нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн цалин урамшууллын хороо нь дараах чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар санал, дүгнэлт боловсруулан ТУЗ-д танилцуулна. Үүнд:

- Компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, тогтмол судалгаа хийж, бодлогын хэрэгжилтэд хяналт тавих;
- Компанид мөрдөж буй ажлын үр дүнтэй холбосон аливаа урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх;
- Ажиллагсдын тэтгэврийн даатгалын болон хувьцаа эзэмшүүлэх аливаа хөтөлбөрийг судалж, сонголт хийх;

## Нэр дэвшүүлэх хороо

Нэр дэвшүүлэх хороо нь 3-аас доошгүй гишүүнтэй байх бөгөөд гишүүдийн 2/3 нь хараат бус гишүүн байна.

- Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн бүрэлдэхүүний аль нэг хүйсийн эзлэх хувийг гучаас доошгүй байх, ТУЗ-ийн дарга болон гишүүдийн олонхыг хараат бус болгох зорилтуудыг баримтлан ажиллана.
- Компанийн ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, тэдний ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
- ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүн нь энэ журамд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх, Компанийн тухай хуулийн 81.5.7-д заасан болон нэр дэвшигчид тавигдах шаардлага хангаагүй гэдэг үндэслэлээр нэр дэвшүүлэхээс татгалзах, тийнхүү татгалзсан бол нэр дэвшигч болон нэр дэвшүүлэхээр санал болгосон этгээдэд мэдэгдэх;
- ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх зарчмыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх;
- ТУЗ-д нэр дэвшигчийг сонгон шалгаруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх (саналын хуудсанд шууд нэрийг нь оруулах);
- Компанийн ТУЗ-ийн гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх захирлаас өгсөн үнэлгээтэй танилцаж, дүгнэлт гаргах;

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО
СТС2420

СЗХ 2024.06.10-ний өдөр БҮРТГЭВ № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2024-05-17
БҮРТГЭВ-02

1.3.2. Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөл

## ЕРДИЙН ГИШҮҮД



**Б.Наранбат**
**ТУЗ-ийн дарга**
**Санхүүч**

Банк санхүүгийн салбарт 17 жил ажилласан

**Туршлага**

2021-одоо Монголын финтек групп ХК, Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал
2018-одоо Хай пэймэнт солюшнс ХХК, Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал
2016 - одоо Гялс төгрөг ХЗХ, Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал
2013 - 2016 Төрийн банк, Санхүү хариуцсан дэд захирал, Гүйцэтгэх захирлын орлогч
2012 - 2013 Төрийн банк, Хөрөнгө зохицуулалтын газрын захирал
2008 - 2012 Сангийн яам: Санхүү эдийн засгийн бодлогын газар мэргэжилтэн



**Б.Эрдэнэ**
**ТУЗ-ийн гишүүн**
**Санхүүч**

Банк санхүүгийн салбарт 15 жил ажилласан

**Туршлага**

2017-одоо Техбокс ХХК, Гүйцэтгэх захирал
2016-2017 Төрийн банк, Актив, пассивын удирдлагын газрын захирал
2015-2016 Төрийн банк, Хяналт шалгалтын газрын захирал
2007-2015 Сангийн яам, Эрсдэлийн удирдлага дотоод аудитын газар Ахлах мэргэжилтэн



**М. Цолмон**
**ТУЗ-ийн гишүүн**
**Санхүүч**

Банк санхүүгийн салбарт 10 жил Хөдөө аж ахуй, уул уурхайн салбарт 7 жил ажилласан

**Туршлага**

2021-одоо Монголын финтек групп ХК, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
2017-одоо Монгол алт ХК, Гүйцэтгэх захирал
2014 - 2016 Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Гүйцэтгэх захирал
2008 - 2012 Сангийн яам, Санхүү эдийн засгийн бодлогын газар мэргэжилтэн



**Н.Билгүүн**
**ТУЗ-ийн гишүүн,**
**Санхүүч**

Банк санхүүгийн салбарт 9 жил ажилласан

**Туршлага**

2022-одоо Инвестлаб Ви Си ХХК, Гүйцэтгэх захирал
2021-2022 Дэлхийн банкны Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн зөвлөх
2018-2021 Селус Номадс ХХК-ийн ерөнхий менежер
2013-2018 Сангийн яам Санхүүгийн бодлогын газар мэргэжилтэн

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК 5183855 9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02



**Н.Цэвэгмид**
**ТУЗ-ийн гишүүн,**
**Эдийн засагч**

Хөрөнгийн зах зээлд 13 жил ажилласан

**Туршлага**

2021-одоо Райнос инвестмент ҮЦК ХХК, Дэд захирал

2016-2021 Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК ХХК, Гүйцэтгэх захирал

2014-2016 Дэу Секьюритис Монгол ҮЦК ХХК, Хөрөнгө оруулалтын менежер

2009-2014 Гаули ҮЦК ХХК, Дэд захирал



**Л.Нарантуяа**
**ТУЗ-ийн гишүүн**
**Хуульч**

Банк санхүүгийн салбарт 17 жил ажилласан

**Туршлага**

2022 - одоо Монголын Финтек Групп ХК-ийн Хууль, эрх зүй хариуцсан захирал

2018 - 2022 Монголиан Мючуал Финанс Групп ХХК, Хууль, эрх зүй хариуцсан захирал

2009- 2018 Төрийн банк, хууль эрх зүйн газар хуульч, Ахлах хуульч

2008-2009 Зоос банк, мэргэжилтэн

## ХАРААТ БУС ГИШҮҮД



**Б.Ануужин**
**ТУЗ-ийн хараат бус гишүүн**
**Аудитын хорооны дарга**

Банк санхүүгийн салбарт 12 жил ажилласан

**Туршлага**

2021-одоо Central TV, Бизнес хөгжил хариуцсан захирал

2018-2021 Австралийн худалдааны танхим, Гүйцэтгэх захирал

2015-2018 Эрнст энд янг монголиа аудит ХХК, Ахлах аудитор

2013-2015 Азийн сан, мэргэжилтэн, төслийн зохицуулагч, төслийн зөвлөх

2012-2013 Азийн сан, мэргэжилтэн



**Б.Цэлмэг**
**ТУЗ-ийн хараат бус гишүүн,**
**Эрсдлийн удирдлагын хорооны дарга**

Санхүүгийн зах зээлд 16 жил ажилласан

**Туршлага**

2022-одоо Ашид Ассет Менежмент ҮЦК ХХК, Хөрөнгө оруулалт хариуцсан захирал

2018-2022 Хас Банк, Санхүү газрын захирал

2015-2018 "Ээс Ээм Би Си" авиашн капитал, Санхүү төслийн менежер

2008-2015 "Жэй Пи Морган" Хөрөнгө оруулалтын сан, Татварын ахлах зөвлөх

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02



**Ц.Саруултуяа**
**ТУЗ-ийн хараат бус гишүүн, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хорооны дарга**

**Туршлага**
2021-одоо МУИС- БС, Ахлах багш
2017 -2019 Голомт Банк, Бизнес хөгжлийн менежер

Боловсролын салбарт 9 жил ажилласан

2012-2017 Тайвань, АИС ШУТИХ, Судалгааны төсөл
2007-2009 Голомт Банк, Судалгааны менежер



**Э.Цэлмэг**
**ТУЗ-ийн нарийн бичиг**
**Эрх зүйч**

**Туршлага**
2024.02–одоо Сэндли ББСБ ХК, ТУЗ-ийн нарийн бичиг
2023.11–2024.02 Монголын Финтек групп ХК, Хуулийн мэргэжилтэн

Санхүүгийн салбарт 2 жил ажилласан

2019–2023 Монголиан Эйрвэйс ХХК, Захиргаа эрх зүйн хэлтсийн менежер
2014-2019 Эмбасси Резидэнс ХХК, хуульч
2010-2024 Хүнну Эйр ХХК, хуулийн мэргэжилтэн

## 1.3.3. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын баг



**Б.Одгэрэл**
**ТУЗ-ийн гишүүн,**
**Гүйцэтгэх захирал**
**Санхүүч**

**Туршлага**
2021-одоо Сэндли ББСБ ХК, Гүйцэтгэх захирал
2016-2021 Гялс төгрөг ХЗХ, Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал

Банк санхүүгийн салбарт 18 жил ажилласан

2013-2016 Төрийн банк, Орон нутгийн зээлийн хэлтсийн захирал
2011-2013 Хадгаламж банк, Орон нутгийн зээлийн хэлтсийн захирал
2006-2011 Хаан банк, Теллер, эдийн засагч, ахлах эдийн засагч



**Х.Ичинхорлоо**
**Үйл ажиллагаа хариуцсан захирал**
**Нягтлан бодогч**

**Туршлага**
2021 - одоо Сэндли ББСБ ХК, Ерөнхий зохицуулалт хариуцсан захирал
2016 - 2021 Гялс төгрөг ХЗХ, Ерөнхий нягтлан бодогч

Банк санхүүгийн салбарт 25 жил ажилласан

2015 - 2016 Төрийн банк, Харилцааны менежер, мэргэжилтэн
2009-2014 Төрийн банк, Салбарын Ерөнхий нягтлан бодогч

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02



**П.Болорчулуун**
**Салбар, нэгж хариуцсан захирал**
**Санхүүч**

Банк санхүүгийн салбарт 20 жил ажилласан

**Туршлага**

2021-одоо Сэндли ББСБ ХК, Салбар, нэгж хариуцсан захирал

2013-2021 Төрийн банк, Тооцооны төвийн захирал

2010-2013 Хадгаламж банк, Дотоод аудитын газар, Ахлах аудитор

2004-2010 Монголшуудан банк, Эдийн засагч

---



**Д. Баярбат**
**Эрсдэл хяналт хариуцсан захирал**
**Санхүүч**

Банк санхүүгийн салбарт 17 жил ажилласан

**Туршлага**

2022-одоо Сэндли ББСБ ХК, Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан захирал

2017-2022 Гялс төгрөг ХЗХ, Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан захирал

2010-2017 Төрийн банк, Хяналт шалгалтын газрын ахлах хянан шалгагч

2007-2009 Анод банк, Эдийн засагч

---



**М.Мөнхгэрэл**
**Санхүү хариуцсан захирал**
**Эдийн засагч**

Санхүүгийн салбарт 12 жил ажилласан

**Туршлага**

2022 - одоо Сэндли ББСБ ХК, Санхүү хариуцсан захирал

2020 - 2021 НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр, Санхүүгийн ажилтан

2012 - 2017 Эрнст энд Янг Монголиа Аудит, Ахлах аудитор

---



**Н.Эрдэнэтулга**
**Мэдээлэл технологи хариуцсан захирал**
**Программист**

Банк санхүүгийн салбарт 18 жил ажилласан

**Туршлага**

2023 - одоо Сэндли ББСБ ХК, Мэдээлэл технологи хариуцсан захирал

2019 - 2023 Радикс технологи ХХК, Хөгжүүлэгч, Захирал

2010 - 2019 Төрийн банк, Программист

2010 - 2018 UST ХХК, Программ хөгжүүлэгч

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ он сар өдөр 20 10 БҮРТГЭВ № 1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02



**Э.Мөнхдэлгэр**
**Бүтээгдэхүүн хөгжүүлэлт хариуцсан захирал**
**Эдийн засгийн кибернетик**

Банк санхүүгийн салбарт 14 жил ажилласан

**Туршлага**

2022-одоо Сэндли ББСБ ХК, Бүтээгдэхүүн хөгжүүлэлт хариуцсан захирал
2016-2021 Гялс төгрөг ХЗХ, Ахлах менежер
2013-2016 Төрийн банк, Хүний нөөцийн газар, Сургалт хөгжлийн ахлах мэргэжилтэн
2009-2013 Хадгаламж банк, Хүний нөөцийн ахлах, Программ ашиглалт, хөгжүүлэлтийн ахлах
2008-2009 Финпак ХХК, Бүтээгдэхүүний мэргэжилтэн, эдийн засагч



**Б.Нямжаргал**
**Мөнгөн гуйвуулга хариуцсан дэд захирал**
**Эдийн засагч**

Банк санхүүгийн салбарт 13 жил ажилласан

**Туршлага**

2022-одоо Сэндли ББСБ ХК, Мөнгөн гуйвуулга хариуцсан захирал
2022-одоо Монголын ББСБ-уудын холбоо, Мэргэжлийн комплаенсийн хорооны дарга
2017-2018 Дэлхийн банк, Экспортыг дэмжих төслийн Бизнес хөгжүүлэлтийн ажилтан
2018 Дэлхийн банк, Экспортыг дэмжих төслийн Санхүүгийн дэмжлэгийн багийн ажилтан
2016-2017 Голомт банк, Харилцааны менежер
2010-2012 Вагнер Ази Тоног Төхөөрөмж ХХК, Ахлах нягтлан бодогч

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 2021031195 СТС24

СЗХ 2024 .08. 10 өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024 -05- 17 БҮРТГЭВ-02

## 1.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

### 1.4.1. "Sendly" аппликэйшний давуу тал, онцлог

Сэндли аппликэйшн нь олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг түргэн шуурхай, шимтгэл багатай хүргэхээс гадна Hipay аппликэйшнээр дамжуулан зээлийн бүтээгдэхүүн, төлбөр тооцооны үйлчилгээг харилцагч нартаа санал болгодог давуу талтай.

*Зураг 13.* "Sendly ба Hipay" аппликэйшн




### Олон улсын мөнгөн гуйвуулга

Үнэт цаас гаргагч нь олон улсын мөнгөн гуйвуулга хийх "Sendly" гар утасны аппликэйшнийг 2020 оны 5 дугаар сард зах зээлд амжилттай нэвтрүүлсэн. Тус аппликэйшнээр дамжуулан хамгийн бага шимтгэлтэйгээр АНУ-аас Монгол, Япон улсаас Монгол, Европын холбооны 27 улсаас Монгол, Монгол Улсаас БНХАУ, Монгол картын дугаар ашиглан 79 орон руу илүү хурдан, найдвартай албан ёсны эрхтэйгээр шилжүүлэг хийх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

*Зураг 14.* "Sendly" АНУ-аас Монгол Улс руу шилжүүлэх мөнгөн гуйвуулга



Анх **2020 оны 5 дугаар сард** АНУ-ын 33 мужаас Монгол Улс руу мөнгөн гуйвуулга хийх боломжтой болсноор "Sendly" Мөнгөн гуйвуулгын үйлчилгээг эхлүүлсэн. Сүүлийн байдлаар Сэндли ББСБ нь АНУ-д мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий **Machnet LLC** компанитай АНУ-ын 50 мужид үйлчилгээгээ тэлэхээр хамтран ажиллаж байна. "Sendly" аппликэйшнийг АНУ-аас дансаа бүртгүүлэхэд аливаа хүндрэл гаргахгүй байхаар загварчилсан бөгөөд **Plaid систем** (АНУ-ын арилжааны банкуудын нэгдсэн систем) дэмжин ажиллаж байна. Энэхүү систем нь Sendly аппликэйшнийг АНУ-д үйл ажиллагаа явуулж буй **5,000** орчим банктай холбогдож ажиллах боломжоор хангадаг юм.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

Зураг 15. "Sendly" Япон улсад




Сэндли ББСБ ХК нь мөнгөн гуйвуулгын **City Express** компанийн Япон дахь салбартай хамтран ажилладаг бөгөөд **2021 оны 11 дүгээр сараас** эхлэн Япон улсаас Монгол улс руу мөнгөн гуйвуулга хийж эхэлсэн билээ. Япон улсад мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг гурван түвшинд олгодог бөгөөд хамтран ажиллагч City Express компани нь 2 дугаар түвшний зөвшөөрөлтэй компани болно.
Мөн **Japan Post** банкны 30,000 гаруй КИОСК машиныг ашиглан шилжүүлэг хийх боломжтой.

Зураг 16. "Sendly" Европын холбооны улс орнуудад

MONREMIT money transfer

Сэндли ББСБ ХК-ийн Англи улс дахь охин компани болох **MonRemit Limited** нь 2021 онд Англи улсын Санхүүгийн зохицуулах хороо болох FCA (Financial Conduct Authority)-оос Англи болон Европын холбооны орнуудад үйл ажиллагаа явуулах **API** (Authorized Payment Institution) тусгай зөвшөөрлийг авсан.
Одоогоор Европын холбооны 27 улсаас Монгол Улс руу мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж байна.

Зураг 17. "Paysend" хамтын ажиллагаа




**2023 оны 9 дүгээр сард** "Paysend" PLC-тэй хамтран ажиллах гэрээ байгуулснаар Монгол Улсаас **170 гаруй гадаад улс орон** руу ердөө 10 минутын дотор мөнгөн гуйвуулга хийх боломжтой болсон.
**"Paysend" PLC** нь банкны картаар (Visa эсвэл MasterCard) олон улсын мөнгөн гуйвуулга илгээх, хүлээн авах боломжийг олгодог хэрэглэгчдэд ээлтэй, хялбар үйлдлийн системтэй, аюулгүй байдлын дэвшилтэт технологи бүхий санхүүгийн платформ юм.
Ингэснээр "Sendly" аппликэйшн нь Монгол Улсаас дэлхийн 170 гаруй оронд байгаа **хүлээн авагчийн банкы карт** руу түргэн шуурхай, найдвартай аргаар шилжүүлэг хийх боломжийг хэрэглэгчдэдээ олгож байна.

Зураг 18. "WeChat Pay" хамтын ажиллагаа




Сэндли ББСБ ХК нь 2021 онд БНХАУ-ын **"WechatPay"** үйлчилгээний Монгол Улс дахь албан ёсны түнш байгууллага болсон бөгөөд "WechatPay" төлбөр тооцооны үйлчилгээг нэвтрүүлснээр Монгол Улсад суугаа Хятад улсын иргэд төлбөрийн хялбар систем ашиглах, Монгол Улсын бизнес эрхлэгчид бараа бүтээгдэхүүнээ БНХАУ-д худалдаалан төлбөр тооцоогоо хийх боломж бүрдсэн юм.
Сэндли ББСБ ХК нь 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдөр Хятад улсын төлбөр тооцооны аппликэйшн болох **"Alipay"**-тэй хамтран ажиллах гэрээ байгуулсан Монгол Улсын хамгийн анхны цорын ганц байгууллага юм. Sendly аппаар дамжуулан Alipay хэтэвчээ **1 минутын дотор** цэнэглэх боломжтой.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

## Цахим зээлийн үйлчилгээ

*Зураг 19.* "Sendly" аппликэйшн дээрх цахим зээлийн үйлчилгээ



Хэрэглэгч, харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээг хангах зорилгоор сар бүр тэнцүү төлбөр хийх нөхцөлтэй 12 сарын хугацаатай зээлийн шугамын эрх, **"Hipay"** аппликэйшн дахь бүтээгдэхүүн үйлчилгээний төлбөрийг төлөх боломжтой **"E-zeel"** үйлчилгээ, даатгалын зээл зэрэг Sendly цахим зээлийн үйлчилгээг "Hipay" болон "Hipay-Merchant" аппликэйшнээр дамжуулан гар утаснаасаа авах боломжийг нэвтрүүлээд байна. Үүнээс гадна уламжлалт аргаар авсан орон сууцны зээл, лизинг, хөрөнгө барьцаалсан зээл гэх мэт бусад төрлийн зээлүүдийнхээ үлдэгдлийг хянах, эргэн төлөлтөө хийх зэрэг зээл олголтоос бусад үйлчилгээг "Hipay" болон "Hipay-Merchant" аппликэйшнийн **"Sendly зээл"** дэд цэсээр дамжуулан авах боломжтой юм.

## Мерчант зээлийн үйлчилгээ

*Зураг 20.* "Sendly" аппликэйшн дээрх мерчант зээлийн үйлчилгээ



Жижиг дунд бизнес эрхлэгч, үйлдвэрлэгчдэд зориулсан богино хугацааны **эргэлтийн хөрөнгийг** санхүүжүүлэх зорилготой мерчант зээлийн үйлчилгээний хэрэглэгч болсноор тухайн бизнес эрхлэгчдэд 1.0 сая төгрөг хүртэлх зээлийн шугам нээгдэхээс гадна тухайн бизнес эрхлэгчдэд нэмэлт үнэлгээ, судалгаа хийгдсэнээр **10.0 сая хүртэлх төгрөгийн** зээлийг 12 сарын хугацаанд шугамаар авч ашиглах боломжтой эрх олгох, хялбар, шуурхай давуу талыг бий болгосон үйлчилгээ юм.

Сэндли ББСБ нь зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагч нартаа хүргэхдээ толгой компани Монголын финтек групп хаалттай ХК-ийн охин компани болох ХайПэй ХХК-ийн Hipay аппликэйшний системээр дамжуулж зээл олгодог ба эргэн төлөлтийн автомат таталт, картаа холбох боломжийг олгодог.

СЗХ
2024 он 05 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

*Схем 6.* Мерчант зээлийн онцлогууд

- Боломжит эрхийн хүрээнд хүссэн үедээ зээл авах
- Зээл авах бүрт төлбөрийн хуваарь 30 хоногийн хугацаанд өдөр бүр төлөх нөхцөлтэйгээр шинэчлэгдэх
- Өдөр бүр бага дүнгээр эргэн төлөлт хийснээр зээлдэгч санхүүгийн ачаалалд өртөхгүй байх
- Зээл төлөлтийн гүйлгээ Hipay аппликэйшнд холбосон картнаас автоматаар төлөх
- Харилцагч цахим хэтэвч, эсвэл арилжааны банк дахь картны данснаасаа зээлээ шууд төлөх
- Зээлээ хугацаандаа төлбөл хүү тооцохгүй давуу талтай

## Шуурхай төлбөр тооцоо

*Зураг 21*. “Sendly” аппликэйшн дээрх төлбөр тооцоо



“Sendly” аппликэйшнээр дамжуулан бизнес эрхлэгч нь өдөр тутмын орлогоо хянах, мерчантууд НӨАТ-ын баримт олгох, QR кодоор төлбөр тооцоо гүйцэтгэх, картаа аппликэйшнтэй холбосон бол зээл төлөхдөө үйлдэл хийх шаардлагагүй зэрэг давуу талтай. Мөн “Sendly” аппликэйшн нь сайн дурын нийгмийн даатгал, онлайн дэлгүүр, Дэлхийн Монгол төгөл, үнэт цаасны арилжаа, зуучлал зэрэг үйлчилгээ үзүүлдэг.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195
СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## 1.4.2. Зээлийн үйл ажиллагаа

### Зээлийн багц

*График 1.* Нийт зээлийн багц ба идэвхтэй харилцагчдын тоо




*Эх сурвалж:* Компанийн үйл ажиллагааны тайлан

Сэндли ББСБ-ын нийт зээлийн багц 2024 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар 53.5 тэрбум төгрөгт хүрсэн ба 2023 оны жилийн эцсийн дүнгээс 26.5 хувиар өссөн. Зээлийн үлдэгдэлтэй идэвхтэй харилцагчдын тоо 2024 оны 1 дүгээр улиралд 26.7 мянга хүрсэн бол 2023 онд идэвхтэй харилцагчдын тоо өмнөх оноос даруй 3 дахин өссөн. Энэхүү өсөлтөнд “Sendly” аппликэйшнээр олгосон цахим зээлдэгчдийн тоо өссөн нь нөлөөлсөн.

*График 2.* Зээлийн багцын ангилал, (тэрбум төгрөг)







*Эх сурвалж:* Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан

Сэндли ББСБ-ын зээлийн багцыг зориулалтаар авч үзвэл худалдаа эрхлэгч нарт олгосон зээл нь нийт зээлийн багцын 21.9 хувь, хэрэглээний зээлийн дүн 24.5 хувь, автомашин барьцаалсан зээл 7.0 хувийг, зээлийн шугам 24.1 хувь тус тус эзэлж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2024-05-17
БҮРТГЭВ-02

Зээлийн багцын чанарын хувьд 2024 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар хэвийн зээлийн багц 92.8 хувь, анхаарал хандуулах зээл 2.3 хувь байгаа бол чанаргүй зээлийн хэмжээ 4.9 хувь байна.

*График 3.* Зээл олголт (тэрбум төгрөг) ба зээлийн тоо




*Эх сурвалж:* Компанийн үйл ажиллагааны тайлан

Сэндли ББСБ-ын олгосон зээлийн хэмжээ 2023 онд 210.0 тэрбум төгрөгт хүрсэн ба 2021 онтой харьцуулахад 16 дахин, 2022 онтой харьцуулбал 2.7 дахин өссөн үзүүлэлт юм. Мөн олгосон зээлийн тоо 2021 онтой харьцуулахад 62 дахин нэмэгдэж 509.7 мянган удаагийн зээл олгожээ.

*График 4.* Зээлдэгчдийн хүн ам зүйн шинж чанар




*Эх сурвалж:* Компанийн санхүүгийн тайлан

2024 оны нэгдүгээр улирлын байдлаар зээлийн үлдэгдэлтэй харилцагчдыг насны бүлгээр ангилбал 18-35 насны залуучууд нийт идэвхтэй зээлдэгчдийн 63.0 хувийг эзэлж байгаа бол 36-55 насны бүлгийн зээлдэгчид 32.5 хувийг, 55-аас дээш насны зээлдэгчид үлдсэн 4.4 хувийг бүрдүүлж байна. Хүйсийн хувьд эмэгтэй зээлдэгчид 55 хувийг эзэлж байна.

2024 оны 01 дүгээр улирлын байдлаар Сэндли ББСБ-ын нийт зээлийн багцын 41% буюу 21.7 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэл Улаанбаатар хотод ногдож байгаа бол үлдсэн 59% буюу 31.7 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэл орон нутгийн харилцагч нарт ногдож байна.

*График 5.* Зээл олгосон хэлбэр




*Эх сурвалж:* Компанийн санхүүгийн тайлан

2023 онд аппликэйшнээр олгосон зээл 34.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй буюу нийт зээлийн багцын 81.8 хувийг, уламжлалт аргаар олгосон зээлийн үлдэгдэл 7.7 тэрбум төгрөг буюу 18.2 хувийг тус тус эзэлж байна.

### 1.4.3. Олон Улсын мөнгөн гуйвуулга

Сэндли ББСБ-ын үйл ажиллагааны нэг гол сегмент болох олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь 2023 оны байдлаар нийт 31.6 мянган хэрэглэгчтэй ба дундаж гуйвуулгын дүн 1.1 сая төгрөг байна. 2023 оны эцсийн байдлаар нийт 338.0 мянган удаагийн 35.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж гүйцэтгэжээ.

*Схем 7.* Мөнгөн гуйвуулгын мэдээлэл, 2023 он




*Эх сурвалж:* Компанийн үйл ажиллагааны тайлан

СЗХ 2024.05.10 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ 02

Олон улсын мөнгөн гуйвуулгын хэмжээгээр АНУ, Япон, Австрали улсаас Монгол Улс руу хийгдэх гүйлгээний дүн буурсан. Харин Европын холбооны улс орнуудаас Монгол Улс руу, Alipay, Wechat гүйлгээний үнийн дүн нэмэгджээ. Тухайлбал 2023 онд гадаад хамтын ажиллагааны үр дүнд Alipay, Wechat мөнгөн гуйвуулгын дүн өмнөх оноос 261 дахин өссөн үзүүлэлттэй байна.

*Хүснэгт 6.* Мөнгөн гуйвуулга, мөнгөн дүнгээр

| № | Гүйлгээ | Симбол | Гүйлгээний мөнгөн дүн* | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2022 | 2023 | | |
| 1 | АНУ - Монгол | USA-MGL | 6,214,513 | 6,158,444 | ▼ | -1% |
| 2 | Япон - Монгол | JPN-MGL | 59,915,451 | 55,200,151 | ▼ | -8% |
| 3 | Австрали - Монгол | AUS-MGL | 561,048 | 337,975 | ▼ | -40% |
| 4 | Монгол – Австрали | MGL-AUS | 465,192 | 267,910 | ▼ | -42% |
| 5 | Европын холбоо – Монгол | EU-MGL | 429,085 | 2,363,687 | ▲ | x5.5 |
| 6 | Alipay, Wechat гүйлгээ | - | 11.7 | 3,061.7 | ▲ | x261.7 |

***Тайлбар:*** ** - Тухайн гадаад улсын валютаар*

Мөнгөн гуйвуулгын тоог авч үзвэл АНУ, Европын холбоо, AliPay, Wechat гүйлгээний тоо 2023 онд өмнөх оноос тус бүр өссөн бол Япон, Автсралиас Монгол Улс руу хийгдсэн гүйлгээ, Монгол Улсаас Автсрали руу хийгдсэн гүйлгээний тоо багассан байна.

*Хүснэгт 7.* Мөнгөн гуйвуулгын тоо

| № | Гүйлгээ | Симбол | Гүйлгээний тоо | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2022 | 2023 | | |
| 1 | АНУ–Монгол | USA-MGL | 22,788 | 23,435 | ▲ | 3% |
| 2 | Япон–Монгол | JPN-MGL | 1,087 | 656 | ▼ | -40% |
| 3 | Австрали–Монгол | AUS-MGL | 1,052 | 906 | ▼ | -14% |
| 4 | Монгол–Австрали | MGL-AUS | 413 | 188 | ▼ | -54% |
| 5 | Европын холбоо–Монгол | EU-MGL | 1,599 | 7,165 | ▲ | x4.5 |
| 6 | Alipay, Wechat гүйлгээ | - | 1,629 | 38,895 | ▲ | x23.9 |

*Эх сурвалж:* Компанийн үйл ажиллагааны тайлан

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

### 1.4.4. Үнэт цаас гаргагчийн нийгмийн хариуцлага

*Зураг 22.* "Аутист артистууд" хөгжмийн наадам




Монголын Аутизмын Холбоо аутизмтай авьяаслаг хүүхэд залуусын хөгжмийн наадмыг Монгол Улсын Филармонитай хамтран 2023 оны 10 дугаар сард анх амжилттай зохион байгуулсан. Тус "Аутист артистууд" хөгжмийн наадмыг Сэндли ББСБ дэмжигч байгууллагаар оролцов.

*Зураг 23.* Улаанбаатар марафон 2023




"Улаанбаатар марафон 2023" Олон Улсын гүйлтийг хоёр дахь жилдээ ерөнхий зохион байгуулагч байгууллагаар ажилласан бөгөөд залуу үеийнхэнд өөрийн дотоод нөөц боломжийг нээх, зорилгодоо хүрэх тэсвэр хатуужлыг олж авах, иргэдийн өдөр тутам биеийн тамираар хичээллэх идэвхи санаачлагыг дэмжин ажилласан.

*Зураг 24.* Ид шидийн орон төсөл



Сэндли ББСБ ХК-ийн Хэнтий салбар нь Мегаболл ХХК-тай хамтран Ид шидийн орон төсөлд тоглоом, ном, үнэ бүхий зүйл, 2023 оны 08 дугаар сард 2-р цэцэрлэгийн тусгай бүлгийн хүүхдүүдэд тоглоом бэлэглэсэн. Мөн 2022 онд алслагдсан дүүргүүдийн 100 хүүхдэд дулаан хувцас, гарын бэлэг хүргэн ажиллалаа.

*Зураг 25.* Тэрбум мод үндэсний хөдөлгөөн




"Дэлхийн Монголчуудын төгөл" төслийн хүрээнд 2023 оны 05 дугаар сард хоёр дахь удаагаа мод тарив. Тус төсөл нь дэлхийн өнцөг булан бүрт амьдарч буй Монголчууд эх орондоо байгаа хайртай дотны хүмүүстээ хүндэтгэл үзүүлэх, үр хойчдоо ногоон ирээдүй өвлүүлэх зорилгоор дурсгалын модыг хамтдаа тарьдаг уламжлалтай.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

*Зураг 26.* Хорт хавдрын эсрэг аян



Нийгмийн хариуцлагын хүрээнд Үнэт цаас гаргагч нь зээлийн хүүгийн орлогын 1.0 хувийг хавдрын эсрэг сайн үйлсийн аян болон хавдрын эсрэг эмч мэргэжилтнүүдийг мэргэжил дээшлүүлэхэд зориулдаг. Энэ хүрээнд Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирал, "Эрүүл хүнс, хавдаргүй иргэн" ТББ, "Элэг нэгт монголчууд" ТББ-н тэргүүн Ж.Чинбүрэнтэй хамтран ажиллаж байна. Эрүүл хүнс, Хавдаргүй иргэн төрийн бус байгууллагаар дамжуулан "Монгол улсад амьд донороос элэг шилжүүлэн суулгах төсөл"-д нийт 124.8 сая төгрөг хандивлаж, 9 хүний алтан амийг аврах үйлсэд хувь нэмэр оруулжээ.

## 1.4.5. Үнэт цаас гаргагчийн шагнал, урамшуулал

*Зураг 27.* Компанийн шагнал, урамшуулал

Fastest Growing FinTech Company in Central Asia



2021 оны 12 дугаар сард "Global Banking & Finance Review" сэтгүүлээс жил бүр тодруулдаг "Төв Азийн хамгийн хурдацтай хөгжиж буй Финтек компани 2021" шагналыг "Sendly" аппликейшн хүртсэн юм.

Best solution of The Year-Bloomberg




2021 онд Монгол Улсын хөгжилд бодит хувь нэмэр оруулж, бизнесийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн шилдгүүдийг тодруулдаг "Bloomberg TV Mongolia Awards"-д High Payment Solutions амжилттай оролцов.

Алтан Од-2023 Шагналын эзэн



Монголын Банк бус санхүүгийн байгууллагын холбооны "Оны шилдэг санхүүгийн хүртээмжтэй ББСБ" Алтан од 2023 шагналын эзэн болсон.

Forbes Mongolia Finance Awards 2021



2021 оны 12 дугаар сард "Forbes Mongolia Finance Awards 2021"-ийн "Шилдэг мөнгөн гуйвуулгын аппликейшн" шагналыг хүртсэн.

## 1.5. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

Үнэт цаас гаргагч нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаартай тогтоолоор "Эрсдэлийн удирдлагын бодлого"-ыг баталсан ба 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн №12 тоот ТУЗ-ийн тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан. Тус эрх зүйн баримт бичигт эрсдэлийн удирдлагын тодорхойлолт, зорилт, үндсэн зарчим, төрөл, ангилал, хэрэгжүүлэх үе шат, шинжилгээ, тайлагнал, хяналт хариуцлагын талаар тусган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд "Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх журам" болон "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр"-ийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 06 тоот тогтоолоор, "Дотоод хяналтын үйл ажиллагааны журам"-ыг Гүйцэтгэх захирлын 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн А/10 тоот тушаалаар шинэчлэн баталсан байна.

Сэндли ББСБ-ын зээлийн эрсдэлийн бодлогын хүрээнд нэг зээлдэгчид олгох зээлийн дээд дүнг бага байлгах, төвлөрлийн эрсдэлийг боломжит доод түвшинд барих бөгөөд 2023 оны эцсийн байдлаар нэг зээлдэгчид ногдох зээлийн дүн 1.8 сая төгрөг байна. Чанаргүй зээлийн эзлэх хувь 2023 оны сүүлийн байдлаар нийт зээлийн багцын 5.4 хувийг эзэлж байна. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 2019 оноос хойш бүрэн хангаж ажиллажээ.

### Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг:

"Сэндли ББСБ" ХК нь эрсдэлийг тодорхойлохдоо өөрийн стратегийн хэрэгжилт, үйл ажиллагаанд тодорхойгүй сөрөг байдал үүсэх магадлал болон түүний нөлөөллөөр хэмжихээр тогтоожээ.

Эрсдэлийг удирдахдаа хараат бусаар үнэлгээ хийх, тогтмол сайн тайлагналтай байх, байнга сайжруулалт хийж байх, эрдсэл нь хэмжигдэхүйц байх, баримтжуулсан байх, эрх мэдлийн төвлөрлийг хязгаарлах, эдийн засгийн үр ашигтай байх зэрэг зарчмыг мөрдөнө.

### Эрсдэлийн удирдлагын бүтэц – Хамгаалалтын 3 шугам

Компани нь эрсдэлийн удирдлагыг нэгдсэн байдлаар хэрэгжүүлэх ба эрсдэлийн удирдлагын төвлөрсөн бүтэцтэй байна. Эрсдэлийн удирдлагын чиг үүргийг компанийн бүтэц, зохион байгуулалтанд **"Хамгаалалтын 3 шугам"**-ын хүрээнд дараах байдлаар тусгана. Үүнд:

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

- Төлөөлөн удирдах зөвлөл – Компанийн эрсдэлийн удирдлагын үндсэн чиг хандлагыг тодорхойлж, стратеги, зарчмыг тодорхойлно.
- Дотоод хяналт хариуцсан албан тушаалтан – Компанийн эрсдэлийн удирдлагын бодлогын хэрэгжилт, компанийн засаглалын болон бүтэц зохион байгуулалтын уялдаа холбоо, үр дүнтэй байдал, компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж буй бодлого, журмын хэрэгжилтэд хяналт тавьж, ТУЗ-д тайлагнана.
- Гүйцэтгэх удирдлага – ТУЗ-ийн тодорхойлсон эрсдэлийн удирдлагын стратеги, зарчмыг ББСБ-ын үйл ажиллагаанд мөрдүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- Бусад нэгжүүд – Эрсдэлийг илрүүлэх, өдөр тутмын үйл ажиллагаандаа эрсдэлийг зохистой түвшинд удирдах үүрэгтэй.

## Эрсдэлийн төрөл, тэдгээрийг удирдах зарчим

"Сэндли ББСБ" ХК-ийн үйл ажиллагаанд учирч болох үндсэн эрсдэлүүдийг дараах байдлаар ангилсан байна. Үүнд:

- ### Зээлийн эрсдэл

  Зээлийн үйл ажиллагаанаас учрах эрсдэл болон хүлээгдэх өгөөжийг хамгийн оновчтой түвшинд байлгахад зээл төлөгдөхийг баталгаажуулсан хангалттай нотолгоо, итгэл үнэмшлийг олж авсны эцэст зээлийг олгох, аливаа зээлийн чанар муудах нөхцөл байдлыг эрт илрүүлэх, эрсдэлийн шинжилгээг хараат бусаар хийх, зээлийн багцыг тархаан байршуулах зэрэг зарчмыг баримтлана.

- ### Зах зээлийн эрсдэл

  Зах зээлийн таагүй нөхцөл байдлын улмаас үүсэх хохирлыг хамгийн бага түвшинд барин ажиллана. Ингэхдээ зах зээлийн өөрчлөлтийг ажиглаж, мэдрэх, мэдээллийн тасралтгүй солицох урсгалыг компани дотроо бий болгох, тогтоосон хязгаарт эрсдэлийг хамгийн бага түвшинд барьж ажиллахыг эрмэлзэнэ. Эрсдэлийн түвшин зөвшөөрсөн хязгаараас давсан тохиолдолд залруулах арга хэмжээг шуурхай авна. Зөвшөөрсөн эрсдэлийн хязгаарт хяналтыг байнга тавьж, тайлан боловсруулж Эрсдэлийн удирдлагын хороонд тогтмол танилцуулна.

- ### Үйл ажиллагааны эрсдэл

  Тус эрсдэлд хүний хүчин зүйлээс хамаарсан ажилтны санаатай, санамсаргүй үйлдэл, дотоод үйл ажиллагааны доголдол, алдаатай эсхүл дутуу зохицуулсан үйл явц, журам, заавар, мөн автоматжуулсан системийн доголдол, гадаад хүчин зүйлийн сөрөг нөлөөллийн улмаас хохирол хүлээх эрсдэлийг тодорхойлжээ. Уг эрсдэлтэй холбогдох удирдлагын хэрэгжүүлэхдээ ажилтан бүр, нэгж, алба тус бүр эрдэлийг цаг алдалгүй

илрүүлэх, бүртгэх, тодорхойлох, урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг авч ажиллана.

- Хөрвөх чадварын эрсдэл:

Энэ төрлийн эрсдэлийн гол удирдлагын хувьд зах зээлийн хэвийн, хэвийн бус нөхцөлд аливаа гуравдагч этгээдийн өмнө гэрээгээр хүлээсэн бүрэн гүйцэтгэж чадахуйц бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрвөх чадвартай хөрөнгийн зохистой нөөцтэй байх, түүнчлэн компанийн ашигт ажиллагааг зохистой түвшинд барихад анхаарна. Хөрвөх чадварыг богино, дунд, урт хугацаанд ангилж шинжлэх, макро эдийн засгийн судалгаа, хүндрэл учирсан үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан баталж, шаардлагатай үед шинэчилж ажиллана.

- Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл:

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл нь байгууллагын бүх төрлийн мэдээлэлд зөвшөөрөлгүй нэвтрэх, ашиглах, задруулах, тасалдуулах, өөрчлөх, устгах зэргээс үүдэн гарч болзошгүй аюул хохирол эрсдэлийг ойлгоно. Иймд компанийн мэдээлэл бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдал хангагдсан байх шаардлагатай. Мөн сүлжээ, сүлжээнд холбогдох тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангаж, мэдээллийн аюулгүй байдлын зөрчлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг журмаар зохицуулна. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг бэлтгэл, эрсдэл тооцоолох, эрсдэлийн түвшинг үнэлэх, эрсдэлийг бууруулах зөвлөмж гаргах гэсэн дөрвөн үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ.

- Байгаль орчин, нийгэм засаглал (ESG)-ын эрсдэл:

Байгаль орчны эрсдэлийн хамрах хүрээ нь эрчим хүчний хэрэглээ болон хэмнэлт, хүлэмжийн хийн ялгарал, уур амьсгалын өөрчлөлт, усны удирдлага, хог хаягдлын асуудлыг хамруулах бол нийгмийн эрсдэлд хүний нөөцийн хөгжил, эрх тэгш байдал, хүртээмжтэй орчин, оролцоо, нийгмийн хариуцлага, ил тод байдал, тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээний удирдлагыг хамруулна. Засаглалын эрсдэлд авлига, ёс зүй, хууль эрх зүйтэй холбоотой эрсдэлийн удирдлагыг хамруулах ба байгаль орчин, нийгэм засаглалын эрсдэлийг эрсдэлийн шинжилгээ хийх, тодорхойлох, үнэлэх байдлаар гүйцэтгэнэ.

- Нэр хүндийн, стратегийн болон комплаенсийн эрсдэл:

Компанийн нэр хүндэд хохирол учруулж, улмаар санхүүгийн тайланд сөрөг нөлөө үүсэх эрсдэлийг хүндийн эрсдэл хэмээн хэлэх бөгөөд ажилтан бүр ёсзүйн дүрмийг чандлан дагаж, харилцагчтай харилцах харилцаа, үйлдэл, үйл ажиллагааг хянаж компанийнхаа нэр хүндийг ямагт хамгаалах үүрэгтэй.

Байгууллагын нөөцийг үр ашиггүй зарцуулснаас үүдэх бизнесийн болон үйл ажиллагааны зорилгодоо хүрч чадахгүйд хүрэх, бизнес төлөвлөгөөний хэрэгжилт тааруу, зах зээлийн өөрчлөлттэй дасан зохицох чадвар бага зэргээс үүдэн бизнесийн өсөлт буурах, алдагдал хүлээх эрсдэлийг стратегийн эрсдэлд хамааруулна.

Компанийн үйл ажиллагаанд хамаарах, мөрдөгддөх хууль тогтоомж, журам, зааварт нийцүүлж үйл ажиллагаа явуулах чадамж алдагдах эрсдэлийг комплаенсийн эрдэл гэж ойлгох бөгөөд эрсдэл, хяналтын тогтолцоонд **хамгаалалтын гурван шугамын** загварыг үйл ажиллагаанд мөрдлөг болгоно.

### Эрсдэлийн удирдлагын процесс:

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| Эрсдэлийг тодорхойлох | Эрсдэлийг үнэлэх | Эрсдэлийг удирдах | Хяналт |

### Эрсдэлийг тодорхойлох, үнэлэх

ББСБ-ын газар, нэгж нь үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд гадаад, дотоод орчны хүчин зүйлсийг шинжлэн эрсдэлийг цаг алдалгүй тодорхойлно. Эрсдэлийн төрөл бүрт чанарын болон тоон шинжилгээг хийн эрсдэлийн түвшинг тогтоож цаашид авах арга хэмжээний хувилбарыг тодорхойлон шийдвэр гаргалтанд дэмжлэг үзүүлнэ.

### Эрсдэлийн удирдлага, хяналт

1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүсэх эрсдэл, хохирол, орлогоос хамаараад эрсдэлийг хүлээн зөвшөөрөх.

2. Эрсдэлийн үнэлгээний үр дүнд өндөр эрсдэлтэй гэж тодорхойлогдсон эсвэл тухайн үйл ажиллагааны эрсдэлийг хангалттай тодорхойлох боломжгүй тохиолдолд уг үйлчилгээг нэвтрүүлэхээс зайлсхийх.

3. Эрсдэлийн төрөл тус бүрт зохистой эрсдэлийн хязгаар тогтоож, эд хөрөнгө, үйлчилгээ, шаардлагатай тохиолдолд ажилтныг даатгалд хамруулж болзошгүй хохирлоос хамгаална. Эрсдэлийн төрөл тус бүрийн эрсдэлийн үзүүлэлт бүрт хяналт тавьж ажиллана.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

СЗХ
өдөр
БҮРТГЭВ
№ 1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

## 1.6. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ИХ ХЭМЖЭЭНИЙ БА СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

*Хүснэгт 8.* Компанийн сүүлийн 3 жилд байгуулсан их хэмжээний ба сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээлэл

| № | Хэлцэл | Тодорхойлолт | Хэвийн хэрэгжиж байгаа | Хэрэгжиж дууссан | Нийт хэлцлийн тоо |
|---|---|---|---|---|---|
| 1 | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | КтХ-ийн 89.1 дүгээр хэсэгт заасны дагуу | 28 | 30 | 58 |
| 2 | Их хэмжээний хэлцэл | КтХ-ийн 87.1 дүгээр хэсэгт заасны дагуу | 1 | 1 | 2 |
| 3 | Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий хэлцэл | ҮЦЗЗтХ -ийн 10.5.7-дахь хэсэгт заасны дагуу | 9 | 12 | 21 |

*Эх сурвалж:* Хуулийн дүгнэлт, (КтХ-Компанийн тухай хууль, ҮЦЗЗтХ-Үнэт цаасны зах зээлийн тухай хууль)

## 1.7. НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Сэндли ББСБ ХК нь 2023 онд хувьцаа эзэмшигч нартаа 2022 оны цэвэр ашгаасаа татварын өмнөх дүнгээр нэгж хувьцаанд 2.75 төгрөг, нийт 614,817,500 төгрөгийн ногдол ашиг хуваарилсан ба 2024 онд нэгж хувьцаанд 5.6 төгрөг, нийт 1,251,992,000 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн.

*Хүснэгт 9.* Ногдол ашгийн мэдээлэл

| № | Шийдвэрийн огноо | Нэгж хувьцаанд тараах ногдол ашиг | Ногдол ашгийн хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | 2023.02.06 | 2.75 төгрөг | 614,817,500 |
| 2 | 2024.02.19* | 5.60 төгрөг | 1,251,992,000 |
| | **Нийт** | - | **1,866,809,500** |

*Эх сурвалж:* Монголын хөрөнгийн бирж

**Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 49 дугаар тогтоолоор санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор тарааж, ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлж байхыг нэлттэй хувьцаат компаниудын удирдлагад даалгасны дагуу Сэндли ББСБ ХК нь ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 07 тоот тогтоолоор ногдол ашиг хуваарилах тухай шийдвэртээ өөрчлөлт оруулж, ногдол ашиг олгох өдрийг Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон өдөрт багтаан буюу 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр болгон өөрчлөн тогтоосон болно.*

УЛААНБААТАР ХОТ
ЭНД КО
ҮЦК
ХХК
5183855
9021031195
СТС2420

СЗХ
2024 он 05 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ 02

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын №22/03 дугаартай тогтоолын хавсралтаар баталсан "Ногдол ашгийн бодлого"-ын баримт бичигт дараах агуулгыг тусгасан байна.

## Ногдол ашиг хуваарилах нөхцөл

- Нэг төрлийн нэгж хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна;
- Компани дор дурдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилж болно. Үүнд:
  - компанийн тухайн жилийн цэвэр ашгийг тухайн жилийн дундаж өөрийн хөрөнгөнд харьцуулсан харьцаа 20 хувиас багагүй байх;
  - шийдвэр гаргах өдрийн байдлаарх зээлийн багцын чанар байдал;
  - ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;
  - ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;
  - компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэн авах нөхцөл байдал үүссэн, өрийн хэрэгслээ эргүүлэн худалдан авах хугацаа болсон бол эдгээр үнэт цаасыг бүрэн эргүүлэн авсан, эсхүл бүрэн худалдан авахад шаардагдах хөрөнгөтэй байх;
  - Компанийн дүрэм, эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт заасан тусгай зориулалтын сангуудад зориулсан хуваарилалтыг бүрэн хийсний дараа хуваарилагдаагүй цэвэр ашиг үлдэж байгаа;
- Компани нээлттэй хувьцаат компани болсон үеэс эхлэн ТУЗ-ийн тогтоолоор татварын дараах цэвэр ашгийн 20 болон түүнээс дээш хувийг ногдол ашиг болгон хувьцаа эзэмшигчдэд хуваарилна.

## Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр

- Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг тухайн санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. ТУЗ шийдвэртээ нэг хувьцаанд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг олгох хэлбэр, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан мэдээлэлтэй хамт мэдээлэл хүргүүлнэ.
- Ногдол ашгийг бэлэн мөнгө, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаас хэлбэрээр төлж болно.
- Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг нийтэд мэдээлж, хувийг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржийн мэдээллийн нэгдсэн санд хүргүүлнэ.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 CTC2420

СЗХ
2024 .06 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -05- 17
БҮРТГЭВ-02

- Жилийн тайланд тусгах мэдээлэлд ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн тусгасан байх бөгөөд ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн бол түүний үндэслэлийг энэ журмын дагуу тайлбарласан байна.
- Компани ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнах бөгөөд тайлбартаа ногдол ашиг хуваарилах боломжгүй байдалд хүрсэн шалтгаан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлбар зэргийг тусгасан байна.

## Ногдол ашиг хуваарилах, тайлагнах

- Ногдол ашиг төлөх хэлбэр, олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна.
- Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ногдол ашгийг ТУЗ-өөс тогтоосон хугацаанд төлөөгүйгээс компанид учирсан хохирлыг гүйцэтгэх захирал болон холбогдох бусад албан тушаалтнууд хариуцна.
- Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан бол төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтөлнө.
- Ногдол ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХК дахь хувьцаа эзэмшигчийн дансанд шилжүүлэх бодлого баримтална.
- Ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын санхүүгийн тайлан гаргах үед “Ногдол ашгийн хуваарилалтын тайлан”-г гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195
СТС2420

Сэндли БОНД 2.0

# 2. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн гүйцэтгэл, шинжилгээ

ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР

ULZII & Co CAPITAL

ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР

Invescore Investment

Golomt Capital

## 2.1. 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ДҮГНЭЛТ

"Хүлэгтхүнну аудит" ХХК нь Сэндли ББСБ ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж дараах дүгнэлтийг гаргасан.

"Бид, компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт"-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна гэж дүгнэж байна" хэмээн дүгнэсэн байна.

## 2.2. СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

*Хүснэгт 10.* Санхүү байдлын тайлан, (мянган төгрөг)

| | 2021 | 2022 | 2023 | 2024.Q1* |
|---|---|---|---|---|
| Хөрөнгө | | | | |
| Эргэлтийн хөрөнгө | | | | |
| Мөнгөн хөрөнгө | 1,169,363.3 | 8,391,786.6 | 14,238,843.3 | 5,857,182.3 |
| Цэвэр зээл | 8,600,430.5 | 22,474,462.8 | 40,682,714.5 | 51,634,137.2 |
| Нийт зээл | 8,608,223.5 | 23,138,779.1 | 42,332,439.4 | 53,475,616.8 |
| Эрсдэлийн сан | (7,793.0) | (664,316.3) | (1,649,725.0) | (1,841,479.6) |
| Хуримтлуулж тооцсон хүү | 503,235.4 | 1,473,141.2 | 3,745,522.0 | 4,125,201.6 |
| Байгууллагаас авах авлага | - | 792,911.8 | 2,306,497.7 | 1,986,404.9 |
| Бусад авлага | 2,250.0 | 699,562.7 | 974,585.6 | 969,494.8 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 119,721.7 | 671,007.2 | 939,975.3 | 1,168,807.9 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 10,395,000.9 | 34,502,872.2 | 62,888,138.3 | 65,741,228.7 |
| Үндсэн хөрөнгө, (цэвэр) | 168,744.3 | 184,288.1 | 275,505.2 | 242,621.6 |
| Биет бус хөрөнгө, (цэвэр) | 40,890.0 | 204,119.2 | 363,609.6 | 400,492.4 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 209,634.3 | 388,407.3 | 639,114.8 | 643,113.9 |
| Нийт хөрөнгө | 10,604,635.2 | 34,891,279.5 | 63,527,253.2 | 66,384,342.6 |
| Өр төлбөр | | | | |
| Банк санхүүгийн байгууллагаас авсан зээл | 100,000.0 | 2,227,897.5 | 5,950,000.0 | 5,216,211.6 |
| Бусад эх үүсвэр | 2,580,000.0 | 11,136,820.3 | 29,665,053.3 | 31,336,495.0 |
| ББСБ-аас гаргасан өрийн бичиг | - | - | 8,500,000.0 | 8,500,000.0 |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 2,580,000.0 | 10,436,891.0 | 19,490,968.4 | 22,581,552.6 |
| Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | - | 699,929.3 | 1,674,084.9 | 254,942.5 |
| Бусад өглөг | 777,430.8 | 100,761.1 | 1,058,488.0 | 913,614.5 |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | 3,457,430.8 | 13,465,478.9 | 36,673,541.2 | 37,466,321.1 |
| Нийт өр төлбөрийн дүн | 3,457,430.8 | 13,465,478.9 | 36,673,541.2 | 37,466,321.1 |
| Эздийн өмч | | | | |
| Энгийн хувьцаа | 6,428,500.0 | 11,178,500.0 | 11,178,500.0 | 11,178,500.0 |

СЗХ 2024 он 06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

| | | | | |
|---|---|---|---|---|
| Нэмж төлөгдсөн капитал | - | 6,284,799.7 | 6,284,799.7 | 6,284,799.7 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | 718,704.7 | 3,947,784.0 | 9,375,306.3 | 11,439,925.9 |
| Нийгмийн хөгжлийн сан | - | 14,716.8 | 15,106.0 | 14,796.0 |
| Эздийн өмчийн дүн | 7,147,204.7 | 21,425,800.5 | 26,853,711.9 | 28,918,021.5 |
| Өр төлбөр ба эздийн өмчийн дүн | 10,604,635.5 | 34,891,279.4 | 63,527,253.2 | 66,384,342.6 |

*Хуснэгт 11*. Орлогын дэлгэрэнгүй тайлан, (мянган төгрөг)

| | 2021 | 2022 | 2023 | 2024.Q1* |
|---|---|---|---|---|
| Хүүгийн орлого | 558,315.6 | 3,825,090.4 | 14,902,346.8 | 4,855,235.7 |
| Хүүгийн зардал | 1,436.6 | 530,699.6 | 1,952,023.8 | 691,859.5 |
| Цэвэр хүүгийн орлого | 556,879.0 | 3,294,390.8 | 12,950,323.1 | 4,163,376.3 |
| Хүүгийн бус орлого | 1,808,592.0 | 7,834,850.1 | 6,705,320.2 | 1,325,447.0 |
| Мөнгөн гуйвуулгын шимтгэлийн орлого | 260,027.5 | 314,704.9 | 544,060.2 | 64,393.5 |
| Арилжааны орлого | - | 240,127.4 | 237,087.5 | 19,710.4 |
| Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого | 241,171.6 | 1,695,144.6 | 1,178,203.7 | 133,515.2 |
| Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | 1,237,621.5 | 5,189,558.7 | 4,447,139.5 | 1,107,407.9 |
| Бусад орлого, олз | 69,771.4 | 395,314.6 | 298,829.3 | 420.0 |
| Хүүгийн бус зардал | 1,706,887.8 | 7,724,424.4 | 12,774,009.8 | 3,196,567.6 |
| Бусад эрсдэлийн сангийн зардал | - | 656,523.3 | 985,898.0 | 191,754.7 |
| Арилжааны зардал | - | 29,178.4 | 69,250.1 | 12,144.8 |
| Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал | 157,130.8 | 1,422,839.1 | 985,768.8 | 63,932.7 |
| Хураамж, шимтгэлийн зардал | 273,468.6 | - | - | 527,821.7 |
| Итгэлцлийн үйлчилгээний хүүгийн зардал | 27,825.5 | 943,921.1 | 3,485,369.0 | 902,115.8 |
| Цалин хөлсний зардал | 432,481.4 | 1,639,252.2 | 2,871,505.9 | 989,409.4 |
| Зар сурталчилгааны зардал | 176,223.2 | 511,017.7 | 464,178.4 | 87,838.2 |
| Элэгдэл, хорогдлын зардал | 33,368.9 | 123,164.9 | 210,785.8 | 48,366.8 |
| Түрээсийн зардал | 130,681.6 | 197,267.1 | 165,822.3 | 49,020.5 |
| Үйл ажиллагааны бусад зардал | 475,707.8 | 2,097,133.0 | 3,364,091.2 | 301,347.9 |
| Бусад зардал, гарз | - | 104,127.6 | 171,340.3 | 22,815.1 |
| Цэвэр хүүгийн бус орлого зардлын дүн | 101,704.2 | 110,425.8 | (6,068,689.6) | (1,871,120.6) |
| Болзошгүй эрсдэлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг/алдагдал | 658,583.2 | 3,404,816.6 | 6,881,633.5 | 2,292,255.7 |
| Болзошгүй эрсдэлийн зардал | 7,793.0 | - | | - |
| Үйл ажиллагааны ашиг | 650,790.2 | 3,404,816.6 | 6,881,633.5 | 2,292,255.7 |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | - | - | - | - |
| Үндсэн бус үйл ажиллагааны зардал | 30,346.3 | - | - | - |
| Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал | 620,443.9 | 3,404,816.6 | 6,881,633.5 | 2,292,255.7 |
| Орлогын татварын зардал | 45,236.2 | 340,530.6 | 826,199.6 | 227,852.8 |
| Цэвэр ашиг | 575,207.7 | 3,064,286.0 | 6,055,433.9 | 2,064,402.9 |

УЛААНБААТАР ХОТ ... ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 ...2420

СЗХ
он сар өдөр
2024 05 16
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

*Хүснэгт 12.* Мөнгөн гүйлгээний тайлан, (мянган төгрөг)

| | 2021 | 2022 | 2023 | 2024.Q1* |
|---|---|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 274,700.50 | 7,316,357.40 | 6,024,679.80 | (8,328,845.9) |
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого | 2,199,391.70 | 21,293,747.60 | 19,518,124.43 | 5,524,925.7 |
| Зээлийн хүүгийн орлого | 558,315.6 | 3,816,023.8 | 13,851,931.5 | 4,453,734.8 |
| Үнэт цаасны хүүгийн орлого | - | 9,066.6 | - | - |
| Харилцах дансны хүүгийн орлого | - | - | 15,621.6 | 9,923.9 |
| Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого | - | - | 124.4 | 11,897.5 |
| Гадаад валютын арилжааны орлого | 59,386.2 | 203,887.1 | 167,837.3 | 7,565.6 |
| Үнэт цаасны арилжааны орлого | - | 36,240.3 | - | - |
| Гадаад валютын ханшийн зөрүү | 84,040.9 | 1,695,144.6 | 192,434.9 | 69,582.5 |
| Мөнгөн гуйвуулгын орлого | 260,027.5 | 314,704.9 | 544,060.2 | 64,393.5 |
| Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | 1,237,621.5 | 5,189,558.7 | 4,447,285.6 | 907,407.9 |
| Бусад үйлчилгээний орлого | - | 10,029,121.6 | 298,829.0 | 420.0 |
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага | 1,924,691.20 | 13,977,390.20 | 13,493,444.63 | 13,853,771.6 |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал | - | 530,699.6 | 462,887.9 | 329,711.5 |
| Өрийн бичгийн хүүд төлсөн мөнгө | | | 1,502,334.2 | 406,882.2 |
| Үндсэн ба нэмэгдэл цалин | 380,426.1 | 1,362,591.4 | 2,385,643.7 | 997,087.4 |
| Ажилтнуудад олгосон нөхөн олговор, тэтгэмж | - | 4,837.7 | 30,837.4 | 24,459.9 |
| Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал | 43,510.2 | 169,538.2 | 298,066.7 | 104,907.5 |
| Албан томилолт, сургалтын зардал | 8,545.1 | 102,284.8 | 156,958.1 | 82,137.9 |
| Ашиглалтын зардалд төлсөн мөнгө | 131,949.2 | 211,062.2 | 282,611.0 | 9,259.0 |
| Шатахуун, холбоо, интернэт, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө | 47,544.4 | 99,363.6 | 163,814.1 | 42,449.6 |
| Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал | 14,416.2 | 57,504.0 | 62,547.9 | 18,778.1 |
| Зар сурталчилгаанд төлсөн мөнгө | 176,223.2 | 511,017.7 | 486,178.4 | 137,838.2 |
| Үнэт цаас болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбоотой гарсан мөнгө | - | 10,173.4 | 189,849.3 | 47,462.3 |
| Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө | 274.5 | 100.0 | 18,589.4 | 3,585.1 |
| Итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбогдох гарсан мөнгө | 27,825.5 | 943,921.1 | 3,585,369.0 | 1,150,793.6 |
| Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө | 275,647.4 | 440,456.1 | 820,923.8 | 485,078.4 |

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК

| | | | | |
|---|---|---|---|---|
| Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө | - | 4,100.0 | 2,880.0 | 5,600.0 |
| Ногдол ашгаар олгосон мөнгө | - | - | 614,817.5 | - |
| Татвар даатгалд төлсөн мөнгө | - | - | 420,368.6 | 534,628.6 |
| Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө | 818,329.4 | 9,529,740.4 | 2,008,767.5 | 9,473,112.3 |
| **Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **(30,346.3)** | **(93,934.0)** | **(177,623.1)** | **(52,815.1)** |
| Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого | - | 10,193.6 | - | - |
| Бусад | - | 10,193.6 | - | - |
| Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага | 30,346.3 | 104,127.6 | 177,623.1 | 52,815.1 |
| Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал | 19,803.0 | 77,454.8 | 160,308.2 | 52,332.1 |
| Торгуулийн зардал | - | 1,409.6 | - | |
| Бусад | 10,543.3 | 25,263.2 | 17,314.9 | 483.0 |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **244,354.2** | **7,222,423.4** | **5,847,056.7** | **(8,381,661.1)** |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 925,009.10 | 1,169,363.3 | 8,391,786.7 | 14,238,843.4 |
| **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **1,169,363.30** | **8,391,786.7** | **14,238,843.4** | **5,857,182.3** |

*Эх сурвалж:* Аудитлагдсан санхүүгийн тайлан, (*)-Урьдчилсан санхүүгийн тайлан

## 2.3. НИЙТ АКТИВЫН БҮТЭЦ

Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар 66.3 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны эцсээс 4.5 хувиар буюу 2.8 тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт зээлийн багц 2023 оны аудитлагдсан дүнгээр 42.3 тэрбум төгрөг буюу 2022 онтой харьцуулахад даруй 1.8 дахин нэмэгдэж, 2024 оны эхний гурван сарын байдлаар 53.4 тэрбум төгрөгт хүрээд байна.

*График 6.* Нийт актив ба зээлийн багц, (сая төгрөг)




*Эх сурвалж:* Компанийн санхүүгийн тайлан

Сэндли ББСБ-ын нийт активыг хөрөнгө талаас задалбал эрсдэлийн сангийн дараах цэвэр зээлийн дүн нийт активын 77.8 хувь буюу 51.6 тэрбум төгрөг, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 8.8 хувь буюу 5.8 тэрбум төгрөг эзэлж байгаа бол бусад хөрөнгийн хэсэг 13.4 хувь буюу 8.9 тэрбум төгрөг тус тус эзэлж байна. 2024 оны 1 дүгээр улиралд тус цэвэр зээлийн багцын хэмжээ 2023 оны эцсээс 10.9 тэрбум төгрөгөөр буюу 26.9 хувь өссөн байна.

*График 7.* Нийт активын бүтэц, (сая төгрөг)




*Эх сурвалж:* Компанийн санхүүгийн тайлан

Нийт активын бүтцийг эх үүсвэр талаас харвал 2022 онд өөрийн хөрөнгө өр төлбөрөөс 1.6 дахин өндөр байсан бол 2023 онд тус харьцаа 0.7 болж өр төлбөрөөр санхүүжүүлэх хөрөнгийн дүн өсжээ.

*График 8.* Зээлийн багцын чанар




*Эх сурвалж:* Компанийн санхүүгийн тайлан

Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн 77.8 хувийг бүрдүүлж буй зээлийн багцын чанаргүйдэл 2024 оны 1 дүгээр улиралд 4.9 хувь болж өнгөрсөн оны эцсээс 0.6 пунктээр сайжирсан ба 2022 оноос хойш чанаргүй зээлийн хувь аажмаар буурах хандлага харуулж байна.

СЗХ сар өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## 2.4. АШИГТ АЖИЛЛАГАА, ӨГӨӨЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Үнэт цаас гаргагч нь 2023 оны жилийн үзүүлэлтээр 6.0 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан ба 2022 оноос ойролцоогоор 2.0 дахин нэмэгдсэн өсөлтийг харууллаа. Цэвэр ашгийн дүн өсөхөд цэвэр хүүгийн орлого 3.2 тэрбум төгрөгөөс 12.9 тэрбум төгрөгт хүрч 4.0 дахин өссөн нь нөлөөлсөн.

*График 9.* Нийт цэвэр орлого ба цэвэр ашиг (сая төгрөг)




*Эх сурвалж:* Компанийн санхүүгийн тайлан

Компанийн хүүгийн бус орлого 2023 онд 1.1 тэрбум төгрөгөөр буюу ойролцоогоор 14.4 хувиар буурахад хураамж шимтгэлийн орлого 0.7 тэрбум төгрөгөөр, мөн валютын ханшийн тэгшитгэлийн орлого төгрөгийн чангаралтай холбоотой 0.5 тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлсөн.

*График 10.* Хүүгийн бус орлогын бүтэц, (сая төгрөг)




*Эх сурвалж:* Компанийн санхүүгийн тайлан

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

*График 11.* Ашигт ажиллагаа, өгөөжийн үзүүлэлт




*Эх сурвалж:* Компанийн санхүүгийн тайлан

Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн өгөөж сүүлийн гурван жилд тасралтгүй өсөж байгаа ба 2023 оны аудитын баталгаажсан санхүүгийн үр дүнгээс тооцож үзэхэд нийт хөрөнгийн өгөөж (ROA) 22.5 хувьд хүрч өсжээ. Харин өөрийн хөрөнгийн өгөөж 2023 онд 9.5 хувь буюу өнгөрсөн оноос 0.7 пунктээр нэмэгдэж, цэвэр ашгийн ахиуц 30.8 хувьд хүрсэн ашигт ажиллагаатай үйл ажиллагаагаа явуулж байна.

## 2.5. САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ

*График 12.* Өр төлбөрийн бүтэц, (сая төгрөг)




*Эх сурвалж:* Компанийн санхүүгийн тайлан

Санхүүжилтийн эх үүсвэрээс өр төлбөрийн бүтцийг салгаж харвал 2023 онд итгэлцлийн үйлчилгээгээр татсан эх үүсвэр 19.4 тэрбум төгрөгт хүрч 2022 оноос 86.7 хувиар буюу 9.0 тэрбум төгрөгөөр өссөн. Мөн 2023 онд 8.5 тэрбум төгрөгийн бондыг олон нийтээс амжилттай татсан бол бусад банк, санхүүгийн байгууллагаас олгосон зээлийн санхүүжилт 5.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй буюу нийт өр төлбөрийн 16.2 хувийг эзэлж байна.

Сэндли ББСБ-ын санхүүгийн хөшүүрэг сүүлийн гурван жилд тасралтгүй өсөж байгаа бөгөөд 2023 оны эцсийн байдлаар 1.3 буюу өр төлбөрийн дүн өөрийн хөрөнгөөс давсан үзүүлэлттэй байна. Харин хүү төлөх чадварын харьцаа 4.3 буюу хүүгийн төлбөр төлөх чадамж сайн байна.

*Хүснэгт 13.* Өр төлбөрийн харьцаа үзүүлэлт

| Харьцаа үзүүлэлт | 2021А | 2022А | 2023А | 2024.Q1* |
|---|---|---|---|---|
| Санхүүгийн хөшүүрэг (Өр төлбөр/Эздийн өмч) | 0.4 | 0.6 | 1.3 | 1.3 |
| Нийт хөшүүрэг (Нийт хөрөнгө/Эздийн өмч) | 1.5 | 1.6 | 2.4 | 2.3 |
| Хүү төлөх чадварын харьцаа (Хүү татварын өмнөх ашиг/Хүүгийн зардал) | 432.9 | 7.4 | 4.5 | 4.3 |

*Эх сурвалж:* Андеррайтерийн тооцоолол

Үнэт цаас гаргагчийн нийт хөшүүргийн харьцаа итгэлцлээр татсан эх үүсвэрийн өсөлттэй холбоотойгоор 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар 2.3 буюу финтек зээлийн үйл ажиллагаандаа санхүүжилт татан төвлөрүүлэх идэвх өндөр байна.

## 2.6. МӨНГӨН УРСГАЛ БА ХӨРВӨХ ЧАДВАР

Сэндли ББСБ-ын бүх цэвэр мөнгөн гүйлгээ 2023 онд 5.8 тэрбум төгрөгийн цэвэр орох мөнгөн урсгалтай, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 14.2 тэрбум төгрөг буюу мөнгө, түүнтэй адилтгах бэлэн мөнгөний нөөц тогтвортой байна.

*График 13.* Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, (сая төгрөг)




*Эх сурвалж:* Компанийн санхүүгийн тайлан

Компанийн үндсэн үйл ажиллагааны орох мөнгөн урсгалын бүтцийн өөрчлөлтийг доорх графикаас харвал зээлийн хүүгийн орлого 3.6 дахин буюу 10.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ба үнэт цаас гаргагчийн зээлийн үйл ажиллагаа 2023 онд идэвхжсэн байна.

*График 14.* Үндсэн үйл ажиллагааны орох мөнгөн урсгалын бүтэц, (сая төгрөг)




*Эх сурвалж:* Компанийн санхүүгийн тайлан

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллгааны гол сегмент болох олон улсын мөнгөн гүйвүүлгын үйлчилгээтэй холбоотой мөнгөн гүйвүүлгын шимтгэл 2023 онд БНХАУ дахь Wechat, Alipay үйлчилгээний тэлэлттэй холбоотойгоор 229.0 сая төгрөгөөр нэмэгдсэн бол гадаад валютын арилжааны орлого 17.6 хувиар буурч 168.0 сая төгрөг болжээ.

## 2.7. САНХҮҮГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

*Хүснэгт 14.* Санхүүгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, (2024.I улирал)

| Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт | Байвал зохих | Утга | Биелсэн эсэх |
|---|---|---|---|
| Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт | | | |
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 10%-аас доошгүй | 38.9% | Тийм |
| Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 20%-аас доошгүй | 39.0% | Тийм |
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа | 10%-аас доошгүй | 43.5% | Тийм |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | | | |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | 8%-аас дээш | 16.5% | Тийм |
| Актив хөрөнгийн төвлөрлийн үзүүлэлт | | | |
| Хөрөнгө (актив)-ийн эрсдлийн сангийн хүрэлцээ (+илүү, -дутуу) | 1,841.4 сая төгрөг | 1,841.4 сая төгрөг | Тийм |
| Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад | 30%-аас хэтрэхгүй | 9.9% | Тийм |

СЗХ сар өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

| | | | |
|---|---|---|---|
| актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа | | | |
| ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 70%-аас хэтрэхгүй | 0.0% | Тийм |
| ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, Гүйцэтгэх захирал, ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа | 25%-аас хэтрэхгүй | 17.6% | Тийм |
| ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, Гүйцэтгэх захирал, ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 10%-аас хэтрэхгүй | 9.9% | Тийм |
| Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 50%-аас хэтрэхгүй | 0.0% | Тийм |
| Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 20%-аас хэтрэхгүй | 0.0% | Тийм |
| Монголын хөрөнгийн биржийн "I", "II" ангиллын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа | 20%-аас хэтрэхгүй | 0.0% | Тийм |
| Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 20%-аас хэтрэхгүй | 0.0% | Тийм |
| Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа | 10%-аас хэтрэхгүй | 0.0% | Тийм |
| Гадаад валютын ханшийн эрсдэл | | | |
| Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | (+/-40%) | -34.3% | Тийм |
| Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн үзүүлэлтүүд | | | |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 80%-аас хэтрэхгүй | 78.1% | Тийм |
| Өрийн бичгийн зохистой харьцаа | 50%-аас хэтрэхгүй | 29.4% | Тийм |
| Үндсэн хөрөнгийн үзүүлэлт | | | |
| Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа | 15%-аас хэтрэхгүй | 0.4% | Тийм |
| Өгөөж | | | |
| Хөрөнгө (актив)-ийн өгөөж | | | 6.2% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж | | | 14.3% |

*Эх сурвалж:* Үнэт цаас гаргагчийн 2024 оны 1 дүгээр улирлын тайлан

## Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт

Өөрийн хөрөнгийн үзүүлэлт нь банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй байгаа эсэхийг тодорхойлсон үнэлгээ илэрхийлэх ба компанийн хувьд 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар хангалттай үнэлгээтэй байна.

СЗХ ... БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

СЗХ 2024.06.10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02



### Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт нь бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг харилцагчийн анхны шаардлагаар буцаан олгох чадварыг илэрхийлдэг. Тус үзүүлэлтийг тооцохдоо түргэн борлогдох активын дүнг бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн дунд харьцуулж тооцдог. Үнэт цаас гаргач нь 2024 оны 1 дүгээр улиралд энэхүү харьцааг зохих түвшинд хангаж байна.

### Активын хөрөнгийн төвлөрлийн үзүүлэлт

Актив хөрөнгийн эрсдэл гэдэг нь тухайн активыг нэг этгээдэд их хэмжээгээр төвлөрүүлснээр хүү, төлбөрийг эргүүлэн төлөх чадахгүйд хүрэхэд учрах эрсдэлийг томьёолдог. Тус эрсдэлийн улмаас банк бус санхүүгийн байгууллага санхүүгийн хүндрэлд орох эрсдэлтэй байдаг ба тус үзүүлэлтийг үнэт цаас гаргагч бүрэн ханган ажиллаж байна.

### Гадаад валютын ханшийн эрсдэл

Гадаад валютын ханшийн эрсдэл нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханш хэлбэлзэхэд алдагдал хүлээх эрсдэл юм. Үнэт цаас гаргагчийн хувьд гадаад валютын актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа нь бүрэн хангагдаж байна.

### Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн үзүүлэлтүүд

Санхүүгийн байгууллага нь бусдаас хөрөнгө татан төвлөрүүлэхдээ санхүүгийн хөшүүргийг зүй зохистой түвшинд, эрсдэлийн тодорхой хязгаарлалтан дунд ашиглах ёстой байдаг. Өрийн бичиг буюу компанийн бонд болон итгэлцлийн үйлчилгээ нь ББСБ-ын эх үүсвэр бүрдүүлэх банкнаас ялгарах гол суваг болдог. Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн зохистой харьцаануудаас дүгнэхэд компани нь өрийн бичиг гаргаж санхүүжилт татах орон зай өндөр байна.

### Үндсэн хөрөнгийн үзүүлэлт

Банк, санхүүгийн байгууллага нь өөрийн хөрөнгийн бүтэц, төрөлжүүлэлтээ зохион байгуулахдаа хөрвөх чадвараа хадгалж байхыг эрмэлздэг. ББСБ-ын хувьд үндсэн хөрөнгөд хэт их хөрөнгөө байршуулах нь богино хугацаанд түргэн борлогдох хөрөнгийн хувь хэмжээг багасгаж эрсдэл үүсгэдэг. Үнэт цаас гаргагч нь үндсэн хөрөнгөө зохистой харьцаанд бүрдүүлж чадсан байна.

### Санхүүжих чадавхийн зэрэглэл

Үнэт цаас гаргагч нь дотоодын эсхүл Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаар санхүүжих чадавхийн зэрэглэл тогтоолгоогүй болно.

СЗХ он сар өдөр 2024.05.10 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## “Сэндли Бонд”-ын эргэн төлөлтийн мэдээлэл

Сэндли ББСБ ХК-иас 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр жилийн 19.2 хувийн хүүтэй, 18 сарын хугацаатай, хүүгийн төлбөр улирал тутамд, үндсэн төлбөр хугацааны эцэст төлөгдөх, 85,000 ширхэг нийт 8.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий компанийн өрийн хэрэгслийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгосон.

Тус бондын хоёрдогч зах зээлийн арилжаа 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс эхэлсэн бөгөөд улирал тутам төлөгдөх хүүгийн төлбөр графикын дагуу амжилттай төлөгдөж байна.

*Хүснэгт 15.* Сэндли бондын эргэн төлөлтийн мэдээлэл

| № | Төлбөр | Төлбөр тооцох өдөр* | Өдрийн тоо | Хүү ба үндсэн төлбөр, (татварын өмнөх) | Төлөгдсөн эсэх |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хүүгийн төлбөр 1 | 2023.04.30 | 90 | 402,410,958.9 | Тийм |
| 2 | Хүүгийн төлбөр 2 | 2023.07.30 | 91 | 406,882,191.8 | Тийм |
| 3 | Хүүгийн төлбөр 3 | 2023.10.30 | 92 | 411,353,424.7 | Тийм |
| 4 | Хүүгийн төлбөр 4 | 2024.01.30 | 92 | 411,353,424.7 | Тийм |
| 5 | Хүүгийн төлбөр 5 | 2024.04.30 | 91 | 406,882,191.8 | Хүлээгдэж буй |
| 6 | Хүүгийн төлбөр 6 | 2024.07.30 | 91 | 406,882,191.8 | Хүлээгдэж буй |
| 7 | Үндсэн төлбөр | 2024.07.30 | - | 8,500,000,000.0 | Хүлээгдэж буй |
| | **Нийт** | | **547** | **10,945,764,383.6** | |

*Тайлбар:* * - Хэрэв төлбөр тооцогдох өдөр нь амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр төлбөрийг үнэт цаас эзэмшигчийн данс руу шилжүүлнэ.

Сэндли ББСБ нь анхны нээлттэй бондын хүүгийн төлбөртөө татварын дараах дүнгээр 1.5 орчим тэрбум төгрөгийн өгөөжийг бонд эзэмшигч нартаа амжилттай олгосон байна.

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

БТРТ/SB-02

Сэндли

БОНД 2.0

# 3. Зах зээлийн судалгаа

2024

ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР

ULZII & Co CAPITAL

ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР

Investment

Golomt Capital

СЗХ 2024.06.10 өдөр БҮРТГЭВ №01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## 3.1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

### 3.1.1. Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал

**Эдийн засгийн өсөлт**

Монгол Улсын бодит эдийн засаг коронавирусТ цар тахлын дараа V хэлбэрийн сэргэлт үзүүлж байгаа бөгөөд 2023 онд бодит ДНБ 7.0 хувь өсөж, өнгөрсөн оноос 2.2 пунктээр нэмэгджээ.

*График 15.* Монгол Улсын бодит ДНБ-ийн өсөлт




*Эх сурвалж:* Үндэсний статистикийн хороо

2023 онд эдийн засгийн өсөлт өмнөх оноос сайжрахад уул уурхайн олборлолт, тэр дундаа нүүрсний үйлдвэрлэл түүхэн дээд хэмжээнд хүрсэн ба үүний нөлөөгөөр тээврийн салбарын орлого огцом нэмэгдэж уул уурхай, тээврийн салбар дангаараа 2023 оны эдийн засгийн өсөлтийн 4.3 нэгж хувийг бүрдүүлсэн талаар Монголбанк 2024 оны нэгдүгээр улирлын Инфляцын тайландаа онцолжээ.

*График 16.* 2024 оны эдийн засгийн өсөлтийн төсөөлөл




*Эх сурвалж:* Блүүмбэрг Монгол

Блүүмбэргийн мэдээлснээр Монголбанк болон Олон Улсын хөндлөнгийн санхүүгийн байгууллагууд 2024 оны Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дунджаар 5.3 хувьд хүрэх төсөөллийг гаргасан. Цаг агаарын гэнэтийн хүндрэл, зудын нөхцөл байдлаас шалтгаалж хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл агших, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын ажил эхлэх хугацаа ирэх он руу хойшилсон, барилгын салбар удааширч буй зэрэг нь

СЗХ БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17

эдийн засгийн өсөлтийн төсөөллийг бууруулахад голлох нөлөөлснийг Монголбанкны инфляцын тайланд дурджээ.

### Мөнгөний бодлого ба инфляц

2024 оны 3 дугаар сарын байдлаар инфляцын түвшин 7.0 хувьд хүрсэн ба өмнөх сараас өөрчлөлтгүй байна. Инфляцын түвшин 2022 оны 6 дугаар сараас эхлэн тасралтгүй буурах чиг хандлага харуулж байгаа бөгөөд сүүлийн зургаан сар дараалан нэг оронтой тоонд хадгалагдаж байна.

*График 17.* Инфляц ба бодлогын хүү




*Эх сурвалж:* Үндэсний статистикийн хороо

Монголбанкны мөнгөний бодлогын хорооны 2024 оны 3 дугаар сарын хурлаар бодлогын хүүг нэг нэгжээр бууруулж 12.0 хувь болгох шийдвэр гарсан. Энэхүү мөнгөний бодлогын шийдвэр нь ирэх онуудад эдийн засгийн хэвийн өсөлтийг хангах зорилготой ба төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтвортой, инфляцын түвшин саарсан нь бодлогыг хүүг бууруулах суурь нөхцөлийг бүрдүүлсэн.

*График 18.* 2024 оны инфляцын төсөөлөл




*Эх сурвалж:* Албан ёсны цахим хуудас тайлан

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -05- 17
БҮРТГЭВ-02

2024 онд зудын нөхцөл байдал, малын зүй бус хорогдлоос үүдэн махны үнэ хаврын улиралд өсөх, 4 дүгээр сараас төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр нэмэгдэх, Эрдэнэс тавантолгой ХК-ийн ногдол ашиг тараагдсан зэрэг нь эрэлтийн шалтгаантай инфляцыг өдөөх эрсдэлтэй байна.

Иймд энэ оны инфляцын дундаж төсөөлөл 9.6 хувь буюу 3 дугаар сарын инфляцын түвшнээс харьцангуй үнийн өсөлт үргэлжлэх төсөөллийг олон улсын банк, санхүүгийн байгууллагууд гаргасан.

## Экспорт ба гадаад худалдаа

*Хүснэгт 16.* Уул уурхайн голлох бүтээгдэхүүний экспорт, оны эхний хоёр сард

| № | Уул уурхайн бүтээгдэхүүн | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | | | 2024.I-II/2023.I-II |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2022.I-II | 2023.I-II | 2024.I-II | |
| 1 | Чулуун нүүрс | сая тн | 1.3 | 7.8 | 10.6 | 35.9% |
| 2 | Зэс | мян тн | 212.3 | 218.5 | 253.6 | 16.1% |
| 3 | Төмөр | мян тн | 308.8 | 830.7 | 1,120.9 | 34.9% |
| 4 | Нефть | мян барр | - | 747.0 | 705.0 | -5.6% |
| 5 | Жонш | мян тн | 30.7 | 113.3 | 188.0 | 65.9% |
| 6 | Молибден | мян тн | 0.6 | 1.1 | 1.0 | -9.1% |
| 7 | Хүрэн нүүрс | мян тн | - | 191.6 | 314.3 | 64.0% |
| 8 | Цайр | мян тн | 13.1 | 40.1 | 7.7 | -80.8% |

*Эх сурвалж:* Үндэсний статистикийн хороо

2024 оны эхний хоёр сард уул уурхайн голлох бүтээгдэхүүний экспортоос чулуун нүүрсний экспорт өмнөх оны мөн үеэс 35.9 хувиар өсөж 10.6 сая тоннд хүрсэн бол зэсийн баяжмал, хүдрийн экспорт 35.1 мянган тонноор нэмэгджээ. Мөн жоншны экспорт 65.9 хувиар өсөж 188.0 мянган тонны экспортыг худалдааны түнш орнууд руу гаргасан байна.

*Хүснэгт 17.* Экспортын орлого (сая ам.доллар), оны эхний хоёр сард

| № | Уул уурхайн бүтээгдэхүүн | Хэмжих нэгж | Экспортын орлого | | | 2024.I-II/2023.I-II |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2022.I-II | 2023.I-II | 2024.I-II | |
| 1 | Чулуун нүүрс | сая тн | 326.2 | 1,271.9 | 1,336.5 | 5.1% |
| 2 | Зэс | мян тн | 441.6 | 371.8 | 445.2 | 19.7% |
| 3 | Төмөр | мян тн | 25.6 | 65.2 | 90.2 | 38.3% |
| 4 | Нефть | мян барр | - | 57.9 | 54.4 | -6.0% |
| 5 | Жонш | мян тн | 6.9 | 29.2 | 41.6 | 42.5% |
| 6 | Молибден | мян тн | 8.7 | 20.8 | 14.7 | -29.3% |
| 7 | Хүрэн нүүрс | мян тн | - | 13.0 | 13.4 | 3.1% |
| 8 | Цайр | мян тн | 24.1 | 66.3 | 9.9 | -85.1% |
| **Нийт** | | | **833.1** | **1,896.1** | **2,005.9** | **5.8%** |

*Эх сурвалж:* Үндэсний статистикийн хороо

УЛААНБААТАР ХОТ
ОЛЗИЙТ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
5183855
9021031195 СТС2420
СЭНДЛИ БОНД ХК

*График 19.* Экспорт ба импорт, (сая ам.доллар)




*Эх сурвалж:* Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл сүүлийн 5 жилд ашигтай гарсан ба 2023 онд 5.9 тэрбум ам.долларын ашигтай гарчээ. Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарснаар гадаад валютын дотоод руу чиглэсэн урсгал нэмэгдэх ба төгрөгийн ханшийн дарамт багасах эерэг талтай.

*График 20.* Урсгал дансны тэнцэл, (сая ам.доллар)




*Эх сурвалж:* Үндэсний статистикийн хороо

Урсгал дансны тэнцэл улирлын мөчлөгөөс хамаарсан хэлбэлзэл өндөр бөгөөд 2024 оны нэгдүгээр сард 309.6 сая ам.долларын алдагдалтай гарсан. Урсгал дансны тэнцэл нь бараа бүтээгдэхүүний экспорт, импортын урсгалаар дамжиж Монгол Улсын валютын орох эсвэл гарах урсгалын ерөнхий төлвийг харуулдаг гол үзүүлэлт болдог.

СЗХ
2024.06.18
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

## Мөнгөний нийлүүлэлт ба валютын ханш

*График 21.* Гадаад валютын улсын нөөц (сая ам.доллар) ба ам.долларын сарын дундаж ханш




*Эх сурвалж:* Үндэсний статистикийн хороо

Уул уурхайн голлох түүхий эдийн экспортын биет хэмжээний өсөлт, дэлхийн зээл дээрх түүхий эдийн үнэ тогтвортой байгаа зэрэг нь гадаад валютын улсын нөөц 5.2 тэрбум ам.долларт хүрч түүхэн дээд түвшинд хүрэхэд гол нөлөө үзүүллээ.

Ийнхүү экспортын орлого нэмэгдсэн, олон улсад гаргасан засгийн газрын өрийн хэрэгслийг дотоод нөөц боломжоор төлж барагдуулсан нь төгрөг ам.долларын эсрэг чангарч, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4.2 хувиар чангарахад нөлөөлсөн.

*График 22.* Мөнгөний нийлүүлэлт ба зээлийн үлдэгдэл (их наяд төгрөг)




*Эх сурвалж:* Үндэсний статистикийн хороо

Мөнгөний нийлүүлэлтийг банкны салбарын аж ахуй нэгж, иргэдэд олгосон зээлийн дүнтэй харьцуулбал 2020 оноос өмнө буюу коронавируст цар тахлаас өмнөх үед зээлийн хэмжээ ба мөнгөний нийлүүлэлт ижил чиглэлд өсөж байсан.

2020 оноос хойш Засгийн газраас авч хэрэгжүүлсэн тэтгэмж, хөнгөлөлтийн бодлого, эдийн засгаа сэргээх 10 их наядын хөтөлбөр нь мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлсэн болович банкны салбарын зээл олголт 2021 онд эсрэгээр буурчээ. 2024 оны 3 дугаар сард мөнгөний нийлүүлэлт 37.4 их наяд төгрөгт хүрсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 6.5 их наяд төгрөгөөр буюу 20.8 хувиар өсжээ.

*График 23.* ААН, иргэдийн зээлийн үлдэгдэл, (их наяд төгрөг)




*Эх сурвалж:* Үндэсний статистикийн хороо

Аж ахуй нэгж ба иргэдэд олгосон зээлийн багцаас чанаргүй зээлийн ангилалд хамаарах зээлийн эзлэх хувь 2020 онд 11.7 хувьд хүрч өсөж байсан бол тус оноос хойш тасралтгүй буурсаар 2024 оны 2 дугаар сарын байдлаар 2.0 их наяд төгрөгийн буюу нийт зээлийн 7.3 хувь чанаргүй ангилалд багтаж байна.

## Сангийн бодлого ба засгийн газрын өр

*График 24.* Төсвийн тэнцэржүүлсэн тэнцэл, (тэрбум төгрөг)




*Эх сурвалж:* Үндэсний статистикийн хороо

СЭХ 2024.06.10 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17

Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл сүүлийн гурван жилд анх удаа 763.4 тэрбум төгрөгийн ашигтай гарсан. 2020 онд цар тахлын хүндрэлтэй холбоотойгоор 4.4 их наяд төгрөгийн төсвийн алдагдал үүрч байсан хэдий ч, 2020 оноос 2022 оны хооронд төсвийн алдагдал аажмаар буурч, 2023 онд төсвийн тэнцэл 763.4 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.

*График 25.* Засгийн газрын нийт өр, (тэрбум төгрөг)




*Эх сурвалж:* Үндэсний статистикийн хороо

Засгийн газрын өрийн хэмжээ 2019 онд 23.9 их наяд төгрөг байсан боловч коронавируст цар тахлын үед эдийн засгаа дэмжихийн тулд төсвийн хурдацтай тэлэлт хийж, 2020 онд Засгийн газрын өрийн хэмжээ 16.6 хувиар буюу 3.9 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

*График 26.* Засгийн газрын нийт өрийн эргэн төлөлт, (тэрбум төгрөг)




*Эх сурвалж:* Үндэсний статистикийн хороо

Засгийн газрын нийт өрийн үлдэгдэл 2023 оны эцсийн байдлаар 30.7 их наяд төгрөг байна. 2023 онд Засгийн газрын нийт 5.1 их наяд төгрөгийн өрийн эргэн төлөлт хийсэн ба 1.0 их наяд төгрөгийн хүүгийн төлбөр төлсөн байна.

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

СЭХ сар өдөр 2024 06 18 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

### 3.1.2. Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал

*График 27.* Үнэт цаасны гүйлгээ (сая төгрөг) ба ТОП-20 индекс




*Эх сурвалж:* Үндэсний статистикийн хороо

Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалагдсан үнэт цаасны гүйлгээний дүн Эрдэнэс тавантолгой ХК-ийн өрийн хэрэгслийн арилжаатай холбоотой 2021 оны 4 дүгээр сард 533.6 тэрбум төгрөг, 2021 оны 8 дугаар сард 422.1 тэрбум төгрөг хүрсэн бол Банкны реформын нөлөөгөөр 2022 оны 12 дугаар сард 170.0 тэрбум төгрөг, 2023 оны 5 дугаар сард 296.6 тэрбум төгрөгийн буюу хамгийн өндөр дүнтэй арилжааны хэлцлүүд хийгджээ.

*График 28.* Зах зээлийн үнэлгээ (их наяд төгрөг) ба ЗЗҮ/ДНБ харьцаа




*Эх сурвалж:* Үндэсний статистикийн хороо

Монголын хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 2024 оны 2 дугаар сарын байдлаар 11.7 их наяд төгрөгт хүрсэн. 2023 онд зах зээлийн үнэлгээ даруй 4.7 их наяд төгрөгөөр нэмэгдсэн нь системийн нөлөө бүхий 5 банк олон нийтэд нээлттэй хувьцаат компани болж хувьцаагаа биржээр арилжаалж эхэлсэн нь нөлөөлсөн. Сүүлийн байдлаар системийн нөлөө бүхий 5 банкны зах зээлийн үнэлгээ 5.2 их наяд төгрөг буюу Монгол Улсын нийт зах зээлийн үнэлгээний 44.4 хувийг дангаар бүрдүүлж байна.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ ба нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа 16.6 хувь буюу 2019 онтой харьцуулахад хөрөнгийн зах зээлийн нийт эдийн засаг дахь ач холбогдол 2.3 дахин өссөн болохыг харуулж байна.

*График 29.* Бонд ба хувьцааны арилжаа (тэрбум төгрөг)




*Эх сурвалж:* Үндэсний статистикийн хороо

Сүүлийн 5 жилд Монголын хөрөнгийн бирж дээр хийгдсэн арилжааны дүнг хувьцаа ба бондын төрлөөр ялган авч үзвэл 2021 онд Эрдэнэс тавантолгой ХК-ийн төгрөг, ам.доллар хосолсон өрийн хэрэгслийн арилжааны нөлөөгөөр нийт бондын арилжаа 1.4 их наяд төгрөгт хүрч байсан. Мөн цар тахлын үед иргэдийн цахим арилжаанд аппликэйшнээр дамжин оролцох сонирхол нэмэгдсэн нь 2021 онд хувьцааны арилжааг 1.0 их наяд төгрөгийн гүйлгээ хийгдэхэд нөлөөлсөн.

Компанийн өрийн хэрэгслийн хувьд 2022 онд 134.1 тэрбум төгрөгийн, 2023 онд 138.1 тэрбум төгрөгийн компанийн өрийн хэрэгсэл Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалагджээ.

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ №01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## 3.2. БАНК БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ

*График 30*. ББСБ-ын салбарын нийт хөрөнгө ба зээл (тэрбум төгрөг)




*Эх сурвалж:* Санхүүгийн зохицуулах хороо

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт активын хэмжээ 2023 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар 4.2 их наяд төгрөгт хүрсэн ба 2022 оны эцэстэй харьцуулбал 20.7 хувиар буюу 730.4 тэрбум төгрөгөөр өсжээ. ББСБ-ын салбарын нийт хөрөнгө банкны салбарын нийт хөрөнгийн 8.6 хувьтай дүйцэж байгаа бол нийт зээлийн багцын хэмжээ банкны салбарын нийт зээлийн багцын 12.8 хувьтай дүйцэж байна.

*График 31*. Өөрийн хөрөнгө ба Хувь нийлүүлсэн хөрөнгө ХНХ (тэрбум төгрөг)




*Эх сурвалж:* Санхүүгийн зохицуулах хороо

2023 оны 3 дугаар улиралд банк бус санхүүгийн байгууллагын салбарын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1.4 их наяд төгрөгт хүрсэн ба тус үзүүлэлтээр банкны салбарын 87.5 хувьтай дүйцэж байна. Өөрийн хөрөнгийн хэмжээгээр банк бус санхүүгийн байгууллагын салбарын хэмжээ 2.5 их наяд төгрөгт хүрсэн ба банкны салбарын 49.1 хувьтай тэнцэж байна.

СЗХ 2024.06.10 өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

*График 32.* Нийт харилцагчид ба зээлдэгчдийн тоо, (мянган хүн)




*Эх сурвалж:* Санхүүгийн зохицуулах хороо

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт харилцагчдын 93.6 хувь нь финтек үйлчилгээ авдаг бол ердөө 6.4 хувь буюу 263.0 мянган харилцагч уламжлалт зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авч байна. Идэвхтэй зээлийн гэрээтэй 1.4 сая зээлдэгчдээс 1.2 сая буюу 86.3 хувь нь финтек зээлийн үлдэгдэлтэй бол 13.7 хувь нь уламжлалт зээлийн гэрээтэй харилцагч нар байна.

*График 33.* Зээлийн жигнэсэн дундаж хүү (ЗЖДХ) ба салбарын ашигт ажиллагаа




*Эх сурвалж:* Санхүүгийн зохицуулах хороо

Монголбанкны бодлогын хүү 2020 оны 11 дүгээр сараас 2022 оны 1 дүгээр сар хүртэл 6.0 хувийн түвшинд хадгалагдаж байснаас хамаарч зээлийн жигнэсэн дундаж хүүгийн түвшин 3.0 хувиас 2.7 хувь хүртэл буурсан. 2022 оны 12 дугаар сар гэхэд Монголбанкны зүгээс бодлогын хүүг 6.0 хувиас 13.0 хувь болгож өсгөсөн ба банк бус санхүүгийн байгууллагын салбарын зээлийн дундаж хүү мөн өсөж 3.1 хувьд хүрсэн.

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын цэвэр ашиг 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 302.4 тэрбум төгрөгт хүрсэн бол нийт орлого 814.7 тэрбум төгрөг болжээ.

СЗХ 2024.06.10 өдөр БҮРТГЭВ №21
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024.05.17 БҮРТГЭВ-02

*График 34.* Зээлийн багц (тэрбум төгрөг) ба зээлийн чанар




*Эх сурвалж:* Санхүүгийн зохицуулах хороо

Банк бус санхүүгийн салбарын нийт зээлийн багцад финтек зээл 570.0 тэрбум төгрөг буюу 16.8 хувь, уламжлалт зээлийн хэмжээ 2,809.0 тэрбум төгрөг буюу 83.2 хувь тус тус эзэлж байна.

Зээлийн багцын чанарыг зээлийн бүтээгдэхүүний төрлөөр ангилбал 2023 оны 3 дугаар улирлын байдлаар финтек зээлийн чанаргүйдэл 20.0 хувь буюу уламжлалт зээлийн багцаас дарүй 4 дахин өндөр зээлийн чанаргүйдэлтэй байна.

*График 35.* Салбарын санхүүжилтийн бүтэц (тэрбум төгрөг)




*Эх сурвалж:* Санхүүгийн зохицуулах хороо

2023 оны 3 дугаар улирлын байдлаар 40 ББСБ нээлттэй болон хаалттай хүрээнд өрийн бичиг гаргаж, үүнийг 1,480 хувь хүн, хуулийн этгээд худалдан авсан ба нийт 263.0 тэрбум төгрөгийн өрийн бичгийн өглөгийн үлдэгдэлтэй байгаа талаар СЗХ-ны тайланд дурджээ.

Харин итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 82 ББСБ-аас 74 ББСБ 7,681 итгэмжлэгчээс 519.0 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн тухай мөн СЗХ-ны ББСБ-ын салбарын нэгтгэл тайланд онцолсон байна.

СЗХ 2024 .06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024 05 17 БҮРТГЭВ-02

## 3.3. МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ЗАХ ЗЭЭЛ

Дэлхийн улс орнууд 2024 онд 858 тэрбум ам.долларын мөнгөн гуйвуулга хийнэ гэж Дэлхийн банкны 2023 оны 6 дугаар сарын тайланд дурджээ. Мөн тус тайланд 2024 онд мөнгөн гуйвуулгын өсөлтөөр хамгийн өндөр бүс нутгаар Зүүн Ази ба Номхон далай, Латин Америк, Ойрхи Дорнодын бүс нутгийн орнуудыг нэрлэсэн.

*График 36*. Дэлхийн мөнгөн гуйвуулгын хэмжээ, (тэрбум ам.доллар)




*Эх сурвалж:* Дэлхийн банкны судалгаа, 2023 оны 6 дугаар сар (*)-Урьдчилсан, (**)-Төсөөлсөн

Бүс нутгуудын бага, дунд орлоготой улс орнуудын бүлэг 2024 онд дэлхий даяар хийгдэх нийт мөнгөн гуйвуулгын 77.7 хувийг бүрдүүлэх төлөвтэй байна. Мөнгөн гуйвуулга нь улс орнуудад гадаадын шууд хөрөнгө оруулалт, хөгжлийн тусламж, хөрөнгө оруулалттай нэгэн адил гадаад санхүүжилтийн чухал эх үүсвэр байдаг гэдгийг Дэлхийн банкны судалгаанд онцолжээ.

*Хүснэгт 18*. Мөнгөн гуйвуулга, бага, дунд орлоготой улс орнууд (тэрбум ам.доллар)

| Бүс нутгууд *** | 2019 | 2020 | 2021 | 2022* | 2023** | 2024** |
|---|---|---|---|---|---|---|
| Зүүн Ази ба Номхон далай | 74 | 72 | 76 | 79 | 81 | 83 |
| БНХАУ | 69 | 59 | 53 | 51 | 50 | 49 |
| Европ ба Төв Ази | 62 | 58 | 66 | 79 | 80 | 80 |
| Латин Америк, Карибын тэнгис | 96 | 103 | 130 | 145 | 150 | 154 |
| Ойрхи Дорнод ба Хойд Африк | 57 | 60 | 67 | 64 | 65 | 67 |
| Өмнөд Ази | 140 | 147 | 157 | 176 | 177 | 178 |
| Сахарын Африк | 49 | 43 | 50 | 53 | 54 | 56 |
| **Нийт** | 547 | 542 | 599 | 647 | 657 | 667 |

*Эх сурвалж:* Дэлхийн банкны судалгаа, 2023 оны 6 дугаар сар
***-бүс нутгууд дахь зөвхөн бага дунд орлоготой улс орнуудын хувьд

УЛААНБААТАР ХОТ ЗЭНД ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС24

СЗХ
2024 06 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 05 17
БҮРТГЭВ -02

Зүүн Ази ба Номхон далайн бүс нутгийн улс орнуудаас хамгийн өндөр мөнгөн гуйвуулга хүлээн авагч улс орны нэгд Монгол Улс багтжээ. 2022 онд Монгол Улс нь 0.4 тэрбум ам.долларын мөнгөн гуйвуулгыг хүлээн авсан байна.

*График 37.* ТОП-10 мөнгөн гуйвуулга хүлээн авагч орнууд, (тэрбум ам.доллар)




*Эх сурвалж:* Дэлхийн банкны судалгаа, 2023 оны 6 дугаар сар

Дэлхийн банкны 2023 оны 6 дугаар сарын "Шилжилт хөдөлгөөн ба мөнгөн гуйвуулга"-ын тайланд дараах зүйлсийг онцолжээ. Үүнд:

- Мөнгөн гуйвуулгын валютын урсгал нь Зүүн Азид гадаадын шууд хөрөнгө оруулалтын дараа хоёрдугаарт орох томоохон санхүүгийн урсгалын нэг хэсэг юм.
- 2021-2022 оны хооронд гадаадын шууд хөрөнгө оруулалт Зүүн Ази, Номхон далайн бүс нутагт валютын урсгалын 40.0% эзэлж байсан бол мөнгөн гуйвуулгын шилжүүлэг 50.0 хувийг бүрдүүлсэн.
- 2022 онд дотоодын болон гадаад улс орнуудын эдийн засгийн нөхцөл байдал Зүүн Азийн орнуудын мөнгөн гуйвуулгад ихээхэн нөлөө үзүүлсэн.
- Хятад, Тайланд, Малайз зэрэг улс оронд хүн ам зүйн өөрчлөлт, ажиллах хүчний шилжилт, эдийн засгийн төрөлжилт нь хоёр хэлбэрээр мөнгөн гуйвуулгын зах зээлд нөлөөлсөн. Нэгдүгээрт, харьцангуй чадварлаг ажиллах хүчин бусад хөгжилтэй улс орнууд руу шилжин суурьшсан, хоёрдугаарт, чадвар бага ажиллах хүчин Зүүн ба Өмнөд азийн орнууд хооронд шилжих хөдөлгөөн хийсэн.
- 2022 оноос эхлэн Зүүн Азийн улс орнуудаас гадаад улс руу гарсан чадварлаг ажиллах хүчнүүд мөнгөн гуйвуулгын урсгалыг Ковид-19 цар тахлын дараах онд эрчимтэй сэргээсэн.
- Зүүн Азийн цагаачлагч 23 орноос 21 орон нь Ковид-19 эсрэг вакцинжуулалтын түвшин өндөр буюу 60-92 хувь байсан учраас Австрали, Шинэ Зеландын хөдөлмөрийн зах зээлд тэргүүлэх ажиллах хүчин болж чадсан.
- Бага ур чадвартай зүүн Азийн цагаачид нь Малайз, Тайланд зэрэг дундаас дээш орлогын түвшинтэй улс орнуудын аж үйлдвэр, экспортын салбарт гол ажиллах хүчин болж шилжин суурьшсан.

*Хүснэгт 19.* Зүүн Ази ба Номхон далайн орнуудаас 200 ам.доллар шилжүүлэх дундаж өртөг

| 5%-иас доош мөнгөн гуйвуулгын шимтгэлтэй гарцууд | 8%-иас дээш мөнгөн гуйвуулгын шимтгэлтэй гарцууд |
|---|---|
| • Малайз-Непал | • Тайланд-Индонез |
| • АНЭУ-Филиппин | • Австрали-Ванатау |
| • Кувэйт-Филиппин | • Тайланд-Вьетнам |
| • Малайз-Филиппин | • Тайланд-Лаос |
| • Малайз-Энэтхэг | • Өмнөд Африк-Хятад |

*Эх сурвалж:* Дэлхийн банкны судалгаа, 2023 оны 6 дугаар сар

2022 оны эцэст Филиппин рүү шилжүүлэг хийх гарцуудын дундаж зардал буурсан бол Тайландаас Зүүн Азийн ихэнх улс орнууд руу хийх мөнгөн гуйвуулгын зардал өссөн.

## 2024 оны Зүүн Ази ба Номхон далайн бүс нутгийн мөнгөн гуйвуулгын зах зээлийн чиг хандлага

- Төв банкуудын мөнгөний хатуу бодлого, үнийн өсөлт, засгийн газрын өрийн хэтрэлт, Украины дайн зэрэг нь өндөр орлоготой улс орнуудаас бусад улс орнууд руу хийгдэх мөнгөн гуйвуулгын хэмжээг бууруулж байна.
- Филипин улсын хүлээж авах мөнгөн гуйвуулгын дүн Хятад улсыг хассанаар Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн 48 хувийг дангаар бүрдүүлдэг. Тус улсад мөнгөн гуйвуулга 2024 онд 40 тэрбум ам.доллар болох төлөвтэй байна.
- Тайланд улсын мөнгөн гуйвуулга 2023 онд 9.4 тэрбум ам.долларт хүрэх урьдчилсан тооцоотой байгаа бол 2024 онд 10 тэрбум ам.доллар хүрч 3.6 хувиар өсөх төлөвтэй.
- Филипин, Тайланд улсад аялал жуулчлал сэргэснээр мөнгөн гуйвуулгын зах зээлд гарч буй гол сорилт нь тухайн улсын иргэд өөрийн орондоо хөдөлмөр эрхлэх боломж нэмэгдэж байгаа учраас гадаад улс орнууд руу гарч хөдөлмөр эрхлэх сонирхол буурсан нь нөлөөлөх төлөвтэй байна.
- Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний эрэлт удааширснаар Камбож улсын мөнгөн гуйвуулгын өсөлт 2023 онд 1.3 хувиар буурах бол 2024 онд мөн доогуур түвшинд хэвээр хадгалагдах төлөвтэй байна.

СЗХ 2024.06.10 өдөр БҮРТГЭВ №01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

## Монгол Улс дахь олон улсын мөнгөн гуйвуулга

Монголбанкны гадаад секторын статистик тайланд дурдсанаар 2022 онд гадаад улсад хөдөлмөр эрхэлж буй Монгол иргэдээс хүлээн авсан мөнгөн гуйвуулгын дүн 119.5 сая ам.долларт хүрч өмнөх оноос 40.0 хувиар буурсан. Харин 2023 оны эхний гурван улирлын байдлаар хүлээн авсан мөнгөн гуйвуулгын дүн өмнөх онтой харьцуулахад 18.0 хувиар буурсан байна.

*График 38*. Хувийн гуйвуулга, (мянган ам.доллар)




*Эх сурвалж:* Монголбанк, Гадаад секторын статистик

Монгол Улсаас гадаад улс орнууд руу шилжүүлсэн гуйвуулгын дүн 2023 оны эхний есөн сарын байдлаар 54.3 сая ам.доллар буюу өнгөрсөн оноос 12.0 хувиар буурсан.

*Хүснэгт 20*. Хүлээн авсан хувийн гуйвуулга, (мянган ам.доллар)

| | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023.Q3 | 2022/2021 |
|---|---|---|---|---|---|---|
| Солонгос | 120,400 | 87,266 | 62,044 | 33,598 | 30,288 | ▼ -46% |
| Америк | 17,824 | 17,454 | 40,263 | 32,460 | 21,930 | ▼ -19% |
| Хятад | 1,615 | 1,027 | 723 | 848 | 661 | ▲ 17% |
| Хонг Конг | 3,116 | 1,379 | 562 | 1,149 | 1,180 | ▲ 104% |
| Их Британи | 10,910 | 14,623 | 4,698 | 4,532 | 1,865 | ▼ -4% |
| ОХУ | 41,534 | 53,913 | 43,738 | 1,389 | 493 | ▼ -97% |
| Сингапур | 4,477 | 13,870 | 8,268 | 17,928 | 21,394 | ▲ 117% |
| Швейцар | 5,474 | 4,447 | 4,821 | 3,970 | 2,017 | ▼ -18% |
| Герман | 7,975 | 6,040 | 6,093 | 5,755 | 5,881 | ▼ -6% |
| Япон | 3,333 | 2,395 | 1,757 | 1,295 | 623 | ▼ -26% |
| Бусад | 37,611 | 32,036 | 24,609 | 16,607 | 11,910 | ▼ -33% |

*Эх сурвалж:* Монголбанк, Гадаад секторын статистик

2023 эхний гурван улиралд өнгөрсөн онтой харьцуулахад БНСУ, ОХУ, Япон улсад ажиллаж амьдарч буй Монгол иргэдээс хүлээн авсан гуйвуулгын

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

СХ 2024.05.10 өдөр БҮРТГЭВ № 01

дүн хамгийн ихээр буурсан. ХонгКонг, Сингапур, Хятад улсаас хүлээн авсан хувийн гуйвуулга хамгийн өндөр хувиар нэмэгджээ.

*Хүснэгт 21.* Шилжүүлсэн хувийн гуйвуулга, (мянган ам.доллар)

| | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023.Q3 | 2022/2021 |
|---|---|---|---|---|---|---|
| Солонгос | 15,861 | 17,938 | 14,059 | 11,847 | 8,555 | ▼ -16% |
| Америк | 16,892 | 12,833 | 12,059 | 14,039 | 12,800 | ▲ 16% |
| Хятад | 3,944 | 2,704 | 3,092 | 2,116 | 1,449 | ▼ -32% |
| Хонг Конг | 1,184 | 1,076 | 1,183 | 1,059 | 825 | ▼ -10% |
| Их Британи | 6,809 | 4,674 | 3,584 | 3,105 | 2,462 | ▼ -13% |
| ОХУ | 10,778 | 8,517 | 9,648 | 1,673 | 41 | ▼ -83% |
| Сингапур | 4,144 | 2,842 | 1,363 | 1,306 | 1,291 | ▼ -4% |
| Швейцар | 497 | 420 | 358 | 619 | 569 | ▲ 73% |
| Герман | 3,065 | 2,670 | 2,693 | 2,685 | 2,622 | ▲ 0% |
| Япон | 3,033 | 2,329 | 1,722 | 2,392 | 2,104 | ▲ 39% |
| Бусад | 56,813 | 34,054 | 23,766 | 20,878 | 21,567 | ▼ -12% |

*Эх сурвалж:* Монголбанк, Гадаад секторын статистик

Монгол Улсаас Хятад, БНСУ, ОХУ руу шилжүүлсэн хувийн мөнгөн гуйвуулгын хэмжээ буурсан бол АНУ, Герман, Япон, Швейцар улс руу шилжүүлсэн мөнгөн гуйвуулгын хэмжээ 2023 оны эхний гурван улирлын байдлаар өссөн байна.

*Хүснэгт 22.* Гадаадад зорчсон Монгол Улсын иргэд

| | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2023/2022 |
|---|---|---|---|---|---|---|
| Автсрали | 5,562 | 877 | 374 | 6,112 | 11,304 | ▲ 85% |
| АНУ | 15,987 | 2,432 | 5,690 | 13,342 | 13,908 | ▲ 4% |
| АНЭУ* | 969 | 290 | 653 | 2,436 | 1,959 | ▼ -20% |
| БНСУ | 97,017 | 18,571 | 9,542 | 74,545 | 147,257 | ▲ 98% |
| Хятад | 1,791,374 | 467,076 | 224,368 | 345,407 | 1,415,917 | ▲ 310% |
| ОХУ | 344,267 | 48,402 | 12,222 | 157,739 | 264,746 | ▲ 68% |
| Тайланд | 7,842 | 1,967 | 2,410 | 8,320 | 13,286 | ▲ 60% |
| Турк | 7,165 | 3,038 | 10,161 | 31,928 | 25,800 | ▼ -19% |
| Герман | 10,241 | 2,673 | 2,682 | 12,327 | 17,138 | ▲ 39% |
| Япон | 27,953 | 6,380 | 2,365 | 22,342 | 39,199 | ▲ 75% |
| Бусад | 106,736 | 20,161 | 11,760 | 54,140 | 92,563 | ▲ 71% |
| Бүгд | 2,415,113 | 571,867 | 282,227 | 728,638 | 2,043,077 | ▲ 180% |

*Эх сурвалж:* Монгол Улсын нийгэм эдийн засгийн байдал, ҮСХ

2023 онд Монгол иргэдийн хамгийн түгээмэл зорчсон улс орнууд нь Австрали, БНСУ, Хятад, ОХУ, Тайланд, Япон зэрэг улс орнууд байна. Харин Турк, Арабын нэгдсэн эмират улс руу зорчсон Монголчуудын тоо 2023 онд өмнөх онтой харьцуулахад эрс буурсан үзүүлэлттэй байна.

КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

*Хүснэгт 23.* Монгол Улсын хилээр орсон гадаад зорчигчид

| Бүс нутаг | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | | 2023/2022 |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зүүн Ази, Номхон далай | 389,581 | 27,806 | 12,799 | 103,374 | 350,738 | ▲ | 239% |
| БНХАУ | 208,449 | 17,340 | 7,519 | 13,972 | 139,936 | ▲ | 902% |
| БНСУ | 103,379 | 5,515 | 2,639 | 54,692 | 141,420 | ▲ | 159% |
| Казахстан | 25,163 | 1,564 | 806 | 17,738 | 20,990 | ▲ | 18% |
| Европ | 207,851 | 35,931 | 2,054 | 177,833 | 260,606 | ▲ | 47% |
| ОХУ | 146,783 | 30,980 | 14,231 | 157,309 | 219,966 | ▲ | 40% |
| Беларусь | 12,654 | 2,338 | 4,509 | 4,194 | 6,938 | ▲ | 65% |
| Герман | 10,716 | 641 | 560 | 4,175 | 9,532 | ▲ | 128% |
| Америк | 27,174 | 1,862 | 2,054 | 11,086 | 17,786 | ▲ | 60% |
| Өмнөд Ази | 4,381 | 296 | 643 | 2,157 | 4,349 | ▲ | 102% |
| Ойрхи Дорнод | 5,453 | 620 | 1,917 | 4,668 | 8,741 | ▲ | 87% |
| Африк | 2,480 | 422 | 401 | 1,391 | 1,835 | ▲ | 32% |
| Харьяалалгүй | - | 3 | 3 | 11 | 9 | ▼ | -18% |
| Бүгд | 636,920 | 66,940 | 39,236 | 300,520 | 644,064 | ▲ | 114% |

*Эх сурвалж:* Монгол Улсын нийгэм эдийн засгийн байдал, ҮСХ

2023 онд Үндэсний статистикийн хорооноос 2020 оны "Хүн ам, орон сууцны тооллого"-ын тоон мэдээн дээр үндэслэн гадаад улсад оршин сууж байгаа 122.3 мянган иргэнээс 1,865 иргэнийг түүврийн аргаар сонгож "Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн нөхцөл байдлын судалгаа"-ны үр дүнг танилцуулсан. Тус судалгааны үр дүнгээс олон улсын мөнгөн гуйвуулгын зах зээлийн ерөнхий төрх, шинж байдлыг тодорхойлов.

*График 39.* Гадаад улсад оршин сууж буй Монгол иргэдийн тоо, 2020 оны байдлаар




*Эх сурвалж:* "Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн нөхцөл байдал" судалгаа 2023 он, ҮСХ

СЗХ
2024 .08 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

*График 40.* Гадаад улсад оршин суугаа Монгол иргэдийн мөнгөн гуйвуулгын мэдээлэл




| Мөнгөн гуйвуулгын жилийн дундаж хэмжээ, (мянган төгрөг) | |
|---|---|
| **Хүйс** | |
| Эрэгтэй | 25,518.3 |
| Эмэгтэй | 16,659.3 |
| **Насны бүлэг** | |
| 18-22 | 8,834.3 |
| 23-30 | 20,342.7 |
| 31-40 | 21,837.9 |
| 41-50 | 18,044.7 |
| 51, түүнээс дээш | 25,129.7 |
| **Дундаж** | 20,200.5 |

*Эх сурвалж:* “Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн нөхцөл байдал” судалгаа 2023 он, ҮСХ

Гадаад улсад оршин сууж буй иргэд жилд дунджаар 20.2 сая төгрөгийн мөнгөн гуйвуулга илгээдэг. Үүнээс 23-40, 51 ба түүнээс дээш насны иргэд хамгийн өндөр дүнтэй мөнгөн гуйвуулга хийдэг байна. Судалгаанд оролцсон 1,865 иргэнээс жилд ядаж нэг удаа гуйвуулга хийсэн 1,306 иргэдийн дунд 3-5 удаа мөнгөн гуйвуулга хийдэг иргэдийн тоо 403 буюу 30.8 хувийг эзэлж байна.

*Хүснэгт 24.* Мөнгөн гуйвуулгын жилийн дундаж хэмжээ, (мянган төгрөг)




*Эх сурвалж:* “Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн нөхцөл байдал” судалгаа 2023 он, ҮСХ

УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024.06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

Мөн нэг жилд дунджаар Монгол Улс руу Швейцарь, Австрали, Чех, БНСУ, АНУ-д ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэд хамгийн өндөр дүнтэй мөнгөн гуйвуулгын шилжүүлэг хийдэг. Тухайлбал, Австрали улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын нэг иргэн жилд дунджаар 28,437.0 мянган төгрөгийн мөнгөн гуйвуулга хийдэг бол БНСУ-д ажилладаг Монгол Улсын нэг иргэн жилд дунджаар 22,751.5 мянган төгрөгийг эх орон руугаа мөнгөн гуйвуулгаар шилжүүлдэг байна.

*График 41.* Жилийн дундаж мөнгөн гуйвуулга, бусад илгээмжийн орлогод эзлэх хувь




*Эх сурвалж:* "Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн нөхцөл байдал" судалгаа 2023 он, ҮСХ

Гадаад улсад оршин сууж байгаа Монгол Улсын иргэдийн 60.5 хувь нь жилийн орлогынхоо 20 хүртэлх хувийг эх орон руугаа мөнгөн гуйвуулга болон биет илгээмж (гар утас, компьютер гэх мэт) хэлбэрээр илгээдэг. Харин 18.1 хувь нь нийт орлогынхоо 20-39 хувийг Монгол Улс руу мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр илгээдэг байна.

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

СЗХ 2024 оны 06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## 3.4. ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА

2023 оны 3 дугаар улирлын байдлаар цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын тусгай зөвшөөрөлтэй 45 ББСБ үйл ажиллагаа явуулж байна. Финтек үйлчилгээ хүргэдэг ББСБ-уудын харилцагчдын тоо 3.8 сая хүрсэн ба идэвхтэй зээлдэгчдийн тоо 1.2 сая хүрчээ. ББСБ-уудаас зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг 339 ББСБ байна.

*Схем 8*. Финтекийн үйлчилгээ үзүүлэгчдийн нэгдсэн матриц




*Эх сурвалж:* App store, Play store, 2022 оны 5 дугаар сарын байдлаар

Дээрх матрицаас харвал Үнэт цаас гаргагч Сэндли ББСБ нь цахим зээл олгодог, онлайнаар мөнгөн гуйвуулгын үйлчилгээг хийдэг цорын ганц өрсөлдөөний давуу тал бүхий компани юм.

### Финтек ББСБ салбарын өрсөлдөгч компаниуд

2023 оны 3 дугаар улирлын байдлаар 32 ББСБ журмын шаардлага хангаж, аппликэйшнээ бүртгүүлснийг СЗХ-ны албан ёсны вэб хуудсанд байршуулсан байна. Мөн нийт финтек үйлчилгээтэй ББСБ-уудаас зөвхөн аппликэйшнээр зээл олгодог дараах 6 ББСБ байна.

*Хүснэгт 25.* Зөвхөн аппликэйшнээр зээл олгодог ББСБ

| № | Финтек | Аппликэйшний нэр | Татлат, Play store |
|---|---|---|---|
| 1 | Соно финтек | Sono Mongolia | +500k |
| 2 | Мобифинанс | Monpay | +1M |
| 3 | Тус финтек | Tus fintech | +100k |
| 4 | Инвескор хэтэвч | Pocket.mn | +500k |
| 5 | Кэйш флов финанс | Tugrug app | +50k |
| 6 | Смарткапитал фанд | My credit | +50k |

*Эх сурвалж:* Санхүүгийн зохицуулах хороо

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855
Sendly

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

Үнэт цаас гаргагч нь харилцагчдад цахимаар зээлийн эрх олгохоос гадна салбар нэгжээс уламжлалт байдлаар зээл авсан харилцагчийн зээлийн үлдэгдлийг аппликэйшнд харуулах, аппликэйшн ашиглаж зээлээ төлөх, хянах боломжийг хангасан. Мөн зээлийн эргэн төлөлтийг харилцагчийн арилжааны банкны картаас автомат таталт хийж болдгоороо бусад ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-аас өрсөлдөөний хувьд маш том давуу талтай юм.

*Хүснэгт 26.* ББСБ-ын тусгай зөвшөөрөл эзэмшигчид, өрсөлдөгчдөөр

| Тусгай зөвшөөрөл | ББСБ тоо | Sendly | lendmn | ARD | InvesCore | sendmn |
|---|---|---|---|---|---|---|
| Зээл | 479 | + | + | + | + | + |
| Факторинг үйлчилгээ | 51 | + | + | | + | |
| Төлбөрийн баталгаа гаргах | 28 | + | | | + | |
| Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах | 6 | | + | | | |
| Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ | 45 | + | + | + | | + |
| Гадаад валютын арилжаа | 147 | + | + | + | | + |
| Итгэлцлийн үйлчилгээ | 82 | + | + | + | + | |
| Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх | 26 | | | + | + | |
| Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх | 39 | | + | + | + | |

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Финтекийн салбарт дээрх 45 ББСБ-аас гадна арилжааны 12 банк, 2 оператор компани үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс МХБ-д бүртгэлтэй ЛэндМН ББСБ, Ард Кредит ББСБ, Инвескор ББСБ-уудаас гадна СэндМН ББСБ нар финтек салбартаа тэргүүлж байна. Эдгээр ББСБ-уудтай харьцуулбал Сэндли ББСБ нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээг технологийн шийдэлтэй хослуулан зах зээлд нэвтрүүлснээрээ онцлогтой.

*Хүснэгт 27.* Цахим үйлчилгээ үзүүлэгч ББСБ-уудын үйлчилгээний харьцуулсан үзүүлэлт

| | Sendly | lendmn | pocket | ARD Credit NBFI | simple | storepay | sendmn |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зээл олгох | √ | √ | √ | √ | √ | | √ |
| Шилжүүлэг хийх | √ | √ | √ | √ | √ | | √ |
| Цахим мөнгөний үйлчилгээ | | √ | √ | √ | | | |
| Оноо цуглуулах | √ | √ | √ | | | √ | |
| Төлбөр тооцоо хийх | √ | √ | √ | √ | | √ | |
| Онлайн худалдаа | √ | √ | √ | √ | | √ | |
| Гадаад мөнгөн гуйвуулга | √ | | | | | | √ |
| Картын төлбөрийн систем | | | | | | | √ |
| Харилцагчийн тоо / Апп таталт | +10k | +1M | +500k | +50k | +100k | +100k | +10k |

*Эх сурвалж:* play store

## Мөнгөн гуйвуулгын өрсөлдөгчид

Үнэт цаас гаргагчийн үзүүлж буй мөнгөн гуйвуулгын үйлчилгээтэй өрсөлдөхүйц нэгэн төрлийн үйлчилгээ үзүүлдэг компаниудын шилжүүлгийн дүн, шилжүүлгийн шимтгэлийн дүнг доор харууллаа.

*Хүснэгт 28.* Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч компаниудын мэдээлэл

| Компани | Улсууд | Валют | Шимтгэл | Байгуулагдсан он | Байршил |
|---|---|---|---|---|---|
| MoneyGram | Дэлхийн 200 гаруй оронд байрлах 347,000 салбар нэгжүүдээс мөнгө гуйвуулах, мөнгө хүлээн авах боломжтой | 50+ | - Тухайн улсаас хамааран 2 хүртэл хувийн шимтгэлтэй | 1980 он | АНУ, Техас муж |
| Western Union | Дэлхийн 200 гаруй орон руу мөнгө гуйвуулах, мөнгө хүлээн авах боломжтой | 170+ | - Тухайн улсаас хамааран 1- 2 хувийн шимтгэлтэй | 1851 он | АНУ, Колорадо муж |
| Swift | Дэлхийн 200 гаруй оронд байрлах 11,000 салбар нэгжүүдээс мөнгө гуйвуулах, мөнгө хүлээн авах боломжтой | 200+ | - Тухайн улсаас хамааран 0.1-1.5 хувийн шимтгэлтэй | 1973 он | Белги улс, Ла Холпи муж |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -05- 17
БҮРТГЭВ-02

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| sendmn | Бэлнээр дэлхийн 170 гаруй орон, Онлайнаар Австрали, Япон, Солонгос зэрэг ази номхон далайн бүсийн 11 орон дээр нь Пакистан, Орос, Турк зэрэг улсууд | 10+ | - Тухайн улсаас хамааран 0.1-1.5 хувийн шимтгэлтэй | 2016 он | Монгол улс, Улаанбаатар хот |
| PUBLIC CREDIT | Дэлхийн 160 гаруй улсын 400.000 гаруй салбар нэгжээр дамжуулан бэлнээр мөнгө шилжүүлэх боломжтой. | 4 | 1.5-2.5% | 2016 он | Монгол улс, Улаанбаатар хот |
| Хувь хүн | Бэлэн, Онлайн аль аль нь болно. | - | Нэгдсэн нэг шимтгэлийн дүн гэж байхгүй, шимтгэл багатай ч ханш өндрөөр бодогддог. | - | - |

*Эх сурвалж:* Андеррайтерийн судалгаа

Монгол улсын 21 аймагт үйл ажиллагаа явуулж буй нийт 181 ББСБ байгаа бөгөөд, үүнээс Орхон аймагт хамгийн олон, харин Говь-Алтай аймагт хамгийн цөөн ББСБ-ын салбар нэгж байдаг байна. Одоогийн байдлаар Сэндли ББСБ нь нийт 18 аймагт өөрийн салбар нэгжийг байгуулаад байна.

*Хүснэгт 29. Гадаад мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгчийн судалгаа*

| Өрсөлдөгчийн давуу тал | Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч |
|---|---|
| Хамгийн их улс руу шилжүүлдэг байгууллага | MoneyGram, Western Union, Swift |
| Хамгийн олон валютын төрлөөр гүйлгээ хийдэг байгууллага | Western Union |
| Хамгийн их хэрэглэгчтэй байгууллага | MoneyGram, Western Union |
| Шууд гүйлгээ буцаадаг байгууллага | MoneyGram, Western Union, Finablr |

*Эх сурвалж:* Андеррайтерийн судалгаа

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
5183855
9021031195 CTC2420

СЗХ 2024 он 06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

*Хүснэгт 30.* ББСБ-уудын орон нутаг дахь тархац

| Аймаг | ББСБ-ын тоо | Сэндли ББСБ | ЛэндМН | Ард | Инвескор |
|---|---|---|---|---|---|
| Архангай аймаг | 10 | 3 | - | - | - |
| Баян-Өлгий аймаг | 7 | 1 | - | - | - |
| Баянхонгор аймаг | 12 | 1 | - | - | - |
| Булган аймаг | 4 | 1 | - | - | - |
| Говь-Алтай аймаг | 3 | - | - | - | - |
| Говьсүмбэр аймаг | 5 | 2 | - | - | - |
| Дархан-Уул аймаг | 21 | 2 | - | - | - |
| Дорноговь аймаг | 10 | 4 | - | - | - |
| Дорнод аймаг | 19 | 3 | - | - | - |
| Дундговь аймаг | 5 | 2 | - | - | - |
| Завхан аймаг | 6 | 2 | - | - | - |
| Орхон аймаг | 27 | 1 | - | - | 1 |
| Өвөрхангай аймаг | 22 | 5 | - | - | - |
| Өмнөговь аймаг | 16 | 3 | - | - | - |
| Сүхбаатар аймаг | 12 | 4 | - | - | - |
| Сэлэнгэ аймаг | 18 | 6 | - | - | - |
| Төв аймаг | 23 | 1 | - | - | - |
| Увс аймаг | 11 | 3 | - | - | - |
| Ховд аймаг | 7 | 1 | - | - | - |
| Хөвсгөл аймаг | 13 | 1 | - | - | - |
| Хэнтий аймаг | 12 | 4 | - | - | - |
| Дүн | 263 | 50 | - | - | 1 |

*Эх сурвалж:* Санхүүгийн зохицуулах хороо

Сэндли ББСБ нь орон нутагт 50 салбартай, Улаанбаатар хот, Налайх, Багануур дүүрэгт 7 салбартай нийт 57 салбартайгаар үйл ажиллагаа идэвхтэй явуулж байна. Энэхүү өргөн тархсан салбар нэгжээрээ дамжуулан Сэндли ББСБ нь зээл, итгэлцлийн үйлчилгээг орон нутгийн харилцагч нарт хүргэн ажиллах хүний нөөц, харилцагчдын бааз, бүтээгдэхүүн үйлчилгээний танигдсан байдал зэрэг харьцангуй давуу талуудтай байна.

## Хувьцааны ханшийн мэдээлэл

*Хүснэгт 31.* ББСБ-уудын хувьцааны ханшийн мэдээлэл

| № | ББСБ | Симбол | Зах зээлийн үнэлгээ*, (тэрбум төгрөг) | Ханш*, (төгрөг) | P/E харьцаа | Ногдол ашиг тараах хувь** | Ногдол ашгийн өгөөж** |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Сэндли | SEND | 30.8 | 137.8 | 5.1 | 20.7% | 4.1% |
| 2 | Инвескор | INV | 537.8 | 7,100.0 | 11.5 | 8.6% | 0.7% |
| 3 | Ард кредит | ADB | 37.8 | 103.9 | 15.0 | 40.5% | 2.7% |
| 4 | ЛэндМН | LEND | 57.9 | 78.3 | 1.2 | 12.4% | 10.2% |
| | | Дундаж | | | 8.2 | 20.5% | 4.4% |

*Тайлбар: *2024.04.17-ны өдрийн МХБ дээрх хаалтын ханш, **-2023 оны санхүүгийн үр дүн*

*Эх сурвалж:* Монголын хөрөнгийн бирж

УЛААНБААТАР ХОТ ... КАПИТАЛ ҮЦК 5183855 9021031195 CTC2420
СЭНДЛИ БОНД ХХК УЛААНБААТАР ХОТ

Нээлттэй хувьцаат компани хэлбэртэй ББСБ-уудын ханшийн мэдээллийг харвал Сэндли ББСБ-ын ногдол ашгийн өгөөж 4.1 хувь, цэвэр ашгаас ногдол ашиг тараалт 20.7 хувь буюу салбарын дундаж үзүүлэлтүүдтэй ойролцоо байна.

*График 42.* Зах зээлд эзлэх хувь (зөвхөн нээлттэй ХК хувьд)




*Эх сурвалж:* Монголын хөрөнгийн бирж

Хувьцааны ханш хэт өндрөөр үнэлэгдсэн эсвэл хэт багаар үнэлэгдсэн эсэхийгг харуулдаг үнэ-ашгийн харьцаа (P/E) үзүүлэлт ББСБ-ын салбарын хувьд 8.2 байгаа бол Сэндли ББСБ-ын хувьцааны үнэ-ашгийн харьцаа 5.1 буюу финтек компанийн хувьд харьцангуй салбарын дундаж үнэлгээтэй ойрхон үнэлгээтэй байна.

*График 43.* Ногдол ашгийн өгөөж ба Үнэ-ашгийн харьцаа




*Эх сурвалж:* Монголын хөрөнгийн бирж

Сэндли ББСБ ХК-ийн хувьцааны ногдол ашгийн өгөөж болон үнэ ашгийн харьцаа үзүүлэлт нь ижил салбарын компаниудын хувьцааны дундаж үзүүлэлттэй ойролцоо байна. Хамгийн өндөр ногдол ашгийн өгөөжтэй хувьцаа нь ЛэндМН ББСБ-ын хувьцаа байгаа бол хамгийн өндрөөр үнэлэгдсэн байж болох хувьцаа нь Ард Кредит ББСБ-ын хувьцаа байна.

СЗХ
2024 он 05 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

## 3.4. SWOT ШИНЖИЛГЭЭ

*Хүснэгт 32.* Үнэт цаас гаргагчийн SWOT шинжилгээ

| Давуу тал | Сул тал |
|---|---|
| - **Хамгийн олон салбар нэгж:** Сэндли ББСБ нь Улаанбаатар хотод 7, орон нутагт 50 салбартай. Монголын хамгийн олон салбартай ББСБ юм.<br>- **Анхдагч ББСБ:** Мөнгөн гуйвуулга хийх улс орнуудын зохицуулагч байгууллагаас "Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл" авч финтек технологи ашиглан Монгол Улсад үйлчилгээ үзүүлж буй анхдагч ББСБ юм.<br>- **Анхдагч үйлчилгээ:** Хилийн чандад байгаа Монгол иргэдэд орон сууцны зээлийн үйлчилгээ, үнэт цаасны арилжаанд орох, сайн дурын нийгмийн даатгал, онлайн худалдаа гэх мэт нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангасан үйлчилгээг аппликэйшнээр дамжуулан хүргэдэг анхны ББСБ юм.<br>- **Экосистем:** Хай Пэймент Солюшн ХХК, Радикс технологи ХХК-тай хамтран өөрсдийн бизнес модель, зээлийн коре системдээ тулгуурлан Сэндли экосистемийг бүрдүүлж байна.<br>- **Токен сервис:** Гадаадын банкны данс болон картын мэдээллийг Sendly аппликэйшн дээр тодорхой хугацаанд势 хадгалж болох тул гүйлгээ хийх тоолонд картын мэдээлэл оруулах шаардлагагүй.<br>- **Аюулгүй байдал:** Картын төлбөрийг аюулгүй дамжуулах (PCI DSS) олон улсын стандартыг хангасан.<br>- **Синержи:** Sendly аппликэйшнээр HiPay дансаа цэнэглэн аппликэйшн доторх үйлчилгээг авах боломжтой.<br>- **Найдвартай:** Олон улсын стандартыг хангасан найдвартай, албан ёсны мөнгөн гуйвуулгын үйлчилгээг хэрэглэгчдэд санал болгодог.<br>- **WeChat-тай хамтардаг:** WeChat-тай интеграц хийгдэж Монголын финтек компаниудад төлбөрийн шийдлийг нэвтрүүлсэн.<br>- **ACH:** Зээл олголтыг тухайн хэрэглэгчийн хүссэн банкны дансруу Hipay системээр дамжуулан Монголбанкны ACH-р шууд хийж гүйцэтгэдэг.<br>- **Автомат таталттай:** Hipay-ийн карт хүлээн авах зөвшөөрөл, карт хадгалах токен сервис үйлчилгээг ашиглан зээлдэгчийн эргэн төлөлтийг автоматаар буюу recurring payment-ээр төлдөг.<br>- **Хувьцаат компани:** Сэндли ББСБ нь нээлттэй хувьцаат компани тул засаглалын бүтэц, олон нийтийн хяналт сайн, санхүү ба үйл ажиллагааны тайлагнал тогтмолжсон. | - **Зорилтот сегментдээ хэт төвлөрсөн:** Зах зээлийн нэвтрэлт нь мерчант, богино хугацаат зээл дээр төвлөрсөн ба лизинг, онлайн худалдан авалтын зээлийн үйлчилгээ дутмаг байна.<br>- **Шинэ үйлчилгээ нэвтрүүлэх хугацаа:** Шинэ үйлчилгээгээ хэрэглэгчдэд таниулахад хугацаа их зарцуулдаг.<br>- **Шаардлага өндөр:** Харилцагчийг таньж мэдэх стандарт нь шат дараалсан хяналттай тул шинэ харилцагчид тавигдах шаардлага өндөр.<br>- **Цаг хугацаа:** Үйлчилгээгээ шинээр нэвтрүүлж буй улсуудын зохицуулагч байгууллагын дүрэм стандартаас шалтгаалж тусгай зөвшөөрлийг авахад цаг хугацаа, зардал их зарцуулдаг.<br>- **Иргэдийн технологийн чадавх:** нийт зээлийн багцын дийлэнх хувийг эзэлдэг орон нутгийн зээлдэгч нар нь ухаалаг утас, шинэ технологийг хэрэглэх чадвар сул байдгаас зээл олгох, зээлийн эргэн төлөх үйл ажиллагаанд ажилтнууд цаг их зарцуулдаг. |

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО
ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2024.06.10 өдөр
БҮРТГЭВ
1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

| Аюул | Боломж |
|---|---|
| - **Өрсөлдөөн их:** Финтекийн салбар хурдацтай хөгжиж байгаа учир дотоод өрсөлдөөн их.<br>- **Хууль эрх зүй:** Шинээр мөрдөгдөх СЗХ-ны “ББСБ-ын зээлийн үйл ажиллагааны журам”-ын дагуу Финтек ББСБ-уудад тавигдах шаардлага өндөр болсон<br>- **Тогтворгүй байдал:** Хэрэв Монгол Улс дахин саарал жагсаалтад орох тохиолдолд өөр улсад мөнгөн гуйвуулгын үйлчилгээг шинээр нэвтрүүлэхэд хязгаарлалтад орох эрсдэлтэй.<br>- **Давагдашгүй хүчин зүйлс:** Цар тахал, байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөгөөр тодорхойгүй нөхцөл байдал болсон тохиолдолд зээлийн үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй.<br>- **Эдийн засаг удаашрах:** Украины дайн, БНХАУ-ын үл хөдлөх салбарын хямрал Монгол Улсын эдийн засгийн гол тулгуур экспортын орлогод сөргөөр нөлөөлж, улмаар харилцагчдын зээлжих чадвхи, зээлийн эргэн төлөлтөд нөлөөлөх эрсдэлтэй.<br>- **Орлуулах бүтээгдэхүүн:** Зах зээл дээр хямд өртөгөөр гадаад гуйвуулга хийх ижил төстэй аппликэйшнууд, бизнес модель түгээмэл болж байна. Иймд гадаад мөнгөн гуйвуулгын зах зээл дээр өрсөлдөөн ширүүсэх эрсдэлтэй. | - **Тэргүүлэх:** Сэндли ББСБ нь Хөгжингүй орнуудын санхүүгийн зохицуулагч байгууллагууд, компаниудтай хамтран ажилласнаар компанид шинэ инновац нэвтрүүлж салбартаа тэргүүлэх боломжтой.<br>- **UnionPay:** UnionPay картын системийг ашиглан тухайн сүлжээ нэвтэрсэн бүх улс, оронд мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх боломжтой.<br>- **Шинэ бүтээгдэхүүн:** Мөнгөн гуйвуулга нэвтэрсэн улс орнуудад ажиллаж амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх боломжтой.<br>- **Зардлыг бууруулах:** Орон нутгийн 50 салбараар дамжуулан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, нэгж бүтээгдэхүүнд ногдох зардлыг бууруулах боломжтой.<br>- **Олон улсын санхүүжилт:** Сэндли ББСБ нь гадаадын биржүүдэд бүртгүүлэх, улмаар нэмэлт эх үүсвэр бүрдүүлэх, хөрөнгө оруулагчдыг татах бүрэн боломжтой.<br>- **Зээлийн бүтээгдэхүүн төрөлжүүлэх:** Шинээр харилцагчдын эрэлт хэрэгцээнд тохирсон зээлийн бүтээгдэхүүн хөгжүүлж, орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх боломжтой. |

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИ ХХК
5183855
9021031195 СТС2420

Сэндли
БОНД 2.0

# 4. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн, бизнесийн төсөөлөл

2024

ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР

ULZII & CO CAPITAL

ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР

RHINOS Investment

Golomt Capital

СЗХ 2024 он 06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## 4.1. ДУНД ХУГАЦААНЫ БИЗНЕСИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 4.1.1. Зээлийн үйл ажиллагааны төлөвлөгөө

Сэндли ББСБ нь бизнесийн үйл ажиллагааны гол чиглэл зээлийн үйл ажиллагаагаа дунд хугацаанд өргөжүүлэхдээ зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний төрөлжилт, хүртээмжид анхаарч автомашины лизингийн зээл, ногоон зээл, хэрэглээний зээл, Алипэй+ зээлийн бүтээгдэхүүний зах зээлээ тэлэхээр төлөвлөж байна.

*Хүснэгт 33.* Идэвхтэй харилцагчдын төсөөлөл

| Харилцагчийн тоо | 2024 | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|
| EasyBuy | 20,122 | 22,385 | 14,924 | 7,462 |
| Хэрэглээний зээл | 9,412 | 9,610 | 9,850 | 10,331 |
| Мерчант зээл | 4,943 | 4,937 | 4,967 | 4,997 |
| Эргэлтийн хөрөнгийн зээл | 120 | 134 | 146 | 157 |
| Зээлийн шугам | 148 | 129 | 76 | 46 |
| Үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл | 557 | 616 | 739 | 1108 |
| Автомашин барьцаалсан зээл | 1,047 | 1,485 | 2,227 | 2,784 |
| Малчны зээл | 1,724 | 2,031 | 2,538 | 3,046 |
| Итгэлцэл барьцаалсан зээл | 168 | 174 | 209 | 244 |
| Лизингийн зээл (автомашин) | 339 | 554 | 937 | 1,267 |
| Лизингийн зээл (бусад) | 2,340 | 2,495 | 3,326 | 5,359 |
| Алипэй+ зээл | 2,458 | 1,144 | 458 | 500 |
| Ногоон зээлийн бүтээгдэхүүн | 353 | 480 | 639 | 799 |
| **Нийт** | 43,731 | 46,174 | 41,036 | 38,100 |

*Эх сурвалж:* Компанийн бизнесийн төсөөлөл

Хэрэглээний зээлийн хувьд 2027 онд 10.3 мянган идэвхтэй харилцагч татахаар төлөвлөж байгаа бөгөөд цалингийн орлоготой, өр орлогын зохистой харьцааг хангасан зээлдэгч нарт олгох зээлийн бүтээгдэхүүн байна. Үнэт цаас гаргагчийн үндсэн зээлийн бүтээгдэхүүн болох худалдаа эрхлэгчдэд олгох мерчант зээлийн тоо 5.0 мянга орчимд хүрэх төлөвтэй байна.

Бага дүнтэй, өдөр тутмын хэрэглээний зардалд зориулсан EasyBuy зээлийн бүтээгдэхүүнийг 2027 онд 7.5 мянган харилцагч идэвхтэй ашиглах бол малчны зээлийн зээлдэгчдийн тоо 3.0 мянга хүрэх төсөөлөлтэй байна. Харин автомашин барьцаалсан зээлийн тоог 2027 онд 2,784 хүргэх ба ногоон зээлийн бүтээгдэхүүнийг 2023 онтой харьцуулахад 2 дахин нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна.

Алипэй+ буюу Алипэй үйлчилгээ нэвтэрсэн улс орнуудад аялж буй Монгол Улсын иргэн өөрийн гар утасны аппликэйшнээр дамжуулан гадаад оронд худалдан авалт хийх зээл авах боломжтой болох юм. Тус зээлийн харилцагчдын тоо 2024 онд 2,458 байх төсөөлөлтэй хэдий ч аажим буурсаар 2027 онд 500 орчим идэвхтэй харилцагчтай байх төсөөлөлтэй байна.

СЗХ
2024.06.10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

### 4.1.1. Мөнгөн гуйвуулгын үйл ажиллагааны төлөвлөгөө

*Хүснэгт 34*. Мөнгөн гуйвуулгын үйл ажиллагааны төлөвлөгөө

| Шинээр хийгдэх ажлууд | 2024-I | 2024-II | 2024-III | 2024-IV | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ■ | | | | | |
| АНУ-ын 50 мужаас шилжүүлэг хийх | | ■ | | | | | |
| Англи (ИБУИНВУ) улсаас гуйвуулга хийх | | | ■ | | | | |
| ОХУ-Монгол шилжүүлэг нээх | | | | | ■ | | |
| Австрали, Канад улсаас шилжүүлэг хийх | | | | ■ | | | |
| Wechat pay цахим хэтэвч цэнэглэх үйлчилгээ | | | | ■ | | | |
| Бусад гуйвуулгын гарц нээх | | | | | | ■ | ■ |

*Эх сурвалж:* Компанийн бизнесийн төсөөлөл

АНУ-ын 50 мужаас шилжүүлэг хийх боломжийг 2024 оны эхний хагас жилд багтаан нээнэ. Харин Англи, Австрали, Канад улсаас гуйвуулга хийх гарцыг 2024 онд нээх зорилготой ажиллаж байна. Мөн ОХУ-аас Монгол руу хийх мөнгөн гуйвуулгын үйлчилгээний гарцыг 2025 онд нэвтрүүлэхээр тус тус төлөвлөж байна.

### Үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө

*Хүснэгт 35.* Үйл ажиллагааны төлөвлөгөө, чиглэлээр

| | |
|---|---|
| Бизнесийн нэгж, салбар нээх | Сэндли ББСБ ХК нь 2024 оны 3-р улирал Говь-Алтай аймагт шинэ салбар нээхээр төлөвлөж байна. 2025 онд Улаанбаатар хот Да хүрээ зах дээр автомашины зээлийн төв байгуулж нийт салбарын тоог 59 болгоно. |
| Үндсэн систем, апп, систем хөгжүүлэлт | Зээлийн суурь систем болох Коре программын хөгжүүлэлтийг тасралтгүй хийх бөгөөд үүнд доорхи ажлууд багтаж байна:<br>• Зээлийн суурь системийн хувилбар шинэчлэлтийг хийх<br>• Тайлангийн системийн хөгжүүлэлт хийх .<br>• Зээлийн мэдээллийн сангийн нийлүүлэлтийг Бүрэн болон Сайн скоринг системүүдэд холбох.<br>• Автомат скорингийн тооцоол хийх, хөгжүүлэлт, дата бааз бүрдүүлэх.<br>• Зээлийн эрсдэл, хууль хяналтыг процесийг сайжруулах хөгжүүлэлт хийх. |
| Эрсдэл хяналтын үйл ажиллагаа | • 2025 онд мэдээллийн аюулгүй байдлын ISO 27001-2022 стандарт баталгаажуулах аудит хийлгэнэ.<br>• Мөн БОНЗ-ын бодлого, дүрэм журам боловсруулан мөрдөн ажиллана. |

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2024 .06.10
БҮРТГЭВ
№ 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

| | |
|---|---|
| Тогтвортой хөгжил, тогтворжтой хөгжлийн үйл ажиллагаа | • Тогтвортой хөгжил, тогвортой санхүүжилтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх<br>• Ногоон зээлийн багцыг нийт зээлийн багцын 5%-аас дээш хувьд хүргэх<br>• Тогтвортой санхүүжилтын эх үүсвэрийг татах, зорилтот зах зээлд байршуулах |
| Санхүүгийн үйл ажиллагаа | • 2025-2027 оны санхүүгийн тайлангуудад олон улсын Аудитын байгууллагаар баталгаажуулалт хийлгэнэ.<br>• 2024 онд зээлжих зэрэглэлийг Зээлжих зэрэглэлийн ангилал тогтоох эрх бүхий байгууллагаар зэрэглэл тогтоолгоно.<br>• 2024-2027 онуудад ногдол ашиг тараах бодлогыг үргэлжлүүлж тайлант жилд тараах ногдол ашгийн хэмжээг 20 хувиас 40 хувь болтол өсгөнө.<br>• 2024-2027 онуудад эх үүсвэрийн дийлэнх хэсгийг итгэлцлийн үйлчилгээгээр бүрдүүлэн, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болох өөрийн хөрөнгийн 80% хүртэл итгэлцэл татна.<br>• 2024 оны 2-р улиралд 10 тэрбумын нээлттэй бонд гарган эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. 2026 онд мөн өөрийн хөрөнгийн 50%-д нээлттэй бонд гаргана. |

*Эх сурвалж:* Компанийн бизнесийн төсөөлөл

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЭХ 2024.06.10 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## 4.2. САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ

*Хүснэгт 36.* Санхүү байдлын тайлангийн төсөөлөл, (сая төгрөг)

| | 2024Т | 2025Т | 2026Т | 2027Т |
|---|---|---|---|---|
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 4,521 | 5,751 | 7,064 | 9,113 |
| Зээл (цэвэр дүнгээр) | 77,208 | 88,672 | 97,353 | 116,323 |
| Зээлийн багц (Нийт) | 79,390 | 91,116 | 100,800 | 120,545 |
| Зээлийн эрсдэлийн сан | (2,183) | (2,445) | (3,448) | (4,222) |
| Бусад хөрөнгө | 4,189 | 4,179 | 12,670 | 14,650 |
| Үндсэн хөрөнгө | 575 | 809 | 1,617 | 2,042 |
| Биет хөрөнгө /цэвэр/ | 244 | 395 | 862 | 987 |
| Биет бус хөрөнгө /цэвэр | 331 | 414 | 755 | 1,056 |
| **Нийт хөрөнгийн дүн** | 86,493 | 99,410 | 118,703 | 142,128 |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 26,877 | 34,812 | 40,800 | 50,200 |
| Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр | 7,300 | - | - | - |
| ББСБ-аас гаргасан өрийн бичиг | 10,000 | 10,000 | 20,000 | 20,000 |
| Бусад өр төлбөр | 7,652 | 9,022 | 4,467 | 4,480 |
| **Нийт өр төлбөр** | 51,829 | 53,834 | 65,267 | 74,680 |
| Энгийн хувьцаа | 11,179 | 11,179 | 11,179 | 11,179 |
| Халаасны хувьцаа | (519) | (519) | (2,500) | (2,500) |
| Нэмж төлөгдсөн капитал | 6,285 | 6,285 | 6,285 | 6,285 |
| Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг, алдагдал | 8,123 | 15,784 | 23,480 | 32,463 |
| Тухайн үеийн ашиг, алдагдал | 9,576 | 12,827 | 14,972 | 20,001 |
| Бусад өөрийн хөрөнгө | 21 | 21 | 21 | 21 |
| **Өөрийн хөрөнгө** | 34,664 | 45,576 | 53,436 | 67,448 |
| **Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн** | 86,493 | 99,410 | 118,703 | 142,128 |

*Эх сурвалж:* Компанийн санхүүгийн төсөөлөл

*График 44.* Нийт хөрөнгө ба нийт зээлийн төсөөлөл, (сая төгрөг)




Нийт хөрөнгө 2024 онд 86.4 тэрбум төгрөгт хүрч, цаашид жилд дунджаар 18.0 хувь өсөнөөр 2027 онд 142.1 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байна. Харин нийт зээлийн багц 2024 онд 79.4 тэрбум төгрөгт хүрэх бол 2027 он хүртэл жилд дунджаар 14.9 хувь өсөж 120.5 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна.

Үнэт цаас гаргагч нь 2027 он хүртэлх нийт хөрөнгийн өсөлтийг 2019 оноос 2023 оны 3 дугаар улирал хүртэлх банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгийн жилийн өсөлт 27.1 хувиас даруй 9.1 пунктээр багаар төсөөлсөн нь харьцангуй үндэслэлтэй таамаглал ашигласан гэж дүгнэж болох юм.

*График 45.* Нийт активын бүтцийн төсөөлөл, (сая төгрөг)




Нийт хөрөнгийн бүтцийг эх үүсвэр талаас харвал 2024 онд нийт хөрөнгийн 60.0 орчим хувийг өр төлбөрөөр санхүүжүүлэх бол 40.0 орчим хувийг хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашгаас бий болгох төсөөлөлтэй байна. 2027 онд нийт өр төлбөрийн дүн 2024 онтой харьцуулахад 44.1 хувь буюу 22.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэх төлөвтэй байна.

*График 46.* Өр төлбөрийн бүтцийн төсөөлөл, (сая төгрөг)




Нийт өр төлбөрийн бүтэц 2027 он гэхэд итгэлцлээр үүсгэсэн санхүүжилт 50.2 тэрбум төгрөгт хүрэх ба нийт өр төлбөрийн 67.2 хувийг бүрдүүлэх юм. Харин өрийн бичгээр татсан санхүүжилтийн хэмжээ 20.0 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байгаа ба нийт өр төлбөрийн 26.7 хувийг эзэлнэ. Өрийн хэрэгслээр татан төвлөрүүлэх дүнг санхүүгийн зохистой харьцааг хангах нөхцөлийн хүрээнд төсөөлжээ.

*Хүснэгт 37.* Орлого, үр дүнгийн тайлангийн төсөөлөл, (сая төгрөг)

| Үзүүлэлт | 2024Т | 2025Т | 2026Т | 2027Т |
|---|---|---|---|---|
| **Хүүгийн орлого** | **20,846** | **24,828** | **33,780** | **40,730** |
| Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого | - | - | 30 | 30 |
| Зээлийн хүүгийн орлого | 20,846 | 24,828 | 33,750 | 40,700 |
| **Хүүгийн зардал** | **7,498** | **8,191** | **12,350** | **14,342** |
| Итгэлцэлийн хүүгийн зардал | 4,567 | 5,906 | 8,650 | 10,642 |
| Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн | 977 | 365 | - | - |
| Өрийн бичгийн хүүгийн зардал | 1,954 | 1,920 | 3,700 | 3,700 |
| Цэвэр хүүгийн орлого | 13,348 | 16,637 | 21,430 | 26,388 |
| **Хүүгийн бус орлого** | **10,334** | **12,577** | **14,735** | **17,500** |
| Гадаад валютын арилжааны орлого | 420 | 483 | 535 | 700 |
| Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого | 2,431 | 2,674 | 2,850 | 3,550 |
| Зээлийн үйлчилгээний шимтгэл, хураамж | 6,146 | 7,682 | 8,500 | 9,800 |
| Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний орлого | 1,337 | 1,738 | 2,600 | 3,200 |
| Бусад орлого | - | - | 250 | 250 |
| **Хүүгийн бус зардал** | **11,568** | **13,049** | **16,400** | **17,645** |
| Гадаад валютын арилжааны зардал | 33 | 38 | 350 | 465 |
| Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал | 1,811 | 1,829 | 1,950 | 2,000 |
| Боловсон хүчний холбогдолтой зардал | 4,020 | 4,624 | 5,900 | 6,550 |
| Үйл ажиллагааны зардал | 5,704 | 6,559 | 8,050 | 8,480 |
| Бусад хүүгийн бус зардал | - | - | 150 | 150 |
| Цэвэр хүүгийн бус орлого | (1,234) | (472) | (1,665) | (145) |
| Зээлийн эрсдэлийн сангийн зардал | 546 | 262 | 1,003 | 775 |
| Татварын өмнөх ашиг, алдагдал | 11,568 | 15,902 | 18,762 | 25,468 |
| Орлогын татварын зардал | 1,992 | 3,076 | 3,791 | 5,467 |
| Татварын дараах ашиг, алдагдал | 9,576 | 12,827 | 14,972 | 20,001 |

*Эх сурвалж:* Компанийн санхүүгийн төсөөлөл

*График 47.* Нийт цэвэр орлогын төсөөлөл, (сая төгрөг)




2024 онд нийт цэвэр орлогын 56.4 хувь буюу 13.3 тэрбум төгрөгийг цэвэр хүүгийн орлогоос, үлдсэн 43.6 хувь буюу 10.3 тэрбум төгрөгийн үйлчилгээний шимтгэл хураамж, мөнгөн гуйвуулгын шимтгэл зэрэг хүүгийн бус орлогоос

СЗХ 2024 оны ... сар 10 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

олох төлөвтэй байна. 2024-2027 оны хооронд нийт цэвэр орлогын дүн жилд дунджаар 22.8 хувиар өсөх төлөвтэй байна.

Үүнээс бизнесийн үйл ажиллагаанд тусгасан орон нутаг дахь салбарын тэлэлт болон харилцагчдын тооны өсөлтөөс шалтгаалж зээлийн хүүгийн орлого жилд дунджаар 25.5 хувиар өсөх бол үйлчилгээний хураамж, мөнгөн гуйвуулгын шимтгэлийн орлго зэрэг хүүгийн бус орлого 19.2 хувиар өсөх төсөөлөлтэй байна.

*График 48*. Цэвэр ашгийн төсөөлөл, (сая төгрөг)




2024 онд Сэндли ББСБ-ын цэвэр ашгийн дүн 9.5 тэрбум төгрөг байх төсөөлөлтэй бол 2027 онд 20.0 тэрбум төгрөг хүрэх боломжтой гэж төсөөлсөн байна. Нийт цэвэр орлогын өсөлт 2024-2027 оны хооронд 22.8 хувь, эсрэгээр нийт хүүгийн бус зардлын өсөлт харьцангуй бага буюу 15.1 хувь байхаар төсөөлсөн тул цэвэр ашгийн дүн дунджаар 27.8 хувиар өсөх төлөвтэй байна.

*Хүснэгт 38*. Мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл, (сая төгрөг)

| | 2024Т | 2025Т | 2026Т | 2027Т |
|---|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | | |
| Цэвэр ашиг | 9,576 | 12,827 | 14,972 | 20,001 |
| Элэгдэл, хорогдлын зардал | 187 | 60 | 504 | 415 |
| Хүүгийн зардал | 7,498 | 8,191 | 12,350 | 14,342 |
| Татварын зардал | 1,992 | 3,076 | 3,791 | 5,467 |
| Гадаад валютын ашиг, (алдагдал) | (1,007) | (1,290) | (1,085) | (1,785) |
| Зээлийн эрсдэлийн зардал | 546 | 262 | 1,003 | 775 |
| Ажлын капиталын өөрчлөлт | (37,072) | (20,909) | (40,409) | (41,417) |
| Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | (18,280) | 2,216 | (8,876) | (2,202) |
| **Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ** | | | | |
| Үндсэн хөрөнгө борлуулсан | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгө худалдаж авсан | 98 | 294 | 1,312 | 841 |
| Халаасласан хувьцаа | (519) | - | (1,981) | - |
| Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ | (422) | 294 | (669) | 841 |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | | |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргасан | 7,300 | - | - | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн | (5,950) | (7,300) | - | - |
| Итгэлцлийн үйлчилгээ гаргасан | 15,000 | 18,000 | 22,000 | 30,000 |
| Итгэлцлийн үйлчилгээний төлбөр төлсөн | (7,614) | (10,065) | (16,012) | (20,600) |
| Бонд гаргасан | 10,000 | - | 20,000 | - |
| Бонд төлсөн | (8,500) | - | (10,000) | - |
| Ногдол ашиг төлсөн | (1,252) | (1,915) | (5,131) | (5,989) |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **8,984** | **(1,280)** | **10,857** | **3,411** |
| Нийт цэвэр мөнгөн гүйлгээ | (9,718) | 1,230 | 1,312 | 2,049 |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 14,239 | 4,521 | 5,751 | 7,064 |
| **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **4,521** | **5,751** | **7,064** | **9,113** |

*Эх сурвалж:* Компанийн санхүүгийн төсөөлөл

*График 49.* Мөнгөн гүйлгээ, төрлөөр (сая төгрөг)




Мөнгөн гүйлгээний дүнг төрлөөр ангилбал 2024 онд 10.0 тэрбум төгрөгийн бонд гаргах, итгэлцлийн үйлчилгээгээр 15.0 тэрбум төгрөгийн санхүүжилт татах зэрэг орох мөнгөн урсгал нэмэгдсэнээр санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 8.9 тэрбум төгрөгийн эерэг үлдэгдэлтэй гарах төсөөлөлтэй байна.

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний хувьд зээл олголт нэмэгдэхтэй холбоотойгоор 2024 онд 18.2 тэрбум төгрөг, 2026 онд 8.8 тэрбум төгрөгийн дутагдалтай байх ба энэхүү эх үүсвэрийн дутагдлыг 2024 онд итгэлцэл ба бондын санхүүжилтээр, 2026 онд 22.0 тэрбум төгрөгийн итгэлцэл, 20.0 тэрбум төгрөгийн бондын эх үүсвэрээр тус тус санхүүжүүлэх төлөвтэй байна.

2025-2027 оны хооронд өнгөрсөн жилийн цэвэр ашгаас 20.0 хувийн ногдол ашгийг тухайн онд олгохоор мөнгөн гүйлгээний тайлангийн санхүүгийн үйл ажиллагааны хэсэгт төсөөлжээ.

СЗХ 2024 он .06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

*Хүснэгт 39.* Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн төсөөлөл

| Зохистой үзүүлэлт | Байвал зохих | 2024Т | 2025Т | 2026Т | 2027Т |
|---|---|---|---|---|---|
| **Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт** | | | | | |
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 10%-аас доошгүй | 40% | 46% | 45% | 47% |
| Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 20%-аас доошгүй | 40% | 46% | 45% | 47% |
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа | 10%-аас доошгүй | 40% | 46% | 45% | 47% |
| **Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа** | | | | | |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | 8%-аас дээш | 8.7% | 10.7% | 10.8% | 12.2% |
| **Актив хөрөнгийн төвлөрлийн үзүүлэлт** | | | | | |
| Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 30%-аас хэтрэхгүй | 8.5% | 8.5% | 8.0% | 7.5% |
| Ббсб-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 70%-аас хэтрэхгүй | - | - | - | - |
| Ббсб-ын хувьцаа эзэмшигч, туз, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа | 25%-аас хэтрэхгүй | 22% | 20% | 18% | 17% |
| Ббсб-ын хувьцаа эзэмшигч, туз, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 10%-аас хэтрэхгүй | 8.5% | 8.5% | 8.0% | 7.5% |
| **Гадаад валютын ханшийн эрсдэл** | | | | | |
| Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | (+/-40%) | -36% | -37% | -25% | -25% |
| **Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн үзүүлэлтүүд** | | | | | |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 80%-аас хэтрэхгүй | 78% | 76% | 76% | 74% |
| Өрийн бичгийн зохистой харьцаа | 50%-аас хэтрэхгүй | 29% | 22% | 37% | 30% |
| **Үндсэн хөрөнгийн үзүүлэлт** | | | | | |
| Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа | 15%-аас хэтрэхгүй | 0.28% | 0.40% | 0.73% | 0.69% |
| **Өгөөж** | | | | | |
| Хөрөнгө /актив/-ийн өгөөж | | 13% | 14% | 14% | 15% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж | | 31% | 32% | 30% | 33% |

*Эх сурвалж:* Компанийн санхүүгийн төсөөлөл

Сэндли ББСБ нь бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн үзүүлэлт, активын төвлөрөл, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг 2024-2027 оны хооронд хангаж ажиллах төсөөлөлтэй байна.

Улаанбаатар хот Элит эндэ ко Хамтлагт ҮНК 5183855 9021031195 СТС2420

Сэндли

БОНД 2.0

# 5. Үнэт цаасны тухай

2024

ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР

ULZII & Co CAPITAL

ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР

RHINOS Investment

Golomt Capital

СЗХ 2024 .06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## 5.1. НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 5.1.1. Бондын нэрлэсэн үнэ, хугацаа, нөхцөл

Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 41 дүгээр зүйл, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 43 дугаар зүйлийн 43.1, 55 дугаар зүйлийн 55.2, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.16, 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 16 дугаар зүйл, Компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10 дахь хэсэг, 8.6.2, 8.6.12, 8.6.23 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хурлын 14 дугаартай тогтоолын дагуу Бондын нэрлэсэн үнэ, хугацаа, бусад нөхцөлийг доорх хүснэгтэд оруулснаар тогтоосон байна.

*Хүснэгт 40.* Бондын нэрлэсэн үнэ, хугацаа, бусад нөхцөл

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | Сэндли ББСБ ХК |
| Үнэт цаасны төрөл | Бонд буюу өрийн хэрэгсэл |
| Бондын арилжаа | Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй хүрээнд |
| Бондын төрөл | Тогтмол хүүтэй энгийн бонд |
| Нэгж бондын нэрлэсэн үнэ | 100,000.0 (нэг зуун мянга) төгрөг |
| Бондын нийт тоо, ширхэг | 100,000.0 (нэг зуун мянга) ширхэг |
| Бондын нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн | 10,000,000,000.0 (арван тэрбум) төгрөг |
| Бондын хугацаа | 24 (хорин дөрөв) сар |
| Бондын жилийн хүүгийн түвшин | 18.5 (арван найм аравны тав) хувь |
| Хүү төлөгдөх давтамж | Улирал тутамд (Бондын хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш улирал тутмын буюу 3 сар тутмын мөн өдрүүдэд хүүг төлөх бөгөөд хүүгийн төлбөр төлөх өдөр амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр төлнө.) |
| Үндсэн төлбөр төлөх | Хугацааны эцэст (Хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 24 дэх сарын мөн өдөр төлнө. Хэрэв амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр төлнө.) |
| Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт | Үндсэн үйл ажиллагаа буюу зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх |
| Бондын барьцаа | • Толгой компани нь өөрийн эзэмшиж буй үнэт цаас гаргагчийн 111,785,000 ширхэг хувьцааг холбогдох журмын дагуу барьцаалуулсан болно.<br>• Толгой компани нь өөрийн эзэмшиж буй газар эзэмших хоёр эрхээ хөндлөнгийн үнэлгээний компанийн тогтоосон 2,811,280,000 төгрөг бүхий үнэлгээнд үндэслэн барьцаалуулсан. |
| Бондын хадгалалт, төлбөр тооцоо | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |

УЛААНБААТАР ХОТ 5183855 9020031195 CTC2420

СЗХ 2024.06.10 өдөр БҮРТГЭВ № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## 5.2. ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

Үнэт цаас гаргагч нь өрийн хэрэгслийн хүүгийн түвшинг тогтоохдоо зах зээлийн нөхцөл байдал, ижил төстэй өрийн хэрэгслийн хүү, бодлогын хүү ба инфляц, эдийн засгийн тодорхой бус байдал, хөрөнгө оруулагчдын хүлээлтэд үндэслэн жилийн 18.5 хувийн хүүг санал болгож байна.

### Бодлогын хүү ба инфляц

Монгол Улсын инфляцын түвшин 2024 оны 3 дугаар сард 7.0 хувьд хүрснээр сүүлийн зургаан сар дараалан инфляцын түвшин нэг оронтой тоонд хадгалагдаж байна. Монголбанкны зүгээс 2022 онд нийт таван удаа бодлогын хүүг өсгөж 13.0 нэгжид хүргэсэн ба мөнгөний энэхүү хатуу бодлого 25 сар үргэлжилсэн юм.

Дээрх мөнгөний бодлогын хүүг 2024 оны 3 дугаар сарын Төв банкны мөнгөний бодлогын хорооны шийдвэрээр 1.0 нэгжээр бууруулж 12.0 хувьд тогтоосон нь зах зээлийн хүүгийн түвшин харьцангуй тогтворжих хүлээлт үүсгэж байна.

Гэвч Монголбанкны бодлогын хүүгийн өөрчлөлт нь гадаад хүчин зүйлс болох АНУ-ын мөнгөний бодлого, БНХАУ-ын эдийн засгийн нөхцөл байдал, Украины дайны хурцадмал шинж байдлаас шууд хамааарах тул хүүгийн түвшин өөрчлөгдөх тодорхой бус байдал хэвээр байна.

### Банкны хадгаламжийн хүү

Монголбанкны нээлттэй статистик мэдээлэлд тайлагнаснаар шинээр татсан төгрөгийн хугацаатай хадгаламжийн дундаж хүү 2024 оны 02 дугаар сард 11.4 хувь буюу өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 0.6 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Ийнхүү хадгаламжийн хүү сүүлийн зургаан сард 11.5 хувь орчимд хадгалагдсаар байгаа нь хөрөнгө оруулагчдын шаардах өгөөжийн хэмжээ өндөр байгааг илтгэж байна.

Монгол Улсын системийн нөлөө бүхий 5 банкны 12 сарын хугацаатай төгрөгийн хадгаламжийн зарласан хүүг харьцуулж харвал дунджаар 12.2 хувь байна. Тухайлбал, Төрийн банкны төгрөгийн энгийн нөхцөлтэй, 12 сарын хугацаатай хадгаламжийн зарласан хүүгийн түвшин хамгийн өндөр буюу 12.6 хувь байгаа бол Хас банкны хүүгийн түвшин харьцангуй бага буюу 11.0 хувь орчим байна.

### Нээлттэй бонд, ХБҮЦ-ны хүүгийн харьцуулалт

Зах зээл дээр нээлттэй арилжаалагдаж байгаа, хамгийн сүүлд гарсан нээлттэй бонд, ХБҮЦ-ны хүүгийн түвшинг харьцуулбал инфляцын өсөлт, бодлогын хүүгийн түвшин, банкны хадгаламжийн хүү болон ижил төстэй өрийн хэрэгслийн хүүтэй өрсөлдөхүйц түвшинд тогтоож байна.

*Хүснэгт 41.* Нээлттэй бонд, ХБҮЦ-ны хүү

| № | Бонд, ХБҮЦ-ны нэр | Хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдөр | Хүү (жилийн) |
|---|---|---|---|
| 1 | Бичил 3 ХБҮЦ | 2024.04.05 | 18.5% |
| 2 | Бэрс 3 ХБҮЦ | 2024.01.04 | 18.0% |
| 3 | Омни ассет ХБҮЦ | 2023.11.28 | 19.6% |
| 4 | Симпл Бонд II | 2023.10.17 | 17.5% |
| 5 | Инвескор Бонд | 2023.08.25 | 18.0% |
| 6 | Бичил 2 ХБҮЦ | 2023.06.28 | 18.5% |
| 7 | БИД Бонд | 2023.06.15 | 18.5% |
| 8 | Сэндли Бонд | 2023.01.30 | 19.2% |
| | **Дундаж** | | **18.48%** |

*Эх сурвалж:* Монголын хөрөнгийн бирж

Дотоодын эдийн засагт гарч буй гэнэтийн өөрчлөлтүүд нь үнэт цаас гаргагч нар хүүгийн түвшнээ тогтоох, санхүүжилтийн зардлаа төлөвлөхөд шууд нөлөөлдөг. Тухайлбал, дээрх хүснэгтээс харахад хүүгийн түвшинг хамгийн сүүлд нээлттэй гарсан гурван бонд, ХБҮЦ дээр ихээхэн ялгаатай тогтоосон байна.

*График 50.* Тогтмол өгөөжтэй хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн дундаж хүү




*Эх сурвалж:* Албан ёсны вэб хуудас

## 5.3. БОНДЫН БАРЬЦАА

Үнэт цаас гаргагчийн өрийн хэрэгслээр татан төвлөрүүлэх дүнгийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор Үнэт цаас гаргагчийн толгой компани “Монголын финтек групп” ХК нь өөрийн эзэмшиж буй “Сэндли ББСБ” ХК-ийн 111,785,000 ширхэг энгийн хувьцаа болон Дорноговь аймгийн нутагт орших хоёр газар эзэмших эрхээ барьцаалуулахаар ТУЗ-ийн 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн №31 тогтоолын дагуу шийдвэрлэсэн. Эдгээр барьцааны зүйлийг СЗХ-ны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын холбогдох заалтын дагуу зах зээлийн үнэлгээнд үндэслэн Үндсэн андеррайтер

“Өлзий энд Ко капитал ҮЦК” ХХК-д №БГ-24/05 Барьцааны гэрээний дагуу барьцаалуулсан болно.

*Хүснэгт 42*. Барьцаа хөрөнгийн мэдээлэл

| № | Барьцааны зүйл | Барьцаа-луулагч | Тоо хэмжээ, ширхэг | Нэгжийн үнэлгээ, (төгрөг) | Барьцааны зүйлийн үнэлгээ | Барьцаагаар хангагдах үүргийн гүйцэтгэлийн дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | “Сэндли ББСБ” ХК-ийн энгийн хувьцаа* | Толгой компани “Монголын финтек групп” хаалттай ХК | 111,785,000 ширхэг | 144.48 | 16,150,696,800* | 11,305,487,760 |
| 2 | Зочид буудлын цогцолбор, олон нийтийн газар** | | 10,000 мкв га | 251,007.0 | 2,510,070,000** | 2,510,070,000 |
| 3 | Худалдаа нийтийн үйлчилгээний газар** | | 1,200 мкв га | 251,008.3 | 301,210,000** | 301,210,000 |
| | | **Нийт** | | | **18,961,976,800** | **14,116,767,760** |

*Тайлбар:* (*) – Хувьцааны үнэлгээг 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрөөр тасалбар болгон Монголын хөрөнгийн биржийн тодорхойлсон сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханш (VWAP)-аар тооцсон.
(**) – Хөндлөнгийн хөрөнгийн үнэлгээний “Файн Эстимэйт” ХХК-ийн 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн тайлангаар газар эзэмших эрхийн үнэлгээг тогтоосон ба үнэлгээг 2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөрх зах зээлийн үнэ цэнээр тооцсон.

“Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 2.7-д заасны дагуу барьцаалах нэгж хувьцааны үнийг тогтоохдоо сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшийг харгалзах ба барьцаалах хувьцааны үнэлгээ нь хувьцааны үнэлгээний 70 хувиас илүүгүй байх шаардлагатай. Үүний дагуу “Сэндли ББСБ” ХК-ийн хувьцааны сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшийг Монголын хөрөнгийн биржийн 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 03/332 тоот албан бичгийн дагуу тодорхойлсон (Хавсралт 4-өөс харна уу.) ба тодруулбал, 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар 144.48 төгрөг байна. Хувьцаагаар хангагдах үүргийн гүйцэтгэлийн үнэлгээг хувьцааны нийт үнэлгээний 70 хувиар тогтоосон нь СЗХ-ны холбогдох журмын шаардлагад нийцэж байна.

*График 51*. Сэндли ББСБ ХК-ийн хувьцааны ханш




*Эх сурвалж:* Монголын хөрөнгийн бирж

СЗХ 2024.06.10 БҮРТГЭВ №01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

СЗХ-ны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 2.5-д заасны дагуу Бонд гаргагч нь бондын үүргийн гүйцэтгэлийг хангах гуравдагч этгээдээс тусгайлан гаргасан баталгаа, батлан даалттай байж болох бөгөөд барьцаа хөрөнгө нь Бонд гаргагчийн гаргагчийн гаргасан энгийн хувьцаа, эсхүл түүнд хөрвөх нөхцөлтэй үнэт цааснаас бусад төрлийн эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн хэлбэртэй байх шаардлагатай. Үүний дагуу "Монголын финтек групп" ХХК нь Дорноговь аймгийн Замын-Үүд суманд орших дараах газар эзэмших эрхийг барьцаалуулахаар шийдвэрлэсэн:

- Зочид буудлын цогцолбор, олон нийтийн газрын зориулалттай нэгж талбарын 4401010485 дугаар бүхий 10,000 мкв газар эзэмших эрх (Улсын бүртгэлийн дугаар: Э-0714002972),
- Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор зориулалттай нэгж талбарын 4401002556 дугаар бүхий 1,200 мкв газар эзэмших эрх (Улсын бүртгэлийн дугаар: Э-0714002967)-ийг тус тус барьцааны гэрээний дагуу барьцаалуулсан.

Монголын финтек групп ХК-ийн Дорноговь аймгийн Замын-Үүд суманд байрлах газар эзэмших хоёр эрхийн зах зээлийн үнэлгээг "Файн Эстимэйт ХХК" тооцоолсон ба үнэлгээний дэлгэрэнгүй тайланг энэхүү үнэт цаасны танилцуулгын Хавсралт-4-өөс харна уу.

## Барьцааны гэрээний тухай

Сэндли ББСБ ХК-ийн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгон гаргах нийт 10,000,000,000.0 (арван тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгслийн хүү ба үндсэн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр №БГ-24/05 дугаартай барьцааны гэрээг нэг талаас "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК (цаашид "Барьцаалагч" гэх)-ийг төлөөлж гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр, нөгөө талаас "Монголын финтек групп" ХК (цаашид "Барьцаалуулагч" эсхүл "Компани" гэх)-ийг төлөөлж гүйцэтгэх захирал Б.Наранбат нар байгуулсан.

Барьцааны гэрээний дагуу үнэт цаас гаргагчийн толгой компани Монголын финтек групп ХК нь өөрийн эзэмшиж буй үнэт цаас гаргагчийн хувьцаа болон газар эзэмших эрхээ барьцаалуулахаар тусгасан байна. Энэхүү барьцааны гэрээнд талуудын эрх, үүрэг, барьцааны нөхцөлийг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- Барьцаалуулагчийн эзэмшиж буй хувьцааг бондын үндсэн төлбөр ба хүүгийн барьцаа болгон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд тусгаарлуулна, газар эзэмших эрхийн барьцааг газрын харьяа сумын газрын даамал, газрын албанд бүртгүүлж, Үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн гэрчилгээг улсын бүртгэлд бүртгүүлнэ;
- Үүрэг гүйцэтгэгч бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг тогтоосон хугацаанд төлөөгүй буюу үүргийн гүйцэтгэл хангагдаагүй тохиолдолд Барьцаалагч нь барьцааны шаардлагыг хангах тухай мэдэгдлийг Барьцаалуулагчид бичгээр хүргүүлж, үүргийн гүйцэтгэлийн үнийн дүнгээс хамааруулан "Сэндли ББСБ" ХК-ийн 111,785,000 ширхэг энгийн

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО 5183855 9021031195 СТС2420

хувьцаа, Э-0714002972 дугаартай 10,000 м.кв газар эзэмших эрх, Э-0714002967 дугаартай 1,200 м.кв газар эзэмших эрх гэсэн дарааллын дагуу барьцаа хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг үл маргах журмаар шүүхээс гадуур хангуулна;

- Барьцаалуулагч нь энэ Гэрээнд заасан барьцааны зүйлийг тусгаарлалтаас чөлөөлж, Барьцаалагчийн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх 57-272 дугаартай дансанд шилжүүлэх хүсэлтийг ҮЦТХТ-д ажлын 1 хоногт багтаан албан бичгээр хүргүүлнэ. Барьцаалагч өөрийн дансанд шилжүүлэн авсан хувьцааг худалдан борлуулж үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрхтэй.
- Барьцаалагчийн хувьцааг худалдан борлуулсан орлого нь барьцаагаар хангагдах шаардлагыг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд энэхүү Гэрээнд заасан дарааллыг баримтлан газар эзэмших эрхийг худалдан борлуулж үүргийн гүйцэтгэл хангуулна.
- Барьцааны зүйлийг худалдах ажиллагаанд Барьцаалагч оролцож, уг зүйлээ худалдан авах санал гаргаж болно.
- Хэрэв ямар нэгэн шалтгаанаар барьцаалсан хөрөнгийг худалдсан үнийн дүн нь хөрөнгө оруулагчдад борлуулсан өрийн хэрэгсэл болон түүний хүү, барьцаалагчид учирсан бусад хохирлыг нөхөн төлүүлэхэд хүрэлцэхгүй бол, эсхүл ба барьцаа хөрөнгийн үнэлгээ буурсан тохиолдолд Барьцаалуулагч нь бусад эд хөрөнгөөр Барьцааны гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлнэ.
- Барьцаалагч нь энэхүү Гэрээнд дурдсан барьцааны хөрөнгийг шалгах, тухайн эд хөрөнгийн бүртгэл, хяналтыг хариуцдаг байгууллагад байгаа (байх ёстой) баримт бичгийг үндэслэн эд хөрөнгийн өмчлөл, хөдөлгөөний талаар лавлагаа авах, энэхүү гэрээний биелэлтэд хяналт тавих эрх, үүрэгтэй бөгөөд Барьцаалуулагч нь түүнд энэхүү хяналт хэрэгжүүлэх бүх нөхцөлийг бүрдүүлнэ. Хэрэв уг үйл ажиллагаанд барьцаалагчид аливаа саад тотгор учруулах болон худал мэдээлэл өгсөн бол энэхүү гэрээг ноцтой зөрчсөн гэж үзэх ба үүнтэй холбогдсон бүх зардлыг Барьцаалуулагч тал бүрэн хариуцна.
- Байгалийн давагдашгүй хүчин зүйл болон гэнэтийн ослын улмаас барьцаалсан эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд учирсан хохирлыг Барьцаалуулагч тал бүрэн хариуцна. Энэ нь хөрөнгө оруулагчдад борлуулсан өрийн хэрэгсэл, түүний үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг төлөх гэрээний нөхцөлд ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүй.
- Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох тогтоолын дагуу Барьцаалуулагчийн эзэмшиж буй “Сэндли ББСБ” ХК-ийн 111,785,000 ширхэг энгийн хувьцаа тусгаарлагдах бөгөөд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн системээс шалтгаалан давхар тусгаарлах боломжгүй тул уг тусгаарлалтын хугацаа дуусахаас ажлын 3 хоногийн өмнө Барьцаалуулагч нь энэ барьцааны гэрээний дагуу тусгаарлуулах албан хүсэлтийг холбогдох шийдвэр болон гэрээний хамт ҮЦТХТ-д хүргүүлж өрийн хэрэгслийн үүргийн гүйцэтгэл хангагдах хүртэл

тусгаарлуулна. Барьцаалуулагч нь энэхүү үйл ажиллагаар урьдчилан ҮЦТХТ-д мэдэгдэж, зөвшөөрөл авна.

- Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн болон дууссан талаар талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

Толгой компани Монголын финтек групп ХК-ийн эзэмшиж буй Сэндли ББСБ ХК-ийн энгийн хувьцаа нь үнэт цаас гаргагчийн 2023 онд гаргасан Сэндли бондын үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор ҮЦТХТ-д тусгаарлагдсан байгаа ба тус өрийн хэрэгслийн хугацаа 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдөр дуусахаар байна. Сэндли Бонд 2.0-ын үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор Барьцааны гэрээгээр барьцаалсан хувьцааг үргэлжлүүлэн тусгаарлана.

## Барьцаа гаргагч Монголын финтек групп ХК-ийн тухай

Монголын финтек групп ХК (Регистр: 6692257) нь хаалттай хувьцаат компани бөгөөд финтек технологид суурилсан бизнес эрхлэгч өөрийн охин компаниудыг гадаад, дотоод хөрөнгө оруулагчидтай холбох, Олон Улсад тэдгээрийн бизнесийг таниулах зорилгоор үүсгэн байгуулагдсан. Одоогоор тус компани нь нийт 10 гаруй компанийн 50.0-аас дээш хувийг эзэмшдэг бөгөөд эдгээр компаниудад ХайПэй ХХК, Гялс төгрөг ХЗХ, Мегаболл ХХК, Стоклаб секьюритиз ҮЦК ХХК, Мони маркет фанд ХХК, Инвестлаб Ви Си ХХК, Мастер шийдэл ХХК зэрэг компаниуд багтдаг.

“Монголын финтек групп” ХК-ийн нийт хувьцааны 85.3 хувийг “Монголын мючуал финанс групп” ХХК, үлдсэн 14.7 хувийг бусад жижиглэн хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна. Монголын финтек групп ХК-ийн эцсийн өмчлөгч нь Монгол Улсын иргэн Б.Наранбат бөгөөд 2023 оны аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлангаар тус компанийн нийт актив 49,769.3 сая төгрөг, цэвэр борлуулалтын орлого 12,490.2 сая төгрөг байна. (Сүүлийн 2 жилийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн үр дүнг Хавсралт 3-аас харна уу.)

## Өрийн хэрэгслийн тухай мэдэгдэл

Мөн Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 14.3.2-т заасны дагуу Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийн үнийн дүн нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 16.4-т заасан шаардлагыг хангаж байгаа ба Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргаж буй Сэндли Бонд 2.0 нь барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр хязгаарлагдаагүй, битүүмжлэгдээгүй болно.

СЗХ сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## 5.4. ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Үнэт цаас гаргагч нь 100,000 (нэг зуун мянга) ширхэг, нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, тогтмол хүүтэй, энгийн бондыг олон нийтэд санал болгож нийт 10,000,000,000 (арван тэрбум) төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлэхээр төлөвлөж байгаа билээ. Энэхүү олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг Үнэт цаас гаргагч нь бизнесийн үндсэн үйл ажиллагаа болох зээлийн үйл ажиллагаагаа санхүүжүүлэхэд зарцуулна.

*Хүснэгт 43. Эх үүсвэрийн зарцуулалт*

| № | Эх үүсвэрийн зарцуулалтын төлөвлөгөө | Мөнгөн дүн |
|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагаа буюу зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх | 10,000,000,000 (арван тэрбум) төгрөг |

Өрийн хэрэгслээр татан төвлөрүүлэх санхүүжилтийг зөвхөн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд тус санхүүжилтийн зардлыг татан төвлөрүүлэх хөрөнгөөс гаргахгүй болно.

## 5.5. ӨРИЙН ХЭРЭГСЛЭЭР ГЭРЧЛЭГДЭХ ЭРХ, ҮҮРЭГ

Өрийн хэрэгсэл нь түүний эзэмшигчийн дараах эрхийг гэрчилнэ:

- Үнэт цаас эзэмшигч, түүний хамтран эзэмшигч нь компанийн санхүүгийн тайлан, үнэт цаасны танилцуулгыг хөрөнгө оруулалтын зорилгоор судлан үзэж, бүрэн танилцсаны үндсэн дээр өрийн хэрэгслийг худалдан авч, хөрөнгө оруулалт хийх шийдвэрийг бие даан гаргах;
- Үнэт цаас эзэмшигч, түүний хамтран эзэмшигч нь өрийн хэрэгслийн хоёрдогч зах зээлийн үнийн мэдээлэлтэй танилцах эрхтэй;
- Өрийн хэрэгслийг бирж дээрээс үнэт цаасны компаниараа дамжуулан чөлөөтэй худалдан авах, хоёрдогч зах зээл дээр худалдах эрхтэй;
- Бондын үнэ болон түүнийг худалдан авахтай холбоотой шимтгэл, хураамжийн үүргийг гүйцэтгэснээр үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэхийг Үнэт цаас гаргагчаас шаардах эрхтэй;
- Үнэт цаас гаргах тухай шийдвэрт заасны дагуу үнэт цаасны хүүгийн төлбөрийг улирал тутамд төлөхийг шаардах;
- Үнэт цаас гаргагч төлбөрийн чадваргүй болсон буюу үүргийн гүйцэтгэлийг хангах эд хөрөнгийн хэмжээ багассан, эсхүл эд хөрөнгөгүй болсон бол Өрийн хэрэгсэл эзэмшигч нь тогтоосон хугацаанаас өмнө үүргээ нэн даруй гүйцэтгэхийг түүнээс шаардах (Иргэний хуулийн 208.6);
- Үнэт цаасаар хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар хувьцааны барьцааны гэрээ байгуулсан Барьцаалуулагчийн талаарх мэдээлэлтэй танилцах;
- Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх.

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183863 9021031195 СТС2420

Өрийн хэрэгсэл нь түүний эзэмшигчийн дараах үүргийг гэрчилнэ:

- Мөнгөн хөрөнгөө урьдчилан байршуулах нөхцөлөөр өөрийн захиалсан өрийн хэрэгслийн төлбөрийг төлөх, тийнхүү төлөөгүй бол захиалсан өрийн хэрэгслийг ҮЦК худалдах эрхтэйг хүлээн зөвшөөрөх;
- Үнэт цаас эзэмшигч, түүний хамтран эзэмшигчийн өрийн хэрэгслийн төлбөрт төлсөн мөнгөн хөрөнгө нь түүний хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого бөгөөд "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль"-ийн дагуу холбогдох шалгуурыг хангасан, эрх зүйн аливаа доголдолгүй, маргаангүй мөнгөн хөрөнгө болохыг бүрэн баталж, эрсдэл болон өгөөжийг бүрэн тооцоолж хөрөнгө оруулалтын шийдвэрийг бие даан гаргасан талаар баталгаа гаргаж ҮЦК-аас гаргасан анхан шатны маягтыг үнэн зөв мэдээлэх болон түүнд орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэх;
- Монгол Улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу Өрийн хэрэгслийн хүүгийн орлогоос татварыг суутгахыг Бонд гаргагчид зөвшөөрөх;
- Холбогдох хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг

- Үнэт цаас гаргагч нь өөрийн санхүү болон бусад бодит байдлын талаар үнэн зөв мэдээлэх үүрэгтэй;
- Өрийн хэрэгслийн үүргийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал үүссэн тохиолдолд Хувьцааны барьцааны гэрээний дагуу зохих арга хэмжээг авч үнэт цаас эзэмшигчийн хүү болон үндсэн төлбөрийг барагдуулах;
- Татан төвлөрүүлсэн хөрөнгийг үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу үр ашигтай захиран зарцуулах;
- Үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу улирал тутамд хүүгийн төлбөрийг төлөх, хугацааны эцэст үндсэн төлбөрийг төлөх үүрэгтэй. Энэхүү үүргээ биелүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллах;
- Үнэт цаас гаргагч нь холбогдох гэрээнүүд дээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирлыг төлж барагдуулах үүрэгтэй;
- Холбогдох хууль тогтоомж болон журамд заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг тогтмол хангах, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах;
- Үнэт цаас гаргагч нь компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд, тодорхой байх зарчмаар буюу хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад хангалттай байдлаар хүргэх;
- Үнэт цаас гаргагч нь бондын үнэ ханшид нөлөөлж болохуйц аливаа үйл явдлын мэдээллийг нэн даруй Андеррайтер, олон нийт, Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх;

- Андеррайтер, бонд эзэмшигчээс хууль тогтоомж болон энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй;
- Холбогдох хууль тогтоомж, холбогдох гэрээгээр тодорхойлогдох бусад эрх, үүрэг.

## Бондын гэрээний тухай

Андеррайтер нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг төлөөлөн Үнэт цаас гаргагчтай бондын нөхцөл, талуудын эрх, үүргийг тусгасан №БОГ-24/01 дугаартай “Бондын гэрээ”-г 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан. Бондын үндсэн нөхцөл нь олон нийтээс татан төвлөрүүлэх үнийн дүн нь 10,000,000,000.0 (арван тэрбум) төгрөг, жилийн 18.5 (арван найм аравны тав) хувийн тогтмол хүүтэй, энгийн хувьцаанд хөрвөх нөхцөлгүй, 24 (хорин дөрөв) сарын хугацаатай, Бондын 24 сарын үндсэн хугацаа дуусахаас өмнө эргүүлэн худалдан авах, худалдах нөхцөлгүй, улирал тутам хүү төлөгдөх давтамжтай, үндсэн төлбөрийг Бондын хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 24 дэх сарын мөн өдөр төлнө (хэрэв амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр төлнө).

Хүүгийн төлбөрийг тооцохдоо нэг өдрийн хүүг жилийн 365 хоногоор тооцох бөгөөд бонд эзэмшигчийн тухайн үнэт цаасыг эзэмшсэн бодит өдрөөр үржүүлж нийт төлбөл зохих хүүгийн дүнгээс Бонд гаргагч нь татварын 5 хувиар суутган авч бонд эзэмшигч тус бүрийн өмнөөс төсөвт төлнө.

Үнэт цаас гаргагчийн Бонд нь барьцаатай ба энэхүү үнэт цаасны танилцуулгын 5.3-д тодорхой тусгаж оруулсан. Үнэт цаас гаргагч нь Бондын хүү болон үндсэн төлбөрийг тогтоосон хугацаанд төлөх боломжгүй нөхцөл үүсэх, эсхүл 2 болон түүнээс дээш удаа дараалан Бондын хүүгийн төлбөрийг гүйцэтгээгүй тохиолдолд төлбөрийн тасалдал (дефолт) болсонд тооцно. Энэ тохиолдолд Андеррайтер нь барьцааны эрх хэрэгжүүлж Сэндли ББСБ-аас төлбөл зохих төлбөрийг барагдуулахыг шаардах ба Бондын гэрээний дагуу бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Төлбөрийн чадваргүй болох тохиолдлыг Монгол Улсын Дампуурлын тухай хуульд заасны дагуу өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаанд биелүүлэхгүй бол төлбөрийн чадваргүйд тооцно. Үнэт цаас гаргагч нь төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд Монгол Улсын Дампуурлын тухай хуулийн хүрээнд шаардлагатай холбогдох арга хэмжээг авна.

- Бонд гаргагч төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан дараалалыг харгалзах бөгөөд ямар ч тохиолдолд бондын хүү, үндсэн төлбөрийг хувьцаа эзэмшэгчдэд ногдол хувь хуваарилахаас өмнө тэргүүн ээлжинд барагдуулна.
- Бонд гаргагчид Бондын гэрээний дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон ББСБ-ын санхүүгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй тохиолдолд нэмж зээл авах, их хэмжээний өр төлбөр гаргахыг хориглосон байна.

- Бонд гаргагчид Бондын гэрээний дагуу хэрэгжүүлж болох зүйлд үнэт цаасны танилцуулгад тусгагдсан бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөлөлдөө хүрэхийн тулд бизнес, санхүүгийн үзүүлэлтээ тогтмол сайжруулж ажиллахыг эрмэлзэх тухай тусгасан.
- Бонд гаргагч нь санхүүгийн чадавхиа сайжруулахтай холбоотой СЗХ-ноос тогтоосон ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах, татан төвлөрүүлсэн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагатай холбоотой бодлого, журам, хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах ёстой.
- Бонд эзэмшигч буюу хөрөнгө оруулагч, Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг, хариуцлагыг энэхүү үнэт цаасны танилцуулгын 5.5 дахь хэсгийн Өрийн хэрэгслээр гэрчлэгдэх эрх, үүрэг хэсэгт дэлгэрэнгүй тусгасан болно.

СЗХ-ны “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д заасан мэдээллийг тухайн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс бондыг Хорооны бүртгэлээс хасах хүртэлх хугацааны туршид тогтоосон хэлбэр, давтамжаар Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлж, нийтэд мэдээлнэ.

- Бондын танилцуулгад заасан үйл ажиллагааны чиглэл, төсөл болон төслийн хэрэгжилтийн явцад өөрчлөлт орох, бусад санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчаас зээл авсан, тэдний өмнө хүлээсэн нэмэлт үүрэг үүссэн, Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, хяналтын багц бүхий хувьцаа эзэмшигчийн бүтцэд өөрчлөлт орсон, Эрх бүхий байгууллагын шийдвэрээр бонд гаргагчийн хөрөнгийг битүүмжилсэн, эсхүл хураасан, Бонд гаргагч тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх болсон, хугацааг сунгуулсан, эсхүл түүнийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, Бонд гаргагч нь гуравдагч этгээдийн өмнөөс баталгаа, батлан даалт гаргасан бол тухай үйл явдал болсноос хойш ажлын 3 өдрийн дотор;
- Улирлын тайланг дараа сарын 10-ны дотор, жилийн тайланг 2 дугаар сарын 10-ны дотор, аудитын тайланг 3 дугаар сарын 10-ны дотор;
- Үнэт цаас гаргагч нь бондын үнэ ханшид нөлөөлж болохуйц аливаа үйл явдлын мэдээллийг нэн даруй буюу 24 цагийн дотор Хороо, арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлж, олон нийтэд мэдээлнэ.

## 5.6. ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТУХАЙ

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасны дагуу нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл болон хөрөнгийн биржийн бүртгэл аль алинд нь бүртгэгдсэн үнэт цаасыг үнэт цаасны анхдагч зах зээлд худалдана.

Тус хуулийн 12.2 дахь хэсэгт зааснаар Үнэт цаасны анхдагч зах зээлд үнэт цаасыг арилжих зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хороо олгох бөгөөд СЗХ нь уг зөвшөөрлийг Хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэсэн болон холбогдох бэлтгэлийг хангасан тухай хөрөнгийн биржээс гаргасан тодорхойлолт, үнэт цаас гаргагчийн хүсэлтэд үндэслэн олгох бөгөөд Монголын хөрөнгийн

биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн №15 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-д заасны дагуу Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь өрийн хэрэгслийг анхдагч зах зээлд байршуулах дэлгэрэнгүй төлөвлөгөөг танилцуулна.

### 5.6.1. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн №14 дугаартай тогтоолын дагуу нийт 100,000 (нэг зуун мянга) ширхэг, нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий компанийн өрийн хэрэгслийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгон арилжаална.

*Схем 9*. Бондыг анхдагч зах зээлд байршуулах дараалал




Анхдагч зах зээлийн арилжааг Биржийн холбогдох журмын дагуу тогтоосон үнийн аргыг ашиглан олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн болно. Олон нийтэд танилцуулах, сурталчлах болон өрийн хэрэгслийн захиалгыг эхлүүлэх хугацаа, хуваарийн талаар уг ажиллагааг эхлүүлэхээс 5-аас доошгүй өдрийн өмнө Хороонд мэдэгдэнэ. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөөг доорх схемээр дүрслэн харуулав.

### 5.6.2. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дуусcанаас хойш ажлын гурван өдөрт багтаан анхдагч зах зээлийн арилжааны тайланг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ. Санхүүгийн зохицуулах хороо нь уг тайланг хүлээн авч аливаа зөрчил гараагүй, амжилттай болсон гэж үзвэл хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрөл олгоно. Тус зөвшөөрлийн дагуу үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийж, арилжаа эрхлэх байгууллагад хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. Энэ өдрөөс эхэлж бондын хүү тооцогдож эхэлнэ.

СЗХ
2024.06 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

### 5.6.2. Өрийн хэрэгсэл худалдан авах заавар

- Тогтоосон үнээр санал болгох арилжааны арга

Монголын хөрөнгийн биржийн 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн №15 дугаартай тогтоолоор баталсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-д заасны дагуу үнэт цаас гаргагчийн тогтоосон тодорхой үнэ (өгөөж)-ээр цаг хугацааны ахлах дараалаар санал болгон арилжих арга юм.

- Бонд худалдан авах заавар

Хөрөнгө оруулагч нь үнэт цаас худалдан авах мөнгөн хөрөнгийг дараах 2 аргаас сонгон дансандаа байршуулах боломжтой. Хэрэв үнэт цаасны дансгүй бол МХБ-д бүртгэлтэй аль нэг үнэт цаасны компаниас сонгон данс нээлгэнэ. Данс бүрэн баталгаажихад 1-2 хоног шаардлагатай байдгийг та тооцно уу.

1. *Дурын банкнаас бонд авах мөнгөн дүнг дараах заврын дагуу байршуулаад өөрийн үйлчлүүлдэг брокерийн компанийн аппликэйшнийг ашиглан захиалгаа оруулах эсхүл брокертоо мэдэгдэж захиалгаа баталгаажуулна.*

   Банкны нэр: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
   Дансны нэр: Таны өөрийн нэр
   Дансны дугаар: **** **** **** (өөрийн брокероос лавлах)
   Гүйлгээний утга: регистрийн дугаар, нэр, утасны дугаар

2. *Дурын данснаас өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанийн номинал дансанд байршуулаад цахимаар болон утсаар захиалгаа баталгаажуулах боломжтой.*

   Банкны нэр: ҮЦК-ийн номинал данс байршиж буй банкны нэр
   Дансны нэр: Үнэт цаасны компанийн нэр
   Дансны дугаар: Үнэт цаасны компанийн номинал дансны дугаар
   Гүйлгээний утга: регистрийн дугаар

- Арилжааны шимтгэл

Хөрөнгө оруулагч нь өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанийн тогтоосон арилжааны шимтгэлийг үнэт цаас авах мөнгөн дүн дээр нэмж байршуулна. Уг шимтгэлд зохицуулагч байгууллагуудын шимтгэл багтсан байна.

- Албан татвар

Хөрөнгө оруулагч нь хувь хүн бол ХХОАТ-ын хуулийн 16.1.4-т заасан хүүгийн орлогын нийт дүнгээс, 17.1.3-т заасан хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогоос худалдан авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдох бусад зардлыг хассан дүнгээс тус хуулийн 21.5-т заасан 5.0 хувийн татвар төлнө. Хөрөнгө оруулагч нь хуулийн этгээд бол ААНОАТ-ын хуулийн

УЛААНБААТАР ХОТ
... ЭНД КО ... КАПИТАЛ ҮЦК ХХК
СТС2420

18.6.3-т заасан хүүгийн орлогын нийт дүнгээс, 18.3-т заасан хувьцаа, үнэт цаас борлуулсан, шилжүүлсэн үнээс худалдан авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдож байгаа шимтгэлийн дүнг хасаж, энэхүү дүнгээс тус хуулийн 20.2.5-д заасан 5.0 хувийн татвар төлнө.

Сэндли

БОНД 2.0

# 6. Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогчид

ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР

ULZII & Co CAPITAL

ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР

Investment

Golomt Capital

СЗХ 2024.06.10 өдөр БҮРТГЭВ 1

2024-06-17 БҮРТГЭВ-02

## 6.1. ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Байгууллагын нэр: "ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК" ХХК
Үйл ажиллагааны чиглэл: Брокер, Дилер, Андеррайтер, Номинал данс эзэмших
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити Тауэр, 25 давхар, 2506 тоот
Утас: +976 7777 6377
Цахим шуудан: info@ucc.mn

Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК нь Монголын тэргүүний үнэт цаасны компаниудын нэг бөгөөд хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээг үзүүлэх үндсэн зорилготойгоор 2007 онд байгуулагдсан билээ. Тус компани нь Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер болон андеррайтерийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, Монголын хөрөнгийн бирж болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн байгууллага юм.

Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК нь Монголын хөрөнгийн биржийн арилжаанд онлайнаар оролцох боломжийг харилцагч нарт олгож, мэдээ мэдээлэл, зөвлөгөөг өгч ажилладаг ба дотоодын үнэт цаасны арилжаа төдийгүй Хонгконг, Лондон, Австрали, НьюЙоркийн хөрөнгийн биржийн арилжаанд бодит цагийн горимоор хувьцаа болон бусад үнэт цаасыг худалдах, худалдан авахад зуучилдаг ба энэхүү үйлчилгээг Монголд анх удаа нэвтрүүлсэн.

Хөгжлийн цоо шинэ шатандаа гарч байгаа Монголын компаниудад хөрөнгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татаж бизнесээ өргөжүүлэх боломжийг таниулан, бизнес болон санхүүгийн мэргэжлийн зөвлөгөө өгч хамтран ажилладаг. Мөн түүнчлэн салбартаа тэргүүлэгч томоохон компаниудын үнэт цаас гаргах үйл ажиллагаанд андеррайтерийн мэргэжлийн үйлчилгээг үзүүлж байна.

### Амжилттай хэрэгжүүлсэн төслүүд

| | |
|---|---|
| 2024 он | "Бичил 3.0" нээлттэй ХБҮЦ-ны Үндсэн андеррайтер |
| 2024 он | "Есөн шижир инвест ББСБ" ХХК-ийн Биржийн бус зах зээл (OTC) дээр гаргасан хаалттай бондын Үндсэн андеррайтер |
| 2023 он | "Инновэйшн инвестмент" ХК-ийн IPO-д Үндсэн андеррайтер |
| 2023 он | "ЛэндМН" Бонд-д Туслах андеррайтер |
| 2023 он | "Хасбанк IPO"-д Хамтрагч андеррайтер |
| 2023 он | "Бичил 2.0" ХБҮЦ-д Үндсэн андеррайтер |
| 2023 он | "БИД нээлттэй бонд"-д Үндсэн андеррайтер |
| 2023 он | "Сэндли нээлттэй бонд"-д Үндсэн андеррайтер |
| 2023 он | Биржийн бус зах зээл (OTC)-д гаргасан "Үйзэн-Ивээлт ББСБ" ХХК-ийн хаалттай бондын Үндсэн андеррайтер |
| 2022 он | "ЛэндМН" ХБҮЦ-д Хамтрагч андеррайтер |
| 2022 он | "Төрийн банк" ХК-ийн IPO-д Үндсэн андеррайтераар ажиллаж, системийн нөлөө бүхий банкууд нээлттэй хувьцаат компани болох эхлэлийг тавьсан. |

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

| | |
|---|---|
| 2022 он | “Сэндли ББСБ” ХК-ийн IPO-д Үндсэн андеррайтер |
| 2022 он | “М-Си-Эс Инвестмент” ХХК-ийн Биржийн бус зах зээл (OTC) дээр төгрөг, ам.долларын хосолсон валютаар гаргасан MCSI хаалттай бондын Үндсэн андеррайтер |
| 2022 он | “Симпл ассет” ТЗК-ийн ХБҮЦ-д Үндсэн андеррайтер |
| 2022 он | МҮОНТ-ийн орон даяарх “Ногоон сум” аянд Хамтрагч компани |
| 2022 он | Биржийн бус зах зээл (OTC)-д гаргасан “Ашид капитал ББСБ” ХХК хаалттай бондын Үндсэн андеррайтер |
| 2021 он | Биржийн бус зах зээлийн (OTC)-ийн анхны “БИД” бондын Үндсэн андеррайтер |
| 2021 он | Монголбанк, СЗХ, Сангийн яамны хамтарсан тушаалаар баталсан “Sandbox” төслийн анхны бүтээгдэхүүн болох “Монпэй” дижитал бондын Үндсэн андеррайтер |
| 2021 он | Биржийн бус зах зээл (OTC)-ийн анхны гишүүн байгууллага |
| 2020 он | Европын сэргээн босголт хөгжлийн банкны брокер |
| 2020 он | МҮОНТ-н “Цагийн хүрдийн баатар” |
| 2020 он | Монголын Үнэт Цаасны Клирингийн төвийн шууд гишүүн |
| 2020 он | “ЛэндМН” ББСБ ХК-ийн нээлттэй бондын Үндсэн андеррайтер |
| 2019 он | “Ард Кредит ББСБ” ХК-ийн IPO-д Үндсэн андеррайтераар ажиллаж хөрөнгийн зах зээлийн түүхэнд анх удаа захиалгын бүртгэлийн аргыг ашиглан, эрэлтэд үндэслэн хувьцааны үнийг тогтоов. |
| 2019-2020 он | Үнэт цаасны арилжаанд голлох байр суурьтай оролцож, МХБ-ийн ТОП-5 ҮЦК-д багтсан. |
| 2018 он | Гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр нь Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал Grand Bull Awards “Шилдэг Мэргэжилтэн” |

Өнөөгийн байдлаар **“ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК”** нь:

“Мобифинанс ББСБ”, “М-Си-Эс Инвестмент” ХХК, “Капитрон банк”, “Ай Си Ти групп”, “Сүү ХК”, “Төрийн банк”, “БИД ББСБ” , “Ашид капитал ББСБ”, “Монголчех Метал”, “ОНДО”, “Монголын финтек групп”, “БИД ББСБ”, “Бичил глобус финанс ББСБ” гэх зэрэг дотоодын тэргүүлэгч банк, банк бус санхүүгийн байгууллагууд болон уул уурхай, үйлдвэрлэл, харилцаа холбоо, барилга, технологийн салбарын компаниудад андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээ үзүүлэн нийт 550.0 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлээд байна.

СЗХ 2024.06 10 өдөр БҮРТГЭВ №1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## 6.2. ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Байгууллагын нэр: “РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК” ХХК
Үйл ажиллагааны чиглэл: Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер, Дилер, Андеррайтер
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Централ Тауэр, 13 давхар, 1308Б тоот
Утас: +976 7510 0575
Цахим шуудан: info@rhinosinvest.com

“Райнос Инвестмент ҮЦК” ХХК нь БНСУ-ын хуулийн этгээд Райнос Эссет Менежмент ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар 2019 онд анх үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол улсын хөрөнгийн зах зээлд амжилттай үйл ажиллагаагаа явуулахаар зорин ажиллаж байна. “Райнос Инвестмент ҮЦК” ХХК нь Брокер, Дилер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Гадаад улсын зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах, Номинал дансаар дамжуулан үнэт цаасны брокерын цогц үйлчилгээг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж байгаа бөгөөд гадаадын хөрөнгийн зах зээлд өрийн хэрэгслийг зуучлах, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг үзүүлж эхлээд байна. Мөн гадаадын зах зээлд арилжаалагдаж буй Монгол Улсын Засгийн Газрын Бонд болон бусад санхүүгийн байгууллагын бондуудад гадаадын хөрөнгө оруулагчдыг зуучлах үйл ажиллагааг явуулж байна.

“Райнос Инвестмент ҮЦК” ХХК-ийн толгой компани болох Райнос Эссет Менежмент компанийн Монголд хийсэн томоохон хөрөнгө оруулалтууд:

- Монголын анхны финтек компани болон “ЛэндМН” ББСБ ХК-ийн IPO-д стратегийн хөрөнгө оруулалтыг гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчийн хувиар хийсэн.
- Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд анх удаа “АНД Системс” ХХК-ийн санхүүжилтэд зориулж хувьцаа барьцаалсан солилцох бондын 7 тэрбум төгрөгийн санг амжилттай байгуулсан.
- 2017 оноос хойш БНСУ-ын хөрөнгө оруулалтын сантай хамтран нийт 14 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, Монголын компаниудыг өсөлт үзүүлэхэд нь дэмжиж ажилласаар ирсэн.
- Монголын Хөгжлийн Банкны гаргасан хадгаламжийн сертификатын (CD) бүтээгдэхүүнд 2017-2019 онуудад хуримтлагдсан дүнгээр нийт 210.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ.
- 2021 онд Технологийн салбарын старт-ап компанид 2.0 сая ам.долларын хөрвөх бондын санхүүжилт хийсэн байна.
- 2022 онд Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг гар утасны аппликейшнээр дамжуулан хялбар, түргэн шуурхай хэрэглэгчдэд хүргэж буй Сэндли ББСБ ХК-ийн 10.05 тэрбум төгрөгийн IPO-д туслах андеррайтераар ажилласан.
- “ЛэндМН” ББСБ ХК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг анх удаа андеррайтер төвтэй анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулж Үндсэн андерратераар ажилласан.
- 2023 оны 1 дүгээр улиралд Сэндли ББСБ ХК-ийн анх удаа нээлттэй санал болгон гаргасан 8.5 тэрбум төгрөгийн өрийн хэрэгслийг арилжаалах үйл ажиллагаанд туслах андеррайтераар ажилласан.

СЗХ 2024.06.10 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

- 2023 оны 2 дугаар улиралд ХасБанк ХК-ийн нийтэд санал болгон анх удаа гаргасан 35.7 тэрбум төгрөгийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалах үйл ажиллагаанд Үндсэн андеррайтераар ажилласан.
- 2023 оны 3 дугаар улиралд ЛэндМН ББСБ ХК-ийн 9.0 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй өрийн хэрэгслийг нийтэд санал болгон арилжаалах үйл ажиллагаанд Үндсэн андеррайтераар ажилласан.

Өнөөгийн байдлаар “Райнос Инвестмент ҮЦК” ГХО ХХК нь:

- "Анд Глобал" ХХК
- "Анд Системс" ХХК
- “ОНДО” ХХК
- "Хас Банк" ХХК
- “ЛэндМН ББСБ” ХХК
- "Капитрон банк" ХХК
- “Хай Пеймент Сольюшнс” ХХК
- “Монгол Алт” ХК
- “Гарнетон” ХХК
- "Сэндли ББСБ” ХК
- "Ган Хийц" ХК
- "Beauty Secrets" ХХК
- "Томъёо" ХХК
- “Монголын Финтек групп” ХК
- “Андореан” ХХК

зэрэг дотоодын тэргүүлэгч банк, банк бус санхүүгийн байгууллагууд болон уул уурхай, үйлдвэрлэл, харилцаа холбоо, барилга, төлбөр тооцооны цогц шийдэл бүхий технологийн салбарын компаниудад андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээ үзүүлэн нийт 100 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтыг татан төвлөрүүлээд байна.

УЛААНБААТАР ХОТ ОЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

Байгууллагын нэр: "ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК" ХХК
Үйл ажиллагааны чиглэл: Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер, Дилер, Андеррайтер
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Парк Плэйс оффис, 4 давхар, 403, 404 тоот
Утас: +976 7012 1530
Цахим шуудан: info@golomtcapital.com

Голомт Капитал ҮЦК ХХК нь 2011 онд Голомт Банк ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар байгуулагдсан. Тус компани нь СЗХ-оос 2011 онд брокерын үйлчилгээ, 2014 онд хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ, 2015 онд андеррайтерийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус авч иргэд, аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулалтын цогц үйлчилгээг үзүүлж байна.

Голомт Капитал ҮЦК ХХК нь 2018 онд Торонтогийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" ХК-ийн давхар бүртгэлд (FPO) хамтран андеррайтераар, даатгалын зах зээлд тэргүүлэгч "Мандал Даатгал" ХК-ийн IPO Үндсэн андеррайтераар, 2019 онд шувууны аж ахуйн салбарт тэргүүлэгч "Түмэн Шувуут" ХК-ийн IPO Үндсэн андеррайтераар, эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэрлэлийн зах зээлд тэргүүлэгч "Монос Хүнс" ХК-ийн IPO Үндсэн андеррайтераар, 2021 онд конвиниес дэлгүүрийн зах зээлд тэргүүлэгч "Сэнтрал Экспресс Си Ви Эс" ХК-ийн IPO Үндсэн андеррайтераар, 2022 онд "Инвескор ББСБ" ХК-ийн FPO үндсэн андеррайтер, "Голомт Банк" ХК-ийн IPO туслах андеррайтер, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн туслах андеррайтер, Симпл I, II нээлттэй бонд, Бэрс 3 ХБҮЦ, БИД ХБҮЦ-ны үндсэн андеррайтераар ажилласан IPO андеррайтерийн зах зээлд нийт 250.0 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлээд буй тэргүүлэгч компани юм.

Түүнчлэн Голомт Капитал ҮЦК ХХК нь 2015 онд Монголын анхны даатгагдсан бонд болох "Эрчим" бонд, 2017 онд анхны нээлттэй бонд болох "Сүү" бонд, 2020 онд анхны хайбрид бонд болох "Мастер" бонд, анхны банкны баталгаат бонд болох "Нөмөр" бонд, 2021 онд анхны биржийн бус зах зээлийн бонд болох "Монкон" бондын андеррайтераар тус тус ажилласан туршлагатай хамт олон юм. Голомт Капитал ҮЦК нь Бонд, ХБҮЦ-ны зах зээлд нийт 200 гаруй тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж, зах зээлд тэргүүлж байна.

СЗХ 2024.08.10 өдөр БҮРТГЭВ 1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## Андеррайтерийн гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг:

Энэхүү гэрээгээр андеррайтерууд үнэт цаас гаргагчийн Монголын хөрөнгийн биржээр нээлттэй бонд гаргах ажлыг зохион байгуулах, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д заасны дагуу үнэт цаасны танилцуулга, холбогдох материалыг бэлтгэх, хөрөнгө оруулагчдад санал болгох, арилжааг зохион байгуулах, эрх бүхий байгууллагуудтай харилцах гэх мэт талуудын хоорондын харилцааг зохицуулна. "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК, "Голомт капитал ҮЦК" ХХК, "Райнос Инвестмент ҮЦК" ХХК (цаашид "андеррайтерууд" гэх) нар Сэндли ББСБ ХК (цаашид "Бонд гаргагч" гэх)-тай 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр №АГ-24/05 дугаартай "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулсан. Энэхүү гэрээнд Үнэт цаас гаргагч болон Андеррайтеруудын дараах эрх, үүргийг тодорхойлсон. Үүнд:

- Андеррайтерууд нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ болон МХБ "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангахад дагаж мөрдөх шаардлагатай холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулна.
- Андеррайтерууд нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн үр ашигтай, хэмнэлттэй байдлаар гүйцэтгэх бөгөөд үр дүнтэй арга зүйг ашиглан үйл ажиллагааны шуурхай удирдлагыг ханган ажиллана.
- Андеррайтерийн үйлчилгээг үр дүнтэй, шуурхай хэрэгжүүлэхэд шаардлагатай байж болох зааварчилгаа, удирдамжийг Бонд гаргагчаас томилсон ажилтан болон удирдлагад гарган өгөх үүрэгтэй. Бонд гаргагчаас томилсон ажилтан нь үүргээ зохих ёсоор гүйцэтгэж чадахгүй байгаа тохиолдолд уг ажилтныг өөр чадвартай ажилтнаар солихыг Бонд гаргагчаас шаардах эрхтэй.
- Бонд гаргагч нь андеррайтерууд ажил, үүргээ гүйцэтгэхэд шаардагдах аливаа зөвшөөрөл, түүнчлэн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай гэж үзсэн Бонд гаргагчийн эрх бүхий этгээдийн тогтоол шийдвэр, мэдээ мэдээлэл, баримт бичгүүдийг Андеррайтеруудаас тогтоосон хугацаанд түргэн шуурхай, бүрэн гүйцэд гаргаж өгөх бөгөөд андеррайтерийг гагцхүү үнэн зөв мэдээллээр хангах үүрэгтэй.
- Гэрээг хэрэгжүүлэх явцад Андеррайтераас Бонд гаргагчид хүргүүлсэн нийтэд ил болоогүй бүх төрлийн мэдээлэл, зөвлөмж, тайлан мэдээ, төсөл төлөвлөгөөний загвар, агуулга, мэдээлэл зэргийг Бонд гаргагч нь зөвхөн өөрийн дотоод хэрэгцээнд, үнэт цаас гаргах бэлтгэл хангахад ашиглах ба эдгээр мэдээлэл, баримт бичиг болон Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх арга барил, ноу хау зэргийн нууцлалыг хадгалж, андерарйтерийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр аливаа гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх үүрэгтэй.
- Бонд гаргагч нь аль нэг андеррайтерийн буруутай үйл ажиллагааны улмаас Бонд гаргагчийн нууц мэдээлэл задарсан бөгөөд Бонд гаргагчид бодит хохирол учирсан нь тогтоогдсон тохиолдолд тухайн бодит хохирлыг нөхөн төлөхийг тухай Андеррайтераас шаардах эрхтэй.

СЭХ 2024 оны 06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## 6.3. АУДИТЫН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Байгууллагын нэр: "ХҮЛЭГТХҮННҮ АУДИТ" ХХК
Үйл ажиллагааны чиглэл: Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер, Дилер, Андеррайтер
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Централ Тауэр, 13 давхар, 1308Б тоот
Утас: +976 7510 0575
Цахим шуудан: info@rhinosinvest.com

Хүлэгтхүнну аудит ХХК нь олон улсын стандарт нийцсэн санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх замаар харилцагчдаа хөгжилд хөтлөх зорилготой мэргэжлийн хамт олон юм. Тус компани нь аудит, хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ, нягтлан бодох бүртгэлийн аутсорсинг, сургалт, мэргэжлийн зөвлөх үйлчилгээ, баримт бичиг боловсруулалт, дотоод аудит, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС) нэвтрүүлэх чиглэлээр ажилладаг.

Аудитын мэргэжлийн жлын туршлагын хувьд "Ариг банк", "Монголын хөрөнгийн бирж", "Мостфинтек", "Дата бэйнк", "Изи Пэй", "Кюу Пэй", "Очир Ундраа", "Улаанбаатар төмөр зам ХНН", "МИАТ ТӨХК", "Тавантолгой төмөр зам", "Мобиком корпораци", "Мэдээлэл харилцаа холбооны газар", "Монголын цахилгаан холбоо" зэрэг аж ахуй нэгж мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай.

Компанийг үүсгэн байгуулагчид нь нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулийн багш нар бөгөөд эдгээр мэргэжилтнүүд нь одоог хүртэл онол, практикийг хослуулан ажиллаж байна. Багийн бүрэлдэхүүнд аудитор 5, мэргэшсэн нягтлан бодогч 5, тэргүүлэх үнэлгээчин 1, мэргэшсэн үнэлгээчин 3 ажилладаг.

### Аудитын үйлчилгээний гэрээгээр хүлээсэн эрх үүрэг:

Сэндли ББСБ ХК нь Хүлэгтхүнну аудит ХХК-тай 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр №А-24/10 тоот "Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулсан. Энэхүү гэрээгээр аудитын байгууллага нь Үйлчлүүлэгчийн СТОУС-ын дагуу бэлтгэсэн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн иж бүрэн санхүүгийн тайлан, тодруулга, нягтлан бодох бүртгэлийн бодлгоос бүрдсэн санхүүгийн тайлангуудад холбогдох дүрэм, журам, хуулийн дагуу аудитын дүгнэлт гаргах зорилготой.

- Аудитын байгууллага нь Үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу энэхүү гэрээт ажлын явцын талаар танилцуулах үүрэгтэй;
- Гэрээт ажлыг гүйцэтгэхтэй холбоотойгоор аудитын байгууллага нь хараат бус байдалд чухалчлан анхаарах бөгөөд холбогдох хууль, дүрэм журам зөрчихгүй байх;
- Үйлчлүүлэгч нь Аудитын байгууллагын ажилтнуудтай хамтран ажиллах, тодруулах мэдээлэл, бусад шаардлагатай мэдээллийг тухай бүрд нь бүрэн гүйцэд, цаг хугацаанд нь бэлдэх үүрэгтэй;
- Үйлчлүүлэгч нь Аудитын үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах аливаа баримт болон мэдээллүүдийг нууцлах үүрэгтэй;

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО ... ХХК 5183855 9021031195 СТС2420

СЭХ 2024.06.10 өдөр БҮРТГЭВ № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024.05.17 БҮРТГЭВ-02

## 6.4. ХУУЛИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Байгууллагын нэр: "ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН
Үйл ажиллагааны чиглэл: Хуулийн зөвлөгөө
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сентрал Тауэр, 13 давхар, 1301 тоот
Утас: +976 11 330048
Факс: +976 11 330049
Вэб хуудас: www.mdskhanlex.mn
Цахим шуудан: info@mdsa.mn

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь 2011 онд байгуулагдсан цагаасаа хойш гадаад, дотоодын бизнесийн байгууллагуудад дэлхийн стандартад нийцсэн хууль зүйн үйлчилгээг дотоодын туршлага, ур чадвартай хослуулан хүргэдэг. "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1-т заасан үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх этгээдээр бүртгэгдсэн, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд бөгөөд тус зах зээл дээр хөрөнгө босгож буй компаниудтай хамтран ажиллаж байсан арвин туршлагатай. Тухайлбал,

- "Эрдэнэс Таван Толгой" ХК-ийн Монгол, Хонг Конг, Лондонгийн хөрөнгийн биржүүд дээр хувьцааг нийтэд анх удаа санал болгох Wolf Төслийн Монголын хууль тогтоомжтой холбоотой зөвлөгөөг өгөх, эрх зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлт гаргах;
- Монгол Улсын Хөрөнгийн Бирж дээр гаргасан анхны 100% даатгагдсан Эрчим бонд гаргах ажилд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хууль зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлт гаргах;
- "ЛэндМН ББСБ" ХК-ийн IPO, 5 удаа бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд санал болгон гаргах;
- "Инвескор ББСБ" ХК-ийн IPO, нэмэлт хувьцаа, бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган олон нийтэд санал болгох, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, биржийн бус зах зээлд компанийн өрийн хэрэгсэл гаргах;
- "Түмэн шувуут" ХК-ийн IPO;
- "Хөвсгөл Алтандуулга" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах;
- "Сүү" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах;
- Монголын ипотекийн корпорацийн 1-13, 21, 23, 24, 28, 29 дэх орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах;
- "Сэндли ББСБ" ХК-ийн IPO, олон нийтэд нээлттэй өрийн хэрэгсэл гаргах;
- "Бэрс Финанс ББСБ" ХХК-ийн 3 удаагийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гарган олон нийтэд санал болгох төсөл;
- "Төрийн банк" ХК-ийн IPO;
- "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-ийн IPO;
- "Ай си рэйт" ХХК-ийн биржийн бус зах зээлд өрийн хэрэгсэл гаргах;
- "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн 2 удаагийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган олон нийтэд санал болгох;
- "Инновэйшн Инвестмент" ХХКийн IPO;

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

- "Инвескор Глобал Кью Хамтын биржээр арилжаалагддаг ХОС"-д хуулийн зөвлөхөөр ажилласан зэрэг үнэт цаасны зах зээлд санхүүгийн хэрэгсэл гаргахтай холбоотой дурдсан туршлагын хүрээнд хууль зүйн судалгаа шинжилгээ хийж, хууль зүйн дүгнэлт гаргах ажлуудыг тус тус гүйцэтгэсэн болно.

Хуульч, хуулийн фирмүүдийн чансаа тогтоодог AsiaLaw сэтгүүл "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН"-ийг "2021, 2022 оны Монгол улсын шилдэг хуулийн фирм"-ээр шалгаруулсан бөгөөд тус фирмийн хөрөнгийн зах зээлд үзүүлсэн үйлчилгээг онцлон тэмдэглэсэн байдаг.

## Хуулийн зөвлөх үйлчилгээний гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг:

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН (цаашид "Хуулийн зөвлөх" гэх) нь 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр Д-С1132407 тоот Гэрээгээр тохиролцсон хууль зүйн зөвлөх үйлчилгээг Сэндли ББСБ ХК (цаашид "Үйлчлүүлэгч" гэх)-д үзүүлэх, Үйлчлүүлэгч нь тохиролцсон хөлсийг Хуулийн зөвлөхөд төлөхтэй холбоотойгоор Талууд "Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ" байгуулж, харилцан хүлээх эрх, үүрэг, хариуцлагатай холбогдон үүсэх дараах харилцааг зохицуулсан байна.

- Хуулийн зөвлөх нь Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор, Гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх;
- Хуулийн зөвлөх нь гаргасан хөндлөнгийн шинжилгээний тайлан, хуулийн дүгнэлттэй холбогдуулан шаардлагатай тохиолдолд зөвлөмж гаргах, шалгасан материалын хүрээнд тайлбар, тодруулга өгөх, танилцуулга хийх;
- Гэрээнд заасны дагуу үйлчилгээ үзүүлэхдээ үнэн бодит мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлсэн талаар бүртгэл хөтлөх, тайлан гаргах, Үйлчлүүлэгчийн нууцыг чандлан хадгалах;
- Хуулийн зөвлөх Үйлчлүүлэгч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд Гэрээг цуцлах эрхтэй;
- Үйлчлүүлэгч нь Гэрээний дагуу тохиролцсон ажлын гүйцэтгэлийг Гэрээнд заасан хугацаанд Хуулийн зөвлөхөөс шаардах;
- Үйлчлүүлэгч нь Хуулийн зөвлөхөд үйлчилгээний талаар шаардлага тавих, санал гаргах эрхтэй;
- Үйлчлүүлэгч Хуулийн зөвлөх нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд Гэрээг цуцлах эрхтэй;
- Үйлчлүүлэгч нь Гэрээнд заасны дагуу үнэн бодит мэдээллээр хангах, Хуулийн зөвлөхийн нууцыг чандлан хадгалах, Гэрээгээр харилцан тохирсон хугацаанд ажлын хөлсийг саадгүй төлөх үүрэгтэй.

СЗХ 2024 06 10 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## 6.5. ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИ

Байгууллагын нэр: "ФАЙН ЭСТИМЭЙТ" ХХК
Үйл ажиллагааны чиглэл: Хөрөнгийн үнэлгээ хийх үйл ажиллагаа, Даатгалын хохирлын үнэлгээ хийх, Бинесийн зөвлөгөө өгөх
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, 14200, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Ялалт плаза, 1002 тоот
Утас: +976 8800 0267
Цахим шуудан: halo_tsoomoo@yahoo.com

"Файн Эстимэйт" ХХК нь 2010 оны 02 дугаар сарын 19-нд Хөрөнгийн үнэлгээ, Үл хөдлөх хөрөнгийн худалдаа, зуучлал болон Бизнесийн зөвлөгөө өгөх чиглэлээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Тус компани нь 2010 онд Санхүүгийн зохицуулах хорооны "Даатгалын хохирлын үнэлгээний тусгай зөвшөөрөл", 2015 онд СЗХ-ны "Үнэт цаасны зах зээлд оролцогчдод хөрөнгийн үнэлгээ хийх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл", "Хөрөнгийн үнэлгээний тухай хууль" шинэчлэгдсэнтэй холбоотойгоор "Хөрөнгийн үнэлгээний хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөл"-ийг 2023 оны 10 дугаар сард Сангийн яамнаас авч 2015 оноос хойш Үнэт цаасны зах зээлд оролцогчдод хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний үйлчилгээ үзүүлж байна.

Файн Эстимэйт ХХК нь орон тооны 4, гэрээт 2 тусгай зөвшөөрөлтэй үнэлгээчидтэй үйл ажиллагаа явуулдаг. Файн Эстимэйт ХХК нь Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэх болон бүртгэлээс хасагдах компаниудын хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ, "Баянхошуу дэд төв", "Сэлбэ дэд төв", "Дамбадаржаа дэд төв", "Толгойт" зэрэг дэд төвүүдийн нөхөн олговрын зориулалттай үнэлгээ, томоохон албан байгууллагуудын санхүүгийн тайлагналын зориулалттай үнэлгээ, банкуудын активын чанарын үнэлгээг хийж гүйцэтгэж байна.

### Хөрөнгийн үнэлгээ хийх үйлчилгээний гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг:

Нэг талаас "Монголын финтек групп" ХК (цаашид "Захиалагч" гэх), нөгөө талаас "Файн Эстимэйт" ХХК (цаашид "Гүйцэтгэгч" гэх) нар газар эзэмших эрхийн үнэлгээ хийх гэрээг 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр байгуулсан.

- Захиалагч нь энэхүү гэрээний дагуу хийгдэх ажиллагааг удирдан зохион байгуулах, шаардлагатай материалыг бэлтгэж өгөх, Гүйцэтгэгчээс ирүүлсэн тайлан болон бусад материалыг хүлээн авч батлах болон төлбөрийн нэхэмжлэлийн дагуу төлбөр хийх үүрэг хүлээнэ.
- Гүйцэтгэгч нь гэрээнд заасны дагуу шаардагдах үнэлгээний тайлангийн төслийг гэрээт ажил дуусгавар болох хугацаанаас ажлын 1 хоногийн өмнө захиалагчид танилцуулах ба эцсийн хувилбарыг гэрээт ажлын хугацааны эцэст хүлээлгэн өгснөөр эдгээр тайлангууд нь төлбөрийг шилжүүлэх нөхцөл болно.
- Гүйцэтгэгч нь үнэлгээний тайланг зориулалтын дагуу татварын байгууллагын өмнөх хамгаалах үүрэг хүлээнэ. Гүйцэтгэгч нь Үнэлгээний Олон Улсын стандартын дагуу, мэргэжлийн ур чадвар, ёс суртахууны өндөр түвшинд үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.

СЗХ 2024.06.10 БҮРТГЭВ №01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## 6.6. АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ

“Өлзий энд Ко капитал ҮЦК” ХХК (Үндсэн андеррайтер гэх), “Райнос инвестмент ҮЦК” ХХК (Туслах андеррайтер гэх), “Голомт Капитал ҮЦК” ХХК (Туслах андеррайтер гэх) нар нь Үнэт цаас гаргагч “Сэндли ББСБ” ХК (РД: 5961548) -тай 2024 оны 03 сарын 21-ний өдөр, АГ-24/05 дугаартай “Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулж, Үнэт цаас гаргагчийн нэг бүр нь 100,000 төгрөгийн үнэтэй, 100,000 ширхэг бондыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгож нийт 10,000,000,000 (арван тэрбум) төгрөг татан төвлөрүүлэх үйл ажиллагаанд хамтран ажиллаж байгаа билээ.

Андеррайтерууд нь энэхүү үйл ажиллагаанд Монгол Улсын макро эдийн засгийн орчин, ирээдүйн төлөв, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээл, салбарын чиг хандлага, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, стратеги, бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөлөл зэргийг судалсны үндсэн дээр үнэт цаасны танилцуулгыг боловсруулан бэлтгэж, Андеррайтерийн мэргэжлийн дүгнэлтийг танилцуулж байна.

### 1. Үнэт цаас гаргагчийн тухай

Үнэт цаас гаргагч нь 2015 онд үүсгэн байгуулагдсан “Гялс кредит ББСБ” ХХК нэртэйгээр үйл ажиллагаа явуулж иржээ. Компанийн оноосон нэрийг өөрийн брэнд бүтээгдэхүүний нэрээр буюу “Сэндли ББСБ” ХХК хэмээн өөрчилснийг СЗХ-ны даргын 2021 оны 12 дугаар сарын 10-ны 328 тоот тушаалаар зөвшөөрч, 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Улсын бүртгэлд бүртгэсэн байна. Тус компани нь хувьцаагаа олон нийтэд МХБ-ээр дамжуулан санал болгож 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр нийт 10.05 тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн юм. Үнэт цаас гаргагч нь 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдөр нээлттэй хувьцаат компанийн гэрчилгээгээ авч, Улсын бүртгэлд бүртгэгдсэн билээ.

“Сэндли ББСБ” ХК нь зээл, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, гадаад валютын арилжаа, итгэлцэл, факторинг, төлбөрийн баталгаа гаргах тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үнэт цаас гаргагчийн бусдаас ялгарах онцлог, давуу тал нь Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ болон жижиглэн худалдаа эрхлэгч буюу мерчантын зээлийн үйлчилгээ юм.

Салбартаа анх удаа олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг нэвтрүүлснээр гадаадад суугаа Монгол иргэд зардал багатайгаар мөнгөн гуйвуулга хийх, түүнчлэн эх орондоо орон сууц худалдаж авах, сайн дурын нийгмийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломжтой болсон байна. Цаашлаад Монгол Улсад орох валютын урсгал ч нэмэгдэх таатай нөхцлийг бүрдүүлснийг 2021 онд “Сэндли ББСБ” ХК-ийн хүлээн авсан мөнгөн

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 9021031195 СТС2429

гүйвуулгын тоо нь арилжааны банкуудын нийт хүлээн авсан SWIFT гүйлгээний тооны 46.2 хувьтай тэнцэж байгаагаас харж болохоор байна.

Үнэт цаас гаргагч нь 2021 онд жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан богино хугацааны эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилготой мерчантын зээлийн үйлчилгээг нэвтрүүлсэн нь банкны барьцаа хөрөнгийн шаардлагыг хангаж чадахгүй байгаа жижиглэн худалдаа эрхлэгчдийг өндөр хүүтэй өдрийн зээл, далд эдийн засгийн харилцаанаас сэргийлсэн чухал ач холбогдолтой үйл явдал байв.

“Сэндли ББСБ” ХК нь үйлчилгээ үзүүлдэг салбар нэгжийн тоогоороо банк бус санхүүгийн салбартаа тэргүүлдэг бөгөөд орон нутагт 50, Улаанбаатар хотод 7 нийт 57 салбараар уламжлалт болон цахим зээлийн үйлчилгээг үзүүлж байна. Монгол Улсад бизнес эрхэлж буй жижиглэн худалдаа эрхлэгчид, бусад олон салбарын бизнес эрхлэгчдийн богино хугацааны эргэлтийн хөрөнгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бүрэн цогц экосистемийн хүрээнд хүргэж байна.

Үнэт цаас гаргагчийн толгой компани нь өөрийн охин компаниудын зах зээлд эзлэх байр суурь, өрсөлдөх чадвар, үнэ цэнийг ямагт нэмэгдүүлэхэд удирдлагаар хангаж ажилладаг бөгөөд зэргэлдээ компани хоорондын синержи үүсгэн, харилцан бие биенээ дэмжин ажилладаг. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирдлага нь банк, санхүүгийн салбарт олон жил ажилласан туршлагатай, мэргэжлийн хамт олон бөгөөд засаглал, дотоод хяналтын тогтолцоо нь ирээдүйн тогтвортой өсөлтийг бүрэн хангах чадвартай хэмээн үзэж байна.

## 2. Үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн төлөв

- Макро эдийн засгийн ерөнхий төлөв:

Монгол Улсын бодит эдийн засгийн өсөлт 2023 онд 7.0 хувь буюу 2022 онтой харьцуулахад 2.2 пунктээр нэмэгдсэн эерэг дүр зураг харууллаа. Ийнхүү 2023 онд эдийн засгийн өсөлт сайжрахад уул уурхайн олборлолт, тэр дундаа нүүрсний олборлолт, экспортын хэмжээ түүхэн дээд хэмжээнд хүрсэн нь нөлөөлсөн. Монголбанкны 2024 оны 3 дугаар сарын Мөнгөний бодлогын хорооны хурлаар бодлогын хүүг нэг нэгжээр бууруулж 12.0 хувьд хүргэсэн нь дунд хугацаанд мөнгөний нийлүүлэлт талаас эдийн засгийн хэвийн өсөлтийг дэмжих ач холбогдолтой хэмээн танилцуулсан юм.

Үнийн өсөлтийн хувьд 2024 оны 3 дугаар сарын эцэст 7.0 хувьд хүрсэн нь зургаан сар дараалан инфляц нэг оронтой тоонд хадгалагдсан чухал үзүүлэлт болж байна. Гэхдээ 2024 оны 4 дүгээр сараас эхлэн төрийн албан хаагчдын цалин, өндөр настны тэтгэвэр нэмэгдэх, Эрдэнэс тавантолгой ХК-ийн ногдол ашиг тараагдсан зэрэг үнийн өсөлтийг өдөөж болзошгүй сорилтууд хэвээр байна. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хувьд чулуун нүүрсний экспортын биет хэмжээ эхний хоёр сард 35.9 хувиар өсөж, 10.6 сая тоннд хүрсэн

СЭХ 2024 06 10 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
2024 .06. 10
он сар өдөр
БҮРТГЭВ

2024 -05- 17
БҮРТГЭВ-02

байна. Мөн уул уурхайн экспортын нөлөөгөөр валютын орох урсгал нэмэгдэж байгаа нь Монгол Улсын гадаад валютын улсын нөөц түүхэн дээд түвшинд буюу 5.2 тэрбум ам.долларт хүрэхэд голлон нөлөөлсөн. Иймд ойрын хугацаанд төгрөгийн ханшид ирэх дарамт буурах төлөвтэй байгаа хэдий ч олон улсын геополитикийн нөхцөл байдал, шатахууны нийлүүлэлт, ханшийн тогтвортой байдал, хөрш БНХАУ-ын түүхий эдийн хэрэглээний өөрчлөлт зэрэг гадаад хүчин зүйлсээс хамаарсан эрсдэлүүд Монгол Улсын эдийн засгийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлж байна.

- Салбарын төлөв:

Үнэт цаас гаргагчийн голлох үйл ажиллагааны чиглэл нь зээлийн үйлчилгээ болон олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ билээ. Банк бус санхүүгийн байгууллагын салбарын хувьд нийт активын хэмжээ нь банкны салбарын нийт активтай харьцуулахад 8.6 хувьтай дүйцэж байна. Финтек санхүүгийн байгууллагуудаас хэрэглэгчид утсаараа хялбар зээл авах боломж нь тус зах зээл тэлэх гол хөшүүрэг болж байна. Жишээ нь банк бус санхүүгийн салбарын нийт 1.4 сая зээлдэгчийн 1.2 сая зээлдэгч нь финтек салбарт ногдож байгаагаас харж болох юм. Тус салбарын ашигт ажиллагаа 2022 онд 312.9 тэрбум төгрөг байсан бол 2023 оны эхний гурван улиралд 302.4 тэрбум төгрөг болсон. Мөн мөнгөний хатуу бодлогыг Монголбанкнаас хэрэгжүүлж байсантай холбоотойгоор 2021 онд тус салбарын зээлийн дундаж хүү 2.7 хувиас 2023 оны 3 дугаар улиралд 3.3 хувь болж өссөн нь салбарын зээлийн хүүгийн орлого өсөхөд нөлөө үзүүлжээ.

Мөнгөн гуйвуулгын зах зээлийн хувьд ажиллах хүчний шилжилт, бус нутаг хоорондын хүн ам зүйн өөрчлөлтөөс олон улсын мөнгөн гуйвуулгын зах зээл шууд хамаардаг нь судалгаагаар нотлогдсон ба олон улсын мөнгөн гуйвуулгын орчныг Ковид-19 цар тахлын дараах хүмүүсийн амьдралын хэв маягийн өөрчлөлт, аялал жуулчлал, хөдөлмөрийн нөхцөл ихээхэн өөрчилж байна. Монгол Улсын хувьд гадаадад зорчсон Монгол иргэдийн тоо 2023 онд өнгөрсөн онтой харьцуулахад 180.0 хувиар өссөн нь ирээдүйд гадаадад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдээс хүлээн авах мөнгөн гуйвуулгын дүн нэмэгдэх хүлээлт бий болгож байна.

## 3. Бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөлөл

“Сэндли ББСБ” ХК санхүү байдлын тайлангийн төсөөллөөс дүгнэхэд нийт актив 2024 онд 86.5 тэрбум төгрөг хүрэх төлөвлөгөөтэй байгаа бол 2027 он гэхэд 142.1 тэрбум төгрөг хүрэх тооцоололтой байна. Үнэт цаас гаргагч нь бизнес төлөвлөгөөний дагуу зээлийн үйлчилгээг идэвхжүүлж, санхүүгийн хөшүүргийг оновчтой ашигласнаар санхүүгийн үзүүлэлтээ хангаж ажиллах бүрэн боломжтой хэмээн дүгнэж байна.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ он сар өдөр 2024 06 10 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

| | 2024Т | 2025Т | 2026Т | 2027Т |
|---|---|---|---|---|
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 4,521 | 5,751 | 7,064 | 9,113 |
| Зээл (цэвэр дүнгээр) | 77,208 | 88,672 | 97,353 | 116,323 |
| Зээлийн багц (Нийт) | 79,390 | 91,116 | 100,800 | 120,545 |
| Зээлийн эрсдэлийн сан | (2,183) | (2,445) | (3,448) | (4,222) |
| Бусад хөрөнгө | 4,189 | 4,179 | 12,670 | 14,650 |
| Үндсэн хөрөнгө | 575 | 809 | 1,617 | 2,042 |
| Биет хөрөнгө /цэвэр/ | 244 | 395 | 862 | 987 |
| Биет бус хөрөнгө /цэвэр | 331 | 414 | 755 | 1,056 |
| **Нийт хөрөнгийн дүн** | 86,493 | 99,410 | 118,703 | 142,128 |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 26,877 | 34,812 | 40,800 | 50,200 |
| Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр | 7,300 | - | - | - |
| ББСБ-аас гаргасан өрийн бичиг | 10,000 | 10,000 | 20,000 | 20,000 |
| Бусад өр төлбөр | 7,652 | 9,022 | 4,467 | 4,480 |
| **Нийт өр төлбөр** | 51,829 | 53,834 | 65,267 | 74,680 |
| Энгийн хувьцаа | 11,179 | 11,179 | 11,179 | 11,179 |
| Халаасны хувьцаа | (519) | (519) | (2,500) | (2,500) |
| Нэмж төлөгдсөн капитал | 6,285 | 6,285 | 6,285 | 6,285 |
| Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг, алдагдал | 8,123 | 15,784 | 23,480 | 32,463 |
| Тухайн үеийн ашиг, алдагдал | 9,576 | 12,827 | 14,972 | 20,001 |
| Бусад өөрийн хөрөнгө | 21 | 21 | 21 | 21 |
| **Өөрийн хөрөнгө** | 34,664 | 45,576 | 53,436 | 67,448 |
| **Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн** | 86,493 | 99,410 | 118,703 | 142,128 |

Үнэт цаас гаргагч нь итгэлцлийн үйчилгээгээр татах санхүүжилт болон өрийн хэрэгслээр эх үүсвэр тогтмол татсанаар зээлийн багцаа идэвхтэй өсгөх төлөвтэй байна. Тухайлбал, 2024 онд нийт хөрөнгийн 60.0 орчим хувийг өр төлбөрөөр санхүүжүүлэх бол 40.0 орчим хувийг хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашгаас бий болгох төсөөлөлтэй байна. 2027 онд нийт өр төлбөрийн дүн 2024 онтой харьцуулахад 44.1 хувь буюу 22.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэх төлөвтэй байна.

Нийт өр төлбөрийн бүтэц 2027 он гэхэд итгэлцлээр үүсгэсэн санхүүжилт 50.2 тэрбум төгрөгт хүрэх ба нийт өр төлбөрийн 67.2 хувийг бүрдүүлэх юм. Харин өрийн бичгээр татсан санхүүжилтийн хэмжээ 20.0 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байгаа ба нийт өр төлбөрийн 26.7 хувийг эзэлнэ. Өрийн хэрэгслээр татан төвлөрүүлэх дүнг санхүүгийн зохистой харьцааг хангах нөхцөлийн хүрээнд төсөөлжээ.

СЗХ
БҮРТГЭВ
он 2024 сар 05 өдөр 10
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

*Хүснэгт Б. Орлого, үр дүнгийн тайлан*

| Үзүүлэлт | 2024Т | 2025Т | 2026Т | 2027Т |
|---|---|---|---|---|
| **Хүүгийн орлого** | **20,846** | **24,828** | **33,780** | **40,730** |
| Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого | - | - | 30 | 30 |
| Зээлийн хүүгийн орлого | 20,846 | 24,828 | 33,750 | 40,700 |
| **Хүүгийн зардал** | **7,498** | **8,191** | **12,350** | **14,342** |
| Итгэлцэлийн хүүгийн зардал | 4,567 | 5,906 | 8,650 | 10,642 |
| Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн | 977 | 365 | - | - |
| Өрийн бичгийн хүүгийн зардал | 1,954 | 1,920 | 3,700 | 3,700 |
| Цэвэр хүүгийн орлого | 13,348 | 16,637 | 21,430 | 26,388 |
| **Хүүгийн бус орлого** | **10,334** | **12,577** | **14,735** | **17,500** |
| Гадаад валютын арилжааны орлого | 420 | 483 | 535 | 700 |
| Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого | 2,431 | 2,674 | 2,850 | 3,550 |
| Зээлийн үйлчилгээний шимтгэл, хураамж | 6,146 | 7,682 | 8,500 | 9,800 |
| Мөнгөн гүйвуулгын үйлчилгээний орлого | 1,337 | 1,738 | 2,600 | 3,200 |
| Бусад орлого | - | - | 250 | 250 |
| **Хүүгийн бус зардал** | **11,568** | **13,049** | **16,400** | **17,645** |
| Гадаад валютын арилжааны зардал | 33 | 38 | 350 | 465 |
| Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал | 1,811 | 1,829 | 1,950 | 2,000 |
| Боловсон хүчний холбогдолтой зардал | 4,020 | 4,624 | 5,900 | 6,550 |
| Үйл ажиллагааны зардал | 5,704 | 6,559 | 8,050 | 8,480 |
| Бусад хүүгийн бус зардал | - | - | 150 | 150 |
| Цэвэр хүүгийн бус орлого | (1,234) | (472) | (1,665) | (145) |
| Зээлийн эрсдэлийн сангийн зардал | 546 | 262 | 1,003 | 775 |
| Татварын өмнөх ашиг, алдагдал | 11,568 | 15,902 | 18,762 | 25,468 |
| Орлогын татварын зардал | 1,992 | 3,076 | 3,791 | 5,467 |
| Татварын дараах ашиг, алдагдал | 9,576 | 12,827 | 14,972 | 20,001 |

*Хүснэгт В. Мөнгөн гүйлгээний тайлан*

| | 2024Т | 2025Т | 2026Т | 2027Т |
|---|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | | |
| Цэвэр ашиг | 9,576 | 12,827 | 14,972 | 20,001 |
| Элэгдэл, хорогдлын зардал | 187 | 60 | 504 | 415 |
| Хүүгийн зардал | 7,498 | 8,191 | 12,350 | 14,342 |
| Татварын зардал | 1,992 | 3,076 | 3,791 | 5,467 |
| Гадаад валютын ашиг, (алдагдал) | (1,007) | (1,290) | (1,085) | (1,785) |
| Зээлийн эрсдэлийн зардал | 546 | 262 | 1,003 | 775 |
| Ажлын капиталын өөрчлөлт | (37,072) | (20,909) | (40,409) | (41,417) |
| Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | (18,280) | 2,216 | (8,876) | (2,202) |
| **Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ** | | | | |
| Үндсэн хөрөнгө борлуулсан | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгө худалдаж авсан | 98 | 294 | 1,312 | [illegible] |
| Халаасласан хувьцаа | (519) | - | (1,981) | |

УЛААНБААТАР ХОТ
ӨДЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЭХ он сар өдөр 2024.06.10 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

| | | | | |
|---|---|---|---|---|
| Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ | (422) | 294 | (669) | 841 |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | | |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргасан | 7,300 | - | - | - |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн | (5,950) | (7,300) | - | - |
| Итгэлцлийн үйлчилгээ гаргасан | 15,000 | 18,000 | 22,000 | 30,000 |
| Итгэлцлийн үйлчилгээний төлбөр төлсөн | (7,614) | (10,065) | (16,012) | (20,600) |
| Бонд гаргасан | 10,000 | - | 20,000 | - |
| Бонд төлсөн | (8,500) | - | (10,000) | - |
| Ногдол ашигт төлсөн | (1,252) | (1,915) | (5,131) | (5,989) |
| Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | 8,984 | (1,280) | 10,857 | 3,411 |
| Нийт цэвэр мөнгөн гүйлгээ | (9,718) | 1,230 | 1,312 | 2,049 |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 14,239 | 4,521 | 5,751 | 7,064 |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 4,521 | 5,751 | 7,064 | 9,113 |

2024 онд нийт цэвэр орлогын 56.4 хувь буюу 13.3 тэрбум төгрөгийг цэвэр хүүгийн орлогоос, үлдсэн 43.6 хувь буюу 10.3 тэрбум төгрөгийн үйлчилгээний шимтгэл хураамж, мөнгөн гуйвуулгын шимтгэл зэрэг хүүгийн бус орлогоос олох төлөвтэй байна. 2024-2027 оны хооронд нийт цэвэр орлогын дүн жилд дунджаар 22.8 хувиар өсөх төлөвтэй байна.

Үүнээс бизнесийн үйл ажиллагаанд тусгасан орон нутаг дахь салбарын тэлэлт болон харилцагчдын тооны өсөлтөөс шалтгаалж зээлийн хүүгийн орлого жилд дунджаар 25.5 хувиар өсөх бол үйлчилгээний хураамж, мөнгөн гуйвуулгын шимтгэлийн орлго зэрэг хүүгийн бус орлого 19.2 хувиар өсөх төсөөлөлтэй байна.

## 3. Хүүгийн түвшин тогтоосон үндэслэл

Үнэт цаас гаргагч нь өрийн хэрэгслийн хүүгийн түвшинг тогтоохдоо дотоодын эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулагчдын хүлээлт, банкны хадгаламжийн хүү, ижил төрлийн өрийн хэрэгслийн хүү зэргийг харгалзан бонд эзэмшигчдэд жилийн 18.5 хувийн хүүг санал болгож байна.

Сэндли Бонд 2.0-ын зах зээл дээрх өрсөлдөхүйц хүүгийн түвшнийг тогтоохын тулд тогтмол өгөөжтэй хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн хүүг судалж, График А.-д нэгтгэн харуулав. 12 сарын хугацаатай банкны хадгаламжийн хүү 12.2 хувь байгаа бол МХБ дээр нээлттэй арилжаалагдсан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны дундаж хүү 18.1 хувь, нээлттэй бонд 18.2 хувийг хөрөнгө оруулагч нарт санал болгож байсан. Харин Сэндли Бонд 2.0-ын хувьд 18.5 хувь нь харьцангуй өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалт болох боломжтой байна.

УЛААНБААТАР ХОТ ... КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 ...021031195 СТС2420

График А. Тогтмол өгөөжтэй хөрөнгө оруулалтын хэрэгсэл




## 5. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь 100,000 (нэг зуун мянга) ширхэг, нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, тогтмол хүүтэй, энгийн бондыг олон нийтэд санал болгож нийт 10,000,000,000 (арван тэрбум) төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлэхээр төлөвлөж байгаа билээ. Энэхүү олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг Үнэт цаас гаргагч нь бизнесийн үндсэн үйл ажиллагаа болох зээлийн үйл ажиллагаагаа санхүүжүүлэхэд зарцуулна.

*Хүснэгт 44. Эх үүсвэрийн зарцуулалт*

| № | Эх үүсвэрийн зарцуулалтын төлөвлөгөө | Мөнгөн дүн |
|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагаа буюу зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх | 10,000,000,000 (арван тэрбум) төгрөг |

Өрийн хэрэгслээр татан төвлөрүүлэх санхүүжилтийг зөвхөн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд тус санхүүжилтийн зардлыг татан төвлөрүүлэх хөрөнгөөс гаргахгүй болно.

## 6. Эрсдэлийн бодлого

Үнэт цаас гаргагч нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаартай тогтоолоор “Эрсдэлийн удирдлагын бодлого”-ыг баталсан ба 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн №12 тоот ТУЗ-ийн тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан. Тус эрх зүйн баримт бичигт эрсдэлийн удирдлагын тодорхойлолт, зорилт, үндсэн зарчим, төрөл, ангилал, хэрэгжүүлэх үе шат, шинжилгээ, тайлагнал, хяналт хариуцлагын талаар тусгасан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Сэндли ББСБ-ын зээлийн эрсдэлийн бодлогын хүрээнд нэг зээлдэгчид олгох зээлийн дээд дүнг бага байлгах, төвлөрлийн эрсдэлийг боломжит доод түвшинд барих бөгөөд 2023 оны эцсийн байдлаар нэг зээлдэгчид ногдох зээлийн дүн 1.8 сая төгрөг байна. Чанаргүй зээлийн эзлэх хувь 2023 оны

СЗХ 2024.05.10 БҮРТГЭВ №01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17

сүүлийн байдлаар нийт зээлийн багцын 5.4 хувийг эзэлж байна. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 2019 оноос хойш бүрэн хангаж ажиллажээ.

*Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг:*

"Сэндли ББСБ" ХК нь эрсдэлийг тодорхойлохдоо өөрийн стратегийн хэрэгжилт, үйл ажиллагаанд тодорхойгүй сөрөг байдал үүсэх магадлал болон түүний нөлөөллөөр хэмжихээр тогтоожээ.

Эрсдэлийг удирдахдаа хараат бусаар үнэлгээ хийх, тогтмол сайн тайлагналтай байх, байнга сайжруулалт хийж байх, эрдсэл нь хэмжигдэхүйц байх, баримтжуулсан байх, эрх мэдлийн төвлөрлийг хязгаарлах, эдийн засгийн үр ашигтай байх зэрэг зарчмыг мөрдөнө.

*Эрсдэлийн удирдлагын бүтэц – Хамгаалалтын 3 шугам*

Компани нь эрсдэлийн удирдлагыг нэгдсэн байдлаар хэрэгжүүлэх ба эрсдэлийн удирдлагын төвлөрсөн бүтэцтэй байна. Эрсдэлийн удирдлагын чиг үүргийг компанийн бүтэц, зохион байгуулалтандаа **"Хамгаалалтын 3 шугам"**-ын бодлого, зарчмыг хэрэгжүүлдэг.

*Эрсдэлийн удирдлага, хяналт*

- ✓ Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүсэх эрсдэл, хохирол, орлогоос хамаараад эрсдэлийг хүлээн зөвшөөрөх.
- ✓ Эрсдэлийн үнэлгээний үр дүнд өндөр эрсдэлтэй гэж тодорхойлогдсон эсвэл тухайн үйл ажиллагааны эрсдэлийг хангалттай тодорхойлох боломжгүй тохиолдолд уг үйлчилгээг нэвтрүүлэхээс зайлсхийх.
- ✓ Эрсдэлийн төрөл тус бүрт зохистой эрсдэлийн хязгаар тогтоож, эд хөрөнгө, үйлчилгээ, шаардлагатай тохиолдолд ажилтныг даатгалд хамруулж болзошгүй хохирлоос хамгаална. Эрсдэлийн төрөл тус бүрийн эрсдэлийн үзүүлэлт бүрт хяналт тавьж ажиллана.

## 7. Хөрөнгө оруулалтын боломж

- Өндөр өгөөж

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад 18.5 хувийн хүүг санал болгож байгаа нь 2022-2023 онд Монгол хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалагдсан бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ)-аас харьцангуй өндөр хүүтэй байна. Тухайлбал ХБҮЦ-ны дундаж хүү 18.1 хувь, компанийн нээлттэй бондын хүү 18.2 хувь, ТОП-5 банкны хадгаламжийн хүү 12.2 хувьтай харьцуулахад харьцангуй өндөр өгөөжийг хөрөнгө оруулагч нарт санал болгож байна.

- Арилжааны боломж

Үнэт цаас гаргагчийн компанийн бонд нь Монгол хөрөнгийн биржийн систем дээр нээлттэй байршиж, олон нийтэд арилжаалагдах учраас бонд эзэмшигч нь хэрэгцээтэй үедээ худалдан авсан бондоо хоёрдогч зах зээл дээр борлуулах, худалдан авах бүрэн боломжтой байна.

- Барьцаатай бонд

“Сэндли ББСБ ХК”-ийн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтээс санхүүжилт татах зорилгоор гаргаж буй 10,000,000,000 (арван тэрбум таван зуун сая) төгрөгийн үнийн дүн бүхий нээлттэй бондын үндсэн төлбөр ба хүүгийн төлбөрийн эрсдэлийг бууруулж, хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс хамгаалах зорилгоор Үнэт цаас гаргагчийн толгой компани Монголын финтек групп ХК ба Үндсэн андеррайтер нь харилцан тохиролцсоны үндсэн дээр толгой компани нь өөрийн эзэмшиж буй үнэт цаас гаргагчийн хувьцаа болон газар эзэмших хоёр эрхээ холбогдох журмын дагуу барьцаалуулсан.

## 8. Хөрөнгө оруулагчдад зөвлөх нь

Хөрөнгө оруулагч нь үнэт цаас гаргагчийн танилцуулгын бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөллүүд нь ирээдүйн макро эдийн засгийн орчин, хөрөнгийн зах зээлийн төлөв байдлын таамаглалууд дээр суурилж байгаа учраас нийгэм, эдийн засгийн урьдчилан таамаглах боломжгүй гэнэтийн шокуудын улмаас өөрчлөгдөж болно гэдгийг анхаарах нь зүйтэй.

Иймд хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан “Эрсдэлийн удирдлага”, “Бизнес төлөвлөгөө”, “Зах зээлийн судалгаа” хэсгүүдтэй сайтар уншиж, танилцсаны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

2024.06.10 он сар өдөр
БҮРТГЭВ

2024-06-17
БҮРТГЭВ-02

# Хавсралт

УЛААНБААТАР ХОТ
ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2024 он 06 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2024 -05- 17
БҮРТГЭВ-02

## ХАВСРАЛТ-1. АУДИТЫН ТАЙЛАН, ДҮГНЭЛТ

**ХҮЛЭГТХҮННҮ АУДИТ ХХК**

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**"СЭНДЛИ ББСБ" ХК**

**2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЭХ 2024 он 05 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

"СЭНДЛИ ББСБ" ХК-ийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

## "СЭНДЛИ ББСБ" ХК

## АГУУЛГА


Удирдлагын хариуцлагын мэдэгдэл ........................................ 3

Байгууллагын талаарх мэдээлэл ........................................ 4

Хараат бус аудиторын тайлан ........................................ 6


## САНХҮҮГИЙН ТАЙЛАН


Санхүүгийн байдлын тайлан ........................................ 7

Орлогын дэлгэрэнгүй тайлан ........................................ 8

Өмчийн өөрчлөлтийн тайлан ........................................ 9

Мөнгөн гүйлгээний тайлан ........................................ 10

"СЭНДЛИ ББСБ" ХК ........................................ 11

1. Банк бус санхүүгийн байгууллагын талаарх мэдээлэл ........................................ 12
2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй ........................................ 12
3. Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, төсөөллүүд ........................................ 23
4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба толилуулгад орсон өөрчлөлтүүд ........................................ 24
5. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө ........................................ 25
6. Харилцагчид олгосон зээл (цэвэр дүнгээр) ........................................ 26
7. Бусад санхүүгийн хөрөнгө ........................................ 27
8. Бусад санхүүгийн бус хөрөнгө ........................................ 27
9. Үндсэн хөрөнгө ........................................ 28
10. Биет бус хөрөнгө ........................................ 28
11. Банк, санхүүгийн байгууллага болон бусдаас татсан эх үүсвэр ........................................ 29
12. Бусад өр төлбөр ........................................ 30
13. Өөрийн хөрөнгө ........................................ 30
14. Хүүгийн орлого ........................................ 30
15. Хүүгийн зардал ........................................ 31
16. Арилжааны цэвэр орлого ........................................ 31
17. Ханш, үнэлгээний цэвэр орлого ........................................ 31
18. Валютын арилжаа болон ханш, үнэлгээний орлогын бодит хэрэгжилт ........................................ 31
19. Хураамж, шимтгэлийн цэвэр орлого ........................................ 31
20. Үйл ажиллагааны бусад зардал ........................................ 32
21. Орлогын татварын зардал ........................................ 33
22. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ ба үлдэгдэл ........................................ 33
23. Санхүүгийн эрсдэлийн удирдлага ........................................ 35
24. Орчуулга ........................................ 35
25. Хураангуй товчлол ........................................ 35


УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК 5183855 9021031195 СТС2420

СЭНДЛИ ББСБ ХК

СЗХ
2024 он 06 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2024-06-17
БҮРТГЭВ-02

**СЭНДЛИ ББСБ ХК**

**ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ**

Сэндли ББСБ ХК-ийн (цаашид "Компани" гэх) Гүйцэтгэх захирал Балжинням овогтой Одгэрэл, Санхүү эрхэлсэн захирал Мөнхбаатар овогтой Мөнхгэрэл, бид энэхүү тайлангийн 1-ээс дугаар хуудсанд толилуулсан тайлангуудыг холбогдох Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэсэн бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

БАЛЖИННЯМ ОДГЭРЭЛ
Гүйцэтгэх захирал

МӨНХБААТАР МӨНХГЭРЭЛ
Ерөнхий нягтлан бодогч

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2024 оны 02 дугаар сарын 19

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК
5183855
2021031195 СТС2420

СЗХ 2024 он 06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

2024-05-17 БҮРТГЭВ-02

"СЭНДЛИ ББСБ" ХК-ийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

## "СЭНДЛИ ББСБ" ХК

Банк бус санхүүгийн талаарх мэдээлэл (2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар)

**Үүсгэн байгуулах шийдвэр**

"Гялс Кредит ББСБ" нь 2015 оны 5 дугаар сарын 04-ны өдөр Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан.

"Гялс Кредит ББСБ" ХХК нь 2021 оны 12 дугаарын сарын 22-ны өдөр оноосон нэрээ Сэнди ББСБ болгон өөрчилсөн.

**Гэрчилгээ ба тусгай зөвшөөрөл**

Банк бус санхүүгийн байгууллага нь 2015 оны 05 сарын 04-ний өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж 5961548 тоот регистрийн дугаар бүхий, Улсын бүртгэлийн 9007001010 тоот гэрчилгээг авсан.

Банк бус санхүүгийн байгууллага нь 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх 101/498 тоот Тусгай зөвшөөрлийг авсан.

**Хувь нийлүүлэгчид**

| | |
|---|---|
| "Монголын Финтек Групп" ХХК | *56.4%* |
| "Олон нийт" | *29.3%* |
| "Сэндли Эмплойе" ХХК | *8.9%* |
| "Компанийн ажилчид" | *4.6%* |
| "Радикс Технологи" ХХК | *0.8%* |

**Гүйцэтгэх удирдлага**

Б.Одгэрэл – Гүйцэтгэх захирал
Х.Ичинхорлоо – Ерөнхий зохицуулалт хариуцсан захирал
М.Мөнхгэрэл – Санхүү хариуцсан захирал
П.Болорчулуун – Бизнес хариуцсан захирал
Д.Баярбат – Эрсдэл хяналт шалгалт хариуцсан захирал
Э.Мөнхдэлгэр – Бүтээгдэхүүн хөгжүүлэлт хариуцсан захирал
Б.Нямжаргал – Мөнгөн гүйвуулга хариуцсан захирал

**Хаяг**

**"Сэндли ББСБ" ХК**

8/4 тоот ,Бакула ренбүчи, 40,50 мянгат
2-р хороо, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар хот, Монгол Улс

**Аудитор**

**"Хүлэгтхүнну Аудит" ХХК**

4/402 тоот, Сити Капитал,
6-р хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс

УЛААНБААТАР ХОТ ... 5183855 9021031195 СТС2420

СЭНДЛИ ББСБ ХК

СЭХ
2024.06.10
БҮРТГЭВ
№01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**СЭНДЛИ ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд**

### Дүгнэлт

Бид СЭНДЛИ ББСБ ХК (цаашид "компани" гэх)-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бид, компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна гэж дүгнэж байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид "МНБЕЗ-н дүрэм" гэх)-ийн дагуу компаниас хараат бус ба МНБЕЗ-н дүрмийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

### Санхүүгийн тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн, шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай залилан үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

### Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай залилан үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар үл үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга

"Хүлээтхүнүү аудит" ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу/14201/, Самбуугийн гудамж, 8-р барилга, 4-р давхарт, 402 тоот
Утас/Факс: +(976)-7014 0505

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК
5183855
2021031195 СТС2420

СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ 2024 он 06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Үүнээс гадна

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоон дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадвартай мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил, дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Гарын үсэг зурсан:

И.[illegible]
Гүйцэтгэх захирал
Хүлээтхүнүү Аудит ХХК

2024 оны 02 дугаар сарын 19-ны өдөр
Монгол Улс, Улаанбаатар хот

• "Хүлээтхүнүү аудит" ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу/14201/, Самбуугийн гудамж, 6-р байшин, 4-р давхарт, 402 тоот
Утас/Факс: +(976)-7014 0505

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 9021031195 5183855 СТС2420

СЗХ 2024 он 06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

“СЭНДЛИ ББСБ” ХК-ийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| *Төгрөгөөр* | Тодруулгын дугаар | 2023 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 5 | 14,238,843,254.00 | 8,391,786,561.40 |
| Харилцагчид олгосон зээл ба урьдчилгаа (цэвэр дүнгээр) | 6 | 44,428,236,471.09 | 23,947,603,979.82 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 7 | 3,281,083,279.57 | 1,492,474,449.12 |
| Бусад санхүүгийн бус хөрөнгө | 8 | 939,975,345.63 | 671,007,207.89 |
| Үндсэн хөрөнгө | 9 | 275,505,198.26 | 184,288,047.46 |
| Биет бус хөрөнгө | 10 | 363,609,616.11 | 204,119,222.05 |
| **Нийт хөрөнгийн дүн** | | **63,527,253,164.66** | **34,891,279,467.74** |
| **Өр төлбөр** | | | |
| Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр | 11 | 5,950,000,000.00 | 2,227,897,495.69 |
| Бусад эх үүсвэр | 11 | 29,665,053,257.28 | 11,136,820,255.27 |
| Бусад санхүүгийн бус өр төлбөр | 12 | 1,058,487,966.59 | 100,761,149.81 |
| **Нийт өр төлбөрийн дүн** | | **36,673,541,223.87** | **13,465,478,900.77** |
| **Өөрийн хөрөнгө** | | | |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 13 | 11,178,500,000.00 | 11,178,500,000.00 |
| Нэмж төлөгдсөн капитал | - | 6,284,799,652.50 | 6,284,799,652.50 |
| Хуримтлагдсан ашиг, алдагдал | - | 9,375,306,295.95 | 3,947,784,104.16 |
| Бусад өөрийн хөрөнгө | 13.2 | 15,105,992.34 | 14,716,810.31 |
| **Өөрийн хөрөнгийн дүн** | | **26,853,711,940.79** | **21,425,800,566.97** |
| **Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн** | | **63,527,253,164.66** | **34,891,279,467.74** |

*11-35 дугаар хуудсанд хавсаргасан нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

ЭРНСТ ЭНД ЯНГ КО КАПИТАЛ ҮНК ХХК УЛААНБААТАР ХОТ 5183855 9021031195 СТС 420

СЗХ
2024 он 06 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

## "СЭНДЛИ ББСБ" ХК-ийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

| *Төгрөгөөр* | Тодруулгын дугаар | 2023 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **Хүүгийн орлого** | | | |
| Зээлийн хүүгийн орлого | 14 | 14,902,346,849.15 | 3,825,090,446.44 |
| **Хүүгийн зардал** | | | |
| Зээлийн хүүгийн зардал | 15 | 1,952,023,754.61 | 530,699,642.81 |
| **Хүүгийн цэвэр орлого** | | **12,950,323,094.54** | **3,294,390,803.63** |
| **Эрсдэлийн сангийн зардал** | | | |
| **Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого** | | **12,950,323,094.54** | **3,294,390,803.63** |
| **Хүүгийн бус орлого** | | | |
| Арилжааны орлого | 16 | 237,087,464.15 | 240,127,395.41 |
| Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого | 17 | 1,178,203,700.82 | 1,695,144,558.50 |
| Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | 19 | 4,991,199,726.13 | 5,504,263,552.67 |
| Бусад орлого, олз | - | 298,829,325.91 | 395,314,641.92 |
| **Хүүгийн бус зардал** | | | |
| Бусад эрсдэлийн сангийн зардал | - | 985,897,960.63 | 656,523,343.51 |
| Арилжааны зардал | 16 | 69,250,139.75 | 29,178,359.56 |
| Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал | 17 | 985,768,832.63 | 1,422,839,113.70 |
| Хураамж, шимтгэлийн зардал | - | - | - |
| Үйл ажиллагааны бусад зардал | 20 | 10,561,752,550.60 | 5,511,755,962.20 |
| Бусад зардал, гарз | - | 171,340,344.85 | 104,127,581.00 |
| **Татварын өмнөх ашиг, алдагдал** | | **6,881,633,483.09** | **3,404,816,592.16** |
| Орлогын татварын зардал | 21 | 826,199,600.18 | 340,530,580.00 |
| **Татварын дараах ашиг, алдагдал** | | **6,055,433,882.91** | **3,064,286,012.16** |
| Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал | | | |
| **Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал** | | **6,055,433,882.91** | **3,064,286,012.16** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | |
| **Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн** | | **6,055,433,882.91** | **3,064,286,012.16** |

*11-35 дугаар хуудсанд хавсаргасан нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

УЛААНБААТАР ХОТ
ОЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮШК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ 2024 .06. 10 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

"СЭНДЛИ ББСБ" ХК-ийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| *Төгрөгөөр* | Хувь нийлүүлсэн хөрөнгө | Нэмж төлөгдсөн капитал | Бусад өөрийн хөрөнгө | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **11,178,500,000** | **6,284,799,652** | **14,716,810** | **835,009,029** | **18,313,025,492** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | | 48,489,063 | 48,489,063 |
| Залруулсан үлдэгдэл | 11,178,500,000 | 6,284,799,652 | 14,716,810 | 883,498,092 | 18,361,514,555 |
| Тайлант үеийн ашиг (алдагдал) | - | - | | 3,064,286,012 | 3,064,286,012 |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **11,178,500,000** | **6,284,799,652** | **14,716,810** | **3,947,784,104** | **21,425,800,567** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - | (627,911,691) | (627,911,691) |
| Залруулсан үлдэгдэл | 11,178,500,000 | 6,284,799,652 | 14,716,810 | 3,319,872,413 | 20,797,888,876 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | 389,182 | - | 389,182 |
| Тайлант үеийн ашиг (алдагдал) | - | - | - | 6,055,433,883 | 6,055,433,883 |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - | - |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **11,178,500,000** | **6,284,799,652** | **15,105,992** | **9,375,306,296** | **26,853,711,941** |

*11-35 дугаар хуудсанд хавсаргасан нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

УЛААНБААТАР ХОТ ... ХХК 5183855 CTC2420

СЗХ 2024 оны 06 сарын 10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024 05 17 БҮРТГЭВ-02

"СЭНДЛИ ББСБ" ХК-ийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| *Төгрөгөөр* | 2023 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|
| **Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн** | **6,024,679,800** | **7,326,550,841** |
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого** | **19,518,124,429** | **11,659,940,595** |
| Зээлийн хүүгийн орлого | 13,851,931,462 | 3,816,023,806 |
| Үнэт цаасны хүүгийн орлого | - | 9,066,641 |
| Харилцах дансны хүүгийн орлого | 15,621,569 | - |
| Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого | 124,433 | - |
| Гадаад валютын арилжааны орлого | 167,837,324 | 203,887,138 |
| Үнэт цаасны арилжааны орлого | - | 36,240,258 |
| Гадаад валютын ханшийн зөрүү | 192,434,868 | 1,695,144,559 |
| Мөнгөн гүйвуулгын орлого | 544,060,228 | 314,704,897 |
| Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | 4,447,285,588 | 5,189,558,655 |
| Бусад үйлчилгээний орлого | 298,828,957 | 395,314,642 |
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага** | **13,493,444,630** | **4,333,389,754** |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал | 462,887,902 | 530,699,643 |
| Өрийн бичгийн хүүд төлсөн мөнгө | 1,502,334,247 | - |
| Үндсэн ба нэмэгдэл цалин | 2,385,643,666 | 1,362,591,434 |
| Ажилтануудад олгосон нөхөн олговор, тэтгэмж | 30,837,358 | 4,837,744 |
| Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал | 298,066,747 | 169,538,155 |
| Албан томилолт, сургалтын зардал | 156,958,079 | 102,284,817 |
| Ашиглалтын зардалд төлсөн мөнгө | 282,611,012 | 211,062,226 |
| Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө | 163,814,149 | 92,811,012 |
| Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал | 62,547,903 | 42,672,223 |
| Татвар, даатгалын төлсөн мөнгө | 420,368,628 | 956,968 |
| Зар сурталчилгаанд төлсөн мөнгө | 486,178,413 | 511,017,695 |
| Үнэт цаас болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбоотой гарсан мөнгө | 189,849,333 | - |
| Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө | 18,589,425 | 100,000 |
| Итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбогдон гарсан мөнгө | 3,585,368,950 | 810,868,266 |
| Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө | 820,923,822 | 440,456,100 |
| Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө | 2,880,000 | 4,100,000 |
| Ногдол ашгаар олгосон мөнгө | 614,817,500 | - |
| Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө | 2,008,767,496 | 49,393,471 |
| **Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **(177,623,107)** | **(104,127,581)** |
| **Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого** | - | - |
| Үндсэн ба хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| Бусад | - | - |
| **Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага** | **177,623,107** | **104,127,581** |
| Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал | 160,308,226 | 77,454,784 |
| Торгуулийн зардал | - | 1,409,565 |
| Бусад | 17,314,881 | 25,263,232 |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **5,847,056,693** | **7,222,423,260** |
| **МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ** | **8,391,786,561** | **1,169,363,301** |
| **МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ** | **14,238,843,254** | **8,391,786,561** |

*11-35 дугаар хуудсанд хавсаргасан нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ АУДИТ ХХК 5183855 9021031195 СТС2420

СЭНДЛИ ББСБ ХК

СЭХ
2024 оны 06 сарын 10 өдөр
БҮРТГЭВ
№ 1

2024 -06- 17
БҮРТГЭВ-02

"СЭНДЛИ ББСБ" ХК-ийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

## 1. Банк бус санхүүгийн байгууллагын талаарх мэдээлэл

### 1.1 Танилцуулга

"Сэндли ББСБ" Хувьцаат Компани (цаашид "банк бус санхүүгийн байгууллага" гэх) нь 2015 оны 5 сарын 04-ны өдөр "Гялс Кредит ББСБ" нэртэйгээр Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан бөгөөд тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг, банк бус санхүүгийн байгууллага нь өөрийн хөрөнгийн хэмжээнд хариуцлага хүлээдэг. Гялс Кредит ББСБ нь 2021 оны 12 дугаарын сарын 22-ны өдөр оноосон нэрээ Сэндли ББСБ болгон өөрчилсөн.

Банк бус санхүүгийн байгууллагын эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд банкны өдөр тутмын үйл ажиллагаар Гүйцэтгэх захирал удирдан зохион байгуулдаг. .

### 1.2 Үйл ажиллагаа, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл

Банк бус санхүүгийн байгууллагын хүчин төгөлдөр дүрмийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр дараах үйлчилгээг эрхэлнэ. Үүнд:

- Зээлийн үйл ажиллагаа
- Цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвүүлгын үйлчилгээ
- Гадаад валютын арилжаа
- Факторинг үйлчилгээ
- Төлбөр баталгаа гаргах
- Итгэлцлийн үйлчилгээ
- Гадаад төлбөр тооцоо хийх

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй

### 2.1 Тайлан бэлтгэсэн үндэслэл

#### 2.1.1 Мөрдсөн стандарт

Санхүүгийн тайлангаа Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс баталж гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлсэн Санхүүгийн зохицуулах хорооны, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого заавар, журмын дагуу дагуу бэлтгэсэн.

#### 2.1.2 Тайлан бэлтгэсэн суурь

Банк бус санхүүгийн байгууллага эдгээр санхүүгийн тайлангууд нь СТОУС-ын дагуу түүхэн бодит өртөг дээр үндэслэн санхүүгийн хэрэглүүрүүдийн анхны хүлээн зөвшөөрөлтөөр өөрчилсөн бодит үнэ цэнээр ба үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдал ("БҮЦАА")-аар илэрхийлэх санхүүгийн хэрэглүүр болон бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлого ("БҮЦБДО")-р илэрхийлэх санхүүгийн хэрэглүүрээр бүртгэх зарчмыг баримтлан бэлтгэсэн.

Банк бус санхүүгийн байгууллага нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу нягтлан бодох бүртгэлээ хөтөлдөг.

Банк бус санхүүгийн байгууллага нь санхүүгийн тайлангуудыг үйл ажиллагааны үндсэн мөнгөн тэмдэгт болох "Монгол төгрөг"-өөр илэрхийлсэн. Бүх санхүүгийн мэдээллийг өөрөөр заагаагүй бол "төгрөг"-өөр илэрхийлсэн.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮДК ХХК
5183855
9020031195 СТС2420

СЭНДЛИ ББСБ ХК

СЭХ 2024 .06 .10 өдөр БҮРТГЭВ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02



## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.2 Санхүүгийн тайлангийн толилуулга

Банк санхүүгийн байгууллага нь санхүүгийн байдлын тайлангийн зүйлсийг хөрвөх чадварынх нь дараалаар толилуулсан. Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараах 12 сарын дотор (богино хугацаанд) ба 12 сараас хойших хугацаанд (урт хугацаанд) хүлээн авахаар толилуулсан.
Банк санхүүгийн байгууллага нь зөвхөн тухайн санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрүүдийг цэвэр дүнгээр нь барагдуулах хуулиар олгогдсон эрхтэй, мөн санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрүүдийг цэвэр дүнгээр нь барагдуулахаар төлөвлөж байгаа, эсхүл хөрөнгийг ашиглаж өр төлбөрийг барагдуулах бол тэдгээр санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр толилуулах эрхтэй.
Нягтлан бодох бүртгэлийн аливаа нэг стандарт эсхүл тайлбараар шаардсан эсхүл зөвшөөрснөөс бусад тохиолдолд орлого, зарлагыг дэлгэрэнгүй орлогын тайланд хооронд нь хааж цэвэр дүнгээр тайлагнаж болохгүй, орлого зардлыг цэвэр дүнгээр нь тайлагнасан тохиолдолд Банк санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогод энэ тухай тусгайлан тодруулна.

### 2.3 Санхүүгийн хэрэглүүр

#### 2.3.1 Хэмжилтийн үндсэн нэр томъёо

Санхүүгийн хэрэгслүүдийн ангиллаас хамааран тэдгээрийг дор тайлбарласны дагуу бодит үнэ цэнэ, анхны өртгөөр, эсвэл хорогдуулсан өртгөөр бүртгэлд тусгана.

**Бодит үнэ цэнэ** нь хэмжилтийн өдөр зах зээлд оролцогч талууд сайн дураараа хоорондоо хөрөнгө худалдах, эсвэл хөрөнгө солилцох, өр төлбөр барагдуулахад төлөх үнэ юм. Бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо нь идэвхитэй зах зээлийн жишиг үнэ юм. Идэвхитэй зах зээл гэдэг нь хөрөнгө ба өр төлбөртэй холбоотой үнийн талаарх хангалттай их хэмжээгээр гүйлгээнүүдийн талаарх мэдээллийг байнга авч болох гарзыг хэлнэ.

Санхүүгийн хэрэгслүүдийн үнэ нь хөрөнгийн зах зээл, эсвэл бусад байгууллагаас тогтмол нийтэд зарлагдах буюу бэлэн олдох боломжтой бөгөөд эдгээр үнээр зах зээл дээр бодит гүйлгээ тогтмол хийгддэг тохиолдолд санхүүгийн хэрэгслүүдийг идэвхитэй зах зээл дээр санал болгосон гэж үзнэ.

Зах зээлийн үнийн талаар гаднаас мэдээлэл олдохгүй байгаа зарим санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнийг тогтоохдоо дискаунтчилсан мөнгөн гүйлгээний үнэлгээний загвар, холбоогүй талуудын хооронд хамгийн сүүлд хийгдсэн хэлцлийн талаарх санхүүгийн мэдээлэл дээр үндэслэн, үнэлгээний загвар болон хөрөнгө оруулалтын объектын талаарх санхүүгийн мэдээлэлд хийсэн дүн шинжилгээг ашиглаж тооцно. Үнэлгээний аргачлалуудад зах зээлийн нээлттэй мэдээлэл ашиглах боломжгүй үед таамаглалыг ашигладаг.

**Анхны өртөг** гэдэг нь худалдан авалтын өдөр төлөгдсөн мөнгөн хөрөнгө буюу түүнтэй адилтгах хөрөнгийн дүн, эсвэл хөрөнгө худалдаж авахад зориулагдсан бусад нөөцийн бодит үнэ бөгөөд үүнд хэлцэл болон ажил гүйлгээний зардлууд орно.

**Гүйлгээний зардлууд** нь санхүүгийн хэрэгслийг худалдан авах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардлууд гэдэг нь гүйлгээ хийгээгүй тохиолдолд үүсэхгүй байх зардал болно. Гүйлгээний зардалд зуучлагч, борлуулагч зуучлагчийн үүрэг гүйцэтгэж буй ажилтнууд, зөвлөх, брокер, диллерүүдэд төлсөн хураамж шимтгэл, зохицуулагч агентлаг, хөрөнгийн биржийн ногдуулсан хураамж төлбөр, мөн өмчлөлийн эрхийг шилжүүлэхэд ногдуулсан татвар хураамжууд хамаарна. Гүйлгээний зардалд өрийн хямдруулалт буюу урамшуулал, санхүүжилтийн зардал, дотоод удирдлагын буюу хадгалалтын зардлууд орохгүй.

**Хорогдуулсан өртөг** гэдэг нь санхүүгийн хэрэгслүүдийг анхлан хүлээн зөвшөөрсөн дүнгээс үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хасаж, хуримтлагдсан хүүг нэмж өгсөн дүн, харин санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 6021031195 СТС2420

СЗХ 2024 .09. 10 өдөр БҮРТГЭВ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024 -09- 17 БҮРТГЭВ-02



## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.3 Санхүүгийн хэрэглүүр (үргэлжлэл)

#### 2.3.1 Хэмжилтийн үндсэн нэр томъёо (үргэлжлэл)

дүн юм. Хуримтлагдсан хүүд анх хүлээн зөвшөөрсөн урамшууллын хойшлогдсон гүйлгээний зардал, мөн хөнгөлөлтийн дүнг үр ашигт хүүгийн аргаар тооцсон хямдруулалт орно. Хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардал, мөн хуримтлагдсан купон болон үнийн хямдруулсан урамшуулал буюу хөнгөлөлтийг (мөн аливаа хойшлогдсон шимтгэлийн хамт) тусад нь толилуулаагүй ба тэдгээрийг санхүүгийн байдлын тайланд хамаарах хэсэгт бүртгэлийн үнээр тусгасан болно.

**Үр ашигт хүүний арга** гэдэг нь хүүний орлого эсвэл хүүний зардлыг хамаарах хугацааны туршид санхүүгийн хэрэгслийн дансны үнээс тооцогдох хүүний хувийг тогтмол байлгахаар (үр ашигт хүүний хувь) хуваарилах арга юм. Үр ашигт хүүний хувь нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн орлого болон гарах зарлагыг (ирээдүйн зээлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэгслүүдийн хүлээгдэж буй хугацаа эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны туршид хямдруулж, санхүүгийн хэрэгслүүдийн бүртгэлийн цэвэр дүнг гаргах авах хүүний хувь болно. Үр ашигт хүүний хувь нь хувьсах хүүтэй санхүүгийн хэрэгслүүдийн мөнгөн урсгалыг хүү өөрчлөгдөх дараагийн моч хүртэл дискаунтчилах бөгөөд санхүүгийн хэрэгсэлд тусгагдсан хөвөх хүү дээр нэмэгдэх зээлийн хүүний зөрүүг илэрхийлсэн урамшуулал болон хөнгөлөлт мөн зах зээлийн ханшийн түвшинтэй уялдан өөрчлөгдөхгүй бусад хувьсах хүчин зүйлсийн нөлөөг дискаунтчилахгүй. Эдгээр урамшуулал болон хөнгөлөлтийг хэрэгслүүдийн хүлээгдэж буй нийт хугацааны туршид хорогдуулна. Өнөөгийн үнэ цэнийн тооцоололд гэрээний талуудын хооронд төлөх эсвэл хүлээн авах бүх хураамжийг оруулах бөгөөд тэдгээр нь үр ашигт хүүний бүрэлдэхүүн хэсэг болно.Санхүүгийн хэрэглүүрүүдийг ангиллаас нь хамааруулан бодит үнэ цэнэ, эсвэл хорогдуулсан өртгөөр доор тайлбарласны дагуу бүртгэлд тусгадаг.

#### 2.3.2 Санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрөх

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хэрэглүүрийг анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрнө. Бусад бүх санхүүгийн хэрэглүүрүүд нь анх гүйлгээний зардлыг тохируулсан бодит үнэ цэнээр бүртгэгддэг. Гүйлгээний үнэ нь анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо болдог. Анх бүртгэх үед үүсэх олз эсвэл гарз нь бодит үнэ цэнэ болон гүйлгээний үнийн хооронд зөрүү гарсан тохиолдолд л бүртгэгдэх бөгөөд үүнийг зөвхөн ижил төрлийн хэрэглүүрийг сүүлийн үед арилжсан талаарх зах зээлийн нээлттэй мэдээллээр баталгаажуулсан эсвэл зөвхөн нээлттэй зах зээлээс авсан мэдээлэл дээр үндэслэж хийсэн үнэлгээний аргачлалаар тооцсон тохиолдлуудад бүртгэнэ.

Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгүүд болон бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын хувьд зээлийн алдагдлын хасагдуулгийг хүлээн зөвшөөрнө.

Зохицуулалт эсвэл зах зээлийн жишгээр тогтоогдсон ("хэвийн" худалдаа болон худалдан авалт) тодорхой хугацаанд багтаан нийлүүлэх шаардлагатай санхүүгийн хөрөнгийн бүхий л худалдаа болон худалдан авалтыг арилжаа хийсэн өдөр буюу ББСБ тухайн санхүүгийн хөрөнгийг нийлүүлэх үүрэг хүлээсэн үед бүртгэнэ. Бусад бүх худалдан авалтыг ББСБ тухайн хэрэглүүрийн гэрээний тал болсон үед хүлээн зөвшөөрнө.

#### 2.3.3 Санхүүгийн хөрөнгө

***Санхүүгийн хөрөнгийн ангилал:*** ББСБ нь санхүүгийн хөрөнгүүдээ дараах байдлаар ангилна. Үүнд:

- Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө
- Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт

УЛААНБААТАР ХОТ ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 6183855 9021031195 СТС2020

СЗХ 2024 .05. 10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.3 Санхүүгийн хэрэглүүр (үргэлжлэл)

### 2.3.3 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

- Өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт ;
- Үүсмэл хэрэглүүрүүд ;
- Зээл ба урьдчилгаа .

ББСБ санхүүгийн хөрөнгүүдийн ангиллыг анхдагч хүлээн зөвшөөрөлтөөр тодорхойлдог. Анхдагч хүлээн зөвшөөрөлтөөрх санхүүгийн хөрөнгүүдийн ангилал нь тэдгээрийг олж эзэмших болсон зорилго болон тэдгээрийн шинж чанараас хамаарна. Санхүүгийн хэрэглүүрүүдийн ангиллаас хамааран тэдгээрийг дор тайлбарласны дагуу бодит үнэ цэнэ эсвэл хорогдуулсан өртгөөр бүртгэлд тусгадаг.

***Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт:*** Санхүүгийн хөрөнгийг анх бүртгэснээс хойш тохиосон нэг буюу олон үйл явдлын ("гарз учруулсан үйл явдлууд") үр дүнд үүссэн бөгөөд санхүүгийн дан ганц эсвэл бүлэг хөрөнгөнөөс ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгалын хэмжээ болон цаг хугацаанд нөлөө үзүүлэх үнэ цэнийн алдагдлыг, тухайн нөлөөг баталгаатай тооцох боломжтой тохиолдолд тайлант жилийн орлого, зардалд бүртгэнэ. Хэрэв ББСБ нь тусгайлан дангаар нь үнэлсэн санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнэ нь их, бага хэмжээгээр буурсныг илэрхийлэх бодит нотолгоо байхгүй гэж тодорхойлсон бол тухайн санхүүгийн хөрөнгийг ижил төрлийн зээлийн эрсдэлийн шинж чанартай санхүүгийн хөрөнгийн бүлэгт багтаан уг бүлгийн үнэ цэнийн бууралтыг хамтатган үнэлдэг. ББСБ-ны санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг тодорхойлоход авч үздэг үндсэн хүчин зүйлс нь тэдгээрийн хугацаа хэтрэлт, мөн барьцаа хөрөнгө (хэрэв байгаа бол)-ийн бодит үнэ цэнийн өөрчлөлт юм. Үнэ цэнэ бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг тодорхойлоход үндэслэл болгодог гол хэмжүүрүүд. Үүнд:

- Гэрээний нөгөө талын аливаа төлбөрийн хугацаа хэтрэлт;
- Гэрээний нөгөө тал санхүүгийн ихээхэн хүндрэлтэй учирдаг болох талаарх мэдээлэл ББСБ-д байгаа мэдээллээр нотлогдож байгаа;
- Гэрээний нөгөө талд нөлөөлөл үзүүлэх үндэсний буюу орон нутгийн эдийн засгийн өөрчлөлтийн нөхцөлтэй холбоотойгоор гэрээний нөгөө талын төлбөр гүйцэтгэлд өөрчлөлт гарсан.

Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын нөхцөлүүд нь хэлэлцээрийн журмаар дахин хянагдах буюу гэрээний нөгөө талын санхүүгийн хүндрэлтэй холбоотойгоор ямар нэг байдлаар өөрчлөгдсөн бол эдгээр нөхцөлийг дахин хянахаас өмнө анхны үр ашигт хүүг ашиглан үнэ цэнийн бууралтыг тодорхойлно. Үүний дараа тухайн санхүүгийн хөрөнгөтэй холбоотой эрсдэл, өгөөж ихээхэн өөрчлөгдсөн бол нөхцөл нь дахин хянагдсан санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасаж, шинэ хөрөнгийг бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ нь анхны болон шинээр хүлээгдэж буй мөнгөн урсгалын дискаунтчилсан үнийн хоорондын зөрүүгээр нотлогдоно.

Үнэ цэнийн бууралтын алдагдлыг үргэлж нөөцийн сангийн дансанд бүртгэж хөрөнгийн бүртгэлийн үнийг хүлээгдэж буй мөнгөн урсгалын (зээлийн хэрэгжээгүй алдагдлыг хасагдуулсан дүнгээр) анхны үр ашигт хүүгээр тооцсон өнөөгийн үнэ цэнэ хүртэл бууруулна. ББСБ-ны мэдэлд байгаа барьцаа төлбөрөөр хамгаалагдсан санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ нь холбогдох барьцааг өмчлөн авч борлуулснаас орж ирэх мөнгөн урсгалыг илэрхийлнэ.

Хэрэв үнэ цэнийн алдагдал дараах үеүдэд буурч, бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш тохиосон бодит үйл явдалтай холбох боломжтой бол, жишээ нь нөгөө талын төлбөрийн чадвар сайжирсан бол нөөцийн сангийн дансыг залруулах замаар өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн алдагдлыг буцааж тухайн жилийн орлого, зардалд бүртгэнэ.

Эргэн төлөгдөх боломжгүй болсон санхүүгийн хөрөнгийг данснаас хасахдаа хөрөнгийг нөхөн төлүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авах бөгөөд алдагдлын хэмжээ тодорхой



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
2024 .06 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -05- 17
БҮРТГЭВ-02



## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.3 Санхүүгийн хэрэглүүр (үргэлжлэл)

### 2.3.3 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

болсон үед холбогдох алдагдлын сангийн дансанд бүртгэн хасна. Өмнө нь данснаас хассан хөрөнгийн дүн дараа эргэн төлөгдсөн тохиолдолд нөхөн төлөгдсөн дүнгээр тухайн жилийн орлого, зардал дахь үнэ цэнийн бууралтын алдагдлын сангийн дансыг бууруулна.

***Санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлт:*** ББСБ нь санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд бүртгэлээс хасдаг. (а) хөрөнгийн төлбөрийг авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, (б) ББСБ хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ бусдад шилжүүлэн өгсөн эсхүл шаардлага хангасан дамжуулан өгөх хэлцэлд оролцсоны үр дүнд (1) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг үндсэнд нь шилжүүлсэн, (2) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийн эрхийг шилжүүлээгүй ч, өөртөө авч үлдээгүй буюу хяналтын эрхийг хадгалж үлдээгүй.

Нөгөө тал хөрөнгийг хараат бус гуравдагч этгээдэд ямар нэгэн хязгаарлалтгүйгээр бүхэлд нь борлуулах бодит боломжгүй байгаа нөхцөлд хяналтыг авч үлдсэнд тооцно.

### 2.3.4 Санхүүгийн өр төлбөр

Дараа үед санхүүгийн өр төлбөрийг доорх нөхцөлөөс бусад тохиолдолд хорогдуулсан өртгөөр ангилна. (i) бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн өр төлбөр: Энэ ангилал нь дериватив, арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн өр төлбөр (жишээ нь үнэт цаасны богино позиц), бизнесийн нэгдлийн үед худалдан авагчийн хүлээн зөвшөөрсөн болзошгүй төлбөр болон анхны хүлээн зөвшөөрөлтөөр тодорхойлсон бусад санхүүгийн өр төлбөрүүд болон (ii) санхүүгийн баталгааны гэрээ ба зээлд хамаарах үүрэг багтана.

Санхүүгийн өр төлбөрийг бүртгэлээс хасах: Санхүүгийн өр төлбөрийг хүчингүй болсон үед (жишээ нь гэрээнд заасан үүргээс чөлөөлөх, цуцалсан эсвэл хугацаа нь дууссан үед) бүртгэлээс хасна. ББСБ болон анхдагч зээлдүүлэгчийн хооронд хийсэн өрийн хэрэглүүрийг одоогийн санхүүгийн өр төлбөрийн нөхцөл, заалтыг их хэмжээгээр өөрчлөх үед анхны өр төлбөрийг хүчингүй болгож, шинэ санхүүгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

Хэрэв шинэ нөхцөлийн дагуу анхны үр ашигт хүүгийн түвшнийг ашиглан төлсөн төлбөр болон хүлээн авсан төлбөрийг хассан дүнгээр хямдруулсан өнөөгийн үнэ цэнэ нь анхны санхүүгийн өр төлбөрийн үлдэх мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээс 10%-иас багагүй байвал заалтыг их хэмжээгээр өөрчилсөн гэж үзнэ. Хэрэв өрийн хэрэглүүрийг солих буюу заалтын өөрчлөлтийг хүчингүй болсон гэж тооцвол гарсан аливаа зардал эсвэл төлбөрийг хүчингүй болгохтой холбоотой олз, гарзны нэг хэсэг байдлаар хүлээн зөвшөөрнө. Харин өрийн хэрэглүүрийг солих буюу заалтын өөрчлөлтийг хүчингүй болсон гэж бүртгээгүй бол гарсан аливаа төлбөр, хураамжаар өр төлбөрийн дансны үнийг тохируулах ба өөрчлөгдсөн өр төлбөрийн үлдсэн хугацааны туршид хорогдуулна.

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн өр төлбөр. ББСБ нь тодорхой өр төлбөрийн бодит үнэ цэнийг анх ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч болно. Ийм өр төлбөрийн олз ба гарзыг өр төлбөрийн зээлийн эрсдэлийн (зах зээлийн эрсдэлийг бий болгодог зах зээлийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлтөд үл хамаарах дүнгээр тодорхойлогддог) өөрчлөлтөд харгалзах бодит үнэ цэнийн өөрчлөлт буюу энэ нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдсэн ба дараа нь ашиг, алдагдалд дахин ангилагдахгүй дүнгээс бусад тохиолдолд ашиг, алдагдалд тусгана. Ийм толилуулга нь нягтлан бодох бүртгэлийн уялдааг бий болгодоггүй бөгөөд энэ тохиолдолд зөрүүг зээлийн эрсдэлийн өөрчлөлтөд хамаарах олз ба гарзыг ашиг, алдагдлын хэсэгт толилуулна.

Бусад банкнуудын байршуулсан хөрөнгө – Бусад банкнуудын байршуулсан хөрөнгийг харилцагч банк ББСБ руу мөнгө буюу бусад төрлийн хөрөнгө шилжүүлсэн үед хүлээн зөвшөөрнө. Дериватив бус өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр бүртгэдэг.

УЛААНБААТАР ХОТ
ОЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
СЭНДЛИ ББСБ ХК

СЗХ 2024.06.10 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.3 Санхүүгийн хэрэглүүр (үргэлжлэл)

### 2.3.4 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

Харилцагчдын харилцах, хадгаламж - Харилцагчдын харилцах, хадгаламжууд нь хувь хүмүүс, улсын болон хувийн эзэмшлийн аж ахуйн нэгж, байгууллагад төлөх дериватив бус өр төлбөр бөгөөд хорогдуулсан өртгөөр бүртгэгддэг.

Бусад зээлийн эх үүсвэр – Бусад зээлийн эх үүсвэрт Монгол Улсын Засгийн газар болон гадаадын санхүүгийн байгууллагаас авсан зээлүүд багтана. Эдгээр санхүүгийн өр төлбөрүүдийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэдэг.

Хоёрдогч өглөг - Хоёрдогч өглөгийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэдэг.

Бусад өглөг - Бусад өглөгийг нөгөө тал гэрээнд заасан үүргээ биелүүлсэн үед хуримтлуулан тооцож хорогдуулсан өртгөөр тусгана.

### 2.4 Гадаад валютын хөрвүүлэлт

Мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлант хугацааны эцсийн өдрийн Монголбанкны албан ханшаар хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ болон гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлант хугацааны эцсийн өдрийн Монголбанкны албан ханш руу хөрвүүлснээс үүсэх ханшийн олз, гарзыг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Түүхэн өртгөөр бүртгэдэг мөнгөн бус гүйлгээнүүдийг тайлант жилийн хаалтын ханшаар хөрвүүлж бүртгэхгүй.

Бодит үнэ цэнэ нь гадаад валютаар илэрхийлэгддэг мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрүүдийг (үүнд үнэт цаасны хөрөнгө оруулалт орно) бодит үнэ цэнэ тооцогдсон өдрийн ханшийг ашиглан хөрвүүлнэ. Гадаад валютын ханшийн зөрүүгээс гарсан өөрчлөлт нь бодит үнэ цэнийн олз, гарзад бүртгэгддэг.

Эдгээр санхүүгийн тайланг бэлтгэхэд ашиглагдсан валютын ханшийг доорх хүснэгтэд үзүүлэв:

| 1 төгрөгтэй харьцах: | 2023.12.31 | 2022.12.31 |
|---|---|---|
| *Ам.доллар* | 3,410.69 | 3,444.60 |
| *Евро* | 3,791.66 | 3,669.02 |
| *Фунт* | 4,372.16 | 4,156.60 |
| *Юань* | 480.01 | 495.40 |
| *Рубль* | 37.67 | 48.85 |

### 2.5 Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд тодорхой хэмжээний мөнгө рүү түргэн хөрвөх боломжтой, үнэ цэнээ алдах эрсдэл багатай зүйлс хамаарна. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд хадгаламжууд, Монголбанк ба Засгийн газрын үнэт цаас, мөн бусад Банкнуудад 3-аас доош сарын анхны хугацаатай байршуулсан бүх мөнгөн хөрөнгө орно. Ашиглалтад нь анх гурван сараас дээш хугацаагаар хязгаарлалт хийсэн эх үүсвэрийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд оруулахгүй. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг хорогдуулсан өртгөөр бүртгэдэг ба энэ нь: (i) гэрээнд заасан мөнгөн гүйлгээг цуглуулах зорилгоор эзэмшдэг бөгөөд эдгээр мөнгөн гүйлгээ нь хүү болон үндсэн төлөлт байх ба (ii) ашиг, алдагдалд бодит үнэ цэнийг нь хүлээн зөвшөөрөхгүй үед бүртгэнэ. Зарим улсын батлан даалтын хууль тогтоомж гэх мэт зөвхөн хуулиар баталгаажуулсан онцлог шинжүүд нь хууль тогтоомж өөрчлөгдсөн ч гэсэн уг онцлог шинж чанарыг хэрэглэж болох тул гэрээний нөхцөлд оруулахаас гадна ЗХҮТ-ийн тестэд нөлөөлөхгүй.

УЛААНБААТАР ХОТ ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ 2024 он 06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.5 Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайланд тусгасан төлбөрт ББСБ шилжүүлсэн бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө орох ба үүнд ББСБ харилцагч талуудын байршуулсан харилцах дансанд оруулсан болон гаргасан үндсэн зээл болон хүүгийн орлого, зарлага зэргийг багтаасан. Учир нь харилцагчдад олгосон зээл нь харилцагчийн хувьд бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг төлөөлөх учир ийнхүү оруулсан.

### 2.6 Бусад банкнуудад байршуулсан хөрөнгө

Бусад Банкнуудад байршуулсан хөрөнгийг банк бус санхүүгийн байгууллага харилцагч банк руу арилжааны бус зорилгоор мөнгө шилжүүлснээр хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй, дериватив бус, тодорхой буюу тодорхойлох боломжтой хугацаанд эргүүлэн төлөгдөх авлага үүсэх үед хүлээн зөвшөөрнө. Бусад банкнуудад байршуулсан хөрөнгийг дараах тохиолдолд хорогдуулсан өртгөөр бүртгэнэ: (i) гэрээнд заасан мөнгөн гүйлгээг цуглуулах зорилгоор эзэмшдэг бөгөөд эдгээр мөнгөн гүйлгээ нь ЗХҮТ байх ба (ii) ашиг, алдагдалд бодит үнэ цэнийг нь хүлээн зөвшөөрөхгүй үед бүртгэнэ.

### 2.7 Харилцагчид олгосон зээл ба урьдчилгаа

Харилцагчдад олгосон зээлийг банк бус санхүүгийн байгууллага нь харилцагчдаасаа хөрөнгийн зах зээл дээр бүртгэгдээгүй, дериватив бус, тодорхой буюу тодорхойлох боломжтой хугацаанд эргүүлэн төлөгдөх авлагыг худалдан авах буюу олгох зорилгоор мөнгө шилжүүлсэн үед мөн уг авлагаа арилжих зорилгогүй тохиолдолд хүлээн зөвшөөрнө. Харилцагчдад олгосон зээлийг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Бизнес загвар болон мөнгөн гүйлгээний шинж чанарт үндэслэн ББСБ харилцагчдад олгосон зээлийг дараах хэмжилтийн ангиллын аль нэгээр нь ангилна : (i) Хорогдуулсан өртгөөр: гэрээнд заасан мөнгөн гүйлгээг цуглуулах зорилгоор олгосон зээл бөгөөд эдгээр мөнгөн гүйлгээ нь ЗХҮТ байх ба сайн дураар бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөөгүй болон (ii) бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх: ЗХҮТ-ийн тест болон хорогдуулсан өртөг, бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх шалгуурыг хангаагүй тохиолдолд бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Үнэ цэнийн бууралтын санг ирээдүй рүү чиглэсэн хүлээгдэж буй зээлийн алдагдлын загварт үндэслэн тодорхойлдог. Хүлээгдэж буй зээлжих эрсдэлийн алдагдлын хэмжилтэд ашигласан өгөгдөл, таамаглал, тооцооллын аргачлал болон ББСБ зээлжих эрсдэлийн алдагдлын загварт ирээдүй рүү чиглэсэн мэдээллийг хэрхэн харуулсан талаар тайлбарыг тусгасан.

### 2.8 Урьдчилгаа төлбөр

Урьдчилгаа төлбөр нь мөнгөн хэлбэрээр төлөгдсөн боловч дараагийн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрөгдөх төлбөр, эсвэл хүлээн аваагүй хөрөнгийн төлбөрөөс бүрдэнэ. Урьдчилгаа төлбөрийг анх хөрөнгөөр бүртгэх ба төлөгдсөн мөнгөн дүнгээр нь хэмжинэ. Уг төлбөрийг тухайн зардал нь гарсан тохиолдолд ашиг, алдагдлаар, эсвэл хөрөнгийн өртөгт үл хүлээн зөвшөөрч бүртгэдэг. ББСБ урьдчилгаа төлбөрийн дансны үнэд үнэ цэнийн бууралт гарсан эсэхийг хянадаг.

### 2.9 Бараа материал

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар бүртгэнэ. Цэвэр боломжит үнэ цэнэ нь бизнесийн энгийн нөхцөлд барааг худалдахаар таамаглаж буй үнээс бараа гүйцээх болон худалдахтай холбоотойгоор гарах таамагласан зардлыг хассан дүн.

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 6183655 9021031198 СТС2420

СЭНДЛИ ББСБ ХК Sendly

СЗХ 2024.06.10 өдөр БҮРТГЭВ №01

2024-05-17 БҮРТГЭВ-02



## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.10 Үндсэн хөрөнгө

Бүх үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрдөг. Үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан дараа үеийн зардал нь тухайн хөрөнгийн анх тооцсон бүтээмжийн түвшинг нэмэгдүүлэх замаар ББСБ эдийн засгийн ирээдүйн өгөөжийг авчрах магадлалтай үед зардлын дүнгээр нь хөрөнгийн дансны үнийг нэмэгдүүлдэг (капиталжуулдаг).

Хүлээн зөвшөөрсний дараах үед үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр илэрхийлдэг. Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилтэнд барилга байгууламжийн хувьд дахин үнэлгээний загвар, барилгаас бусад хөрөнгийн хувьд өртгийн загварыг ашигладаг.

Хөрөнгө тус бүрийн өртгийг үлдэх өртөг хүртэл дараах ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар элэгдүүлдэг.

| | |
|---|---|
| Барилга, байгууламж | 40 жил |
| Түрээсийн сайжруулалт | Гэрээний ашиглалтын жил |
| Тээврийн хэрэгсэл | 10 жил |
| Тавилга, эд хогшил | 5-20 жил |
| Компьютер дагалдах хэрэгсэл | 2-13 жил |

Үндсэн хөрөнгийн дансны дүн, элэгдүүлэх хугацаа, арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрт хянаж үздэг.

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулсан, эсвэл түүнийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл үл хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Үндсэн хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого (хэрэв байгаа бол), дансны үнийн зөрүүг тайлант жилийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

### 2.11 Биет бус хөрөнгө

ББСБ-ын биет бус хөрөнгө нь ашиглах тодорхой хугацаатай бөгөөд үндсэндээ капиталжуулсан компьютерын програм хангамжийн лицензүүд юм. Худалдан авсан компьютерын програм хангамжийн лицензүүдийг тэдгээрийг худалдан авах үед үүсэх зардал болон ашиглахад бэлэн болгоход гарсан зардлын үндсэн дээр бүртгэдэг. Хэрэв эзэмшлийн бүх төрлийн програм хангамжийн урт хугацааны өгөөж нь зардлаас их байх нь тодорхой бол тухайн програм хангамжийг хөгжүүлсэнтэй холбоотой зардлыг биет бус хөрөнгө гэж бүртгэнэ. Капиталжуулах зардалд програмыг хөгжүүлсэн ажилчдын зардал болон хамаарах илүү цагийн зардлууд багтана. Компьютерын програм хангамжтай холбоотой бусад бүх зардлуудыг ашиг алдагдалд зардал гэж хүлээн зөвшөөрнө.

Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийг шулуун шугамын аргаар эдийн засгийн ашигтай хугацааны турш хорогдуулах ба үнэ цэнэ бууралтын шинж тэмдэг илэрсэн үед тухайн хөрөнгийн үнэ цэнэ бууралтыг үнэлнэ.

Энэхүү хорогдуулалтын аргачлалыг хамгийн багадаа жил бүрийн тайлант хугацааны эцэст хянаж үздэг. Биет бус хөрөнгийн төлөвлөсөн ашиглагдах хугацааг дараах байдлаар тогтоосон.

Програм хангамжийн лицензүүд – 3-20 жил

### 2.12 Түрээс

**ББСБ түрээслэгчийн хувьд түрээсийн нягтлан бодох бүртгэл.** ББСБ нь оффисын байр түрээсэлдэг. ББСБ нь түрээсийг ашиглах эрхтэй хөрөнгө болон түүнтэй холбоотой өр төлбөрийг уг түрээсэлж буй хөрөнгийг ашиглах эрх нь бий болсон өдрөөр хүлээн зөвшөөрнө. Түрээсийн төлбөр бүрийг өр төлбөр ба санхүүгийн зардлын хооронд хуваарилдаг. Санхүүгийн

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЙК 5183855 CTC2420

СЗХ
2024 он 06 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -05- 17
БҮРТГЭВ-02



## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.12 Түрээс (үргэлжлэл)

зардлыг түрээсийн хугацааны туршид ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг бөгөөд ингэснээр хугацаа тус бүрийн өр төлбөрийн үлдэгдэл дээр хүүгийн хугацааны турш дахь тогтмол хувийг бий болгоно.

Ашиглах эрхтэй хөрөнгийг өртгөөр хүлээн зөвшөөрөх ба ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны аль багаар нь шулуун шугамын аргаар хорогдуулна.

Түрээсийн өр төлбөрийг өнөөгийн үнэ цэнээр нь анх хэмжинэ. Түрээсийн өр төлбөр нь дараах түрээсийн төлбөрийн өнөөгийн цэвэр үнэ цэнийг агуулна:

- тогтмол төлбөрүүд (үг чанар нь тогтмол төлбөрүүд мөн орно), хасах нь аливаа түрээсийн урамшууллын авлага;
- индекс эсвэл хувь хэмжээнээс хамааралтай хувьсдаг түрээсийн хувьсах төлбөрүүд;
- баталгаат үлдэх өртгийн дагуу ББСБ-ын төлөхөөр тооцоолж буй дүн;
- худалдан авах сонголтын хэрэгжих үнэ (хэрэв ББСБ тухайн сонголтыг хийх нь тодорхой үндэслэлтэй бол); болон
- түрээсийн гэрээг цуцлахтай холбоотой торгуулийн төлбөрүүд (хэрэв түрээсийн нөхцөлд түрээсийг цуцлах сонголтыг хэрэгжүүлэхээр ББСБ тусгасан).

Түрээсийн төлбөрүүдийг нуугдмал хүүний түвшнээр хорогдуулах ба хэрэв тодорхойлох боломжгүй бол өсөн нэмэгдэх зээлийн хүүний түвшинг ашиглана. Энэ нь ББСБ эдийн засгийн ижил төстэй нөхцөл байдалд ашиглах эрхтэй хөрөнгөтэй ижил төстэй өөр хөрөнгийг худалдан авахад шаардлагатай санхүүжилтийг ижил төстэй нөхцөлөөр зээлэх үед төлөх зээлийн хүүгийн түвшинг хэлнэ.

Ашиглах эрхтэй хөрөнгийг дараах өртгөөр хэмжинэ:
- түрээсийн өр төлбөрийн анхны хэмжилтийн дүн
- түрээсийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх өдөр болон түүнээс өмнө төлсөн түрээсийн төлбөрүүд (хүлээн авсан аливаа урамшууллыг хассан дүнгээр)
- анхдагч шууд зардал
- нөхөн сэргээгдэх зардал.

Дээр дурдсанаас үл хамааран ББСБ богино хугацаатай түрээс болон бага үнэ цэнэтэй түрээсийн хөрөнгийн төлбөрийг шулуун шугамын аргаар хуваарилан үйл ажиллагааны зардалд бүртгэдэг.

ББСБ түрээсийн хугацааг тодорхойлохдоо Түрээсийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх өдрөөс сунгах эсвэл цуцлах өдөр хүртэл өөрчлөгдөхөөр таамаглагдаж байгаа бүх холбогдох баримт болон нөхцөл байдлыг харгалзан үзэж, ББСБ-нд түрээсийн гэрээг сунгах эсвэл цуцлахгүй байх нь өөрт эдийн засгийн ашигтай байх эсэхийг судална. Сунгах болон цуцлах хугацааны сонголтыг зөвхөн тодорхой үндэслэлтэйгээр хэрэгжүүлнэ гэсэн тохиолдолд түрээсийн хугацаанд оруулна.

Түрээслэгчийн хяналтанд байгаа аливаа чухал нөлөө бүхий үйл явдал эсвэл нөхцөл байдалд өөрчлөлт гарсан тохиолдолд дахин үнэлгээ хийнэ.

**ББСБ түрээслүүлэгчийн хувьд үйл ажиллагааны түрээсийн нягтлан бодох бүртгэл.** Хэрэв хөрөнгийг үйл ажиллагааны түрээсээр түрээслүүлсэн тохиолдолд түрээсийн авлагыг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар хуваарилан түрээсийн орлогоор бүртгэнэ.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2024 оны 05 сарын 10 өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.13 Болзошгүй өр төлбөр ба хөрөнгө

Аж ахуйн нэгжийн бүрэн хяналтаас гадуурх нэг болон түүнээс дээш ирээдүйн үйл явдал тохиолдох, эс тохиолдохоос хамаарч үүсэх эсэх нь тодорхойлогддог тул болзошгүй өр ба болзошгүй хөрөнгийг бүртгэдэггүй. Эдийн засгийн өгөөжийг агуулсан нөөцийн гадагш урсгал гарах магадлал маш бага биш л бол бүх тохиолдолд болзошгүй өр төлбөрийг санхүүгийн тайланд нэмж тодруулна. Харин эдийн засгийн өгөөж орж ирэх өндөр магадлалтай үед л болзошгүй хөрөнгийг санхүүгийн тайланд нэмж тодруулна.

### 2.14 Нөөц

Өр төлбөр ба зардлын нөөц/сан нь тодорхой бус хугацаа болон дүнгийн санхүүгийн бус өр төлбөр ба ББСБ нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн эрх зүйн хувьд эсвэл бодит үндэслэлтэй үүрэг хүлээсэн бөгөөд энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн үнэ цэнэ бүхий эх үүсвэрийг төлөх магадлалтай, мөн уг үүргийн дүнг баталгаатайгаар тооцоолох боломжтой үед эдгээр нөөц/санг хуримтлуулан байгуулна.

### 2.15 Хувьцаат капитал

Хувьцаат капитал нь ББСБ гаргасан энгийн хувьцааг илэрхийлэх бөгөөд хүлээн авсан дүнгээс хувьцаа гаргахтай холбоотой шууд зардлыг хассан цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

### 2.16 Ногдол ашиг

Ногдол ашгийг зарласан хугацаанд эзэмшигчдийн өмчид бүртгэнэ. Тайлант үеийн эцсээс хойш, гэхдээ санхүүгийн тайлангуудыг нийтлэхийг зөвшөөрөхөөс өмнө зарлагдсан ногдол ашгийг тайлант хугацааны дараах үйл явдлын тодруулгад оруулан толилуулдаг. Ногдол ашгийн хуваарилалтыг хуримтлагдсан ашгаас олгоно.

### 2.17 Орлого, зардал

Хүүгийн орлого, зардлыг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд бүх өрийн хэрэглүүр бүрийн хувьд аккруэль суурь дээр үндэслэн үр ашигт хүүгийн аргаар тооцоолон бүртгэнэ. Энэ аргын дагуу гэрээний талуудын хооронд төлөгдсөн эсвэл хүлээн авсан бүх хураамж, гүйлгээний зардал болон бүх үнийн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг үр ашигт хүүнд оруулан тооцож, цаг хугацааны хувьд хойшлуулан хүүгийн орлого эсвэл зардалд бүртгэдэг. Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэрэглүүрийн хүүгийн орлогыг нэрлэсэн хүүгээр тооцож орлого үр дүнгийн тайлангийн "Бусад ижил төстэй орлого" мөрөнд толилуулсан.

Үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болох хураамжид санхүүгийн хөрөнгийг худалдан авах эсвэл санхүүгийн өр төлбөрийг үүсгэхэд шууд холбоотойгоор нэмэгдэн гардаг, жишээлбэл төлбөрийн чадварыг үнэлэх, зээлийн баталгаа эсвэл барьцааг үнэлэх болон бүртгэх, хэрэглүүрийн нөхцөлүүдийг хэлэлцэх болон холбогдох баримт бичиг боловсруулах зэрэг гэрээ байгуулахтай холбоотой аливаа хураамжууд орно. ББСБ нь харилцагчид зээл олгосны дараах богино хугацаанд тухайн зээлийн худалдах магадлалтай тохиолдолд тухайн зээлийг зах зээлийн хүүгээр олгохтой холбоотой хураамж, шимтгэлийг үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болгон тооцно. Зээл олгохоор хүлээсэн үүргийг ББСБ ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдсэн санхүүгийн өр төлбөр гэж ангилдаггүй. Үүссэн болон зээлийн үнэ цэнэ бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүгийн түвшин нь хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг (үүнд анхны хүлээгдэж буй зээлийн алдагдал орно) анх бодит үнэ цэнээр нь (худалдан авах үнээр нь илэрхийлэгддэг) хүлээн зөвшөөрөхдөө хямдруулах хүү юм.

Хураамж, шимтгэлийн орлогыг харилцагч ББСБ-ын үйл ажиллагааны үр дүнд бий болсон үр өгөөжийг нэгэн зэрэг хүлээн авч, ашигладаг учраас үйлчилгээг үзүүлсэн үед нь шулуун шугамын аргаар цаг хугацааны туршид хүлээн зөвшөөрдөг. Хувьсах төлбөр хураамжийг

УЛААНБААТАР ХОТ
ЭРНСТ ЭНД ЯНГ
КАПИТАЛ
5183855
9021031195 СТС2420

СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024.05.10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024.05.17
БҮРТГЭВ-02



## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.17 Орлого, зардал (үргэлжлэл)

томоохон хэмжээний буцаалт байхгүй гэдгийг өндөр магадлалтайгаар удирдлага тодорхойлсон үед л хүлээн зөвшөөрдөг.

Бусад хураамж, шимтгэлийн орлого нь ихэвчлэн үндсэн ажил гүйлгээ гарсны дараа тодорхой нэг хугацаанд буюу ББСБ гүйцэтгэлийн үүргээ хангасан үед хүлээн зөвшөөрнө.

Хүлээн авсан хураамж, шимтгэл болон авлагын дүн нь гүйцэтгэлийн ялгаатай үүргүүд гэж тодорхойлсон үйлчилгээний хувьд гүйлгээний үнийг илэрхийлнэ. Ийм орлогод харилцагчийн нэрийн өмнөөс гадаад валют худалдах, худалдан авахад зориулсан хураамж, төлбөрийн гүйлгээ боловсруулах хураамж, бэлэн мөнгөний төлбөр тооцоо, цуглуулах, зарцуулах хураамж зэрэг багтана.

### 2.18 Ажиллагсдын зардал болон холбогдох шимтгэлүүд

Цалин, хөлс болон цалинтай холбоотой бусад зардлуудыг ажилтны хөдөлмөр эрхэлсэн тайлант хугацаанд нь зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Ээлжийн амралт, бусад богино хугацаат тэтгэмжийг олгохоор шийдвэрлэсэн үед нь зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд хуулийн дагуу заавал тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн даатгалын сангуудад шимтгэл төлдөг. Эдгээр даатгалын шимтгэлийг цалин, хөлсийг тооцсон үе бүрд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

### 2.19 Зээлийн зардал

Бэлтгэл шаардагдах хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил, эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай зээлийн өртгийг капиталжуулна. ББСБ бусад зээлийн өртгийг гарсан зээлийн өртгийг гарсан тайлант үед нь зардал гэж хүлээн зөвшөөрнө. Бэлтгэл шаардагдах хөрөнгө гэдэг нь түүнийг зориулалтаар нь ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгоход их хэмжээний хугацаа зарцуулдаг хөрөнгийг хэлэх ба уг хөрөнгийг ашиглах ба борлуулахад бэлэн болох хүртэлх хугацаанд хүүгийн зардлыг хөрөнгийн өртөгт оруулдаг.

### 2.20 Орлогын албан татвар

Орлогын татварын зардал нь тайлант жилийн татварын зардал, хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэнэ.

***Тайлант жилийн орлогын албан татвар:*** Тайлагналын өдрөөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" хууль (цаашид "татварын хууль" гэх)-ийн дагуу татвар ногдуулах орлого, төлбөл зохих орлогын албан татварын дүнг тооцоолсон. Татварын хуулийн болон СТОУС-ын үзэл баримтлалын ялгаатай байдлын улмаас татвар ногдуулах орлогын дүнг тодорхойлохдоо СТОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч бүртгэсэн зарим орлого, зардлын дүнг огт авч үздэггүй (тухайлбал, баримтаар нотлогдохгүй зардал), эсвэл уг хуульд заасан шаардлагын дагуу түр хойшлуулан авч үздэг (тухайлбал, мөнгөн зүйлсийг хаалтын ханшаар дахин үнэлснээс үүссэн ханшийн зөрүүний олз ба гарз).

***Хойшлогдсон татвар:*** Хойшлогдсон орлогын албан татварыг тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь, тэдгээрийн санхүүгийн бүртгэлийн дүн хоёрын хоорондын түр зөрүүний дүнгээс тайлан тэнцлийн аргыг хэрэглэн тооцдог. Бараг бүх (маш бага түр зөрүүнээс бусад) татвар ногдох болон хасагдах түр зөрүүнээс тайлагналын өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа татварын хуулиуд ба татварын хувиар хойшлогдсон татварын өр болон хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Түр зөрүүг арилсан үеийн татвар ногдуулах орлогыг тохируулах байдлаар үл хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлагналын өдөр бүр хянаж үздэг ба уг хөрөнгийг бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн ашиглахад хангалттай хэмжээний татвар ногдох орлого

УЛААНБААТАР ХОТ
ЭРНСТ ЭНД ЯНГ КО КАПИТАЛ ҮНЭ ХХК
5183855
2021031195 СТС2420



СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.20 Орлогын албан татвар (үргэлжлэл)

орж ирэх магадлал буурах үед дансны үнийг бууруулдаг. Үл хүлээн зөвшөөрсөн хойшлогдсон татварын хөрөнгийг тайлагналын өдөр бүр дахин үнэлж үздэг ба хойшлогдсон татварын хөрөнгийг ашиглах боломжтой орлого ирээдүйд орж ирэх магадлалтай үед хүлээн зөвшөөрдөг.

### 2.21 Холбоотой тал

ББСБ болон түүнтэй холбоотой этгээдүүдийн хооронд ажил үйлчилгээ эсвэл үүрэг хариуцлага шилжүүлэхдээ төлбөр нэхэмжилсэн эсэхээс үл хамааран тэдгээрийн хооронд хийгдсэн ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ гэнэ.
Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд банктай холбоотой гэж үзнэ.

- ББСБ-ийг шууд эсвэл хамтран хянадаг
- ББСБ-ны үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг
- ББСБ-ны удирдах ажилтан

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, санхүүгийн тайлангийн өдрөөр тайлагнагдсан хөрөнгө, өр төлбөрийн дүн, болзошгүй хөрөнгө өр төлбөрийн тодруулга болон тайлант үед хүлээн зөвшөөрөгдсөн орлого, зардлын дүнд тус тус нөлөөлдөг. Ирээдүйд гарах бодит үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

## 3. Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, төсөөллүүд

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, санхүүгийн тайлангийн өдрөөр тайлагнагдсан хөрөнгө, өр төлбөрийн дүн, болзошгүй хөрөнгө өр төлбөрийн тодруулга болон тайлант үед хүлээн зөвшөөрөгдсөн орлого, зардлын дүнд тус тус нөлөөлдөг. Ирээдүйд гарах бодит үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

Тооцоолол, түүнийг хийхэд хэрэглэсэн таамаглал, төсөөллийг байнга хянадаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг өөрчлөлт хийгдсэн тайлант үе болон ирээдүйн тайлант үеүдэд тус тус тусгадаг.

### 3.1. Тасралтгүй үйл ажиллагаа

Компанийн удирдлагын зүгээс компанийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадварыг үнэлж үзсэн бөгөөд компани нь ойрын ирээдүйд бизнесээ тасралтгүй явуулж чадах хэмжээний нөөцтэй гэж дүгнэсэн. Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварын талаар эргэлзээ төрүүлж болох аливаа нэг материаллаг тодорхойгүй байдал байхгүй гэж компанийн удирдлага үзэж байна. Иймд санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэсэн.

### 3.2 Зээлийн эрсдэлийн сан

ББСБ нь СТОУС-ын дагуу үнэ цэнэ бууралтын сан байгуулахдаа Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Активыг ангилах, Эрсдэлийн сан байгуулах журмын дагуу байгуулдаг. Журмын дагуу ББСБ нь тоо хэмжээний хүчин зүйлсд хугацаа хэтэрсэн байдал (өөрөөр хэлбэл эргэн төлөлтийн хоцролт) гэх мэт хугацааны шинжтэй хүчин зүйлс хамаардаг.

СЗХ 2024 .09. 10 БҮРТГЭВ №1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024 .05. 17 БҮРТГЭВ-02



## 3. Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, төсөөллүүд (үргэлжлэл)

### 3.2 Зээлийн эрсдэлийн сан

Харилцагчид олгосон зээлийг хэвийн, хугацаа хэтэрсэн, мөн хэвийн бус гэж ангилдаг. Хэвийн бус зээл нь эргэлзээтэй, муу зээл болон чанаргүй зээл гэж дэд ангиллаар ангилагддаг. Ангилал бүрт тусгайлан тооцсон хувийн дагуу эрсдэлийн санг байгуулдаг.

Байгууллагын орлогын албан татварын хуулийн дагуу хэвийн зээл дээр байгуулагдсан үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан нь татвараас чөлөөлөгдөхгүй зардал гэж үздэг.

### 3.3 Санхүүгийн хөрөнгийн өөрчлөлт

Хэрэв санхүүгийн хөрөнгүүд гэрээгээр өөрчлөгдсөн үед (өөрөөр хэлбэл дахин тохиролцох гэх мэт) ББСБ нь уг өөрчлөлтийн ач холбогдлыг үнэлж, анхны хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх, уг хөрөнгийг шинээр бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрөх эсэхийг үнэлдэг. Энэхүү үнэлгээ нь нягтлан бодох бүртгэлийн холбогдох бодлогод тусгагдсан чанарын хүчин зүйлсэд үндэслэдэг. Тухайлбал, ББСБ нь үнэ цэнийн бууралттай дахин тохиролцсон зээлийг үл хүлээн зөвшөөрөх, шинээр хүлээн зөвшөөрөгдсөн зээлийг анхны хүлээн зөвшөөрөлтийн үед нь үнэ цэнийн бууралттай хэмээн тооцох эсэхийг шийддэг. Хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлт нь эрсдэл болон өгөөжөөс шалтгаална. Үүнд хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний (үүнд гэрээний мөнгөн гүйлгээ орохгүй) өөрчлөгдөх боломж, уг өөрчлөлтөөс үүдэх өөрчлөлт гэх зэрэг орно.

Удирдлага нь гэрээний өөрчлөлтийг харгалзан тухайн нөхцөл байдал бүрт оруулах өөрчлөлтийг үнэлдэг бөгөөд эдгээр зээлийн өөрчлөлтөөс үүсэх эрсдэл, өгөөж нь өөрчлөгдөөгүй гэж тодорхойлсон.Тиймээс бүх өөрчлөлтийг хийхдээ эдгээр зээлийг бүртгэлээс хасаагүй эсвэл үнэ цэнэ нь буурсан ангиллаас дахин ангилаагүй.

### 3.4 Түрээсийн хугацааны тодорхойлолт

ББСБ оффисын барилгыг гэрээний дагуу гуравдагч этгээдээс түрээслэдэг ба гэрээний хугацаа дуусахаас өмнөх дундажаар сарын дотор талууд өөрөөр тохиролцоогүй тохиолдолд түрээсийн гэрээг ижил нөхцөлөөр сунгасанд тооцдог. ББСБ түрээсийн хуацааг тодорхойлохдоо түрээсийн хугацааг цуцлахад гарч болзошгүй торгууль, түрээсийн сайжруулалт, нүүлгэн шилжүүлэх өртөг мөн уг түрээсийн байрны ББСБ-ын үйл ажиллагаан дахь ач холбогдол зэргийг харгалзан үздэг. Оффисын барилгуудыг түрээслэх хугацаа дундажаар 1-5 жилийн хугацаатай байдаг.

## 4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба толилуулгад орсон өөрчлөлтүүд

### 4.1 Тайлант жилд хэрэгжиж эхэлсэн шинэчлэгдсэн СТОУС болон шинэ тайлбарууд

Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан 2023 оны 1 сарын 1-нээс хэрэгжүүлэх дараах стандартууд байна. Үүнд:

УЛААНБААТАР ХОТ ... 5183855 9021031195 СТС2420

СЗХ 2024 оны 06 сарын 10 өдөр БҮРТГЭВ № 01

2024-05-17 БҮРТГЭВ-02



## 4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба толилуулгад орсон өөрчлөлтүүд (үргэлжлэл)

### 4.1 Тайлант жилд хэрэгжиж эхэлсэн шинэчлэгдсэн СТОУС болон шинэ тайлбарууд (үргэлжлэл)

| Хэрэгжих хугацаа | Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд |
|---|---|
| 2023 оны 1 сарын 1 | СТОУС 17 Даатгалын гэрээ, нэмэлт өөрчлөлтүүд<br>НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт Эргэлтийн ба Эргэлтийн бус өр төлбөрийн ангилал, дагаж мөрдөх хугацааг хойшлуулах<br>СТОУС 17 ба СТОУС 9-ийн анхны хэрэглээ - Харьцуулсан мэдээлэл<br>НББОУС 1 ба СТОУС-ын практик мэдэгдэл 2-д оруулсан нэмэлт өөрчлөлт Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулга<br>НББОУС 8-ийн нэмэлт өөрчлөлт Нягтлан бодох бүртгэлийн тооцооны тодорхойлолт<br>Нэг удаагийн гүйлгээний үр дүнд бий болсон хөрөнгө, өр төлбөртэй холбоотой хойшлогдсон татвар |

### 4.2 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй СТОУС-ууд

Шинээр батлагдаж, хэвлэн нийтлэгдсэн боловч хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх хугацаа нь хараахан болоогүй байгаа стандарт болон стандартуудын нэмэлт өөрчлөлтүүдийг доор жагсаасан бөгөөд шинэ стандарт, нэмэлт өөрчлөлт болон тайлбарууд нь ирэх тайлант жилүүдэд хүчин төгөлдөр үйлчилж эхлэх бөгөөд ББСБ эдгээрийг эрт хэрэгжүүлээгүй байна.

| Хэрэгжих хугацаа | Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд |
|---|---|
| Тодорхойгүй | СТОУС 10, НББОУС 28 Хөрөнгө оруулагч ба түүний хараат компани, хамтарсан компанийн хооронд худалдсан эсвэл хандивласан хөрөнгийн нэмэлт өөрчлөлт |

## 5. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайланд тусгасан мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дэлгэрэнгүйг доор үзүүлэв. Үүнд:

| *Төгрөгөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах /Монгол/ | 4,143,988,840.98 | 3,399,430,637.35 |
| Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах /Гадаад/ | 1,091,824,413.03 | 1,110,291,724.05 |
| Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж | 9,003,030,000.00 | 3,882,064,200.00 |
| | **14,238,843,254.00** | **8,391,786,561.40** |

### 5.1 Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах /Дотоод,Гадаад/

| *Төгрөгөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Голомт банкинд байршуулсан мөнгө | 87,936,511.95 | 68,779,281.01 |
| Хаан банкинд байршуулсан мөнгө | 814,506,839.10 | 1,468,004,818.98 |
| Хас банкинд байршуулсан мөнгө | 672,633,287.31 | |

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 2021031195 СТС2420

СЭНДЛИ ББСБ ХК УЛААНБААТАР ХОТ

## 5. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө (үргэлжлэл)

### 5.1. Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах /Дотоод,Гадаад/ (үргэлжлэл)

| *Төрөлөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| ХХБ банкинд байршуулсан мөнгө | 85,677,892.24 | 1,161,373,417.27 |
| Төрийн банкинд байршуулсан мөнгө | 164,476,280.80 | 131,948,842.29 |
| Капитрон банкинд байршуулсан мөнгө | 3,566,381.37 | 466,091,423.80 |
| Тээвэр хөгжлийн банкинд байршуулсан мөнгө | 2,149,542,357.47 | - |
| Дотоод бусад санхүүгийн байгууллага дахь | 165,649,290.74 | 103,232,854.00 |
| Гадаад банкинд байршуулсан мөнгө | 58,956,747.55 | 159,398,199.55 |
| Гадаад бусад санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө | 1,032,867,665.48 | 950,893,524.50 |
| | **5,235,813,254.01** | **4,509,722,361.40** |

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн 37 хувийг харилцах данс эзэмшиж байгаа бөгөөд харилцах дансны 79 хувийг монголд 21 хувийг гадаадад байршуулдаг байна. Монгол харилцахын 52 хувь буюу 2,149,542.6 мянган төгрөгийг Тээвэр хөгжлийн банкинд, 20 хувь буюу 814,506.8 мянган төгрөгийг Хаан банкинд, үлдсэн 28 хувийг бусад банкуудад байршуулсан байна. Гадаадад байршуулсан харилцах нь мөнгөн гүйвүүлгатай холбоотой байна.

### 5.2 Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж

| *Төрөлөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Тээвэр хөгжлийн банк дахь хадгаламж | 9,003,030,000.00 | - |
| Хаан банк дахь хадгаламж | - | 1,033,380,000.00 |
| Худалдаа хөгжлийн банк дахь хадгаламж | - | 2,848,684,200.00 |
| | **9,003,030,000.00** | **3,882,064,200.00** |

2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Тээвэр хөгжлийн банкинд 1 сарын хугацаатай 3 хадгаламжын дансуудад, 10.5% хүртэлх хувийн хүүтэй хадгаламж багтсан болно.

## 6. Харилцагчид олгосон зээл (цэвэр дүнгээр)

***Харилцагчдад олгосон зээл болон зээлийн хүүгийн үлдэгдэл ангилалаар:***

| *Төрөлөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Хэвийн зээл | 39,348,447,319.07 | 21,253,022,776.28 |
| Хугацаа хэтэрсэн зээл | 668,886,022.73 | 582,818,292.70 |
| Хэвийн бус зээл | 599,056,242.81 | 511,579,864.15 |
| Эргэлзээтэй зээл | 502,130,843.05 | 568,155,526.95 |
| Муу зээл | 1,213,919,019.99 | 223,202,641.51 |
| **Нийт зээл** | **42,332,439,447.65** | **23,138,779,101.59** |
| Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 3,745,521,983.76 | 1,473,141,177.88 |
| Хасах нь: Зээлийн эрсдэлийн сан | (1,649,724,960.32) | (664,316,299.65) |
| **Дансны цэвэр дүн** | **44,428,236,471.09** | **23,947,603,979.82** |

Банк бус санхүүгийн байгууллага нь тайлант оны эцэст нийт 20,637 зээлдэгчид 42,332,439.5 мянган төгрөгийн зээл олгосон байгаа бөгөөд үүний 93 хувийг "Хэвийн зээл, 2 хувийг

СЗХ 2024 оны 06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## 6. Харилцагчид олгосон зээл (цэвэр дүнгээр) (үргэлжлэл)

"Хугацаа хэтэрсэн зээл", 1 хувийг "Хэвийн бус зээл", 1 хувийг "Эргэлзээтэй зээл" үлдсэн 3 хувийг "Муу зээл" ээзлж байна.

***Зээлийн багцын ангилал:***

Банк бус санхүүгийн байгууллага нь Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 988 дугаар тогтоол "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах журам" -ын дагуу зээлийг ангилж, эрсдлийн сан байгуулсан байна. Тухайн журмын дагуу хугацааны хүчин зүйлд нь тулгуурладаг байна.

Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу зээлийн хугацаа 1-30 хоног хүртэлх "Хэвийн", 31-90 хоног хүртэлх "Хугацаа хэтэрсэн зээл", 91-180 хоног хүртэлх " Хэвийн бус зээл", 181-360 хоног хүртэлх "Эргэлзээтэй" болон 361-ээс дээш хоног үндсэн төлбөр, хүүгийн төлбөр төлөгдөөгүй бол "Муу зээл"-ээр тус тус ангилана. Мөн төлбөр хариуцагчийн төлбөрийн чадвар алдагдсан, дампуурсан үед барьцаанд тавьсан эд хөрөнгийн тухайн үеийн үнэлгээ нь активын үндсэн өр болон хүүгийн 75-аас доошгүй хувийг төлж барагдуулахад хангалттай тохиолдолд эргэлзээтэй ангилалд, хангалтгүй тохиолдолд муу ангилалд хугацаа харгалзахгүй ангилна.

***Зээлийн эрсдэлийн сангийн өөрчлөлт:***

Доорх хүснэгтэнд тайлант оны зээлийн эрсдэлийн сангийн өсөлт бууралтыг харууллаа.

| *Төгрөгөөр* | 2023 |
|---|---|
| Хэвийн зээл сан | - |
| Хугацаа хэтэрсэн зээл сан | 33,259,415.72 |
| Хэвийн бус зээл сан | 149,488,364.41 |
| Эргэлзээтэй зээл сан | 252,117,546.64 |
| Муу зээл сан | 1,214,859,633.56 |
| **Нийт** | **1,649,724,960.32** |

Банк бус санхүүгийн байгууллага нь Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 988 дугаар тогтоол "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах журам" -ын дагуу "Хэвийн" ангилалд байгаа зээлэнд эрсдлийн сан байгуулахгүй, "Анхаарал хандуулах" ангилалд 5 хувь, "Хэвийн бус" ангилалд 25 хувь, "Эргэлзээтэй" ангилалд 50 хувь болон "Муу" ангилалд 100 хувь эрсдлийн сан байгуулна гэж тус тус заасан байна.

## 7. Бусад санхүүгийн хөрөнгө

| *Төгрөгөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Байгууллагаас авах авлага | 2,306,497,719 | 792,911,762 |
| Санхүүгийн бус байгууллагаас авах авлага | 130,200 | - |
| Бусад авлага | 974,455,360 | 699,562,686 |
| | **3,281,083,280** | **1,492,474,449** |

Байгууллагаас авах авлагын 2,151,686.6 мянган төгрөг нь HIPAY-с авах мерчантын авлага, 41,788.1 мянган төгрөг нь мөнгөн гүйвүүлгын авлага, Бусад авлагын 875,000.00 мянган төгрөг нь Гялс төгрөг ХЗХ-д өгсөн холбоотой талын авлага байна.

УЛААНБААТАР ХОТ 5183855 9021031195 CTC2420

СЗХ 2024 он 06 сар 10 өдөр БҮРТГЭВ №01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE Үнэт цаасны танилцуулга 2024-05-17 БҮРТГЭВ-02

## 8. Бусад санхүүгийн бус хөрөнгө

| *Төрөлөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 2,504,152 | - |
| Бараа материал, үнэ бүхий зүйл | 75,389,171 | 36,175,173 |
| Бусад тооцоо | 862,082,022 | 634,832,035 |
| | **939,975,346** | **671,007,208** |

Хойшлогдсон татварын хөрөнгөд тусгагдсан 2,504,152 төгрөг нь 2023 оны 12 дугаар сарын 31 өдрөөр гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөөс 10,016,606.91 төгрөгний гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит бус алдагдлаас /татварын түвшин 25%/ тооцсон дүн юм.

### 8.1 Бусад тооцоо

| *Төрөлөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Урьдчилж төлсөн тооцоо | 819,226,092 | 634,832,035 |
| Урьдчилж төлсөн хүүгийн тооцоо | 42,815,931 | - |
| | **862,082,023** | **634,832,035** |

Урьдчилж төлсөн тооцоо дансны 8 хувь буюу 69,116.7 мянган төгрөг нь салбаруудын түрээсийн барьцааны урьдчилгаа төлбөр, 67 хувь буюу 552,178.9 мянган төгрөг нь англи гуйвуулга гүйлгээ явуулахтай холбоотой "Монремит Лимитед"-д урьдчилж төлсөн төлбөр болон 11 хувь буюу 93,978.8 мянган төгрөг нь андеррайтерт урьдчилж төлсөн зардал байна.

## 9. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүйг доор үзүүлэв. Үүнд:

| *Төрөлөөр* | Компьютер, техник хэрэгсэл | Эд хогшил | Түрээсийн хөрөнгө | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| **Анхны өртөг** | | | | |
| **Эхний үлдэгдэл** | 258,481,731 | 88,191,000 | - | 346,672,731 |
| Нэмэгдсэн | 71,936,670 | 61,178,163 | 204,753,174 | 337,868,006 |
| Хасагдсан (-) | (4,800,000) | (17,347,743) | (-) | (22,147,743) |
| **Эцсийн үлдэгдэл** | **325,618,401** | **132,021,420** | **204,753,174** | **662,392,995** |
| **Хуримтлагдсан элэгдэл** | | | | |
| Эхний үлдэгдэл | 151,114,014 | 11,270,670 | - | 162,384,684 |
| Байгуулсан элэгдэл | 103,721,446 | 7,342,265 | 113,751,763 | 224,815,474 |
| Хасагдсан (-) | (41,116) | (271,245) | (-) | (312,362) |
| **Эцсийн үлдэгдэл** | **254,794,344** | **18,341,690** | **113,751,763** | **386,887,797** |
| **Дансны үнэ** | | | | |
| **Эхний үлдэгдэл** | 107,367,718 | 76,920,330 | - | 184,288,047 |
| **Эцсийн үлдэгдэл** | **70,824,058** | **113,679,730** | **91,001,411** | **275,505,198** |

Ашиглах эрхтэй хөрөнгө нь үндсэн хөрөнгө үзүүлэлтийн "түрээсийн хөрөнгө"-ийн хэсэгт орж толилуулагдсан.

ББСБ нь салбарын оффисын зориулалтаар нийт 57 байршилд талбай түрээсэлдэг. Үүнээс 2025 онд гэрээ нь дуусгавар болох цаашид түрээслэх магадлалтай төв салбарыг санхүүгийн түрээсээр бүртгэхээр бүртгэлд тусгасан байна.

УЛААНБААТАР ХОТ 5183855 9021031195 СТС2420

СЗХ 2024.06.10 өдөр БҮРТГЭВ №01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

"СЭНДЛИ ББСБ" ХК-ийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

## 10. Биет бус хөрөнгө

| *Төгрөгөөр* | Програм хангамж | Нийт дүн |
|---|---|---|
| **Биет бус хөрөнгө /өртөг/** | | |
| Эхний үлдэгдэл | 224,197,500 | **224,197,500** |
| Худалдаж авсан | 335,307,500 | **335,307,500** |
| Хасагдуулсан | (143,307,500) | **(143,307,500)** |
| **Эцсийн үлдэгдэл** | **416,197,500** | **416,197,500** |
| **Хуримтлагдсан хорогдол** | | |
| Эхний үлдэгдэл | 20,078,278 | 20,078,278 |
| Байгуулсан хорогдол | 32,509,606 | 32,509,606 |
| **Эцсийн үлдэгдэл** | **52,587,884** | **52,587,884** |
| **Дансны үнэ** | | |
| **Эхний үлдэгдэл** | **204,119,222** | **204,119,222** |
| **Эцсийн үлдэгдэл** | **363,609,616** | **363,609,616** |

## 11. Банк, санхүүгийн байгууллага болон бусдаас татсан эх үүсвэр

| *Төгрөгөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| **ББСБ-аас гаргасан өрийн бичиг:** | | |
| 'ҮЦТХТ" ХХК авсан зээл | 8,500,000,000 | - |
| | **8,500,000,000** | - |
| **Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл:** | | |
| Капитрон банкнаас авсан зээл | 2,000,000,000 | 1,527,897,496 |
| Мони Маркет Фонд ХХК | - | 700,000,000 |
| Девелопинг энтерпренориал монголиа ББСБ | 500,000,000 | - |
| Repo зээлийн нөхцөлөөр/14 гэрээ/ | 3,450,000,000 | - |
| | **5,950,000,000** | **2,227,897,496** |
| **Итгэлцлийн үйлчилгээний өглөг:** | | |
| Байгууллагаас татсан итгэлцлийн өглөг | 1,000,000,000 | - |
| Иргэдээс татсан итгэлцлийн өглөг/MNT/ | 14,001,434,229 | 6,733,946,000 |
| Иргэдээс татсан итгэлцлийн өглөг/MNT/ | 4,489,534,171 | 3,702,945,000 |
| | **19,490,968,400** | **10,436,891,000** |
| Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | **1,674,084,857** | **699,929,255** |
| **Нийт** | **35,615,053,257** | **13,364,717,751** |

***Зээлийн гэрээний мэдээлэл:***

***"ҮЦТХТ" ХХК авсан зээл:*** Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв болон Сэндли ББСБ ХК-ийн 2023 оны 01 сарын 20 өдөр "ҮНЭТ ЦААСНЫ ХАДГАЛАМЖИЙН БОЛОН ҮНЭТ ЦААСТАЙ ХОЛБОГДОЛТОЙ ТӨЛБӨР ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ"-нд нэгж бүр 100,000 төгрөгний нэрлэсэн үнэтэй, 85,000 ширхэг бондыг 8,500,000,000 төгрөгний үнийн дүнгээр, 18 сарын хугацаатай, жилийн 19.2% хүүгийн түвшинтэй, улирал тутамд хүүг төлөх нөхцөлтэйгээр үнэт цаасны гэрээ байгуулсан.

УЛААНБААТАР ХОТ ... КАПИТАЛ ҮЦК ... 5183855 9021031195 CTC2420

## 11. Банк, санхүүгийн байгууллага болон бусдаас татсан эх үүсвэр (үргэлжлэл)

***Капитрон банкнаас авсан зээл:*** Капитрон банк болон Сэндли ББСБ ХХК хооронд 2023 оны 12 сар 27 өдөр 2,000,000,000 төгрөгийг, жилийн 21.6% хүүтэй, 1 жилийн хугацаатай зээлийн гэрээ байгуулсан.

***Репо нөхцөлтэй зээл:*** 2023 оны турш нийт 98 удаагийн гэрээгээр 22,100,000,000 төгрөгийг 14, 28, 84 хоногийн хугацаатайгаар, 15,5%-20.0% хүүгийн түвшинтэйгээр зээлсэн. 2023 оны 12 сарын 31 өдрийн байдлаар 14 зээлийн гэрээний 3,450,000,000 төгрөгний зээлийн үлдэгдэлтэй байна.

## 12. Бусад өр төлбөр

| *Төгрөгөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| **Бусад санхүүгийн өр төлбөр** | | |
| Санхүүгийн түрээсийн өр төлбөр | 106,754,623 | - |
| | **106,754,623** | - |
| **Бусад санхүүгийн бус өр төлбөр** | | |
| Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын өглөг | 716,222,334 | 100,761,149 |
| Бусад татварын өглөг | 50,454,340 | - |
| Бусад өглөг | 146,025,629 | - |
| Шимтгэлийн өглөг | 11,118,232 | - |
| Хойшлогдсон татварын өглөг | 27,912,808 | - |
| | **951,733,344** | **100,761,149** |

Хойшлогдсон татварын өглөгт тусгагдсан 27,912.8 мянган төгрөг нь гадаад валютаар илэрхийлэгдсэн 2022 оны 1,075,000 ам.доллар, 2023 оны 2,195,900 ам.долларын Репо зээлийн үлдэгдэлд үүссэн 111,651.2 мянган төгрөгний гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит бус ашгаас /татварын түвшин 25%/ тооцсон дүн юм.

## 13. Өөрийн хөрөнгө

### 13.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө

2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх хувьцаа эзэмшигчдийн энгийн хувьцааны тоо болон хувьцаат капиталыг дор харуулав:

| | Энгийн хувьцаа | |
|---|---|---|
| *Төгрөгөөр* | 2023 | 2022 |
| "Монголын Финтек Групп" Хаалттай ХК | 6,304,674,000.00 | 6,304,674,000.00 |
| Олон нийт | 3,275,300,500.00 | 3,275,300,500.00 |
| "Сэндли Эмплойе" ХХК | 994,886,500.00 | 994,886,500.00 |
| Компанийн ажилчид | 514,211,000.00 | 514,211,000.00 |
| "Радикс Технологи" ХХК | 89,428,000.00 | 89,428,000.00 |
| | **11,178,500,000** | **11,178,500,000** |

СЗХ 2024.06.10 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

"СЭНДЛИ ББСБ" ХК-ийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 13.2 Бусад өөрийн хөрөнгө

| Төрөлөөр | 2023 | 2022 |
|---|---|---|
| Нийгмийн хөгжлийн сан | 15,105,992 | 14,716,810 |
| | 15,105,992 | 14,716,810 |

### 14. Хүүгийн орлого

| Төрөлөөр | 2023 | 2022 |
|---|---|---|
| Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого | 14,110,419,013 | 2,378,317,188 |
| Хугацаа хэтэрсэн хүүгийн орлого | 775,695,326 | 1,437,706,618 |
| Харилцах дансны хүүгийн орлого | 16,108,077 | - |
| Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого | 124,433 | - |
| Үнэт цаасны хүүгийн орлого | - | 9,066,641 |
| | **14,902,346,849** | **3,825,090,446** |

### 15. Хүүгийн зардал

| Төрөлөөр | 2023 | 2022 |
|---|---|---|
| Өрийн бичгийн хүүгийн зардал | 1,502,334,247 | - |
| Банк, бусад санхүүгийн байгууллагын хүүгийн зардал | 420,071,971 | 530,699,643 |
| Санхүүгийн түрээсийн хөрөнгийн хүүгийн зардал | 29,617,537 | - |
| | **1,952,023,755** | **530,699,643** |

### 16. Арилжааны цэвэр орлого

| Төрөлөөр | 2023 | 2022 |
|---|---|---|
| Гадаад валютын арилжаанаас олсон орлого | 237,087,464 | 203,887,138 |
| Гадаад валютын арилжаанаас хүлээсэн зардал | (69,250,140) | (29,178,360) |
| | **167,837,324** | **174,708,778** |

### 17. Ханш, үнэлгээний цэвэр орлого

| Төрөлөөр | 2023 | 2022 |
|---|---|---|
| Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн олсон орлого | 1,247,453,841 | 1,695,144,559 |
| Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал | (1,055,018,972) | (1,422,839,114) |

СЭНДЛИ ББСБ ХХК УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ОДЗИЙ ЭНД КО КАПИТАЛ АУДИТ 5183855 0210311195 СТС2420

СЗХ 2024.05.10 өдөр БҮРТГЭВ №1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

"СЭНДЛИ ББСБ" ХК-ийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

## 18. Валютын арилжаа болон ханш, үнэлгээний орлогын бодит хэрэгжилт

| *Төгрөгөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Арилжааны цэвэр орлого | 167,837,324 | 174,708,778 |
| Ханш, үнэлгээний цэвэр орлого | 192,434,868 | 272,305,445 |
| | **360,272,192** | **447,014,223** |
| Гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит бус орлого | (100,068,589) | - |
| | **260,203,603** | **447,014,223** |

## 19. Хураамж, шимтгэлийн цэвэр орлого

| *Төгрөгөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Мөнгөн гүйвуулгын орлого | 544,060,228 | 314,704,897 |
| Үйлч.шимтгэлийн орлого /Хэрэглээний зээл/ | 10,521,666 | 27,629,239 |
| Үйлч.шимтгэлийн орлого /Шуурхай бичил зээл/ | 4,436,513,921 | 5,161,929,415 |
| Үйлч.шимтгэлийн орлого /Шугамын зээл/ | 250,000 | - |
| | **4,991,345,816** | **5,504,263,553** |

## 20. Үйл ажиллагааны бусад зардал

| *Төгрөгөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Ажилтнуудтай холбоотой зардал | 2,871,505,850 | 1,639,252,151 |
| Үнэт цаас болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбоотой гарсан зардал | 189,849,333 | 10,173,427 |
| Зээл болон бусад авлагыг барагдуулахтай холбоотой зардал | 18,589,425 | 100,000 |
| Итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбогдон гарсан зардал | 3,485,368,950 | 943,921,123 |
| Мэргэжлийн үйлчилгээний хураамж | 820,923,822 | 440,456,100 |
| Даатгалын зардал | 956,968 | - |
| Зарлал, сурталчилгаа, маркетингийн зардал | 464,178,413 | 511,017,695 |
| Элэгдэл, хорогдлын зардал | 210,785,836 | 123,164,889 |
| Түрээсийн зардал | 165,822,309 | 197,267,115 |
| Ашиглалтын зардал | 24,370,943 | 13,795,111 |
| Харилцагчдын сургалт судалгааны зардал | 14,787,227 | 8,872,006 |
| Програм хангамж, автоматжуулалтын урсгалзардал | 61,152,976 | 49,393,471 |
| Бичиг хэргийн зардал | 17,718,489 | 21,451,528 |
| Харуул, хамгаалалтын зардал | 6,887,500 | 5,921,000 |
| Харилцаа холбооны зардал | 60,790,687 | 43,111,087 |
| Түлш шатахуун, тээврийн зардал | 56,002,532 | 23,390,734 |
| Хөдөлмөр хамгаалал, галын аюулаас хамгаалах зардал | 37,253,430 | 16,288,191 |
| Ариун цэврийн зардал | 44,829,414 | 21,220,695 |
| Зохицуулалт хураамжийн зардал | 2,880,000 | 4,100,000 |
| Үйл ажиллагааны бусад зардал | 2,008,055,415 | 1,437,902,671 |
| | **10,561,752,551** | **5,511,755,962** |



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК 5183855 9021031195 CTC2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

СЗХ 2024.06.10 БҮРТГЭВ №01



## 20. Үйл ажиллагааны бусад зардал (үргэлжлэл)

Ажилчдын зардал дараахаас бүрдэнэ. Үүнд:

| *Төгрөгөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Цалин хөлс, урамшуулал | 2,385,643,666 | 1,343,041,236 |
| Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл | 298,066,747 | 169,538,155 |
| Ажилчдын тэтгэмж | 3,166,817 | 3,337,744 |
| Ажилдад олгосон нөхөн олговор | 27,670,541 | 1,500,000 |
| Албан томилолт | 122,098,421 | 84,278,149 |
| Сургалтын зардал | 26,191,257 | 15,760,439 |
| Бусад зардал | 8,668,400 | 21,796,427 |
| | **2,871,505,850** | **1,639,252,151** |

## 21. Орлогын татварын зардал

### 21.1 Орлогын албан татварын зардлын бүрэлдэхүүн

Тайлант жилийн орлого, зарлагад бүртгэсэн орлогын албан татварын зардлыг доор үзүүлэв:

| *Төгрөгөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Тайлант жилийн орлогын албан татвар | 795,391,131 | 340,530,580 |
| Хойшлогдсон татварын зардал | 30,808,469 | - |
| | **826,199,600** | 340,530,580 |

### 21.2 Татварын зардал ба ашиг, алдагдал хоорондын холбогдох татварын хэмжээгээр тооцсон тохируулга

Банк бус санхүүгийн байгууллага нь татварын өмнөх ашгийг татвар ногдохгүй орлого болон татвараас хасагдахгүй зардлаар тохируулга хийх замаар орлогын албан татварын зардлыг тодорхойлдог. Банк бус санхүүгийн байгууллага ААНОАТ-ын тухай хуулийн дагуу 6 тэрбум төгрөг хүртэлх татвар ногдох орлогоос 10 хувийн, 6 тэрбум төгрөгөөс давсан дүнгээс 25 хувийн орлогын албан татвар төлдөг.

Тайлант жилийн татварын дүнг санхүүгийн тайлангаарх цэвэр ашгаас тооцсон тохируулга:

| *Төгрөгөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| **Санхүүгийн тайлангаарх татварын өмнөх цэвэр ашиг** | **6,881,633,483** | **3,404,816,592** |
| *Түр зөрүү:* | | |
| Валютын ханшийн зөрүүгийн бодит бус ашиг, алдагдал | (100,068,590) | - |
| **Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдох орлогын дүн** | **6,781,564,525** | **3,404,816,592** |

**Тайлант жилээс валютын ханшийн бодит бус ашиг алдагдлын зөрүүний нөлөөллөөс уг зөрүүгийн нөлөөллийг тооцож Санхүү болон татварын зорилгоор хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр хүлээн зөвшөөрч бүртгэсэн.**

СЭНДЛИ ББСБ ХК

УЛААНБААТАР ХОТ ЭРНСТ ЭНД ЯНГ КО ХАРИЛЦАА ХХК 5183855

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

СЗХ
2024 он 06 сар 10 өдөр
БҮРТГЭВ

"СЭНДЛИ ББСБ" ХК-ийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

## 22. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ ба үлдэгдэл

Эдгээр санхүүгийн тайлангийн зорилгоор талууд нь НББОУС 24 буюу "Холбоотой талын тодруулга"-д тодорхойлсноор хэрвээ тухайн ББСБ нь нөгөө этгээдийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол холбоотой талууд гэж тодорхойлно. Холбоотой талуудын магадлалд хамаарлыг авч үзэхдээ хуулийн хэлбэрээс илүү эдийн засгийн холбоо хамаарлыг авч үздэг.

Бизнесийн ердийн үйл ажиллагааны явцад ББСБ нь хувьцаа эзэмшигчид, тэргүүлэх удирдлагын бүрэлдэхүүн болон бусад холбоотой талуудтай ажил гүйлгээ явуулдаг. Эдгээр ажил гүйлгээнүүдэд төлбөр тооцоо, зээл олгох, хадгаламж татан төвлөрүүлэх, арилжаа, гадаад валютын гүйлгээ зэрэг багтана. ББСБ-ын бодлогын дагуу холбоотой талуудын ажил

Холбоотой талуудыг доорх байдлаар ангилна:

| Холбоотой талуудын нэр | Холбоо хамаарал |
|---|---|
| Монгол Финтек Групп ХХК | Толгой компани |
| Хайпэймэнт Солюшнс ХХК | Зэргэлдээ компани |
| Хөүм Моргейж ХХК | Зэргэлдээ компани |
| Дижитал Вендин ХХК | Зэргэлдээ компани |
| Датапүүл ХХК | Зэргэлдээ компани |
| Мони Маркет Фанд ХХК | Зэргэлдээ компани |

### 22.1 Холбоотой талуудын үлдэгдэл

Холбоотой талуудын авлагын үлдэгдлийг доор харуулав:

| *Төрөгөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Мони Маркет Фанд ХХК | 348,795,616 | - |
| Хайпэймэнт Солюшнс ХХК | 384,917,187 | - |
| Хөүм Моргейж ХХК | 265,246,444 | - |
| Дижитал Вендин ХХК | 166,481,644 | - |
| Датапүүл ХХК | 101,802,740 | - |
| | **1,267,243,630** | **-** |

Холбоотой талуудад өглөгийн үлдэгдлийг доор харуулав:

| *Төрөгөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Хайпэймэнт Солюшнс ХХК | 60,463,524 | 178,000,000 |
| | **60,463,524** | **178,000,000** |

### 22.2 Холбоотой талуудын хоорондын ажил гүйлгээ

Холбоотой талуудад олгосон зээлийг доор харуулав:

| *Төрөгөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Мони Маркет Фанд ХХК | 2,374,000,000 | - |
| Хайпэймэнт Солюшнс ХХК | 1,150,000,000 | - |
| Хөүм Моргейж ХХК | 650,000,000 | - |
| Дижитал Вендин ХХК | 450,000,000 | - |
| Датапүүл ХХК | 250,000,000 | - |
| | **4,874,000,000** | |

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК
5163855
СТС2420

СЗХ
2024 . 06 . 10
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

"СЭНДЛИ ББСБ" ХК-ийн 2023 оны 12 сарын 31-нийн өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

## 22. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ ба үлдэгдэл (үргэлжлэл)

### 22.2 Холбоотой талуудын хоорондын ажил гүйлгээ (үргэлжлэл)

Холбоотой талуудын олгосон зээлээс төлсөн гүйлгээг доор харуулав:

| *Төрөлөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Мони Маркет Фанд ХХК | 200,000,000 | - |
| Хайпэймэнт Солюшнс ХХК | 138,302,573 | - |
| Хөүм Моргейж ХХК | 100,000,000 | - |
| Дижитал Вендин ХХК | 100,000,000 | - |
| Датапүүл ХХК | 100,000,000 | - |
| | **638,302,573** | **-** |

Холбоотой талуудад борлуулсан ажил гүйлгээг доор харуулав:

| *Төрөлөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Мони Маркет Фанд ХХК | 323,704,110 | - |
| Хайпэймэнт Солюшнс ХХК | 476,328,510 | - |
| Хөүм Моргейж ХХК | 265,160,548 | - |
| Дижитал Вендин ХХК | 161,704,110 | - |
| Датапүүл ХХК | 89,704,110 | - |
| | **1,316,601,387** | **-** |

Холбоотой талуудад борлуулалтаас төлсөн гүйлгээг доор харуулав:

| *Төрөлөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Хайпэймэнт Солюшнс ХХК | 187,350,397 | - |
| Дижитал Вендин ХХК | 17,000,000 | - |
| | **204,350,397** | **-** |

Холбоотой талуудаас худалдан авсан ажил гүйлгээг доор харуулав:

| *Төрөлөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Мони Маркет Фанд ХХК | 126,010,700 | 58,710,000 |
| Хайпэймэнт Солюшнс ХХК | 1,608,415,516 | 1,265,409,931 |
| Стоклаб Секьюритиз ҮЦК ХХК | 73,430,576 | - |
| | **1,807,856,793** | **1,324,119,931** |

Холбоотой талуудаас худалдан авалтаас төлсөн ажил гүйлгээг доор харуулав:

| *Төрөлөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Мони Маркет Фанд ХХК | 126,010,700 | 58,710,000 |
| Хайпэймэнт Солюшнс ХХК | 1,547,951,992 | 1,265,409,931 |
| Стоклаб Секьюритиз ҮЦК ХХК | 73,430,576 | - |
| | **1,747,393,269** | **1,324,119,931** |



УЛААНБААТАР ХОТ
... КАПИТАЛ ҮЦК ХХК
9021031195 5183855 СТС2420

СЗХ 2024.06.10
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02



## 23. Санхүүгийн эрсдэлийн удирдлага

ББСБ үйл ажиллагааны салшгүй хэсэг бол эрсдэл юм. Эрсдэлийг байнгын илрүүлэлт, хэмжилт, хяналтын үйл явцуудаар дамжуулан удирддаг. ББСБ эрсдэлийн удирдлага нь санхүүгийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, комплаенсийн эрсдэл, каунтерпарти эрсдэл, гуравдагч талын эрсдэл, хуулийн эрсдэл, нэр хүндийн эрсдэл, технологийн эрсдэл болон бусад цаг үеийн шинж чанартай тулгарах эрсдэлүүдийг хамаардаг. Санхүүгийн эрсдэлд зах зээлийн эрсдэл (хүүгийн эрсдэл, гадаад валютын эрсдэл болон бусад зах зээлийн үнээс хамаарсан эрсдэл), зээлийн эрсдэлийн болон төлбөрийн чадварын эрсдэл багтдаг.

## 24. Орчуулга

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Монгол, Англи хэл дээр бэлтгэсэн бөгөөд хувилбаруудын хооронд утга, агуулгын зөрүү гарах тохиолдолд Монгол хэл дээр хувилбарыг баримтална.

## 25. Хураангуй товчлол

| Товчлол | Товчилсон үгсийн тайлбар |
|---|---|
| ААНОАТ | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар |
| ББСБ | Банк бус санхүүгийн байгууллага |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| БҮЦАА | Бодит үнэ цэнийн ашиг, алдагдал |
| БҮЦБДО | Бодит үнэ цэнийн бусад дэлгэрэнгүй орлого |
| ЗХҮТ | Зөвхөн хүү болон үндсэн төлбөр |
| НББОУС | Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |
| ХХК | Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани |

УЛААНБААТАР ХОТ Өлзий энд Ко Капитал аудит 5183855 СТС2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 05 17
БҮРТГЭВ-02

СЗХ
2024.06.10
БҮРТГЭВ

MDSKhanLex

**"СЭНДЛИ ББСБ" ХК-ИАС ӨРИЙН ХЭРЭГСЭЛ ГАРГАН НИЙТЭД САНАЛ БОЛГОХТОЙ ХОЛБОГДУУЛАН БЭЛТГЭСЭН**

**ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ**

| | |
|---|---|
| **ХААНА:** | **"СЭНДЛИ ББСБ" ХК** |
| **ХАЯГ:** | **МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 2-Р ХОРОО, 40, 50 МЯНГАТ /15171/, БАКУЛА РЕНБҮЧИ ГУДАМЖ, 8/4 ТООТ** |
| **УТАС/ФАКС:** | **(976) 70177700** |
| **ХААНААС:** | **"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН** |
| **ХАЯГ:** | **УЛААНБААТАР ХОТ, СҮХБААТАР ДҮҮРЭГ, СҮХБААТАРЫН ТАЛБАЙ 2 СЭНТРАЛ ТАУЭР, 13 ДАВХАР, 1301 ТООТ** |
| **УТАС/ФАКС:** | **(976-11) 330048, (976-11) 330049** |
| **ОГНОО:** | **2024 ОНЫ 04 САРЫН 30-НЫ ӨДӨР** |

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КАПИТАЛ ХЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

MDSKhanLex
Утас:
Факс:
Олон улс:
2024.04.30 № Б-24/103

"СЭНДЛИ ББСБ" ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
НАР ТАНАА

**"СЭНДЛИ ББСБ" ХК ӨРИЙН ХЭРЭГСЭЛ ГАРГАН НИЙТЭД САНАЛ БОЛГОХТОЙ ХОЛБОГДУУЛАН БЭЛТГЭСЭН ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ**

Тус "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь (цаашид "МДСХ" гэх) нь "Сэндли ББСБ" ХК (цаашид "**Компани**", эсхүл "**Үнэт цаас гаргагч**", эсхүл "**ББСБ**" гэх)-ийн өрийн хэрэгсэл гарган нийтэд санал болгохтой холбогдуулан бэлтгэсэн энэхүү хууль зүйн дүгнэлт (цаашид "**Дүгнэлт**" гэх)-ийг гаргаж байгаа болно. Энэхүү Дүгнэлт нь тухайлан зориулж гаргасан этгээдүүдээс бусад этгээдийн өмнө ямар нэгэн үүрэг хариуцлага бий болгохгүй. Дүгнэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэгдсэн бөгөөд энэ нь аливаа гуравдагч этгээдэд ашигтай байх, эсхүл давуу байдлыг бий болгох мэдээлэл, баталгаа өгөх зорилгогүй болно.

Энэхүү Дүгнэлтийг боловсруулахад ирүүлсэн бүрдүүлбэр материал, баримтуудад агуулагдсан дараах асуудлаар МДСХ нь хариуцлага хүлээхгүй ба Дүгнэлт гаргаагүй болно. Үүнд:

1. Дүгнэлт нь зөвхөн хууль зүйн асуудлаар хийгдсэн бөгөөд аливаа тоон мэдээлэл, хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ зэрэг тусгай мэргэжлийн хүрээний мэдээллүүдийн талаар бид нарийн мэдлэггүй, тэдгээрийн үнэн зөв байдлыг тогтоохгүй болно;
2. Дүгнэлтэд өөрөөр дурдсанаас бусад тохиолдолд бидний хийсэн ажил энэхүү Дүгнэлтийн тайлбар хэсгийн судалгаа шинжилгээний ажлын хүрээгээр хязгаарлагдаж байгаа болно;
3. Нотариатын гэрчилсэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн үйлдэл нь бодит эсэх;
4. Бусад улсын хууль тогтоомж буюу бусад эрх зүйн харьяаллын хүрээнд хийгдсэн, хуульд нийцсэн, хүчин төгөлдөр эсэх талаар;
5. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт "...санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна." гэж заасны дагуу санхүүгийн мэдээлэл, андеррайтерын судалгаа, дүгнэлт, таамаглал болон нийтэд илэрхий мэдээллийн талаар;
6. Дүгнэлтэд тусгайлан дурдсанаас бусад аливаа судалгаа, шинжилгээ, асуулга хийгдээгүй болно. Тийнхүү хийгдээгүй судалгаа, шинжилгээ, асуулгын үндэс болсон аливаа мэдээлэл, бүртгэл нь бүрэн биш, шинэчлэгдээгүй, жишээ нь, тухайн баримт бичиг нь холбогдох эрх бүхий байгууллагад бүртгэгдээгүй, хувийн хэргээс устсан, алга болсон, эсхүл бусад байдлаар хувийн хэрэгт байхгүй болсон байж болно;
7. Компанийн бүх баримт бичиг, гэрээ, төлөвлөгөө, харилцаа холбоо, зөвшөөрөл, хувийн хэрэгтэй танилцсан, тэдгээрийг судалсан гэх амлалтыг энэхүү Дүгнэлттэй холбоотой бид гаргахгүй болно;

СЗХ
он сар өдөр
2024.06.10
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

8. Дүгнэлт боловсруулах үед хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Монгол Улсын хуулийн хүрээнд хийгдсэн бөгөөд бид өөр бусад эрх зүйн тогтолцооны холбоо, хамаарал, нөлөөллийн талаар ямар нэгэн үзэл бодол илэрхийлээгүй болно.

МДСХ нь Дүгнэлтэд өөрөөр тусгаагүй бол Компанийн үйл ажиллагааны хүрээнд байгуулагдсан ач холбогдол бүхий гэрээ, их хэмжээ болон сонирхлын зөрчилтэй хэлцэл, Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5% ба түүнээс дээш үнийн дүн бүхий гэрээ, хэлцлүүд, дүрэм журмыг 2024 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөр тасалбар болгон хянасан бөгөөд энэхүү дүгнэлтэд тусгайлан дурдаагүйгээс бусад дүрэм, журам, байгуулагдсан гэрээг энэхүү Дүгнэлтэд оруулаагүй болно.

Мөн Компанийн зүгээс ач холбогдол бүхий баримт, мэдээллийг нуусан, орхигдуулсан, Дүгнэлт гаргах явцад танилцуулаагүй, буруу, дутуу танилцуулсан нөхцөлд үүсэх асуудлаар МДСХ хариуцлага хүлээхгүй.

"Өмгөөллийн Эм Ди эс энд Хаанлекс" ХХН нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.5.5 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 226 тоот тогтоолоор батлагдсан Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.4.3 дахь заалтад заасныг тус тус удирдлага болгон Үнэт цаас гаргагч "Сэндли ББСБ" ХК, үндсэн андеррайтер "Өлзий энд ко капитал ҮЦК" ХХК, туслах андеррайтер "Райнос инвестмент ҮЦК" ХХК, "Голомт капитал ҮЦК" ХХК, аудит "Хүлээгтхүнү Аудит" ХХК-тай аливаа сонирхлын зөрчилгүй болохоо үүгээр мэдэгдэж байна. Туслах андеррайтер "Райнос инвестмент ҮЦК" ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Цэвэгмид нь Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдон ажиллаж байгааг дурдах нь зүйтэй гэж үзэв.

Дор дурдсанаас бусад тохиолдолд бидний бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэхүү дүгнэлтийг ашиглах, иш татах, бусад баримт бичигт оруулан дурдах, бусдад хувилан хүргүүлэхийг хориглоно. Үүнд:

1. Хувьцаагаа анх удаа нийтэд санал болгон гаргахтай холбогдуулан "Сэндли ББСБ" ХК-ийн болон түүнтэй гэрээгээр ажиллаж буй нягтлан бодогч, хуульч болон мэргэжлийн зөвлөхүүд;
2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу та бүхний мэдээлэл, тайлан гаргаж хүргүүлэх ёстой төрийн болон өөрийгөө зохицуулах байгууллага.

Дүгнэлтийг дээрх хаягласан этгээдүүдэд хүргүүлсэн өдрөөс хойш хууль тогтоомжид өөрчлөлт орсон болон бусад үйл ажиллагаатай холбогдуулан бид нэмэлт хууль зүйн дүгнэлт хийх үүрэг хүлээхгүй болно.

Энэхүү албан бичиг нь Дүгнэлтийн салшгүй хэсэг байна.

Хүндэтгэсэн,

"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН-ИЙН

ГИШҮҮН, ХУУЛЬЧ

Д.ДҮГЭРЖАВ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2024 .06 ар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 51

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

**АГУУЛГА**

**Удиртгал** .......... 5

1. **Компани хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх, үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх** .......... 7

2. **Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, Эрх бүхий албан тушаалтнууд нь холбогдох хууль тогтоомж болон Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журам, Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын талаар мэдээлэл** .......... 11

3. **Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм, журмууд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, нийтэд санал болгон нэмж хувьцаа гаргаж буй үнэт цаас гаргагчийн хувьд түүний дотоод дүрэм, журмууд нь Хорооноос баталсан компанийн засаглалын кодекст нийцсэн эсэх** .......... 25

4. **Бусадтай байгуулсан худалдах худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн зэрэг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх** .......... 35

5. **Сүүлийн 3 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх** .......... 46

6. **Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх** 55

7. **Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх** .......... 58

8. **Үнэт цаас бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх** .......... 62

9. **Компанийн толгой, охин, хараат, хэрэгжүүлэгч компанийн талаарх мэдээлэлд үндэслэн Үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох** .......... 64

10. **Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эрүүгийн гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх** .......... 66

11. **Татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх** .......... 68



УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНКО КАПИТАЛ ҮЦК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2024 он 05 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

## Удиртгал

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН (цаашид **"МДСХ"**, эсхүл **"Бид"** гэх) нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид **"СЗХ"** гэх)-ны 2014 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 25 тоот тогтоолоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1 дэх хэсэгт заасныг Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр анх бүртгэгдсэн бөгөөд СЗХ-ны 2016 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 42 тоот тогтоолоор тус бүртгэлд өөрчлөлт оруулан шинэчлэн бүртгүүлсэн Үнэт цаасны зохицуулалттай этгээд (Хавсралт 1.1)-ийн хувьд энэхүү хууль зүйн үйлчилгээг үзүүлэх эрхтэй болно.

Монгол Улсын хуулийн этгээд болох "Сэндли ББСБ" ХК (Регистрийн дугаар: 5961548), (цаашид **"Компани"**, эсхүл **"Үнэт цаас гаргагч"** гэх) нь өрийн хэрэгсэл гарган нийтэд санал болгох гэж буйтай холбогдуулан Хууль зүйн дүгнэлт гаргахыг биднээс хүсч, улмаар бид 2024 оны 3 дугаар сарын 14-ний өдөр "Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ" (Хавсралт 1.2) байгуулан, тус гэрээний дагуу энэхүү Хууль зүйн дүгнэлт (цаашид **"Дүгнэлт"** гэх)-ийг гаргаж байна.

Энэхүү Дүгнэлтийг зөвхөн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, түүний дотор Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 41 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.18 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 16 дугаар зүйлд заасны дагуу Компани нь өрийн хэрэгсэл гарган олон нийтэд санал болгох эрх зүйн үндэслэлтэй гэж үзсэний үндсэн дээр гаргаж байна.

Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйл (Компанийн өрийн бичиг), 42 дугаар зүйл (Үнэт цаас гаргах тухай шийдвэр), Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 (Өрийн хэрэгсэл), 5 дугаар зүйл (Үнэт цаас), 6 дугаар зүйл (Үнэт цаас гаргах) 7 дугаар зүйл (Үнэт цаас гаргагч), 8 дугаар зүйл (Нийтэд санал болгон үнэт цаас гаргах журам), 9 дүгээр зүйл (Үнэт цаас бүртгэх, нийтэд санал болгохыг зөвшөөрөх), 10 дугаар зүйл (Үнэт цаасны танилцуулга), 11 дүгээр зүйл (Үнэт цаасыг нийтэд санал болгох), 16 дугаар зүйл (Өрийн хэрэгсэл гаргах)-д заасны дагуу өрийн хэрэгсэл гарган СЗХ, Монголын хөрөнгийн бирж (цаашид **"МХБ"** гэх)-д бүртгүүлж, нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн байна.

**Хангагдсанд тооцох нөхцөл**

Энэхүү Дүгнэлтийг боловсруулахдаа Бид дараах нөхцөл хангагдсан гэж үзсэн болно. Үүнд:

1. Бидний судлан шинжилсэн бүх баримт бичгийн хуулбар, эсхүл маягтууд нь үнэн зөв, тэдгээр дээрх аливаа тэмдэглэгээ, гарын үсэг, тамга тэмдэг нь үнэн;
2. Бүх баримт бичгүүд нь тэдгээрийг үйлдсэн талуудын бүрэн эрхийн хүрээнд үйлдэгдсэн;
3. Бидэнд өгөгдсөн аливаа баримт бичгийн хуулбар нь тухайн баримт бичгийн эх хувьтайгаа нийцсэн бөгөөд тэдгээрийг бүрэн хуулбарласан, үнэн зөв;
4. Бидэнд өгөгдсөн баримт бичгийн дагуу үүсэх аливаа үүрэг нь Монгол Улсаас бусад эрх зүйн тогтолцоонд хүчин төгөлдөр байх ба тэдгээр үүргийн хэрэгжилт хууль бус, хүчин төгөлдөр бус, эсхүл хэрэгжих боломжгүй биш байна;
5. Монгол Улсаас өөр улсад үйлдэгдсэн аливаа баримт бичиг нь тийнхүү үйлдэгдсэн улсын хуулийн шаардлагыг хэлбэрийн болон агуулгын хувьд бүрэн хангасан, хүчин төгөлдөр баримт бичиг ба тэдгээрийн хэрэгжилт нь тийнхүү хэрэгжих улсын хуулийн шаардлагыг мөн хангасан;

УЛААНБААТАР ХОТ
ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС ХХН
5183855
9021031195
СТС2420

Сэндли Бонд 2.0

СЗХ
2024.06.10
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2024-05-17
БҮРТГЭВ-02

6. Загвар хувилбараар ирсэн баримт бичиг нь тухайн хувилбарыг үндэс болгон баталгаажсан;
7. Компани, түүний ажилтнуудаас аливаа хэлбэрээр хүлээн авсан аливаа мэдээлэл нь үнэн зөв, бодитой;
8. Шүүх, төрийн эрх бүхий болон бусад байгууллагаас авсан мэдээлэл, баримт бичиг нь үнэн зөв;
9. Үнэт цаасны танилцуулгад тусгасан андеррайтер, аудитор, хөрөнгийн үнэлгээчний хийсэн судалгаа, дүгнэлт, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв;
10. Бидний судалж ашигласан бичиг баримтыг бэлтгэсэн болон түүнд гарын үсэг зурсан этгээд нь тийнхүү уг баримт бичгийг бэлтгэх, гарын үсэг зурах бүрэн эрхтэй;
11. Компанийн ТУЗ, Гүйцэтгэх захирал нь СЗХ-ны тохиромжтой этгээдийн шаардлага хангасан тухай мэдээллийг СЗХ-нд өгч, холбогдох зөвшөөрөл авсан;
12. Үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компани болж компанийн хэлбэрээ өөрчилсний улмаас хязгаарлагдмал хариуцлагатай компани байх үед байгуулсан гэрээ, хэлцэл, баталсан журмууд нь эрх залгамжлалын дагуу хүчин төгөлдөр үйлчилнэ.

Энэхүү үнэт цаасны бүртгэл болон арилжаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7 дахь хэсэг, СЗХ-ны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”, СЗХ-ны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 226 тоот тогтоолоор батлагдсан “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”, МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор батлагдсан МХБ-ийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын дагуу явуулна гэж бид ойлгож байна.

Бид Дүгнэлт гаргах зорилгоор Компаниас түүний Гэрчилгээ, Дүрэм, Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон бидний хувьд шаардлагатай гэж үзсэн бусад бичиг баримтын эх хувь болон хуулбарыг гаргуулан авч, хууль зүйн үндэслэл болон мэдээллийг тулган шалгаж, судалсан болно. Түүнчлэн Компанийн үйл ажиллагааны талаар шүүх, төрийн эрх бүхий байгууллагуудаас шаардлагатай гэж үзсэн хөндлөнгийн мэдээллийг гаргуулж судалсан болно.

Бид ийнхүү судалгаа шинжилгээ (due diligence) хийж, Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн доор дурдсан Дүгнэлтийг гаргаж байна:



УЛААНБААТАР ХОТ
ХХК
5183855
9021031195 СТС2420

## Компани хууль тогтоомжийн дагуу үүсэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх, үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх

***Компани хууль тогтоомжийн дагуу үүсэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх талаар.***

Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуулийн дагуу хоёр гишүүн (Монгол Улсын иргэн Л.Отгонбаатар, Б.Тамир)-тэйгээр үүсгэн байгуулагдаж, 2015 оны 05 дугаар сарын 04-ний өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн байна. (Улсын бүртгэлийн дугаар: 9007001010, Регистрийн дугаар: 5961548) (Хавсралт 1.3, Хавсралт 1.10). Үнэт цаас гаргагч нь өмнө "Гео финанс" ХХК, "Гялс кредит ББСБ" оноосон нэртэйгээр үйл ажиллагаагаа эрхэлж байсан ба "Гялс кредит ББСБ" оноосон нэрийг "Сэндли ББСБ" ХХК болгон өөрчилснийг СЗХ-ны даргын 2021 оны 12 дугаар сарын 10-ны 328 тоот тушаал (Хавсралт 1.5, Хавсралт 1.6)-аар зөвшөөрч, 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Улсын бүртгэлд бүртгэсэн байна.

"Сэндли ББСБ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн "Үнэт цаас нийтэд санал болгон гаргах тухай" 02 тоот шийдвэр (Хавсралт 1.7), 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн "Хувьцаагаа анх удаа нийтэд санал болгон гаргах тухай" 08 тоот шийдвэр (Хавсралт 1.8)-ээр энгийн хувьцааг нэмж гаргаж, олон нийтэд санал болгон, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн "Нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэх тухай" 413 дугаартай тогтоол (Хавсралт 1.9)-оор зөвшөөрснөөр анхдагч зах зээлийн арилжаа болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг амжилттай зохион байгуулж, Үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компани болсныг 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдөр улсын бүртгэлд бүртгэсэн байна (Хавсралт 1.10).

Үнэт цаас гаргагч нь 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн улсын бүртгэлийн гэрчилгээ (Хавсралт 1.3), 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн тогтоолоор баталж, 2022 оны 12 сарын 27-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлсэн "Сэндли ББСБ" ХК-ийн дүрэм (Хавсралт 1.4)-д заасны дагуу зээлийн үйл ажиллагаа, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, гадаад валютын арилжаа, факторингийн үйлчилгээ, төлбөрийн баталгаа гаргах, итгэлцлийн үйлчилгээ эрхэлж байна.

Компанийн мэдээлэл:

| | |
|---|---|
| *Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:* | 000264577; |
| *Улсын бүртгэлийн дугаар:* | 9007001010; |
| *Регистрийн дугаар:* | 5961548; |
| *Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр:* | "Сэндли ББСБ" Хувьцаат Компани /нээлттэй хувьцаат компани/; |
| *Хугацаа:* | Хугацаагүй; |
| *Хувьцаа эзэмшигчдийн тоо:* | 6797 (2024 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаа) (Хавсралт 1.11); |
| *Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (төгрөгөөр):* | 11,178,500,000 (Хавсралт 1.3, Хавсралт 1.4, Хавсралт 1.10, 1.11); |

СЗХ 2024 .06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

| | |
|---|---|
| *Хуулийн этгээдийн албан ёсны хаяг:* | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 40, 50 мянгат /15171/, Бакула ренбүчи гудамж, 8/4 тоот; |
| *Гэрчилгээ олгосон сүүлчийн огноо:* | 2022.12.27; |
| *Гүйцэтгэх захирал:* | Б.Одгэрэл. |

Энэхүү Дүгнэлт гаргах өдрийн байдлаар 2015 оны 05 дугаар сарын 04-ний өдөр анх улсын бүртгэлд бүртгэсэн тухай 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдөр шинэчлэн олгосон Улсын бүртгэлийн гэрчилгээ (Гэрчилгээний дугаар: 000264577, Улсын бүртгэлийн дугаар: 9007001010, Регистрийн дугаар: 5961548) (Хавсралт 1.3) бүхий "Сэндли ББСБ" ХК нь Компанийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн байна.

***Үнэт цаас гаргах тухай шийдвэрийн талаар.***

"Сэндли ББСБ" ХК-ийн 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар Нээлттэй өрийн хэрэгсэл гаргах тухай 14 тоот шийдвэр (Хавсралт 1.12)-ээр "Сэндли ББСБ" ХК-ийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор дараах нөхцөлөөр өрийн хэрэгсэл гарган нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

| | |
|---|---|
| Үнэт цаас | Нээлттэй арилжаалах өрийн хэрэгсэл "Сэндли Бонд 2.0" |
| Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага | Монголын хөрөнгийн бирж |
| Үнэт цаасны төрөл | Энгийн хүүтэй бонд |
| **Бондын үнийн дүн** | **10,000,000,000 (арван тэрбум) төгрөг** |
| Нэгж бондын нэрлэсэн үнэ | 100,000 төгрөг |
| Бондын нийт тоо, ширхэг | 100,000 ширхэг |
| Бондын хугацаа | 24 (хорин дөрөв) сар |
| Бондын хүү (жилийн буюу 365 хоног) | 18,5% (татварын өмнөх) |
| Хүү төлөгдөх давтамж | Улирал тутамд |
| Үндсэн төлбөр төлөх хугацаа | Бондын хугацааны эцэст (24 сарын дараа) |
| Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулах зориулалт | Үндсэн үйл ажиллагаа буюу зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх |
| Нийтэд санал болгон гаргах хугацаа | 2024 оны III улирал (Зохицуулагч байгууллагын зөвшөөрлөөс шалтгаалан өөрчлөгдөж болно) |
| Бондын хадгалалт, төлбөр тооцоо | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |
| Бондын барьцаа/баталгаа | Компанийн толгой компани болох "Монголын финтек групп" ХК нь "Сэндли ББСБ" ХК-д өөрийн эзэмшиж буй 111,785,000 ширхэг энгийн хувьцаа, "Монголын финтек групп" ХК-ийн Дорноговь аймгийн Замын-үүд сум, 1-р баг Соёмбо, ТЗӨЧ-4 гудамжны 406 тоот хаягт байрлах Улсын бүртгэлийн дугаар Э-0714002972, газар |



УЛААНБААТАР ХОТ ... ХХК 5183855 9021031195 СТС2420

| | |
|---|---|
| | эзэмших эрхийн гэрчилгээний дугаар 0000237626, нэгж талбарын дугаар 4401010485 бүхий зочид буудлын цогцолбор, олон нийтийн газар зориулалттай, 10000 м.кв газар эзэмших эрх болон Дорноговь аймгийн Замын-үүд сум, 1-р баг Соёмбо, ТЗӨЧ-3 гудамжны 320 хаягт байрлах, Улсын бүртгэлийн дугаар Э-0714002967, газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар 0000237326, нэгж талбарын дугаар 4401002556 бүхий Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор зориулалттай 1200 м.кв газар эзэмших эрх |
| Үндсэн андеррайтер | "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК |
| Туслах андеррайтер | "Райнос Инвестмент ҮЦК" ХХК, "Голомт Капитал ҮЦК" ХХК |

Уг тогтоол (Хавсралт 1.12) нь Компанийн тухай хуулийн 4.3 дахь хэсэг, 41 дүгээр зүйл, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 43 дугаар зүйлийн 43.1, 55 дугаар зүйлийн 55.2, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.6, 76.1.18 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1.2 дахь заалт, 6.1 дэх хэсэг, 16 дугаар зүйл, Компанийн дүрмийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.6.2, 8.6.12, 8.6.23, 8.10 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт тус тус нийцэж байна.

**Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 210 дугаар тогтоолоор баталсан Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журмын 7 дугаар зүйлийн 7.1.2-т зааснаар банк бус санхүүгийн байгууллагын гаргасан өрийн бичгийг өөрийн хөрөнгөнд харьцуулсан харьцаа нь 50 хувиас хэтрэхгүй байх шаардлагатай бөгөөд тус зохистой харьцааны шаардлагыг хангаж байгаа талаар Компанийн Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.1).**

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 226 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 2.5-д "Бонд гаргагч нь бондын үүргийн гүйцэтгэлийг хангах гуравдагч этгээдээс тусгайлан гаргасан баталгаа, батлан даалттай байж болох бөгөөд бонд гаргагч компанийн хувьд энэ журмын 2.6-д зааснаас бусад тохиолдолд барьцаа хөрөнгө нь бонд гаргагчийн гаргасан, энгийн хувьцаа эсхүл түүнд хөрвөх нөхцөлтэй үнэт цааснаас бусад төрлийн эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн хэлбэртэй байна", 2.6-д "Бонд гаргагч нь нэгдмэл хувьцаат компани бол тухайн компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцаагаар батлан даалт болох бөгөөд батлан даах хувьцаа нь бонд гаргагчийн нийт гаргасан энгийн хувьцааны 50 хувиас дээшгүй байна", 2.7-д "Энэ журмын 2.6-д заасны дагуу батлан даасан хувьцааны үнэлгээг тогтоохдоо арилжаа эрхлэх байгууллагын албан ёсны мэдээнд тусгасан сүүлийн зургаан сарын жигнэсэн дундаж ханшийг харгалзах бөгөөд барьцаалах үнэлгээ нь тухайн хувьцааны үнэлгээний 70 хувиас илүүгүй байна" гэж тус тус заасан.

Үүний дагуу "Монголын Финтек Групп" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 31 тоот тогтоол (Хавсралт 1.13)-оор өөрийн эзэмшлийн бүх 16,150,696,800 (арван зургаа тэрбум нэг зуун тавин сая зургаан зуун ерин зургаан мянга найман зуу) төгрөгийн үнэлгээ бүхий "Сэндли ББСБ" ХК-ийн 111,785,000 ширхэг энгийн хувьцаа, Дорноговь аймгийн Замын-үүд сум, 1-р баг Соёмбо, ТЗӨЧ-4 гудамжны 406 хаягт байрлах Улсын бүртгэлийн дугаар Э-0714002972, газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар 0000237626, нэгж талбарын дугаар 4401010485 бүхий зочид буудлын цогцолбор, олон нийтийн газар зориулалттай, 10000 м.кв газар эзэмших эрх (Хавсралт 1.14) болон Дорноговь аймгийн Замын-үүд сум, 1-р баг Соёмбо, ТЗӨЧ-3 гудамжны 320 хаягт байрлах, Улсын бүртгэлийн дугаар Э-

0714002967, газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар 0000237326, нэгж талбарын дугаар 4401002556 бүхий Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор зориулалттай 1200 м.кв газар эзэмших эрх (Хавсралт 1.15)-ийг тус тус бондын үндсэн болон хүүгийн төлбөр төлөгдөж дуусах хүртэл хугацаагаар барьцаалуулахаар шийдвэрлэсэн байна.

"Сэндли ББСБ" ХК нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар нийт 223,570,000 (хоёр зуун хорин гурван сая таван зуун далан мянга) ширхэг энгийн хувьцаа гаргасан, үүнээс "Монголын Финтек Групп" ХК нь 111,785,000 (нэг зуун арван нэгэн сая долоон зуун наян таван мянга) ширхэг энгийн хувьцааг барьцаалуулж буй нь Журмын 2.6-д заасан шаардлагыг хангана гэж үзэв (Хавсралт 1.4, 1.10, 1.11).

Мөн "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 03/332 тоот албан бичиг (Хавсралт 1.16)-т заасныг Компанийн хувьцааны жигнэсэн дундаж ханш нь 144.48 (нэг зуун дөчин дөрөв зууны дөчин найм) төгрөг байна гэжээ. Хувьцааны ханш өөрчлөгдөж болно. "Монголын Финтек Групп" ХК-ийн хувьцаа барьцаалах тухай шийдвэр нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Газрын тухай хуулийн холбогдох зохицуулалтад нийцэж байна.

Түүнчлэн "Файн Эстимэйт" ХХК-ийн 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 4/25-24 тоот Хөрөнгийн үнэлгээний тайлан (Хавсралт 1.17)-д тусгаснаар "Монголын Финтек Групп" ХК-ийн Дорноговь аймгийн Замын-үүд сум, 1-р баг Соёмбо, ТЗӨЧ-4 гудамжны 406 хаягт байрлах Улсын бүртгэлийн дугаар Э-0714002972, газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар 0000237626, нэгж талбарын дугаар 4401010485 бүхий зочид буудлын цогцолбор, олон нийтийн газар зориулалттай, 10000 м.кв газар эзэмших эрх (Хавсралт 1.14) болон Дорноговь аймгийн Замын-үүд сум, 1-р баг Соёмбо, ТЗӨЧ-3 гудамжны 320 хаягт байрлах, Улсын бүртгэлийн дугаар Э-0714002967, газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар 0000237326, нэгж талбарын дугаар 4401002556 бүхий Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор зориулалттай 1200 м.кв газар эзэмших эрх (Хавсралт 1.15)-ийг 2,811,280,000 (хоёр тэрбум найман зуун арван нэгэн сая хоёр зуун найман зуун мянга) төгрөгийн үнэлгээтэй болохыг тогтоосон байна.

Нэгтгэн дүгнэвэл, Компанийн өрийн хэрэгсэл гарган нийтэд санал болгох тухай шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан [illegible] Хорооны баталсан [illegible] Компанийн засаглалын кодекс [illegible]

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй Компанийн дүрмийн 20.1-д заасны ТУЗ-ийн дарга, гишүүд, Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон тэдгээртэй адилтгах албан тушаалтныг Компанийн эрх бүхий албан тушаалтан гэж тодорхойлсон нь Компанийн тухай хуулийн 84-р зүйлийн 84.2, 84.3 дахь заалтаа "Компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна" гэж заасан шаардлагад нийцсэн байна. Иймд, Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд үндэслэн тус Компанийн Эрх бүхий албан тушаалтан гэдэгт ТУЗ-ийн дарга, гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Үйл ажиллагаа хариуцсан захирал, Салбар, нэгж хариуцсан захирал, Мэдээлэл, технологи хариуцсан захирал, Бүтээгдэхүүн хөгжүүлэлт хариуцсан захирал, Мөнгөн гүйвуулга хариуцсан захирал, Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан захирал, Санхүү хариуцсан захирал нарыг компанийн эрх бүхий албан тушаалтанд хамруулан авч үзлээ.

***Төлөөлөн удирдах зөвлөл***

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 02 тоот шийдвэр (Хавсралт 2.1)-ээр Компанийн ТУЗ-ийг нийт 9 бүрэлдэхүүнтэйгээр сонгосон байна. Ийнхүү СЗХ-ны банк бус санхүүгийн байгууллагын газрын даргын 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 7/2591 дугаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг бүртгэх тухай (Хавсралт 2.33) бичиг, 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 7/4809 дугаар албан бичиг (Хавсралт 2.54)-т тус тус заасаар ТУЗ-ийн гишүүд нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 75.8 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд бүртгэсэн байна. Түүнчлэн, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдөр ТУЗ-ийн гишүүдийг эрх барих этгээдээр бүртгэсэн байна (Хавсралт 1.10).

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд 5 эмэгтэй, 4 эрэгтэй сонгогдож хүйсийн тэнцвэртэй байдлыг хангаж байгаа нь СЗХ-ны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр баталсан Компанийн засаглалын кодексийн 1.4-т заасан зарчимд нийцэж байгаа бөгөөд Зөвлөхийн практикт ийнхүү хүйсийн тэнцвэрийг хангасан анхны тохиолдол болохыг онцлон тэмдэглэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 22/01 тоот тогтоол (Хавсралт [illegible])-оор ТУЗ-ийн даргаар Б.Наранбатыг сонгож, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 02 тоот тогтоол (Хавсралт [illegible])-оор ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Э.Цэлмэгийг томилон ажиллаж байна.

ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын боловсрол, ажлын туршлагыг дараах хүснэгтээр харуулав[1] (Хавсралт 12.1). Үүнд:

[1] *ТУЗ-ийн гишүүдээс гаргаж өгсөн анкет, нэхэмжлэл [illegible] эх сурвалжийн мэдээлэл, баталсан. Компанийн Гүйцэтгэх захирлын мэдэгдлээр үнэлэгдсэн байна.*

СЗХ БҮРТГЭВ №1 2024.06.10

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-17 БҮРТГЭВ-02

| № | Нэр | Боловсрол | Ажлын туршлага |
|---|---|---|---|
| **ЕРДИЙН ГИШҮҮД:** | | | |
| 1. | Баттулгын Наранбат (Хавсралт 2.3) | 2003-2007 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуульд санхүүч мэргэжлээр бакалавр; 2010-2011 онд Японы гадаад худалдааны байгууллагад эдийн засагч. | 2008-2012 онд Сангийн яаманд мэргэжилтэн; 2012-2013 онд Төрийн банкны Хөрөнгө зохицуулалтын хэлтэст захирал; 2013-2016 онд Төрийн банкны Санхүү хариуцсан дэд захирал; 2016 онд Төрийн банкны Гүйцэтгэх захирлын орлогч; 2016 оноос одоог хүртэл Гялс төгрөг ХЗХ-нд үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал. |
| 2. | Мөнхтөрийн Цолмон (Хавсралт 2.4) | 2007 онд Америкийн Нэгдсэн Улсын Индианагийн их сургуульд санхүүч мэргэжлээр бакалавр. | 2008-2012 онд Сангийн яаманд мэргэжилтэн; 2012-2014 онд Тээвэр дархан ХК-д Эдийн засагч; 2014-2016 онд Тариалан эрхлэлтийг дэмжих санд Гүйцэтгэх захирал; 2017 оноос одоог бүртэл Монгол алт ХК-д Гүйцэтгэх захирал; 2021 оноос одоог хүртэл Монголын Финтек Групп ХК-д Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга. |
| 3. | Лхагжавын Нарантуяа (Хавсралт 2.5) | 2004 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуульд Эрх зүйч мэргэжлээр Бакалавр. | 2008-2009 онд сар Зоос банк ХХК-д Мэргэжилтэн; 2009-2018 онд Төрийн банкинд Хуульч, Ахлах хуульч; 2018-2022 онд Монголиан Мючуал Финанс Групп ХХК-д |



УЛААНБААТАР ХОТ … КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195

СЗХ
2024 .05 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

| | | | |
|---|---|---|---|
| | | | Хууль эрх зүй харицуцан захирал;<br>2022 оноос одоог хүртэл Монголын Финтек Групп ХК-ийн Хууль, эрх зүй харицуцан захирал. |
| 4. | Найдангийн Билгүүн<br>(Хавсралт 2.6) | 2009 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуульд Эрх зүйч мэргэжлээр Бакалавр;<br>2012 онд АНУ-ын Миссури их сургуульд Бизнесийн удирдлага мэргэжлээр магистр. | 2013-2018 онд Сангийн Яамд мэргэжилтэн;<br>2018-2021 онд Сэлүс Номадс компанид Менежер;<br>2021-2022 онд Дэлхийн банкинд Зөвлөх;<br>2022 оноос одоог хүртэл Инвестлаб Ви Си ХХК, Гүйцэтгэх захирал. |
| 5. | Батбаярын Эрдэнэ<br>(Хавсралт 2.7) | 2007 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуульд бизнесийн удирдлагын бакалавр;<br>2014 онд Австрали Улсын Шинэ Өмнөд Уэльсийн их сургууль (UNSW)-д санхүүгийн удирдлагын мастер. | 2007-2012 онд Сангийн яамны ДАХШҮГ-т Мэргэжилтэн;<br>2014-2015 онд Сангийн яамны ЭУДАГ-т Ахлах мэргэжилтэн;<br>2015-2016 онд Төрийн банкны Хяналт шалгалтын газрын Захирал;<br>2016-2017 онд Төрийн банкны Актив, пассивын удирдлагын газрын Захирал;<br>2017 оноос одоог хүртэл Техбокс ХХК-ийн Гүйцэтгэх захирал. |
| 6. | Нармандахын Цэвэгмид (Хавсралт 2.8) | 2007 онд БНСУ-ын Инха Их сургуульд Эдийн засгийн ухааны бакалавр;<br>2009 онд БНСУ-ын КАИСТ их сургуульд Менежмент, Инженерчлэлийн магистр; | 2009-2014 онд ГАУЛИ ХХК-д Дэд захирал;<br>2014-2016 онд Дэу Сэкьюритис Монгол ҮЦК ХХК-д Хөрөнгө оруулалтын менежер;<br>2016-2021 онд Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК ХХК-д Гүйцэтгэх захирал; |



УЛААНБААТАР
ХХК
5183855
9021031195 СТС2420

| | | | |
|---|---|---|---|
| | | | 2021 оноос одоог хүртэл Райнос инвестмент ҮЦК ХХК, Дэд захирал. |
| **ХАРААТ БУС ГИШҮҮД:** | | | |
| 7. | Баатархүүгийн Анужин (Хавсралт 2.9) | 2008-2012 онд Бритиш Колумбийн Их сургуульд Байгаль орчин, тогтвортой хөгжил мэргэжлээр бакалавр;<br><br>2015-2016 онд Гренобль Бизнес сургуульд Бизнесийн удирдлага мэргэжлээр магистр. | 2012-2015 онд АНУ-ийн Азийн санд Хөтөлбөрийн мэргэжилтэн;<br><br>2016-2018 онд Эрнст энд Янг Аудитад Ахлах аудитор;<br><br>2018 оноос одоог хүртэл Централ ТВ-д Бизнес хөгжил хариуцсан захирал, Гүйцэтгэх захирал; |
| 8. | Батмөнхийн Цэлмэг (Хавсралт 2.10) | 2003-2008 онд Ирланд улсын Ирланд Америкийн Институтэд Олон улсын бизнесийн удирдлагаар бакалавр;<br><br>2009-2011 онд Ирланд улсын Банкируудын Институтийн Хөрөнгө оруулалтын сангийн мэргэшсэн диплом;<br><br>2014-2015 онд Мэргэшсэн нягтлан бодогчдын холбоо (ACCA)-ны Олон улсын мэргэшсэн нягтлан бодогч;<br><br>2017-2018 онд Ирландын Хуульчдын холбооны Аэро/Нисэх онгоц лизинг болон санхүүгийн мэргэшсэн диплом. | 2008-2015 онд Жэй Пи Морган Хөрөнгө оруулалтын санд Татварын ахлах зөвлөх;<br><br>2015-2018 онд Ээс Эм Би Си Авиашн Капиталд Санхүү төслийн менежер;<br><br>2018-2022 онд Хас банкинд Санхүүгийн газрын захирал;<br><br>2022 оноос одоог хүртэл Ашид Ассет Менежмент ҮЦК ХХК-д Хөрөнгө оруулалт хариуцсан захирал. |
| 9. | Цэндсүрэнгийн Саруултуяа (Хавсралт 2.11) | 2003-2007 онд Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн Сургуульд Бизнесийн удирдлагаар бакалавр;<br><br>2009-2011 онд Тайвань улсын Азийн их сургуульд Бизнесийн удирдлагаар магистр; | 2007-2009 онд Голомт банкинд Судалгааны менежер;<br><br>2012-2017 онд Тайвань улсын АИС, ШУТИХ-д Төслийн судлаач; |

| | | | |
|---|---|---|---|
| | | 2011-2017 онд Тайвань улсын Азийн их сургуульд доктор. | 2017-2019 онд Голомт банкинд Бизнес хөгжлийн менежер;<br><br>2021 оноос одоог хүртэл Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн сургуульд Ахлах багш. |
| **ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:** | | | |
| 10. | **Э.Цэлмэг** (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга)<br><br>(Хавсралт 2.24) | 2010 онд МУИС-ийн Хууль Зүйн Сургуульд олон улсын эрх зүйч мэргэжлээр бакалавр;<br><br>2021 онд СЭЗИС-д Санхүү, Бизнесийн удирдлагаар бакалавр. | 2010-2014 онд Хүннү Эйр ХХК-д хуулийн мэргэжилтэн;<br><br>2014-2019 онд Эмбасси Резидэнс ХХК-д хуульч;<br><br>2019-2023 онд Монголиан Эйрвейс ХХК-д Захирга, эрх зүйн хэлтсийн менежер,<br><br>2023 оны 11 сараас одоог хүртэл Монголын финтек групп ХК-д хуулийн мэргэжилтэн. |

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2-д "Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ" гэж заасан. Түүнчлэн Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам (Хавсралт 3.17)-ын 10.1-д заасны дагуу Компанийн ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороодын бүтцийг шинэчлэн батлах тухай 10 тоот тогтоол (Хавсралт 2.22)-оор ТУЗ-ийн дэргэд (1) цалин урамшууллын хороо, (2) аудит, эрсдэлийн удирдлагын хороо, (3) нэр дэвшүүлэх хороо гэсэн байнгын хороог байгуулсан байна.

Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав.

| **КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮД, НАРИЙН БИЧГИЙН ДАРГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА** | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **№** | **Нэр/Шаардлага** | **Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага,** | **Ял шийтгэл эдэлж байгаа эсэх (КтХ-ийн 84.3.2)*** | **Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж,** | **Хувь хүн байх (КтХ-ийн 77.3, 83.2, 83.3)** |

СЗХ 2024 оны 05 сар 10 өдөр БҮРТГЭВ № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

| | | хэрэг, цагдаа, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэх | | гэрчилгээ авсан эсэх (КтХ-ийн 75.8) | |
|---|---|---|---|---|---|
| 1. | Б.Наранбат (ТУЗ-ийн дарга) | Үгүй | Үгүй* | Тийм /2021.05.17-ны өдөр, Дугаар 0430282/ (Хавсралт 2.3) | Тийм |
| 2. | М.Цолмон (ТУЗ-ийн гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2021.05.17-ны өдөр, Дугаар 0430814/ (Хавсралт 2.4) | Тийм |
| 3. | Л.Нарантуяа (ТУЗ-ийн гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2021.05.17-ны өдөр, Дугаар 0430825/ (Хавсралт 2.5) | Тийм |
| 4. | Н.Билгүүн (ТУЗ-ийн гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2021.05.17-ны өдөр, Дугаар 0430824/ (Хавсралт 2.6) | Тийм |
| 5. | Б.Эрдэнэ (ТУЗ-ийн гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2021.05.17-ны өдөр, Дугаар 0430816/ (Хавсралт 2.7) | Тийм |



УЛААНБААТАР ... ХХК 5183855 9021031195 СТС...

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6. | **Н.Цэвэгмид (ТУЗ-ийн гишүүн)** | Үгүй | Үгүй* | Тийм /2019.02.24-ний өдөр, Дугаар 0520841/ (Хавсралт 2.8) | Тийм |
| 7. | **Б.Ануджин (ТУЗ-ийн хараат бус гишүүн)** | Үгүй | Үгүй* | Тийм /2022.05.09-ны өдөр, Дугаар 0132018/ (Хавсралт 2.9) | Тийм |
| 8. | **Б.Цэлмэг (ТУЗ-ийн хараат бус гишүүн)** | Үгүй | Үгүй* | Тийм /2021.06.19-ний өдөр, Дугаар 0131604/ (Хавсралт 2.10) | Тийм |
| 9. | **Ц.Саруултуяа (ТУЗ-ийн хараат бус гишүүн)** | Үгүй | Үгүй* | Тийм /2022.12.02-ны өдөр, Дугаар 0431031/ (Хавсралт 2.11) | Тийм |
| 10. | **Б.Одгэрэл** | Үгүй | Үгүй* | Тийм /2021.05.17-ны өдөр, Дугаар 0430823/ (Хавсралт 2.23) | Тийм |
| 11. | **Э.Цэлмэг (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга)** | Үгүй | Үгүй* | Тийм /2024.02.06-ны өдөр, Дугаар 0731749/ (Хавсралт 2.24) | Тийм |

**Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаггүй эсэх. Компанийн тухай хуулийн 84.3.2-т заасан шийтгэл эдлээгүй байх шаардлагыг ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнууд хангаж байгаа эсэхийг бидэнд гаргаж өгсөн анкет, мэдүүлэг, баталгааны үндсэн дээр дүгнэв*

СЗХ 2024 оны 06 сарын 10 өдөр БҮРТГЭВ № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавих нэмэлт шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:

| ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах нэмэлт шаардлага | | | | |
|---|---|---|---|---|
| № | Шаардлага | ТУЗ-ийн хараат бус гишүүдийн нэрс | | |
| | | Б.Анужин (Хавсралт 2.9) | Б.Цэлмэг (Хавсралт 2.10) | Ц.Саруулт уна (Хавсралт 2.11) |
| 1. | Өөрөө эсхүл компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран Компанийн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй байх (КтХ-ийн 79.1.1) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 2. | Өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанид болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, сүүлийн 3 жилийн хугацаанд эдгээр ажил, албан тушаал эрхэлж байгаагүй байх (КтХ-ийн 79.1.2) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 3. | Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй байх (КтХ-ийн 79.1.3) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 4. | Компанитай бизнесийн гэрээ хэлцэл байгуулаагүй байх, тийм холбоогүй байх (КтХ-ийн 79.1.4) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 5. | Сүүлийн 5 жилд компанид нэгдмэл сонирхолтой этгээд болж байгаагүй байх | Тийм** | Тийм** | Тийм** |
| 6. | Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй зөвлөх үйлчилгээ үзүүлдэггүй байх | Тийм** | Тийм** | Тийм** |
| 7. | Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй ханган нийлүүлэгч ба харилцагч биш байх | Тийм** | Тийм** | Тийм** |



УЛААНБААТАР ХОТ ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК 5183855 9024031195 CTC2420

СЗХ 2024 06 10 БҮРТГЭВ № 1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8. | Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй үйлчилгээ үзүүлэх гэрээ хийгээгүй байх | Тийм** | Тийм** | Тийм** |
| 9. | Компанийн ТУЗ, гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, дотоод аудитын ажилтны нэгдмэл сонирхолтой этгээд биш байх | Тийм** | Тийм** | Тийм** |
| 10. | Хувьцаа эзэмшигч эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн ойрын хамаатан биш байх | Тийм** | Тийм** | Тийм** |

***Компанийн тухай хуулийн 79.1.1-79.1.4 зүйл, Компанийн засаглалын кодекст заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг тус Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд хангаж байгаа эсэхийг тэдний гаргаж өгсөн мэдүүлэг, баталгаагаар үндэслэж дүгнэв.*

ТУЗ-ийн дэргэдэх аудит, эрсдэлийн удирдлагын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Цэлмэг, гишүүдээр хараат бус гишүүн Б.Анужин, ердийн гишүүн Н.Билгүүн нар, Цалин урамшууллын хорооны даргаар хараат бус гишүүн Б.Анужин, гишүүдээр хараат бус гишүүн Ц.Саруултуяа, ердийн гишүүн Б.Эрдэнэ нар, Нэр дэвшүүлэх хорооны даргаар хараат бус гишүүн Ц.Саруултуяа, гишүүдээр хараат бус гишүүн Б.Цэлмэг, ердийн гишүүн Л.Нарантуяа нар ажиллаж байгаа нь (Хавсралт 2.12) Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2-т заасан ТУЗ-ийн цалин урамшууллын, нэр дэвшүүлэх, аудитын хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх, мөн хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4-т заасан аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх шаардлагыг тус тус хангаж байна.

Компанийн ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйл, 84 дүгээр зүйлийн 84.3 дахь хэсэгт заасан шаардлагыг тус тус хангаж, тус хуулийн 75 дугаар зүйлийн 75.8 дахь хэсэгт заасны дагуу компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан.

Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын мэргэжил, боловсрол, эрхэлж байсан\байгаа ажлын туршлага зэргээс үзвэл Компанийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай мэдлэг, туршлагатай, Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон Компанийн засаглалын кодексоор тогтоосон шаардлагыг хангаж байна гэж дүгнэв.

***Компанийн бусад эрх бүхий албан тушаалтан***

Компанийн бусад эрх бүхий албан тушаалтнууд болох Гүйцэтгэх захирал Б.Одгэрэл "Гэлэс кредит ББСБ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 03 тоот шийдвэр (Хавсралт 2.13)-ээр, Ерөнхий нягтлан бодогч Х.Ичинхорлоо Гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Б/93-1 тоот тушаал (Хавсралт 2.14)-аар, Үйл ажиллагаа хариуцсан захирал Х.Ичинхорлоо Гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Б/93-1 тоот тушаал (Хавсралт 2.15)-аар, Салбар, нэгж хариуцсан захирал П.Болорчулуун Гүйцэтгэх захирлын 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн Б/27 тоот тушаал (Хавсралт 2.16)-



УЛААНБААТАР ХОТ ... КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

СЭХ 2024 .06. 10 өдөр БҮРТГЭВ №

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024 -06- 17 БҮРТГЭВ-02

аар, Мэдээлэл, технологи хариуцсан захирал Н.Эрдэнэтулга Гүйцэтгэх захирлын 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Б/142 тоот тушаал (Хавсралт 2.17)-аар, Бүтээгдэхүүн хөгжүүлэлт хариуцсан захирал Э.Мөнхшүүдэр Гүйцэтгэх захирлын 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн Б/68 тоот тушаал (Хавсралт 2.18)-аар, Мөнгөн гүйвүүлга хариуцсан захирал Б.Нямжаргал Гүйцэтгэх захирлын 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн Б/62 тоот тушаал (Хавсралт 2.19)-аар, Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан захирал Д.Баярбат Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Б/29 тоот тушаал (Хавсралт 2.20), Санхүү хариуцсан захирал М.Мөнхзэрэл Гүйцэтгэх захирлын 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн Б/55 тоот тушаал (Хавсралт 2.21)-аар тус тус томилогдон ажиллаж байна.

Эдгээр эрх бүхий албан тушаалтнуудын боловсрол, ажлын туршлагыг авч үзвэл:

| № | Нэр | Боловсрол | Ажлын туршлага |
|---|---|---|---|
| 1. | **Балжиннямын Оюгэрэл** (Гүйцэтгэх захирал)<br><br>(Хавсралт 2.22) | 2002-2006 онд Санхүү Эдийн Засгийн Их Сургуульд Санхүүгийн удирдлагын бакалавр. | 2006-2011 онд Хаан банкинд Теллер, эдийн засагч, ахлах эдийн засагч;<br><br>2011-2013 онд Хадгаламж банкинд мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, орон нутгийн зээлийн хэлтсийн захирал;<br><br>2013-2016 онд Төрийн банкинд Орон нутгийн зээлийн хэлтсийн захирал;<br><br>2016-2021 онд Гялс төгрөг ХЗХ-нд Үйл ажиллагаа хариуцсан захирал;<br><br>2021 оноос одоог хүртэл Сэндли ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирал. |
| 2. | **Хандхүүгийн Ичинхорлоо** (Ерөнхий нягтлан бодогч, Үйл ажиллагаа хариуцсан захирал) (Хавсралт 2.23) | 1995 1999 онд Санхүү Эдийн Засгийн Дээд Сургуульд Бизнесийн удирдлагын бакалавр;<br><br>Эдийн засгийн үндэсний дээд сургуульд Бизнесийн удирдлагын магистр. | Зоос банкны Кассын нярав, Хянагч нягтлан бодогч, Теллер, Ахлах теллер, Ерөнхий нягтлан бодогч;<br><br>2009-2016 онд Төрийн банкны салбарын Ерөнхий нягтлан бодогч, Харилцааны менежер, Мэргэжилтэн;<br><br>2016-2021 онд Гялс Төгрөг ХЗХ-д Ерөнхий нягтлан |



УЛААНБААТАР ХОТ ЭЛБИЙ ЭНД ХОТ ХХК 5183855 9021031195 CTC2420

| | | | |
|---|---|---|---|
| | | | бодогч;<br><br>2021 оноос одоог хүртэл Сэндли ББСБ-ын Ерөнхий нягтлан бодогч, Ерөнхий зохицуулалт хариуцсан захирал. |
| 3. | **Пүрэвдоржийн Болорчулуун** (Салбар, нэгж хариуцсан захирал) (Хавсралт 2.26) | 2000-2004 онд Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуульд Санхүүгийн удирдлагын бакалавр. | 2004-2010 онд Монгол шуудан банкны Нягтлан, Эдийн засагч, Мэргэжилтэн, Хянан шалгагч;<br><br>2010-2013 онд Хадгаламж банкны Ахлах аудитор, Ахлах менежер;<br><br>2013-2021 онд Төрийн банкны Тооцооны төвийн захирал, Менежер;<br><br>2021 оноос одоог хүртэл Сэндли ББСБ-ын Салбар, нэгж хариуцсан захирал. |
| 4. | **Н.Эрдэнэтулга** (Мэдээлэл, технологи хариуцсан захирал) (Хавсралт 2.27) | 2007 онд ШУТИС-ийн КТМСургуульд Компьютерийн техник болон программ хангамжийн инженер мэргэжлээр бакалавр. | 2006-2010 онд Юу Эс Ай ХХК-д Програм хөгжүүлэгч;<br><br>2010-2019 онд Төрийн банкинд Программист;<br><br>2019-2023 онд Радикс Технологи ХХК-д хөгжүүлэгч, захирал;<br><br>2023 оноос одоог хүртэл Сэндли ББСБ ХК-д Мэдээлэл технологи хариуцсан захирал. |
| 5. | **Энхжаргалын Мөнхзлгэр** (Бүтээгдэхүүн хөгжил хариуцсан захирал) (Хавсралт 2.28) | 2008 онд Хөдөө Аж Ахуйн Их Сургуульд Эдийн засгийн кибернетикч мэргэжлээр бакалавр. | 2008-2009 онд Финпак ХХК-ийн Бүтээгдэхүүний мэргэжилтэн, эдийн засагч;<br><br>2009-2013 онд Хадгаламж банкны Хүний нөөцийн ахлах, Програм ашиглалт, хөгжүүлэлтийн ахлах;<br><br>2013-2016 онд Төрийн банкны |

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

| | | | |
|---|---|---|---|
| | | | Хүний нөөцийн газар, Сургалт хөгжлийн ахлах мэргэжилтэн;<br>2016-2021 онд Гэлс төгрөг ХЗХ-ны Ахлах менежер;<br>2021 оноос одоог хүртэл Сэндли ББСБ-ны Бүтээгдэхүүн хөгжил хариуцсан захирал. |
| 6. | **Батдоржийн Нямжаргал** (Мөнгөн гүйвуулга хариуцсан захирал) (Хавсралт 2.29) | 2011 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн Сургуульд Санхүүгийн менежментийн бакалавр;<br>2015 онд Pacific States University-д Бизнесийн удирдлагын магистр. | 2010-2012 онд Вагнер Ази Тоног Төхөөрөмж ХХК-ийн Ахлах нягтлан бодогч;<br>2016-2017 онд Голомт банкны Харилцааны менежер;<br>2018 онд Дэлхийн банкны Экспортыг дэмжих төслийн Бизнес хөгжүүлэлтийн ажилтан,<br>2021 оноос одоог хүртэл Сэндли ББСБ-ын Мөнгөн гүйвуулга хариуцсан дэд захирал. |
| 7. | **Дашзэвгийн Баярбат** (Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан захирал) (Хавсралт 2.30) | 2007 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн Сургуульд Санхүүч мэргэжлээр бакалавр;<br>2016 онд Санхүү Эдийн Засгийн Их Сургуульд Санхүүгийн менежер мэргэжлээр магистр. | 2007-2009 онд Анод банкны Эдийн засагч ;<br>2010-2017 онд Төрийн банкны Ахлах хянан шалгагч;<br>2017-2020 онд Гэлс төгрөг ХЗХ-д Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан дэд захирал. |
| 8. | **Мөнхбаатарын Мөнхгэрэл** (Санхүү хариуцсан захирал) (Хавсралт 2.31) | 2007-2012 онд Дублины Бизнесийн Их Сургуульд Санхүү, нягтлан бодох бүртгэл мэргэжлээр бакалавр;<br>2018-2021 онд Корнивусын Их Сургуульд Эдийн засгийн магистр. | 2012-2017 онд Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК-д Ахлах аудитор;<br>2020-2021 онд НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрт Санхүүгийн ажилтан;<br>2022 оноос одоог хүртэл Сэндли ББСБ ХК-д Санхүү |



УЛААНБААТАР ХОТ ... ХХК 5183855 9021031195 СТС2420

СЗХ
он сар өдөр
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2024-05-17
БҮРТГЭВ-02

| | | | |
|---|---|---|---|
| | | | хариуцсан захирал. |

Компанийн дурдсан эрх бүхий албан тушаалтан нар нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:

| № | Нэрс/Шаардлага | Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, шүүх, цагдаа, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэх | Ял шийтгэл эдэлж байгаа эсэх (КтХ-ийн 84.3.2)* | Хувь хүн байх (КтХ-ийн 77.3, 83.2, 83.3) | СЗХ-ны тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаж буй эсэх |
|---|---|---|---|---|---|
| 1. | Б.Одгэрэл (Гүйцэтгэх захирал) | Үгүй | Үгүй* | Тийм | Тийм** |
| 2. | Х.Ичинхорлоо (Ерөнхий нягтлан бодогч, Ерөнхий зохицуулалт хариуцсан захирал) | Үгүй | Үгүй* | Тийм | Тийм** |
| 3. | П.Болорчулуун (Санхүүгийн удирдлага хариуцсан захирал) | Үгүй | Үгүй* | Тийм | Тийм** |
| 4. | Н.Эрдэнэтулга (Мэдээлэл, технологи хариуцсан захирал) | Үгүй | Үгүй* | Тийм | Тийм** |
| 5. | Э.Мөнхэлгэр (Бүтээгдэхүүн хөгжүүлэлт хариуцсан захирал) | Үгүй | Үгүй* | Тийм | Тийм** |



УЛААНБААТАР ХОТ
ХХК
5183855
9021031195

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6. | **Б.Нямжаргал** (Мөнгөн гүйвуулга хариуцсан захирал) | Үгүй | Үгүй* | Тийм | Тийм** |
| 7. | **Д.Баярбат** (Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан захирал) | Үгүй | Үгүй* | Тийм | Тийм** |
| 8. | **М.Мөнхгэрэл** (Санхүү хариуцсан захирал) | Үгүй | Үгүй* | Тийм | Тийм** |

**Компанийн тухай хуулийн 84.3.2-т заасан ял шийтгэл эдэлсэн байх шаардлагыг ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтан хангаж байгаа эсэхийг бидэнд гаргаж өгсөн мэдүүлэг, баталгаа, материалд үндэслэж дүгнэв.*

***Эрх бүхий албан тушаалтны нь СЗХ-ны тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаж буй эсэхийг тэдний гаргасан баталгааг үндэслэж дүгнэв.*

**Б.Одгэрэл, Х.Ичинхорлоо, Б.Нямжаргал нар компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байгаа нь компанийн засаглалын болон мэргэжлийн үйл ажиллагаа явуулах талаар зохих мэдлэг туршлагатайг харуулж байна.**

**Дүгнэвэл, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, бусад эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекс, Тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангаж байгаа бөгөөд тэдгээр нь Компанийг удирдах чадвар, дадлага туршлагатай гэж дүгнэв.**

СЗХ 2024 оны 06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-17 БҮРТГЭВ-02

***Компанийн дүрэм.*** Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 01 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар "Сэндли ББСБ" ХК-ийн дүрэм (цаашид "Дүрэм" гэх)-ийг (Хавсралт 1.4) баталсан байна. Дүрмээр нийтлэг үндэслэл, компанийн үйл ажиллагаа, компанийн хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгө, компанийн удирдлага, хяналтын тогтолцоо, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд, ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх удирдлага, түүний бүрэн эрх, ТУЗ-ийн дэргэдэх хороод, дотоод хяналт, хөндлөнгийн аудит, компанийн санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл тайлан, сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл батлах, компанийн эрх бүхий албан тушаалтан, хүлээх хариуцлага, үнэт цаас худалдах, эргүүлэн авах, ногдол ашиг хуваарилан олгох, компанийн өөрчлөн байгуулах, татан буулгах тухай нийт 5 бүлэг, 24 зүйл зохицуулалтыг тодорхойлсон байна. Энэхүү дүрэм нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн тухай хууль, СЗХ-ны 2016 оны 03-р сарын 11-ний өдрийн 71 дугаар тогтоолоор баталсан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн болно.

**Компанийн үндсэн үйл ажиллагаанд хамаарах журам**

***Хөдөлмөрийн дотоод журам.*** (Хавсралт 3.1). "Сэндли ББСБ" ХК-ны зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын хөдөлмөр зохион байгуулалт, ажил олгогч болон ажилтны эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, хяналт тавих, хөдөлмөрийн бусад харилцааг зохицуулах зорилгоор Компанийн гүйцэтгэх захирлын 2024 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн А/01 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар нийт 15 бүлэг зохицуулалтаас бүрдэх Хөдөлмөрийн дотоод журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, Сэндли ББСБ ХК-ийн удирдлага, зохион байгуулалт, Сэндли ББСБ ХК-ийн дотоод үйл ажиллагаа, эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, нэгдсэн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, ажилтныг ажилд авах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дуусгавар болгох, цуцлах, ашиг сонирхлын зөрчил, ажил хүлээлцэх, ажил олгогч, ажилтны эрх, үүрэг, ажил, амралтын цаг, чөлөө, урамшуулал, суутгал, ажилтанд үзүүлэх хөнгөлөлт, тусламж, тэтгэмж, нөхөн олговор, ажилтанд хориглох зүйл, хөдөлмөрийн сахилгын болон эд хөрөнгийн хариуцлага, хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт хяналтыг тодорхойлсон байна. Компанийн тухай хуулийн 83.1, Компанийн дүрмийн 9.8.9 дэх заалтад заасан бүрэн эрхийн дагуу, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэгт заасны дагуу Компанийн гүйцэтгэх захирал нь Хөдөлмөрийн дотоод журмыг баталсан байх ба энэхүү журам нь Хөдөлмөрийн тухай хуулийн зөрчилгүй байна.

***Зээлийн үйл ажиллагааны журам.*** (Хавсралт 3.2) Гүйцэтгэх захирлын 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/17 тоот тушаалын Хавсралтаар харилцагчийн зээлийн хүсэлт хүлээн авч, судлах, зээл олгох, ашиглалтад хяналт тавих, үндсэн зээл болон хүүг төлүүлэх, зээлийн барьцааны зүйл, үнэлгээ тогтоох, шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг үйл ажиллагаатай холбогдон гарах харилцааг зохицуулах зорилгоор нийт 10 бүлгээс бүрдсэн Зээлийн үйл ажиллагааны журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар нийтлэг үндэслэл, зээлийн шийдвэр гаргах үйл ажиллагаа, баримтлах үндсэн зарчим, зээлийн хороо, түүний хэлэлцэх асуудал, зээлдэгчид тавигдах шаардлага, зээл судлах, олгох, зээлд хяналт тавих, төлүүлэх, зээлийн хугацаа сунгах,



УЛААНБААТАР ХОТ ... ХХК 5183855 9021031195 ... 2420

хугацаа хэтэрсэн зээл төлүүлэх үйл ажиллагаа, зээлийн барьцааны зүйл, үнэлгээ, зээлийн бүтээгдэхүүн, судалгаа шинжилгээ, ажилтны хүлээх хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү журмыг Компанийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/15 тоот тушаалаар шинэчлэн боловсруулж, 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/17 тоот тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Энэхүү журам болон түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

***Зээлийн бодлого.*** (Хавсралт 3.3) Харилцагчдын санхүүгийн хэрэгцээнд нийцсэн зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох, зээлийн үйл ажиллагаанд хяналтын тогтолцоог хэрэгжүүлж, зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 06 тоот тогтоолын хавсралтаар нийт 5 бүлгээс бүрдэх Зээлийн бодлого (Хавсралт )-ыг батлан мөрдүүлж байна. Энэхүү Зээлийн бодлого нь Компанийн зээлийн үйл ажиллагаа, зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, барьцаа болон зээлийн багцын талаар баримтлах бодлого болон зээлийн эрсдэлийн удирдлага, хяналтын бодлогыг тодорхойлсон. Энэхүү бодлого нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох дүрэм, журамд нийцэж байна.

***Дотоод хяналтын үйл ажиллагааны журам.*** (Хавсралт 3.4) ББСБ-ын хяналт, шалгалтын нэгжийн үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ, зарчим, зохион байгуулалт болон хянан шалгагчийн эрх, үүргийн тодорхойлж, хяналт, шалгалтын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор компанийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/10 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар батлан мөрдүүлж байна. Энэхүү дотоод хяналтын үйл ажиллагааны журам нь зорилго, нэр томьёо, хамрах хүрээ, чиг үүрэг, хянан шалгагчийн ёс зүй, хянан шалгагчийн эрх, үүрэг, хориглох үйл ажиллагаа, хяналтын нэгжийн үйл ажиллагааны төрөл, хяналт төлөвлөлтийн ажлыг төлөвлөх үе шатууд, газар дээрх болон зайны хяналт шалгалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хяналт, хариуцлагын харилцааг зохицуулсан. Энэхүү журам нь 2011 оны Засгийн газрын 311 тоот тогтоол, Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хуульд нийцсэн байна. Мөн хяналтын нэгжийн үйл ажиллагааны төрөл нь Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журамд заасан хяналт шалгалтын үйл ажиллагааны төрөлтэй нийцсэн байна.

***Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам.*** (Хавсралт 3.5) Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/10 тушаалын Хавсралт 2-оор Компаниар дамжуулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, сэжигтэй харилцагчийг таньж мэдэх, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор нийт 7 бүлгээс бүрдсэн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль", Санхүүгийн зохицуулах хорооны баталсан "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам" зэрэг эрх бүхий байгууллагаас баталсан журам зааврыг зөрчсөн зүйл байхгүй байна.

***Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр.*** (Хавсралт 3.6) Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх

тухай хуулийн 14.1-д дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй байна гэсний дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 06 тоот тогтоолын Хавсралт 2-оор Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үнэт цаас гаргагчийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журмын хэрэгжилтийг хангах, банк бусаар дамжуулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүрээнд эрсдэлийг тодорхойлох, харилцагчид үнэлгээ өгөх, түүнд үндэслэн эрсдэлийн түвшинээр ангилах, удирдах, хянах зорилгоор нийт 6 бүлгээс бүрдсэн хөтөлбөр баталсан байна. Энэхүү хөтөлбөр нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Монголбанкнаас баталсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх үйл ажиллагааны журамд нийцсэн байна.

***Комплаенсийн үйл ажиллагааны журам.*** (Хавсралт 3.7) Банк бус санхүүгийн байгууллагын комплаенсийн бодлого болон комплаенсийн эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх хүрээнд ББСБ-д учирч болзошгүй комплаенсийн эрсдэлийг тодорхойлох, бууруулах, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Компанийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн А/10 тоот тушаалын хавсралт №3-аар баталсан нийт 7 бүлгээс бүрдэх Комплаенсийн үйл ажиллагааны журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү Комплаенсийн үйл ажиллагааны журам нь нийтлэг үндэслэл, нэр томьёоны тодорхойлолт, ББСБ-ын комплаенсийн үйл ажиллагаа, комплаенсийн ажилтны эрх хэмжээ, тайлагнах, комплаесийн үйл ажиллагааны хяналт, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан. Энэхүү журам нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам, Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журамд нийцсэн байна.

***Комплаенсийн болон мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх аргачлал.*** (Хавсралт 3.8) 2024 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн гүйцэтгэх захирлын А/07 тушаалаар баталсан байна. Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, ББСБ-н Комплаенсын бодлого, Комплаенсын үйл ажиллагааны журам болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг хангах, учирч болзошгүй комплаенсын болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэхэд ашиглах зорилгоор нийт 5 бүлгээс бүрдсэн Комплаенсийн болон мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх аргачлалыг батлан мөрдүүлж байна. Энэхүү аргачлалаар нийтлэг үндэслэл, Комплаенсийн эрсдэлийг үнэлэх, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх, үнэлгээнд ашиглах шалгуур үзүүлэлт, эрсдэлийн түвшин, хяналт тайлагналтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Уг аргачлал нь Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

***Тусгай активын нэгжийн үйл ажиллагааны журам.*** (Хавсралт 3.9) 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн Гүйцэтгэх захирлын А/20 тушаалын хавсралтаар баталсан байна. ББСБ-ийн олгосон зээл, авлага бусад актив хөрөнгийг төлүүлэх, хянах, салбарт заавар чиглэл өгөх, болзошгүй хохирлыг бууруулах, үр ашигтай тогтолцоог бий болгож хэрэгжүүлэх зорилгоор нийт 5 бүлгээс бүрдсэн "Сэндли ББСБ" ХК-ийн чанаргүй актив төлүүлэх тусгай активын нэгжийн үйл ажиллагааны журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар нийтлэг үндэслэл, тусгай активын нэгжид чанаргүй актив шилжүүлэх үйл ажиллагаа, чанаргүй актив төлүүлэх үйл ажиллагаа, чанаргүй актив шилжүүлэхэд гарах зардал, болон бусад зүйлтэй холбоотой харилцааг зохицуулсан. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам, Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.



СЗХ 2024 оны 05 сар 10 өдөр БҮРТГЭВ № 11
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02
УЛААНБААТАР ХОТ ХХК 5183855 9021031195

*Эрсдэлийн үнэлгээ хийх, хяналт тавих журам* (Хавсралт 3.10) 2023оны 06 дугаар сарын 16-ны өдрийн Гүйцэтгэх захирлын А/21 тушаалын хавсралтаар баталсан байна. Зах зээл, хөрвөх чадвар, зээлийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, зохистой удирдах, хянах болон урьдчилан сэргийлэх замаар ББСБ-ын хүлээж болзошгүй хохирлыг бууруулах зорилгоор нийт 8 бүлгээс бүрдсэн Эрсдэлийн үнэлгээ хийх, хяналт тавих журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар нийтлэг үндэслэл, эрсдэлийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцох, үнэлэх, капиталын хүрэлцээний үзүүлэлтийн зохистой харьцаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа, актив хөрөнгийн үзүүлэлтийн зохистой харьцаа, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн үзүүлэлтийн зохистой харьцаа, газар, хэлтсийн эрх үүрэг, хяналт хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэ журам нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна

*Мөнгөн гүйвуулгын журам.* (Хавсралт 3.11) Олон улсын мөнгөн гүйвуулгын үйлчилгээгээр харилцагч Гадаад улсаас Монгол улс руу, Монгол улсаас гадаад улс руу мөнгөн гүйвуулга илгээх, хүлээн авахтай холбоотой үүсэх харилцааг зохицуулах зорилгоор Гүйцэтгэх захирлын 2022 оны 3-р сарын 24 өдрийн А/10 тоот тушаалын 4-р хавсралтаар батлан мөрдүүлж байна. Энэхүү мөнгөн гүйвуулгын журам нийтлэг зүйл, журмын нэр томьёо, мөнгөн гүйвуулгын үйлчилгээнд тавигдах шаардлага, үйлчилгээний нөхцөл, төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулга илгээх, хүлээн авах, шилжүүлэх, гүйлгээг буцаах, валютын ханш, Тест гүйлгээ, тайлан, мэдээ, эрхийн түвшин буюу мэдээллийн аюулгүй байдал, хариуцлага, хяналттай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү журам нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нийцсэн байна.

*Итгэлцлийн үйлчилгээний журам.* (Хавсралт 3.12) Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу итгэлцлийн үйлчилгээтэй холбогдсон "Сэндли" Банк бус санхүүгийн байгууллага болон итгэлцэл үүсгэгч талуудын хоорондын харилцааг зохицуулах зорилгоор Компанийн 2024 оны 01 дүгээр сарын 2-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 01 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар нийт 10 бүлгээс бүрдэх Итгэлцлийн үйлчилгээний журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү итгэлцлийн үйлчилгээний журам нь нийтлэг үндэслэл, нэр томьёо, итгэлцлийн үйлчилгээний нөхцөл, баримтлах зарчим, тайлагнал, итгэмжлэгчид тавигдах шаардлага, хөрөнге иттэмжлэх гэрээ байгуулах, нягтлан бодох бүртгэлд тусгах, кувийн хэргийн бүрдүүлбэр болон хадгалалт хамгаалал, хяналт, хариуцлагатай холбоотой харилцаар зохицуулсан нь Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 09 дүгээр 01-ний өдрийн 434 дугаар тогтоолоор баталсан Итгэлцлийн үйлчилгээний журамд нийцсэн байна.

*Факторингийн үйл ажиллагааны журам.* (Хавсралт 3.13) Факторингийн үйл ажиллагааны журмыг зээлдүүлэгч буюу үүрэг гүйцэтгэгчээс мөнгөн төлбөрийн үүргийн шаардах эрхийг шилжүүлэн авах, эрхээ хэрэгжүүлэх болон үүсэн гарах харилцааг зохицуулах зорилгоор компанийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/10 тоот тушаалын 6 дугаар хавсралтаар батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь шаардах эрхээ шилжүүлэх зохицуулалт, түүний үйл ажиллагааны бүрдэл, хяналт, хариуцлага, бусад харилцааг зохицуулсан байна. Шаардах эрхээ шилжүүлэх зохицуулалтын тухайд Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хууль болон Иргэний хуулийн Эдийн бус хөрөнгө олж авах 122 дугаар зүйл, Шаардах эрхээ шилжүүлэх 123 дугаар зүйлд нийцсэн байна. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 5 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Банк

бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн зааврын дагуу Факторингийн авлагын бүртгэл, Факторингийн авлагын эрсдэлийн сан /ФАЭС/-ийн бүртгэл, Факторингийн тооцоогоор үүссэн авлагын ангиллыг өөрчлөлтийн бүртгэлийг хийхээр тусгасан байна.

***Төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам.*** (Хавсралт 3.14) Төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагааны журмыг иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн гуравдагч этгээд буюу үүрэг гүйцэтгүүлэгчид баталгаа гаргах зорилгоор компанийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/10 тоот тушаалын 7 дугаар хавсралтаар батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, нэр томьёо, баталгааны төрөл, ангилал, баталгаа гаргахад баримтлах ерөнхий нөхцөл, төлбөрийн баталгаа гаргах, баталгааны нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, баталгааны дагуу төлбөр гүйцэтгэх, баталгааг цуцлах, дуусгавар болгох, тайлан мэдээ, баталгааны үйл ажиллагаанд тавих хяналт, хариуцлагыг зохицуулсан нийт 11 бүлэг, 4 хавсралтаас бүрдэнэ. Журам нь Иргэний хуулийн 234 дүгээр зүйл, 457 дугаар зүйлд нийцсэн ба тус журамд заасан банк бус санхүүгийн байгууллагаас гаргах төлбөрийн баталгааны дүн нь Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хуульд заасан дүнтэй нийцэж байна.

***Гадаад валютын арилжааны журам.*** (Хавсралт 3.15) Гүйцэтгэх захирлын 2022 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн А/14 тоот тушаалын хавсралтаар гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн дагуу компанийн салбаруудад гадаад валютыг арилжаалах, энэхүү үйл ажиллагаанаас ашиг олох болон уг арилжаанд оролцох албан тушаалтнуудын эрх, үүргийг тодорхойлох, тэдгээртэй холбогдон гарах бусад харилцааг зохицуулах зорилгоор нийт 9 бүлгээс бүрдсэн Гадаад валютын арилжааны журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар нийтлэг үндэслэл, журмын нэр томьёо, арилжаа хийхэд мөрдөгдөх зарчим, самбарын болон дотоод ханш, ханш зарлах, түүнийг мөрдөх, арилжааг хязгаарлах, арилжааг хийж гүйцэтгэх, арилжааны орлого хуваарилах, арилжааны гүйлгээ болон хяналт, хариуцлага зэргийг зохицуулсан байна. Энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зарчим болон холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

***Орон сууц худалдан авах зээлийн үйл ажиллагааны журам.*** (Хавсралт 3.16) Гадаад улсад албан ёсоор амьдарч, хөдөлмөр эрхэлж буй Монгол Улсын иргэн Монгол Улсад байршилтай орон сууцыг худалдан авахад зориулан зээлийн хүсэлтийг хүлээн авч, судалгаа шинжилгээ хийх, зээл олгох тухай шийдвэр гаргах, зээлийн зарцуулалт, эргэн төлөлтөд хяналт тавих, зээлийг төлүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулах зорилгоор Гүйцэтгэх захирлын 2022 оны 2-р сарын 01-ний өдрийн А/05-01 тоот тушаалын 1-р хавсралтаар батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар зээлийн тодорхойлолт, зориулалт, нэр томьёо, зээл олгох нөхцөл, барьцааны зүйлд тавигдах шаардлага, зээлдэгчид тавигдах шаардлага, бүрдүүлэх материал, зээлийн судалгаа шинжилгээ, зээл олголт, зээлийн хувийн хэрэг, зээлийн төлбөр хүлээн авах, зээлийг төлүүлэх, зээлийн хяналттай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү журам нь Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нийцсэн байна.

***Бизнес картын зохицуулалтын заавар.*** (Хавсралт 3.17) Энэхүү заавраар тус компанийн бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны зорилтот түвшинг биелүүлэх, бизнес хамтын ажиллагааг сайжруулах, багийн ажиллагааг сайжруулж, гүйцэтгэлийг дэмжихэд зориулж Гүйцэтгэх захирлын баталсан лимитийн дагуу компанийн ажилтнуудад бизнес карт олгох, нээх, хаах,

СЗХ 2024 .06 сар 10 өдөр БҮРТГЭВ №01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

зарцуулалтын тооцоог хийхтэй холбоотой харилцааг зохицуулж байгаа бөгөөд хууль тогтоомжинд нийцсэн байна.

***Хөрөнгийн үнэлгээний заавар***. (Хавсралт 3.18) ББСБ-ын зээлийн үйлчилгээнд хөрөнгө барьцаалах үндэслэл, барьцаа хөрөнгөд үнэлгээ хийх аргачлалыг тогтоохтой холбоотой харилцааг зохицуулах зорилгоор Компанийн гүйцэтгэх захирлын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 17/05 тоот тогтоолын хавсралтаар нийт 6 бүлгээс бүрдэх Хөрөнгийн үнэлгээний зааврыг батлан мөрдүүлсэн байна. Энэхүү заавар нь нийтлэг үндэслэл, нэр томьёоны тодорхойлолт, хөрөнгийн үнэлгээ хийх үндэслэл, хөрөнгийн үнэлгээ хийх арга, аргачлал, бусад, хариуцлага гэсэн үндсэн зохицуулалтаас бүрдэх ба зааврын хавсралтаар Зээлийн барьцаа хөрөнгө болох тээврийн хэрэгсэл, орон сууц (орон сууц, амины сууц, хашаа байшин, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж)-ны үнэлгээг тодорхойлох хүснэгтийн загварыг баталсан байна. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19.11-т зааснаар зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээтэй холбогдсон журмыг Санхүүгийн Зохицуулах хороо, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батлахаар зохицуулсан боловч СЗХ-ноос энэ талаар журам хараахан батлагдаагүй байна. ББСБ-аас олгосон зээлийн гэрээний барьцаа хөрөнгийг хэрхэн үнэлэх талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй тул үнэлгээ хийх аргачлал, үндэслэл нь аливаа хуулийн зөрчилгүй гэж үзнэ. Зааврын үндэслэлийг хянан үзвэл, энэ зааврын зорилт нь Сэндли ББСБ-ын зээлийн барьцаа хөрөнгөд үнэлгээ хийх, барьцаанд авах үндэслэлийг тогтоож, МУ-ын Үндсэн хууль, Иргэний хууль Зөвшөөрлийн тухай хууль, Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль, Банк бус санхүүгийн байгууллагны тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан ББСБ-ын эрх бүхий этгээдийн баталсан, заавар журмыг мөрдөж ажиллах, холбогдох арга хэмжээ, үйл ажиллагаатай холбогдох харилцааг зохицуулахаар заасан.

***Нийгмийн хөгжлийн санг байгуулах, зарцуулах журам***. (Хавсралт 3.19) Нийгмийн хөгжлийн санг бүрдүүлэх болон зарцуулахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах зорилгоор Гүйцэтгэх захирлын 2022 оны 2-р сарын 14-ний өдрийн А/06-01 тоот тушаалын хавсралтаар батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар нийтлэг үндэслэл, нийгмийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, хуваарилалт, нийгмийн хөгжлийн сангийн зарцуулалт, үүрэг хариуцлагатай холбоотой 4 бүлэг харилцааг зохицуулсан байна.

**Компанийн засаглалын бодлого, журам**

***ТУЗ-ийн үйл ажиллагааны журам***. (Хавсралт 3.20) ТУЗ, түүний чиг үүрэг, ТУЗ-ийн гишүүдэд тавигдах шаардлага, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох, чөлөөлөх нөхцөл, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүн, ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын бүрэн эрх, үүрэг, хариуцлага, гишүүдийн үйл ажиллагааг дүгнэх, ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг, ТУЗ-ийн хурлыг зарлах, түүнд бэлтгэх, хуралдуулах, шийдвэр гаргах, шийдвэрийг мэдээлэх, биелэлтэд хяналт тавих, ТУЗ-ийн дотоод үйл ажиллагаа, гишүүдийн цалин, урамшуулал олгох зэрэг ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор нийт 15 бүлэг 7 хавсралтаас бүрдсэн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг 2024 оны 03 дүгээр сарын 26-ны өдрийн хурлын 11 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан байна. Журмын 2.3-т ТУЗ нь 9 болон түүнээс дээш гишүүнтэй байхаар зохицуулсан нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2-т заасан хувьцаат компани нь төлөөлөн удирдах зөвлөлтэй байх, мөн хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-т заасан хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байна гэсэн шаардлагад нийцэж байна. ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 10 дугаар бүлэгт ТУЗ нь цалин урамшууллын хороо, нэр



УЛААНБААТАР ХОТ КАПИТАЛ ҮЦК ХХК 5183204 9021031195 СТС2420

дэвшүүлэх хороо, аудит, эрсдэлийн удирдлагын хороотой байхаар зохицуулсан нь Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2-т заасан хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх гэсэн шаардлагад нийцсэн байна.

ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 11.1-д "ТУЗ-ийн хурлаар тухайн жилийн ТУЗ-ийн хурлын товыг батлах бөгөөд улирадд нэгээс доошгүй удаа хуралдуулна. Шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал хийж болно..." гэж заасан нь Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1-т Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хурал хийж болно, Компанийн дүрмийн 8.8-д "ТУЗ-ийн хурлыг улиралд нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн дарга, Компанийн Гүйцэтгэх захирлын санаачилгаар эсвэл ТУЗ-ийн дэргэдэх хорооны саналаар нэмэлт хурал хуралдуулж болно" гэж зохицуулсантай нийцэж байна. Нэгтгэн дүгнэвэл, энэхүү журам нь Компанийн тухай хуульд нийцэж байна.

***Эрсдэлийн удирдлагын бодлого.*** (Хавсралт 3.21) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, хянах замаар компанийн хүлээж болзошгүй хохирлыг бууруулах эрсдэлийн удирдлагын үр ашигтай тогтолцоог бий болгож хэрэгжүүлэх зорилгоор нийт 12 бүлгээс бүрдсэн эрсдэлийн удирдлагын бодлогыг баталсан байна. Энэхүү бодлого нь нийтлэг үндэслэл, бодлогын зорилт, үндсэн зарчим, эрсдэлийн төрөл, эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэх үе шат, эрсдэлийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт, зээлийн, зах зээлийн, үйл ажиллагааны, хөрвөх чадварын, нэр хүндийн, стратегийн болон комплаенсийн эрсдэлийн удирдлага, эрсдэлийн шинжилгээ ба тайлагналт болон хяналт хариуцлага хүлээлгэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Мөн Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 12 тоот тогтоол (Хавсралт 3.43)-оор компанийн Эрсдэлийн удирдлагын бодлогод өөрчлөлт оруулж, мэдээллийн аюулгүй байдал болон байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийг нэмж тодорхойлсон байна.

***Хүний нөөцийн бодлого.*** (Хавсралт 3.22) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 08 тоот шийдвэрийн хавсралтаар мэргэжлийн болон харилцааны чадвар чадавхтай өндөр бүтээмжтэй хүний нөөцийг бүрдүүлэх, сургаж хөгжүүлэх, компанийн өмнө тавьсан зорилго зорилтод хүрэхэд дэмжин ажиллах хүсэл эрмэлзэлтэй ажилтныг төлөвшүүлэх, ажлын гүйцэтгэл сайн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, ажилтан бүрийн хувийн ур чадварыг бүрэн нээж хөгжүүлэн оновчтой үр бүтээлтэй ашиглах компанийн хүний нөөцийн менежментийн үндсэн чиглэл, баримтлах үндсэн зарчим, эрхэмлэх зүйлсийг тодорхойлох, компанийн амжилтад оруулсан хувь нэмрээ шударгаар үнэлүүлэн урамшуулан шагнагдах, албан тушаал ахих нөхцөлүүдийг бүрдүүлэх зорилгоор нийт 11 бүлгээс бүрдсэн хүний нөөцийн бодлогыг баталсан байна. Энэхүү бодлогод удиртгал буюу бодлогын зорилго, үндсэн чиглэл, зарчмууд, үйл ажиллагаанд мөрдлөг болгох зүйлс, ажилтнуудад тавих шаардлага, нэр томьёо, хүний нөөцийн стратеги, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлүүд, хүний нөөцийн төлөвлөлт, ур чадварын тогтолцоо, ажлын байрны шинжилгээ ба тодорхойлолт, хүний нөөцийн бүрдүүлэлт, хүний нөөцийн сонголт, карьер хөгжлийн төлөвлөлт, хүний нөөцийн сургалт, хөгжүүлэлт, гүйцэтгэлийн удирдлага, цалин хөлс урамшуулал нийгмийн халамж, хөдөлмөрийн сахилга ба хариуцлага зэргийг тусгаж өгсөн байна.

***Ёс зүйн дүрэм.*** (Хавсралт 3.23) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 09 тоот шийдвэрийн хавсралтаар компани, түүний бүх ажилтанд Байгууллагын нууцын

тухай, Хувь хүний нууцын тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон компанийн дотоод дүрэм, журмаар тодорхойлсон зорилт, эрх, чиг үүргийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, ёс зүйн хэм хэмжээ, зан үйлийг тогтоон хэвшүүлэх, дагаж мөрдөх, ёс зүйн зөрчилтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор нийт 7 бүлгээс бүрдсэн Ёс зүйн дүрмийг баталсан байна. Энэхүү дүрэмд нийтлэг үндэслэл, нэр томьёоны тодорхойлолт, ёс зүйн зарчим, ёс зүйн хэм хэмжээ, зөрчлийг мэдээлэх, шийдвэрлэх, хяналт, хариуцлага, бусад зэргийг тусгасан байна.

***Хороодын ажиллах журам.*** (Хавсралт 3.24) Гүйцэтгэх захирлын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/02 тоот шийдвэрийн хавсралтаар хүний нөөцийн хороо, эрсдэлийн удирдлагын хороо, актив пассивын удирдлагын хороодын бүрэлдэхүүн, үйл ажиллагааны хэлбэр, зохион байгуулалт, хэлэлцэх асуудал, шийдвэр гаргалт болон гишүүдийн үүрэг хариуцлагатай холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор нийт 5 бүлэг, 6 хавсралтаас бүрдсэн Хороодын ажиллах журмыг баталсан байна. Энэхүү журамд ерөнхий зүйл, хүний нөөцийн хороо, эрсдэлийн удирдлагын хороо, актив пассивын удирдлагын хороо, хяналт хариуцлагын талаар тусгасан байна.

***Ногдол ашгийн бодлого.*** (Хавсралт 3.25) Төлөөлөн удирдах зөвлөлөөс баримтлах ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах нөхцөл, журмыг Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекст нийцүүлэн тодорхойлох зорилгоор Ногдол ашгийн бодлогыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 22/03 тоот тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталж, хүчин төгөлдөр мөрдөж байна. Энэхүү бодлого нь нийтлэг үндэслэл, ногдол ашиг хуваарилах нөхцөл, ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр, ногдол ашиг хуваарилах, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Ногдол ашгийн бодлого нь Компанийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

***Салбар, нэгжийн үйл ажиллагааны журам*** (Хавсралт 3.26) Гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/15 тоот тушаалын хавсралтаар салбарын бүтэц зохион байгуулалт, эрх, үүрэг, хариуцлага, үйл ажиллагааг зохицуулах зорилгоор нийт 9 бүлгээс бүрдсэн Салбар, нэгжийн үйл ажиллагааны журмыг баталсан байна. Тус журамд нийтлэг үндэслэл, салбарын бүтэц бүрэлдэхүүн, салбарын үйл ажиллагааны бүтэц бүрэлдэхүүн, салбарын үйл ажиллагааны зохион байгуулалт, тайлагнал, зээлийн үйл ажиллагаа, мөнгөн гүйвуулгын үйл ажиллагаа, валют арилжааны үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, кассын үйл ажиллагаа, аюулгүй ажиллагаа, хяналт, хариуцлагын талаар тусгасан байна.

Компани нь дор дурдсан нийт 57 салбар (Хавсралт 3.27)-ын үйл ажиллагааг тус журмаар зохицуулж байна. Үүнд:

| Салбарын байршил | Салбарын тоо |
|---|---|
| Улаанбаатар (Чингэлтэй дүүрэг 2, Баянзүрх дүүрэг 2, Сонгинохайрхан дүүрэг 1, Налайх дүүрэг 1, Багануур дүүрэг 1) | 7 |
| Архангай аймаг | 3 |
| Баянхонгор аймаг | 2 |
| Баян-Өлгий аймаг | 1 |
| Булган аймаг | 2 |
| Говьсүмбэр аймаг | 2 |
| Дархан-Уул аймаг | 2 |
| Дорноговь аймаг | 4 |
| Дорнод аймаг | 3 |

| | |
|---|---|
| Дундговь аймаг | 2 |
| Завхан аймаг | 2 |
| Орхон аймаг | 1 |
| Өвөрхангай аймаг | 5 |
| Өмнөговь аймаг | 3 |
| Сүхбаатар аймаг | 4 |
| Сэлэнгэ аймаг | 6 |
| Увс аймаг | 3 |
| Хэнтий аймаг | 4 |
| Төв аймаг | 1 |
| **Нийт** | **57** |

***Цалин урамшууллын бодлого.*** (Хавсралт 3.28) Компанийн цалин, урамшууллын зарчим, хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлж, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын багийн болон компанийн нийт ажилтнуудын цалин хөлс, урамшууллын тогтолцооны суурь зарчмыг тодорхойлох зорилгоор Цалин урамшууллын бодлогыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 22/09 тоот тогтоолын гуравдугаар хавсралтаар баталж, хүчин төгөлдөр мөрдөж байна. Энэхүү бодлого нь нийтлэг үндэслэл, үндсэн чиглэл, зарчим, ТУЗ, гүйцэтгэх удирдлагын баг, компанийн ажилтнуудын цалин урамшуулал тогтоох нөхцөлийг тодорхойлж, журмын биелэлтэд хяналт тавих, сайжруулахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэ бодлого нь Компанийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

***Залгамж халааны бодлого.*** (Хавсралт 3.29) Компанийн удирдах албан тушаалтны орон тоо гэнэт буюу төлөвлөгдөөгүйгээр өөрчлөгдсөнөөс үүдэн компанийн үйл ажиллагаа тасралтгүй, хэвийн явуулах, оролцогч талууд хохирохгүй байх нөхцөлийг хангах зорилгоор Залгамж халааны бодлогыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 22/09 тоот тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталж, хүчин төгөлдөр мөрдөж байна. Тус бодлогоор нийтлэг үндэслэл, бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагаа зэрэг харилцааг зохицуулсан байна.

***Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журам.*** (Хавсралт 3.30) Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, түүнтэй хийх хэлцлийг тодорхойлох компанийн үйл ажиллагаа дахь сонирхлын зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэхүү журмыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 22/09 тоот тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталж, хүчин төгөлдөр мөрдөж байна. Журам нь нийтлэг үндэслэл, нэгдмэл сонирхолтой этгээдийг тодорхойлох, бүртгэх, нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх сонирхлын зөрчилтэй хэлцлийг тодорхойлох, компани дахь сонирхлын зөрчлийг зохицуулах, журамд хяналт тавих, хариуцлага хүлээлгэх, болон бусад нөхцөлийг тодорхойлсон байна. Журам нь Компанийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

***ISO/IEC 27001 стандартыг нэвтрүүлэхтэй холбоотой журмууд***Компани нь ISO/IEC 27001 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж байгаатай холбоотойгоор дараах журмуудыг баталсан.

| № | Журмын нэр | Дугаар | Огноо | Баталсан |
|---|---|---|---|---|
| 1 | Мэдээллийн аюулгүй байдлын бодлого (Хавсралт 3.31) | 03 Хавсралт | 2023.01.11 | Төлөөлөн удирдах зөвлөл |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | Мэдээллийг хадгалах, хамгаалах, нөөцлөх журам (Хавсралт 3.32) | А/12 Хавсралт | 2023.03.17 | Гүйцэтгэх захирал |
| 3 | Мэдээлэл, мэдээллийн технологийн системийн нууцын журам (Хавсралт 3.33) | А/12 Хавсралт | 2023.03.17 | Гүйцэтгэх захирал |
| 4 | Мэдээлэл, мэдээллийн технологийн систем, сүлжээнд хандах хандлагыг хянах журам (Хавсралт 3.34) | А/12 | 2023.03.17 | Гүйцэтгэх захирал |
| 5 | Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам (Хавсралт 3.35) | А/12 Хавсралт | 2023.03.17 | Гүйцэтгэх захирал |
| 6 | Мэдээллийн аюулгүй байдлын дотоод аудит хийх журам (Хавсралт 3.36) | А/12 | 2023.03.17 | Гүйцэтгэх захирал |
| 7 | Мэдээллийн аюулгүй байдлын зөрчлийн үед ажиллах журам (Хавсралт 3.37) | А/12 Хавсралт | 2023.03.17 | Гүйцэтгэх захирал |
| 8 | Сүлжээ, сүлжээнд холбогдох тоног төхөөрөмжийн аюулгүй байдлын журам (Хавсралт 3.38) | А/12 Хавсралт | 2023.03.17 | Гүйцэтгэх захирал |
| 9 | Байр, байшингийн аюулгүй байдлын заавар (Хавсралт 3.39) | А/12 Хавсралт | 2023.03.17 | Гүйцэтгэх захирал |
| 10 | Бизнесийн мэдээлэл, мэдээллийн системийн үйл ажиллагааны тасралтгүй байдлын болон гэнэтийн аюулаас сэргээх төлөвлөгөө (Хавсралт 3.40) | А/12 Хавсралт | 2023.03.17 | Гүйцэтгэх захирал |
| 11 | Программ хангамжийн журам (Хавсралт 3.41) | А/12 Хавсралт | 2023.03.17 | Гүйцэтгэх захирал |
| 12 | Баримт бичгийн хяналтын журам (Хавсралт 3.42) | А/12 Хавсралт | 2023.03.17 | Гүйцэтгэх захирал |

Эдгээр журмуудыг олон улсын стандарт, холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгахад аливаа зөрчил илрээгүй болно.

Нэгтгэн дүгнэвэл, Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм, журмууд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, нийтэд санал болгон нэмж хувьцаа гаргаж буй үнэт цаас гаргагчийн хувьд түүний дотоод дүрэм, журмууд нь Хорооноос баталсан компанийн засаглалын кодекст нийцсэн эсэх Компанийн дүрэм, бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, СЗХ-оос баталсан журамд нийцсэн байна.

Бид тус Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн Компанийн үйл ажиллагаанд голлох ач холбогдол бүхий доор дурдсан гэрээг дараах ангиллын дагуу хянасан болно.

1. *Үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж буй гэрээ, загвар гэрээ*
2. *Гадаад хамтын ажиллагаатай холбоотой гэрээ, хэлцэл*
3. *Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд ашигладаг загвар гэрээ*
4. *Нэхэмжлэгч, хариуцагчийн хэрэгтэй холбоотой мэргэжлийн байгууллагуудтай байгуулсан гэрээ, хэлцэл*
5. *Зээлийн болон репо хэлцлийн гэрээ*
6. *Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ*

***I. Үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж буй гэрээ, хэлцэл:***

***Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ /Контракт/.*** Гүйцэтгэх захирал Б.Олгэрэл нь 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 03 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр ([illegible])-ээр томилогдсон. Компанийн тухай хуулийн 83.7-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Наранбаттай "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-г ([illegible])-г 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр шинэчлэн байгуулсан байна. Энэхүү гэрээг хугацаагүй байгуулсан бөгөөд гэрээгээр гэрээний зүйл, гол нөхцөл, хугацаа, ажлын цаг, ажил олгогчийн эрх, үүрэг, ажилтны эрх, үүрэг, цалин олгох, ажил дүгнэх, шагнах, урамшуулах нөхцөл, нууцлал, оюуны өмч, гэрээг дуусгавар болгох, цуцлах, хариуцлага тооцох, эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэх үндсэн болон бусад нөхцөлийг тодорхойлсон байна. Гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын гэрээ нь 2022 оны 01-р сарын 01-ээс хүчин төгөлдөр хэрэгжиж буй Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлд заасан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд хамаарах тул тус зохицуулалтад тавьсан шаардлагад нийцсэн байна.

| Түрээсийн гэрээ | Гэрээний огноо | Гэрээний дугаар | Гэрээний зүйл |
|---|---|---|---|
| *Түрээсийн гэрээ /Булган/* (Хавсралт 4.1) | 2024.03.13 | - | Булган аймаг, Булган сум, 5-р баг, Жаргалант Хатанбаатар С.Магсаржав, 2 гудамж, 222 тоотод байрлах талбай |
| *Түрээсийн гэрээ /Дорноговь/* (Хавсралт 4.2) | 2023.02.01 | 2023/01 | Дорноговь аймаг, Сайншанд сум, 3-р баг, Залуучууд 301 тоот хаягт байрлах талбай |
| *Түрээсийн гэрээ /Архангай/* (Хавсралт 4.3) | 2023.03.01 | 01/23 | Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 3-р баг, Мөйлт худалдааны төвийн 3-р давхар хаягт байрлах 20 кв.м талбай |
| *Түрээсийн гэрээ /Дорнод/* (Хавсралт 4.4) | 2022.05.10 | 2022/02 | Дорнод аймаг, Хэрлэн сум, 9-р баг, Сити Центр, 07 тоот хаягт байрлах үйлчилгээний зориулалттай талбай |
| *Түрээсийн гэрээ /Баян-Уул/* (Хавсралт 4.5) | 2023.05.22 | - | Үзвэр үйлчилгээний танхим |

СЗХ 2024.05.10 он сар өдөр БҮРТГЭВ № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

| | | | |
|---|---|---|---|
| *Түрээсийн гэрээ /Багануур/* (Хавсралт 4.6) | 2023.08.15 | 2023/071701 | Багануур дүүргийн 1-р хороо, 7-р байрны 02 тоотод байрлах үл хөдлөх хөрөнгө |
| *Түрээсийн гэрээ /Онгон соёлын төв/* (Хавсралт 4.7) | 2023.01.01 | - | Сүхбаатар аймаг, Онгон сум, 5-р баг, Соёлын төвийн 1-р давхар хаягт байрлах талбай |
| *Түрээсийн гэрээ /Налайх/* (Хавсралт 4.8) | 2022.11.23 | 2021/11231 | Налайх дүүрэг 2-р хороо, Жаргалант Д.Даваажавын гудамж 13-р байр 1 давхарт хаягт байрлах үйлчилгээний зориулалттай талбай |
| *Түрээсийн гэрээ /Баянзүрх/* (Хавсралт 4.9) | 2023.10.02 | 2021/07 | Баянзүрх дүүрэг, 6-р хороо, Энхтайвны өргөн чөлөө гудамж, 64-р байр, V1 тоот |
| *Түрээсийн гэрээ /Чингэлтэй дүүрэг/* (Хавсралт 4.10) | 2024.04.12 | 0470 | Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 40, 50 мянгат /15171/, Бакула Ренбүчи гудамж 8/4 тоот хаяг байрлах үйлчилгээний зориулалттай 1 давхрын талбай |
| *Түрээсийн гэрээ /Зуун мод/* (Хавсралт 4.11) | 2022.03.01 | 2022 | Төв аймаг, Зуунмод сум, Улаанзагалмайн урд байрдах Могул төв, 3-р давхар хаягт байрлах талбай |
| *Түрээсийн гэрээ /Дэнжийн мянга/* (Хавсралт 4.12) | 2024.03.07 | - | Дэнжийн мянга төвийн 2 давхарт байрлах талбай |
| *Түрээсийн гэрээ /Сүхбаатар аймаг/* (Хавсралт 4.13) | 2023.11.03 | | Сүхбаатар аймаг, Мөнххаан сум, 4-р баг, Баясгалант хийдийн 3-р гудамж, 1 тоот хаягт байрлах талбай |
| *Үйлчилгээ үзүүлэх гэрээ /Цагаан-Овоо/* (Хавсралт 4.14) | 2023.01.05 | - | Цэвэрлэгээ, үйлчилгээ үзүүлэх |
| *Түрээсийн гэрээ /Нарантуул/* (Хавсралт 4.15) | 2023.01.10 | - | Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 18-р хороо, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж 19/1-403 тоот хаягт байрлах талбай |
| *Түрээсийн гэрээ /Ховд/* (Хавсралт 4.16) | 2023.06.23 | 2023/06241 | Ховд аймгийн жаргалант Баатарсайхан баг, Д.Сандагийн гудамж 1 дүгээр гудамж, 123а тоот хаягт байрлах талбай |
| *Түрээсийн гэрээ /Хархорин/* (Хавсралт 4.17) | 2023.05.01 | №3 | Сонгинохайрхан дүүрэг, 17-р хороо, 1-р хороолол, Москва гудамж 43/а байр, 2 давхарын талбай |
| *Түрээсийн гэрээ /Хөвсгөл/* (Хавсралт 4.18) | 2023.07.03 | 20230701/01 | Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 6-р баг, 6-р гудамж, 1 тоот хаягт байрлах талбай |
| *Түрээсийн гэрээ /Central branch/* (Хавсралт 4.19) | 2022.05.01 | - | Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 40, 50 мянгат /15171/, Бакула Ренбүчи гудамж 8/4 тоот хаяг байрлах үйлчилгээний зориулалттай 1 давхрын талбай |



УЛААНБААТАР ХОТ ХХК 9021031195 СТС2420

СЗХ 2024.06.10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар зарим Түрээсийн гэрээ (Хавсралт 4.11, 4.12, 4.15)-ний хугацаа дууссан боловч гэрээний үүрэг хэвийн хэрэгжиж байгаа, гэрээний хугацааг сунгахаар ажиллаж байгаа талаар Компанийн гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.1).

Үл хөдлөх хөрөнгийн тодорхой хэсгийг түрээслэж буй тохиолдолд Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.3 дахь хэсэгт заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлагагүй талаарх шүүхийн практикийн дагуу зарим түрээсийн гэрээ (Хавсралт 4.2, 4.3, 4.7, 4.9, 4.13, 4.17) нь холбогдох бүртгэлд бүртгэгдээгүй байж болно. Бусад гэрээ нь Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.3-т заасны дагуу зохих ёсоор улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

***Танилт, нэвтрэлтийн систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ.*** Компани нь Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай Танилт, нэвтрэлтийн системд холбогдож, мэдээллийг хүлээж авахтай холбоотой үүсэн харилцааг зохицуулахаар 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр 2022/01, "Танилт, нэвтрэлтийн систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ" (Хавсралт 4.20)-г 3 жилийн хугацаатайгаар 2025 оны 12 дугаар сарын 14-ний өдрийг дуустал хугацаагаар байгуулжээ. Энэхүү гэрээнд Нийтлэг үндэслэл, Талуудын эрх үүрэг, Гэрээний хугацаа, Гэрээний төлбөр, Давагдашгүй хүчин зүйлс, Талуудын хүлээх хариуцлага, Гэрээнээс үүдэлтэй маргаан шийдвэрлэх, Бусад зүйлс, Хавсралт гэсэн 9 зүйл, 1 хавсралтаас бүрдсэн байна.

"ХУР" системээр дамжуулан мэдээлэл хүлээн авах ажиллагаа нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журамд нийцсэн байна.

***Хамтын ажиллагааны гэрээ*** (Хавсралт 4.21) ББСБ нь Монголбанкны ажиллуулж буй зээлийн мэдээллийн санд болон зээлдүүлэгчид байгаа иргэд, аж ахуй нэгжийн зээл, хүлээж буй болзошгүй үүрэг, үнэт цаас, бусад актив, алдаа өр төлбөр болон холбогдох бусад мэдээллийг харилцан солилцохтой холбоотой харилцааг зохицуулахаар Монголбанктай 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдөр 0619/281 тоот "Хамтын ажиллагааны гэрээ"-г байгуулжээ. Энэхүү гэрээ нь Зээлийн мэдээллийн тухай хуулийн 28.3 дахь хэсэгт нийцсэн байна.

***Програм хангамж түрээслэж ашиглах гэрээ*** (Хавсралт 4.22) ББСБ нь ГрэйпСити Монгол ХХК-тай харилцагч, харилцагчийн данс, хугацаат хадгаламж, барьцаа хөрөнгө, зээл, монголбанкны зээлийн мэдээллийн сан руу мэдээлэл илгээх, дотоодын данс, балансын гадуурх данс, ерөнхий дэвтэр, МОСТ платформын интерфэйс буюу поларис суурь системийг түрээслэж ашиглах, түүнтэй холбогдон гарах нэвтрүүлэлтийн ажил, дагалдах засвар үйлчилгээг хүргэх болон мэдээллийн нууцлал, төлбөр тооцоотой холбогдсон харилцааг зохицуулахаар 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдөр ЛА-21/50 тоот "Програм хангамж түрээслэж ашиглах гэрээ"-г байгуулсан. Энэхүү гэрээгээр гүйцэтгэх ажил, техникийн шаардлага, төслийн үе шат ба хугацаа, төслийн хяналт ба хэрэгжилт, гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл, нэвтрүүлэлтийн дараах засвар үйлчилгээ, төслийн баг, талуудын эрх, үүрэг, хариуцлага, мэдээллийн нууцлал, оюуны өмч ба зохиогчийн эрх, хэвлэн нийтлэх, маргаан шийдвэрлэх, гэрээ дуусгавар болох, цуцлах харилцааг зохицуулсан нь Иргэний хуулийн 31-р бүлэг, Зохиогчийн эрхийн тухай хуулийн 35.1.2 дахь хэсэг, 37.2 дахь хэсэгт нийцсэн байна.

***Зээлийн мэдээлэл өгөх, авах гэрээ*** (Хавсралт 4.23) ББСБ нь "Бүрэн Скор ЗМС" ХХК-тай 2022 оны 7-р сарын 04-ний өдөр байгуулсан БХЗ/021-22 тоот бүхий Зээлийн мэдээлэл өгөх, авах гэрээгээр Мэдээлэл нийлүүлэгч нь зээлдэгчийн мэдээллийг Үйлчилгээ үзүүлэгчийн мэдээллийн санд нийлүүлэх, Үйлчилгээ үзүүлэгчийн мэдээллийн сангаас зээлийн мэдээлэл болон зээлийн түүхийн мэдээлэл бүхий зээлийн лавлагаа, мэдээлэл авах, үйлчилгээний хөлс төлөхтэй



УЛААНБААТАР ХОТ ... КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195

холбоотой харилцааг зохицуулсан байна. Зээлийн мэдээлэл өгөх, авах гэрээнд талуудын эрх үүрэг, хариуцлага, гэрээний хугацаа түүнийг цуцлах, дуусгавар болгох журам болон гомдол маргаан шийдвэрлэх журмыг тусгасан нь Зээлийн мэдээллийн тухай хуулийн 13.1 дэх хэсэгт, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А-231 дүгээр тушаалын хавсралтаар баталсан Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн зээлийн мэдээллийг хадгалах, хамгаалах журмын 14.4 дэх хэсэгт тус тус нийцсэн байна.

***Хэрэглэгчийн гэрээ*** (Хавсралт 4.24). ББСБ нь зээлийн мэдээллийн үйлчилгээ авах, зээлийн мэдээллийг ашиглах, бүтээгдэхүүн үйлчилгээний хөлс төлөх тэдгээртэй холбогдон үүсэх бусад харилцаа, талуудын эрх, үүрэг, хариуцлагыг зохицуулахаар "Титан Си Ар Эй Зээлийн мэдээллийн сан" ХХК-тай 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Г961-22 тоот Хэрэглэгчийн гэрээг байгуулсан байна. Гэрээ нь Зээлийн мэдээллийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

***Санамж бичиг*** (Хавсралт 4.25). Хөүм моргейж корпорэйшн ХХК-ийн Гадаад улсад ажиллаж, амьдарч буй Монгол улсын иргэд эх орондоо орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлэх төсөл дээр хамтран ажиллахтай холбоотой харилцааг зохицуулсан Тэхбокс ХХК, Хөүм моргейж корпорэйшн ХХК-нуудтай Санамж бичгүүд байгуулж ажилсан байна. Эдгээр санамж бичиг нь хэлцлийн хувьд сонирхлын зөрчилтэй боловч аливаа үүрэг хүлээсэн шинжгүй байх тул сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцон оруулаагүй болно. Тус компаниудтай санамж бичиг байгуулах, цаашилбал төсөлтэй холбоотой гэрээ хэлцэл байгуулах бүрэн эрхийг Компанийн ТУЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 07 тоот тогтоол (Хавсралт 4.26)-оор олгосон нь хуульд нийцэж байна.

***Хөдөлмөрийн гэрээний загвар*** (Хавсралт 4.27). Компанийн хөдөлмөрийн дотоод журмын хавсралтаар ажил олгогч, ажилтны хооронд үүсэх хөдөлмөрийн болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулж буй "Сэндли ББСБ" ХК, /"Ажил олгогч"/-ын ажилтнуудтайгаа байгуулдаг хөдөлмөрийн гэрээний загварыг баталжээ. Энэхүү загвар нь гэрээний зүйл, гэрээний гол нөхцөл, хугацаа, ажлын цаг, ажилтан, ажил олгогчийн эрх, үүрэг, цалин ба нэмэгдэл хөлс олгох, нууцлал, оюуны өмч, гэрээг дуусгавар болох, цуцлах, хариуцлага хүлээлгэх, эд хөрөнгийн бүрэн хариуцлага болон бусад нөхцөлийг тогтоосон нийт 13 зүйл бүлэг зохицуулалтаас бүрдэж байна. Хөдөлмөрийн гэрээний загвар нь Хөдөлмөрийн тухай хуульд нийцэж байна.

***Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээний загвар*** (Хавсралт 4.28). Компани нь ажилтанд эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэх зорилгоор байгуулдаг энэхүү гэрээний загвар нь нийтлэг үндэслэл, компанийн эрх, үүрэг, ажилтны эрх, үүрэг, хариуцлага, бусад зүйл гэсэн 5 бүлэг бүхий зохицуулалтаас бүрдсэн байна. Гэрээг Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн хянахад аливаа хуулийн зөрчил илрээгүй.

***2. Гадаад хамтын ажиллагаатай холбоотой гэрээ, хэлцэл:***

| № | Нөгөө тал | Огноо | Гэрээний нэр, агуулга |
|---|---|---|---|
| 1. | *Австрали улсын Flexewallet Pty Limited* | *2020.04.02* | *Flexewallet түншлэлийн үйлчилгээний гэрээ / Flexewallet affiliate services agreement/ нь Үйлчлүүлэгчээс мөнгөн хөрөнгийг цуглуулж, улс, хороонд шилжүүлэх, шилжүүлгийн талаар мэдээлэл өгөх, холбогдох шимтгэл, төлбөртэй холбоотой талуудын харилцааг зохицуулсан.* |

СЗХ
он сар өдөр
2024.06.10
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

| | | | |
|---|---|---|---|
| 2. | Япон Улсын City express money transfer Japan Co.Ltd., | 2021.06.22 | Мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн гэрээ нь Үйлчлүүлэгчээс мөнгөн хөрөнгийг цуглуулж, улс, хороонд шилжүүлэх, шилжүүлгийн талаар мэдээлэл өгөх, холбогдох шимтгэл, төлбөртэй холбоотой талуудын харилцааг зохицуулсан. |
| 3. | "XXX" Компани | 2019.05.16 | Sub-marketing partner agreement нь мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн маркетингийн үйл ажиллагаатай холбоотой талуудын харилцааг зохицуулсан. |
| 4. | Tenpay Payment Technologies Co., Ltd. | 2021.11.11 | Wechat төлбөрийн улс хоорондын үйлчилгээг ашиглан төлбөр тооцоо хийх, аюулгүй байдлыг хангахтай холбоотой талуудын харилцааг зохицуулсан. |

Дээр дурдсан хамтын ажиллагааны гэрээ хэлцэлд гадаад улсын хууль тогтоомж, шүүх, арбитрын харьяаллыг сонгосон байна. Зөвлөх нь эдгээр гэрээ гадаад улсын хуульд нийцэж буй эсэх талаар дүгнэлт гаргах эрхгүй болно.

*3. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд ашигладаг загвар гэрээ:*

МДСХ нь тус ББСБ-ын үндсэн үйл ажиллагаанд ашигладаг дараах загвар гэрээг хянасан бөгөөд хууль зөрчсөн заалт илрээгүй ба гэрээний тал, нөхцөлүүдээс хамаарч өөрчлөгдөх боломжтой болно. Үүнд:

| Баримт бичгийн нэр | Огноо, Дугаар, тайлбар |
|---|---|
| Зээлийн гэрээ (Хавсралт 4.29) | - |
| Малчны зээлийн гэрээ (Хавсралт 4.30) | - |
| Цахим зээлийн эрх гэрээний загвар /мерчант/ (Хавсралт 4.31) | |
| Үл хөдлөх хөрөнгийн зээлийн гэрээ (Хавсралт 4.32) | - |
| Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.33) | - |
| Орон сууцны зээлийн гэрээний загвар (Хавсралт 4.34) | Орон сууц худалдан авах зээлийн үйл ажиллагааны журмын хавсралт |
| Зээлийн шугамын гэрээний загвар (Хавсралт 4.35) | - |
| Хэрэглээний зээлийн эрх нээх гэрээ (Хавсралт 4.36 | - |
| Баталгааны гэрээ /Төлбөрийн баталгаа гаргах/ (Хавсралт 4.37) | - |
| | |

Дээр дурдсан гэрээнүүд нь Монгол Улсын хууль тогтоомж, СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд байгуулагдсан гэж үзэв.

*4. Нэхэмжлэх орчийн хэрэгсэл гаргахтай холбоотой мэргэжлийн байгууллагуудтай байгуулсан гэрээ, хэлцэл:*



УЛААНБААТАР ХОТ
ХХК
5183855
9021031195 СТС2420

2024.08.10 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

***Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ*** (Хавсралт 4.38). Үнэт цаас гаргагчийн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу бэлтгэсэн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн иж бүрэн орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудитын гүйцэтгэж, аудитын дүгнэлт гаргуулахаар энэхүү гэрээг байгуулсан байна. Уг гэрээ нь нийтлэг үндэслэл, ерөнхий зүйл, талуудын эрх үүрэг, үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, үйлчилгээний хөлс болон төлбөр төлөлт, хариуцлага, нууцлал болон гэрээний хамгаалалт, давагдашгүй хүчин зүйл, гэрээний хугацаа ба цуцлалт, маргаан шийдвэрлэлт, бусад зүйлүүд гэсэн 11 бүлэг бүхий зохицуулалтаас бүрдэх бөгөөд зохицуулалт нь Аудитын тухай хуульд заасан гэрээнд тусгавал зохих мэдээллийг тусгасан, гэрээ нь хуулийн хүчин төгөлдөр гэрээ байна. "Хүлэгтхүнү Аудит" ХХК нь СЗХ-ны 2014 оны 6 сарын 25-ны өдрийн 222 тогтоолоор Үнэт цаас гаргагчдад аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 4.39), СЗХ-ны 2023 оны 10 сарын 25-ны өдрийн 548 тогтоолоор Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийх зөвшөөрөл (Хавсралт 4.40)-тэй байх тул аудитын үйлчилгээ үзүүлэх этгээдээр бүртгүүлсэн, энэхүү гэрээг байгуулах эрхтэй болно.

***Андеррайтерийн гэрээ*** (Хавсралт 4.41). "Сэндли ББСБ" ХК-ийн МХБ-ээр олон нийтэд нээлттэй гаргах бондын төсөлд Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг "Өлзий энд Ко Капитал ҮЦК" (үндсэн андеррайтер), "Райнос Инвестмент ҮЦК" ХХК, "Голомт Капитал ҮЦК" ХХК (туслах андеррайтер)-тай 2024 оны 3 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан АГ-24/05 дугаартай гэрээгээр зохицуулсан байна. Гэрээ нь нийтлэг үндэслэл, андеррайтерийн үйлчилгээ, гэрээний хугацаа, үйлчилгээний төлбөр, талуудын эрх, үүрэг, дотоод мэдээлэл эзэмшигч, гүүний үүрэг, маргаан шийдвэрлэх, бусад нөхцөлийг тодорхойлсон 8 бүлгээс бүрдэх зохицуулалттай байна. Энэхүү гэрээ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.5 дахь хэсэгт заасан нөхцлийг хангасан байна.

Гэрээний 2.1, 2.3 дахь зүйлд зааснаар андеррайтер нь үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг зохион байгуулах, бондыг нээлттэйгээр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгох ажлыг зохион байгуулахдаа хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах /Best Effort/ хэлбэрээр зохион байгуулах, бондыг тогтоосон үнийн аргаар санал болгон арилжаалах, үнэт цаасыг нийтэд санал болгохтой холбогдон гарах маркетинг сурталчилгааны ажил, танилцуулах аянд андеррайтеруудтай хамтран ажиллахаар тохиролцсон байна.

Үндсэн болон туслах андеррайтер (http://www.frc.mn/o/198521 http://www.frc.mn/o/6717 http://www.frc.mn/o/198494) нь үнэт цаасны зах зээлд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх эрхтэй бөгөөд Компанийн ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 13 тоот тогтоол (Хавсралт 1.18)-ын дагуу гэрээ байгуулсан нь аливаа хууль зүйн зөрчилгүй байна.

***Бондын гэрээ*** (Хавсралт 4.42). Үнэт цаас гаргагч нь өрийн хэрэгсэл (цаашид "Бонд" гэх) гаргахтай холбогдуулан бондын нөхцөл, төлбөрийг тооцоолох аргачлал, худалдах, худалдан авах нөхцөл, Бонд гаргагч хөрөнгө оруулагчдын өмнө үүрэг гүйцэтгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК (Үндсэн андеррайтер)-тай 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр №БОГ- 24/01 тоот Бондын гэрээг байгуулсан байна. Энэхүү гэрээ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 226 дугаар тогтоолоор батлагдсан Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.7 дахь хэсэгт нийцсэн байна.



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

*Барьцааны гэрээ* (Хавсралт 4.44). Үнэт цаас гаргагч нь өөрийн хэрэгсэл гарган, олон нийтэд санал болгож буйтай холбоотойгоор "Монголын Финтек групп" ХК нь өөрийн эзэмшиж буй "Сэндли ББСБ" ХК-ийн 111,785,000 ширхэг хувьцаа, Дорноговь аймгийн Замын-үүд сум, 1-р баг Соёмбо, ТЗӨЧ-4 гудамжны 406 хаягт байрлах Улсын бүртгэлийн дугаар Э-0714002972, газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар 0000237626, нэгж талбарын дугаар 4401010485 бүхий зочид буудлын цогцолбор, олон нийтийн газар зориулалттай, 10000 м.кв газар эзэмших эрх болон Дорноговь аймгийн Замын-үүд сум, 1-р баг Соёмбо, ТЗӨЧ-3 гудамжны 320 хаягт байрлах, Улсын бүртгэлийн дугаар Э-0714002967, газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар 0000237326, нэгж талбарын дугаар 4401002556 бүхий Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор зориулалттай 1200 м.кв газар эзэмших эрхийг "Сэндли ББСБ" ХК болон үндсэн андеррайтер "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК нарын хооронд байгуулагдсан 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн № БОГ/01 тоот Бондын гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар тус тус барьцаалуулж, мөн өдөр БГ-24/05 тоот Барьцааны гэрээ (Хавсралт 4.44) байгуулсан байна. Тус гэрээгээр барьцааны зүйл, түүний үнэ, барьцаагаар хангагдах шаардлага, барьцаа хөрөнгөөр шаардлага хангах журам, барьцааны гэрээ дуусгавар болох, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл зэрэг нөхцөлийг тодорхойлж зохицуулсан байна. Энэхүү гэрээ нь холбогдох хууль тогтоомжийн зөрчилгүй байна.

***5. Зээлийн болон репо гэрээнүүд:***

***"Монголын финтек групп" ХХК болон "Сэндли" ББСБ ХК нарын хооронд 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр байгуулагдсан ЗГ/23-01 дугаартай Зээлийн шугамын** гэрээ (Хавсралт 4.44)*

Гэрээний мэдээлэл:

- Зээлийн дүн: 5,000,000,000 (таван тэрбум) төгрөг
- Зээлийн зориулалт: эргэлтийн хөрөнгө
- Зээлийн хүү: жилийн XX хувь
- Зээлийн хугацаа: 24 сар

Гэрээнд зээлийн дүн, үндсэн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ, зээлийн хугацаа, зориулалт, зээл олгох, эргэн төлөх хэлбэр, зээлдэгч болон зээлдүүлэгчийн эрх, үүрэг, талуудын хүлээх хариуцлага, баталгаа ба зөвшөөрөл, гэрээ дуусгавар болох цуцлах нөхцөл, журам, маргаан шийдвэрлэх заалтуудыг тусгасан бөгөөд ба эдгээр нөхцөлүүд нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

Түүнчлэн энэ гэрээ нь Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав ба түүнээс дээш үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээнд, мөн Компанийн тухай хуулийн 89-р зүйлийн 89.1 дэх хэсэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэлд нэгэн зэрэг хамаарч байна

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн хурлын 09 (Хавсралт 4.45) тоот "Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоолоор уг зээлийн шугамын гэрээ байгуулахыг зөвшөөрч, хэлцэл байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал Б.Одгэрэлд олгосон байна. "Монголын финтек групп" ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Наранбат гарын үсэг зурсан байна. Энэхүү тогтоол нь 89.1 дэх хэсэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамд нийцсэн ба Сэндли ББСБ ХК болон түүний толгой компани болох "Монголын финтек групп" ХХК-ийн хооронд 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан Зээлийн шугамын гэрээ нь хүчин төгөлдөр байна.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02
УЛААНБААТАР ХОТ ХХК 5183855 9021031195

СЗХ
он сар өдөр 2024.06.10
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-17
БҮРТГЭВ-02

2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн Зээлийн мэдээллийн лавлагаа (Хавсралт 4.46)-аас үзвэл, Компани нь 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр төлөгдөж дуусах нөхцөлтэй 2,000,000,000 (хоёр тэрбум) төгрөгийн зээлийн эрх нээлгэсэн ба лавлагаа гарсан өдрийн байдлаар 2,000,000,000 (хоёр тэрбум) төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, зээлийн ангилал "хэвийн" байна. Компани нь үүнээс бусад зээлгүй, сүүлийн 3 жилд байгуулсан бусад бүх зээлийн гэрээ зохих ёсоор хэрэгжиж дууссан болохыг Компанийн гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.1).

***"Девелопинг Энтерпренюриал Монголиа" ББСБ болон "Сэндли" ББСБ ХК нарын хооронд 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдөр байгуулагдсан ЗГ/202-203 дугаартай Зээлийн гэрээ*** (Хавсралт 4.47)

Гэрээний мэдээлэл:

- Зээлийн дүн: 500,000,000 (таван зуун сая) төгрөг
- Зээлийн зориулалт: эргэлтийн хөрөнгө
- Зээлийн хүү: жилийн XX хувь
- Зээлийн хугацаа: 12 сар

Гэрээнд зээлийн дүн, үндсэн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ, зээлийн хугацаа, зориулалт, зээл олгох, эргэн төлөх хэлбэр, зээлдэгч болон зээлдүүлэгчийн эрх, үүрэг, талуудын хүлээх хариуцлага, баталгаа ба зөвшөөрөл, гэрээ дуусгавар болох цуцлах нөхцөл, журам, маргаан шийдвэрлэх заалтуудыг тусгасан байх ба эдгээр нөхцөлүүд нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

***"Капитрон банк" ХХК болон "Сэндли" ББСБ ХК нарын хооронд 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр байгуулагдсан Зээлийн шугамын гэрээ*** (Хавсралт 4.48)

Гэрээний мэдээлэл:

- Зээлийн дүн: 2,000,000,000 (хоёр тэрбум) төгрөг
- Зээлийн зориулалт: Зээлийн шугам байгуулалга
- Зээлийн хүү: жилийн XX хувь
- Зээлийн хугацаа: 12 сар
- Хариуцлага: Зээлдэгч, хамтран зээлдэгч, хамтран үүрэг гүйцэтгэгч нь зээлийн төлбөрийг гэрээнд заасан хуваарийн дагуу зээл, түүний хүү төлөгдөөгүй бол зээл хугацаандаа төлөгдөөгүй гэж үзэх үндэслэл болно. (Гэрээний 5.1)

Гэрээнд зээл олгох нөхцөл, зээлийн зориулалт, хүү, хугацаа, баталгаа зөвшөөрөл, үүргийн гүйцэтгэл, талуудын эрх, үүрэг болон хариуцлагын талаар тусгасан байх ба эдгээр нөхцөлүүд нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

Мөн энэ гэрээ нь Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав ба түүнээс дээш үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээнд хамаарч байна.

3096-2023/165 тоот зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор Компани нь Капитрон банктай 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан 3096-2023/165-1 тоот Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ (Хавсралт 4.50) байгуулжээ. Уг барьцааны гэрээнд барьцааны зүйл, нөхцөл, барьцаалуулагчийн мэдэгдэл, зөвшөөрөл, талуудын



УЛААНБААТАР ХОТ
ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ 2024.05.10 өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

эрх үүрэг, үүргийн гүйцэтгэл хангуулах, маргаан шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан бөгөөд хууль тогтоомжид нийцсэн байна.

Үнэт цаас гаргагч нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар одоогоор хэвийн хэрэгжиж байгаа 3 репо зээлийн гэрээ, тэдгээр үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээг тус тус байгуулсан байна. Үүнд:

| № | Гэрээ байгуулагч тал | Зээлийн гэрээний огноо, дугаар | Зээлийн хугацаа | Зээлийн үнийн дүн /төгрөг/ | Барьцаа |
|---|---|---|---|---|---|
| 1. | Ашид Капитал ББСБ ХХК | 2024.01.25 20240125-30-269/14-171 (Хавсралт 4.49) | 84 хоног | 1,000,000,000 | Барьцааны гэрээ<br><br>Ашид Капитал ББСБ ХХК-тай 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр B2024012530269/14171 тоот барьцааны гэрээ байгуулжээ (Хавсралт 4.51). |
| 2. | Нэг Инвеско ББСБ ХХК | 2024.02.08, 20240208-40-59/14-173 (Хавсралт 4.52). | 84 хоног | 500,000,,000 | Барьцааны гэрээ<br><br>Нэг Инвеско ББСБ ХХК-тай 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр B202402084059/14173 тоот барьцааны гэрээ байгуулжээ (Хавсралт 4.53). |
| 3. | Туркойс Финанс ББСБ ХХК | 2024.03.19 20240319-39-173/14-179 (Хавсралт 4.54). | 84 хоног | 600,000,000 | Барьцааны гэрээ<br><br>Туркойс Финанс ББСБ ХХК-тай 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр B-20240319-39-173/14-179 тоот барьцааны гэрээ байгуулжээ (Хавсралт 4.55). |

Одоогоор дээр дурдсан зээлийн гэрээнээс өөр хүчин төгөлдөр үйлчилж буй репо зээлийн гэрээ байхгүй, тэдгээр гэрээний үүргийн гүйцэтгэл хэвийн хэрэгжиж байгаа болохыг Компанийн гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.1).

***7. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн таа болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ:***



УЛААНБААТАР ХОТ ... ХХК 5183855 9021031195 CTC2420

СЭХ
Он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-09-17
БҮРТГЭВ-02

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлттэй холбоотойгоор Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн нь 2021 онд 71,425,000 төгрөг, 2022 оны 01 сараас 2022 оны 6 сар хүртэлх хугацаанд 321,425,000 төгрөг, 2022 оны 6 сараас хойш 2022 оны 12 дугаар сарын 27 хүртэлх хугацаанд 391,425,000 төгрөг, 2022 оны 12 дугаар сарын 27-ноос хойш тасалбар болгох өдрийн байдлаар 558,925,000 төгрөг байна.

Бидэнд ирүүлсэн мэдээллээр дээрх тооцооллын дагуу Компани нь сүүлийн 3 жилд хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн нийт 21 гэрээ байгуулсан байна:

| № | Гэрээний дугаар | Гэрээний огноо | Гэрээний нэр | Үнийн дүн /төгрөг/ | Хэрэгжсэн, хэрэгжиж буй эсэх |
|---|---|---|---|---|---|
| 1. | - | 2021.07.05 | Зээлийн шугамын гэрээ (Хавсралт 4.56) | 5,000,000,000 | Хэрэгжиж дууссан |
| 2. | ИГ18/01 | 2021.10.10 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.57) | 2,450,000,000 | Хэрэгжиж дууссан |
| 3. | ЗГ/211027 | 2021.10.27 | Зээлийн шугамын гэрээ (Хавсралт 4.58) | 110,000,000 | Хэрэгжиж дууссан |
| 4. | ИГ18/02 | 2021.12.06 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.59) | 100,000,000 | Хэрэгжиж дууссан |
| 5. | ИГ22/01 | 2022.01.28 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.60) | 656,000,000 | Хэрэгжиж дууссан |
| 6. | 3096-2022/59 | 2022.04.15 | Зээлийн гэрээ /зээлийн шугам/ (Хавсралт 4.61) | 1,500,000,000 | Хэрэгжиж дууссан |
| 7. | СО-22/04 | 2022.05.02 | Үнэ тогтворжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ (Хавсралт 4.62) | 1,000,000,000 | Хэрэгжиж дууссан |
| 8. | ИГ11722424010400012 1 | 2022.06.06 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.63) | 1,000,000,000 | Хэрэгжиж байгаа |
| 9. | ИГ1172240104000123 | 2022.06.08 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.64) | 500,000,000 | Хэрэгжиж дууссан |
| 10. | №ЗОНГ/СС 221202003-1,№ЗОНГ/СС221202003-1-1 | 2022.12.02, 2022.12.06 | Зээлийн эрх нээх гэрээ (Хавсралт 4.65) | 2,170,000,000 | Хэрэгжиж дууссан |
| 11. | 2022/12/07-7 | 2022.12.07 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.66) | 1,000,000$ | Хэрэгжиж дууссан |
| 12. | 11722401800005 | 2022.12.19 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.67) | 500,000,000 | Хэрэгжиж дууссан |



УЛААНБААТАР ХОТ
ХХК
5183855
9021031195

СЗХ
2024 он 05 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 1

2024-05-17
БҮРТГЭВ-02

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 13. | 1172240105 000027 | 2023.04.14 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.68) | 1,000,000$ | Хэрэгжиж байгаа |
| 14 | ИГ1172240 104000108 | 2023.05.23 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.69) | 603,171,999 | Хэрэгжиж байгаа |
| 15. | ИГ1172240 102000032 | 2023.06.09 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.70) | 1,500,000,000 | Хэрэгжиж дууссан |
| 16. | ИГ18/00 | 2023.09.19 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.71) | 1,000,000,000 | Хэрэгжиж байгаа |
| 17. | 3096-2023/165 | 2023.12.27 | Зээлийн гэрээ /зээлийн шугам/ (Хавсралт 4.72) | 2,000,000,000 | Хэрэгжиж байгаа |
| 18. | 3096-2023/165-1 | 2023.12.27 | Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ (Хавсралт 4.73) | 2,000,000,000 | Хэрэгжиж байгаа |
| 19. | 1172240110 000001 | 2024.01.30 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.74) | 400,000$ | Хэрэгжиж байгаа |
| 20. | 1172240108 000029 | 2024.02.14 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.75) | 200,000$ | Хэрэгжиж байгаа |
| 21. | ИГ1172240 104000335 | 2024.02.16 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.76) | 900,000,000 | Хэрэгжиж байгаа |

Тэдгээр 21 гэрээнээс 12 гэрээ хэрэгжиж дууссан, 9 гэрээ хэвийн хэрэгжиж байгаа талаар Компанийн Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.1).

Дээрхийг нэгтгэн дүгнэвэл, Үнэт цаас гаргагчийн эрхэлж буй банк бус санхүүгийн байгууллагын үйлчилгээтэй холбоотой загвар гэрээ, үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж буй түрээсийн, хамтын ажиллагаа болон бусад гэрээ, хөдөлмөрийн харилцаанд хамаарах гэрээ, загвар гэрээ, зээл, репо зээлийн гэрээ, үнэт цаас гаргахтай холбоотой байгуулсан гэрээ, хэлцэл болон компанийн үйл ажиллагаанд ач холбогдол бүхий бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжийн зөрчилгүй байна. Мөн Компанийн гүйцэтгэх захирал дүгнэлтэд дурдсан гэрээний үүрэг хэвийн хэрэгжиж байгаа бөгөөд одоогоор тэдгээр гэрээ хэлцлийн улмаас Компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсээгүй талаар бидэнд мэдэгдсэн (Хавсралт 12.1) болно.

УЛААНБААТАР ХОТ
ХХК
5183855
9021031195 СТС2420

Хуулийн дүгнэлт гаргах явцад бид тус компанид албан ёсоор хандсанаар сүүлийн 3 жилд байгуулсан доор дурдсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хянав:

| № | Гэрээний нөгөө тал | Гэрээний нөхцөл | Их хэмжээний, сонирхлын зөрчилтэй алин болох | Хэрэгжсэн, хэрэгжиж буй эсэх |
|---|---|---|---|---|
| 1. | "Монголын финтек групп" ХК | Компанийн ХЭХ-ын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 09 тоот "Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" шийдвэр (Хавсралт 4.56)-ээр зөвшөөрөл олгосны дагуу Компани нь өөрийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор толгой компаниасаа зээл авах, түүнийг буцаан төлөхтэй холбоотой харилцааг зохицуулахаар 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдөр 5 тэрбум төгрөгийн Зээлийн шугамын гэрээ (Хавсралт 4.56) байгуулсан. | Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж дууссан |
| 2. | "Хай пэймэнт солюшнс" ХХК | Компанийн ХЭХ-ын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 04 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.1)-оор зөвшөөрөл олгосны дагуу "Hi-Pay" аппликэйшнаар дамжуулан ББСБ-аас зээлдэгч нарт олгосон зээлийн мөнгөн хөрөнгийг "Hi-Pay" дансанд шилжүүлэх, бүртгэл хөтлөхтэй холбоотой харилцааг зохицуулахаар 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Н-21/11 тоот Хамтран ажиллах гэрээ (Хавсралт 5.2)-г байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |
| 3. | "Хай пэймэнт солюшнс" ХХК | Компанийн ХЭХ-ын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 04 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.1)-оор зөвшөөрөл олгосны дагуу гэрээгээр тохиролцсон нууц мэдээллийг ашиглах, хадгалах, түгээхтэй холбоотой харилцааг зохицуулахаар 2021 оны 03 дугаар сарын | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 10-ны өдөр Н-21/12 тоот Нууцлалын гэрээ (Хавсралт 5.3)-г байгуулсан. | | |
| 4. | "Хай пэймэнт солюшнс" ХХК | Компанийн ХЭХ-ын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 04 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.1)-оор зөвшөөрөл олгосны дагуу "Hi-Pay" аппликэйшн болон QR-аар дамжуулан бараа, үйлчилгээний төлбөрийг хүлээн авахтай холбоотой харилцааг зохицуулахаар 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр 21-01/38 тоот Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээг (Хавсралт 5.4)-г байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |
| 5. | "Хай пэймэнт солюшнс" ХХК | Компанийн ХЭХ-ын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 04 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.1)-оор зөвшөөрөл олгосны дагуу Компани нь өөрийн цахим үйлчилгээгээр дамжуулан нөгөө талын Автопэй үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх, автоматаар бараа, үйлчилгээний төлбөр авахтай холбоотой харилцааг зохицуулахаар 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр S21-01/01 тоот Мерчанттай "Автопэй" үйлчилгээгээр хамтран ажиллах гэрээ (Хавсралт 5.5)-г байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |
| 6. | "Мони маркет фанд" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 06 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.6)-оор зөвшөөрөл олгосны дагуу репо зах зээлд платформоор дамжуулан оролцох, бусад ББСБ-аас зээл авахтай холбоотой харилцааг зохицуулах 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр М-МГ21/16 тоот Зээл авахад зуучлах, репо зээлийн мастер гэрээ (Хавсралт 5.7)-г байгуулсан. Мөн энэхүү гэрээнд 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр ББСБ нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан мөн зарим нөхцөлийг өөрчилж нэмэлт өөрчлөлт | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |

СЗХ
он 2024 .06. сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | (Хавсралт 5.8) оруулсан байна. | | |
| 7. | "Техбокс" ХХК | Компанийн ХЭХ-ын 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 10 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.9)-оор Зээлдэгч ББСБ-аас авсан зээлийн хөрөнгөөр Худалдаа эрхлэгчээс бараа худалдан авахтай холбоотой харилцааг зохицуулах 2021 оны 08 дугаар сарын 09-ний өдөр 03 тоот Хамтран ажиллах гэрээ (Хавсралт 5.10)-г байгуулсан | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж дууссан |
| 8. | "Техбокс" ХХК болон "Хай пэймэнт солюшнс" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 07 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.11, 5.12)-оор зөвшөөрөл олгосон. "Хай пэймэнт солюшнс" ХХК нь Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээг Техбокс ХХК-тай байгуулсан ба энэхүү гэрээнд ББСБ нэмэлт оролцогч тал болсонтой холбогдуулан 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээнд ББСБ нь оролцогч болсон нэмэлт өөрчлөлт оруулах гэрээ (Хавсралт 5.11)-г байгуулжээ. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |
| 9. | "Хай пэймэнт солюшнс" ХХК болон "Үндэсний ухаалаг цахим шийдэл" | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 08 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.12)-аар "Хай пэймэнт солюшнс" ХХК, түүний мерчант байгууллагуудтай хамтран ажиллах зорилгоор гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон. "Хай пэймэнт солюшнс" ХХК нь Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээг Мерчанттай байгуулсан ба энэхүү гэрээнд ББСБ нэмэлт оролцогч тал болсонтой холбогдуулан 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээнд ББСБ нь оролцогч болсон нэмэлт өөрчлөлт оруулах гэрээ (Хавсралт 5.13)-г байгуулжээ. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |



УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183855
9021031195

Сэндли Бонд 2.0

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2024-05-17
БҮРТГЭВ-02

| | | | | |
|---|---|---|---|---|
| 10. | "Хай пэймэнт солюшнс" ХХК болон "Зочил технологи" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 08 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.12)-аар "Хай пэймэнт солюшнс" ХХК, түүний мерчант байгууллагуудтай хамтран ажиллах зорилгоор гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон. "Хай пэймэнт солюшнс" ХХК нь Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээг Мерчанттай байгуулсан ба энэхүү гэрээнд ББСБ нэмэлт оролцогч тал болсонтой холбогдуулан 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээнд ББСБ нь оролцогч болсон нэмэлт өөрчлөлт оруулах гэрээ (Хавсралт 5.14)-г байгуулжээ. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |
| 11. | "Хай пэймэнт солюшнс" ХХК болон "Цэцэгт мэндчилгээ" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 08 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.12)-аар "Хай пэймэнт солюшнс" ХХК, түүний мерчант байгууллагуудтай хамтран ажиллах зорилгоор гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон. "Хай пэймэнт солюшнс" ХХК нь Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээг Мерчанттай байгуулсан ба энэхүү гэрээнд ББСБ нэмэлт оролцогч тал болсонтой холбогдуулан 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээнд ББСБ нь оролцогч болсон нэмэлт өөрчлөлт оруулах гэрээ (Хавсралт 5.15)-г байгуулжээ. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |
| 12. | "Хай пэймэнт солюшнс" ХХК болон "Моду лабс" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 08 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.12)-аар "Хай пэймэнт солюшнс" ХХК, түүний мерчант байгууллагуудтай хамтран ажиллах зорилгоор гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон. "Хай пэймэнт солюшнс" ХХК нь Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээг Мерчанттай байгуулсан ба энэхүү гэрээнд ББСБ нэмэлт оролцогч тал болсонтой холбогдуулан 2021 оны 12 | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |

УЛААНБААТАР ХОТ
ХХК
5183855
9021031195 СТС2420

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | дугаар сарын 06-ны өдөр Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээнд ББСБ нь оролцогч болсон нэмэлт өөрчлөлт оруулах гэрээ (Хавсралт 5.16)-г байгуулжээ. | | |
| 13. | "Хай пэймэнт солюшнс" ХХК болон "Ундрам Хан Хангай" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 08 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.12)-аар "Хай пэймэнт солюшнс" ХХК, түүний мерчант байгууллагуудтай хамтран ажиллах зорилгоор гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон. "Хай пэймэнт солюшнс" ХХК нь Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээг Мерчанттай байгуулсан ба энэхүү гэрээнд ББСБ нэмэлт оролцогч тал болсонтой холбогдуулан 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээнд ББСБ нь оролцогч болсон нэмэлт өөрчлөлт оруулах гэрээ (Хавсралт 5.17)-г байгуулжээ. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |
| 14. | "Даталүүл Монголиа" ХХК | Компанийн ХЭХ-ын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 22 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" шийдвэр (Хавсралт 5.18)-ээр зөвшөөрөл олгосны дагуу Компани нь зэргэлдээ компанийн мөнгөн хөрөнгийг итгэмжлэн удирдахтай холбоотой харилцааг 2021 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 2,450,000,000 төгрөгийн Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 5.19) байгуулсан. Зах зээлийн нөхцөл байдлын улмаас хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үр ашгийг хүүг багасгаж 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдөр НГ18/01-1 тоот Нэмэлт гэрээ байгуулжээ (Хавсралт 5.19). | Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж дууссан |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 15. | "Мони маркет фанд" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 06 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.6)-оор зөвшөөрөл олгосны дагуу "Мони маркет фанд" ХХК-тай 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр М-МГ21/16 тоот "Зээл авахад зуучлах, репо зээлийн мастер гэрээ" (Хавсралт 5.7), 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр "Зээл авахад зуучлах, репо зээлийн мастер гэрээний нэмэлт өөрчлөлтийн гэрээ" (Хавсралт 5.8)-г тус тус байгуулсан байна. Энэхүү мастер гэрээний дагуу нийт 25 удаа[2]-гийн Репо зээлийн гэрээ, түүний барьцааны гэрээг "Мони маркет фанд" ХХК-тай тухай бүр байгуулсан (Хавсралт 5.21). | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж дууссан |
| 16. | "Мони маркет фанд" ХХК | Дээр дурдсан ТУЗ-ийн тогтоол, мастер гэрээний дагуу "Мони маркет фанд" ХХК-тай Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хэрэгжиж байгаа нийт 2 удаа[3]-гийн Репо зээлийн гэрээг байгуулсан (Хавсралт 5.22). | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |
| 17. | "Райнос инвестмент ҮЦК" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 22/07 тоот "Нэлттэй өрийн хэрэгсэл гаргах тухай" тогтоол (Хавсралт 5.23)-оор зөвшөөрөл олгосны дагуу 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр 22/23 тоот Андеррайтер болон зөвлөх үйлчилгээний гэрээ (Хавсралт 5.24)-г "Райнос инвестмент ҮЦК" ХХК-тай байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж дууссан |
| 18. | "Хай пэймэнт солюшнс" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 15 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.25)-оор зөвшөөрөл олгосны дагуу 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Н22/35 тоот | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |

[2] 20220609-36-3/1433, 20220610-36-6/1434, 20220922-36-15/1456, 20220906-36-14/14-53, 20220809-36-12/1445, 20220728-36-11/1441, 20220708-36-10/1440, 20220706-36-8/1439, 20220706-36-7/14-38, 20221201-36-19/14-69, 20221220-36-20/14-70, 20221220-36-21/14-71, 20221223-36-22/14-72 дугаартай Репо зээлийн гэрээ, Барьцааны гэрээнүүд багтана.

[3] 20240208405 9/14173 болон 20240125302 69/14171 дугаартай Репо зээлийн гэрээнүүд багтана.

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Хамтран ажиллах гэрээ (Хавсралт 5.26), мөн 2023 оны 6 дугаар сарын 9-ний өдөр Н22/35-1 тоот Н22/35 тоот гэрээний нэмэлт гэрээ (Хавсралт 5.28)-г "Хай пэймэнт солюшнс" ХХК-тай тус тус байгуулсан. | | |
| 19. | "Монголын финтек групп" ХК | Компанийн ТУЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 09 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.29)-оор зөвшөөрөл олгосны дагуу 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр ЗГ/24-28 тоот Зээлийн шугамын гэрээ (Хавсралт 5.30), мөн ЗГ/24-29 тоот Зээлийн шугамын гэрээ (Хавсралт 5.31)-г тус тус "Монголын финтек групп" ХК-тай байгуулсан байна. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |
| 20. | "Мони маркет фанд" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 09 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.29)-оор зөвшөөрөл олгосны дагуу 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр ЗГ/23-01 тоот Зээлийн шугамын гэрээ (Хавсралт 5.32)-г "Мони маркет фанд" ХХК-тай байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |
| 21. | "Мони маркет фанд" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 16 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.35)-оор зөвшөөрөл олгосны дагуу 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдөр MMFIT-23/0006 тоот Итгэлцлийн үйлчилгээ зуучлах мастер гэрээ (Хавсралт 5.36)-г "Мони маркет фанд" ХХК-тай байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |
| 22. | "Хай пэймэнт солюшнс" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 16 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.32)-оор зөвшөөрөл олгосны дагуу 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдөр Н-23/60 тоот Мерчанттай хамтран ажиллах гэрээ (Хавсралт 5.37), 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Н23/60 дугаартай Мерчанттай | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |

СЗХ
он сар өдөр
2024.05.10
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2024-05-17
БҮРТГЭВ-02

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хамтран ажиллах гэрээ нэмэлт өөрчлөлтийн H23/60-1 тоот гэрээ (Хавсралт 5.38), 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдөр H-23/59 тоот Хамтран ажиллах гэрээ (Хавсралт 5.39), 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдөр H-23/61 тоот Үйлчилгээ үзүүлэх гэрээ (Хавсралт 5.33)-г тус тус "Хай пэймэнт солюшнс" ХХК-тай байгуулсан. | | |
| 23. | "Стоклаб Секьюритиз ҮЦК" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 16 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.32)-оор зөвшөөрөл олгосны дагуу 2023 оны 08 дугаар сарын 17-ны өдөр Үнэт цаасны зөвлөх үйлчилгээний гэрээ (Хавсралт 5.34)-г "Стоклаб Секьюритиз ҮЦК" ХХК байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |
| 24. | "Райнос инвестмент ҮЦК" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 13 тоот "Бэлтгэл хангах тухай" тогтоол (Хавсралт 1.18)-оор зөвшөөрөл олгосны дагуу 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр АГ-24/05 тоот Андеррайтер болон зөвлөх үйлчилгээний гэрээ (Хавсралт 5.27)-г "Райнос инвестмент ҮЦК" ХХК-тай байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |

***Сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар:***

Бидэнд ирүүлсэн мэдээллээр Компани сүүлийн 3 жилд сонирхлын зөрчилтэй 58 хэлцэл хийсэн бөгөөд тус гэрээнүүдээс 30 нь хэрэгжиж дууссан, 28 нь Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хэрэгжиж байгаа, мөн ямар нэгэн зөрчил маргаан гараагүй талаар Компанийн гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.1).

Дээр дурдсанаар зарим сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрлийг ХЭХ-аар шийдвэрлэсэн ба тухайн үед ТУЗ-гүй нэг хувьцаа эзэмшигчтэй байсан тул Компанийн хуулийн дагуу хурлын тэмдэглэл шаардлагагүй болно. Компани нь сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулахтай холбогдон Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан журам болон Компанийн дүрэмд заасны дагуу хэлцэл байгуулахаасаа өмнө ТУЗ-ийн хурлаар урьдчилан хэлэлцэж, зөвшөөрөл олгох хуулийн шаардлагыг мөрдөж ажиллаж байна гэж үзэхээр байна.

***Их хэмжээний хэлцлийн талаар:***



УЛААНБААТАР ХОТ
ХХК
5183852
9021031195 СТС2420

Компанийн тухай хуулийн 87-д зааснаар их хэмжээний хэлцэл нь сүүлийн балансын активын нийт дүнгийн 25% буюу Компанийн сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлангийн актив, түүнд ногдох их хэмжээний хэлцлийн үнийн дүн дараах байдалтай байна:

| № | Хэлцлийн хамрах хугацаа | Өмнөх жилийн балансын актив (төгрөгөөр) | Тухайн жилийн балансын активын 25% (төгрөгөөр) | Гэрээ байгуулагдсан эсэх |
|---|---|---|---|---|
| 1. | 2021.03.01-2021.12.31 | 1,889,437,396 | 472,359,349 | Тийм |
| 2. | 2022.01.01-2022.12.31 | 10,604,635,511 | 2,651,158,877 | Үгүй |
| 3. | 2023.01.01-2023.12.31 | 34,891,279,500 | 8,722,819,875 | Үгүй |
| 4. | 2024.01.01-2024.03.01 | 63,527,253,164 | 15,881,813,291 | Үгүй |

Компанийн их хэмжээний хэлцлийн хувьд дээр дурдсан сонирхлын зөрчилтэй хэлцлийн жагсаалт-хүснэгтийн 1, 14-д дурдсан хоёр хэлцэл нь их хэмжээний хэлцэл байх бөгөөд дүгнэлт гаргах өдрийн байдлаар нэг гэрээ хэрэгжиж дууссан, нэг гэрээ хэвийн хэрэгжиж байгаа, ямар нэгэн зөрчил маргаан гараагүй болохыг Компанийн гүйцэтгэх захирал (Хавсралт 12.1) бидэнд мэдэгдсэн.

Үнэт цаас гаргагч нь их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах талаар Компанийн тухай хуульд заасан журмыг мөрдөж ажилласан гэж дүгнэв.

Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 318 дугаар тогтоол (Хавсралт 6.1)-оор Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх ТЗ 101/498 дугаар тусгай зөвшөөрөл (Хавсралт 6.4), 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 62 дугаар тогтоолоор Банк бус санхүүгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 6.2), мөн Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 441 дүгээр тогтоолоор Банк бус санхүүгийн санхүү факторингийн үйлчилгээ, төлбөрийн баталгаа гаргах, итгэлцлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг (Хавсралт 6.3) тус тус авсан.

Компанийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нь Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2.1.1 хэсэгт заасны дагуу эрх бүхий этгээд болох Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгогдсон байх бөгөөд Компанид Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2.2.7-д заасан банк бус санхүүгийн гадаад валютын арилжаа эрхлэх, 2.2.8-д заасан банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ эрхлэх, 2.2.9-д заасан банк бус санхүүгийн зээл олгох үйл ажиллагаа эрхлэх, 2.2.10-д заасан банк бус санхүүгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх, 2.2.11-д заасан банк бус санхүүгийн факторингийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлүүд, 2.2.29-д заасан банк бус санхүүгийн төлбөрийн баталгаа гаргах энгийн зөвшөөрлийг тус тус авсан байна. Эдгээр нь Зөвшөөрлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9.1 дэх хэсэгт заасан банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход тавигдах шаардлагад нийцсэн гэж үзэв.

Мөн Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 7/2821 тоот албан бичиг (Хавсралт 6.19)-ээр Сэндли ББСБ ХК-н "Sendly" аппликэйшнийг Санхүүгийн зохицуулах хорооны Цахим зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцэн холбогдох хууль, журмын шаардлагыг хангасан гэж дүгнэж, үйл ажиллагаа явуулах боломжтой финтек зээлийн бүтээгдэхүүнээр бүртгэсэн болохыг мэдэгдсэн байна.

Компанийн нэр дээр байх дээрх энгийн болон тусгай зөвшөөрлүүд нь Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчинтэй эсэх, тэдгээрийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл байдал үүссэн эсэх талаар Санхүүгийн зохицуулах хорооноос тодруулахад, 2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 3/1355 тоот албан бичиг (Хавсралт 6.20)-ээр тус өдрийн байдлаар тусгай зөвшөөрлүүд нь түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл бүрдээгүй талаар бидэнд мэдэгдсэн иргэсэн болохыг дүгнэлт гаргах өдрийн байдлаар хариу ирээгүй байна.

Компанийн зэргэлдээ компани болох "Хай пэймэнт солюшнс" ХХК-д цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээ зөвшөөрлийг 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн Монголбанкны ерөнхийлөгчийн тушаалаар олгосон. Уг зөвшөөрлийн үндсэн дээр ББСБ болон "Хай пэймэнт солюшнс" ХХК нар тогтмол хамтран ажилдаг байна (Хавсралт 6.17, 6.18).

***Оюуны өмч.***

СЗХ 2024 .06. сар 0 өдөр БҮРТГЭВ № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

Оюуны өмчийн газрын барааны тэмдгийн гэрчилгээ болон Оюуны өмчийн газрын барааны тэмдгийн цахим бүртгэлийн 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хайлтаар (Хавсралт 6.5. 6.6. 6.7. 6.8) болон барааны тэмдгийн гэрчилгээ хайлтаар (Хавсралт 6.9 - 6.15)-т тусгаснаар "Сэндли ББСБ" ХК ("Гялс кредит ББСБ" ХХК)-ийн нэр дээр эрхийн хамгаалалт хийгдсэн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, зохиогчийн эрхийн аливаа бүтээл байхгүй. Компанийн нэр дээр дараах барааны тэмдгийг бүртгүүлсэн байна:

| № | Утга /тэмдэг/ | Мэдүүлгийн дугаар | Улсын бүртгэлийн дугаар | Хүчинтэй хугацаа |
|---|---|---|---|---|
| 1. | Sendly | 40-2020-0025416 | 40-0022102 (Хавсралт 6.9) | 2030.01.22 |
| 2. | sendly | 40-2020-0026084 | 40-0022687 (Хавсралт 6.12) | 2030.05.13 |
| 3. | send | 40-2020-0027152 | 40-0025585 (Хавсралт 6.11) | 2030.10.20 |
| 4. | sndly | 40-2021-0028919 | 40-0024867 (Хавсралт 6.12) | 2031.06.23 |
| 5. | Сэндли | 40-2022-0031344 | 40-0026807 (Хавсралт 6.15) | 2032.06.13 |
| 6. | Сэнд | 40-2022-0031343 | 40-0026806 (Хавсралт 6.14) | 2032.06.13 |
| 7. | Sendly | 40-2022-0031345 | 40-0026808 (Хавсралт 6.13) | 2032.06.13 |

Компани нь дээр дурдсан долоон барааны тэмдгээс бусад аливаа оюуны өмчийн эрх эзэмшдэггүй болохыг Компанийн гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн (Хавсралт 12.1).



УЛААНБААТАР ХОТ ХХК 5183... 9021031195 СТС2420

СЗХ
он сар өдөр
2024.05.10 ЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

***Домэйн нэр.*** Компанийн www.sendly.mn домэйн нэр нь 2027 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр хүртэл хүчинтэй байна (Хавсралт 6.16).

***ISO 270001 гэрчилгээ.*** Компани нь мэдээллийн аюулгүй байдлын системийн Олон Улсын ISO/IEC 27001:2013 стандартын шаардлагыг хангаж, зээлийн үйлчилгээ, олон улсын мөнгөн шилжүүлэг, итгэлцлийн үйлчилгээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангасан болохыг баталгаажуулсан байна (Хавсралт 6.21).

Дээр дурдсаны дагуу дүгнэлт гаргах өдрийн байдлаар Компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, барааны тэмдэг, домайн нэр нь хүчин төгөлдөр, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл байдал үүсээгүй гэж дүгнэв (Хавсралт 12.1).



УЛААНБААТАР ХОТ
5183855
9021031195 СТС2420

[illegible]

***Үнэт цаас.***

**Компани нь дараах компанийн хувьцааг эзэмшдэг ба аливаа өөр үнэт цаас эзэмшдэггүй болохыг тус Компанийн Гүйцэтгэх захирал айбан ёсоор бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.1).Үүнд:**

| “СЭНДЛИ ББСБ” ХК | | | | |
|---|---|---|---|---|
| **№** | **Хувьцаа эзэмшигчдийн нэрс** | **Эзэмших хувь** | **Бүртгэлтэй улс** | **Зээлийн гэрээний дагуу барьцаалагдсан эсэх** |
| **1** | **Мон ремит лимитед компани (Хавсралт 7.4)** | **100%** | **Англи** | **Үгүй** |
| **2** | **Сэндли Монголиа (Хавсралт 7.7)** | **100%** | **АНУ** | **Үгүй** |

**Охин компани нь Англи улсад төлбөрийн үйлчилгээтэй холбоотой тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаагаа эрхэлж байна[4]. Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн “Охин компанийн хувьцааг худалдах тухай” 09 тоот шийдвэр (Хавсралт 7.5)-ээр Компанийн 100%-ийн охин компани болох Англи улсад бүртгэлтэй “Мон ремит” компанийн хувьцааг худалдахаар шийдвэрлэсэн. Хувьцаа шилжүүлэх ажиллагаа нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар үргэлжилж байна.**

**“Сэндли Монголиа” ХХК нь “Сэндли ББСБ” ХК-ийн 100 хувийн охин компани болохыг Компанийн гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.1).**

***Үнэт цаас гаргагчийн барьцаанд байгаа хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө.***

**Барьцааны эрхийн цахим мэдээллийн сангаас үзэхэд, Компаний нь 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар дараах хөрөнгөө барьцаалуулсан байна (Хавсралт 7.1):**

| **№** | **Хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн төрөл** | **Хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн нэр, дугаар** | **Зээлийн Гэрээний дагуу Барьцаалагдсан эсэх** |
|---|---|---|---|
| 1. | **Банкны дансны орлого, Хэвийн зээлийн багц** | **ХААН банк дахь Сэндли ББСБ ХХК-ийн 5176387172 тоот харилцах данс болон бусад банкин дахь харилцах, хадгаламжийн дансны орлого, 150 сая төгрөгийн үлдэгдэл дүн бүхий хэвийн зээлийн багц** | **“Мони Маркет Фанд” ХХК, “Түмэн Ембүүт Финанс ББСБ” ХХК-тай байгуулсан 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 20240425-31-52/14-184 тоот Репо зээлийн гэрээ, №В-20240425-31-52/14-184 тоот Барьцааны гэрээний дагуу барьцаалсан (Хавсралт 7.1).** |

[4] Payment services / electronic money status https://register.fca.org.uk/s/firm?id=0010X00004ToxgQQAR



232

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ №1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

| | | | |
|---|---|---|---|
| 2. | Банкны дансны орлого, Хэвийн зээлийн багц | ХААН банк дахь Сэндли ББСБ ХХК-ийн 5176387172 тоот харилцах данс болон бусад банкан дахь харилцах, хадгаламжийн дансдын орлого, 600 сая төгрөгийн үлдэгдэл дүн бүхий хэвийн зээлийн багц | "Мони Маркет Фанд" ХХК, "Туркойс Финанс ББСБ" ХХК-тай байгуулсан 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 20240425-39-185/14-183 тоот Репо зээлийн гэрээ, №B-20240425-39-185/14-183 тоот Барьцааны гэрээний дагуу барьцаалсан (Хавсралт 7.1). |
| 3. | Банкны данс ны орлого, Хэвийн зээлийн багц | ХААН Банк дахь 5176387172 тоот харилцах данс болон бусад банкан дахь харилцах, хадгаламжийн дансдын орлого, 450 сая төгрөгийн үлдэгдэл дүн бүхий хэвийн зээлийн багц | "Мони Маркет Фанд" ХХК, "Ашид Капитал ББСБ" ХХК-тай байгуулсан 2024 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 20240416-30-287/14-182 тоот Репо зээлийн гэрээ, №B-20240416-30-287/14-182 тоот Барьцааны гэрээний дагуу барьцаалсан (Хавсралт 7.1). |
| 4. | Банкны данс ны орлого, Хэвийн зээлийн багц | ХААН Банк дахь 5176387172 тоот харилцах данс болон бусад банкан дахь харилцах, хадгаламжийн дансдын орлого, 750 сая төгрөгийн үлдэгдэл дүн бүхий хэвийн зээлийн багц | "Мони Маркет Фанд" ХХК, "Си-И Си-Инвестмент ББСБ" ХХК-тай байгуулсан 2024 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 20240416-59-19/14-181 тоот Репо зээлийн гэрээ, №B-20240416-59-19/14-181 тоот Барьцааны гэрээний дагуу барьцаалсан (Хавсралт 7.1) |
| 5. | ББСБ-ын актив | | "Капитрон банк" ХК-тай байгуулсан 2024 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 3096-024/39 тоот Зээлийн гэрээ /зээлийн шугам/-ний дагуу мөн өдрийн 3096-2024/39-1 тоот Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээний дагуу барьцаалсан байна. (Хавсралт 7.1) |
| 6. | Банкны дансны орлого, Хэвийн зээлийн багц | ХААН Банк дахь 5176387172 тоот харилцах данс болон бусад банкан дахь харилцах, хадгаламжийн дансдын орлого, | "Мони Маркет Фанд" ХХК, "Тэнгэрлиг Авто Финанс ББСБ" ХХК-тай байгуулсан 2024 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 20240319-32-8/14-180 тоот Репо зээлийн |



УЛААНБААТАР ХОТ ... ХХК 5183855 9021031195 СТС2420

СЗХ 2024 он 05 сар 10 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

| | | | |
|---|---|---|---|
| | | 150 сая төгрөгийн үлдэгдэл дүн бүхий хэвийн зээлийн багц | гэрээ, В-20240319-32-8/14-180 тоот Барьцааны гэрээний дагуу барьцаалсан. (Хавсралт 7.1) |
| 7. | Банкны дансны орлого, Хэвийн зээлийн багц | ХААН Банк дахь 5176387172 тоот харилцах данс болон бусад банкан дахь харилцах, хадгаламжийн дансын орлого, 900 сая төгрөгийн үлдэгдэл дүн бүхий хэвийн зээлийн багц | "Мони Маркет Фанд" ХХК, "Туркойс Финанс ББСБ" ХХК-тай байгуулсан 2024 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 20240319-39-173/14-179 тоот Репо зээлийн гэрээ, №В-20240319-39-173/14-179тоот Барьцааны гэрээний дагуу барьцаалсан (Хавсралт 7.1). |
| 8. | Банкны дансны орлого, Хэвийн зээлийн багц | ХААН Банк дахь 5176387172 тоот харилцах данс болон бусад банкан дахь харилцах, хадгаламжийн дансын орлого, 750 сая төгрөгийн үлдэгдэл дүн бүхий хэвийн зээлийн багц | "Мони Маркет Фанд" ХХК, "Нэг Инвеско ББСБ" ХХК-тай байгуулсан 2024 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 20240208-40-59/14-173 тоот Репо зээлийн гэрээ, №В-20240208-40-59/14-173 тоот Барьцааны гэрээний дагуу барьцаалсан (Хавсралт 7.1). |
| 9. | ББСБ-ын актив | "Сэндли ББСБ" ХК-ийн хэвийн ангилалтай зээлийн багц (гэрээнд заасны дагуу) | "Капитрон банк" ХК-тай байгуулсан 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 3096-2023/165 тоот Зээлийн гэрээ, 3096-2023/165-1 тоот Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээний дагуу барьцаалсан (Хавсралт 7.1). |

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар дээр дурдсанаас өөр Үнэт цаас гаргагчийн барьцаанд байгаа хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө байхгүй болно (Хавсралт 12.1).

***Тээврийн хэрэгсэл.*** Компани нь 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар нийт 732 тээврийн хэрэгслийг өмчилдөг (Хавсралт 7.2) бөгөөд эдгээр нь аливаа байдлаар барьцаалагдаагүй байна. Компани нь эдгээр 732 тээврийн хэрэгслийг бүгдийг нь фидуцийн гэрээний дагуу өмчилж байгаа бөгөөд компанийн өөрийн өмчлөлийн тээврийн хэрэгсэлгүй байна. (Хавсралт 12.1)

***Үл хөдлөх эд хөрөнгө.*** УБЕГ-ын Эд хөрөнгийн бүртгэлийн 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн албан бичиг (Хавсралт 7.3)-ээр Компани нь аливаа үл хөдлөх хөрөнгө өмчилдөггүй болно.

***Газар эзэмших эрх.*** Газар зохион байгуулалтын албаны 2024 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 01-05/1978 дугаар албан бичиг (Хавсралт 7.6)-т тусгаснаар Нийслэлийн Засаг даргын



УЛААНБААТАР ХОТ ... ХХК 5183655 9021031195

захирамжаар Компанийн нэр дээр эзэмшүүлж, ашиглуулсан эрхийн бүртгэл 2024 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн байдлаар Газрын кадастрын мэдээллийн сангийн "Лэнд менежер" программ байхгүй буюу Компани нь аливаа газар эзэмших эрх эзэмшдэггүй байна (Хавсралт 12.1).

Дээрхийг нэгтгэн дүгнэвэл, Үнэт цаас гаргагч нь хувьцаа, тээврийн хэрэгслээс өөр хөрөнгө эзэмшдэггүй бөгөөд тус эд хөрөнгийн өмчлөх эрх нь хүчин төгөлдөр, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээгээгүй байна (Хавсралт 12.1).

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт "Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг энэ хуулийн 33.2.1-д заасан хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг энэ хуулийн 33.2.3-т заасан аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна" гэж заасны дагуу тус МДСХ нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээллүүдийг нягталж нийтэд ил болсон мэдээлэл, төрийн болон эрх бүхий байгууллага, Үнэт цаас гаргагчийн зүгээс гаргаж өгсөн баримт бичигт харьцуулсан дүн шинжилгээний үндсэн дээр Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээлэл нь үнэн зөв, хууль зүйн хувьд хүчин төгөлдөр эсэхийг дүгнэв.

МДСХ нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий дараах мэдээлэл Үнэт цаас гаргагч, төрийн болон бусад эрх бүхий байгууллагаас гаргуулж авсан баримт материалтай нийцэж байх тул үнэн зөв тусгагдсан байна гэж үзэв. Үүнд:

- Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагдсан огноо, оноосон нэр, оршин байгаа газрын шуудангийн болон холбоо барих хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагаа;
- Үнэт цаас гаргагч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, улсын бүртгэлд бүртгэсэн огноо;
- Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, түүнд хувьцаа эзэмшигч нарын эзлэх хувь, зарласан болон гаргасан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ;
- Үнэт цаас гаргагчийн холбогдох этгээдийн тухай;
- Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, тэдгээрийн өмчлөл дэх хувьцааны тоо, хувь хэмжээний талаарх мэдээлэл;
- Үнэт цаас гаргах шийдвэр /үнэт цаасны тоо, хэлбэр, нэрлэсэн үнэ, нийтэд санал болгох үнэ, нөхцөл, татан төвлөрүүлэх хөрөнгийн зориулалт г.м/;
- Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл, удирдлагын баг, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод, эрх бүхий албан тушаалтны мэдээлэл;
- Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөл;
- Нээлттэй хүрээнд санал болгож байгаа үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг;
- Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн таа болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл, тэдгээрийн хэрэгжилтийн тухай мэдээлэл;
- Компанийн эрх бүхий байгууллагаар батлуулсан ногдол ашгийн бодлого;
- Тухайн үнэт цаасыг нээлттэй хүрээнд санал болгох ажиллагаанд оролцож байгаа зохицуулалттай этгээд, мэргэжлийн үйлчилгээ үзүүлж буй (үндсэн андеррайтер, аудит, хууль, үнэлгээний байгууллага) этгээдийн тухай, тэдгээртэй байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагын тухай талаарх;
- Үнэт цаас гаргагч болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлсэн хуулийн этгээдүүдийн хоорондох үүсэж болзошгүй аливаа сонирхлын зөрчлөөс сэргийлэх талаар гаргасан мэдэгдэл.

Дээр дурдсан хууль зүйн ач холбогдолтой мэдээллээс бусад Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлт, бүтээгдэхүүн, үйлчилгээ, санхүүжих зэрэглэл, борлуулалтын хэмжээ, ашиг, алдагдал

2024 06 10
2024 -05- 17
БҮРТГЭВ-02

зэрэг санхүүгийн гүйцэтгэл, шинжилгээ, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд хамаарах зах зээлд эзэлж буй байр суурь, өрсөлдөгч байгууллагуудын тухай мэдээлэл, зах зээлийн судалгаа, нөхцөл байдал, салбарын тойм, салбарын үзүүлэлт, тэдгээрт агуулагдсан элийн застийн ерөнхий мэдээлэл, дунд хугацааны бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөлөл, өрийн хэрэгслийн хүү тогтоосон үндэслэл болон санхүүгийн тайланд тусгагдсан баталгаажуулах боломжгүй тоон үзүүлэлт, харъяат бус байгууллагуудын хийсэн дүн шинжилгээ, санхүүгийн тооцоолол, үнэлгээ, дүгнэлт, Үнэт цаас гаргагчийн талаар олон нийтэд ил, тодорхой үйл баримт, түүхэн замнал, ололт, амжилт зэрэг бизнесийн үйл ажиллагаа, танилцуулга болон хувьцаа анхдагч зах зээлд байршуулах, захиалга авах, худалдах, арилжих нөхцөл зэрэг мэдээлэлд МДСХ дүн шинжилгээ хийгээгүй болохыг дурдаж байна.

Нэгтгэн дүгнэвэл, Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны танилцуулгад тусгасан хууль зүйн мэдээлэл нь үнэн зөв, хууль зүйн хувьд хүчин төгөлдөр байна гэж дүгнэв.



УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183857
9021031195 СТС2420

[illegible] Үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч [illegible] тодорхойлох.

Дүгнэлтийн энэ хэсэгт Үнэт цаас гаргагч болон түүний толгой компанийн гэрчилгээ, дүрэм Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын дэлгэрэнгүй лавлагаа, хувьцаа эзэмшигчдийн анкет зэрэг мэдээллийг үндэслэн Үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлж байна.

***Компанийн хяналтыг хэрэгжүүлэгч***

Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэгт "Хуулийн этгээд удирдах байгууллагаараа дамжуулан иргэний эрх зүйн харилцаанд орно" гэж заасан тул бид эдгээр компаниудын хувьцаа эзэмшигч, ТУЗ, Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж, шийдвэр гаргахад хамгийн нөлөө бүхий хувь хүн (хүмүүс)-ийг Үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байна гэж үзэв. Ингэхдээ Компанийн тухай хуулийн компанийн нэгдлийн талаар зохицуулсан 6 дугаар зүйл, нэгдмэл сонирхолтой этгээдийг тодорхойлсон тус хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсгийг үндэслэн тодорхойллоо.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 22900002005073 тоот Компанийн хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа (Хавсралт 1.3), 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 22900002005092 тоот Компанийн хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа (Хавсралт 1.4)-г гаргуулан судалсан.

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Монгол улсад бүртгэлтэй "Сэндли ББСБ" ХК-ийн дэлгэрэнгүй лавлагаа, Үнэт цаас эзэмшигчдийн судалгаанаас харахад (Хавсралт 1.19, Хавсралт 1.15) уг компанийн хувьцааг 3293 хүн, хуулийн этгээд эзэмшиж байна. Компанийн хувьцааны хяналтын багцыг буюу 56,42% хувийг "Монголын финтек групп" ХК эзэмшиж байна (Хавсралт 1.15, 1.19).

"Монголын финтек групп" ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 41 тоот хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрээр батлагдсан, дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөж буй дүрмээс үзвэл тус компанийн саналын эрхтэй энгийн хувьцааны 76.6%-ийг Монгол Улсын хуулийн этгээд "Монголиан мючуал финанс групп" ХХК, үлдсэн хувьцааг Компанийн бусад хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна (Хавсралт 9.1, Хавсралт 9.2).

Түүнчлэн Үнэт цаас гаргагчийн саналын эрхтэй энгийн хувьцааны 0.77%-ийг "Радикс технологи" ХХК, 8,95%-ийг "Сэндли Эмплойе" ХХК, 29,97%-ийг олон нийт буюу бусад жижиг хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна (Хавсралт 1.19). "Радикс технологи" ХХК-ийн дүрмийн 5.2.1-д зааснаар нийт гаргасан энгийн хувьцааны 22%-ийг "Монголиан мючуал финанс групп" ХХК эзэмшиж байгаа (Хавсралт 9.6, Хавсралт 9.7), "Сэндли Эмплойе" ХХК-ийн дүрмийн 7.1-т зааснаар компанийн цорын ганц хувьцаа эзэмшигч нь "Монголиан мючуал финанс групп" ХХК байна (Хавсралт 9.8, Хавсралт 9.9).

"Монголиан мючуал финанс групп" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан, дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөж буй дүрмийн 6.2-д зааснаас үзвэл, тус компанийн саналын эрхтэй энгийн хувьцааны 100%-ийг Сингапур улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд болох Монгол Мючуал Пте. Лтд эзэмшиж байна. (Хавсралт 9.3, Хавсралт 9.4)

"Монгол Мючуал" Пте. Лтд-ийн хувьцааг дор дурдсан хувьцаа эзэмшигчид /хувь хүмүүс/ эзэмшиж байна. (Хавсралт 9.5) Үүнд:

| № | Овог, нэр/ Хуулийн этгээдийн нэр | Эзэмшиж буй хувь |
|---|---|---|
| 1 | Баттулгын Наранбат | 70% |
| 2 | Мөнхторийн Цолмон | 30% |

Иргэний хуулийн 26.4-т: "Хуулийн этгээд удирдах байгууллагаараа дамжуулан иргэний эрх зүйн харилцаанд орно" гэж заасан тул бид эдгээр компанийн хувьцаа эзэмшигч, ТУЗ, Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж, шийдвэр гаргахад хамгийн нөлөө бүхий хувь хүн (хүмүүс) Үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байна гэж үзэв. Ингэхдээ Компанийн тухай хуулийн компанийн нэгдлийн талаар зохицуулсан 6 дугаар зүйл, нэгдмэл сонирхолтой этгээдийг тодорхойлсон 99.1-д дурдсан зохицуулалтыг анхааралдаа авсан болно.

Дээрх бүх анализын үндсэн дээр Дүгнэлт гаргах өдрийн байдлаар "Монгол Мючуал" Пте. Лтд-ийн 70 хувийг эзэмшигч, Сэндли ББСБ ХК-ийн ТУЗ-ийн дарга Баттулгын Наранбат, "Монгол Мючуал" Пте. Лтд-ийн 30 хувийг эзэмшигч, Сэндли ББСБ ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн Мөнхторийн Цолмон нар нь хамтдаа, эсхүл Б.Наранбат дангаараа "Сэндли ББСБ" ХК-ийн жинхэнэ хяналтыг хэрэгжүүлэгч гэж үзэв.

***Эцсийн өмчлөгч***

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10.1.14 дэх заалт, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар аливаа хуулийн этгээд эцсийн өмчлөгчөө бүртгүүлсэн байх үүрэгтэй.

Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаанаас үзвэл, Үнэт цаас гаргагчийн эцсийн өмчлөгчөөр "Монголын финтек групп" ХК-ийг 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдөр улсын бүртгэлд бүртгэсэн байна (Хавсралт 1.19). Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-д "эцсийн өмчлөгч" гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасныг ойлгоно гэж заасан. "Монголын финтек групп" ХК-ийг эцсийн өмчлөгчөөр бүртгэсэн нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д зааснаар эцсийн өмчлөгч нь "...хүн" байна гэсэнтэй нийцэхгүй байна.

Зөвлөхийн зүгээс Компанийн хяналтыг хэрэгжүүлэгчийн талаар хийсэн дээр дурдсан дүн шинжилгээг үндэслэн Үнэт цаас гаргагчийн эцсийн өмчлөгч нь Монгол Улсын иргэн Баттулгын Наранбат гэж үзэж болохоор байна.

Энэхүү дүгнэлт нь бусад хүчин зүйлийн нөлөөгөөр өөрчлөгдөх боломжтойг дурдаж байна.



СЗХ 2024.06.10 БҮРТГЭВ №1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-17 БҮРТГЭВ-02
УЛААНБААТАР ХОТ ... КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 TC2420

***Эрүүгийн хэрэг***

Цагдаагийн Ерөнхий Газар Мэдээлэл, Дүн Шинжилгээ, Шуурхай Удирдлагын Албаас 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 156/1112 тоот албан бичиг (Хавсралт 10.1)-т "Сэндли ББСБ" ХХК-ийг эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдаж байсан эсэхийг цагдаагийн байгууллагын мэдээллийн сангаас шалгахад мэдээлэл бүртгэгдээгүй байна. Өөрөөр хэлбэл, Компани нь эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй болно.

***Иргэний хэрэг***

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архиваас 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 1/778 тоот албан бичиг (Хавсралт 10.2)-т тусгаснаар Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн байдлаар Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэрэгт тус тус хариуцагчаар оролцож байгаагүй байна. Түүнчлэн Гүйцэтгэх захирлын албан бичиг (Хавсралт 12.1)-т дурдсанаар сүүлийн 3 жилийн хугацаанд 3 иргэний хэрэгт нэхэмжлэгчээр оролцож байсан бөгөөд үүнээс иргэн Г.И-д холбогдох 591,869,589 төгрөгийн үнийн дүн бүхий "Сэндли ББСБ" ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагатай нэг иргэний хэрэг Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна.

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон улсын арбитрын 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 4/489 тоот Тодорхойлолт (Хавсралт 10.3)-д тусгаснаар тус арбитраар хянан шийдвэрлэгдсэн болон арбитрын ажиллагаа явагдаж байгаа хэрэгт Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн байдлаар нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй байна.

Мөн Улаанбаатар хотын худалдааны танхимын дэргэдэх Үндэсний ба Олон улсын Арилжааны арбитрын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А-24/37 албан тоот Тодорхойлолт (Хавсралт 10.4)-д Компани нь сүүлийн 3 жилийн хугацаанд тус арбитрт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцож байгаагүй болохыг тусгасан байна.

***Захиргааны хэрэг***

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны Шүүхийн тамгын газрын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр ирүүлсэн 372 тоот албан бичиг (Хавсралт 10.5)-т тусгаснаар Үнэт цаас гаргагч нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч болон гуравдагч этгээдээр сүүлийн 3 жилийн хугацаанд оролцож байгаагүй байна.

***Тухайн компанийн эрхэлдэг үйл ажиллагаатай холбоотойгоор хийсэн хууль зүйн нэмэлт судалгаа, шинжилгээ***

Бид Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны болон МХБ-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын зохицуулалтаас гадна хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахад ач холбогдолтой гэж үзэн зарим хөндлөнгийн мэдээлэл цуглуулж, тус Компанитай холбоотой дараах нөхцөл байдлуудыг тогтоосон болно Үүнд:

- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр ирүүлсэн 03-04/455 тоот албан бичиг (Хавсралт 10.6)-т тусгаснаар 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар Үнэт цаас гаргагч нь Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас Өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн үндэслэлээр захиргааны шийттэл оногдуулж байгаагүй ба Өрсөлдөөний тухай хуулийн 15.1.6-д заасан зах зээлд давамгай байдалтай аж ахуйн нэгжээр тогтоож байгаагүй болно."Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоо"-ноос 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр гаргасан 2024/016 тоот албан бичиг (Хавсралт 10.7)-т тусгаснаар Үнэт цаас гаргагч нь "Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоо" -ны гишүүн бөгөөд гишүүний ёс зүйн дүрэм зөрчсөн үйлдэл гаргаж хариуцлага хүлээж байгаагүй байна.
- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр гаргасан 01/467 тоот албан бичиг (Хавсралт 10.8)-т тусгаснаар "Сэндли ББСБ" ХК нь 2022 оноос "Үнэт цаасны хадгаламжийн болон үнэт цаастай холбогдолтой төлбөр гүйцэтгэх гэрээ"-г байгуулан ажиллаж байгаа бөгөөд 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар гэрээний үүргийн хэрэгжилтийн зөрчилгүй, өр төлбөрийн тооцоогүй байна.
- Монголын хөрөнгийн биржийн 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр гаргасан 01/239 тоот албан бичиг (Хавсралт 10.9)-т тусгаснаар "Сэндли ББСБ" ХК нь 2023 оны жилийн эцсийн байдлаар дүгнэсэн хууль, журам, гэрээнд заасан үүргийн хэрэгжилтийн ***хангалттай*** үнэлгээтэй, компанийн засаглалын кодексын хэрэгжилтийг мөрдөн ажиллаж байна.
- Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн Хариу хүргүүлэх тухай 164 албан тоот (Хавсралт 10.10)-д тусгаснаар "Сэндли ББСБ" ХК нь биржийн бус зах зээлд үнэт бүртгүүлж байгаагүй болно.

Бидэнд ирсэн мэдээллээр Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн хугацаанд аж ахуйн үйл ажиллагааны эрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байгаагүй байна (Хавсралт 12.1).

## 11. Татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх

Компани нь 2024 оны 03-р сарын 20-ны өдрийн Монголын татварын албаны тодорхойлолтоор татварын байгууллагад 481,772.0 төгрөгийн илүү төлөлттэй, 250,170,580.50 төгрөгийн дутуу төлөлттэй (Хавсралт 11.1) байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 03-р сарын 18-ны өдрийн Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт (Хавсралт 11.2)-д заасанаар Үнэт цаас гаргагч нь нийгмийн даатгалын шимтгэлийн өглөггүй байна.

Мөн Гаалийн ерөнхий газрын тодорхойлолтод заасанаар Компани нь 2024 оны 03-р сарын 19-ний өдрийн байдлаар гаалийн байгууллагад татварын өргүй (Хавсралт 11.3), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2024 оны 03-р сарын 20-ны өдөр гаргасан Тодорхойлолт (Хавсралт 11.4)-д заасанаар шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй байна.

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Компанид гааль, нийгмийн даатгал, татварын дутуу төлөлттэй холбоотой нөхөн татвар, торгууль, алданги оногдуулаагүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөргүй талаар Компанийн гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.1).

**ХҮНДЭТГЭСЭН,**

**"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН-ИЙН**

**ГИШҮҮН, ХУУЛЬЧ**

Д.ДҮГЭРЖАВ

2024-05-17

БҮРТГЭВ-02

ХХК

5183855

9021031195

СЗХ
он 2024 .09. 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2024 -05- 17
БҮРТГЭВ-02

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав

# МОНГОЛ УЛС
# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

0000086027

2011.07.06
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9022001010
/ Улсын бүртгэлийн дугаар /

5495997
/ Регистрийн дугаар /

Өмгөөллийн Эм Ди Эс энд хаанлекс ХХН Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Гэрээ
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол
/ шийдвэрийн нэр /

01
/ дугаар /

2011.06.30
/ он, сар, өдөр /

6910
/ код /

Хууль зүйн зөвлөгөө өгөх
/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

/ код /
/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй
/ хугацаа /

6
/ хувьцаа эзэмшигчийн тоо /

1,500.00
/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 5-р хороо, 5 хороолол, 22, 24 тоот, Утас1: 91913905, Утас2: 99999678, Факс:
/ хуулийн этгээдийн оршин байгаа газрын хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2014 он 8 сар 7 өдөр

УЛААНБААТАР ХОТ
ХХК
5183855
9021031195

СЗХ
2024.09.10
БҮРТГЭВ
№ 01

2024.05.17
БҮРТГЭВ-02

## Харилцах дансны бүртгэл

| Харилцагч банкны нэр | Дансны төрөл | Дансны дугаар | Бүртгэсэн ажилтан тэмдэг |
|---|---|---|---|
| Голомт банк | Валютын | 1410003014 | Г.Өлзийбаяр |
| Голомт банк | Валютын | 1105091644 | У.Дашдаваасүрэн |
| Голомт банк | Төгрөгийн | 1105088619 | У.Дашдаваасүрэн |
| Голомт банк | Валютын | 1105079895 | В.Хандсүрэн |
| Голомт банк | Төгрөгийн | 1105079891 | В.Хандсүрэн |
| Голомт банк | Төгрөгийн | 1105079895 | В.Хандсүрэн |
| Голомт банк | Валютын | 1105079882 | В.Хандсүрэн |

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Жанчивдорж овогтой Майзориг-г Захирал-р томилсныг бүртгэв | 2011 07 07 | Г.Өлзийбаяр |
| 2 | Дахин гэрчилгээ олгов | 2014.08.07 | У.Дашдаваасүрэн |
| 5 | Голомт төв банк банкны 1105088620 тоот төгрөгийн дансыг бүртгэв<br>Голомт төв банк банкны 1105088622 тоот валютын дансыг бүртгэв<br>Голомт төв банк банкны 1105088623 тоот валютын дансыг бүртгэв<br>Голомт төв банк банкны 1105091643 тоот төгрөгийн дансыг бүртгэв<br>Голомт төв банк банкны 1105091645 тоот төгрөгийн дансыг бүртгэв<br>Голомт төв банк банкны 1105091646 тоот валютын дансыг бүртгэв | 2014 08.07 | У.Дашдаваасүрэн |
| 7 | Голомт төв банк банкны 1410003013 тоот төгрөгийн дансыг бүртгэв<br>Голомт төв банк банкны 1105079887 тоот төгрөгийн дансыг бүртгэв<br>Голомт төв банк банкны 1105079889 тоот төгрөгийн дансыг бүртгэв<br>Голомт төв банк банкны 1105079893 тоот төгрөгийн дансыг бүртгэв<br>Голомт төв банк банкны 1105079894 тоот валютын дансыг бүртгэв<br>Голомт төв банк банкны 1105079888 тоот валютын дансыг бүртгэв<br>Голомт төв банк банкны 1105079890 тоот валютын дансыг бүртгэв | 2011 07 07 | Г.Өлзийбаяр |
| 9 | ХААН банк банкны 5007965794 тоот төгрөгийн дансыг бүртгэв<br>ХААН банк банкны 5007965807 тоот валютын дансыг бүртгэв | 2015 06 04 | Б.[illegible] |
| 10 | [illegible] | [illegible] | [illegible] |
| 11 | Хувь нийлүүлэгчээс 1 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 6 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2018 01 22 | Б.Дашдаваасүрэн |
| 12 | Өөрийн хөрөнгийн хэмжээ 250 мян.төг-р хасагдаж нийт 1250 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв. | 2018.01.22 | Б.Дашдаваасүрэн |
| 13 | Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 1 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 6 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2018 09.21 | С.Мөнхбаяр |
| 14 | Хувь нийлүүлэгчээс 1 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 5 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2018.10.01 | Ж.Оюумаа |
| 15 | Өөрийн хөрөнгийн хэмжээ 125 мян.төг-р хасагдаж нийт 1125 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв | 2018.10.01 | Ж.Оюумаа |
| 16 | Өөрийн хөрөнгийн хэмжээ 250 мян.төг-р хасагдаж нийт 875 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв | 2019 06 17 | Э.Эрдэнэбилэг |
| 17 | Хувь нийлүүлэгчээс 1 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 4 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2019.06.17 | Э.Эрдэнэбилэг |
| 18 | Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, , , , Сүхбаатарын талбай 2 Сэнтрал тауэр 13 давхар 1301 тоот, Утас1 91911905, Утас2 99939678, Факс хаягийг өөрчилсөнийг бүртгэв | 2019 06.14 | Э.Эрдэнэбилэг |
| 24 | Эцсийн өмчлөгч-ийн бүртгэв. | 2020.08.14 | О.Мөнхсайхан |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

УЛААНБААТАР ХОТ
ХХК
5183855
9021031195

СЗХ
2021 .08. 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -05- 17
БҮРТГЭВ-02

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 02 сарын 24 өдөр Дугаар 42 Улаанбаатар хот

"Эм Ди Эс энд ХаанЛекс" ХХН-ийг
үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө үзүүлэх
хуулийн этгээдээр бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.15, 24.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 451 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам"-ын 4.2, 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Өмгөөллийн "Эм Ди Эс энд ХаанЛекс" ХХН-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсүгэй.

2. Өмгөөллийн "Хаанлекс" ХХН, Өмгөөллийн "Эм Ди Эс энд Ассошэйтс" ХХН нар нь нэгдэж "Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН болсон тул "Хаанлекс" ХХН, "Эм Ди Эс энд Ассойшэйтс" ХХН нарыг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийн бүртгэлээс хассугай.

3. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг Өмгөөллийн "Эм Ди Эс энд ХаанЛекс" ХХН /Ж.Майзориг/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Ю.Нэргүй/-т үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ДЭД ДАРГА Д.БАТБОЛД

0000 УЛААНБААТАР ХОТ
ХХК
5183855
9021031195

СЗХ он сар өдөр 2024.06.18 БҮРТГЭВ № 01

2024-06-17 БҮРТГЭВ-02

## ХАВСРАЛТ-3. БАРЬЦАА ГАРГАГЧИЙН ТОГТООЛ, САНХҮҮГИЙН ТАЙЛАН

МОНГОЛЫН ФИНТЕК ГРУПП

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

24.04.25 № 31

***Компанийн эзэмшиж буй хувьцаа болон газар эзэмших эрх барьцаалуулах тухай***

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, "Монголын финтек групп" ХК (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.22 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. **Компанийн охин компани болох "Сэндли ББСБ" ХК-ийн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгон гаргах нийт 10,000,000,000 *(арван тэрбум)* төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэглийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар дараах хөрөнгийг барьцаалуулахаар шийдвэрлэсүгэй. Үүнд:**

1.1. **Хувьцаа:**

| № | Барьцаа хөрөнгийн нэр | Барьцаалуулагчийн нэр | Тоо, ширхэг | Барьцааны зүйлийн үнэлгээ |
|---|---|---|---|---|
| 1 | "Сэндли ББСБ" ХК-ийн энгийн хувьцаа | "Монголын финтек групп" ХК | 111,785,000 | СЗХ-ны журамд заасанаар Монголын хөрөнгийн бирж дээрх хувьцааны сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшаар тооцсон үнэлгээний 70%-иар тооцох. |

1.2. **Газар эзэмших эрх:**

| № | Барьцаа хөрөнгийн нэр | Хаяг талбайн хэмжээ | Улсын бүртгэлийн дугаар, гэрчилгээний дугаар | Хөрөнгийн үнэлгээний байгууллагын үнэлгээ |
|---|---|---|---|---|
| 1 | Зочид буудлын цогцолбор, олон нийтийн газар | Дорноговь аймгийн Замын-үүд сум, 1-р баг Соёмбо 406 хаягт байрлах нэгж талбарын 4401010485 дугаар бүхий 10000 м.кв газар эзэмших эрх | Г-0000237626<br>Э-0714002972 | Хөндлөнгийн хөрөнгийн үнэлгээний "Файн Эстимэйт ХХК-ийн 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хөрөнгийн үнэлгээний тайланг үндэслэх |
| 2 | Худалдаа, нийтийн | Дорноговь аймгийн Замын- | Г-0000237326<br>Э-0714002967 | |

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

СЭХ
2024.06.10
БҮРТГЭВ
№ 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

| | | | |
|---|---|---|---|
| үйлчилгээний газар, төв, цогцолбор зориулалттай | үүд сум, 1-р баг Соёмбо 320 хаягт байрлах нэгж талбарын 4401002556 дугаар бүхий 1200 м.кв газар эзэмших эрх | | |

1. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт дурдсан хувьцаа болон газар эзэмших эрхийг "Сэндли ББСБ" ХК-ийн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгон гаргах нийт 10,000,000,000 *(арван тэрбум)* төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөр төлөгдөж дуусах хүртэлх хугацаагаар андеррайтер "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК-д барьцаалуулж, холбогдох гэрээ байгуулах бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Наранбат)-д олгосугай.

2. Энэхүү тогтоолын 2 дахь хэсэгт дурдсан барьцааны гэрээний хугацаанд Компанийн эзэмшиж буй "Сэндли ББСБ" ХК-ийн 111,785,000 ширхэг энгийн хувьцааг эрх бүхий байгууллагад бүртгүүлж тусгаарлуулах, газар эзэмших эрхийн барьцааг холбогдох журмын дагуу бүртгүүлэхийг Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Д.Хажидмаа ИЭ0125190)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад арга хэмжээ авахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Наранбат)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Д.Хажидмаа)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
М.ЦОЛМОН

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
2024 он 06 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 - 05 - 17
БҮРТГЭВ-02

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ЧАДВАРЛАГ
АУДИТ ХХК
Нягтлан бодох бүртгэл, аудит, санхүүгийн хөндлөнгийн хяналтын байгууллага

# "МОНГОЛЫН ФИНТЕК ГРУПП" ХК

2023 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болгосон группийн нэгтгэсэн санхүүгийн тайлан

Улаанбаатар хот

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
9021031195

СЗХ 2024.06.10 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-17 БҮРТГЭВ-02

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд
нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (2023 оны 12 дугаар сарын 31)

# АГУУЛГА


БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ... 1
УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ ... 3
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ... 4
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ... 8
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН ... 8
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН ... 9
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН ... 9
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН ... 10
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ ... 11

1. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БЭЛТГЭЖ, ТАЙЛАГНАСАН ҮНДЭСЛЭЛ ... 12
2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТОМООХОН ТООЦООЛЛУУД ... 23
3. МӨНГӨН ХӨРӨНГӨ ... 24
4. ДАНСНЫ АВЛАГА ... 25
5. ТАТВАР, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН АВЛАГА ... 25
6. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ ... 25
7. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ/ТООЦОО ... 26
8. БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ ... 26
9. ҮНДСЭН ХӨРӨНГӨ ... 26
10. БИЕТ БУС ХӨРӨНГӨ ... 27
11. ТАТВАРЫН ӨР ... 27
12. БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ... 27
13. УРЬДЧИЛЖ ОРСОН ОРЛОГО ... 27
14. ЭЗДИЙН ӨМЧ ... 28
15. ЭЗДИЙН ӨМЧИЙН БУСАД ХЭСЭГ ... 29
16. ХУРИМТЛАГДСАН АШИГ ... 29
17. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО ... 29
18. БУСАД ОРЛОГО ... 29
19. БОРЛУУЛАЛТ, МАРКЕТИНГИЙН БОЛОН ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ ... 30
20. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ ... 31
21. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА ... 31
22. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧИЛ ... 34


УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

# БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| **Үүсгэн байгуулах шийдвэр** | "Монголын финтек групп" ХК нь Үүсгэн байгуулагчийн 2021 оны 04 дугаар сарын 02–ний өдрийн 01 тоот шийдвэрийн дагуу Хувьцаат компани /хаалттай хувьцаат компани/ хэлбэрээр үүсгэн байгуулагдсан. |
| **Гэрчилгээ ба лиценз** | 2021 оны 04 дугаар сарын 05–ны өдөр Монгол улсын Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас 6692257 тоот регистрийн, 9008001006 тоот бүртгэлийн дугаар бүхий хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг олгосон. |
| **Зорилго** | "Монголын финтек групп" ХК нь финтек технологид суурилсан санхүүгийн олон төрлийн үйлчилгээг өөрийн охин компаниудаар дамжуулан хүргэх, хилийн чанадад буй монголчуудад болон гадаад, дотоодын хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгч, иргэдийг холбох, олон улсад тэдгээрийн бизнесийг таниулах, өргөжүүлэх гүүр нь буюу Санхүүгийн холдинг компани болох зорилготой. |
| **Хаяг байршил** | Бүртгэлтэй хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Арт хаус, 3 давхарт |
| **Холбоо барих утас** | 70157700 |
| **Өөрийн хөрөнгийн хэмжээ** | 6,507,382,400 төгрөг |
| **Үндсэн болон туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл** | 63990- Мэдээлэл технологийн үйл ажиллагаа эрхлэх<br>70200- Менежментийн зөвлөгөө өгөх |

| | | |
|---|---|---|
| **ТУЗ-ийн гишүүд:** | **Дарга** | М.Цолмон |
| | Ердийн гишүүд | Б.Наранбат<br>Б.Эрдэнэ<br>Ё.Амарбат<br>Ц.Баярхүү<br>Н.Билгүүн |
| | Хараат бус гишүүд | Dwyer III James Bernard<br>Б.Жавхлан<br>Г.Цацрал |

СЗХ 2024 он 06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

| | | |
|---|---|---|
| **ТУЗ-ын дэргэдэх хороод** | **Эрсдэл, комплайнсын удирдлагын хороо дарга гишүүн** | **Б.Нарантуяа Д.Баярбат Д.Эрдэнэ** |
| | **Аудитын хороо дарга гишүүн** | **Д.Баярбат Б.Чинбат Н.Билгүүн** |
| | **Цалин урамшуулын хороо дарга гишүүн** | **Б.Наранбат М.Цолмон Д.Эрдэнэ** |
| **Удирдлагын баг** | ТУЗ-ын дарга | М.Цолмон |
| | Гүйцэтгэх захирал | Б.Наранбат |
| | Ерөнхий нягтлан бодогч | О.Нямдэлэг |

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 2

СЭХ
2024.06.10 өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-17
БҮРТГЭВ-02

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (2023 оны 12 дугаар сарын 31)

---

**УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ**

Удирдлага нь санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, компанийн 2023 оны 12-р сарын 31-ний байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу зохистой толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага дараах үүрэг хариуцлагыг биелүүлсэн. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн зохимжтой бодлогыг сонгох, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй нягт нямбай тооцоолон, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн.
- Компанийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа залилан мэх, зүй бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.
- Санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагаанд үндэслэн бэлтгэсэн.

"Монголын финтек групп" ХК-ийн ТУЗ-ийн дарга М.Цолмон, гүйцэтгэх захирал Б.Наранбат компанийн санхүүгийн удирдлагыг хариуцан ажилладаг ерөнхий нягтлан бодогч О.Нямдалай бид энэхүү 1-ээс 34 дугаар хуудсанд үзүүлсэн компанийн санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх компанийн санхүүгийн байдал болон мөн тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн болохыг үүгээр мэдэгдэж байна.

| | | |
|---|---|---|
| ТУЗ-ийн дарга | Гүйцэтгэх захирал | Ерөнхий нягтлан бодогч |
| М.Цолмон | Б. Наранбат | О.Нямдалай |

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195
СТС 420

СЭХ
2024.06.10
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-17
БҮРТГЭВ-02

ЧАДВАРЛАГ АУДИТ ХХК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
1-р хороо, Оо плаза, 201 тоот
Утас / Факс: (976) 99999924
E-mail: ChadvarlagAUDIT@gmail.com
2024.03.13 № А/24-10

"МОНГОЛЫН ФИНТЕК ГРУПП" ХК -ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Дүгнэлт**

Бид "Монголын финтек групп" ХК ба түүний охин компаниудын 2023 оны 12 сарын 31-ээр нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр "Монголын финтек групп" ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар, нэгтгэсэн санхүүгийн байдал, тухайн жилийн нэгтгэсэн санхүүгийн гүйцэтгэл болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх)-ын дагуу үнэн, зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой аудиторын үүрэг хэсэгт тусгасан. Бид нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (НБЁЗОУСЗ-ын дүрэм)-ийн дагуу Группээс хараат бус ба НБЁЗОУСЗ-ын дүрмийн дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

**Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд нь тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал асуудлууд юм. Нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудлууд тус бүрт тусад нь дүгнэлт гаргаагүй болно.

УЛААНБААТАР ХОТ
ОЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ 2024.06.10 БҮРТГЭВ №31
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

ЧАДВАРЛАГ АУДИТ ХХК

**Бусад мэдээлэл**

Удирдлага нь бусад мэдээллийн талаар үүрэг хүлээнэ. Бусад мэдээлэлд төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") -ийн дарга болон гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл багтана. Бусад мэдээлэл нь энэхүү аудиторын тайланг гаргасан өдрөөр бидэнд бэлтгэн хүргүүлдэг.

Энэхүү санхүүгийн тайланд өгөх манай дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид бусад мэдээлэлд ямар нэгэн дүгнэлт өгөхгүй.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид дээр тодорхойлогдсон бусад мэдээллийг бэлэн болсон үед уншиж үүрэгтэй бөгөөд бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад цуглуулсан мэдээллээс материаллаг хэмжээний алдаатай эсэхийг авч үзэх ёстой.

Бусад мэдээллийг уншиж, бусад мэдээлэл нь материаллаг хэмжээний зөрүүтэй эсвэл алдаатай байвал бид засаглах эрх бүхий этгээдэд мэдэгдэх үүрэгтэй бөгөөд бид бусад горимыг гүйцэтгэж, дараах зүйлсийг тодорхойлно:

- Бусад мэдээлэл нь материаллаг хэмжээний алдаатай эсэх;
- Группийн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай эсэх;
- Группийн болон түүний орчны талаарх бидний ойлголтыг шинэчлэх хэрэгтэй эсэх.

Хэрэв бид бусад мэдээлэлд материаллаг хэмжээний алдаа байгаа гэж үзсэн ба түүнийг нь залруулаагүй бол, бид залруулагдаагүй материаллаг хэмжээний алдааг манай тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд хүргэхийн тулд зохистой арга хэмжээ авахыг засаглах эрх бүхий этгээдээс хүсэх болно.

Хэрэв бид группийн аудитлагдсан санхүүгийн тайлан болон группийн болон түүний орчны талаарх бидний ойлголтод материаллаг хэмжээний алдаа байна гэж үзвэл, бид АОУС-ын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

**Нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн үүрэг хариуцлага**

Удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага группийн үйл ажиллагааг нь зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
6021031195 СТС2420

ЧАДВАРЛАГ АУДИТ ХХК

Засаглах эрх бүхий этгээд нь группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

**Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын үүрэг хариуцлага**

Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай залилан үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг болгож, бид аудитын туршид мэргэжлийн үнэлэмжээ ашиглан, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Мөн бид:

- Залилан болон алдаанаас үүсэж болохуйц нэгтгэсэн санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлох, түүнийг үнэлэн, уг эрсдлүүдэд тохирох аудитын горимуудыг боловсруулан гүйцэтгэж, аудитын дүгнэлтийн үндэслэл болох хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авсан. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг. Учир нь залилангийн үед хуйвалдаан, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл хэрэгжүүлэх явдлууд тохиолдсон байж болдог.
- Аудитын горимуудыг сонгохтой холбоотойгоор дотоод хяналтуудыг судалдаг ба энэ нь группийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгогүй болно.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал болон удирдлагын бэлтгэсэн нягтлан бодох бүртгэлийн тааамаглал болон холбогдох тодруулгуудын бодитой байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн тасралтгүй байх нөхцөлийг үргэлжлүүлэн хангах Группын чадварт мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал болон материаллаг тодорхой бус байдал үүссэн эсэхийг үнэлдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал байгаа гэж үзвэл аудиторын дүгнэлт болон нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулдаг ба уг тодруулгууд нь зохистой биш гэж үзсэн тохиолдолд бид дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь манай аудиторын тайлангийн өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд үндэслэсэн байдаг. Хэдий тийм боловч ирээдүйд болох үйл явдал эсвэл нөхцөл байдал нь группийг үйл ажиллагаагаа явуулахад нь саад учруулж болох юм.
- Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлдэг. Үүнд тодруулгаас гадна санхүүгийн тайланг үнэн зөв толилуулсан эсэхийг үнэлэхийн тулд эх гүйлгээ, үйл явдлуудыг толилуулсан эсэхийг үнэлдэг.
- Нэгтгэсэн санхүүгийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд группийн доторх компаниуд болон бизнесийн үйл ажиллагаа болон санхүүгийн мэдээллийн талаарх зохистой аудитын нотолгоо олж авсан. Бид нэгтгэсэн санхүүгийн тайлангийн

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд
нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (2023 оны 12 дугаар сарын 31)

ЧАДВАРЛАГ АУДИТ ХХК

аудитын гүйцэтгэл болон түүнийг удирдан зохион байгуулахтай холбоотой үүргийг хүлээдэг. Мөн бид өөрсдийн аудитын дүгнэлтийн талаар үүрэг хүлээдэг.

Аудитор нь засаглах эрх бүхий этгээдтэй зөвхөн аудитын ажлын цар хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад илэрсэн ач холбогдол бүхий асуудлуудаар холбогддог ба үүнд аудитын үеэр аудиторын илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц алдаа болон дутагдал орно.

**Бусад асуудал**

Энэхүү тайланг өөр ямар нэг зорилгоор биш, Монгол Улсын компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд зориулан аудитыг гүйцэтгэсэн болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд аливаа бусад этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.

ЗАХИРАЛ
Д.РЭНЦЭНХАНД

СЗХ 2024 .06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

2024-05-17 БҮРТГЭВ-02

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд
нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (2023 оны 12 дугаар сарын 31)

## САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

*(мянган төгрөгөөр)*

| Үзүүлэлт | тодруулга | 2022 | 2023 |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | 24,882,569.0 | 41,812,076.6 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 1 | 6,297,118.0 | 12,520,758.3 |
| Дансны авлага | | 4,112,587.2 | 4,181,320.7 |
| Зээлийн авлага | 2 | 13,672,597.0 | 22,952,788.6 |
| Бусад авлага | 2.1 | 188,894.9 | 186,608.8 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 3 | 100,000.0 | 1,094,512.6 |
| Бараа материал | | 23,224.3 | 90,090.2 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 4 | 28,579.0 | 23,715.8 |
| Урьдчилж төлсөн зардал/ тооцоо | 5 | 459,568.6 | 762,281.6 |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | 12,127,036.6 | 7,957,297.2 |
| Үндсэн хөрөнгө (цэвэр) | 6 | 2,363,274.1 | 2,177,131.4 |
| Биет бус хөрөнгө (цэвэр) | 7 | 2,566,627.5 | 5,196,465.4 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 8 | 7,197,135.0 | 583,700.4 |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | | 37,009,605.6 | 49,769,373.8 |
| **ӨР ТӨЛБӨР** | | 17,154,792.5 | 45,685,219.4 |
| **Богино хугацаат өр төлбөр** | | 17,154,792.5 | 40,891,219.4 |
| Дансны өглөг | 9 | 3,341,034.9 | 2,110,184.4 |
| Цалингийн өглөг | 9 | 1,809.7 | 1,997.1 |
| Татварын өглөг | 9.1 | 65,423.1 | 696,885.5 |
| НДШ-ийн өглөг | 9.1 | 214.9 | 320.5 |
| Богино хугацаат зээл | 9.2 | 1,256,534.2 | 4,205,700.0 |
| Хүүгийн өглөг | 9.2 | 394,760.1 | 944,183.8 |
| Урьдчилж орсон орлого | 9.2 | | 41,590.9 |
| Нөөц өр төлбөр | 9.2 | 0 | 0 |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 9.2 | 12,095,015.6. | 32,890,357.2 |
| **Урт хугацаат өр төлбөр** | | 0 | 4,794,000.0 |
| Урт хугацаат зээл | 10 | | 4,794,000.0 |
| **ЭЗДИЙН ӨМЧ** | | 19,854,813.1 | 19,854,813.1 |
| - Хувьцаат | | 17,898,196.4 | 12,823,696.4 |
| Халаасны хувьцаа | 11 | | (3,482,144.2) |
| Нэмж төлөгдсөн капитал | 11 | 6,883,618.1 | 5,427,427.2 |
| Эздийн өмчийн бусад хэсэг | 11 | 8,300.3 | 8,519.8 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | 11 | (4,935,301.7) | (10,693,344.8) |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | | 37,009,605.6 | 49,769,373.8 |

*Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.*

УЛААНБААТАР ХОТ
5183855
9021031195

СЗХ
он сар өдөр
2024.06.10
БҮРТГЭВ
№ 01

2024.06.17
БҮРТГЭВ-02

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд
нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (2023 оны 12 дугаар сарын 31)

## ОРЛОГЫН ТАЙЛАН

*(мянган төгрөгөөр)*

| Үзүүлэлт | 2022 | 2023 |
|---|---|---|
| **Борлуулалтын орлого (цэвэр)** | 7,464,461.9 | **12,490,248.6** |
| Борлуулалтын өртөг | 855,670.6 | 4,715,798.1 |
| **Нийт ашиг (алдагдал)** | **6,608,791.3** | **7,774,450.5** |
| Бусад орлого | 675.0 | 3,601,938.9 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 7,954,704.4 | 15,251,288.4 |
| Бусад зардал | | 143,543.0 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | | 209122.6 |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | (1,345,238.1) | (3,809,319.4) |
| Орлогын татварын зардал | | 385,057.8 |
| **Татвар дараах ашиг (алдагдал)** | **(1,345,238.1)** | **(4,194,377.2)** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | **(1,345,238.1)** | **(4,194,377.2)** |
| **Орлогын нийт дүн** | **(1,345,238.1)** | **(4,194,377.2)** |
| Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | | |

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

*(мянган төгрөгөөр)*

| Үзүүлэлт | Өмч | Халаасны хувьцаа | Нэмж төлөгдсөн капитал | Нөөц сангуудын үлдэгдэл | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 2022 | 17,898,196.4 | - | 6,883,618.1 | 8,300.3 | (4,935,334.1) | 19,854,780.7 |
| НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | - | - | | (8,923.0) | (8,923.0) |
| **Залруулсан үлдэгдэл** | 17,898,196.4 | - | 6,883,618.1 | 8,300.3 | (4,944,257.1) | 19,845,857.7 |
| НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | (1,554,710.5) | (1,554,710.5) |
| Тайлант оны цэвэр ашиг (алдагдал) | | | | | (4,194,377.2) | (4,194,377.2) |
| Өмчид гарсан өөрчлөлт | (5,074,500.0) | (3,482,144.2) | (1,456,190.9) | 219.5 | | (10,012,615.6) |
| 2023 | 12,823,696.4 | (3,482,144.2) | 5,427,427.2 | 8,519.8 | (10,693,344.8) | 4,084,154.4 |

*Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланд холбогдох тодруулгын хамтаар уншина уу.*

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
9021031195 5183855 СТС2020

СЗХ
он сар өдөр
2024.06.10 В
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02



"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд
нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (2023 оны 12 дугаар сарын 31)

# МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

*(мянган төгрөгөөр)*

| Үзүүлэлт | 2022 | 2023 |
|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **Мөнгөн орлогын дүн** | **7,605,878.1** | **14,341,991.7** |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого | 7,428,255.7 | 11,919,503.6 |
| Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | 177,622.4 | 2,422,488.1 |
| **Мөнгөн зарлагын дүн** | **8,096,048.3** | **18,443,050.3** |
| Ажилчдад төлсөн | 1,819,635.2 | 3,654,232.0 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 227,716.6 | 453,540.8 |
| Бараа материал худалдан авахад | 1,707,028.3 | 5,535,510.8 |
| Ашиглалтын зардалд төлсөн | 202,367.2 | 611,611.5 |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 119,727.3 | 103,299.6 |
| Хүүний төлбөрт төлсөн | 336,293.0 | 4,341,685.4 |
| Татварын байгууллагад төлсөн | 22,633.0 | 657,234.0 |
| Бусад мөнгөн зарлага | 3,660,847.7 | 3,085,936.2 |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(490,170.2)** | **(4,101,058.6)** |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **Мөнгөн орлогын дүн** | | **4,051,370.4** |
| Бусдад олгосон зээл, урьдчилгааны буцаан төлөлт | | 3,998,423.4 |
| Хүлээн авсан ногдол ашиг | | 52,947.0 |
| **Мөнгөн зарлагын дүн** | **625,889.0** | **8,470,307.8** |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 625,889.0 | 3,095,130.5 |
| Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаалт | | 5,151,386.8 |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | 223,790.5 |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(625,889.0)** | **(4,418,937.4)** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **Мөнгөн орлогын дүн** | **7,370,319.2** | **284,848,311.2** |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | 267,230,211.2 |
| Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 7,370,319.2 | 17,618,100.0 |
| **Мөнгөн зарлагын дүн** | **7,595,713.0** | **270,104,674.9** |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 7,595,713.0 | 265,813,114.4 |
| Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | | 4,291,560.5 |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(225,393.8)** | **14,743,636.3** |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(1,341,453.0)** | **6,223,640.3** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **7,638,571.0** | **6,297,118.0** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **6,297,118.0** | **12,520,758.3** |

*Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.*

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
9021031195 СТС2420

СЭНДЛИ БОНД ХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024.06.10
БҮРТГЭВ
№ 01

2024.05.17
БҮРТГЭВ-02

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд
нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (2023 оны 12 дугаар сарын 31)

## 1. Үндсэн үйл ажиллагаа ба зохион байгуулалт

Монголын финтек групп ХК нь 2021 онд Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан. Компанийн толгой компани болох "Монголиан мючуал финанс групп" ХХК нь 76.6 хувийг эзэмшдэг бөгөөд үлдсэн 23.4 хувийг нь жижиг хувьцаа эзэмшигчид эзэмшдэг.

Энэхүү аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэхдээ Компани болон түүний охин компаниудыг нэгтгэн бэлтгэсэн байна. Группийн охин компаниудын эрхлэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг тодруулга 23-т тодруулсан.

Группийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон нэгтгэсэн санхүүгийн тайланг 2023 оны 12-р сарын 31-ний өдрөөр группийн удирдлага батлан гаргасан.

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй

### 2.1 Мөрдсөн стандарт

Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС)-ын дагуу бэлтгэж, тайлагнасан байна.

### 2.2 Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь

Нэгтгэсэн санхүүгийн тайланг зарим үндсэн хөрөнгөөс бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт үндэслэн бэлтгэсэн. Нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгаснаар зарим үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн үнэ буюу бодит үнэ цэнээр бүртгэсэн. Түүхэн өртөг нь хөрөнгийг худалдан авах үед төлсөн эсвэл солилцсон зүйлийн бодит үнэ цэнэ байдаг.

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг группийн үйл ажиллагааны үндсэн мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн дүнгүүдийг тодруулгад өөрөөр заагаагүй бусад тохиолдолд мянгачилан, санхүүгийн мэдээллийг мянган төгрөгөөр илэрхийлсэн.

### 2.3 Нэгтгэлийн суурь

Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Компанийн болон Компанийн хяналтад байдаг охин компаниудын санхүүгийн тайлангуудаас бүрддэг. Хяналт байгаа эсэхийг дараах элементүүдээр хэмждэг:

- Санхүүжигчид үзүүлэх нөлөө;
- Санхүүжигчийн өгөөжөөс хүртэх эрх;
- Санхүүжигчийн өгөөжөөс хүртэх дүнд нөлөөлөх чадвар.

Компани санхүүжигчид хяналт тогтоож байгаа эсэхийг дээрх гурван элементүүдэд өөрчлөлт гарсан эсэхээр дахин үнэлдэг.

Компани охин компанийг хяналтдаа оруулсан өдрөөс эхлэн нэгтгэсэн санхүүгийн тайланд уг охин компанийг нэгтгэх ба охин компани дахь хяналтаа алдсан өдрөөс эхлэн нэгтгэхээ зогсоодог. Тусгайлан, охин компанийн тайлант жилийн орлого, зардлыг нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгахдаа тухайн охин компани дахь хяналтыг олж авсан өдрөөс тухайн охин компани дахь хяналтаа алдсан өдөр хүртэлх тайлант жилийн орлого, зардлыг ашиг алдагдал болон бусад нэгтгэсэн иж бүрэн орлогын тайланд нэгтгэдэг. Хэрэв шаардлагатай бол, группийн нягтлан бодох бүртгэлийн бодлоготой

УЛААНБААТАР ХОТ
5183855
9021031195
СТС2420

СЭНДЛИ БОНД ХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024.06.10 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд
нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (2023 оны 12 дугаар сарын 31)

нийцүүлэхийн тулд охин компанийн санхүүгийн тайланд тохируулга хийж болно.

Толгой болон охин компаниудын хооронд гарсан орлого, зардал, мөнгөн гүйлгээ болон хөрөнгө, өр төлбөр, эзэмшийн дансдын үлдэгдлийг нэгтгэсэн санхүүгийн тайланд бүрэн устгана.

2.4 Бараа материал

Бараа материалыг жигнэсэн дундаж өртгийн арга, цэвэр боломжит үнэ цэнээр тооцоолсон худалдан авалт ба үйлдвэрлэлийн өртгөөр хэмжинэ. Худалдан авах зардал нь тайлант хугацаанд худалдан авалтын холбогдох нэмэлт зардлыг агуулдаг. Үйлдвэрлэлийн зардал нь шууд хамааралтай зардлууд ба бүтээгдэхүүнтэй холбоотойгоор шууд бус зардлын зарим хэсгийг багтаана. Цэвэр боломжит үнэ цэнэ нь тооцоолсон борлуулалтын үнээс холбогдох гүйцэтгэлийн зардал болон борлуулалтын зардлыг хассан дүн юм.

Бараа материалын хэрэглээний болон цэвэр боломжит үнэ цэнийг харгалзан материал, бүтээгдэхүүний хувьд хасагдуулга нөөцийг шаардлагатай үед тодорхойлно.

2.5 Урьдчилгаа төлбөр

Урьдчилгаа төлбөр нь мөнгөн хэлбэрээр төлөгдсөн боловч зардал нь гарч амжаагүй төлбөр эсвэл бараа материалаа хүлээн аваагүй төлбөрөөс бүрдэнэ. Урьдчилгаа төлбөрийг анх хөрөнгөөр бүртгэх ба төлөгдсөн мөнгөн дүнгээр нь хэмжинэ. Уг төлбөрийг тухайн зардал нь гарсан тохиолдолд ашиг, алдагдал руу, бараагаа хүлээн авсан тохиолдолд холбогдох хөрөнгө руу ангилдаг.

Урьдчилгаа төлбөртэй холбоотой бүтээгдэхүүний өртөг эсвэл үйлчилгээ нь нэг жилийн дотор зарлагадах бол урьдчилгаа төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд эргэлтийн хөрөнгөөр ангилна. Бусад тохиолдолд эргэлтийн бус хөрөнгөөр ангилна.

Тайлант жилийн эцэст групп урьдчилгаа төлбөрийн дансны үнэд үнийн цэнийн бууралт гарсан эсэхийг хянадаг.

2.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн өртөг дараах зардлуудаас бүрдэнэ. Үүнд:

- Хөнгөлөлт урамшууллын дараах худалдан авсан үнэ, гаалийн татвар болон худалдан авалттай холбоотой буцаан олгогдохгүй татвар;
- Удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож түүнийг байршуулах болон шаардлагатай нөхцөлийг хангахтай холбоотой гарсан аливаа шууд зардлууд;

Худалдаж авсан програм хангамж нь холбогдох тоног төхөөрөмжийн үйл ажиллагаатай салшгүй холбоотой бол тухайн тоног төхөөрөмжийн нэг хэсэг байдлаар капиталжуулна.

Тайлант үеийн эцэст газар болон барилгаас бусад үндсэн хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнэ бууралтыг хассан дүнгээр хэмжсэн.

Дахин үнэлсэн үндсэн хөрөнгийн элэгдлийг тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг. Дахин үнэлсэн хөрөнгийг худалдах эсвэл ашиглалтаас хасах үед дахин үнэлгээний санд үлдсэн нэмэгдлийг хуримтлагдсан ашиг руу шууд шилжүүлнэ.

УЛААНБААТАР ХОТ 5183855 9021031195 СТС2420

2

СЭХ он 2024 сар 06 өдөр 18 БҮРТГЭВ № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд
нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (2023 оны 12 дугаар сарын 31)

Үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан дараа үеийн зардал нь тухайн хөрөнгийн анх тооцсон бүтээмжийн түвшинг нэмэгдүүлэх замаар групп-д эдийн засгийн ирээдүйн өгөөжийг авчрах магадлалтай үед зардлын дүнгээр хөрөнгийн дансны үнийг нэмэгдүүлдэг.

Бусад бүх худалдан авалтын дараа гарсан зардлуудыг гарсан тайлант үед нь зардлаар бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн өртөг эсвэл дахин үнэлсэн дүнгээс тэдгээрийн үлдэгдэл өртгийг хассан дүнг шулуун шугамын аргаар, ашиглалтын хилд нь элэгдүүлдэг. Тооцоолсон ашиглалтын жил, үлдэх өртөг болон элэгдлийг бодох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил:

| | |
|---|---|
| Тоног төхөөрөмж | 10 жил |
| Тавилга, эд хогшил, компьютер | 3-10 жил |
| Тээврийн хэрэгсэл | 10 жил |

Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл үндсэн хөрөнгийн зүйлийг бүртгэлээс хасдаг. Үндсэн хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг алдагдалд тусгана.

2.7 Биет бус хөрөнгө

Ашиглагдах жил нь тодорхой, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжсэн. Биет бус хөрөнгийн хорогдлыг шулуун шугамын аргаар, биет бус хөрөнгийн ашиглалтын жилээр тооцоолсон. Тооцоолсон ашиглалтын жил болон элэгдэл бодох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг. Ашиглагдах жил нь тодорхойгүй, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өртгөөс нь үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжсэн.

Биет бус хөрөнгийн ашиглалтын жил нь 3-аас 10 жил.

Биет бус хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл хөрөнгийн зүйлийг бүртгэлээс хасдаг. Биет бус хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг алдагдалд тусгана.

2.8 Биет ба биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант үеийн эцэст биет хөрөнгийн дансны үнийг үнэ цэнэ бууралтын шинж тэмдэг илэрсэн эсэхийг тодорхойлох шалгалтад хамруулдаг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрсэн бол үнэ цэнэ бууралтын алдагдал (ийм алдагдал гарсан бол)-ыг тогтоохын тулд тухайн хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно. Хөрөнгийн нөхөгдөх

боломжтой үнийг тухайн хөрөнгийн хувьд тооцоолох боломжгүй бол уг хөрөнгийн харьяалагдах "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн нөхөгдөх боломжтой үнийг тооцоолно. "Мөнгөн орлого үүсгэгч нэгж"-д хуваарилах боломжийн бөгөөд тууштай суурь үзүүлэлтийг тодорхойлж чадвал аж ахуйн зориулалттай хөрөнгийг тодорхой "мөнгөн орлого

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

СЭНДЛИ АЙ ББСБ ХК УЛААНБААТАР ХОТ

үүсгэгч нэгж"-д хуваарилах ба ийм боломжгүй бол хамгийн боломжийн бөгөөд тууштай ашиглах боломжтой суурь үзүүлэлтийг ашиглан хамгийн жижиг "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-д хамааруулан шалгадаг.

Хөрөнгийн эсвэл "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн нөхөгдөх боломжтой үнэ гэдэг нь хөрөнгийн бодит үнээс борлуулах өртөг зардлыг хассан цэвэр дүн ба хөрөнгийг ашигласнаар олж болох өгөөж хоёрын аль их нь тогтоогдоно. Ашигласнаар олж болох өгөөжийг үнэлэхдээ татварын өмнөх дискаунтын хувиар дискаунтлан тооцсон ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг ашигладаг. Дискаунтын хувь нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэлийн одоогийн зах зээлийн үнэлэмжийг тусгасан байх ёстой. Үнэ цэнэ бууралтын шалгалтын зорилгоор дангаар нь шалгах боломжгүй хөрөнгийг цаашид ашигласнаар бусад хөрөнгө эсвэл бүлэг хөрөнгөөс ("мөнгөн орлого үүсгэгч нэгж") хамааралгүйгээр дангаараа мөнгөн орлого бий болгох чадвартай хамгийн жижиг хөрөнгийн бүлэгт хамааруулан шалгадаг.

Нэгж хөрөнгө эсвэл түүний харьяалагдах "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн дансны үнэ нь нөхөгдөх боломжтой тооцоолсон үнээс их байвал үнэ цэнэ бууралтын алдагдлыг бүртгэж, нэгтгэсэн иж бүрэн орлогын тайланд тусгана. "Мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн хувьд тодорхойлсон үнэ цэнэ бууралтын алдагдлыг бүртгэхдээ эхлээд тухайн нэгжид хуваарилагдсан гүүдвилийн дансны үнийг бууруулах ба үлдсэн алдагдлын дүнгээр тухайн нэгж (бүлэг нэгж)-д багтсан бусад хөрөнгийн дансны үнийг хувь тэнцүүлэн бууруулна.

Өмнөх жилүүдэд бүртгэсэн үнэ цэнэ бууралтын алдагдал буурсан эсвэл алдагдал үгүй болсон эсэхийг илрүүлэхийн тулд үнэ цэнэ бууралтын алдагдлыг тайлангийн өдрөөр дахин хянана. Нөхөгдөх боломжтой дүнг тодорхойлоход хэрэглэсэн тооцоолол өөрчлөгдсөн бол үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана. Үнэ цэнийн бууралт бүртгээгүй байсан бол байх байсан элэгдэл хорогдлыг хассан хөрөнгийн дансны үнийг бууруулахгүй байхаар бодож үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана.

2.9. Санхүүгийн хэрэглүүд

Групп тухайн хэрэгслийн гэрээний нэг оролцогч тал болсон үед санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд тусгадаг.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анх бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Санхүүгийн хэрэгсэл (бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслээс бусад)-ийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг анх бүртгэлд тусгахдаа санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ дээр нэмж эсвэл ба өр төлбөрийн бодит үнэ цэнээс хасаж бүртгэнэ. Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг шууд тухайн жилийн ашиг алдагдлаар бүртгэнэ.

2.10. Санхүүгийн хөрөнгө

Ердийн журмаар худалдах, худалдан авах санхүүгийн хөрөнгийг бодит гүйлгээ гарсан өдрөөр нягтлан бодох бүртгэлд тусгах эсвэл бүртгэлээс хасдаг.

Ердийн журмаар худалдах, худалдан авах гэдэг нь тогтоосон хугацааны дотор эсвэл

тухайн зах зээл дээр тогтсон дүрэм журмаар хөрөнгийг шилжүүлэх нөхцөлөөр санхүүгийн хөрөнгийг худалдах, худалдан авахыг хэлнэ.
Санхүүгийн хөрөнгийг ангиллаас нь хамааран санхүүгийн хөрөнгийг анх бүртгэсний дараа хорогдуулсан өртгөөр эсвэл бодит үнэ цэнээр нь хэмждэг.

2.10.1. Санхүүгийн хөрөнгийн ангилал

14

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд
нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (2023 оны 12 дугаар сарын 31)

Дараах нөхцөлүүдийг хангасан өрийн хэрэгслүүд нь дараа үеүдэд хорогдуулсан өртгөөр хэмжигдэнэ:

- Мөнгөн урсгалыг цуглуулахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилготой бизнесийн загвараар эзэмшдэг;
- Зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт ба гэрээний нөхцөлөөр тодорхой заасан өдрөөрх төлөгдөөгүй үндсэн төлбөрийг үлдэгдэлд тооцсон хүүгийн төлбөрөөс бүрдэх төлбөрүүдийн мөнгөн урсгалыг тогтоосон хугацаанд хуваарийн дагуу хүлээн авах нөхцөлтэй байх.

Дараах нөхцөлүүдийг хангасан өрийн хэрэгслүүдийг хэмжихдээ бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тухайн жилийн бусад иж бүрэн орлогоор тусгана (БҮЦБИБО):

- Мөнгөн урсгалыг цуглуулахын тулд эсвэл арилжаалах зорилгоор санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилго бүхий бизнесийн загвараар эзэмшдэг;
- Тодорхойлон заасан өдрүүдэд зөвхөн төлөгдөөгүй үлдсэн үндсэн төлбөр ба хүү төлөлтийн мөнгөн урсгалыг хүлээн авах санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөлтэй байх;

Бусад санхүүгийн хөрөнгийг хэмжихдээ бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг (БҮЦАА).

Дээр дурдсанаас үл хамааран, групп санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед дараах ангиллыг сонгон бүртгэж болно:

- Групп тодорхой шалгууруудыг хангасан тохиолдолд буцаах сонголтгүйгээр өмчийн хэрэглүүр дэх хөрөнгө оруулалтыг дараа үеүдэд хэмжихдээ бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад иж бүрэн орлогоор тусгана.
- Групп өрийн хэрэглүүрээр хөрөнгө оруулалтыг хорогдуулсан өртөг эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад иж бүрэн орлогоор бүртгэх шаардлагыг сонгосон байсан боловч бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тайлагнах нь илүү тохиромжтой, бүртгэлийн нийцгүй байдлыг арилгана гэж үзэж байвал бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тухайн жилийн ашиг алдагдлыг тусгаж болно.

Группийн санхүүгийн хөрөнгө нь хорогдуулсан өртгөөр санхүүгийн хөрөнгөөс бүрдэж байна.

*Хорогдуулсан өртөг болон үр ашигт хүүгийн арга*

Үр ашигт хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өрийн хорогдуулсан өртгийг тооцоолон, хүүгийн орлогыг хугацааны туршид хуваарилах арга юм.

Худалдаж авсан эсвэл бий болгосон үнэ цэнийн бууралт бүхий зээл ба авлагын санхүүгийн хөрөнгөөс бусад (анхлан хүлээн зөвшөөрөхдөө үнэ цэнэ нь буурсан хөрөнгө) санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр (үр ашигт хүүгийн хувьд нөлөөлөх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний зардал, хөнгөлөлт урамшууллыг багтаасан)-ийг санхүүгийн өрийн гэрээний хугацааны эцэс гэхэд анх бүртгэсэн цэвэр дансны үнэтэй тэнцүү байхаар үнэ цэнийн бууралтын нөөцийг хасахын өмнөх төлбөрийн өрийн хугацаа эсвэл шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хуваарилахад хэрэглэдэг хүүгийн хувь юм. Худалдаж авсан эсвэл бий болгосон үнэ цэнийн бууралт бүхий зээл ба авлагын санхүүгийн хөрөнгийн хувьд гэрээний мөнгөн урсгалыг тооцоолох үед ирээдүйн нийт хугацаанд хүлээгдэж буй авлага ба зээлийн алдагдлыг оруулан тохируулсан үр ашигт хүүгийн түвшинг ашиглан өрийн хэрэглүүрийг анхлан хорогдуулан бүртгэнэ.

Санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөг гэдэг нь санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед хэмжсэн дүнгээс үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хасаж, анхны дүн

ба дуусгавар болох үеийн дүнгийн хооронд үүссэн аливаа зөрүүг үр ашигт хүүний арга ашиглан тооцсон хорогдуулгыг нэмж аливаа алдагдлын нөөцийг тохируулсан дүнгээр тодорхойлогдоно. Санхүүгийн хөрөнгийн дансны үнэ нь аливаа алдагдлын нөөцөөр тохируулаагүй дүн байна.

Хүүгийн орлогыг бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь дараа үеүдэд тухайн жилийн бусад иж бүрэн орлогоор тусгах эсвэл хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэрэгслийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан бүртгэлд тусгадаг. Худалдаж авсан эсвэл бий болгосон үнэ цэнийн бууралт бүхий зээл ба авлагын санхүүгийн хөрөнгийн хувьд, дараа үед үнэ цэнэ буурсан зээл ба авлагаас бусад, санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүний түвшинг ашиглан авлага ба зээлийн дансны дүнгээс хүүгийн орлогыг тооцно. Санхүүгийн хөрөнгийн анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээл ба авлагын үнэ цэнийн бууралт бий болсон санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүний түвшинг ашиглан аливаа алдагдлын нөөцийг багтаасан цэвэр дансны дүнгээс хүүний орлогыг тооцно.

Хэрэв дараагийн тайлагналын үеүдэд, үнэ цэнэ буурсан зээл ба авлагын санхүүгийн хэрэгслийн эрсдэл буурч, үнэ цэнийн бууралтгүй болох үед үр ашигт хүүгийн түвшинг ашиглан санхүүгийн хөрөнгийн дансны дүнгээс хүүгийн орлогыг тооцно.

Групп худалдаж авсан эсвэл бий болгосон үнэ цэнийн бууралт бүхий зээл ба авлагын санхүүгийн хөрөнгийн хувьд анх хүлээн зөвшөөрсөн гэрээний мөнгөн урсгалыг тооцоолох үед ирээдүйн нийт хугацаанд хүлээгдэж буй авлага ба зээлийн алдагдлыг оруулан тохируулсан үр ашигт хүүгийн түвшинг ашиглан хүүгийн орлогыг тооцоолон бүртгэнэ. Хэрэв дараагийн тайлагналын үеүдэд, үнэ цэнэ буурсан зээл ба авлагын санхүүгийн хэрэгслийн эрсдэл буурч, үнэ цэнийн бууралтгүй болсон тохиолдол цэвэр дансны дүнгээс тооцно.

Хүүгийн орлогыг тайлант үеийн ашиг, алдагдлаар тайлагнадаг ба "санхүүгийн болон бусад орлого хүүгийн орлого" хэсэгт ангилна.

2.10.2. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Групп хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн өмчийн хэрэгслээрх хөрөнгө оруулалтад хүлээгдэж буй алдагдлыг хүлээн зөвшөөрөн бүртгэдэг. Тухайн санхүүгийн хэрэгслийг хүлээгдэж буй алдагдлын дүн анх хүлээн зөвшөөрч бүртгэснээс хойш эрсдэлийн өөрчлөлтийг үнэлж тайлант хугацаа болгонд шинэчилнэ.

Групп дансны авлагад нийт хугацааны туршид хүлээгдэж буй алдагдлыг тооцоолон бүртгэдэг. НББОУС 39-ийн дагуу үнэ цэнийн бууралттай авлагаас бусад дансны авлагын үлдэгдэл нь 400 сая төгрөгөөс давсан бөгөөд даатгагдаагүй авлагыг тусгайлан үнэлж, үлдсэн авлагын дүнг хугацаа хэтэрсэн хоногт үндэслэн багцын аргаар тооцсон. Эдгээр санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй алдагдлыг тооцоолохдоо алдагдлын түүхэн мэдээллийг зээлдэгчдэд тусгайлан тодорхойлсон хүчин зүйлс, үндсэн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн нөхцөл байдал, одоогийн болон ирээдүйг таамаглаж буй мэдээллийг тайлагналын өдрөөр харгалзан тохируулсан матрицыг ашиглан тооцоолж болох бөгөөд уг тооцоололд тохиромжтой гэж үзвэл мөн мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг харгалзан үзэж болно.

Нийт хугацааны туршид хүлээгдэж буй алдагдал нь санхүүгийн хэрэгслийн хүлээгдэж буй нийт хугацааны туршид гарах бүхий л боломжит дефолт үйл явдлаас үүсэх алдагдлыг илэрхийлнэ.

*Зээл ба авлагын эрсдэлийн мэдээдэхүйц өсөлт*

Санхүүгийн хэрэгслийн зээлийн эрсдэл нь анх бүртгэлд тусгаснаас хойш мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн эсэхийг үнэлэхдээ групп анх бүртгэлд тусгасан өдрийн санхүүгийн хэрэгслээс үүссэн эрсдэлийг, тайлант өдрөөрх эрсдэлийн дүнтэй харьцуулдаг. Энэ

үнэлгээг хийхдээ групп үндэслэлтэй бөгөөд дэмжигдэхүйц тоон болон чанарын мэдээллийн аль алиныг нь харгалзан үзэх ба эдгээр нь түүхэн туршлага болон өндөр хүчин чармайлт, өртөг шаардахгүйгээр олж авах боломжтой ирээдүйг таамаглаж буй мэдээллүүд байна.

Ирээдүйг таамаглаж буй мэдээлэл нь группийн зээлдэгчийн үйл ажиллагаа эрхэлдэг салбарын ирээдүйн хэтийн төлөвийг агуулсан, эдийн засгийн шинжээчийн тайлангаас авсан мэдээлэл болон санхүүгийн шинжээч, засгийн газрын байгууллага, холбогдох судалгааны байгууллага, бусад ижил төстэй байгууллагаас гаргасан мэдээллүүд болон группийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой эдийн засгийн бодит болон урьдчилан таамагласан янз бүрийн гадаад эх сурвалжийн мэдээллүүдийг авч үздэг.

Зээл ба авлагын эрсдэл нь анх хүлээн зөвшөөрснөөс хойш мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн эсэхийг үнэлэхдээ дараах мэдээллийг харгалзан үзнэ:

- Санхүүгийн хэрэгслийн гадаад (хэрэв байгаа бол) эсвэл дотоод зээл ба авлагын үнэлгээний бодит эсвэл хүлээгдэж буй мэдэгдэхүйц бууралт;

- Тухайн санхүүгийн хэрэгслийн гадаад зах зээлийн эрсдэлийн үзүүлэлтүүдийн бууралт. Үүнд: ижил төстэй хэрэглүүрийн өгөөжийн түвшин ихээхэн ялгаатай байх, зээл ба авлагын эрсдэлийг солилцох гэрээний үнэ эсвэл шаардагдах цаг хугацаа болон үргэлжлэх байдлын улмаас санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь хорогдуулсан өртгөөсөө бага байх зэрэг юм;

- Одоо байгаа эсвэл урьдчилан таамагласан бизнест нөлөөлж болохуйц сөрөг өөрчлөлт, зээлдэгчийн өрийг эргэн төлөх чадварыг бууруулж болзошгүй нөлөөлөх санхүүгийн эсвэл эдийн засгийн нөхцөл байдлууд;

- Зээлдэгчийн үйл ажиллагааны бодит эсвэл хүлээгдэж буй үр дүнгийн мэдэгдэхүйц бууралт;

- Зээлдэгчийн бусад санхүүгийн хэрэгслүүдийн зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт;

- Зээлдэгчийн хууль эрх зүй, эдийн засаг, технологийн орчинд гарч буй бодит буюу хүлээгдэж буй томоохон сөрөг өөрчлөлтүүд нь төлбөрийн үүргээ биелүүлэх чадварыг мэдэгдэхүйцээр бууруулах.

Дээрх үнэлгээний үр дүнгээс үл хамааран групп анх бүртгэлд тусгаснаас хойш гэрээний төлбөр 30 хоногоос дээш хугацаагаар хэтэрсэн үед санхүүгийн хөрөнгийн зээл ба авлагын эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдсэн гэж үзнэ. Хэрвээ зээл ба авлагын эрсдэл мэдэгдэхүйцээр нэмэгдээгүйг илтгэх үндэслэлтэй бөгөөд дэмжигдэхүйц нотолгоо байгаа тохиолдолд эрсдэлийг мэдэгдэхүйцээр нэмэгдсэн гэж үзэхгүй байж болно.

Хэрэв санхүүгийн хэрэгсэл нь тайлант өдрөөр эрсдэлийн түвшин бага гэж тодорхойлогдсон бол дээр дурдсанаас үл хамааран групп санхүүгийн хэрэгслийн зээл ба авлагын эрсдэл анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц өсөлт гараагүй гэж үздэг. Санхүүгийн хэрэгсэл нь дараах нөхцөлд зээл ба авлагын эрсдэл бага гэж тодорхойлогдоно:

- Санхүүгийн хэрэгсэл нь эргэн төлөгдөхгүй байх эрсдэл багатай,
- Зээлдэгч ойрын хугацаанд гэрээний мөнгөн урсгалын үүргийг биелүүлэх бүрэн чадавхтай,
- Урт хугацаанд эдийн засгийн болон бизнесийн нөхцөл байдалд гарах сөрөг өөрчлөлт нь зээлдэгч гэрээний мөнгөн урсгалын үүргээ биелүүлэх чадварыг бууруулж болзошгүй боловч энэ нь заавал бууруулна гэж тооцохгүй байж болно.

Хэрэв группийн хөрөнгө нь дэлхийн түвшинд танигдсан зээл ба авлагын үнэлгээний тодорхойлолттой нийцсэн эсвэл хөндлөнгийн үнэлгээний мэдээллийн олдоц хомс

тохиолдолд, дотооддоо "хэвийн" гэж үнэлсэн санхүүгийн хөрөнгийг эрсдэл багатай гэж үзнэ. Хэвийн" гэсэн үнэлгээ нь оролцогч тал санхүүгийн хувьд өндөр чадавхтай бөгөөд өнгөрсөн хугацаанд хугацаа хэтэрсэн төлөгдөөгүй үүрэг үүсээгүй байхыг хэлнэ.

Групп зээл ба авлагын эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт гарсан эсэхийг тодорхойлоход ашигласан шалгуурууд нь зээл ба авлагын төлөгдөх хугацаа хэтрэхээс өмнө эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийг тодорхойлох үр ашигтай үзүүлэлтүүд гэдгийг тогтмол хянадаг ба шаардлагатай тохиолдолд өөрчилдөг.

*Дефаултын тодорхойлолт*

Групп дотоод удирдлагын зорилгоор түүхэн туршлагад үндэслэн, зээл ба авлагын эрсдэлийн дараах шалгууруудын аль нэгийг нь хангасан санхүүгийн хөрөнгүүд нь нөхөгдөх боломжгүй болсон үед түүнийг дефаулт үйл явдал гэж үздэг:

- Зээлдэгч гэрээнд заасан санхүүгийн харьцаа үзүүлэлтүүдийг зөрчсөн тохиолдолд; эсвэл
- Зээлдэгчийн талаар дотооддоо боловсруулсан эсвэл гадаад эх сурвалжаас авсан мэдээлэл нь зээлдэгч бусад зээлдүүлэгчдэд болон групп-д зээл ба авлагаа бүрэн эргүүлэн төлөх магадлал багатайг илэрхийлж буй тохиолдолд (Группын эзэмшиж буй барьцаа хөрөнгийг харгалзан үзэхгүй).

Дээрх шалгуураас үл хамааран группийн санхүүгийн хөрөнгийн төлбөр төлөх хугацаа 90 хоногоос дээш хугацаагаар хэтэрсэн бол дефаулт үйл явдал гэж үзнэ. Хэрвээ гэрээнд заасан үүргээ биелүүлэхэд нэмэлт хугацаа хэрэгтэй болсныг батлах үндэслэлтэй бөгөөд дэмжигдэхүйц мэдээлэл байгаа бол дээрх тодорхойлолтод хамаарахгүй байж болно.

*Зээл ба авлагын үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгүүд*

Нэг болон түүнээс дээш үйл явдал тухайн санхүүгийн хөрөнгөөс хүлээн авахаар тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй тохиолдолд тухайн санхүүгийн хөрөнгө нь зээл ба авлагын үнэ цэнийн бууралттай гэж үзнэ. Дараах тодорхойлолтууд нь санхүүгийн хөрөнгийн зээл ба авлагын үнэ цэнэ буурсан илэрхий нотолгоо болох юм:

a) Гэрээний үүргээ биелүүлэхгүй байх, тухайлбал эргэн төлөлтийг төлбөрийн хугацааг хэтрүүлэх эсвэл төлөх чадамжгүй болох
b) Үнэт цаас гаргагч эсвэл зээлдэгч талд томоохон хэмжээний санхүүгийн хүндрэл үүссэн;
c) Зээлдэгчийн санхүүжүүлэгч нь зээлдэгчийн санхүүгийн хүндрэлтэй байдлаас үүссэн эдийн засгийн болон гэрээний шалтгааны улмаас зээлдэгчидтэй тохирсон үүрэг амлалтаа хэрэгжүүлэх боломжгүй болох;
d) Зээлдэгч нь дампуурлаа зарлах эсвэл санхүүгийн хувьд дахин бүтцийн өөрчлөлт хийх магадлалтай болсон;
e) Санхүүгийн хүндрэлээс болж тухайн санхүүгийн хөрөнгийн идэвхтэй зах зээл байхгүй болох.

*Бүртгэлээс хасах*

Групп санхүүгийн хөрөнгийг зээлдэгч нь томоохон санхүүгийн хүндрэлд орсон ба зээлдэгчийн татан буугдах эсвэл дампуурах үйл явц эхэлсэн, авлага төлөгдөх хугацаа 2 жилээс дээш хугацаагаар хэтэрсэн зэрэг үйл явдлын аль нэг нь бий болсон үед буюу авлагын эргэн төлөлт хийгдэх бодит боломж байхгүй болсон үед бүртгэлээс хасна. Бүртгэлээс хасагдсан санхүүгийн хөрөнгийг Группийн бодлогын дагуу авлага цуглуулах үйл явц хийгдэж, хуулийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч болно. Бүртгэлээс хасагдсан авлага нь эргэн төлөгдсөн тохиолдолд тайлант жилийн ашиг,

СЗХ
2024 .08 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд
нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (2023 оны 12 дугаар сарын 31)

алдагдлын тайланд тусгана.

*Хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдлыг хүлээн зөвшөөрөх, хэмжих*

Хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдал нь төлбөр төлөгдөхгүй байх магадлал, алдагдал үүсэх магадлал болон эрсдэлд өртөх боломжтой зээл ба авлагын дүнгийн үржвэр юм. Төлбөр төлөгдөхгүй байх магадлал болон алдагдал үүсэх магадлалын үнэлгээ нь ирээдүйг таамаглаж буй мэдээллээр залруулагдсан түүхэн мэдээлэлд үндэслэгддэг.

Тайлагналын өдрийн байдлаар дансны үнээрээ толилуулагдсан эрсдэлтэй зээл ба авлагын санхүүгийн хөрөнгийг группийн зээлдэгчийн ирээдүйд шаардагдах санхүүжилтийн хэмжээ болон ирээдүйг таамаглаж буй мэдээллүүд ашиглан тодорхойлно.

Тайлангийн өдрөөрх эрсдэлд өртөх магадлалтай зээл ба авлага нь тухайн санхүүгийн хөрөнгийн дансны үнээрээ илэрхийлэгдсэн.

Санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдал нь гэрээний дагуу группийн хүлээн авах эрх бүхий нийт мөнгөн урсгал болон Группийн хүлээн авахаар тооцоолсон бүх мөнгөн гүйлгээг үр ашигт хүүгийн аргаар дискаунтчилсан дүнгийн зөрүүгээр тооцоологддог.

Хэрэв өмнөх тайлант үед санхүүгийн хэрэгслийн алдагдлын нөөц сан нь нийт хугацаанд хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдлаар хэмжигдсэн хэдий ч тайлант жилийн эцэст нийт хугацаанд хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдлын шалгуурыг хангаагүй бол групп хялбарчилсан аргачлал ашигласан хөрөнгөөс бусад санхүүгийн хөрөнгийн хувьд тайлант жилийн эцсээрх 12 сарын хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдлыг тооцоолдог.

Групп бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тухайн жилийн бусад иж бүрэн орлогоор

хэмждэг өрийн хэрэгслээрх хөрөнгө оруулалтаас бусад бүх санхүүгийн хэрэгслийн үнэ цэнийн бууралтын алдагдал болон буцаалтыг үнэ цэнийн бууралтын нөөц сангийн дансаар дамжуулан тэдгээрийн дансны үнийг залруулж, ашиг алдагдлаар бүртгэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тухайн жилийн бусад иж бүрэн орлогоор хэмждэг өрийн хэрэгслээрх хөрөнгө оруулалтын алдагдал нь бусад иж бүрэн орлогоор бүртгэгдэж, хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөцөөр хуримтлуулан бүртгэж, тус дүнгээр санхүүгийн байдлын тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бууруулж тайлагнадаггүй.

2.10.3. Санхүүгийн хөрөнгийг данснаас хасах

Групп нь санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд данснаас хасна: санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон эсвэл санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх ба хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүх эрсдэл болон өгөөжийг бусдад шилжүүлсэн. Хэрэв групп нь санхүүгийн хөрөнгийг шилжүүлээгүй болоеч санхүүгийн хөрөнгийг эзэмшихтэй холбоотой ихэнх эрсдэл ба өгөөжийг хадгалж үлдээгүй бол уг хөрөнгөөс Групп-д үлдсэн хувь хэмжээгээр хөрөнгийг бүртгэлдээ хэвээр үлдээх ба төлбөр төлөх үүрэг байгаа бол холбогдох өрийг бүртгэнэ. Хэрэв групп нь шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийн ихэнхийг өөртөө хадгалсаар байгаа бол санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасахгүй ба санхүүгийн хөрөнгөөр барьцаалсан зээлийн өрийг бүртгэнэ.

Хорогдуулсан өртгөөр санхүүгийн хөрөнгийг данснаас хасахдаа тухайн хөрөнгийн дансны үнэ ба хүлээн авсан дүн болон авлагын нийлбэрийн зөрүүг ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2024 оны 05 сарын 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд
нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (2023 оны 12 дугаар сарын 31)

2.11. Өрийн ба өмчийн хэрэгсэл

2.11.1. Өр төлбөр эсвэл өмчийн хэрэгслээр ангилах

Өрийн болон өмчийн хэрэгслийг тэдгээрийн гэрээгээр хүлээсэн нөхцөлийн бодит байдал ба санхүүгийн өр төлбөр болон өмчийн хэрэгслийн тодорхойлолтонд үндэслэн өр эсвэл өмчийн хэрэгслээр ангилдаг.

2.11.2. Өмчийн хэрэгсэл

Группийн бүх хөрөнгөөс өр төлбөрийг хассаны дараа үлдэх хэсгээс хувь хүртэх нөхцөл бүхий аливаа гэрээг өмчийн хэрэгсэл гэдэг. Группээс гаргаж байгаа өмчийн хэрэгслийг хүлээн авсан мөнгөнөөс санхүүгийн хэрэгслийг гаргахтай холбоотой шууд зардлыг хассан дүнгээр хэмжиж бүртгэдэг.

2.11.3. Санхүүгийн өр төлбөр

Бүх санхүүгийн өр төлбөрийг анх бүртгэсний дараа үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэдэг. Группийн санхүүгийн өр төлбөр нь үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хэрэгслүүдээс бүрддэг.

➢ Хорогдуулсан өртгөөр санхүүгийн өр төлбөр

Үр ашигт хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийг тооцож, холбогдох хугацааны туршид хүүгийн зардлыг хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр (үр ашигт хүүгийн хувьд нөлөөлөх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний зардал, хөнгөлөлт урамшууллыг багтаасан) -ийг санхүүгийн өр төлбөрийн хугацааны туршид эсвэл шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хорогдуулахад хэрэглэдэг хүүгийн хувь юм.

➢ Санхүүгийн өр төлбөрийг данснаас хасах

Групп нь санхүүгийн өр төлбөрийг зөвхөн гэрээний үүрэг биелэгдсэн, цуцлагдсан эсвэл гэрээний хугацаа дууссан тохиолдолд данснаас хасна. Данснаас хасаж буй санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ ба төлсөн дүн болон өглөгийн нийлбэрийн зөрүүг ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

2.12. Орлого хүлээн зөвшөөрөлт

Группийн орлого нь дараах үндсэн эх үүсвэрээс бүрддэг:

a) Үйлчилгээний орлого;
b) Хүүгийн орлого
c) Бусад орлого.

2.12.1. Үйлчилгээний орлого

Групп гүйцэтгэлийн үүргээ биелүүлэх үед ут гүйцэтгэлээр дамжуулан харилцагч үр өгөөж хүртэлх болон хяналтыг нэгэн зэрэг шилжүүлэн авснаар борлуулалтын орлогыг үйлчилгээ үзүүлж буй хугацааны туршид хүлээн зөвшөөрнө.

Гүйцэтгэлийн үүргийн ахиц дэвшлийг гарцын аргаар хэмжих бөгөөд тодорхой өдөр хүртэл харилцагчид шилжүүлсэн бараа, үйлчилгээний бодит үнэ цэнийг Группийн гэрээний дагуу шилжүүлэхээр амласан үлдсэн бараа, үйлчилгээнд ногдох дүнгээр орлого хүлээн зөвшөөрнө.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЭНДЛИ БОНД ХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024.05 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02



2.12.2. Хүүгийн орлого

Эдийн засгийн өгөөж нь групп-д ирэх өндөр магадлалтай ба орлогын дүнг найдвартайгаар тооцоолох боломжтой тохиолдолд хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрнө. Хүүг хугацаанаас хамааралтайгаар үндсэн өрийг үр ашигт хүүгийн хувиар үржүүлж хуримтлуулан бүртгэдэг. Үр ашигт хүүгийн хувь гэдэг нь санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгийг бодох ба хүү тооцох хугацааны турш бүртгэх хүүгийн зардлыг хуваарилах арга юм.

2.12.3. Бусад орлого

Бусад орлого нь бизнесийн хэвийн бус нөхцөлд үүссэн бөгөөд эдийн засгийн өгөөжийг найдвартай хэмжих боломжтой, үүнийг групп хүртэх магадлалтай үед бусад орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

2.13. Түрээс

Хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл болон өгөөжийг түрээслэгчид шилжүүлж байвал уг түрээсийг санхүүгийн түрээсээр тайлагнадаг. Бусад бүх түрээсийг үйл ажиллагааны түрээсээр тайлагнадаг.

2.13.1. Түрээслүүлэгч

Үйл ажиллагааны түрээсийн орлогыг түрээсийн нийт төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын арга ашиглан бүртгэдэг. Түрээсийн гэрээ байгуулах үед гарсан нэмэлт зардлуудыг түрээсийн хөрөнгө оруулалт дээр нэмж бүртгэж, түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар хорогдуулдаг.

2.13.2. Түрээслэгч

Групп-д томоохон түрээсийн гэрээ байхгүй. Үйл ажиллагааны түрээсийн нийт төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын арга ашиглан зардлаар бүртгэдэг. Үйл ажиллагааны түрээстэй холбоотой болзошгүй төлбөрийг тэдгээрийг гарсан жилд зардлаар бүртгэдэг. Үйл ажиллагааны түрээсийн гэрээний дагуу урамшуулал авсан бол түүнийг өр төлбөр гэж бүртгэдэг ба түрээсийн хугацаанд шулуун шугамын арга ашиглан түрээсийн өглөгийг бууруулж, зардлаар бүртгэдэг.

2.14. Гадаад валютын ажил гүйлгээ

Группийн бие даасан компани бүрийн хувьд санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн тайлагналын валютаас бусад валютыг (гадаад валют) ажил гүйлгээ гарсан өдрийн ханшаар хөрвүүлэн бүртгэсэн. Төгрөгөөс бусад мөнгөн тэмдэгт нь гадаад валют гэж тооцогддог ба гадаад валютаар хийгдсэн гүйлгээнүүд нь тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар төгрөг рүү хөрвүүлэгддэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөр нь тухайн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар төгрөг рүү хөрвүүлэгддэг. Энэхүү гадаад валютын хөрвүүлгийн гүйлгээнээс үүссэн ханшийн зөрүүг тухайн тайлант хугацаанд нэгтгэсэн иж бүрэн орлогын тайлангийн хэсэгт тусгадаг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийн хөрөнгө ба өр төлбөр нь тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар хөрвүүлэгддэг.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхтэй холбоотойгоор, группийн гадаад үйл ажиллагааны хөрөнгө болон өр төлбөрийг тайлант хугацаа бүрийн эцсийн өдрийн ханшаар төгрөг рүү хөрвүүлсэн. Тайлант хугацааны турш дахь орлого болон зардлын зүйлсийг хөрвүүлэхдээ ажил гүйлгээ үүссэн өдрийн ханшийг ашигласан. Ханшийн зөрүүнээс үүссэн зөрүүг бусад иж бүрэн орлогын тайланд тусган эздийн өмчийн хэсэгт хуримтлуулан бүртгэнэ.

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 21 5183855 9021031195 СТС2420

СЭХ 2024.06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

2.15. Зардал хүлээн зөвшөөрөлт

Зардлыг нэгтгэсэн иж бүрэн орлогын тайланд зардлын чиг үүргийн аргыг ашиглан тайлагнадаг. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт борлуулсан барааны бүтээгдэхүүнтэй шууд холбоотой зардлууд багтдаг. Группийн үйл ажиллагааны зардалд ерөнхий ба удирдлагын, борлуулалт ба маркетингийн болон бусад бизнесийн үйл ажиллагааны зардлууд ордог.

2.16. Зээлийн зардал

Шалгуурт нийцсэн хөрөнгийн олж бэлтгэх, барьж байгуулах ба үйлдвэрлэхэд шууд холбоотой хүүгийн зардлыг тэдгээр хөрөнгийн өртөгт оруулж бүртгэдэг. Шалгуурт нийцсэн хөрөнгө гэдэг нь түүнийг зориулалтаар нь ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгоход их хэмжээний хугацаа зарцуулдаг хөрөнгийг хэлэх ба уг хөрөнгийг ашиглах ба борлуулахад бэлэн болгох хүртэлх хугацаанд хүүгийн зардлыг хөрөнгийн өртөгт оруулдаг.

Шалгуурт нийцсэн хөрөнгийг санхүүжүүлэхээр хүлээж буй зээлийг сул чөлөөтэй үед нь богино хугацаагаар хүү олох хөрөнгө оруулалтад ашигласан бол олсон хүүг капиталжуулах хүүгийн зардлыг бууруулж бүртгэнэ.Бусад бүх зээлийн хүүг тэдгээрийг гарсан жилийн ашиг алдагдлын тайланд тусгана.

2.17. Ажилчдын тэтгэмж

Групп нь тайлант хугацаанд ажилчдад олгох цалингийн зардлаас төлсөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр өрийг бүртгэдэг. Түүнчлэн ойрын хугацаанд мөнгөн шагнал олгох, ашиг хуваах хөтөлбөрийн хүрээнд төлөх дүнгээр өр бүртгэдэг. Ингэхдээ ажилчдынхаа үзүүлсэн үйлчилгээний үр дүнд ийнхүү төлөхөөр хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хүлээсэн бөгөөд холбогдох өрийн дүнг найдвартайгаар тооцоолох боломжтой бол өрийн санг бүртгэдэг.

Богино хугацаат тэтгэвэр, тэтгэмжийг ажилчид үйлчилгээ үзүүлсэн үед дискаунтлаагүй сууриар хэмжиж, зардлаар хүлээн зөвшөөрдөг.

2.18. Нөөц

Групп нь өнгөрсөн үйл явдлын улмаас хуулиар үүрэг хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн бөгөөд энэхүү үүргийг барагдуулахад эдийн засгийн өгөөжийг зарцуулах өндөр магадлалтай бөгөөд үүрэг хариуцлагыг бодитоор хэмжих боломжтой бол нөөцийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Бүртгэлд тусгагдсан нөөцийн дүн нь үүссэн өрийг төлж барагдуулахад шаардагдах мөнгөн дүнгийн хэмжээг тайлант жилийн эцсийн байдлаар тухайн өртэй холбоотой нөхцөл байдал, эрсдэлийг харгалзан тооцоолсон удирдлагын хийж чадах хамгийн сайн тооцоололд үндэслэдэг. Одоогийн үүссэн өрийг барагдуулахад хэрэгтэй тооцоолж буй мөнгөн гүйлгээнд үндэслэн нөөцийг хэмждэг ба түүний дансны дүн нь тэдгээр мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр тодорхойлогддог.

Нөөцийг барагдуулахад шаардлагатай эдийн засгийн өгөөжийг бүгдийг нь эсвэл заримыг нь гуравдагч тал нөхөн төлөх магадлалтай ба хэрэв нөхөн төлөх нь тодорхой болсон бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг найдвартай хэмжих боломжтой үед түүнийг авлага хэмээн бүртгэнэ.

Нөөцийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин хянах ба тайлант хугацааны эцэст хамгийн сайн тооцооллыг тусгаж залруулдаг. Эдийн засгийн өгөөжийг шилжүүлж өр төлбөрийг барагдуулах шаардлагагүй болсон үед нөөцийг буцаана.

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ 2024.05.10 он сар өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд
нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (2023 оны 12 дугаар сарын 31)

2.19. Болзошгүй өр төлбөр ба хөрөнгө

Аж ахуйн нэгжийн бүрэн хяналтаас гадуурх нэг болон түүнээс дээш ирээдүйн үйл явдал тохиолдох, эс тохиолдохоос хамаарч үүсэх эсэх нь тодорхойлогддог тул болзошгүй өр ба болзошгүй хөрөнгийг бүртгэдэггүй. Эдийн засгийн өгөөжийг агуулсан нөөцийн гадагш урсгал гарах магадлал маш бага биш л бол бүх тохиолдолд болзошгүй өр төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн тайланд нэмж тодруулна.

2.20. Холбоотой тал

Групп болон группийн толгой компани болон түүнтэй холбоотой этгээдүүдийн хооронд нөөц, ажил үйлчилгээ эсвэл үүрэг хариуцлага шилжүүлэхдээ төлбөр нэхэмжилсэн эсэхээс үл хамааран тэдгээрийн хооронд хийгдсэн ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ гэнэ. Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд групптэй холбоотой гэж үзнэ:

- Группийг шууд эсвэл хамтран хянадаг;
- Группийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг;
- Группийн болон группийн толгой компанийн удирдах ажилтан;

Хэрэв дараах нөхцөлийн аль нэг нь хангагдаж байвал тухайн аж ахуйн нэгжийг групптэй холбоотой гэж үзнэ:

- Тухайн аж ахуйн нэгж болон групп нь нэг бүлэг аж ахуйн нэгжийн бүрэлдэхүүнд багтаж байвал өөрөөр хэлбэл, толгой компани, охин компани болон нэг толгой компанид багтдаг охин компаниуд бүгд бусадтайгаа холбоотой гэсэн үг юм.
- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол эсвэл нөгөө аж ахуйн нэгжийг багтаасан бүлгийн нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол
- Хоёр компани хоёулаа нэг гуравдагч этгээдийн хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол
- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан үйлдвэр ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч аж ахуйн нэгжийн хараат компани бол
- Тухайн аж ахуйн нэгж нь групп эсвэл групптэй холбоотой аж ахуйн нэгжийн аль нэгнийх нь ажилчдын тэтгэвэр тэтгэмжид зориулсан ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төлөвлөгөө байгаа бол
- Тухайн аж ахуйн нэгж нь дээр дурдсан холбоотой талаар тодорхойлогдсон хувь хүний шууд эсвэл хамтарсан хяналтан дор байх
- Группийг шууд эсвэл хамтран хянадаг этгээд нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд их хэмжээний нөлөөтэй байх, тухайн аж ахуйн нэгжийн, эсвэл түүний толгой компанийн удирдах ажилтан

2.21. Татвар

Орлогын татварын зардал нь тухайн жилд төлөхөөр тооцсон татвар ба хойшлогдсон татварын нийлбэрээс бүрдэнэ.

2.21.1. Тухайн жилийн орлогын албан татвар

Тухайн жилийн татварын өглөг нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод суурилсан байна. Татвар ногдуулах орлого нь группийн санхүүгийн тайлангаар тодорхойлсон ашгаас зөрүүтэй байдаг нь санхүүгийн тайланд тусгагдсан орлого, зарлагын зүйлсийн татвар ногдох, татвар ногдох орлогоос хасагдах хугацаа нь татварын тайлангийн зорилгоор өөр тайлант хугацаанд үүсдэг эсвэл эдгээр нь огт татвар ногдохгүй эсвэл татвар ногдох орлогоос хасагдахгүй байдагтай холбоотой. Группийн тухайн жилийн татварын өрийг тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр тооцож, тодорхойлно.

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 23 5183855 9021031195 СТС2420

2.21.2. Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварыг нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татвар ногдуулах орлогыг тооцоход хэрэглэсэн тэдгээрийн татварын суурь хоёрын хоорондын түр зөрүүнд тооцдог. Ерөнхийдөө бүх татвар ногдох түр зөрүүгээр хойшлогдсон татварын өрийг бүртгэдэг. Хойшлогдсон татварын хөрөнгийг бараг бүх хасагдах түр зөрүүнд тооцдог болович ирээдүйд тэдгээр хасагдах түр зөрүүг шингээхэд хүрэлцэхүйц татвар ногдуулах ашигтай байх өндөр магадлалтай эсэхийг харгалздаг. Эдгээр хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг гүүдвилл болон татварын ногдуулах орлого ба санхүүгийн ашгийн аль алинд нь нөлөөлөхгүй ажил гүйлгээ (бизнесийн нэгдлээс бусад)-ний үед бусад хөрөнгө ба өр төлбөрийг анх бүртгэхэд үүссэн түр зөрүүгээр бүртгэдэггүй.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацааны эцэст хянаж үздэг ба уг хөрөнгийг болон хөрөнгийн зарим хэсгийг нөхөхөд хүрэлцэхүйц татвар ногдуулах ашигтай байх магадлал бага болсон бол дансны үнийг бууруулдаг. Тайлант жилийн татварын зардал нь тухайн жилийн татвар ногдох орлогод нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээг ашиглан ногдуулсан татварын өр болон өмнөх жилүүдийн татварын өртэй холбоотой залруулгаас бүрдэнэ.

Хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг уг татварыг үүсгэж байгаа хөрөнгө, өр төлбөрийг борлуулах, барагдуулах үеийн татварын хувийг ашиглан хэмжих ба тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр тооцож, тодорхойлно. Хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг хэмжихдээ уг татварыг үүсгэж байгаа хөрөнгө, өр төлбөрийг тайлангийн өдрийн байдлаар групп хэрхэн борлуулах, барагдуулахаар төлөвлөж байгаа ба түүнээс хамаарсан татварын нөлөөллийг тусгасан байх ёстой.

## 3. МӨНГӨН ХӨРӨНГӨ

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2022 | 2023 |
|---|---|---|
| **Бэлэн мөнгө** | | |
| Төгрөг | 278,607.0 | 0 |
| Доллар | - | - |
| **Бэлэн мөнгөний үлдэгдэл** | **278,607.0** | **0.0** |
| **Банкин дахь харилцах дансны мөнгө** | | |
| Төгрөгийн | 2,556,987.6 | 11,523,372.8 |
| Долларын | 3,461,523.4 | 997,385.5 |
| **Банкин дахь харилцах дансны үлдэгдэл** | **6,018,511.0** | **12,520,758.3** |
| **Нийт дүн** | **6,297,118.0** | **12,520,758.3** |

Сендли ББСБ ХХК 8,034,654.4, Мегаболл ХХК 1,021,713.8, Мастер шийдэл ХХК 7,829.3, Датапүүл ХХК 349.5, Хоум моргейж ХХК 4,641.2, Хай пэймэнт солюшнс ХХК 3,371,951.4, Инвест Лаб Ви Си ХХК 22,849.9, Кореа ремитанс ХХК 372.1, Сэндли эмплойе ХХК 227.3, Стоклаб секьюритиз ҮЦК ХХК 39,989.8, Хай лоялти ХХК 9,956.9, Гялс пропертиз ХХК 246.5, Монголын Финтек групп ХК 5,926.3 мянган төгрөгийн тус тус үлдэгдэлтэй байна.

СЗХ 2024 .08 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024 -05- 17 БҮРТГЭВ-02

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компанууд
нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (2023 оны 12 дугаар сарын 31)

## 4. ДАНСНЫ АВЛАГА

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | Дансны авлага | НАХ | Дансны авлага (цэвэр) |
|---|---|---|---|
| **Эхний үлдэгдэл** | 4,112,587.2 | | 4,112,587.2 |
| Нэмэгдсэн | | | 68,733.5 |
| Хасагдсан | | - | 0 |
| **Эцсийн үлдэгдэл** | | - | **4,181,320.7** |

Монголын Финтек групп ХК-ийн нийт авлага 68,733.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Сендли ББСБ ХХК 3,959,020.0 мянган төгрөгийн, Хай Пэймэнт солюшнс ХХК 166,092.8 мянган төгрөгийн, Мастер шийдэл ХХК 14,307.9 мянган төгрөгийн, Монголын Финтек групп ХК-ийн 41,900.0 мянган төгрөгийн, нийт 4,181,320.7 мянган төгрөгийн авлагатай гэж тайлагнасан байна.

## 5 ЗЭЭЛИЙН АВЛАГА

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2022 | 2023 |
|---|---|---|
| Зээл олгосон | 13,672,597.0 | 22,952,788.6 |
| **Нийт дүн** | **13,672,597.0** | **22,952,788.6** |

Монголын Финтек групп ХК-ийн нийт зээлийн үлдэгдэл өмнөх оноос 9,280,191.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Сендли ББСБ ХХК 22,952,788.6 мянган төгрөгийн зээлийг харилцагчид олгосон зээлийн үлдэгдэл байна.

## 6 БУСАД АВЛАГА

*((мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2022 | 2023 |
|---|---|---|
| Холбоотой талаас авах авлагын тайлант хугацаанд хамаарах дүн | 188,894.9 | 186,608.8 |
| **Нийт дүн** | **188,894.9** | **186,608.8** |

Тайлант хугацаанд Монголын Финтек групп ХК 164,056.0 мянган төгрөгийн, Хай пэймэнт солюшнс ХХК 22,534.8 мянган төгрөгийн, Сэндли эмплойе ХХК 18.0 мянган төгрөгийн, нийт 186,608.8 мянган төгрөгийн холбоотой талаас авах авлагатай байна.

## 5. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2022 | 2023 |
|---|---|---|
| Бусад санхүүгийн хөренгө | 100,000.0 | 1,094,512.6 |
| **Нийт дүн** | **100,000.0** | **1,094,512.6** |

Тайлант онд Монголын Финтек групп ХК 994,512.6 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК 25 5183855 9021031195 СТС2420

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд
нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (2023 оны 12 дугаар сарын 31)

## 6 БАРАА МАТЕРИАЛ

| Төрөл | 2022 | 2023 |
|---|---|---|
| Хангамжийн материал | 23,224.3 | 90,090.2 |
| **Нийт дүн** | **23,224.3** | **90,090.2** |

Сендли ББСБ ХХК 42,519.5 мянган төгрөгийн, Хай Пэймэнт солюшнс ХХК 12,281.8 мянган төгрөгийн, Монголын Финтек групп ХК 35,000.0 мянган төгрөгийн, нийт 90,090.2 мянган төгрөгийн хангамжийн материалын үлдэгдэлтэй байна.

## 7. БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

| Төрөл | 2022 | 2023 |
|---|---|---|
| Бусад эргэлтийн хөрөнгө | 28,579.0 | 23,715.0 |
| **Нийт дүн** | **28,579.0** | **23,715.0** |

Стоклаб секьюритиз ҮЦК ХХК 23,715.0 мянган төгрөгийн бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

## 8. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ, ТООЦОО

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2022 | 2023 |
|---|---|---|
| Урьдчилж төлсөн зардал | 459,568.6 | 762,281.6 |
| **Нийт дүн** | **459,568.6** | **762,281.6** |

Сендли ББСБ ХХК 449,658.1 мянган төгрөгийн, Хай Пэймэнт солюшнс ХХК 51,489.7 мянган төгрөгийн, Мастер шийдэл ХХК 295.0 мянган төгрөгийн, Стоклаб секьюритиз ҮЦК ХХК 790.0 мянган төгрөгийн, Монголын Финтек групп ХК 260,048.80 мянган төгрөгийн, зардлыг урьдчилж төлсөн байна.

## 9. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2022 | 2023 |
|---|---|---|
| Машин тоног төхөөрөмж | 602,388.9 | 698,801.4 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (79,133.7) |
| Тээврийн хэрэгсэл | 47,000.0 | |
| Хуримтлагдсан элэгдэл | (283.3) | |
| Тавилга, эд хогшил | 48,989.8 | 467,543.2 |
| Хуримтлагдсан элэгдэл | (146.2) | (50,552.9) |
| Компьютер, бусад хэрэгсэл | 1,916,830.0 | 2,226,713.9 |
| Хуримтлагдсан элэгдэл | (251,505.1) | (1,206,353.5) |
| Бусад хэрэгсэл | | 120,113.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | | |
| **Нийт дүн** | **2,363,274.1** | **2,177,131.4** |

Сендли ББСБ ХХК 104,290.5 мянган төгрөгийн, Хай Пэймэнт солюшнс ХХК 820,221.0 мянган төгрөгийн, Хоум моргейж ХХК 9,909.4 мянган төгрөгийн, Стоклаб секьюритиз ҮЦК ХХК 2,352.1 мянган төгрөгийн, Мастер шийдэл ХХК 5,435.4 мянган төгрөгийн, Мегаболл ХХК 753,285.1 мянган төгрөгийн, Инвест Лаб Ви Си ХХК 307,613.5 мянган төгрөгийн, Монголын Финтек групп ХК 174,024.4 мянган төгрөгийн, хөрөнгийн цэвэр үлдэгдэлтэй байна.

## 10. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2022 | 2023 |
|---|---|---|
| Компьютерийн програм хангамж | 1,368,310.7 | 1,368,530.8 |
| Хуримтлагдсан хорогдол | | |
| Патент | 1,098,036.9 | 1,195,794.2 |
| Хуримтлагдсан хорогдол | | |
| Барааны тэмдэгт | 279.9 | 4,778.1 |
| Хуримтлагдсан хорогдол | | |
| Тусгай зөвшөөрөл | 100,000.0 | 105,355.2 |
| Хуримтлагдсан хорогдол | | |
| Зохиогчийн эрх | | 185.0 |
| Газар эзэмших эрх | | 2,518,713.2 |
| **Нийт дүн** | **2,566,627.5** | **5,196,465.4** |

Сендли ББСБ ХХК 205,105.4 мянган төгрөгийн, Хай Пэймэнт солюшнс ХХК 2,265,886.1 мянган төгрөгийн, Хоум моргейж ХХК 13.0 мянган төгрөгийн, Стоклаб секьюритиз ҮЦК ХХК 123,719.1 мянган төгрөгийн, Датапүүл ХХК 5 000.0 мянган төгрөгийн, Мастер шийдэл ХХК 37,478.5 мянган төгрөгийн, Мегаболл ХХК 280.0 мянган төгрөгийн, Монголын Финтек групп ХК 2,558,983.3 мянган төгрөгийн, биет бус хөрөнгө бүртгэлтэй байна

## 11. УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

*(мянган төгрөг)*

| Төрөл | 2022 | 2023 |
|---|---|---|
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 7,197,135.0 | 583,700.4 |
| **Нийт дүн** | **7,197,135.0** | **583,700.4** |

Тайлант онд урт хугацаат хөрөнгө оруулалтын дунд хамаарах холбоотой талуудын урт хугацаат зээлийн өр төлбөрийн гүйлгээгээр усттах бүртгэл хийгдсэн байна.Кориа ремитанс ХХК 583,700.4 мянган төгрөгийн урт хугацаат хөрөнгө оруулалт байна

## 12. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2022 | 2023 |
|---|---|---|
| Дансны өглөг | 3,341,034.9 | 2,110,184.4 |
| ХХОАТ-ын өглөг | 65,423.1 | 696,885.5 |

СЗХ 2024.05.10 өдөр БҮРТГЭВ № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд
нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (2023 оны 12 дугаар сарын 31)

| | | |
|---|---|---|
| ЭМ, НДШ-ийн өглөг | 214.9 | 320.5 |
| Цалингийн өглөг | 1,809.7 | 1,997.1 |
| **Нийт дүн** | **3,408,482.6** | **2,809,387.5** |

Хай Пэймэнт солюшнс ХХК 2,110,184.4 мянган төгрөгийн дансны өглөг, Хай Пэймэнт солюшнс ХХК 379.1, Сток лаб секьюритиз ХХК 119.6, Мастер шийдэл ХХК 111.4, Мегаболл ХХК 1,186.8, Инвест лаб Ви Си ХХК 66.5, Хоум моргейж ХХК 60.7, Монголын Финтек групп ХК 72.9 мянган төгрөгийн цалингийн өглөг, Сэндли ББСБ ХХК 438,682.3, Хай Пэймэнт солюшнс ХХК 498.1, Стоклаб секьюритиз ҮЦК ХХК 25.4, Мегаболл ХХК 255,328.6, Инвест лаб Ви Си ХХК 137.7, Монголын Финтек групп ХК 2,213.4 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг, Монголын Финтек групп ХК 320.5 мянган төгрөгийн НДШ-ийн өглөгтэй, нийт 2,809,387.5 мянган төгрөгийн богино хугацаат өр төлбөртэй байна.

## 13. БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2022 | 2023 |
|---|---|---|
| Богино хугацаат зээл | 1,256,534.2 | 4,205,700.0 |
| Хүүгийн өглөг | 394,760.1 | 944,183.8 |
| Урьдчилж орсон орлого | | 41,590.9 |
| Мөнгөн гүйвүүлга бусад өглөг | | |
| Бондын өр төлбөр | 12,095,015.6 | 32,890,357.2 |
| **Нийт дүн** | **13,746,309.9** | **38,081,831.9** |

Сэндли ББСБ ХХК 3,355,800.0, Мегаболл ХХК 849,900.0 мянган төгрөгийн богино хугацаат зээлийн үлдэгдэлтэй, Сэндли ББСБ ХХК 944,183.8 мянган төгрөгийн хүүгийн өглөгийн үлдэгдэлтэй байна. Монголын Финтек групп ХК 21,280,009.7, Сэндли ББСБ ХХК 10,992,906.2, Хай Пэймэнт солюшнс ХХК 617,441.3, бүгд 32,890,357.2 мянган төгрөгийн бонд гарган, бондын өглөгөөр бүртгэж, тайлагнасан байна.

## 14. УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

| Төрөл | 2022 | 2023 |
|---|---|---|
| Урт хугацаат зээл | | 4,794,000.0 |
| **Нийт дүн** | | **4,794,000.0** |

Тайлант хугацаанд Сэндли ББСБ ХХК 4,794,000.0 мянган төгрөгийн урт хугацаат зээлийн үлдэгдэлтэй тайлан гаргасан байна.

## 15. ЭЗДИЙН ӨМЧ

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | | 2022 | 2023 |
|---|---|---|---|
| Өмч: | а) төрийн | - | - |
| | б) хувийн | | |
| | в) хувьцаат | 17,898,196.4 | 12,823,696.4 |
| **Нийт дүн** | | **17,898,196.4** | **12,823,696.4** |

Монголын Финтек групп ХК 6,519,022.4 мянган төгрөгийн, Сэндли ББСБ ХХК 6,304,674.0



УЛААНБААТАР ХОТ ... АУДИТ ЭНД КО ... 5183855 9021031195 СТС2420

СЗХ 2024 .06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024 05 17 БҮРТГЭВ-02

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд
нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (2023 оны 12 дугаар сарын 31)

мянган төгрөгийн хувьцаат эздийн өмч байна. Өмнөх оны хувийн өмчид бүртгэгдсэн 5,074.5 мянган төгрөгийн бүртгэлийг залруулсан байна.

## 16. ЭЗДИЙН ӨМЧИЙН БУСАД ХЭСЭГ

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2022 | 2023 |
|---|---|---|
| Нэмж төлөгдсөн капитал | 6,883,618.1 | 5,427,427.2 |
| Эздийн өмчийн бусад хэсэг | | |
| Нөөц сангуудын үлдэгдэл | 8,300.3 | 8,519.8 |
| Халаасны хувьцаа | | (3,482,144.2) |
| **Нийт дүн** | **6,891,918.4** | **1,953,802.8** |

Монголын Финтек групп ХК 1,882,800.3 мянган төгрөгийн, Сэндли ББСБ ХХК 3,544,627.0 мянган төгрөгийн нэмж төлөгдсөн капитал, Сэндли ББСБ ХХК нөөц сангийн үлдэгдэл 8,519.8 мянган төгрөг гэж тайлагнасан байна.

## 17. ХУРИМТЛАГДСАН АШИГ

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2022 | 2023 |
|---|---|---|
| Тайлант үеийн ашиг (алдагдал) | (1,345,238.1) | (4,194,377.2) |
| Өмнөх үеийн ашиг (алдагдал) | (3,590,063.6) | (6,498,967.6) |
| **Нийт дүн** | **(4,935,301.7)** | **(10,693,344.8)** |

Тайлант хугацаанд холбоотой компаниудын өмнөх үеийн хуримтлагдсан ашгийг тэгшитгэх замаар хуримтлагдсан ашиг бүртгэж тайлагнасан байна.

## 18. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2022 | 2023 |
|---|---|---|
| Борлуулалтын орлого | 7,464,461.9 | 12,490,248.6 |
| Түрээсийн орлого | 260.0 | 17,841.7 |
| Бусад орлого | 415.0 | 3,454,566.8 |
| **Нийт дүн** | **7,465,136.9** | **16,092,187.5** |

Сэндли ББСБ ХХК 8,399,698.4, Хай Пэймэнт Солюшн ХХК 2,249,431.0, Сток лаб секьюритиз ХХК 107,720.9, Мастер шийдэл ХХК 98,867.6, Мегаболл ХХК 1,579,190.3, Инвест лаб Ви Си ХХК 55,340.3 мянган төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан.

## 19. БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2022 | 2023 |
|---|---|---|
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 855,670.6 | 4,715,798.1 |
| **Нийт дүн** | **855,670.6** | **4,715,798.1** |

УЛААНБААТАР ХОТ ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

СЗХ 2024 он 05 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 2024 05 17 БҮРТГЭВ-02

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд
нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (2023 оны 12 дугаар сарын 31)

Сэндли ББСБ ХХК 3,749,431.1 мянган төгрөгийн, Мегаболл ХХК 975,796.5 мянган төгрөгийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг тооцон ажилласан байна.

## 20. ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

*(мянган төгрөгөөр)*

| Зардлын төрөл | 2022 | 2023 |
|---|---|---|
| Ажиллагчдын цалингийн зардал | 1,819,635.2 | 3,926,493.2 |
| ААН-ээс төлсөн НДШ-ийн зардал | 227,716.5 | 434,734.6 |
| ХЧТАТэттэмжийн зардал | | 17,296.2 |
| А/ татвар, төлбөр, хураамжийн зардал | 22,633.0 | 25,448.5 |
| Томилолтын зардал | 30,772.5 | 510,275.0 |
| Бичиг хэргийн зардал | 9,007.1 | 59,123.3 |
| Шуудан холбооны зардал | 109,372.6 | 190,478.6 |
| Мэргэжлийн үйлчилгээний зардал | 299,682.9 | 2,124,175.0 |
| Сургалтын зардал | 287,445.9 | 51,908.6 |
| Харуул, хамгаалалтын зардал | 4,232.6 | 7,195.5 |
| Ашиглалтын зардал | 9,018.1 | 32,825.3 |
| Засварын зардал | 38,336.3 | 11,646.1 |
| Банкны шимтгэлийн зардал /hipay 1%/ | | 1,409,664.9 |
| Хөдөлмөр хамгааллын зардал | | 155,467.2 |
| Түрээсийн зардал | 193,349.1 | 563,124.9 |
| Цэвэрлэгээний зардал | 17,297.5 | 38,533.1 |
| Хүүний зардал | | 2,327,723.1 |
| Материалын зардал | | 5,629.8 |
| Сэлбэг хэрэгслийн зардал | | 4,485.2 |
| Автоматжуулалтын зардал | | 139,247.2 |
| Тээврийн зардал | 16,786.7 | 3,194.9 |
| Шатахууны зардал | 102,940.5 | 36,091.8 |
| Зар сурталчилгааны зардал | 626,829.9 | 1,255,422.0 |
| Элэгдэл, хорогдлын зардал | 20.1 | 1,063,347.6 |
| Хүлээн авалтын зардал | 37,060.7 | 81,294.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ | | 379,205.5 |
| Шагнал урамшууллын зардал | | 166,169.1 |
| Даатгалын зардал | | 353.1 |
| Баяр ёслолын зардал | 4,102,567.8 | 230,046.2 |
| Бусад зардал | | 688.9 |
| **Нийт дүн** | **7,954,704.4** | **15,251,288.4** |

СЭНДЛИ БОНД ХК

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
СТС2420

СЭХ 2024.06.10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 2024-05-17 БҮРТГЭВ-02

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд
нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (2023 оны 12 дугаар сарын 31)

## 21 БУСАД ЗАРДАЛ

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2022 | 2023 |
|---|---|---|
| Бусад зардал | | 143,543.0 |
| **Нийт дүн** | | **143,543.0** |

## 22. БУСАД АШИГ (АЛДАГДАЛ)

| Төрөл | 2022 | 2023 |
|---|---|---|
| Бусад ханшийн зөрүүнээс үүссэн олз (гарз | | 209,122.6 |
| **Нийт дүн** | | **209,122.6** |

## 23. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2022 | 2023 |
|---|---|---|
| Тайлант үеийн орлогын татварын зардал | | 385,057.8 |
| **Орлогын татварын зардал (орлого)-ын нийт дүн** | | **385,057.8** |

**Тайлант онд Сэндли ББСБ 385,057.8 мянган төгрөгийн орлогын албан татварыг төлөхөөр** тайлагнасан байна. Мөн жилийн эцсээр 4,194,377.2 мянган төгрөгийн алдагдалтай тайлан гаргасан байна.

## 24. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА

| № | Үзүүлэлт | Гүйлгээний утга | Өглөг | Хөрөнгө оруулалт | Авлага | НИЙТ ДҮН |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Монголын финтек групп ХК | Үйл ажиллагааны зардалд | 2,621,068.6 | | | 2,621,068.6 |
| 2 | Сэндли эмплойе ХХК | Дүрмийн сан нэмэгдүүлсэн гүйлгээ | | | 628.7 | 628.7 |
| 3 | Стоклаб секьюритиз ХХК | Үйл ажиллагааны зардалд | | | 291,789.9. | 291,789.9. |
| 4 | Инвест лаб Ви Си ХХК | Хөрөнгө оруулалт, дүрмийн сан нэмэгдүүлсэн | | 1,938,972.7 | 44,288.6 | 1,981,261.3 |
| 5 | Мастер шийдэл ХХК | Үйл ажиллагааны зардалд | | | 132,689.0 | 132,689.0 |
| 6 | Кореа ремитанс ХХК | Солонгос улсад мөнгөн гуйвуулга хийх барьцаа хөрөнгө | - | | 583,700.4 | 583,700.4 |
| 7 | Мегаболл ХХК | Үйл ажиллагааны зардалд | | - | 608,566.2 | 608,566.2 |
| | ДҮН | | 2,621,068.6 | 1,938,972.7 | 1,659,662.8 | 6,219,704.1 |

СЗХ 2024.06.10 БҮРТГЭВ №01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (2023 оны 12 дугаар сарын 31)

25. ОХИН КОМПАНИУДЫН ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

| № | Охин компанийн нэр | Эрхлэх үйл ажиллагаа |
|---|---|---|
| 1 | Сэндли ББСБ ХХК | Зээлийн үйлчилгээ |
| | | Олон улсын мөнгөн гуйвуулга |
| 2 | Хай пэймэнт солюшнс ХХК | Мэдээлэл технологийн үйл ажиллагаа |
| | | Програм хангамж |
| 3 | Гялс пропертиз ХХК | Менежментийн зөвлөгөө өгөх |
| 4 | Стоклаб секьюритиз ҮЦК ХХК | Брокерийн үйл ажиллагаа |
| | | Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх |
| 5 | Инвестлаб Ви Си ХХК | Бизнесийн зөвлөгөө өгөх |
| | | Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх |
| 6 | Мастер шийдэл ХХК | Даатгалын зуучлалын үйлчилгээ |
| 7 | Хай лоялти ХХК | Мэдээлэл технологийн үйл ажиллагаа |
| | | Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх |
| 8 | Хоум моргейж ХХК | Санхүүгийн тайлан гаргах түүнтэй холбоотой зөвлөгөө өгөх |
| | | Хөрөнгө итгэмжлэн удирдах |
| | | Бизнесийн зөвлөгөө өгөх |
| 9 | Корea ремитанс ХХК | Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх |
| 10 | Датапүүл Монголиа ХХК | Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх |
| | | Мэдээлэл технологийн үйл ажиллагаа |
| 11 | Мегаболл ХХК | Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ |
| | | Үл хөдлөх хөрөнгийн худалдаа |
| 12 | Сэндли эмплойе ХХК | Менежментийн зөвлөгөө өгөх |
| | | Бизнесийн зөвлөгөө өгөх |

32

3233344

УЛААНБААТАР ХОТ ... КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

СЗХ 2024.06.20 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд
нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (2023 оны 12 дугаар сарын 31)

26 ОХИН КОМПАНИУДЫН ХУВЬ ЭЗЭМШИЛ

| № | Үзүүлэлт | Байгууллагын нэр | Хувь эзэмшил /%/ |
|---|---|---|---|
| 1 | 5961548 | Сэндли ББСБ ХК | 56.4 |
| 2 | 6303277 | Хай пеймент солюшнс ХХК | 100.0 |
| 3 | 5999782 | Сэндли эмплоймент ХХК | 100.0 |
| 4 | 6235085 | Мегаболл ХХК | 100.0 |
| 5 | 5463785 | Хоум моргейж ХХК | 65.0 |
| 6 | 5908345 | Мастер шийдэл ХХК | 100.0 |
| 7 | 5742153 | Гялс пропертиз ХХК | 90.0 |
| 8 | 6695159 | Стоклаб секюритиз ҮЦК ХХК | 79.0 |
| 9 | 6696465 | Даталүүл ХХК | 100.0 |
| 10 | 6695302 | Кореа ремитинс ХХК | 100.0 |
| 11 | 6695388 | Инвестлаб ХХК | 97.5 |

3233344

УЛААНБААТАР ХОТ 33 ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2020

СЗХ 2024.06.10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024.05.17 БҮРТГЭВ-02

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд
нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (2023 оны 12 дугаар сарын 31)

27. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙН ТАЛААР

Тайлант хугацаанд биет бус хөрөнгийн хорогдуулалтыг тооцож, холбогдох дансны бичилт хийгээгүй байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 17-р зүйлийн 17.1.4 " Ашиглах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгө ... хүчин төгөлдөр байх хугацаанд хорогдлыг тооцно" мөн "Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалын хавсралтын 4.31-д "Элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ. Тайлангийн үеийн элэгдлийн шимтгэлийг зардал гэж хүлээн зөвшөөрнө" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

28. АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖ

Хамаарал бүхий компаниудын бүртгэлтэй биет бус хөрөнгийн хорогдуулалтыг тооцож, холбогдох дансны бичилт хийж, Татварын ерөнхий хуулийн 17-р зүйлийн 17.1.4 "Ашиглах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгө ...хүчин төгөлдөр байх хугацаанд хорогдлыг тооцно" гэж заасан заалтыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгч байна

Аудитаар нийт 1 зөвлөмж өгсөн байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ЗАХИРАЛ, АУДИТОР Д.РЭНЦЭНХАНД

АХЛАХ АУДИТОР П.СОСОРБУРАМ

ЧАДВАРЛАГ АУДИТ ХХК УЛААНБААТАР ХОТ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР Б.АЛТАНЦЭЦЭГ

2024 ОНЫ 3 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР

3233344

УЛААНБААТАР ХОТ 34 ЭЙЗИ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

СЭХ 2024.06.19 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

ЧАДВАРЛАГ АУДИТ ХХК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
1-р хороо, Од плаза 201 тоот
Утас / Факс: (976) 99200034
E-mail:ChadvarlagAUDIT@gmail.com
2024.03.13 № А/24-10

"МОНГОЛЫН ФИНТЕК ГРУПП" ХК -ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Дүгнэлт**

Бид "Монголын финтек групп" ХК ба түүний охин компаниудын 2023 оны 12 сарын 31-ээр нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр "Монголын финтек групп" ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар, нэгтгэсэн санхүүгийн байдал, тухайн жилийн нэгтгэсэн санхүүгийн гүйцэтгэл болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх)-ын дагуу үнэн, зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой аудиторын үүрэг хэсэгт тусгасан. Бид нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (НБЁЗОУСЗ-ын дүрэм)-ийн дагуу Группээс хараат бус ба НБЁЗОУСЗ-ын дүрмийн дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

**Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд нь тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал асуудлууд юм. Нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудлууд тус бүрт тусад нь дүгнэлт гаргаагүй болно.

СЭХ
2024.08.10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-08-17
БҮРТГЭВ-02

ЧАДВАРЛАГ АУДИТ ХХК

**Бусад мэдээлэл**

Удирдлага нь бусад мэдээллийн талаар үүрэг хүлээнэ. Бусад мэдээлэлд төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") -ын дарга болон гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл багтана. Бусад мэдээлэл нь энэхүү аудиторын тайланг гаргасан өдрөөр бидэнд бэлтгэн хүргүүлдэг.

Энэхүү санхүүгийн тайланд өгөх манай дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид бусад мэдээлэлд ямар нэгэн дүгнэлт өгөхгүй.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид дээр тодорхойлогдсон бусад мэдээллийг бэлэн болсон үед унших үүрэгтэй бөгөөд бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад цуглуулсан мэдээллээс материаллаг хэмжээний алдаатай эсэхийг авч үзэх ёстой.

Бусад мэдээллийг уншиж, бусад мэдээлэл нь материаллаг хэмжээний зөрүүтэй эсвэл алдаатай байвал бид засаглах эрх бүхий этгээдэд мэдэгдэх үүрэгтэй бөгөөд бид бусад горимыг гүйцэтгэж, дараах зүйлсийг тодорхойлно:

- Бусад мэдээлэл нь материаллаг хэмжээний алдаатай эсэх;
- Группийн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай эсэх;
- Группийн болон түүний орчны талаарх бидний ойлголтыг шинэчлэх хэрэгтэй эсэх.

Хэрэв бид бусад мэдээлэлд материаллаг хэмжээний алдаа байгаа гэж үзсэн ба түүнийг нь залруулаагүй бол, бид залруулагдаагүй материаллаг хэмжээний алдааг манай тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд хүргэхийн тулд зохистой арга хэмжээ авахыг засаглах эрх бүхий этгээдээс хүсэх болно.

Хэрэв бид группийн аудитлагдсан санхүүгийн тайлан болон группийн болон түүний орчны талаарх бидний ойлголтод материаллаг хэмжээний алдаа байна гэж үзвэл, бид АОУС-ын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

**Нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн үүрэг хариуцлага**

Удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага группийн үйл ажиллагаагаа нь зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ 2024.06.10 өдөр БҮРТГЭВ №01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02
ЧАДВАРЛАГ АУДИТ ХХК

Засаглах эрх бүхий этгээд нь группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

**Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын үүрэг хариуцлага**

Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай залит үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар үл үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг болгож, бид аудитын туршид мэргэжлийн үнэлэмжээ ашиглан, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Мөн бид:

- Залилан болон алдаанаас үүсэж болохуйц нэгтгэсэн санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн, уг эрсдлүүдэд тохирох аудитын горимуудыг боловсруулан гүйцэтгэж, аудитын дүгнэлтийн үндэслэл болох хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авсан. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг. Учир нь залилангийн үед хуйвалдаан, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл хэрэгжүүлэх явдлууд тохиолдсон байж болдог.
- Аудитын горимуудыг сонгохтой холбоотойгоор дотоод хяналтуудыг судалдаг ба энэ нь группийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгогүй болно.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал болон удирдлагын бэлтгэсэн нягтлан бодох бүртгэлийн таамаглал болон холбогдох тодруулгуудын бодитой байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн тасралтгүй байх нөхцөлийг үргэлжлүүлэн хангах Группын чадварт мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал болон материаллаг тодорхой бус байдал үүссэн эсэхийг үнэлдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал байгаа гэж үзвэл аудиторын дүгнэлт болон нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулдаг ба уг тодруулгууд нь зохистой биш гэж үзсэн тохиолдолд бид дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь манай аудиторын тайлангийн өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд үндэслэсэн байдаг. Хэдий тийм боловч ирээдүйд болох үйл явдал эсвэл нөхцөл байдал нь группийг үйл ажиллагаагаа явуулахад нь саад учруулж болох юм.
- Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлдэг. Үүнд тодруулгаас гадна санхүүгийн тайланг үнэн зөв толилуулсан эсэхийг үнэлэхийн тулд ажил гүйлгээ, үйл явдлуудыг толилуулсан эсэхийг үнэлдэг.
- Нэгтгэсэн санхүүгийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд группийн доторх компаниуд болон бизнесийн үйл ажиллагаа болон санхүүгийн мэдээллийн талаарх зохистой аудитын нотолгоо олж авсан. Бид нэгтгэсэн санхүүгийн тайлангийн

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
5183855
0021031195 СТС2420

СЗХ 2024 он 06 сар 18 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

ЧАДВАРЛАГ АУДИТ ХХК

аудитын гүйцэтгэл болон түүнийг удирдан зохион байгуулахтай холбоотой үүргийг хүлээдэг. Мөн бид өөрсдийн аудитын дүгнэлтийн талаар үүрэг хүлээдэг.

Аудитор нь засаглах эрх бүхий этгээдтэй зөвхөн аудитын ажлын цар хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад илэрсэн ач холбогдол бүхий асуудлуудаар холбогддог ба үүнд аудитын үеэр аудиторын илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц алдаа болон дутагдал орно.

**Бусад асуудал**

Энэхүү тайланг өөр ямар нэг зорилгоор биш, Монгол Улсын компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд зориулан аудитыг гүйцэтгэсэн болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд аливаа бусад этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.

ЗАХИРАЛ

Д.РЭНЦЭНХАНД

СЗХ
2024.06 сарын ... өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024.05.17
БҮРТГЭВ-02

## ХАВСРАЛТ-4. БАРЬЦАА ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ

### (Хувьцааны сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханш)

**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ**
**ХУВЬЦААТ КОМПАНИ**
Д.Сүхбаатарын талбай 3, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 31 05 01, 31 37 47, Факс: (976-11) 32 51 70,
Цахим шуудан: info@mse.mn, Цахим хуудас: www.mse.mn

2024.04.29 № 03/332
танай ____________-ны № ____________-т

"СЭНДЛИ ББСБ" ХК-Д

"СЭНДЛИ ББСБ" ХК-ийн үнэт цаасны 2024 оны 04 дүгээр сарын 19-ны байдлаар сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханш 144 төгрөг 48 мөнгө байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ЗАХИРАЛ И.ЖАВХЛАН

1524760268

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ 2024.05.10 БҮРТГЭВ №

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

(Газар эзэмших эрхийн үнэлгээ)

ФАЙН ЭСТИМЭЙТ ХХК
Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага
Хаяг: УБ хот, ЧД 5-р хороо, Ялалт плаза 1002 тоот
И-мэйл: info_tsoemoo@yahoo.com
Утас: 88000267, 88861839
Үнэлгээчин **Н.Цолмонгэрэл** ММҮИ-ийн гишүүн тусгай зөвшөөрлийн дугаар 091100172



**Захиалагч:** "Монголын финтек групп" ХК
**Хаяг:** Улаанбаатар, Чингэлтэй, 1-р хороо, Бизнес 34 центр, А корпус 01 тоот
**Цахим хаяг:** https://fintechgroup.mn/
**Утас:** +976 7015-7700

**Үнэлгээний зүйлийн нэр, байршил:**
"Монголын финтек групп" ХК-ийн эзэмшлийн Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЭӨЧ-4 гудамж 406 тоот болон Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЭӨЧ-3 гудамж 320 тоот хаягт байрлах газар эзэмших эрх нь энэхүү үнэлгээний зүйл болно.

**Тайлангийн**
Дугаар: А 04/24-11
Огноо: 2024-04-25
Нэр: "Монголын финтек групп" ХК-ийн үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг тодорхойлох үнэлгээний тайлан

**Үнэлгээний гэрээний**
Огноо: 2024-04-22
Дугаар:
Төрөл: Үл хөдлөх хөрөнгө

**Үнэлгээний өдөр:**
2024-04-20

**Тооцоолсон үнэ цэнийн**
Төрөл: Зах зээлийн үнэ цэнэ
Дүн: **2,811,280,000.0 /Хоёр тэрбум, найман зуун арван нэгэн сая, хоёр зуун наян мянган/ төгрөг**

Хуулбар № 1: Тус үнэлгээний тайлан 17, хуудас хавсралтыг хамруулаад нийт 33 хуудаснаас бүрдсэн бөгөөд тайланг 2 хувь үйлдэж, нэг хувийг үнэлгээчин өөрийн баримтад авч үлдсэн болно.

УЛААНБААТАР ХОТ ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

"Монголын финтек групп" ХК-д

FINE ESTIMATE

ФАЙН ЭСТИМЭЙТ ХХК

Хөрөнгийн үнэлгээ, бизнесийн зөвлөгөө

Монгол Улс, Улаанбаатар хот 14200, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо,
Ялалт плаза 1002 тоот, И-мэйл: info.fineestimate@gmail.com,
Утас: 8800 0267, 88861839

Огноо 2024/04/25 Дугаар 04/24-11

**Хөрөнгийн үнэлгээний тайлан хүргүүлэх тухай**

Та бүхний захиалгын дагуу бид "Монголын финтек групп" ХК-ийн үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг 2024 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн байдлаар тогтоох үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэн үнэлгээний тайланг хүргүүлж байна.

Хөрөнгийн үнэлгээний энэхүү тайланг зөвхөн "Монголын финтек групп" ХК-ийн хэрэгцээнд захиалагч түүнтэй холбоотой компаниудын хэрэгцээнд зориулан боловсруулсан бөгөөд үнэлгээний үр дүнг өөр зорилгоор эсхүл бусад этгээд өөр зорилгоор ашиглахад тохиромжгүй болохыг онцолж байна.

Хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг тооцоолоход захиалагчаас авсан мэдээлэл болон өөрсдийн хийсэн шинжилгээ, дүгнэлтийг ашигласан.

Үнэлгээний үр дүн нь энэхүү тайланд үзүүлсэн шинжилгээ, орц мэдээлэл болон таамаглалууд, ашиглаат болон хязгаарлалтад тулгуурласан болно.

Та бүхэн энэхүү тайлантай холбоотой аливаа санал болон асуулт байвал бидэнтэй холбоо барина уу.

ХҮНДЭТГЭСЭН,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.ЦОЛМОНГЭРЭЛ

"Монголын финтек групп" ХК-д

FINE ESTIMATE

ФАЙН ЭСТИМЭЙТ ХХК
Хөрөнгийн үнэлгээ бизнесийн чиглэлээр
Монгол Улс, Улаанбаатар хот 14200, Чингэлтэй дүүрэг, 3 дугаар хороо,
Жанжин плаза 1002 тоот, И-мэйл: info.fineestimate@gmail.com,
Утас: 8800 0267, 88861839

Огноо 2024/04/25 Дугаар A04/24-11

**Ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлэх захидал**

Манай компани нь 2010 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр үүсгэн байгуулагдсан, хөрөнгийн үнэлгээ, даатгалын нөхөн төлбөрийн зориулалтаар хохиролын үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага юм. Бид хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаагаа Үнэлгээний Олон Улсын Стандарт (ҮОУС), Монгол Улсын "Хөрөнгийн үнэлгээний тухай" хууль болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн явуулдаг. Манай компани нь тус компанийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн үнэлгээг зээлийн барьцааны зориулалтаар үнэлэх ажлыг гүйцэтгэхтэй холбоотойгоор ямар нэг хууль бус, үнэлгээчний ёс зүйн дүрэмд харшлах үйлдэл хийгээгүй бөгөөд энэхүү гэрээт ажилтай ашиг сонирхлын зөрчилгүй талаар дараах мэдээллийг хүргүүлж байна. Үүнд:

1. Монгол Улсын "Хөрөнгийн үнэлгээний тухай" хуулийн 13-р зүйлд заасан аливаа нөхцөл манай үнэлгээчид болон захиалагч, үйлчлүүлэгчийн хооронд байхгүй болно.
2. Үнэлгээчин энэхүү үнэлгээг хийхдээ ММҮИ-ийн бүх гишүүдийн хурлаар баталсан "Ёс зүйн дүрэм"-ийн шаардлагуудыг даган мөрдсөн гэдгээ баталж байна. Үүнд:
   а) Тайланд тусгагдсан баримт мэдээлэл нь үнэлгээчний мэдэж байгаагаар үнэн зөв;
   б) Шинжилгээ ба дүгнэлт нь тайлагнасан таамаглал, нөхцөл байдлаар хязгаарлагдсан;
   в) Үнэлгээчин нь хөрөнгөө үнэлүүлж буй байгууллагатай ашиг сонирхлын ямар нэгэн холбоогүй;
   г) Үнэлүүлж буй хөрөнгө эсвэл оролцогч этгээдүүдтэй холбоотой ямар нэгэн өнөөгийн эсвэл ирээдүйн хувь оролцоо, ялгаварлах үзэл байхгүй;
   д) Үнэлгээний ажлын хөлс тайлангийн аль нэг хэсгээс хамааралгүй;
   е) Үнэлгээчин мэргэжлийн боловсролын шаардлагыг хангасан;
   ё) Үнэлгээчин үнэлж буй хөрөнгийн төрөл, зүйлийн талаар туршлагатай;
   ж) Тайланд тусгайлан дурьдснаас бусад ямар ч этгээд тухайн тайланг боловсруулахад мэргэжлийн туслалцаа үзүүлээгүй болохыг баталж байна.

ХҮНДЭТГЭСЭН,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.ЦОЛМОНГЭРЭЛ

СЗХ 2024.06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02



**ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН АГУУЛГА**


НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ....4
1.1 Захналагчийн мэдээлэл. ....4
1.2 Үнэлгээчний тодорхойлолт. ....4
1.3 Үнэлгээний зорилго....5
1.4 ҮОУС-ын шаардлагууд....5
1.5 Үнэлгээнд баримталсан ҮОУС-ын тодорхойлолтууд....6
1.6 Үнэ цэнийн суурь....6
1.7 Тогтоох үнэ цэнэ....7
1.8 Үнэлгээний валют....7
1.9 Үнэлгээний өдөр....7
1.10 Найдвартай мэдээллийн эх үүсвэр ба шинж чанар....7
1.11 Таамаглал ба тусгай таамаглалууд....7
1.12 Үнэлгээний талаарх баталгаа ба хязгаарлах нөхцөл....8
ХОЁР. ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ....9
2.1 Газар эзэмших эрхийн тодорхойлолт, үнэлгээ....9
2.1.1 Газар эзэмших эрхийн тодорхойлолт....9
2.1.2 Газар эзэмших эрхийн үнэлгээ....11
Дуудлага худалдааны анхны үнэ тогтоох аргачиллаарх үнэлгээ:....11
Арилжааны харьцуулалтын (Зах зээлийн жишиг үнийн) аргаарх үнэлгээ:....11
ГУРАВ. ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ....15
ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ХЭРЭГЛЭЭ....16
4.1 Бэлтгэх тайлангийн төрөл....16
4.2 Зориулагдсан бусад хэрэглэгч....16
4.3 Тайлангийн хэвлэлт, түгээн тараалт ба хэрэглээний хязгаарлалтууд....16
4.4 ҮОУС-ын гажилт....16
4.5 Үнэлгээчин нь бүх мэдэгдэхүйц орцуудыг үнэлэх....16
ТАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ....17




УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК 5183855 9021031195 СТС2420

ҮЛ ХӨДЛӨХ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

## НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2024 оны 04 дүгээр сарын 25 №: 4/25-24 Улаанбаатар хот

### 1.1 Захиалагчийн мэдээлэл.

Хүснэгт №1. Захиалагчийн ерөнхий мэдээлэл

| | |
|---|---|
| **Нэр** | *"Монголын финтек групп" ХК* |
| **Регистрын дугаар** | *6692257* |
| **Удирдлага** | *Гүйцэтгэх захирал Баттулга Наранбат* |
| **Үйл ажиллагааны код, тайлбар** | *63990 - Мэдээллийн технологийн үйл ажиллагаа, 70200 - Менежментийн зөвлөгөө өгөх* |
| **Хаяг** | *Улаанбаатар, Чингэлтэй, 1-р хороо, Бизнес 34 центр, А корпус 01 тоот* |
| **Цахим хаяг** | https://fintechgroup.mn/ |
| **И мэйл хаяг** | contact@fintechgroup.mn |
| **Утас** | *+976 7015-7700* |

### 1.2 Үнэлгээчний тодорхойлолт.

1.2.1 Энэхүү үнэлгээний ажлыг гүйцэтгэгч нь: МУ-ын компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан "Файн эстимэйт" ХХК юм.

Хүснэгт №2. Гүйцэтгэгчийн ерөнхий мэдээлэл

| | |
|---|---|
| **Хуулийн этгээдийн нэр:** | "ФАЙН ЭСТИМЭЙТ" ХХК |
| **Үүсэн байгуулагдсан огноо:** | 2010.03.29 |
| **Улсын бүртгэлийн дугаар** | 9011344109 |
| **Регистрийн дугаар** | 5353459 |
| **Удирдлагын овог, нэр** | Нямцэрэнгийн ЦОЛМОНГЭРЭЛ |
| **Одоогийн эрхэлж байгаа үйл ажиллагаа** | Бизнесийн зөвлөгөө өгөх, хөрөнгийн үнэлгээ хийх, даатгалын зориулалтаар хохиролын өөхөн олговорын үнэлгээ хийх, үнэт цаасны зах зээлийн үнэлгээ хийх |
| **Захиалагчийн хаяг** | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 5-р хороо, Ялалт плаза 1002 тоот<br>Утас: 88000267, 88861839 |

1.2.2 Хөрөнгийн үнэлгээний энэхүү тайланд үнэлгээний ажилд оролцсон бүх ажилтан бүс зөвхөн Сангийн сайдын тушаалаар эрх олгогдсон тусгай зөвшөөрөлтэй үнэлгээчид болон компанийн удирдлага гарын үсэг зурж баталгаажуулсан болно.

Хүснэгт №3. Үнэлгээчдийн ерөнхий мэдээлэл

| № | Үнэлгээчний овог нэр | Тусгай зөвшөөрөл олгосон хугацаа, дугаар | Үнэлгээчнээр ажилласан хугацаа | Хариуцлагын даатгалын мэдээлэл |
|---|---|---|---|---|
| 1 | Н.Цолмонгэрэл | Сангийн сайдын 2018 оны 12-р сарын 19-ны өдрийн 284 тоот тушаал № 091100172 | 14 жил | Монре даатгал ХХК, Гэрээний дугаар: 21/09/103/01310/CGL |
| 2 | Э.Батболд | Сангийн сайдын 2021 оны 9-р сарын 28-ны өдрийн 167 тоот тушаал № 202107001 | 2 жил | Монре даатгал ХХК, Гэрээний дугаар: 21/12/10004/00071/PLi |
| 3 | Ч.Отгончимэг | Сангийн сайдын 2021 оны 9-р сарын 28-ны өдрийн 167 тоот тушаал № 202107004 | 2 жил | Монре даатгал ХХК, Гэрээний дугаар: 21/12/10004/00072/PLi |

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ФАЙН ЭСТИМЭЙТ ХХК

СЗХ
2024 он 06 сар 19 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02



25-APR-2024

**1.7 Тогтоох үнэ цэнэ**

1.7.1 Захиалагчийн үнэлүүлэхээр хүсэлт гаргасан үл хөдлөх өмчийн **Зах зээлийн үнэ цэнэ-ийг** харaат бусаар тодорхойлох нь энэхүү гэрээт ажлын зорилго болно.

1.7.2 **Зах зээлийн үнэ цэнэ** гэдэг нь зохих маркетинг сурталчилгаа хийгдсэний дараа талуул тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагчийн хооронд харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө, өрг төлбөрийг арилжвал зохино гэж уг үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн юм. (УОУС 104-ын 30.1-р заалт)

**1.8 Үнэлгээний валют.**

1.8.1 Үнэ цэнийг Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр хэмжсэн болно.

**1.9 Үнэлгээний өдөр**

1.9.1 Үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээгээр бид зах зээлийн үнэ цэнийг 2024 оны 04-р сарын 20-ний өдрийн байдлаар тогтоохоор тохиролцсон.

1.9.2 Үнэлгээний өдөр гэдэг нь үнэлгээчний үнэ цэнийн дүгнэлт гаргасан өдөр.

1.9.3 УОУС-д үнэлгээний өдрийг үнэ цэнийн талаарх дүгнэлтийг хэрэглэх өдрөөр зааж өгсөн. Энэ нь үнэлгээний тайланг бэлтгэж хүлээлгэн өгөх өдөр эсвэл судалгаа шинжилгээг гүйцэтгэж дуусгавар болох өдрөөс ялгаатай байж болно.

1.9.4 Бид үнэлж буй хөрөнгийн шинж байдлыг тодорхойлох зорилгоор биет үзлэг хэмжилтийг 2024 оны 04-р сарын 23-ны өдөр хийж гүйцэтгэсэн.

1.9.5 Үнэлэгдэж буй хөрөнгийн онцлог, холбогдох зах зээлийн судалгаа шинжилгээг үзлэг хийсэн өдрөөс эхлэн үнэлгээний тайлан бэлтгэх хүртэл хийсэн бөгөөд үнэлгээний тайланг 2024 оны 04-р сарын 25-ний өдөр хүлээлгэн өгсөн.

**1.10 Найдвартай мэдээллийн эх үүсвэр ба шинж чанар**

1.10.1 *Захиалагч болон үйлчлүүлэгчээс хаpуулсан мэдээлэл:* Үнэлэгдэж буй хөрөнгийн шинж байдлыг тодорхойлох үүднээс өмчлол, хийц бүтэц, ашиглалтын байдалтай холбоотой дараах баримт бичгийн хуулбарыг авсан болно. Үүнд:

- ✓ Газар эзэмших эрхийн гэрчилгээний хуулбар
- ✓ Кадастрын зураг

1.10.2 *Үнэлж буй хөрөнгийн талаарх үнэлгээчний цуглуулсан мэдээлэл:* Үнэлж буй хөрөнгийн ашиглалтын өнөөгийн байдал, хэмжээг тогтоох үүднээс биет, үзлэг хэмжилтээр дараах мэдээллийг цуглуулсан. Үүнд:

- ✓ Хөрөнгийн хийц бүтэц болон ашиглалтыг харуулсан гэрэл зураг

1.10.3 *Үнэ цэнийн тооцоолол ашигласан судалгааны мэдээлэл:* зах зээлийн төлөв байдал, хэтийн хандлагыг тогтоох үнэлж буй хөрөнгийн хамаарах зах зээлийн талаарх төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын гаргасан дараах мэдээллийг ашигласан. Үүнд:

- ✓ Хэрэглээний үнийн индекс- Үндэсний статистикийн хорооны боловсруулж, Монголбанкны зарладаг сар бүрийн хэрэглээний үнийн индексийн судалгаа

1.10.4 *Үнэ цэнийн тооцоолол ашигласан үнэлгээчний цуглуулсан мэдээлэл:* Үнэлгээний зорилго, үнэ цэнийг тогтооход ашигласан аргаас хамаарч үнэлгээчин дараах мэдээллийг үл хөдлөх хөрөнгө зуучлалын компаниудын цахим хуудас болон бусад эх сурвалжийг ашиглан цуглуулсан болно. Үүнд:

- ✓ Жишиг хөрөнгийн зах зээлийн үнэ, түрээсийн төлбөрийн мэдээллийг холбогдох үл хөдлөх хөрөнгө зуучлалын компаниудын цахим хуудаснаас, тухайлбал www.unegui.mn , www.remax.mn, www.zarnedee.mn, www.erdenetzar.mn гэх мэт
- ✓ Жишиг болохуйц хөрөнгийн судалгаа, сонголт
- ✓ Жишиг хөрөнгийн зах зээлийн жишиг үнийн судалгаа
- ✓ Жишиг хөрөнгийн зах зээлийн түрээсийн төлбөр
- ✓ Жишиг хөрөнгийн түрээсийн өгөөжийн түвшин
- ✓ Үнэлж буй хөрөнгийн орлого олох боломж, ашиглалтын үлдсэн хугацааг үнэлэх

**1.11 Таамаглал ба тусгай таамаглалууд**

1.11.1 *Хамгийн өндөр ба хамгийн сайн ашиглалт* гэдэг нь оролцогчийн хэтийн төлөвөөс авч үзсэн, тухайн хөрөнгийн хувьд хамгийн өндөр үнэ цэнийг бий болгох ашиглалт юм. (УОУС 2020. Стандарт 104. 140.1) Үнэлж буй хөрөнгө нь худалдаа үйлчилгээний зориулалтаар



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

# ҮЛ ХӨДЛӨХ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хүснэгт №4. Үнэлгээчдийн үүрэг, оролцоо

| № | Үнэлгээчний овог нэр | Үүрэг, оролцоо |
|---|---|---|
| 1 | Н.Цолмонгэрэл | Үнэлгээний ажлыг удирдаж, үнэлгээний явц, үнэлгээний тайланг хянасан. Үнэлгээний арга зүйг тодорхойлж, үнэ цэнийн тооцоолол судалгааг хийн, үнэлгээний тайланг бэлтгэсэн. |
| 2 | Э.Батболд | Үнэлгээнд хамрагдаж буй үл хөдлөх хөрөнгөнд биет үзлэг, хэмжилт хийн мэдээлэл цуглуулж, Үнэлгээний арга зүйг тодорхойлж, үнэ цэнийн тооцоолол судалгаа хийн, үнэлгээний тайланг бэлтгэсэн. |
| 3 | Ч.Отгончимэг | Хөрөнгийн биет үзлэг хэмжилт хийхэд туслаж, зах зээлийн үнийн судалгаа хийн, мэдээлэл боловсруулан үнэлгээчинд туслан ажилласан. |

## 1.3 Үнэлгээний зорилго.

1.3.1 Үнэлгээний зорилго: "Монголын финтек групп" ХК-ийн газар эзэмших эрхийн зах зээлийн үнэ цэнийг тодорхойлох нь энэхүү гэрээт ажлын зорилго болно.

Хүснэгт №5. Үнэлгээнд буй хөрөнгийн нэр төрөл

| № | Эзэмшигчийн нэр | Хөрөнгийн нэр | Хэмжээ /м.кв/ | Хаяг | ҮХЭХ бүртгэлийн дугаар |
|---|---|---|---|---|---|
| 1 | "Монголын финтек групп" ХК | Зочид буудлын цогцолбор, олон нийтийн газрын зориулалттай | 10,000.0 | Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЗӨЧ-4 гудамж 406 тоот | 4401010485 |
| 2 | "Монголын финтек групп" ХК | Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай | 1,200.0 | Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЗӨЧ-3 гудамж 320 тоот | 4401002556 |

1.3.2 Энэхүү үнэлгээний ажил нь "Монголын финтек групп" ХК-ийн үнэлүүлэхээр захиалсан дээрх нэр төрлийн үл хөдлөх хөрөнгөөр хязгаарлагдах бөгөөд захиалагчийн хүсэлт гаргаагүй үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил зэрэг бусад хөрөнгө үнэлгээний хамрах хүрээнд орохгүй болно.

1.3.3 Манай Улсын "Хөрөнгийн үнэлгээний тухай" хуульд хөрөнгийн үнэлгээг Олон Улсын Үнэлгээний Стандартын Хорооноос эрхлэн гаргадаг Үнэлгээний Олон Улсын Стандарт (ҮОУС) ба үндэсний стандарт, аргачлалыг удирдлага болгон гэсний дагуу үнэлгээнд ҮОУС 2020, манай улсад мөрдөгдөж байгаа "Хөрөнгийн үнэлгээний тухай" хууль, үнэлгээний холбогдох аргачлал, журам, дүрмүүдийг үндэс болгосон.

1.3.4 Үнэлгээний ажлыг гүйцэтгэхтэй холбогдон захиалагчийг төлөөлж "Монголын финтек групп" ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Наранбат, гүйцэтгэгчийг төлөөлж Файн Эстимэйт ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Цолмонгэрэл нарын 2024 оны 04 дүгээр сарын 22-ний өдөр байгуулсан гэрээ нь үнэлгээний ажлын үндэслэл болно.

## 1.4 ҮОУС-ын шаардлагууд

1.4.1 Хөрөнгийн үнэлгээний тайлан нь бүтэц, агуулгын хувьд ҮОУС 103 "Тайлагнал" болон Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, эрх зүйн бусад баримт бичгийн шаардлагад нийцэж байгаа болно.

1.4.2 ҮОУС-д заасны дагуу үнэлгээний үйл ажиллагаанд хараат бус байдал, үнэлгээний үндсэн зарчмууд, стандарт, дүрэм журам хэрхэн мөрдөгдсөн болохыг батлан нийцлийн талаарх мэдэгдлийг хөрөнгийн үнэлгээний тайланд тусгаж байх шаардлагын дагуу дараах байдлаар илэрхийлж байна. Үүнд:

- ✓ Хөрөнгийн үнэлгээг бодитой, шударга хандах байр сууринаас хөрөнгийн үнэлгээний олон улсын болон үндэсний хэмжээнд мөрдөгддөг ёс зүйн дүрмийг баримтлан гүйцэтгэсэн;

ҮЛ ХӨДЛӨХ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

- ✓ Үнэлгээг гүйцэтгэгч компани болон үнэлгээчид нь хийгдсэн хөрөнгийн үнэлгээг гэрээнд зааснаас өөр ямар нэг байдлаар ашиглах зорилгогүй, түүнчлэн захиалагч болон гүйцэтгэгч ашиг сонирхлын холбоогүй бөгөөд хөрөнгийн үнэлгээг хараат бус байдалд хийсэн болно;
- ✓ Үнэлгээчид уг ажлыг гүйцэтгэх хангалттай хэмжээний дадлага, туршлага, чадвартай бөгөөд үнэлгээг үнэлгээний тусгай эрхтэй гурван мэргэшсэн үнэлгээчин, гурван үнэлгээчний туслахаас бүрдсэн баг гүйцэтгэсэн ба үнэлгээний ажилд гадны байгууллага, мэргэжилтний туслалцаа аваагүй;
- ✓ Үнэлгээний ажлын хөлс үнэлгээний дүнгээс хамааралгүйгээр ажил гүйцэтгэхийн өмнө захиалагчтай байгуулсан гэрээгээр урьдчилан тохиролцсон;
- ✓ Үнэлгээнд ашигласан болон тайланд тусгагдсан тоо, мэдээллүүд, хийгдсэн таамаглалууд нь үнэлгээчдийн ойлголтын түвшинд үнэн зөв.

**1.5 Үнэлгээнд баримталсан ҮОУС-ын тодорхойлолтууд**

1.5.1 ***Үнэ цэнийн суурьуд*** (зарим үед үнэ цэнийн стандартууд гэж нэрлэдэг) нь тухайн тайлагнах үнэ цэнийг үндэслэн гаргах суурь урьдчилсан нөхцөлүүдийг тодорхойлдог. Үнэлгээний арга, орц, төсөөллүүдийн талаарх үнэлгээчний сонголт болон үнэ цэнийн тухай гүүний эцсийн санал дүгнэлтэд нөлөөлдөг буюу чиглүүлдэг байж болох тул үнэ цэнийн суурь (буюу суурьнууд) нь үнэлгээний гэрээт ажлын нөхцөл ба зорилгод тохирсон байх нь чухал ач холбогдолтой юм. (ҮОУС 2019. Стандарт 104. 10.1)

1.5.2 ***Зах зээлийн үнэ цэнэ*** гэдэг нь зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа, талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагчийн хооронд харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө, өр төлбөрийг арилжвал зохино гэж уг үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн юм. (ҮОУС 2019. Стандарт 104. 30.1)

1.5.3 ***Тэгш шударга үнэ цэнэ*** гэдэг нь зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа, тогтсон тодорхой талуудын хооронд хөрөнгө буюу өр төлбөрийг шилжүүлэх тооцоолсон дүн бөгөөд тэдгээр талуудын тус тусын холбогдох ашиг сонирхлыг тусган илэрхийлдэг. (ҮОУС 2020. Стандарт 104. 50.1)

1.5.4 ***Бодит үнэ цэнэ*** нь хэмжилтийн өдөр зах зээлийн оролцогчдын хооронд хэвийн ажил гүйлгээгээр хөрөнгийг борлуулснаар хүлээн авах эсвэл өр төлбөрийг шилжүүлснээр төлөх үнэ гэж СТОУС 13-д тодорхойлсон байдаг. (ҮОУС 2020. Стандарт 104. 90.1)

1.5.5 ***Хамгийн өндөр ба хамгийн сайн ашиглалт*** гэдэг нь оролцогчийн хэтийн төлөвөөс авч үзсэн, тухайн хөрөнгийн хувьд хамгийн өндөр үнэ цэнийг бий болгох ашиглалт юм. Санхүүгийн олонх хөрөнгө нь өөр хувилбар ашиглалттүй байдаг учраас энэхүү үзэл баримтлалыг санхүүгийн бус хөрөнгөнд хамгийн өргөнөөр хэрэглэдэг боловч санхүүгийн хөрөнгийн хамгийн өндөр ба хамгийн сайн ашиглалтыг харгалзан үзэх шаардлагатай тийм нөхцөл байдлууд байж болох юм. (ҮОУС 2020. Стандарт 104. 140.1)

1.5.6 ***Зах зээлийн хандлага*** нь тухайн хөрөнгийг үнийн мэдээлэл нь бэлэн олдоцтой байгаа ижил буюу жишиж болох (өөрөөр хэлбэл, төсөөтэй) хөрөнгүүдтэй харьцуулснаар үнэ цэнийн үзүүлэлтийг тодорхойлдог. (ҮОУС 2020. Стандарт 105. 20.1)

1.5.7 ***Орлогын хандлага*** нь ирээдүйн мөнгөн гүйлгээг өнөөгийн үнэ цэнэд хөрвүүлснээр үнэ цэнийн нэг л үзүүлэлтийг тооцоолдог. Орлогын хандлагын дагуу тухайн хөрөнгийн бий болгох орлогын үнэ цэнэ, мөнгөн гүйлгээ эсвэл өртгийн хэмнэлтийг харгалзсанаар хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлдог. (ҮОУС 2020. Стандарт 105. 40.1)

1.5.8 ***Өртгийн хандлага*** нь хөрөнгийн одоогийн орлуулалт болон дахин үйлдвэрлэлтийн өртгийг тооцоолох ба биет чанаргүйдэлт болон хоцрогдлын холбогдох бусад бүх хэлбэрүүдийн хувьд хасагдуулга хийснээр үнэ цэнийн үзүүлэлтийг гаргадаг. (ҮОУС 2020. Стандарт 105. 60.1)

**1.6 Үнэ цэнийн суурь**

1.6.1 Энэхүү үнэлгээний ажил нь зээлийн барьцааны зориулалтаар хийгдэж байгаа учраас ҮОУС 104 *Үнэ цэнийн суурьуд*-ын 10-р зүйлд тодорхойлсон зах зээлийн үнэ цэнийн суурийг баримталлаа.

**1.7 Тогтоох үнэ цэнэ**

1.7.1 Захиалагчийн үнэлүүлэхээр хүсэлт гаргасан үл хөдлөх **өмчийн Зах зээлийн үнэ цэнэ-ийг** хараат бусаар тодорхойлох нь энэхүү гэрээт ажлын зорилго болно.

1.7.2 **Зах зээлийн үнэ цэнэ** гэдэг нь зохих маркетинг сурталчилгаа хийгдсэний дараа талууд тус бүр зохих мэдлэгтэй, болон төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагчийн хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө, өрт төлбөрийг арилжвал зохино гэж уг үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн юм. (ҮОУС 104-ын 30.1-р заалт)

**1.8 Үнэлгээний валют.**

1.8.1 Үнэ цэнийг Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр хэмжсэн болно.

**1.9 Үнэлгээний өдөр**

1.9.1 Үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээгээр бид зах зээлийн үнэ цэнийг 2024 оны 04-р сарын 20-ний өдрийн байдлаар тогтоохоор тохиролцсон.

1.9.2 Үнэлгээний өдөр гэдэг нь үнэлгээчний үнэ цэнийн дүгнэлт гаргасан өдөр.

1.9.3 ҮОУС-д үнэлгээний өдрийг үнэ цэнийн талаарх дүгнэлтийг хэрэглэх өдрөөр зааж өгсөн. Энэ нь үнэлгээний тайланг бэлтгэж хүлээлгэн өгөх өдөр эсвэл судалгаа шинжилгээ гүйцэтгэж, дуусгавар болох өдрөөс ялгаатай байж болно.

1.9.4 Бид үнэлж буй хөрөнгийн шинж байдлыг тодорхойлох зорилгоор биет үзлэг хэмжилтийг 2024 оны 04-р сарын 23-ны өдөр хийж гүйцэтгэсэн.

1.9.5 Үнэлэгдэж буй хөрөнгийн онцлог, холбогдох зах зээлийн судалгаа шинжилгээ үзлэг хийсэн өдрөөс эхлэн үнэлгээний тайлан бэлтгэх хүртэл хийсэн бөгөөд үнэлгээний тайланг 2024 оны 04-р сарын 25-ний өдөр хүлээлгэн өгсөн.

**1.10 Найдвартай мэдээллийн эх үүсвэр ба шинж чанар**

1.10.1 *Захиалагч болон үйлчлүүлэгчээс гаргуулсан мэдээлэл:* Үнэлэгдэж буй хөрөнгийн шинж байдлыг тодорхойлох үүднээс өмчлөл, хийц бүтэц, ашиглалтын байдалтай холбоотой дараах баримт бичгийн хуулбарыг авсан болно. Үүнд:

- ✓ Газар эзэмших эрхийн гэрчилгээний хуулбар
- ✓ Кадастрын зураг

1.10.2 *Үнэлж буй хөрөнгийн талаарх үнэлгээчний цуглуулсан мэдээлэл:* Үнэлж буй хөрөнгийн ашиглалтын өнөөгийн байдал, хэмжээг тогтоох үүднээс биет, үзлэг хэмжилтээр дараах мэдээллийг цуглуулсан. Үүнд:

- ✓ Хөрөнгийн хийц бүтэц болон ашиглалтыг харуулсан гэрэл зураг

1.10.3 *Үнэ цэнийн тооцоолол ашигласан судалгааны мэдээлэл:* зах зээлийн төлөв байдал, хэтийн хандлагыг тогтооход үнэлж буй хөрөнгийн хамаарах зах зээлийн талаарх төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын гаргасан дараах мэдээллийг ашигласан. Үүнд:

- ✓ Хэрэглээний үнийн индекс- Үндэсний статистикийн хорооны боловсруулж, Монголбанкны зарладаг сар бүрийн хэрэглээний үнийн индексийн судалгаа

1.10.4 *Үнэ цэнийн тооцоолол ашигласан үнэлгээчний цуглуулсан мэдээлэл:* Үнэлгээний зорилго, үнэ цэнийг тогтооход ашигласан аргаас хамаарч үнэлгээчин дараах мэдээллийг үл хөдлөх хөрөнгө зуучлалын компаниудын цахим хуудас болон бусад эх сурвалжийг ашиглан цуглуулсан болно. Үүнд:

- ✓ Жишиг хөрөнгийн зах зээлийн үнэ, түрээсийн төлбөрийн мэдээллийг холбогдох үл хөдлөх хөрөнгө зуучлалын компаниудын цахим хуудаснаас, тухайлбал www.unegui.mn , www.remax.mn, www.zarmedee.mn, www.erdenetzar.mn гэх мэт
- ✓ Жишиг болохуйц хөрөнгийн судалгаа, сонголт
- ✓ Жишиг хөрөнгийн зах зээлийн жишиг үнийн судалгаа
- ✓ Жишиг хөрөнгийн зах зээлийн түрээсийн төлбөр
- ✓ Жишиг хөрөнгийн түрээсийн өгөөжийн түвшин
- ✓ Үнэлж буй хөрөнгийн орлого олох боломж, ашиглалтын үлдсэн хугацааг үнэлэх

**1.11 Таамаглал ба тусгай таамаглалууд**

1.11.1 *Хамгийн өндөр ба хамгийн сайн ашиглалт* гэдэг нь оролцогчийн хэтийн төлөвөөс авч үзсэн, тухайн хөрөнгийн хувьд хамгийн өндөр үнэ цэнийг бий болгох ашиглалт юм. (ҮОУС 2020. Стандарт 104. 140.1) Үнэлж буй хөрөнгө нь худалдаа үйлчилгээний зориулалтаар

СЭХ 2024.06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02



ашиглах нь бнет байдлын хувьд тохиромжтой, эрх зүйн хязгаарлалт байхгүй, санхүүгийн хувьд хэрэгжих боломжтой гэж үзэж байна.

1.11.2 Дээрх ердийн таамаглалуудаас өөр ямар нэгэн тусгай таамаглал авч үзээгүй болно.

**1.12 Үнэлгээний талаарх баталгаа ба хязгаарлах нөхцөл**

1.12.1 Энэхүү тайлангийн 1.11.1-т заасан үйлчлүүлэгчээс гаргуулсан мэдээллийг үнэлж буй хөрөнгөтэй холбоотой албан ёсны эрх зүйн баримт бичгүүдийн хуулбар хувийг бидэнд өгсөн гэж үзсэн тул эх хувь болон бидэнд өгсөн мэдээллийн өөрчлөлт, зөрүүтэй холбоотой ямар нэгэн үүрэг хариуцлага хүлээхгүй болно.

1.12.2 Бид найдвартай гэж үзсэн эх сурвалжаас статистик мэдээлэл цуглуулсан. Мөн гуравдагч этгээдийн гаргасан мэдээллийн түйлын үнэн зөв байдлыг баталж чадахгүй тул уг мэдээлэл үнэн зөв бус эсвэл төөрөгдүүлэхээр тохиолдолд ямар нэгэн үүрэг хариуцлага, өр төлбөр хүлээхгүй.

1.12.3 Барилгын чанар байдлыг үнэлэн, хэмжилт хийснээр техникийн болон инженерийн үзлэг шинжилгээг хязгаарласан бөгөөд үнэлгээчин нь ийм зүйлстэй холбоотой үүрэг хариуцлага хүлээхгүй.

1.12.4 Үнэлгээний цар хүрээн дотор хүрээлэн байгаа орчныг авч үзэх боломжгүй бөгөөд үнэлгээчин энэ асуудалтай холбоотой үүрэг хүлээхгүй.

1.12.5 Үнэлж буй хөрөнгөнд бнет үзлэг, хэмжилт хийсэн өдрөөс хойш хөрөнгөнд гарсан аливаа өөрчлөлтийн талаар үүрэг хариуцлага хүлээхгүй бөгөөд тайлбар өгөх үүрэгтүй болно.

1.12.6 Үнэлж буй хөрөнгө эсвэл түүний эрхтэй холбоотойгоор бид ямар нэгэн тусгай гэрээ байгуулаагүй л бол бид нэмэлт ажил гүйцэтгэх, мэдүүлэг өгөх эсвэл шүүх үйл ажиллагаанд оролцох үүрэг хүлээхгүй.

1.12.7 Бид өөдрөг төсөөлөл болон зах зээлд байж болох сайн төсөөллөөр үнэлгээнд хандаж дүгнэлтээ гаргаснаар хууль эрх зүйн ямар нэгэн хариуцлага хүлээхгүй гэж төсөөлсөн болно.

1.12.8 Бидний зах зээлээс олж авсан мэдээлэл нь тохиромжтой мэдээлэл гэдэгт бид итгэж байгаа боловч тэдгээрийг яг үнэн гэсэн баталгаар гаргах боломжгүй. Мөн судалгаа шинжилгээ гүйцэтгэсэн болон бэлтгэсэн тайланг үйлчлүүлэгчид хүлээлгэн өгснөөс хойших хугацаанд гарсан зах зээлийн өөрчлөлтөөс үүдэлтэй аливаа үүрэг хариуцлага хүлээхгүй болно.

Сэндли бонд ХК



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 5021031195 СТС2420

СЗХ 2024.06 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

ҮЛ ХӨДЛӨХ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

25-APR-2024

## ХОЁР. ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ

### 2.1 Газар эзэмших эрхийн тодорхойлолт, үнэлгээ
### 2.1.1 Газар эзэмших эрхийн тодорхойлолт

**Эзэмшлийн байдал:** "Монголын финтек групп" ХК нь Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЗӨЧ-4 гудамж 406 тоот хаягт байрлах нэгж талбарын 4401010485, улсын бүртгэлийн Э-0714002972 дугаар бүхий 10,000 кв.метр газрыг Зочид буудлын цогцолбор, олон нийтийн газрын зориулалтаар олж эзэмшиж байна. Энэхүү эзэмшил газар нь Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЗӨЧ-4 гудамж 406 тоот буюу Соёмботой хөшөөний урд талд байрлалтай.

**Эзэмшлийн байдал:** "Монголын финтек групп" ХК нь Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЗӨЧ-3 гудамж 320 тоот хаягт байрлах нэгж талбарын 4401002556, улсын бүртгэлийн Э-0714002967 дугаар бүхий 1,200 кв.метр газрыг Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалтаар олж эзэмшиж байна. Энэхүү эзэмшил газар нь Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЗӨЧ-3 гудамж 320 тоот буюу Соёмботой хөшөөний хойд талд байрлалтай. Эдгээр газрын байршлыг харуулсан план зургийг энэхүү тайлангийн дүрслэл №1-зэр оруулав.

**Ашиглалтын байдал:** Дээрх эзэмшил газруудыг хараахан ашиглаж эхлээгүй байна. Газрын гадаргуу ерөнхийдөө тэгш, эдгээр газрын хэлбэр нь тэгш өнцөгт хэлбэртэй.

**Эзэмшлийн эрх зүйн байдал:** "Монголын финтек групп" ХК-ийн нэр дээр аж ахуй нэгж газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг 2023 онд олгожээ. Газар эзэмших эрхийн гол үзүүлэлтүүдийг дараах хүснэгтээр харуулллаа.

Хүснэгт №6. Газар эзэмших эрхийн байдал.

| № | Үзүүлэлтүүд | Утга | Утга |
|---|---|---|---|
| 1 | Эзэмшигчийн нэр | "Монголын финтек групп" ХК | "Монголын финтек групп" ХК |
| 2 | Нэгж талбарын дугаар | 4401010485 | 4401002556 |
| 3 | Улсын бүртгэлийн дугаар | Э-0714002972 | Э-0714002967 |
| 4 | Өмчлөлийн төрөл | Эзэмших | Эзэмших |
| 5 | Эрхийн хязгаарлалт | Аливаа эрхийн хязгаарлалтгүй | Аливаа эрхийн хязгаарлалтгүй |
| 6 | Зориулалт | Зочид буудлын цогцолбор, олон нийтийн газрын зориулалттай | Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай |
| 7 | Гэрчилгээний дугаар | 0000237626 | 0000237326 |
| 8 | Гэрчилгээний огноо | 11/27/2023 | 11/24/2023 |
| 9 | Олгосон захирамжийн дугаар | А/313 | А/309 |
| 10 | Олгосон захирамжийн огноо | 11/27/2023 | 11/27/2023 |
| 11 | Эзэмшүүлсэн хугацаа | 15 жил | 15 жил |
| 12 | Газрыг хэмжих нэгж | м.кв | м.кв |
| 13 | Гэрчилгээнд заасан хэмжээ | 10,000.0 | 1,200.0 |
| 14 | Газрын байршил | Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЗӨЧ-4 гудамж 406 тоот | Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЗӨЧ-3 гудамж 320 тоот |
| 15 | Хамаарах үнэлгээний бүсчлэл | 31 \| Дорноговь, Замын-Үүд \| 1 | 31 \| Дорноговь, Замын-Үүд \| 1 |
| 16 | Төвийн цахилгааны шугам | Холбогдоогүй. | Холбогдоогүй. |
| 17 | Төвийн дулааны шугам | Холбогдоогүй. | Холбогдоогүй. |
| 18 | Төвийн бохир усны шугам | Холбогдоогүй. | Холбогдоогүй. |
| 19 | Төвийн цэвэр усны шугам | Холбогдоогүй. | Холбогдоогүй. |

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ФАЙН ЭСТИМЭЙТ ХХК

УЛААНБААТАР ХОТ ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨХ КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195

Сэндли Бонд ХК

СЗХ
2024.06.10 -ны өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

ҮЛ ХӨДЛӨХ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

25-APR-2024

Дүрсэл №1: Газар эзэмших эрхийн байршил /Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЗӨЧ-4 гудамж 406 тоот/




Дүрсэл №1: Газар эзэмших эрхийн байршил /Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЗӨЧ-4 гудамж 406 тоот/




ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ФАЙН ЭСТИМЭЙТ ХХК

УЛААНБААТАР ХОТ
ФАЙН ЭСТИМЭЙТ ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2024.06.19
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-17
БҮРТГЭВ-02

25-APR-2024

## ҮЛ ХӨДЛӨХ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**2.1.2 Газар эзэмших эрхийн үнэлгээ**

Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЗӨЧ-3 гудамж 320 тоот болон Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЗӨЧ-4 гудамж 406 тоот хаягт байрлах 2ш Газар эзэмших эрхийн үнэлгээг хийхдээ (а) "Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал" -аар дуудлага худалдааны доод үнэлгээ, (б) Арилжааны харьцуулалтын (Зах зээлийн жишиг үнийн) аргаар газар эзэмших эрхийн үнэлгээг хийхдээ орон сууцны зориулалтаар тус байршилтай ойр арилжаалагдсан газар эзэмших эрхийн зах зээлийн жишиг үнийн судалгааг хийж, нэг м.кв газарт ногдох эзэмших эрхийн үнийг тодорхойлон зах зээлийн жишиг үнийн хандлагын арилжааны харьцуулалтын аргаар үнэлгээг тодорхойллоо. Газар эзэмших эрхийг өртөг болон орлогын хандлагын аргуудаар үнэлсэнгүй. Учир нь эдгээр аргаар үнэлгээг тогтоохад шаардлагатай газрын бүтээж буй орлого, орлогыг капиталчлах хувь, газрыг олж эзэмших өртөг зэрэг мэдээллийн олдоц муу бөгөөд тооцоололд шаардлагатай таамаглалыг дэвшүүлэхэд хүрэлцэхүйц мэдээлэл алга байна. Газар эзэмших эрхийн үнэлгээг хийхдээ үнэлгээний суурь болох талбайг газар эзэмших эрхийн гэрчилгээн дээрх талбайгаар авч тооцсон болно. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хуулбарыг энэхүү тайлангийн хавсралтаас харна уу.

**Дуудлага худалдааны анхны үнэ тогтоох аргачлалаарх үнэлгээ:**

Энэхүү аргачилалаар дээр тодорхойлсон газар эзэмших эрхийн үнэлгээг хийхдээ Монгол улсын Засгийн газрын 2018 оны 06-р сарын 20-ны өдрийн 182 тоот тогтоолоор батлагдсан **"АЙМГИЙН ТӨВИЙН СУМ, НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ, БАГАНУУР, БАГАХАНГАЙ ДҮҮРЭГ, ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД, ЦОГТЦЭЦИЙ, ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАРХОРИН, ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР, СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ, АЛТАНБУЛАГ, ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ, ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН ТӨВ (ХОТ, ТОСГОН, БУСАД СУУРИНЫ ГАЗАР)-ИЙН ГАЗРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЗЭРЭГЛЭЛ (БҮС), 1 ГА ГАЗРЫН СУУРЬ ҮНЭЛГЭЭ"-г** баримтлан дараах хүснэгт №7-ын дагуу тооцсон.

**Хүснэгт №7. Газрын эзэмших эрхийн дуудлага худалдааны анхны үнийг тогтоох аргачилалаарх үнэлгээ**

| Д/Д | Газрын нэр | Нийт талбай, $м^2$ | Газрын үнэлгээний зэрэглэл(бүс)-ийн дугаар | Газар ашиглалтын зориулалт (Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоос) | Тухайн зэрэглэлд хамаарах суурь үнэлгээ /төг/ | Газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээ (төг) |
|---|---|---|---|---|---|---|
| А | Б | В | Г | Д | Е | Ж |
| 1 | Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЗӨЧ-4 гудамж 406 тоот | 10,000 | 31 \| Дорноговь, Замын-Үүд \| 1 | Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ | 15,000 | 150,000,000 |
| 2 | Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЗӨЧ-3 гудамж 320 тоот | 1,200 | 31 \| Дорноговь, Замын-Үүд \| 1 | Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ | 15,000 | 18,000,000 |

Дуудлага худалдааны анхны үнэ тогтоох аргачлалаарх үнэлгээ нь цаг хугацааны, хэмжээний, хэлбэрийн, дэд бүтцийн хангамжийн, хийгдсэн сайжруулалтын, хүрээлэн буй орчны, байршлын болон гадаргуугийн зэрэг хүчин зүйлсийг харгалздаггүй тул бодит үнэ цэнийг илэрхийлэхэд учир дутагдалтай байдаг. Иймээс газар эзэмших эрхийн зах зээлийн үнийг судлаж, зах зээлийн жишиг үнийн хандлагын арилжааны харьцуулалтын аргаар үнэлгээг тогтоох нь тохиромжтой гэж үзэв. Аж ахуйн нэгжүүд газрын эзэмших, ашиглах эрхийг бие биенээсээ худалдан авах нь элбэг байна. Сүүлийн жилүүдэд аж ахуйн нэгжүүд нь газрыг их хэмжээгээр худалдан авч эзэмшиж байгаа бөгөөд худалдан авалтын өртөг нь бидний газрын үнэлгээнд ашиглаж буй зах зээлийн харьцуулалтын аргаар мөн тооцогдох боломжтой.

**Арилжааны харьцуулалтын (Зах зээлийн жишиг үнийн) аргаарх үнэлгээ:**

Энэхүү аргаар үл хөдлөх хөрөнгө /Газар эзэмших эрх/-ийг үнэлэхдээ ижил хэмжээтэй, ойролцоо байршилд арилжаалагдсан болон арилжаалагдахаар хүлээгдэж буй үл хөдлөх хөрөнгийн үнийг судалж, арилжаалагдсан үнэд нөлөөлсөн байршлын, эзэмших эрхийн,

## ҮЛ ХӨДЛӨХ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

хэлцлийн, санхүүжилтийн, хөрөнгийн биет байдлын зэрэг хүчин зүйлсийг тодорхойлж, эдгээрийн шаардлагатай тохируулгыг хийж үнэлж буй хөрөнгийн үнэлгээг тодорхойлдог арга юм. Арилжаалахаар хүлээгдэж буй жишиг хөрөнгийн үнийн судалгаар хийхдээ үл хөдлөх хөрөнгийн зуучлал эрхэлдэг компаниудын цахим хуудас болон Шуурхай зар, Зар мэдээ зэрэг зарын тогтмол хэвлэлийн эх сурвалжийг ашигласан. Жишээлбэл: /www.unegui.mn, www.centuty21.mn, www.refmax.mn, www.ezar.mn, www.negdoor.mn, www.zarmedee.mn, www.osmo.mn, www.mmgproperties.com, www.facebook.com/. Сонин дээрх зарууд болон, үл хөдлөх хөрөнгө зуучийн компаниудын сайт дээрх зарын мэдээлэл нэг бүрчлэн, бүгд www.unegui.mn сайтад давхар бүртгэгдсэн байснаас гадна, үл хөдлөх зуучийн компаниуд тус бүр бэлэн байгаа үл хөдлөхүүдийн мэдээллийг мөн оруулсан байсан тул хамгийн найдвартай, бүх мэдээллийг багтаасан гэж үзээд www.unegui.mn дээрх мэдээллийг бүгдийг нэгтгэж авлаа.

Хүснэгт №8. Газрын үнийн зах зээлийн судалгаа

| № | Байршил | Зориулалт | Хугацаа | Газрын хэмжээ, м.кв | Худалдах үнэ, мян.төг | Эх сурвалж | Утас |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Замын үүд хот, хил нэвтрэх вокзал дээр байрлал сайтай газрын эрх шилжүүлнэ. | Гэр, орон сууцны хашааны газар | 4/10/2024 | 1,150 | 380,000.0 | https://www.unegui.mn/adv/7950715_zamy [illegible]-uud-khot-vokzal-dotor-gazar/ | 88029454 |
| 2 | Замын-Үүд суманд худалдаа, нийтийн үйлчилгээний зориулалттай 2000м2 газрын эрх шилжүүлнэ. | Худалдаа, нийтийн үйлчилгээ | 3/29/2024 | 2,000 | 95,000.0 | https://www.unegui.mn/adv/7382291_gazr [illegible]-erkh-shilzhuulne/ | 99570806 |
| 3 | Дорноговь аймаг, замын үүд хот Соёмбо хотхоны баруун талд эзэмших эрхтэй газрын эрхийг шилжүүлнэ. | Худалдаа, нийтийн үйлчилгээ | 4/23/2024 | 1000 | 180,000.0 | https://goiconnect.com/AdvancedSearch/AdvancedListingFull.aspx?ListingKey=[illegible]ce9f-a946-4576-8be7-24c1c642e372&Result=1&CurrentIndex=0 | 88029454 |

Үнэлж буй газартай ойр байршилд, үнэлгээний өдрийн ойролцоо арилжаалсан байгаа/шинэхэн/ дараах 3 арилжааны мэдээллийг жишиг үнийн мэдээллээр сонгон авлаа. Эдгээр сонгон авсан үнийн мэдээлэл нь газар эзэмших эрхийн зах зээлийн өнөөгийн бодит үнэ цэнийг тогтоохоод чиглэгдсэн, үнэ цэнэд нөлөөлөх хүчин зүйлсийн тохируулга бага хийгдэх шаардлагыг хамгийн сайн хангана.

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ФАЙН ЭСТИМЭЙТ ХХК

25-APR-2024

Хүснэгт №9. Жишиг газрын зах зээлийн судалгаа

| Үзүүлэлт | Жишиг хөрөнгө №1 | Жишиг хөрөнгө №2 | Жишиг хөрөнгө №3 |
|---|---|---|---|
| ...өрөнгийн нэр | Замын үүд хот, хил нэвтрэх вокзал дээр байрлал сайтай газрын эрх шилжүүлнэ. | Замын-Үүд сумынд худалдаа, нийтийн үйлчилгээний зориулалттай 2000м2 газрын эрх шилжүүлнэ. | Дорноговь аймаг, замын үүд хот Соёмбо хотхоны баруун талд зэмших эрхтэй газрын эрхийг шилжүүлнэ. |
| ...гноо | 4/10/2024 | 3/29/2024 | 4/23/2024 |
| ...азрын зориулалт | Гэр, орон сууцны хашааны газар | Худалдаа, нийтийн үйлчилгээ | Худалдаа, нийтийн үйлчилгээ |
| ...арагдах орчин | Харагдах орчин дунд. 1 талаараа жижиг замтай. | Харагдах орчин сайн. 1 талаараа засмал замтай. | Харагдах орчин дунд. 1 талаараа жижиг замтай. |
| ...үүрэн тал | Нүүрэн талд биш буюу төв зам дагуу биш. | Нүүрэн талд буюу төв зам дагуу. | Нүүрэн талд буюу төв зам дагуу. |
| ...азрын хэлбэр | Тэгш өнцөгт хэлбэртэй. | Тэгш өнцөгт хэлбэртэй. | Тэгш өнцөгт хэлбэртэй. |
| ...эд бүтэц | Дэд бүтэцэ холбогдоогүй. | Дэд бүтцэд холбогдоогүй. | Дэд бүтцэд холбогдоогүй. |
| ...айршил | Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЗӨЧ-4 гудамж 405 тоот буюу Соёмботой хөшөөний зүүн тала байрлалтай. | Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 3-р баг, Жаргалант 48 га төлөвлөлт буюу 640 хүүхдийн сургуулийн урд тала байрлалтай. | Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЗӨЧ-3 гудамж 300 тоот буюу Соёмбо хотхоны баруун тала байрлалтай. |
| ...айршлын давуу болон ...үл тал | Энэхүү жишиг газар нь засмал зам дагуу, үнэлэгдэж байгаа хөрөнгүүдээс 150м зайд байрлалтай. Ерөнхий байршлын хувьд үнэлэгдэж байгаа хөрөнгүүдтэй ижил байрлалтай. | Энэхүү жишиг газар нь засмал зам дагуу, үнэлэгдэж байгаа хөрөнгөөс зүүн хойд зүгт 2.8км зайд байрлалтай. Ерөнхий байршлын хувьд үнэлэгдэж байгаа хөрөнгөөс сул. | Энэхүү жишиг газар нь гуслах засмал зам дагуу, үнэлэгдэж байгаа хөрөнгөөс хойд зүгт 700м зайд байрлалтай. Ерөнхий байршлын хувьд үнэлэгдэж байгаа хөрөнгөөс бага зэрэг сул. |
| ...үйлгээний төрөл | Арилжих үнийн санал | Арилжих үнийн санал | Арилжих үнийн санал |
| ...азрын хэмжээ | 1,150 | 2,000 | 1000 |
| ...ийт үнэ | 380,000,000.0 | 95,000,000.0 | 180,000,000.0 |
| ...эгж талбайн үнэ | 330,435 | 47,500 | 180,000 |
| Эх сурвалж | https://www.unegui.mn/adv/7950715_zamyn-uud-khot-vokzal-dotor-gazar/ | https://www.unegui.mn/adv/7382291_gazryn-erkh-shilzhuulne/ | https://goiconnect.com/AdvancedSearch/AdvancedListingFull.aspx?ListingKey=fea1ee9f-a946-4576-8be7-24e1e642e372&Result=1&CurrentIndex=0 |
| Холбогдох утасны дугаар | 88029454 | 99570806 | 88029454 |
| ...зрын зураг |  |  |  |

СЭХ
2024.06.сар ... өдөр
БҮРТГЭВ
№ 01

2024-05-17

25-APR-2024
B-02

## ҮЛ ХӨДЛӨХ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хүснэгт №10. Газрын зах зээлийн жишиг үнийн тооцоолол /Худалдаа, үйлчилгээний зориулалтаар/

| № | Үзүүлэлт | Тооцоолол | Харьцуулагдах жишиг хөрөнгө №1 | Харьцуулагдах жишиг хөрөнгө №2 | Харьцуулагдах жишиг хөрөнгө №3 |
|---|---|---|---|---|---|
| 1 | Худалдах зарын он, сар | $A_i$ | 4/10/2024 | 3/29/2024 | 4/23/2024 |
| 2 | Худалдах үнэ, төг | $Б_i$ | 380,000,000.00 | 95,000,000.00 | 180,000,000.00 |
| 3 | Талбайн хэмжээ, м.кв | $В_i$ | 1,150.00 | 2,000.00 | 1,000.00 |
| 4 | Нэгж талбайн үнэ, төг | $Г_i = Б_i / В_i$ | 330,434.78 | 47,500.00 | 180,000.00 |
| 5. Тохируулга 5.1 | Байршлын | И1 | 1.00 | 1.25 | 1.10 |
| 5.2 | Арилжааны нөхцлийн | И2 | 0.95 | 0.95 | 0.95 |
| 5.3 | Хөрөнгийн зориулалтын | И3 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 5.4 | Санхүүжилтийн нөхцлийн | И4 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 5.5 | Дэд бүтцийн | И5 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 5.6 | Хугацаа | И6 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 5.7 | Газрын хэмжээний | И7 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 5.8 | Нүүрэн талын | И8 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 5.9 | Хэлбэр дүрсийн | И9 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 5.10 | Газрын налуугийн | И10 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 6 | Харьцуулах үнийн тохируулга | Иi | 313,913.04 | 56,406.25 | 188,100.00 |
| 7 | Жишиг хөрөнгөд өгөх ач холбогдлын хувь | | 50% | 0% | 50% |
| 8 | Ач холбогдлоор тохируулагдсан нэгж талбайн үнэ, төг | MV=Pi*Иi | 156,956.52 | - | 94,050.00 |
| 9 | Тохируулагдсан нэгж талбайн дундаж үнэ, төг | ДҮ | 251,006.52 | | |
| 10 | Үнэлж буй хөрөнгийн талбай, м.кв /10,000 м.кв/ | S | 10,000.00 | | |
| 11 | Газрын зах зээлийн үнэ цэнэ, төг | $P_1$ = ДҮ x S | 2,510,065,217 | | |
| 12 | **Газрын зах зээлийн бүхэлчилсэн үнэ цэнэ, төг** | P | **2,510,070,000** | | |
| 13 | Үнэлж буй хөрөнгийн талбай, м.кв /1,200 м.кв/ | S | 1,200.00 | | |
| 14 | Газрын зах зээлийн үнэ цэнэ, төг | $P_1$ = ДҮ x S | 301,207,826 | | |
| 15 | **Газрын зах зээлийн бүхэлчилсэн үнэ цэнэ, төг** | P | **301,210,000** | | |



УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
6021031195 СТС2420

СЗХ 2024.05.10 БҮРТГЭВ №01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02
25-APR-2024



## ГУРАВ. ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний нэгтгэсэн товчоог дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №11. Хөрөнгийн үнэлгээний товчоо /төгрөгөөр/

| № | Эзэмшигчийн нэр | Хөрөнгийн нэр | Хэмжээ м.кв | Дуудлага худалдааны анхны үнэ тогтоох аргачлалаар, төг | Зах зээлийн хандлагаар, төг | Тогтоосон үнэлгээ, төг |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | "Монголын финтек групп" ХК | Газар эзэмших эрх - Зочид буудлын цогцолбор, олон нийтийн газрын зориулалттай | 10,000.0 | 150,000,000 | 2,510,070,000 | 2,510,070,000 |
| 2 | "Монголын финтек групп" ХК | Газар эзэмших эрх - Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай | 1,200.0 | 18,000,000 | 301,210,000 | 301,210,000 |
| | **НИЙТ** | | | **168,000,000** | **2,811,280,000** | **2,811,280,000** |

Үнэлсэн хөрөнгийн зах зээлийн хандлагаарх үнэ цэнийг **2,811,280,000.0 /Хоёр тэрбум, найман зуун арван нэгэн сая, хоёр зуун наян мянган/** төгрөг гэж тогтоон үйлчлүүлэгчид хүргүүлж байна.



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 CTC2420

СЗХ
2024.06.10
БҮРТГЭВ
№ 1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02



## ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ХЭРЭГЛЭЭ

**4.1 Боловсруулах тайлангийн төрөл**

4.1.1 Үл хөдлөх хөрөнгийн санхүүгийн тайлагналын зориулалтаарх энэхүү тайланг Монгол хэл дээр хэвлэмэл /бичгээр/-ээр хоёр хувь үйлдэж, үйлчлүүлэгчид нэг хувийг өгсөн болно.

**4.2 Зориулагдсан бусад хэрэглэгч**

4.2.1 "Монголын финтек групп" ХК-ийн хэрэгцээнд зориулан боловсруулсан болно.

**4.3 Тайлангийн хэвлэлт, түгээн тараалт ба хэрэглээний хязгаарлалтууд**

4.3.1 Энэхүү тайланд тусгагдсан үнэлгээний аливаа тооцооллууд нь зөвхөн энэ үнэлгээнд хамрагдаж, түүний салшгүй хэсэг байхын зэрэгцээ тэдгээрийг тайлангийн агуулгаас гадуур ашиглаж үл болно. Энэ үнэлгээний ажил нь зөвхөн энэхүү тайлангийн зорилгуудын хувьд хүчин төгөлдөр болно.
4.3.2 Хэвлэмэлээр хүлээлгэн өгсөн тайланг үйлчлүүлэгч өөрийн хэрэгцээнд болон аудитын шалгалт хийж буй этгээдэд хянуулах зорилгоор ашиглаж болох ба бусад этгээдэд дамжуулах, хувилан олшруулах, зориулалтаас өөр зорилгоор, хэсэгчлэн авч ашиглахгүй байвал зохино.

**4.4 ҮОУС-ын гажилт**

4.4.1 ҮОУС-аас гажсан гэж тодорхойлон бичээгүй бол, түүнийг шаардлагыг даган мөрдсөн гэж ойлговол зохино. Хэлцэл хийгдсэн нөлөөтэй мэдээллийн хомс байдал болон тухайн хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар муу, бодит хэлцэл бага хийгдсэн үед зарлагдсан үнийн дүнг ашиглан зах зээлийн үнэ цэнийг илтгэх зорилгоор хэлцэл бууруулах (зарлагдсан үнээс хямдруулах) хувь тооцно. Энэ нь ҮОУС-с гажиж буй нөхцөл боловч бид үүнийг зах зээлийн үнэ цэнийг тооцох хамгийн тохиромжтой арга гэж үзэж байна.

**4.5 Үнэлгээчин нь бүх мэдэгдэхүйц оролцуудыг үнэлэх**

4.5.1 Бидэнд үйлчлүүлэгчийн болон үнэлж буй хөрөнгөтэй холбоотой албан ёсны эрх зүйн баримт бичгүүдийн хуулбар хувийг үйлчлүүлэгч гаргаж өгсөн. Эдгээр баримт бичгүүдийн эх хувийг шаардаагүй болно.
4.5.2 Барилгад чанар байдлыг үнэлэн, хэмжилт хийснээр техникийн болон инженерийн үзлэг шинжилгээг хязгаарласан. Мөн үнэлгээний цар хүрээн дотор хүрээлэн байгаа орчныг авч үзэх боломжгүй бөгөөд үнэлгээчин энэ асуудалтай холбоотой үүрэг хүлээхгүй.
4.5.3 Үнэлгээний тайлангийн өдрөөс хойш зах зээлийн нөхцөл байдалд гарсан аливаа өөрчлөлттэй холбоотойгоор энэхүү тайланд өөрчлөлт орсон тохиолдолд бид ямар нэгэн үүрэг хүлээхгүй.
4.5.4 Бидний зах зээлээс олж авсан мэдээлэл нь тохиромжтой мэдээлэл гэдэгт бид итгэж байгаа боловч тэдгээрийг ят үнэн гэсэн баталгаа гаргах боломжгүй.



УЛААНБААТАР ХОТ
5183855
CTC2420

СЗХ
2024.05.10
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
ЭТГЭВ-02



25-APR-2024

## ТАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ

Энэхүү үнэлгээг хийхтэй холбоотойгоор ашигласан дараах баримтын эх хувийг шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчээс авч ашиглана уу.

1. Газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээ, кадастрын зураг
2. Үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ
3. Хавсралт фото зураг

Үнэлгээчин эдгээр баримтын үйлчлүүлэгчийн гаргаж өгсөн хуулбар хувийг ажлын баримтандаа хадгалсан болно.

Үнэлгээг гүйцэтгэж, тайлан бичсэн:

Үнэлгээчин: /Н.Цолмонгэрэл/

Үнэлгээчин: /Э.Батболд/

Үнэлгээний тайланг:
Хүлээлгэн өгсөн:
"Файн Эстимэйт" ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

Н.Цолмонгэрэл



УЛААНБААТАР ХОТ
5183855
9021031195
СТС2420

СЭХ 2024.06.10 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02
25-APR-2024

ҮЛ ХӨДЛӨХ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

## ХАВСРАЛТ ЗУРАГ



Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЗӨЧ-4 гудамж 406 тоот



Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЗӨЧ-4 гудамж 406 тоот

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ФАЙН ЭСТИМЭЙТ ХХК

5183855 9021031195 СТС2420

СЗХ
2024.08.10
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

ҮЛ ХӨДЛӨХ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

25-APR-2024



Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЗӨЧ-4 гудамж 406 тоот



Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЗӨЧ-3 гудамж 320 тоот

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ФАЙН ЭСТИМЭЙТ ХХК

19

УЛААНБААТАР ХОТ
ЭЗИЙ ЭНД КО ПИТАЛ ҮЦК ХХК
9021031195 СТС2420

СЗХ
2024 оны 10 сарын 09 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

25-APR-2024



**Газар эзэмших эрхийн гэрчилгээний хуулбар /Дорноговь аймаг, Замын-Үүд сум. 1-р баг, Сөёмбо ТЗӨЧ-4 гудамж 406 тоот/**

МОНГОЛ УЛС

АЖ АХУЙН НЭГЖИЙН ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН

# ГЭРЧИЛГЭЭ

**Дугаар: 0000237626**

"Монголын финтек групп"ХК 6692257
(аж ахуйн нэгж, байгууллагын нэр) (регистрийн дугаар)

Сумын Засаг даргын захирамж 20 23 оны 11 сарын 27 өдрийн А/313 тоот
(шийдвэр гаргагч)

шийдвэрийг үндэслэн Дорноговь Замын-Үүд 1-р баг. Сөёмбо
(аймаг, нийслэл) (сум, дүүрэг) (баг, хороо)

ТЗӨЧ-4 406 хаягт
(гудамжны нэр) (хашааны дугаар)

байрлах, нэгж талбарын 4401010486 дугаар бүхий 10000 м.кв газрыг

Зочид буудлын цогцолбор, олон нийтийн газар зориулалтаар

15 жилийн хугацаатай эзэмшүүлж, эрхийн улсын бүртгэлийн Э-0714002972

дугаарт бүртгэж гэрчилгээ олгов.

Энэхүү гэрчилгээ хүчинтэй эсэхийг QR кодыг уншуулж шалгах боломжтой.
бөгөөд гэрчилгээнд агуулагдаж буй мэдээллийг харах боломжтой.

Хэвлэсэн огноо: 2023-11-27



УЛААНБААТАР ХОТ
СЭНДЛИ БОНД ХК
УЛААНБААТАР ХОТ
ОЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5863855
9021031185 СТС2020

СЗХ 2024 .06 сар 10 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

25-APR-2024

## ҮЛ ХӨДЛӨХ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

### Дорноговь аймгийн Замын-Үүд сум

Нэгж талбарын дугаар: 4401010485 Эрхийн төрөл: эзэмших

**Регистрийн** дугаар: 6692257 Хуулийн этгээдийн нэр: Монголын финтек групп

| ХАЯГ: | Аймаг/Хот: Дорноговь | Сум/Дүүрэг: Замын-Үүд | Баг/Хороо: 1-р баг, Соёмбо | Кадастрын мужк: 0010 |
|---|---|---|---|---|
| | ШИНЭ: Гудамж: ТЗӨЧ-4 Тоот: 406 | | ХУУЧИН: ГудамжТөмөр замчдын-1 | Тоот: 4 |



Зургийн масштаб - 1:1543 (1 сантиметрт 15.43 метр багтана)

Хэвлэсэн огноо: 2023-11-27

Орчны тойм



Масштаб - 1 27084

Координатын систем

WGS84/UTM 49N

EPSG: 32649

Нэгж талбар

| № | X | Y | Урт |
|---|---|---|---|
| 1 | 573307.90 | 4840477.85 | 51.01 |
| 2 | 573343.64 | 4840514.22 | 196.33 |
| 3 | 573483.17 | 4840376.25 | 51.02 |
| 4 | 573447.25 | 4840340.04 | 196.08 |

Барилга

| № | X | Y | Урт | Дугаар | Талбай |
|---|---|---|---|---|---|

**Талбайн хэмжээ: 10000 квадрат метр**

Энэхүү кадастрын зураг нь газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ болон гэрээний хамт хүчин төгөлдөр болно

www.egazar.gov.mn

## ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ФАЙН ЭСТИМЭЙТ ХХК

УЛААНБААТАР ХОТ ФАЙН ЭСТИМЭЙТ ХХК 5183855 9021031195 СТС2420

# ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН УДИРДЛАГЫН ЦАХИМ СИСТЕМ

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

## НЭГЖ ТАЛБАРЫН ТОДОРХОЙЛОЛТ

Нэгж талбарын дугаар: **4401010485** (Хадаас)
Гэрчилгээний дугаар: **0000237828**
Гэрээний дугаар: **04416-2023/00518**

| **Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэний мэдээлэл:** | **Нэгж талбарын мэдээлэл:** | |
|---|---|---|
| Иргэн/хуулийн этгээдийн төрөл: **3: Монгол улсын хуулийн этгээд**<br>Регистрийн дугаар: **6692257**<br>Иргэн/хуулийн этгээдийн нэр: **"Монголын финтек групп"ХК**<br>Төрөл: **Шинэ газар эзэмшигч/ашиглагч** | Эрхийн төрөл: **эзэмших**<br>Зориулалт: **Зочид буудлын цогцолбор, олон нийтийн газар**<br>Талбайн хэмжээ: **10000**<br>Гудамжны нэр: **ТЭЗЧ-4**<br>Хашааны дугаар: **406** | |
| **Газрын эрхийн мэдээлэл:** | **Барьцааны мэдээлэл:** | **Шүүхийн шийдвэрийн мэдээлэл:** |
| Шийдвэрийн түвшин: **Сумын Засаг даргын захирамж**<br>Шийдвэрийн огноо: **2023-11-27**<br>Шийдвэрийн дугаар: **04416-А/313/2023**<br>Улсын бүртгэлийн дугаар: **3-0714002073**<br>Гэрээ дуусах огноо: **2038-11-27** | Барьцаалсан эсэх: Байхгүй<br>Чөлөөлөгдөх хугацаа: | Эрх түдгэлзүүлсэн эсэх: Үгүй |

**Үнэлгээний мэдээлэл**

| # | Газрын суурь үнэлгээний зэрэглэл /Бүс/ | Газрын суурь үнэ /1га/ | Дуудлага худалдааны анхны үнийн итгэлцүүр | Дуудлага худалдааны анхны үнэ |
|---|---|---|---|---|
| 1 | 11 ¦ Дорноговь, Замын-Үүд ¦ 1 | 150,000,000₮ | 0.4 | 60,000,000₮ |
| | **Нийт:** | | | **60,000,000₮** |

**Төлбөр, татварын мэдээлэл**

| # | Төлбөр, татварын бүс | Газрын төлбөр, татварын хувь хэмжээ | Газрын төлбөр, татвар /1м2/ | Газрын төлбөр, татварын дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ ¦ Дорноговь, Замын-Үүд ¦ 1 | 1 | 150.000₮ | 1,499,999₮ |
| | **Нийт:** | | | **1,499,999₮** |

## НЭГЖ ТАЛБАРЫН ТҮҮХ

| Өргөдлийн төрөл | Шийдвэрийн мэдээлэл | Нэгж талбарын мэдээлэл |
|---|---|---|

СЗХ 2024.05.10 БҮРТГЭВ №1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## ҮЛ ХӨДЛӨХ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

25-APR-2024

| | | |
|---|---|---|
| 7: Газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх | Шийдвэрийн түвшин: **Сумын Засаг даргын захирамж**<br>Шийдвэрийн огноо: **2023-11-27**<br>Шийдвэрийн дугаар: **04416-A/313/2023** | Иргэн хуулийн этгээд: **"Монголын финтек групп"ХК**<br>Зориулалт: **Зочид буудлын цогцолбор, олон нийтийн газар**<br>Талбайн хэмжээ: **10000**<br>Гэрээ дуусах огноо: **2038-11-27** |
| 7: Газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх | Шийдвэрийн түвшин: **Сумын Засаг даргын захирамж**<br>Шийдвэрийн огноо: **2022-11-27**<br>Шийдвэрийн дугаар: **04416-A/313/2023** | Иргэн хуулийн этгээд: **"Монголын финтек групп"ХК**<br>Зориулалт: **Зочид буудлын цогцолбор, олон нийтийн газар**<br>Талбайн хэмжээ: **10000**<br>Гэрээ дуусах огноо: **2025-08-17** |
| 5: Шинээр газар эзэмших | Шийдвэрийн түвшин: **Сумын Засаг даргын захирамж**<br>Шийдвэрийн огноо: **2010-08-17**<br>Шийдвэрийн дугаар: **04416-a110/2010** | Иргэн хуулийн этгээд: **Капитал банк ХХК төв салбар**<br>Зориулалт: **Зочид буудлын цогцолбор, олон нийтийн газар**<br>Талбайн хэмжээ: **10000**<br>Гэрээ дуусах огноо: **2025-08-17** |

**Хэвлэсэн огноо: 2023 оны 11 сарын 27-ны өдөр**

УЛААНБААТАР ХОТ 5183855 9021031195 СТС2420

## ҮЛ ХӨДЛӨХ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

25-APR-2024

**Газар эзэмших эрхийн гэрчилгээний хуулбар / Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Соёмбо ТЗӨЧ-3 гудамж 320 тоот/**



МОНГОЛ УЛС

АЖ АХУЙН НЭГЖИЙН ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН

ГЭРЧИЛГЭЭ

**Дугаар: 0000237326**

"Монголын финтек групп"ХК 6692257

(аж ахуйн нэгж, байгууллагын нэр) (регистрийн дугаар)

Сумын Засаг даргын захирамж 20 23 оны 11 сарын 24 өдрийн А/309 тоот

(шийдвэр гаргагч)

шийдвэрийг үндэслэн Дорноговь Замын-Үүд 1-р баг, Соёмбо

(аймаг, нийслэл) (сум, дүүрэг) (баг, хороо)

ТЗӨЧ-3 320 хаягт

(гудамжны нэр) (хашааны дугаар)

байрлах, нэгж талбарын 4401002556 дугаар бүхий 1200 м.кв газрыг

Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, тев, цогцолбор зориулалтаар

15 жилийн хугацаатай эзэмшүүлж, эрхийн улсын бүртгэлийн З-0714002967

дугаарт бүртгэж гэрчилгээ олгов.

Энэхүү гэрчилгээ хүчинтэй эсэхийг QR кодыг уншуулж шалгах бөгөөд гэрчилгээнд агуулагдаж буй мэдээллийг харах боломжтой.

**Хэвлэсэн огноо: 2023-11-27**

СЗХ 2024.06.10 БҮРТГЭВ

2024-05-17 БҮРТГЭВ-02

## ҮЛ ХӨДЛӨХ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

25-APR-2024

### Дорноговь аймгийн Замын-Үүд сум

Нэгж талбарын дугаар: 4401002556 Эрхийн төрөл: эзэмших

Регистрийн дугаар: 6692257 Хуулийн этгээдийн нэр: Монголын финтек групп

| ХАЯГ: | Аймаг/Хот: Дорноговь | Сум/Дүүрэг: Замын-Үүд | Баг/Хороо: 1-р баг, Соёмбо | Кадастрын муж: 0010 |
|---|---|---|---|---|
| | ШИНЭ: Гудамж: ТЗӨЧ-3 Тоот: 320 | | ХУУЧИН: Гудамж10-р хэсэг Тоот: 0 | |




Зургийн масштаб = 1:457 (1 сантиметрт 4.57 метр багтана)

Хэвлэсэн огноо: 2023-11-27

Орны тойм

Масштаб = 1: 13542

Координатын систем

WGS84/UTM 49N

EPSG: 32649

Нэгж талбар

| № | X | Y | Урт |
|---|---|---|---|
| 1 | 573263.56 | 4840720.80 | 31.59 |
| 2 | 573240.55 | 4840742.42 | 40.66 |
| 3 | 573262.39 | 4840770.66 | 31.22 |
| 4 | 573283.28 | 4840753.48 | 38.22 |

Барилга

| № | X | Y | Урт | Дугаар | Талбай |
|---|---|---|---|---|---|

Талбайн хэмжээ: 1200 квадрат метр

Энэхүү кадастрын зураг нь газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ болон гэрээний хамт хүчин төгөлдөр болно.

www.egazar.gov.mn



УЛААНБААТАР ХОТ ФАЙН ЭСТИМЭЙТ ХХК 5183855 9021031195 СТС2420

СЭХ 2024 .06 сар 10 өдөр БҮРТГЭВ №

2024 -05- 17 БҮРТГЭВ-02

25 APR 2024

## ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН УДИРДЛАГЫН ЦАХИМ СИСТЕМ

Монгол Улсын Засгийн газар

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

### НЭГЖ ТАЛБАРЫН ТОДОРХОЙЛОЛТ

Нэгж талбарын дугаар: **4401002556** (Харах)
Гэрчилгээний дугаар: **0000237326**
Гэрээний дугаар: **04416-2023/00514**

| **Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэний мэдээлэл:** | **Нэгж талбарын мэдээлэл:** | |
|---|---|---|
| Иргэн/хуулийн этгээдийн төрөл: **3: Монгол улсын хуулийн этгээд**<br>Регистрийн дугаар: **6692257**<br>Иргэн/хуулийн этгээдийн нэр: **"Монголын финтек групп"ХК**<br>Төрөл: **Шинэ газар эзэмшигч/ашиглагч** | Эрхийн төрөл: **эзэмших**<br>Зориулалт: **Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор**<br>Талбайн хэмжээ: **1200**<br>Гудамжны нэр: **Т384-3**<br>Хашааны дугаар: **320** | |
| **Газрын эрхийн мэдээлэл:** | **Барьцааны мэдээлэл:** | **Шүүхийн шийдвэрийн мэдээлэл:** |
| Шийдвэрийн түвшин: **Сумын Засаг даргын захирамж**<br>Шийдвэрийн огноо: **2023-11-24**<br>Шийдвэрийн дугаар: **04416-А/309/2023**<br>Улсын бүртгэлийн дугаар: **Э-0714002987**<br>Гэрээ дуусах огноо: **2038-11-24** | Барьцаалсан эсэх: Байхгүй<br>Чөлөөлөгдөх хугацаа: | Эрх түдгэлзүүлсэн эсэх: Үгүй |

**Үнэлгээний мэдээлэл**

| **#** | **Газрын суурь үнэлгээний зэрэглэл /Бүс/** | **Газрын суурь үнэ /1га/** | **Дуудлага худалдааны анхны үнийн итгэлцүүр** | **Дуудлага худалдааны анхны үнэ** |
|---|---|---|---|---|
| 1 | 31 \| Дорноговь, Замын-Үүд \| 1 | 150,000,000₮ | 0.4 | 7,200,000₮ |
| | **Нийт:** | | | **7,200,000₮** |

**Төлбөр, татварын мэдээлэл**

| **#** | **Төлбөр, татварын бүс** | **Газрын төлбөр, татварын хувь хэмжээ** | **Газрын төлбөр, татвар /1м2/** | **Газрын төлбөр, татварын дүн** |
|---|---|---|---|---|
| 1 | Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ \| Дорноговь, Замын-Үүд \| 1 | 1 | 150.000₮ | 180,000₮ |
| | **Нийт:** | | | **180,000₮** |

### НЭГЖ ТАЛБАРЫН ТҮҮХ

| **Өргөдлийн төрөл** | **Шийдвэрийн мэдээлэл** | **Нэгж талбарын мэдээлэл** |
|---|---|---|

УЛААНБААТАР ХОТ
МЭЙ ЭН ДИ БО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420



СЭНДЛИ БОНД ҮЦК ХХК

СЗХ
2024.06.18
БҮРТГЭВ.
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

## ҮЛ ХӨДЛӨХ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

25-APR-2024

| | | |
|---|---|---|
| 7. Газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх | Шийдвэрийн түвшин: **Сумын Засаг даргын захирамж**<br>Шийдвэрийн огноо: **2023-11-24**<br>Шийдвэрийн дугаар: **04416-А/309/2023** | Иргэн хуулийн этгээд: **"Монголын финтек групп"ХК**<br>Зориулалт: **Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор**<br>Талбайн хэмжээ: **1200**<br>Гэрээ дуусах огноо: **2038-11-24** |
| 7. Газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх | Шийдвэрийн түвшин: **Сумын Засаг даргын захирамж**<br>Шийдвэрийн огноо: **2023-11-24**<br>Шийдвэрийн дугаар: **04416-А/309/2023** | Иргэн хуулийн этгээд: **"Монголын финтек групп"ХК**<br>Зориулалт: **Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор**<br>Талбайн хэмжээ: **1200**<br>Гэрээ дуусах огноо: **2011-09-16** |
| 5. Шинээр газар эзэмших | Шийдвэрийн түвшин: **Сумын Засаг даргын захирамж**<br>Шийдвэрийн огноо: **2011-06-30**<br>Шийдвэрийн дугаар: **04416-124/2011** | Иргэн хуулийн этгээд: **Хаан ХХК**<br>Зориулалт: **Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор**<br>Талбайн хэмжээ: **1200**<br>Гэрээ дуусах огноо: **2011-09-16** |

Хэвлэсэн огноо: 2023 оны 11 сарын 27-ны өдөр

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЗХ
2024.05.10 өдөр
БҮРТГЭВ
№01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

# ҮЛ ХӨДЛӨХ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

25-APR
2024

**Жишиг хөрөнгийн эх сурвалжийн мэдээлэл №1.**

23/04/2024, 12:00 Замын үүд хот, вокзал дотор газар 380 сая ₮ №7950715 УБ — Сүхбаатар -д - Газар зарна - Unegui.mn үнэгүй зарын сайт

**380 сая ₮**

## Замын үүд хот, вокзал дотор газар

Нийтэлсэн: 2024-04-10 13:22

Bella

Энхтайван оргөн 1-р сдр. 201






**Лизингүй**

- Замын үүд хот, хил нэвтрэх вокзал дээр байрлал сайтай газрын эрх шилжүүлнэ.

Зочид буудал, үйлчилгээний цогцолбор барихад тохиромжтой
1га хэмжээтэй

## Ижил зарууд



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮНЭ ХХК
5183855
9021031195 СТС2420

# ҮЛ ХӨДЛӨХ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

25-APR-2024

**Жишиг хөрөнгийн эх сурвалжийн мэдээлэл №2.**

23/04/2024, 12:01 Замын үүд суманд газар 95 сая ₮ №7382291 Дорноговь -д - Газар зарна - Unegui.mn үнэгүй зарууд худалдаж авна зарна б/у

## Замын-үүд суманд газар

**95 сая ₮**

Нийтэлсэн: 2024-03-29 10:43



Жагсаа

Эзэмшил өмнө 10-р сар, 20

Газрын эрх шилжүүлнэ.
Замын-Үүд суманд худалдаа, нийтийн үйлчилгээний зориулалттай 2000м2 газрын эрх шилжүүлнэ.
- Шилжээр татагдсан засмал замын хажууд
- Төвийн дулаан болон цэвэрлэх ... шугамтай ойрхон
- Сургууль цэцэрлэгтэй ойрхон

Газрын зураг

Ижил зарууд

https://www.unegui.mn/adv/7382291_gazryn-erkh-shilzhuulne/

СЭХ
2024 06 10
БҮРТГЭВ
№ 1

MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -05- 17
БҮРТГЭВ-02

25-APR-2024

## ҮЛ ХӨДЛӨХ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**Жишиг хөрөнгийн эх сурвалжийн мэдээлэл №3.**

23/04/2024, 12:01 RE/MAX iConnect

# Property Details

Print | Share Property

### Газар-Худалдах-Замын-Үүд, MN



**180,000,000 ₮**

Листингийн статус Идэвхтэй DOM 160

Замын-Үүд, MN

Listing ID: 119050035-47

| | |
|---|---|
| Гэрээний төрөл: | Энгийн |
| Original Listing Date: | 14/11/2023 |
| Expiry Date: | 14/11/2024 |

Дорноговь аймаг, замын үүд хот Соёмбо хотхоны баруун талд эзэмших эрхтэй газрын эрхийг шилжүүлнэ
төвийн шугам 100м зайтай, худалдаа үйлчилгээний газар, цогцолборын зориулалтаар ашиглах зөвшөөрөлтэй
1000мк хэмжээтэй

https://goconnect.com/AdvancedSearch/AdvancedListingFull.aspx?ListingKey=0ea4cc9f-a946-4576-8be7-24c1c542a372&Result=1&CurrentIndex=0

## ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ФАЙН ЭСТИМЭЙТ ХХК

УЛААНБААТАР ХОТ
ХӨДИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

СЭХ
2024 .04 10 өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -05- 17
БҮРТГЭВ-02

25 APR 2024

ҮЛ ХӨДЛӨХ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хөрөнгийн үнэлгээчний тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар

МОНГОЛ УЛС
ХУГАЦААГҮЙ ЭРХТЭЙ ҮНЭЛГЭЭЧНИЙ

# ГЭРЧИЛГЭЭ

№ 91100172

Цээж зураг

Ургийн овог: Бэх цагаан

Эцэг(эх)-ийн нэр: Нямцэрэн

Нэр: Цолмонгэрэл

Монгол улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасан бүх шаардлагыг хангасан тул Хөрөнгийн үнэлгээчний эрхийг хугацаагүйгээр олгов.

Энэхүү гэрчилгээг эзэмшигч нь зөвхөн үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ хийх эрхтэй бөгөөд хөрөнгийн үнэлгээчинд хамаарах бүрэн эрхийг эдэлж, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

Гэрчилгээ олгосон шийдвэр:
**Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институтийн Удирдах Зөвлөлийн 20 23 оны 5 сарын 12-ний өдрийн 19 тоот тогтоол**

Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институтийн

Удирдах зөвлөлийн дарга, Тэргүүн /Г.БАЯНМӨНХ/

Гүйцэтгэх Захирал /Б.ЭНХБОЛД/

MICA

Улаанбаатар хот

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ФАЙН ЭСТИМЭЙТ ХХК

УЛААНБААТАР ХОТ
ЗҮЙЛ ЭНД КО ...ИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195 СТС2420

СЗХ 2024.06.10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

25-APR-2024

ҮЛ ХӨДЛӨХ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

МОНГОЛ УЛС
ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭЧНИЙ
# ГЭРЧИЛГЭЭ

№ 202107001

*Цээж зураг*

Ургийн овог: Дуутан

Эцэг(эх)-ийн нэр: Эрхэмсайхан

Нэр: Батболд

Монгол улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 14.3-д заасан бүх шаардлагыг хангаж, хуулийн 14.1-д үнэлгээчний эрх олгох шалгалтад тэнцсэн тул Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институтийн Удирдах Зөвлөлийн 20 23 оны 5 сарын 12-ны өдрийн 10 тоот тогтоолоор **Хөрөнгийн үнэлгээчний эрхийг** олгов.

Гэрчилгээ нь 20 24 оны 9 сарын 27-ны өдөр хүртэл хүчинтэй.

Энэхүү гэрчилгээг эзэмшигч нь зөвхөн үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ хийх эрхтэй бөгөөд хөрөнгийн үнэлгээчинд хамаарах бүрэн эрхийг эдэлж, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институтийн

Удирдах зөвлөлийн дарга бөгөөд Тэргүүн Г.БАЯНМӨНХ

Гүйцэтгэх Захирал Б.ЭНХБОЛД

Улаанбаатар хот

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ФАЙН ЭСТИМЭЙТ ХХК

Улаанбаатар хот ... ЗЭЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ 2024.05.10 өдөр БҮРТГЭВ №01

MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

25-APR 2024

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМ СИСТЕМИЙН ЛАВЛАГАА ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2023.10.11

**Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үндсэн мэдээлэл**

Регистрийн дугаар : **5353459**
Нэр : **ФАЙН-ЭСТИМЭЙТ**

**Зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл**

| | |
|---|---|
| Авсан огноо : | **2023-10-10** |
| Дуусах огноо : | **2028-10-10** |
| Хүчинтэй эсэх : | **Хүчинтэй** |
| Тусгай зөвшөөрлийн нэр : | **ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ** |

*Цахим систем нь бусад төрийн байгууллагуудаас шаардлагатай мэдээллийг татан авч байгаа шалгуур болон ашиглаж байгаа бөгөөд QR кодыг уншуулах үед тухайн шалгууруудыг хангасан эсэхээс хамааран эрчилгээний төлөв өөрчлөгдөх буюу тухайн үеийн байдлаар харагдахыг анхаарна уу*



УЛААНБААТАР ХОТ ... КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 CTC2420

# МОНГОЛ УЛС
# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2010.01.26
/Бүртгэсэн он, сар, өдөр/

9011223011
/Улсын бүртгэлийн дугаар/

5353459
/Регистрийн дугаар/

Файн-Эстимэйт Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/

Дүрэм
/Үүсгэн байгуулах баримт бичиг/

| | | |
|---|---|---|
| Шийдвэр | 01 | 2010.01.25 |
| /шийдвэрийн нэр/ | /дугаар/ | он, сар, өдөр |

511000 Гадаад худалдаа
/код/ /Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

/код/ /Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

| | | |
|---|---|---|
| Хугацаагүй | 2 | 10,000.0 |
| хугацаа | /эзэмшигчдийн тоо/ | /өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр/ |

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олн гудамж, 3 - 201, утас1:88000267, утас2:99118071, факс:
/хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газар
/Бүртгэсэн байгууллагын нэр/

СЗХ 2024.06.10 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

СЗХ
2024 он 06 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

## Харилцах банкны бүртгэл:

| Харилцагч банкны нэр | Дансны төрөл | Дансны дугаар | Бүртгэсэн ажилтан, тэмдэг |
|---|---|---|---|
| *Капитрон банк* | *Төгрөгийн* | *3001005229* | *Ч.Гэрэлцэцэг* |

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:

| Д/д | Нэмэлт, өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн Огноо | Бүртгэсэн Ажилтан, тэмдэг |
|---|---|---|---|
| 1 | *702000.Харилцааны үнэлгээ хийх эрхлох үндсэн үйл ажиллагааг 2 жилийн хугацаатайгаар шинээр бүртгэв.* | *2010.02.19* | *Ч.Батцэцэг* |
| 2 | *749900 Бизнесийн зөвлөгөө өгөх эрхлэх туслах үйл ажиллагааг шинээр бүртгэв.* | *2010.02.19* | *Ч.Батцэцэг* |
| 2 | *701000 Үл хөдлөх хөрөнгийн худалдаа, зуучлал эрхлэх туслах үйл ажиллагааг шинээр бүртгэв* | *2010.02.19* | *Ч.Батцэцэг* |
| 3 | *660300 Дээтээгийн хохирлын үнэлгээ хийх эрхлэх туслах үйл ажиллагааг 2 жилийн хугацаатайгаар шинээр бүртгэв.* | *2011.07.07* | *Д.Чулуунцэцэг* |
| 5 | *Чадваабат овогтой Отгончимэг нь Гүйцэтгэх захирал-р томилогдсоныг бүртгэв* | *2016.11.04* | [illegible] |
| 6 | *6512 Даатгалын хохирлын үнэлгээ хийх /хугацаа 2018.12.19-2021.12.19/ эрхлэх үйл ажиллагааг шинээр бүртгэв.* | *2019.05.14* | *З.Эрдэнэбилэг* |
| 7 | *6820 Хөрөнгийн үнэлгээ хийх /хугацаа 2018.12.19-2021.12.19/ эрхлэх үйл ажиллагааг шинээр бүртгэв.* | *2019.05.14* | *З.Эрдэнэбилэг* |
| 13 | *Эцсийн өмчлөгч 1 ургэн бүртгэв* | *2020.08.15* | *С.Мөнхсанчир* |
| 14 | *Эцсийн өмчлөгч 2 ургэн бүртгэв* | *2020.08.15* | *С.Мөнхсанчир* |
| 15 | *Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 30000 мян.төг-р нэмэгдэж нийт 40000 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.* | *2022.03.03* | *Н.Должоржав* |
| 16 | *Эцсийн өмчлөгч 2 ургэн бүртгэв.* | *2022.03.03* | *Н.Должоржав* |
| 17 | *6820 Хөрөнгийн үнэлгээ хийх /хугацаа 2018.12.19-2021.12.19/ үйл ажиллагаа хассаныг бүртгэв. 68210 Хөрөнгийн үнэлгээ хийх үйл ажиллагаа /2021.12.19-2024.12.19/ үйл ажиллагаа шинээр бүртгэв.* | *2022.09.30* | *О.Шижиртуяа* |
| 18 | *Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, оён 3, 201 Утас1: 88000267, Утас2: , Факс: хаягийг шинээр бүртгэв.* | *2022.12.08* | *Г.Санхаа* |
| 19 | *Хувьцаа эзэмшигч 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв* | *2022.12.08* | *Г.Санхаа* |
| 20 | *Эцсийн өмчлөгч 1 ургэн бүртгэв.* | *2022.12.08* | *Г.Санхаа* |
| 21 | *Нямцэрэн овогтой Цолмонсэрэн с Гүйцэтгэх захирал -р сонгогдсон(томилогдсон)-ыг бүртгэв* | *2023.01.04* | *Г.Санхаа* |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

УЛААНБААТАР ХОТ
ОЙЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
9021031195
СТС2020

СЗХ 2024.06.10 өдөр БҮРТГЭВ №1

MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## ХАВСРАЛТ-5. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000264577

2015.05.04
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9007001010
/ Хувийн хэргийн дугаар /

5961548
/ Регистрийн дугаар /

Сэндли ББСБ Хувьцаат компани /нээлттэй ХК/
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол / шийдвэрийн нэр / — 01 / дугаар / — 2015.04.30 / он, сар, өдөр /

| / Код/ | / Үйл ажиллагааны чиглэл / |
|---|---|
| 6611 | Зээлийн үйл ажиллагаа |
| 6499 | Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ |
| 6419 | Гадаад валютын арилжаа /2016.02.07-2016.02.07/ |
| 66110 | Факторингийн үйлчилгээ |
| 09902 | Төлбөрийн баталгаа гаргах |
| 64300 | Итгэлцлийн үйлчилгээ |

Хугацаагүй / хугацаа / — 12 / гишүүдийн тоо / — 11,178,500.00 / хөрөнгийн хэмжээ, мөнгөн төгрөгөөр /

Улаанбаатар, Чингэлтэй, 2-р хороо, 40, 50 мянгат/15171/, Бакула ринбүчи гудамж, 8/4 тоот,
Утас1: 70177700, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ /гэмдэг/ Б.БАТЗОРИГ /нэрийн үсэг/

Гэрчилгээ дахин олгосон 2022 он 12 сар 27 өдөр

СЭНДЛИ ББСБ ХК — УЛААНБААТАР ХОТ

ЭЛЗИЙ ЭНД НО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183856 9021031195 СТС2420

СЗХ 2024.06.10 БҮРТГЭВ

MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

**Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл**

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | *Балжинням овогтой Одзэрэл-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.* | *2021.05.27* | *М.Монголжин* |
| 2 | *Дахин зэрчилгээ олгов.* | *2022.12.27* | *Б.Батзориг* |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

УЛААНБААТАР ХОТ ОЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

СЭХ 2024 .06 .10 БҮРТГЭВ

MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

## ХАВСРАЛТ-6. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 101/498

2015 оны 07 сарын 03 өдөр

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 07 сарын 03 өдрийн 318 дугаар тогтоолоор

"СЭНДЛИ ББСБ" ХК -д

Банк бус санхүүгийн

үйл

ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА
"Тамга"
БАЯРСАЙХАН

Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй

(Энэхүү хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй)

**МОНГОЛ УЛС САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

**ТЗ 101/498 ТООТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ**

"Тэмдэг"

Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд зорнулсан тэмдэглэлүүд

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр: **"СЭНДЛИ ББСБ" ХК**

ХОЁР. Хуулийн этгээдийн ангилал: **БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ГУРАВ. Үйл ажиллагааны төрөл,хэлбэрийн тэмдэглэл:

| Д/д | Үйл ажиллагааны төрөл, хэлбэр | Олгосон огноо | Олгосон шийдвэрийн дугаар | Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, сунгасан хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|
| 1. | Зээл | 2015.07.03 | №318 тогтоол | |
| 2. | Гадаад валютын арилжаа | 2018.02.07 | №62 тогтоол | |
| 3. | Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ | 2018.02.07 | №62 тогтоол | |
| 4. | Факторинг | 2021.10.13 | №441 тогтоол | |
| 5. | Итгэлцэл | 2021.10.13 | №441 тогтоол | |
| 6. | Төлбөрийн баталгаа гаргах | 2021.10.13 | №441 тогтоол | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

СЗХ он сар өдөр 2024 06 10 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17

"Гео финанс ББСБ" ХХК-ийн оноосон нэрийг "Гялс кредит ББСБ" ХХК болгон өөрчлөхийг зөвшөөрсөн. 2017.11.21 №501.
"Гялс кредит ББСБ" ХХК -ийн оноосон нэрийг "Сэндли ББСБ" ХХК болгон өөрчлөхийг зөвшөөрсөн. 2021.12.10-№328 туш.

ДӨРӨВ. Хуулийн этгээдийн хаяг, хаягийн өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хаяг | Утас | Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг |
|---|---|---|---|
| 1. | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Хангай хотхон, 512-3 тоот. | | |
| 2. | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жуулчны гудамж, Бизнес 34 центр А корпус, 1 тоот. | 99114006 99080387 | 2017.10.20 №7/3051албан тоот |
| 3. | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 40,50 мянгат/15171/, Бакула ренбүчи гудамж, 8/4 тоот. | | 2022.04.01 ЦМ-7/041 цахим мэдэгдэл |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

ТАВ. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн, хорогдуулсан хэмжээ | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1. | | 2015.07.03 | №318 | 400,000,000 /анх олгосон/ |
| 2. | 400,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2017.07.18 | №377 | 800,000,000 |
| 3. | 20,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2017.09.27 | №427 | 820,000,000 |
| 4. | 180,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2017.11.21 | №500 | 1,000,000,000 |
| 5. | 428,500,000 /нэмэгдүүлсэн/ | 2019.05.27 | №384 | 1,428,500,000 |
| 6. | 3,000,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2021.10.07 | №268 | 4,428,500,000 |
| 7. | 2,000,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2021.12.31 | №371 | 6,428,500,000 |
| 8. | 1,400,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2022.06.03 | №296 | 7,828,500,000 |
| 9. | 3,350,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2022.12.23 | №7/4900 албан тоот | 11,178,500,000 |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

СЗХ 2024.06.10 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

тушаал
ал.

"Сэндли ББСБ" ХХК нь нээлттэй хувьцаат компани болсон. 2022.08.10 №413 тогтоол

ЗУРГАА. Хувьцаа эзэмшигчийн талаар:

| Д/д | Овог нэр /Хуулийн этгээдийн нэр/ | Регистрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн | Хувь | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар, тэмдэг |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | "Монголын финтек групп" ХК | 6692257 | 6,307,085,000 | 98.11% | 2021.12.31 | №371 тушаал |
| 2. | Радикс технологи ХХК | 6439705 | 85,710,000 | 1.33% | 2021.12.31 | №371 тушаал |
| 3. | Б.Нямжаргал | ЙЮ91040826 | 14,285,000 | 0.22% | 2021.12.31 | №371 тушаал |
| 4. | З.Цолмон | УУ89031123 | 5,355,000 | 0.08% | 2021.12.31 | №371 тушаал |
| 5. | Ц.Дашсүрэн | МЯ80081921 | 3,570,000 | 0.06% | 2021.12.31 | №371 тушаал |
| 6. | Л.Нарантуяа | ЙЮ82042221 | 3,570,000 | 0.06% | 2021.12.31 | №371 тушаал |
| 7. | О.Нямдэлэг | ФА72102208 | 3,570,000 | 0.06% | 2021.12.31 | №371 тушаал |
| 8. | Г.Саруул-Од | УЕ82081903 | 3,570,000 | 0.06% | 2021.12.31 | №371 тушаал |
| 9. | Г.Гантуяа | ЕС90020106 | 1,785,000 | 0.02% | 2021.12.31 | №371 тушаал |
| 1. | "Монголын финтек групп" ХК | 6692257 | 6,307,085,000 | 80.56% | 2022.06.03 | №296 тушаал |
| 2. | "Сэндли эмплойе" ХХК | 5999782 | 1,000,000,000 | 12.77% | 2022.06.03 | №296 тушаал |
| 3. | Б.Наранбат | ХП86021476 | 400,000,000 | 5.10% | 2022.06.03 | №296 тушаал |
| 4. | "Радикс технологи" ХХК | 6439705 | 85,710,000 | 1.10% | 2022.06.03 | №296 тушаал |
| 5. | Б.Нямжаргал | ЙЮ91040826 | 14,285,000 | 0.18% | 2022.06.03 | №296 тушаал |
| 6. | З.Цолмон | УУ89031123 | 5,355,000 | 0.07% | 2022.06.03 | №296 тушаал |
| 7. | Ч.Дашсүрэн | МЯ80081921 | 3,570,000 | 0.05% | 2022.06.03 | №296 тушаал |
| 8. | Л.Нарантуяа | ЙЮ82042221 | 3,570,000 | 0.05% | 2022.06.03 | №296 тушаал |
| 9. | О.Нямдэлэг | ФА72102208 | 3,570,000 | 0.05% | 2022.06.03 | №296 тушаал |
| 10. | Г.Саруул-Од | УЕ82081903 | 3,570,000 | 0.05% | 2022.06.03 | №296 тушаал |
| 11. | Г.Гантуяа | ЕС90020106 | 1,785,000 | 0.02% | 2022.06.03 | №296 тушаал |
| 1. | "Монголын финтек групп" ХК | 6692257 | 6,307,085,000 | 56.42% | 2022.12.23 | №7/4900 албан тоот |
| 2. | "Сэндли эмплойе" ХХК | 5999782 | 1,000,000,000 | 8.95% | 2022.12.23 | №7/4900 албан тоот |
| 3. | Б.Наранбат | ХП86021476 | 400,000,000 | 3.57% | 2022.12.23 | №7/4900 албан тоот |
| 4. | "Радикс технологи" ХХК | 6439705 | 85,710,000 | 0.77% | 2022.12.23 | №7/4900 албан тоот |
| 5. | Б.Нямжаргал | ЙЮ91040826 | 14,285,000 | 0.12% | 2022.12.23 | №7/4900 албан тоот |
| 6. | З.Цолмон | УУ89031123 | 5,355,000 | 0.05% | 2022.12.23 | №7/4900 албан тоот |
| 7. | Ч.Дашсүрэн | МЯ80081921 | 3,570,000 | 0.03% | 2022.12.23 | №7/4900 албан тоот |
| 8. | Л.Нарантуяа | ЙЮ82042221 | 3,570,000 | 0.03% | 2022.12.23 | №7/4900 албан тоот |
| 9. | О.Нямдэлэг | ФА72102208 | 3,570,000 | 0.03% | 2022.12.23 | №7/4900 албан тоот |
| 10. | Г.Саруул-Од | УЕ82081903 | 3,570,000 | 0.03% | 2022.12.23 | №7/4900 албан тоот |
| 11. | Г.Гантуяа | ЕС90020106 | 1,785,000 | 0.02% | 2022.12.23 | №7/4900 албан тоот |
| 12. | Олон нийт | ЕС90020106 | 3,350,000,000 | 29.97% | 2022.12.23 | №7/4900 албан тоот |

УЛААНБААТАР ХОТ ОЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

ДОЛОО. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын тэмдэглэл:

| Д/д | Нэр, дугаар | Хаяг, хаягийн өөрчлөлт | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|---|
| 1. | Салбар-01 | Өвөрхангай аймаг, Арвайхээр сум. | 2020.01.10 | №05 тушаал | |
| 2. | Салбар-02 | Дорноговь аймаг, Сайншанд сум. | 2020.01.10 | №05 тушаал | |
| 3. | Салбар-03 | Дорноговь аймаг, Замын-Үүд сум. | 2020.01.10 | №05 тушаал | |
| 4. | Салбар-04 | Өмнөговь аймаг, Даланзадгад сум. | 2020.01.10 | №05 тушаал | |
| 5. | Салбар-05 | Баянхонгор аймаг, Баянхонгор сум. | 2020.01.10 | №05 тушаал | |
| 6. | Салбар-06 | Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум. | 2020.01.10 | №05 тушаал | |
| 7. | Салбар-07 | Дархан-Уул аймаг, Дархан сум. | 2020.01.10 | №05 тушаал | |
| 8. | Салбар-08 | Дундговь аймаг, Сайнцагаан сум. | 2020.01.10 | №05 тушаал | |
| 9. | Салбар-09 | Орхон аймаг, Баян-Өндөр сум. | 2020.01.10 | №05 тушаал | |
| 10. | Салбар-10 | Увс аймаг, Улаангом сум. | 2020.01.10 | №05 тушаал | |
| 11. | Салбар-11 | Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум. | 2020.01.10 | №05 тушаал | |
| 12. | Салбар-12 | Завхан аймаг, Улиастай сум. | 2020.01.10 | №05 тушаал | |
| 13. | Салбар-13 | Архангай аймаг, Эрдэнэбулган сум. | 2020.01.10 | №05 тушаал | |
| 14. | Салбар-14 | Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум. | 2020.01.10 | №05 тушаал | |
| 15. | Салбар-15 | Сэлэнгэ аймаг, Мандал сум. | 2020.01.10 | №05 тушаал | |
| 16. | Салбар-16 | Дорнод аймаг, Хэрлэн сум. | 2020.01.10 | №05 тушаал | |
| 17. | Салбар-17 | Хэнтий аймаг, Хэрлэн сум. | 2020.01.10 | №05 тушаал | |
| 18. | Салбар-18 | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг | 2021.06.30 | №164 тушаал | |
| 19. | Салбар-19 Салбар-2 | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг | 2021.06.30 | №164 тушаал | |
| 21. | Салбар-21 | Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг | 2021.07.27 | №194 тушаал | |
| 22. | Салбар-22 | Баян-Өлгий аймаг, Өлгий сум. | 2021.10.01 | №259 тушаал | |
| 23. | Салбар-23 | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг. | 2022.01.12 | №15 тушаал | |
| 24. | Салбар-24 | Сэлэнгэ аймаг, Баянгол сум. | 2022.01.12 | №15 тушаал | |
| 25. | Салбар-25 | Дундговь аймаг, Эрдэнэдалай сум. | 2022.01.12 | №15 тушаал | |
| 26. | Салбар-26 | Өмнөговь аймаг, Гурван тэс сум. | 2022.01.12 | №15 тушаал | |
| 27. | Салбар-27 | Хэнтий аймаг, Батноров сум. | 2022.01.12 | №15 тушаал | |
| 28. | Салбар-28 | Дорнод аймаг, Баян-Уул сум. | 2022.01.12 | №15 тушаал | |
| 29. | Салбар-29 | Сэлэнгэ аймаг, Сайхан сум. | 2022.01.12 | №15 тушаал | |
| 30. | Салбар-30 | Завхан аймаг, Тосонцэнгэл сум. | 2022.01.12 | №15 тушаал | |
| 31. | Салбар-31 | Булган аймаг, Булган сум. | 2022.01.12 | №15 тушаал | |
| 32. | Салбар-32 | Говьсүмбэр аймаг, Шивээговь сум. | 2022.01.12 | №15 тушаал | |
| 33. | Салбар-33 | Хэнтий аймаг, Өмнөдэлгэр сум. | 2022.01.12 | №15 тушаал | |
| 34. | Салбар-34 | Архангай аймаг, Тариат сум. | 2022.01.12 | №15 тушаал | |
| 35. | Салбар-35 | Өвөрхангай аймаг, Хархорин сум. | 2022.01.12 | №15 тушаал | |
| 36. | Салбар-36 | Өвөрхангай аймаг, Сант сум. | 2022.03.16 | №114 тушаал | |
| 37. | Салбар-37 | Увс аймаг, Зүүнговь сум. | 2022.03.16 | №114 тушаал | |
| 38. | Салбар-38 | Өвөрхангай аймаг, Бат-Өлзий сум. | 2022.03.16 | №114 тушаал | |
| 39. | Салбар-39 | Сэлэнгэ аймаг, Ерөө сум. | 2022.03.16 | №114 тушаал | |
| 40. | Салбар-40 | Дархан-Уул аймаг, Шарын гол сум. | 2022.03.16 | №114 тушаал | |
| 41. | Салбар-41 | Увс аймаг, Тэс сум. | 2022.03.16 | №114 тушаал | |
| 42. | Салбар-42 | Өвөрхангай аймаг, Богд сум. | 2022.03.16 | №114 тушаал | |
| 43. | Салбар-43 | Архангай аймаг, Эрдэнэмандал сум. | 2022.03.16 | №114 тушаал | |
| 44. | Салбар-44 | Дорнод аймаг, Цагаан-Овоо сум. | 2022.03.16 | №114 тушаал | |

СЗХ 2024.05.10 өдөр БҮРТГЭВ № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-05-17 БҮРТГЭВ-02

ДОЛОО. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын тэмдэглэл:

| Д/д | Нэр, дугаар | Хаяг, хаягийн өөрчлөлт | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|---|
| 45.<br>46. | Салбар-45<br>Салбар-46 | Дорноговь аймаг, Дэлгэрэх сум.<br>Сэлэнгэ аймаг, Цагааннуур сум. | 2022.03.16<br>2022.03.16 | №114 тушаал<br>№114 тушаал | |
| 47.<br>48. | Салбар-47<br>Салбар-48 | Сүхбаатар аймаг, Эрдэнэцагаан сум.<br>Сүхбаатар аймаг, Мөнххаан сум. | 2022.03.16<br>2022.03.16 | №114 тушаал<br>№114 тушаал | |
| 49.<br>50. | Салбар-49<br>Салбар-50 | Хэнтий аймаг, Бор-Өндөр сум.<br>Сүхбаатар аймаг, Онгон сум. | 2022.03.16<br>2022.03.16 | №114 тушаал<br>№114 тушаал | |
| 51.<br>52. | Салбар-51<br>Салбар-52 | Өмнөговь аймаг, Цогтцэций сум.<br>Дорноговь аймаг, Даланжаргалан | 2022.03.16<br>2022.03.16 | №114 тушаал<br>№114 тушаал | |
| 53.<br>54. | Салбар-53<br>Салбар-54 | Улаанбаатар хот,Налайх дүүрэг. Төв аймаг, Зуунмод сум. | 2022.03.16<br>2022.04.22 | №114 тушаал<br>№212 тушаал | |
| 55.<br>56. | Салбар-55<br>Салбар-56 | Ховд аймаг, Жаргалант сум<br>Хөвсгөл аймаг, Мөрөн сум | 2023.08.03<br>2023.08.03 | №362 тушаал<br>№362 тушаал | |
| 57. | Салбар-57 | Улаанбаатар хот, Багануур дүүрэг | 2023.08.28 | №378 тушаал | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

УЛААНБААТАР ХОТ ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

СЗХ
2024.06.10
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

## БАТЛАХ ХУУДАС

СЗХ
2024.06 сар 10
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-05-17
БҮРТГЭВ-02

Бирж болон Хороонд хүргүүлж байгаа танилцуулга нь адил бөгөөд, ямар нэг зөрүүтэй мэдээлэл тусгагдаагүй болно.

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд нээлттэй өрийн хэрэгсэл санал болгох үйл ажиллагаанд оролцогч мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь хоорондоо болон Үнэт цаас гаргагчтай аливаа нэгдмэл сонирхол болон бизнесийн ашиг сонирхлын зөрчилгүй болно.

---

Овог, нэр: Б.НАРАНБАТ
Албан тушаал: Үнэт цаас гаргагч "Сэндли ББСБ" ХК-ийн ТУЗ-ийн дарга

Гарын үсэг:..........................................................(Тамга/Тэмдэг)

---

Овог, нэр: Б.ОДГЭРЭЛ
Албан тушаал: Үнэт цаас гаргагч "Сэндли ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:..........................................................(Тамга/Тэмдэг)

---

Овог, нэр: М.МӨНХГЭРЭЛ
Албан тушаал: Үнэт цаас гаргагч "Сэндли ББСБ" ХК-ийн Санхүү хариуцсан захирал

Гарын үсэг:..........................................................(Тамга/Тэмдэг)

---

Овог, нэр: Н.ЭНХЧИМЭГ
Албан тушаал: Үнэт цаас гаргагч "Сэндли ББСБ" ХК-ийн Ерөнхий нягтлан бодогч

Гарын үсэг:..........................................................(Тамга/Тэмдэг)

---

Овог, нэр: Б.ӨЛЗИЙБАЯР
Албан тушаал: Андеррайтерийн "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:..........................................................(Тамга/Тэмдэг)

КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183855
9021031195 СТС2420